1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамжийн үйлчилгээ нь зөвхөн нийгмийн халамжийн хуулиудаар тогтоосон зорилтот иргэнд зориулагдсан хөрөнгө байх бөгөөд үүнийг улсын төсвөөс нэг мөр санхүүжүүлж байх нь зүйтэй болов уу.
2. Зарим орны жишгээр /шинээр мэндэлсэн хүүхэд, нийгмийн даатгалд хамрагдаагүй эхчүүдэд, жирэмсний болон тодорхой хугацаанд хүүхдээ асарсан г. м./ -ийн тэтгэмж олгох боломжтой. Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт тэтгэмж олгохыг тодорхой хугацаанаас эхлэн хүүхэд бүрт олгодог нэг удаагийн тэтгэмж гэж нэрлэх бололцоотой юм. Харин эх үүсвэр нь “Хүний хөгжлийн сан” байж болох юм.
3. Сүүлийн жилүүдэд шинээр бий болгосон хүүхдийн тэтгэмж, хүүхдийн хөгжлийн тэтгэмж шинэ гэр бүлийн мөнгөн тусламж зэрэг нийтийг хамарсан тэтгэмжээс татгалзах эсвэл боломжтой гэж үзвэл шинээр байгуулж байгаа “Хүний хөгжлийн сан”-гаас тусгайд нь санхүүжүүлж болох юм.
4. Нийгмийн халамжийн удирдлага зохицуулалтын үүргийг босоо тогтолцоогоор бус орон нутгийн эрх барих байгууллагад шилжүүлж, тухайлбал баг хорооны түвшинд засаг даргад нь шууд хариуцуулах юм бол энэ үйлчилгээ эзэндээ ойртох, баг хорооны дарга нь иргэддээ ойртох хөшүүрэг болно гэдэг нь Япон, БНСУ-ын туршлагаас тодорхой байна.
5. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкнаас гаргасан “Монгол улс дахь ядуурлын дүр төрх” судалгааны мэдээллээс дүгнэж үзэхэд нийт ядуу хүмүүсийн дунд ажил эрхэлдэг хүмүүс 66.2 хувийг эзэлж байгаа нь манай халамжийн үйлчилгээг хавтгайруулахад хүргэсэн гэж дүгнэх боломжтой. Ийм учраас цалин хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх замаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн доод хэмжээг нэмэгдүүлэх нь оновчтой болов уу. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хэмжээг ч нэмэгдүүлэх шаардлагатай болох нь дээр дурьдсан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санал, “Монгол улс дахь ядуурлын дүр төрх” судалгаанаас илэрхий байна.
6. Нийгмийн халамжийн мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, тэдгээрийг энэ ажилд шалгаруулж авах талаар тусгай дүрэм, журам гаргах шаардлагатай болсон гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бодлогын баримт бичиг, судалгаа

1. “Нийгмийн халамжийг сайжруулах нь” Үндэсний семинар, 1993
2. ОУХБайгууллагаас Монгол улсын нийгмийн хангамжийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх талаар гаргасан илтгэл 1992 он
3. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг

4. Төрөөс тэтгэврийн тогтолцоог шинэчлэх талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл
5. Нийгмийн хамгаалал онол-арга зүй туршлага, харьцуулалат 2004 он
6. Дэлхийн банк Үндэсний статистикийн хорооны хамтарсан “Монгол улс дахь ядуурлын дүр төрх

Ном, гарын авлага

1. Ч.Дагвадорж. Нийгмийн хамгаалал: онол-аргазүй, туршлага, харьцуулалт УБ. 2004 он
2. П.Бямбацэрэн, Ч.Дагвадорж. Нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд. УБ. 2000он

Хууль, эрх зүйн баримт бичиг

1. Монгол улсын үндсэн хууль
2. Нийгмийн халамжийн тухай хууль 2005 он.
3. Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль 2007 он.
4. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он.
6. Эх хүүхдэд тэтгэмж олгох, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль 2006 он.
7. Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн тухай хууль 2008 он.

Электрон мэдээллийн эх сурвалж.

1. Yandex.ru – ОХУ
2. Parlament.kz- Казахстан улс
3. WWW.Government.kz
4. WWW.Pravo.by – БНБел Улс
5. Tusuv.mn



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ АСУУДАЛ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)

Т. Мягмаржав

АГУУЛГА

1. Судалгааны зорилго
2. Жендэрийн тэгш байдлыг хангах талаар олон улсын туршлага
 - Япон улс
 - Хятад улс
 - Норвеги улс
 - Австрали улс
 - Дани улс
 - Швед улс
3. Төрийн бус байгууллагууд болон Олон улсын байгууллагуудын зүгээс өгсөн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжүүд
4. Жендэрийн харилцааг хуульчлах шаардлага, үндэслэл
5. Дүгнэлт
6. Хавсралт

* * *

Нэг. Судалгааны зорилго нь:

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн төсөлд шинжилгээ хийх, хуулиар зохицуулж буй харилцаа нь бусад орнуудын хувьд хэрхэн зохицуулагдаж байгааг шинжлэн судлахад чиглэгдэнэ. Судалгааны явцад:

- “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хууль бүхий орнуудын туршлага, /харьцуулсан судалгаа/
- ТББ байгууллага болон Олон улсын байгууллагуудын зүгээс Монгол Улсын жендэрийн тэгш байдлын талаар өгсөн үнэлэлт, зөвлөмжийг нэгтгэн дүгнэх
- Монгол улсын жендэрийн харилцааны өнөөгийн байдал болон тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх зорилт тавьсан болно.

Судалгаанд Жендэрийн асуудалтай холбоотой эрх зүйн асуудал, Олон улсын гэрээ конвенц, тунхаглал, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжуудыг судлан үзэв.

- “Жендэр” гэдгийг Нийгэм дэх эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хоорондын харилцааны асуудлыг жендэр гэж ойлгох бөгөөд энэ нь шинжлэх ухааны шинэ салбар юм.
- “Жендэр” гэдэг нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш бөгөөд энэ нь төр, эдийн засаг болон нийгмийн макро ба микро үйл явц, институцуудтай уялдсан эрэгтэй эмэгтэй хүмүүсийн бүтцийн харилцаа юм.
- “Жендэр” гэдэг нь эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа, нийгмийн үүргийг салгаж ойлгох арга зам юм гэх мэтээр /Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтууд. 2003/ гэсэн номонд бичсэн байна.

Жендэрийн тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэйчүүд хүний эрхээ бүрэн хангуулах тэгш нөхцлийг бүрдүүлэх, үндэсний ба улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс хүртэх, түүнд оролцох тэнцүү боломжтой байх ойлголт. Нийгэм, соёлын бүх хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахын төлөө хүчин чармайлтыг гаргахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш байдал гэж чухам юу вэ гэдэг талаар сонголт хийх, тэгш боломж олгох ёстой бөгөөд тэрхүү тэгш байдлын төлөө хамтран ажиллах ёстой байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримталж байсан нийтлэг үзэл, хандлага манай улсад түүхэн цаг үеийн зорилттой уялдан хөгжсөөр ирсэн. Монгол улсын өнөөгийн төрийн бодлогын үндэс нь 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй” гэж заасан бөгөөд түүнтэй нийцүүлэн хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байна. Одоогоор Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 367 хуулиас 50 орчим хуулинд Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой зохицуулалт хийгдсэн байна. /Хуулийн зохицуулалтыг хавсралтаар/

Монгол улсын хэмжээнд хэрэгжиж буй нийт Үндэсний хөтөлбөрүүдээс Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлыг зохицуулсан “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, “Хүн худалдах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр” гэсэн 4 хөтөлбөр батлагдсан байна

Хоёр. Жендэрийн тэгш байдлыг хангах талаар олон улсын туршлага

Олон улсын жендэрийн хөгжлийн чиг хандлага улам бүр боловсронгуй болж өөрчлөгдсөөр байна. Тухайлбал: 1960-1970 онд эдийн засгийн хөгжил хүн бүрт ашгаа хүртээснээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдал хангагдана гэж үзэж байсан бол 1970-1980 онуудад эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлага, хэрэгцээнд үндэслэсэн бодлого баримталж иржээ. Харин 1980-аад оны сүүлээс аливаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хөрөнгө нөөцийг хуваарилах үйл явцад эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш оролцуулах, түүнд хяналт тавих, ашиг тусыг хүртэх эрх мэдлийг тэнцвэржүүлэх, тэднийг тэгш боломжоор хангах бодлогыг баримтлах болсон байна.

Жендэрийн мэдрэмжтэй бодлогын үр дүнд “эрэгтэй, эмэгтэйчүүд эрхээ эдлэх, хөрөнгө нөөц эзэмших, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хөгжилд идэвхитэй нөлөөлөгч гол хүчин мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, нийгмийн амьдралд оролцох нөхцөл, бололцоог адил тэгш олгосноор аливаа улс орон эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, үр өгөөж бүхий сайн засаглалын чадавхийг бүрдүүлэх боломжтой” гэсэн үзэл баримтлал давамгайлж байна. Үүний нэг жишээ бол НҮБ-ын Дээд хэмжээний чуулга уулзалтаас 2000 оны 9 дүгээр сард баталсан “Мянганы тунхаглал” болон “Мянганы хөгжлийн зорилт”-д жендэрийн хандлагыг аливаа улс орны хөгжлийн стратегийн зорилт болгон тавьсан юм.

Үүнтэй нийцүүлэн УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын мянганы хөгжлийн 2015 он хүртэлх зорилтод “Жендэрийн тэгш байдлыг хангах” явдал томоохон байр суурийг эзэлсэн юм. Олон Улсын хэмжээнд эдүгээ Япон, Хятад Норвеги, Швед, Австрали, Ирланд, Канад, Финлянд, Дани, Өмнөд Солонгос, Вьетнам зэрэг улсад жендэрийн харилцааг бие даасан хуулиар зохицуулж байна. Ийм хуультай байх нь Европын Холбоонд гишүүнээр элсүүлэх шалгуур үзүүлэлтийн нэг болдог. Харин ОХУ -д эрэгтэй, эмэгтэй хүний эрх, эрх чөлөө, тэгш боломжийг хангах төрийн баталгааны тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлж байна.

* * *

Жендерийн тэгш байдлыг хангах тухай бие даасан хуультай орнууд

д/д	Улсын нэр	Хууль батлагдсан он, сар, өдөр	Хуулийн нэр	Хэдэн зүйл заалттай
1	Япон	1999	Жендерийн тэгш эрхт нийгэм бий болгох тухай ерөнхий хууль	Оршил 1 ба нэмэлт 1 бүлэгтэй, үндсэн 3 бүлэгтэй 26 заалт
2	Хятад	1992 2005 онд өөрчилсөн	БНХАУ-ын эмэгтэйчүүдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах тухай хууль	9 бүлэг 61 заалт
3	Австрали	1994	Хүйсээр ялгаварлан гадуурхахын эрсэг хууль	3 бүлэг 48 заалт
4	Дани	2000	Жендерийн тэгш байдлын тухай хууль	7 бүлэг 31 заалт
5	Норвеги	1978	Жендерийн тэгш байдлын тухай хууль	6 бүлэг 54 заалттай

* * *

Япон

- Япон улсад 1999 оноос жендерийн тэгш байдлын тухай суурь хууль үйлчилж байна. Энэ үндсэн хууль нь нийгэм дахь жендерийн эрх тэгш байдлыг бодит үйл хэрэг болгоход чиглэсэн 5 зарчмыг гол болгодог ба төр орон нутгийн удирдлагууд болон иргэдийн үүрэг оролцоог тус тусад нь заасан юм. Жендерийн тэгш байдлыг төрийн механизмыг боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөтгөх зорилгоор 2001 онд Засгийн газрын дэргэд Жендерийн тэгш эрхийн зөвлөл болон жендерийн тэгш эрхийн товчоо тус тус байгуулагдсан. Японы эмэгтэйчүүдийн хувьд чухал өөрчлөлт бол ажил эрхлэлтийн адил тэгш боломжийн тухай хууль зэрэг хүйсийн харилцаа, эрх тэгш байдалд хамаарал бүхий хэд хэдэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж чадсан.
- Олон улсын байгууллагуудын хүчин чармайлтаар, Үндсэн хуулийг хэрэгжүүлэхийн тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх эрхийг эрх тэгш хангахад зориулагдсан ба нийгмийн өөрчлөлтийг даган тэдний болон өндөр настан, хүүхдүүдийн гэх мэт нийгэмд эзлэх эрхийг баталгаажуулах тухай мөн бусад салбарын хуулиудад тусгайлсан тэгш эрхийг хангах тухай хуулиуд бие даан гарсан

Хятад

- Хуулиндаа гол нь эмэгтэй хүнийг хүйсээр ялгаварлан гадуурхахгүй хөдөлмөр эрхлүүлэх, албан тушаалд томилох зэргийг тусгасан байна. Бэлгийн дарангуйлал, ажлын байран дахь бэлгийн дарангуйлалын эсрэг бие даасан хууль байдаг. Эрүүгийн хуулинд хүн ардын жендерийн балансыг хадгалах тухай заалт нэмэлтээр орсон. Хариуцлагын механизмыг тодорхой тусгасан байна. Бүх шатандаа өөрөөр хэлбэл Төрийн Зөвлөл, муж, автономит бүс нутаг болон хотын захиргааны ардын засаглал нь Тэргүүлэх Засаглалын шууд удирдлаган доор зохион байгуулалтын арга хэмжээг авч холбогдох яам газруудын бодлоготой уялдуулан зохицуулж эмэгтэйчүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална гэдэг нь жендерийн харьцааг маш сайн зохицуулж албан тушаалд томилохдоо солбицуулан томилох замаар зохион байгуулдаг байна. / дарга нь эрэгтэй бол дэд дарга нь эмэгтэй гм/
- Бүх-Хятадын Эмэгтэйчүүдийн Холбоо болон бүх шатны эмэгтэйчүүдийн холбоод

нь бүх үндэстэн ястны эмэгтэйчүүдийг төлөөлж, тэдгээрийн эрхийн төлөө үйл ажиллагаагаа явуулахаас гадна эрх ашиг сонирхлыг хамгаалахын төлөө бүхий л хүч бололцоогоо дайчлан мөн Үйлдвэрчний эвлэлүүд, Коммунист Залуучуудын Холбоо байгууллагууд өөрсдийн зохион байгуулж буй ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн эрх ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай бодлого үйл ажиллагаагаа явуулна. Эмэгтэйчүүдийн хууль зүйн эрх ашиг, сонирхлыг хамгаалахад дорвитой амжилт ололт олсон хувь хүн, албан байгууллагыг төр засаг болон холбогдох байгууллага сайшаан магтаж шагнана.

Норвеги

- Норвеги улсад эмэгтэйчүүдийн төлөөллийг төрийн өндөр албан тушаалд хангаж чадсан нь энэхүү хууль батлагдсантай холбоотой. Хууль нь маш сайн хэрэгждэг, хувь хүн, байгууллага, албан тушаалтан хэн ч байсан хуулийг хэрэгжүүлэхийг үүргээ гэж үздэг. Ямар ч байгууллагын албан тушаалтан жилийн эцсийн тайландаа тухайн байгууллагынхаа жендерийн тэгш эрхийг хэрхэн хангасан талаар заавал тусгахыг хуульчилж өгсөн байдаг. Жендерийн тэгш эрхийн хуулийг хэрэгжүүлдэг, хянадаг бие даасан байгууллага болох Омбуд, Немуд, хуулийг иргэддээ сурталчлах, таниулах үүрэгтэй "Жендерийн тэгш эрхийн төв" зэрэг байгууллага ажилладаг. Манай орны онцлогт тохируулаад авч хэрэгжүүлчихмээр оновчтой зохицуулалт их байдаг.
- Хуулийг хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй Омбуд, Немуд зэрэг бие даасан байгууллагыг Норвегийн Засгийн газраас 6 жилийн хугацаатайгаар томилдог, төсвөөс санхүүжүүлдэг. Тэгш эрх нь зөрчигдсөн иргэд Омбудадад өргөдөл гаргадаг. Иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг. Омбуд гомдлыг хүлээн авч 2 талыг зөвшилцүүлж, асуудлыг шийддэг. Омбудын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол иргэн Немудад хандаж болно. Немуд 7 гишүүнтэй. Гишүүдийн 2-ыг үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Ажил олгогчдын холбоо томилдог. Омбуд, Немудад шийдэгдээгүй маргаантай асуудал шүүхэд шилждэг. Гэхдээ ер нь шүүхэд шилжих асуудал ховор, гол төлөв Омбуд, Немудад эцэслэн шийдэгддэг юм байна. Ер нь Омбуд, Немудыг маргааныг шүүхээс гадуур, шүүхийн бус аргаар шийдвэрлэдэг байгууллага гэж ойлгож болно. Германд гэхэд л гэр бүлийн маргааныг зуучийн оролцоотойгоор шийдэхийг илүүд үздэг, энэ нь зохимжтой хувилбар.
- Норвегийн хувьд сонгуулийн систем нь пропорциональ, намууд нь "цахилгаан товч"-ны зарчмаар нэрсийн жагсаалтаа гаргахдаа эрэгтэй, эмэгтэйгээр нь салаавчлуулж бичдэг учраас эмэгтэйчүүд сонгогдох магадлал өндөр байдаг байна. Норвегийн парламентын гишүүдийн 36%, Засгийн газрын гишүүдийн 40% нь эмэгтэйчүүд байна. Батлан хамгаалах яамны сайд нь хүртэл эмэгтэй байна. Парламентын ордон дотор хүүхдийн тэрэгнүүд харагддаг ба ээжүүд нь чуулганд сууж, хүүхдүүд нь цэцэрлэгтээ орчихсон байна. Хүүхдийн тоглоомын газартай болох талаар ч бас ярьж байна. Норвегийн ясли, цэцэрлэг, бага сургууль, хүүхэд хамгаалах байгууллагад ажилладаг эрчүүдэд ажлын нөхцөл, цалингийн хувьд эмэгтэйчүүдээс давуу боломж олгох замаар хүйсийн харьцааг тэнцвэржүүлдэг юм байна. Эцэг эхчүүдийн хувьд хүүхдийнхээ талаар адил эрх, үүрэгтэй байх нөхцлийг бүрдүүлэх үүднээс Норвегид хүүхэдтэй болсон эцэг, эх хоёрт хоёуланд нь цалинтай амралт өгдөг.

Авсрали

- Гэр бүлийн үүрэг, хариуцлага, жирэмслэлт, асрамж, ажил эрхлэлт, өмч хөрөнгийн эрх, байгууллагын гишүүнчлэл болон бусад нийгмийн бүхий л асуудал, салбарт жендэрээр ялгаварлан гадуурхахгүй, ялгаварлан гадуурхах хандлага гаргуулахгүй байх, хүний эрхийг хэрэгжүүлэхдээ шууд буюу шууд бус хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох агуулгатай. Хууль нь маш сайн хэрэгждэг, хувь хүн, байгууллага, албан тушаалтан хэн ч байсан хуулийг хэрэгжүүлэхийг үүргээ гэж үздэг.

Дани

- Жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглох, хариуцлага тооцох, шүүн хэлэлцэх тухай, нийгмийн байдал, хөгжилд эрх тэгш хувь нэмэр оруулах, тэгш боломж эдлэх агуулга бүхий заалтуудтай Жендэрийн тэгш байдлын тухай хуулийг 2000 оны 6-р сарын 1-нд хүчин төгөлдөр болгон баталсан. Хуулиндаа шууд бус ялгаварлан гадуурхах тодорхой заалттай, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох механизм нь сайн хийгдсэн.
- Нийгмийн даатгал, нийгмийн халамжаас ижил хувь хүртэх, ижил цалинтай байх зарчимтай. Хүүхэдтэй болсон эцэг эх хоёрт хоёуланд нь цалинтай чөлөө өгдөг. Жендэрийн тэгш байдлын сайдтай. Жендэрийн чиглэлээр олон нийтийн 8 хороо байгууллагатай. Хорооны гишүүнийг сайд өөрөө томилно. Жендэрийн тэгш байдлын тайлан жилд нэг удаа гаргах заалттай. Салбар салбараа хариуцсан хороодууд жилд 1 удаа тайлан гаргаж сайддаа өгнө. Сайд жил бүрийн 11-р сарын 1-ээс өмнө тайлангуудаа нэгтгэж гаргана. Жендэрийн тэгш байдлын удирдах зөвлөлийг 3 жилийн хугацаатай сайд өөрөө томилно. Удирдах зөвлөлийн тэргүүн нь мэргэжлийн шүүгч байна.Бусад гишүүд нь хуулийн мастер зэргээс дээгүүр зэрэгтэй, үйлдвэрлэлийн харилцааны талаар зохих мэдлэгтэй хүмүүс байх хуулийн заалттай.
- Удирдах зөвлөлийн дүрэм, журмыг сайд баталдаг. Удирдах зөвлөлийн ажлыг сайдын нарийн бичгийн дарга үндсэндээ хариуцаж ажилладаг. Хуулийн дагуу удирдах зөвлөлд урамшуулал олгодог. Удирдах зөвлөл санал гомдол хүлээн авна. Өөр байгууллагын чиглэлээр гаргасан санал гомдлыг авахгүй, шүүхэд өгсөн гомдлыг авахгүй, удирдах зөвлөлд өгсөн гомдол, саналыг шүүхэд өгөхгүй гэсэн заалтуудтай юм байна. Удирдах зөвлөл жилд 1 удаа тайлан гаргаж өгнө. Энэ хууль батлагдсанаар: Боловсрол болон ажил мэргэжлийн зааварчилгааны тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Данийн захирагааны хэргийн шүүхийн тухай хууль зэрэг олон хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон байна.

Швед

- НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллагад элссэнээр жил бүр тайлан бичдэг. Парламентэд хөдөлмөрийн байнгын хороо нь маш өндөр үүрэгтэй. Парламентэд 47 хувь нь эмэгтэйчүүд байна. Тэд парламентэд орохдоо ямар нэгэн квотоор орж ирдэггүй. Парламентын даргын дэргэд Жендэрийн тэгш байдлын комисс байна. Нам болгоноос 1 гишүүн ордог. Өөрөөр хэлбэл зөвлөх групп. Жендэрийн тэгш байдлыг хангахад бас нэгэн чухал үүрэгтэй хууль бол гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль юм. Шведэд эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагад төрөөс мөнгө өгч дэмжлэг үзүүлдэг. Парламентын даргын дэргэд мэргэжлийн ажилтан /зөвлөгч/ ажилладаг. Европын холбоонд элсэхийн тулд заавал ийм хуультай байх ёстой гэсэн заавар, журам байдаг. Шведэд хөдөлмөрийн зах зээл дээр эмэгтэйчүүд олноороо ажил хийж байна. Гэхдээ эмэгтэйчүүд хагас цагаар давамгайлсан салбарт илүү олноороо ажиллаж байна.

№	Улс	Авах санаа
1	Норвеги	1. Хуулийг хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй Омбуд, Немуд зэрэг бие даасан байгууллагыг Норвегийн Засгийн газраас 6 жилийн хугацаатайгаар томилдог, төсвөөс санхүүжүүлдэг.Хяналтын байгууллага 2. Норвегийн хувьд сонгуулийн систем нь пропорциональ, намууд нь “цахилгаан товч”-ны зарчмаар нэрсийн жагсаалтаа гаргахдаа эрэгтэй, эмэгтэйгээр нь салаавчлуулж бичдэг 3. Хүүхэдтэй болсон эцэг эхэд хоёуланд нь цалинтай амралт өгдөг.

2	Швед	1. Парламентын даргын дэргэд “Жендэрийн тэгш байдлын комисс” байна. Нам болгоноос 1 гишүүн ордог.
3	Хятад	1. Жендэрийн харьцааг маш сайн зохицуулж албан тушаалд томилохдоо солбицуулан томилох замаар зохион байгуулдаг байна. / дарга нь эрэгтэй бол дэд дарга нь эмэгтэй гм/
4	Дани	1. Жендэрийн тэгш байдлын сайдтай 2. Жендэрийн тэгш байдлын удирдах зөвлөлийг 3 жилийн хугацаатай сайд өөрөө томилно.

Гурав. ТББ -ууд болон ОУ-ын байгууллагуудын зүгээс өгсөн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжүүд

Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагын зүгээс жендэрийн тэгш байдлыг хангах гурван багц стратегийг хэрэгжүүлэхийг зөвлөдөг болсон байна. Үүнд:

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх, боломжийг хангах чиглэлээр байгууллагын бүтцийг шинэчлэн өөрчлөх (үндсэн эрх дэх тэгш байдлыг хангах, жендэрээр ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээг тэгш хүртээмтэй хөгжүүлэх);
- Хөрөнгө нөөцийг тэгш хуваарилах, тэгш оролцоог хангахад эдийн засгийн хөгжлийг чиглүүлэх;
- Хөрөнгө нөөцийн эрх мэдэл, улс төрийн оролцоон дахь жендэрийн тэнцвэртэй байдлыг хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна.

Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангах талаар олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагуудын идэвхи санаачилгаар эхлэн хийгдсээр 10 гаруй жил өнгөрсөн ба Засгийн газрын бүтцийн доторхи Жендэрийн Тэгш Байдлын Үндэсний Хороо байгуулагдан эндэрийн тэгш байдлын шинэ хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлсэн нь нийгэм эдийн засгийн бүх салбарт жендэрийн үзэл баримтлалыг үйл хэрэг болгох албан тогтолцоог үүсгэсэн. Өнөөдрийн байдлаар манай оронд Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай ойлголтыг нийгмийн оюун санаанд бэхжүүлэх, хүргэх зорилгоор олон улсын болон Төрийн бус 30 гаруй байгууллагууд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Тэдний үзэж буйгаар:

- Үйл ажиллагаанууд нь голдуу сургалт сурталчилгааны чиглэлтэй байдаг ч тодорхой үр дүнд хүрч байна.
- Олон улсын гэрээгээр баталгаажуулсан хөдөлмөр эрхлэлтэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш зарчмыг хэрэгжүүлэхэд жирэмсний болон хүүхэд асарсны чөлөө авсан, нөхөн үржихүйн үйл ажиллагааны улмаас өвдөж, ажлаасаа хөндийрсөн эмэгтэйчүүдийг сургах, давтан сургах тухай хууль эрх зүйн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид бий болгох шаардлагатай.
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хэрэгжилт удаашралтай, бодитой үр дүн гарахгүй байгаа бөгөөд үүний шалгааныг үндэсний түвшинд хамтран ажиллах чадваргүй сул тогтолцоо, хөгжлийн бус чиг баримжаатай төсөвтэй холбон тайлбарлаж байна.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаатай хэрэгцээ, сонирхол, үүрэг, нөөцтэйгийн адилаар тэдгээрийн бодлого болон төсөлд нэвтрэх боломж нь мөн ялгаатай байдаг гэж үзэж байна.
- Монгол улс социалист хөгжлийн баримжаатай үедээ эмэгтэйчүүд парламентийн

гишүүдийн 24 хувиас доошгүй хувийг эзлэх тухай эрх баригч улс төрийн намын квотыг баримталж хэрэгжүүлж байсан. Харин ардчилсан улс болж хүний эрхийг дээдэлж байгаа сүүлийн жилүүдэд түүнчлэн нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх тухай Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг 2007 оны сонгууль болох босгон дээр хүчингүй болгосон нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 4 дүгээр зүйлд заасан эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш эрхийг түргэтгэхэд чиглэсэн тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхээс ухарсан явдал боллоо гэж үзэн байна.

Дөрөв. Жендэрийн харилцааг хуульчлах шаардлага, үндэслэл:

Манай орны нийт хүн амын 50.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд хүн амын 58.3 хувь, нийт ажиллагсдын 51.7 хувийг бүрдүүлж байна үүнээс боловсролтой эмэгтэйчүүд 70 орчим хувь, гүйцэтгэх ажилтнуудын 60,9 хувь, туслах ажилтны 53,8 хувь, үйлчилгээний ажилтны 54,6 хувийг тус тус эзэлж байгаа хэдий ч албан тушаалын зэрэглэл ахих тусам эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурч байна. Нийт албан тушаалтнуудын 63,9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Эндээс харахад эрх мэдэл, цалин хөлс, хангамж нь жендэрийн хувьд ялгаатай хуваарилагдаж байгаа нь ажиглагдаж байна. Эрэгтэйчүүдийн өвчлөл нийт хүн амын 60 гаруй хувийг нас баралт залуужин, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа зэрэг нь мөн л жендэрийн харьцааг алдагдуулж байна.

2005-2008 онуудад байгууллагуудын ажилагсдын цалиндунджаар 32.8 хувиар өссөн хэдий ч өндөр цалинтай байгууллагуудад ажиллаж буй эрэгтэйчүүдийн цалин эмэгтэйчүүдийн цалингаас илүү өссөн байна. Жишээ нь удирдах ажилтан эрэгтэйчдийн цалин мөн адил эмэгтэйчүүдийнхээс 22.8 хувиар илүү, ижилхэн инженер техникийн ажилтнууд ч эмэгтэй ажилтангуудаас 45.4 хувиар илүү цалин авдаг өссөн үзүүлэлт байна.

Өндөр настан, өвчтэй хүн асрахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 5 дахин илүү цаг, гэр бүлдээ эрэгтэйчүүдээс мөн 2 дахин илүү цаг зарцуулж байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог парламентад эзэлсэн суудлын тоогоор харьцуулсан үзүүлэлтээр 187 орноос Монгол улс 115-р байр эзэлсэн ба 2008 онд 76 суудалтай парламентад 3 эмэгтэй сонгогдож 3.4 хувийн төлөөллийг бүрдүүлсэн нь олон улсын парламентын дунджаас даруй 2.6 дахин бага байна.

Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн халамжийн тэтгэврийг 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 нас хүрсэн эх, /50 хүрсэн эцэг/ авч болох бөгөөд мөн л адил насны эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд насны явгавартай хандсан байна. Хөдөлмөрийн тухай хуульд хүүхдээ асарч байгаа эх, эцэгт хөнгөлөлт үзүүлэх тухай заалт эрэгтэй хүний хувьд зөвхөн эхнэргүй, ганц бие эрэгтэйд хөнгөлөлт үзүүлэхээр заасан нь нийгэмд байдаг эмэгтэй хүн л гэрийн ажил хийж хүүхдээ асарч хүмүүжүүлэх ёстой гэсэн тэгш бус хандлагыг хуулиар хүлээн зөвшөөрсөн агуулгатай адил юм гм олон зүйл заалтууд зөрчигдөж байгаа нь бие даасан хуультай болох шаардлагатайг харуулж байна.

Дэлхийн 40 гаруй орон хуулиар квотын систем тогтоогоод байна. Квот гэдэг нь хүйсийн төлөөллийн доод хязгаарын хэмжээ буюу квот нь сонгууль болон томилгоот албан тушаалын бүх түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувийн доод хязгаарыг тогтоосон тэгш оролцоог ханган, баталгаажуулах аргачлал юм. Хуулиар тогтоосон квотын системийн ачаар Иордани, Марокко, Судан, Танзани, Афганистан, Армени, Бангладеш, Индонези, Ардчилсан Солонгос, Балба, Пакистан, Франц, Ирак зэрэг орнууд шашин соёлын уламжлалаа хөгжлийн цаг үетэй зохицуулан шинэчилж байна. 2005 онд Шведийн парламентын 45%, Финляндын 38%, Данийн 37%, Норвегийн 36%, Исландын 30%-ийг эмэгтэйчүүд эзэлж байжээ.

Монгол улсын хувьд авч үзвэл: УИХ-ын 1992, 1996, 2000, 2004, 2008 оны сонгуулийн дүнгээс сонгогдсон эмэгтэй гишүүдийг нэр дэвшсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь байнга өсч, харин сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь буурсан байна.

Хууль тогтоох засаглал дахь жендэрийн харьцаа (1992, 1996, 2000, 2004, 2008)

Онууд	УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид		УИХ-д сонгогдсон гишүүд	
	Нийт	Үүнээс эмэгтэй	Нийт	Үүнээс эмэгтэй
1992	298	23	76	3
1996	302	28	76	7
2000	603	66	76	9
2004	249	33	76	5
2008	356	66	76	3

Тав. Дүгнэлт

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад эрэгтэй эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах талаар тодорхой хэмжээгээр тусгаж хэрэгжүүлж байгаа боловч энэ нь ихэвчлэн тунхаглалын шинжтэй байна.
2. Хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн тэгш байдал Монгол Улсад хангагдаагүй, хянах тогтолцоо сулаас хууль эрх зүйгээр баталгаажуулсан эрхүүд зөрчигдөж байдаг, амьжиргааны баталгаа орхигдсон нийгмийн эрүүл мэндийн хамгаалал сул, эмэгтэйчүүдийн орлогын хувь хэмжээ эрэгтэйчүүдийнхээс ялгавартай /доогуур/, нийгэмд тэр дундаа өрх толгойлсон эмэгтэйчүүд ихээр өртөж байгаа зэрэг нь эрэгтэй эмэгтэйчүүд тэгш эрхтэй, эрх чөлөөтэй ба тэгш боломжтой байх зарчмыг алдагдуулж байна.
3. Эдийн засаг, нийгэм, соёл, улс төр, гэр бүлийн зэрэг бүхий л салбарыг зохицуулж буй хуулиндаа жендэрийн тэгш байдал, нас хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг тодорхой хэмжээгээр тусгасан хэдий ч жендэрийн ялгаварлан гадуурхалтын улмаас үүссэн маргаан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг тодорхойлоогүй байгаа нь бие даасан хууль боловсруулах шаардлагыг бий болгож байна.
4. УИХ-д өргөн барьсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн төслийн бүтэц, агуулганд
 - Үндсэн хуулийн харилцаа
 - Хөдөлмөрийн харилцаа
 - Нийгмийн халамж үйлчилгээ
 - Гэр бүлийн харилцаа
 - Эрүүгийн эрх зүйн харилцаа
 - Иргэний эрх зүйн харилцаа

Улс төрийн харилцааны талаар тодорхой тусгасан нь гадаадын ийм төрлийн хуультай

орнуудын хуулийн үндсэн зарчим, агуулгатай ерөнхийдөө нийцэж буй.

5. Эрэгтэй эмэгтэй хүн тэгш эрхтэй, тэнцүү үүрэгтэй байхын зэрэгцээ энэхүү эрх үүргээ хэрэгжүүлэх боломж нь адил байхыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байна. Ялангуяа Зүүн Азийн орнуудын ихэнх нь Жендэрийн харилцааг зохицуулсан тусгай багц хуультай болсон байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Парламент дахь Эмэгтэйчүүд, /тоо ба агуулга/
2. Жендэрийн сургалтын модуль, УБ хот 2006 он
3. Яагаад үгүй гэж?, УБ хот 2006 он
4. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, УБ хот 2007 он
5. Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлаас хойш 10 жилд монгол улс, 2004 он
6. /Хүйсийн тэгш байдал, тэгш эрхийг хангаж, эмэгтэйчүүдийг чадавхижуулах нь/
7. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаархи монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ -ын холбогдох ороодын хуралдааны тэмдэглэл, зөвлөмжүүдийн эмхтгэл, УБ хот 2004 он
8. Жендэрийн асуудал, УБ хот 2007 он
9. Монголын төрийн бус байгууллагуудын лавлах, УБ хот 2003 он
10. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /ЗГ-274/, УБ хот 2002 он

* * *

Хавсралт

Жендэрийн харилцааны асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан байдал /лавлагаа, мэдээлэл/

№ - Хуулийн нэр	Холбогдох заалт
-----------------	-----------------

1. Үндсэн хууль
 - 1.2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.
 - 14.1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна.
 - 14.2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.
 - 16.11/ Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрыны тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.
2. Хөдөлмөрийн тухай хууль /1999 оны 05 дугаар сарын 14/
 - 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй,

- нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.
- 7.4-ийн “Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харъяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй”
 - 35.1.Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг дараахь тохиолдолд хэвээр хадгална.
 - 35.1.4.Жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа.
 - 35.1.6.Цэргийн зарлан дуудах хуудас авсан ажилтныг цэргийн жинхэнэ албанд татсан тухай цэрэг татлагын комиссын шийдвэр гартал.
 - 37.1.Хөдөлмөрийн гэрээ дараахь үндэслэлээр дуусгавар болно.
 - 37.1.6.Ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсан.
 - 40.1.Хөдөлмөрийн гэрээг дараахь үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцалж болно.
 - 40.1.3.ажилтан 60 нас хүрчү өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн.
 - 49.2.Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно.
 - 68.1.Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүнийг энэ хуулийн 107.1-д зааснаар эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн хугацаанд алин хөлс нь буурсан бол түүний урьд авч байсан болон одоо авч байгаа цалин хөлсний зөрүүтэй тэнцэх олговор олгоно.
 - 100.1.Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон энэ хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно.
 - 100.2.Энэ хуулийн 100.1 нь гурав хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.
 - 101.1.Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.
 - 102.1.Жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдол шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглоно.
 - 102.2.Энэ хуулийн 102.1 нь 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.
 - 103.1.Амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно.
 - 103.2.Энэ хуулийн 103.1 нь ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.
 - 103.3.Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажилласан цагт оруулан тооцно.
 - 104.1.Эхэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгоно.
 - 104.2.Хүүхдээ 196, түүнээс дээш хоног тээгээд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар атсалсан, 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эмэгтэй хүнд энэ хуулийн 104.1-д заасан жирэмсний болон амаржсаны амралт олгоно.
 - 104.3.Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн,

жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан эмэгтэй хүнд өвчний учир чөлөөлөх ердийн журмыг баримтлан ажлаас чөлөө олгоно.

- 107.1.Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно.
 - 108.1.Хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнээс илүү хүнд ачааг эмэгтэй хүнээр өргүүлэх, зөөлгөхийг хориглоно.
 - 141.1.3.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, эрэгтэй, эмэгтэй, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварласан, хязгаарласан, давуу байдал тогтоосон, иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлогтой холбоогүйгээр ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан болон албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох,
 - 141.1.6.эмэгтэй болон насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил гүйцэтгүүлсэн, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг хэвийн бус нөхцөлтэй болон түүний оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах ажлын байранд, эсхүл амралтын өдөр, шөнө буюу илүү цагаар ажиллуулсан, ажилтныг энэ хуулийн 47 дүгээр зүйлийн заалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан албан тушаалтныг 15000-30000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох,
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001 оны 04 сарын 19/
- 4.2.1.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах,
 - 4.2.2.хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь адил тэгш, хүртээмжтэй, ажлын байрны мэдээлэл нээлттэй, ил тод байх нөхцөл бүрдүүлэх,
4. Цацрагийн хамгаалалт аюулгүй байдлын тухай хууль /2001 оны 06 сарын 21/
- 22.6.Шаардлагатай бол цацрагтай ажилладаг жирэмсэн эмэгтэй Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлд заасны дагуу ажлын нөхцлөө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ нь түүнийг ажлаас халах үндэслэл болохгүй
5. Төрийн албаны тухай хууль /2002 оны 06 сарын 28/
- 16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харъяалал зэргээр ялгаварлаж үл болно.
 - 23.3.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар төрийн албанаас түр чөлөөлнө.
 - 23.3.1.Хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон.
 - 23.3.2.Гурван сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон.
 - 23.3.3.Цэргийн жинхэнэ алба хаах болсон.
6. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай /1991 оны 04 сарын 19/
- 3 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх. 1. Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах

зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр үйлдвэрчний эвлэлд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй

7. Авлигын ту хай хууль /2006 оны 07 сарын 06/

- 21.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.
- 21.2.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргад нэр дэвшигчэнэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна.
- 21.2.1.Авлигатай тэмцэх газрын даргад нэр дэвшигч нь төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 55 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.

8. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль /2006 оны 05 сарын 26/

- 13.5.Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйг химийн хорт болон аюултай бодистой харьцах ажилд ажиллуулахыг хориглоно.

9. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай /1994 оны 6 сарын 07/

- 2. Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна.
- 2.2/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж,
- 3.Төр, аж ахуйн нэгж, байгууллагаас дараахь хугацааны шимтгэлийг тэтгэвэрийн болон тэтгэмжийн даатгалын санд төлсөн тохиолдолд эдгээр хугацааг шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.
- 3.3/ тэтгэмжтэй чөлөө авч хүүхдээ асарсан хугацаа;
- 4.1. Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 насхүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.
- 4.2.Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- 4.3.Газрын дор болон хөдөлмөрийн халуун нөхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан болзлыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- 4.3.1/ нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол;
- 4.3.2/ нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн халуун нөхцөлд ажиллаж, тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол,
- 4.5. Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.
- 12.1.4/ эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл тахир дутуу болсон эцэг эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;
- 17.2.Хүүхдээ 196 хоног хүртэл тэгээгүй дутуу төрүлсэн буюу үр хөндүүлсэн

- эмэгтэйчүүд /даатгуулагч/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.
- 19.1.Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амарсжаны тэтгэмж авах эрхтэй.
 - 19.2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амарсжаны тэтгэмж авах эрхтэй.
 - 19.3.Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амарсжаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн чөлөөтэй байсан хугацааны хоёр удаагийн төрөлт хамаарагдана.
9. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай /1994 оны 06 сарын 13/
- 3.1.Цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна.
 - 1/Цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан тэтгэвэр,
 - 2/тахир дутуугийн тэтгэвэр,
 - 3/тэжээгчээ алдсаны тэтгэвэр,
 - 3.2.Цэргийн тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна.
 - 1/хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж,
 - 2/оршуулгын тэтгэмж,
 - 3/ нэг удаагийн тэтгэмж,
 - 8.1.Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагад 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй.20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-иос доошгүй жил алба хаасан генерал, офицер, ахлагч, байлдагч нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгээр тогтоогон авах эрхтэй.
 - 8.2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг хангаагүй боловч 10-аас доошгүй жил цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан цэргийн албан хаагч дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй:
 - 1/ орон тоо,, зохион байгуулалтын өөрчлөлтөөр,
 - 2/ биеийн эрүүл мэндээр,
 - 3/цэргийн алба хаах нас хэтэрч.
 - 15.2.Цэргийн албан хаагч эмэгтэй хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.
 - 19.1.Цэргийн албан хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-иос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад тэдний ажиллаж байсан нөхцөл, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдлыг харгалзан 18-37 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.
 - 12.3.Цэргийн албан хаагч /байлдагч, түрүүчээс бусад/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаанаар тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол сарын дундаж цалин хөлсний 60 хувиар тахир

дутуугийн тэтгэвэр тогтоож, 20-иос илүү албан хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон сарын дундаж цалин хөлсний 1,0 хувиар тэтгэврийн нэмэгдэл олгоно. Хэрэв хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан бол сарын дундаж цалин х өлсний 60 хувьд ногдох хэсгээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар бодож тахир дутаагийн тэтгэвэр тогтооно.

10. Тэтгэвэрийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай /1999 оны 06 сарын 10/
- 7.1.Дор дурьдсан болзол хангасан даатгуулагч нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.
 - 7.1.2.60 нас хүрсэн даатгуулагч, эсхүл 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл,
12. Нийгмийн халамжийн тухай /2005 оны 12 сарын 01/
- 4.1.Хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монго Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршинс уудаг гадаадын иргэн, харъяалалгүй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олон нийтийн ролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй.
 - 17.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр дараахь төрөлтэй байна.
 - 17.1.3.Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр.
 - 18.1.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дор дурдсан иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй.
 - 18.1.1.Тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй.,
 - 18.1.2.хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон бол нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй.
 - 18.1.5.16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүхэдтэй, нэн ядуу амьдралтай өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.
13. Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд,э х, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх /2005 оны 05 сарын 05/
- 4.4. Эх жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам тэтгэмж авах эрхтэй.
 - 4.5."Эхийн алдар" нэг, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эх жилд нэг удаа мөнгөн тусламж давхардуулахгүйгээр авах эрхтэй.
14. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай /2005 оны 12 сарын 08/
- 3.1.60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн энэ хуульд хамрагдана.
15. Төмөр замын тээврийн тухай /2007 оны 07 сарын 05/
- 31.1.1.Төмөр замын байгууллагад тсралтгүй 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй төмөр замын байгууллагаас тэтгэвэр тогтоолгосон бол зургаан сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авана
16. Прокурорын байгууллагын тухай /2007 оны 07 сарын 04/
- 35.7.Прокурорын тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 60 нас байна. 55 насанд

хүрсэн эмэгтэй прокурор өөрийн хүсэлтээр тэтгэвэрээ тогтоолгох эрхтэй.

17. Шүүхийн тухай /2002 оны 07 сарын 04/

- 8.1. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
- 57.1.Шүүгч дараах үндэслэлээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар шүүн таслах ажил эрхлэх боломжгүй бол бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ.
- 57.1.1. Эрдэм шинжилгээний бүтээл туурвих, эрдмийн цол зэрэг хамгаалах
- 57.1.2.удаан хугацааны сургалтанд хамрагдах,
- 57.1.3..удаан хугацаагаар өвчлөх, гачигдал гарах
- 57.1.4.цэргийн жинхэнэ албанд татагдах
- 57.1.5.эрүүгийн хариуцлагад татагдах
- 8.2.Тавин насанд хүрсэн эмэгтэй шүүгч өөрөө хүсвэл тэтгэвэрээ тогтоолгож болно.

18. Монгол улсын Засгийн газрын тухай /1993 оны 05 сарын 06/

- 5 дугаар зүйл. Засгийн газрын үйл ажиллагааны зарчим.
- 1.Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилалсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.
- 9 дүгээр зүйл. Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх
- 5. Хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

19. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэвэрийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай /1957 оны 04 сарын 03/

- 1."Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одлон, "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонг тус тус бий болгосугай.
- 2.8 ба түүнээс дээш хүүхэд төрүүлэн өсгөсөн эхэд "Эхийн алад" нэгдүгээр зэргийн одон, 5-8 хүртэл хүүхэд төрүүлэн өсгөсөн эхэд "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонг шагналын хамт тус тус олгож байхаар тогтоосугай.

20. Гэр бүлийн тухай хууль /1999 оны 06 сарын 19/

- 3.1.1."Гэрлэлт" гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг,
- 3.1.3."гэрлэгчид" гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг,
- 4.2.Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 6.2. Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна.
- 10.1.Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.
- 10.2.Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл

санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах тэгш эрхтэй.

- 0.3.Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээнэ.
- 12.2.Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно.
- 26.1.Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.
- 36.1.Гэрлэгчдийн хэн нэг нь хүүхэд үрчлэн авч байгаа бол энэ тухай зөвшөөрлийг эхнэр буюу нөхрөөсөө авна.

21. Эрүүгийн хууль /2002 оны 01 сарын 03/

- 5.1.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- 50.4.Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй.
- 51.3.Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, баг насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй
- 52.3.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй.
- 52.5.Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.
- 52.6.Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.
- 52.8.Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.
- 53.4.Арван найсан насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.
- 55.1.Шүүх ял оногдуулахдаа дор дурдсан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- 55.1.8.Жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн.
- 56.1.Шүүх ял оногдуулахдаа зөвхөн дор дурдсан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- 56.1.6.Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, бие хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн,
- 63.1.Шүүх анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял

оногдуулан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

- 91.2.14.Хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.
- 108.2.8.Насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж хулгайлсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 109.1.Хүнийг хууль бусаар хорьсон нь энэ хуульд заасан албан тушаалын болон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, түүнчлэн хүн хулгайлах, барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 112.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан болтаван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 112.2.8.Насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 125.1.Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж лбуюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 127.1.Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлсэн бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

22. Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002 оны 01 сарын 10/

- 14.1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
- 68.8.Энэ хуулийн 68.2-т заасан үндэслэлийн аль нэг нь байвал жирэмсэн эмэгтэйг эмнэлгийн байгууллагын хяналтан дор цагдан хорьж болно.
- 68.9.Хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй этгээд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд энэ хуулийн 68.2-т заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хориглоно.
- 74.3.14.Насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэйг, хүнд өвчний учир ирж чадахгүй этгээдийг албадан ирүүлэхийг хориглоно.
- 332.1.2.Ялтан жирэмсэн бол төрөхөөс өмнө 45 хоног, төрснөөс хойш 1 жилээс илүүгүйгээр албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хориглоно.

23. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002 оны 01 сарын 10/

- 104.2.Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтан болон жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан бол түүнийг гүйцэтгэхэд энэ хуулийн 102, 103 дугаар зүйлд заасан журмыг нэгэн адил баримтална.
- 111.1.Эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлнэ.
- 111.2.Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.
- 111.3.Эмэгтэй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд

удаан хугацааны уулзалтыг жилд найман удаа хийж болно.

- 111.4.Эмэгтэй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард нэг удаа илгээмж авч болно.
- 111.5.Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно.
- 111.6.Энэ хуулийн 111.5-д заасны дагуу хорих анги нь эхийн хамт байгаа 0-1 насны хүүхдийг эрүүл мэнд өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.
- 108.1.Чанга дэглэмтэй хорих ангийн ялтан нь 2 сард нэг удаа түр, 3 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, сард нэг удаа илгээмж авч болно.
- 116.1.Ялтны хорих ял эдлэх ангийн төрөл, дэглэмийг шүүх тогтооно.
- 116.2.Насанд хүрээгүй болон эмэгтэй ялтны ялыг жирийн, чанга дэглэмтэй хорих анги, насанд хүрсэн эрэгтэй ялтны ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд тус тус эдлүүлнэ.
- 127.2.Насанд хүрсэн эрэгтэй ялтныг 30 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэй ялтныг 60 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 30 хүртэл хоног сахилгын байранд хорино.

24. Өршөөл үзүүлэх тухай /2000 оны 07 сарын 10/

- 1.2.Арван дөрвөн насанд хүрээгүй гурав ба түүнээс дээш хүүхэдтэй хүмүүс буюу гурав хүртэл насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдийг шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ.
- 4.1.3.Өөрийн шууд асрамжид байгаа арван найм хүртэл насны хагас өнчин хүүхэдтэй эрэгтэйчүүдийг шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ.
- 1.5.Жараас дээш насны эрэгтэйчүүд, тавин таваас дээш насны эмэгтэйчүүдийг шүүхээс оногдуулсан ялын хугацааг харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ.

25. Согтууруулах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай /2000 оны 1 сарын 28/

- 3.4.Насанд хүрээгүй, эсхүл 60-аас дээш настай эрэгтэй, 55-аас дээш настай эмэгтэй, 16 насанд хүрээгүй хүмүүс түүнчлэн жирэмсэн эмэгтэйчүүдийг албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

26. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай /1999 оны 07 сарын 01/

- 5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.
- 30.1.Хоригдож байгаа жирэмсэн эмэгтэйг аахуйн нөхцөлийн хувьд сайжруулсан байранд байрлуулж, эмчийн хяналтад байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 30.2.Жирэмсэн эмэгтэйн өдөр тутмын салхинд гарах хугацаа нэг цаг ба түүнээс дээш байна.
- 30.3.Жирэмсэн эмэгтэйг сахилгын байранд хорьж болохгүй.

- 32.2.Дараахь этгээдийг бусад сэжигтэн, яллагдагчаас тусгаарлан хорино.
 - 32.2.2.Эмэгтэйчүүд
27. Гүйцэтгэх ажлын тухай /1998 оны 12 сарын 19/
- 4.Гүйцэтгэх ажилд үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах зарчмыг удирдлага болгоно.
 - 5.Хувь хүний иргэний харъяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын б айдаль нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад саад болохгүй.
 - 14.1.Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн нь зөвшөөрснөөс иргэний харъяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.
28. Иргэний хууль /2002 оны 01 сарын 10/
- 126.4.Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ.
 - 128.1.Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж ашиглаж, захиран зарцуулна.
 - 29.5.Гэр бүлийн гишүүн нь цэргийн жинхэнэ алба хаах, сургуульд суралцах, удаан хугацаагаар өвчлөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бүрэлдэхэд хөдөлмөрөөр буюу хөрөнгөөрөө оролцож чадаагүй бол энэ хуулийн 129.4 дэх хэсэг хамаарахгүй.
 - 520.1.Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвчлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй.
 - 520.1.1.Нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх,
 - 520.1.2.Энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ,
 - 522.3.Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойной төрсөн хүүхэд, түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно.
 - 508.3.Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөөгөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдсаны тэтгэврийг хасна.
 - 508.4.Гэм хор учруулсны төлбөрийг дор дурдсан хугацаанд нөхөн төлнө.
 - 508.4.2.Тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд бүх насаар нь төлнө.

29. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай
- 4.1-д “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.
30. Өмч хувьчлах тухай /1991 оны 05 сарын 22/
- 4.1.Төрийн хувьчлагдах эд хөрөнгийг Монгол Улсын иргэн бүр энэ хууль болон Монгол улсын бусад хуульд заасан бүх арга хэлбэрийн дагуу өмчлөх адил тэгш эрхтэй.
31. Ерөнхийлөгчийн сонгуулийн туахй /1993 оны 02 сарын 15/
- 3. Анхан шатны сонгууль бүх нийтийн байна. Санал хураах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.
32. Улс төрийн намын ту хай /2005 оны 01 сарын 25/
- 5.1.3. Гишүүдээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох
33. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /2005 оны 12 сарын 29/
- 6.1. Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгуульд оролцож, саналаа өгөх эрхтэй.
 - 28.2.Нам, эсвлээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.
 - 31.1. Энэ хуулийн 30.12, 30.13-т заасны дагуу бүртгэгдэж, үнэмлэх авсан бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах, эсхүл нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчийг татан гаргах, түүний оронд өөр хүний нэр дэвшүүлэх эрхтэй.
34. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тухай /1996 оны 08 сарын 27/
- 3.2. Санал авах өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа Монгол Улсын 18 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.
35. Ард нийтийн санал асуулгын тухай /1995 оны 10 сарын 19/
- 3.2.Санал ава хөдөр эх орондоо байгаа 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэжл байгаа хүн санал асуулгад оролцохгүй.

36. Онц байдлын тухай хууль /1995 оны 11 сарын 14/

- 17.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээлсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
- 18.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоох хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг үл хөндөнө.

37. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай /1996 оны 05 сарын 7

- 4.1.Хүүхдийн болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал,байдал, төрсөн газар, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах.

38. Ой хээрийг түймрээс хамгаалах тухай /1996 оны 05 сарын 28/

- 10.2.Түймэртэй тэмцэх дайчилгаанд 16 нас хүрээгүй хүн, 60 -аас дээш насны эрэгтэй, 55 -аас дээш насны эмэгтэй хүн, тахир дутуу болон архаг өвчтэй хүн, жирэмсэн эмэгтэй, асрамжлах хүнгүй, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй хүн, байнгын тасралтгүй ажиллагаатай /эмнэлэг, холбоо зэрэг/ газрын ээлжийн ажилтан хамрагдахгүй

39. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай /1998 оны 01 сарын 28/

- 5.2.Хүн амын амьжиргааны доод түвшинг хүн амын нас, хүйсийн ангиллаар тодорхойлно.

40. Эрүүл мэндийн тухай /1998 оны 05 сарын 07/

- 4.1.2.Иргэдэдэрүүлмэндийнанханшатнытусламжийгялгаварлангадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

41. Дайны байдлын тухай /1998 оны 05 сарын 05/

- 26.1.Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно.

42. Донорын тухай /2000 оны 01 сарын 28/

- 4.3.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно”.
- 7.1.Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр иргэн эрүүл мэндээ сайжруулах, амь насаа аврах, гоо сайхныхаа хэрэгцээг хангах зорилгоор донорын цус сэлбүүлэх, эд эрхтэн шилжүүлэн суулгуулах ажилбарыг хийлгүүлж болно.

43. Дархлаажуулалтын тухай /2000 оны 04 сарын 20/

- 4.1.Энэ хууль нь нийт иргэн болон хуулийн этгээдэд үйлчилнэ.

44. Зар сурталчилгааны тухай /2002 оны 05 сарын 30/

- 7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.
- 7.1.5.Үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан.

45. Гамшгаас хамгаалах ту хай /2003 оны 06 сарын 20/

- 20.2.Мэргэжлийн ангийг Монгол Улсын харъяат, хөдөлмөрийн чадвартай, 16-60 хүртэлх насны эрэгтэй, 16-55 хүртэлх насны эмэгтэйчүүдээс бүрдүүлэн байгуулна. Энэ заалтад цэргийн алба хаагч, тахир дутуу хүн, жирэмсэн эмэгтэй, асрамжлах хүнгүй, сургуулийн өмнөх насны хүүхэдтэй хүмүүс хамаарахгүй

46. Боловсролын тухай /2002 оны 05 сарын 30/

- 5.1.4.Иргэнийг сурч боловсролход үндэс угсаа, хэл, арсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана.

47. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай /1992 оны 05 сарын 04/

- 2.2.Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.
- 3 дугаар зүйл. Цэргийн алба. 2.Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ. Цэргийн жинхэнэ алба нь байлдагч, түрүүчийн алба, ахлагчийн болон офицерийн албанаас бүрдэнэ. Харин цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд сайн дураараа офицер, ахлагчийн албыг хуулийн д агуу хааж болно. 3.Энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль, цуглралтаар болон хууль тогтоомжид заасан цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ. Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ.
- 4 дүгээр зүйл. Цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтэн 1.Цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг цэргийн албан хаагч гэнэ. Цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерийг нэгдүгээр зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ. Бэлтгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд, мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг хоёрдугаар зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ.
- 9 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ албаны татлага. 2.18-25 насны Монгол Улсын иргэн эрэгтэйчүүдийг цэргийн жинхэнэ албанд татна. Цэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах хуудас авсан иргэнийг цэргийн жинхэнэ албанд татагдагч гэнэ.
- 12 дугаар зүйл. Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх 1. Монгол Улсын иргэнийг цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаас дараахь үндэслэлээр түр чөлөөлж болно. 1/ эцэг, эх нь хоёулаа, эсхүл ганц бие эцэг буюу эх нь хөдөлмөрийн чадваргүй /60-аас дээш настай эцэг, 55-аас дээш настай эх, энэ насанд хүрээгүй боловч тахир дутуугийн I, II зэрэгт орсон эцэг, эхийг хөдөлмөрийн чадваргүйд тооцно/ бөгөөд тэднийг хууль ёсоор асран хамгаалах, харгалзан дэмжих өөр хүнгүй бол хамт амьдардаг эсхэийг харгалзахгүйгээр,
- 13 дугаар зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаар 1.Цэргийн албан

хаагч нь: 1/байлдагч, түрүүчийн албыг, - хугацаат цэрэг 27 нас хүртэл, - гэрээт цэрэг 31 нас хүртэл 2/ ахлагчийн албыг 45 нас хүртэл, 3/ офицерын албыг: дунд офицер 45 нас хүртэл, ахлах офицер 50 нас хүртэл дээд офицер 55 нас хүртэл тус тус хааж болно. Эмэгтэйчүүд ахлагч, офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 45 нас хүртэл хааж болно.

- 18 дугаар зүйл. Ахлагчийн алба 3.Ахлагчийн албанд дараахь хүмүүсийг авч болно: 2/35 хүртэлх насны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, 3/30 хүртэлх насны эмэгтэйчүүд.
- 20 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албанд байх нас Цэргийн бэлтгэл албанд дээд, ахлах офицер 60 нас, дунд офицер, ахлагч 55 нас эмэгтэй офицер, ахлагч болон байлдагч, түрүүч 50 нас хүртэлж байж болно.

48. Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай /1993 оны 12 сарын 2/

- 3 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын зарчим.
- 1. Хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүнийэрх, эрх чөлөөг хүндэтгэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.



ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА, ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГИЙН АСУУДЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (Харьцуулсан судалгаа)

*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, Ц. Болормаа
Д. Жигваагүнсэл, Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа*

Сэдвийн агуулга:

Оршил

Монгол Улсын төрөөс дээд боловсролын салбарт баримталж буй бодлого, эрх зүйн орчны мэдээлэл

Нэгдүгээр бүлэг:

- Монгол Улсад төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл тусламжийн хэлбэрүүд
 - 1.1. Төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл тусламжийн хэлбэрүүд /түүхчилсэн лавлагаа/
 - 1.2. Тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд, олгох шалгуур үзүүлэлт, эргэн төлөгдөх нөхцөл
 - 1.3. Тэтгэлэг зээл тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэл
 - 1.4. Дүгнэлт

Хоёрдугаар бүлэг:

- **Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт**
 - 2.1. **Өндөр хөгжилтэй орнууд**
 - Австрали
 - Их Британи
 - Турк
 - Швед
 - 2.2. **Хуучин Социалист орнууд**
 - ОХУ
 - БНКаз Улс
 - БНБел Улс
 - 2.3. **Азийн орнууд**
 - Энэтхэг
 - Япон
 - Солонгос
 - Монгол

2.4. Дүгнэлт

Санал зөвлөмж

Ашигласан материал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Оршил

УИХ-ын Тамгын газрын СШОНХТөвийн судалгааны баг “Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцаа, оюутны тэтгэлэгийн асуудал” сэдэвт харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

Монгол Улсад дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн талаархи бодлогыг Дээд боловсролын хуулийн 18-р зүйлд ерөнхийлөн зохицуулсаныг Засгийн газраас баталсан “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”, “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” болон 2001 онд БСШУЯ ба СЭЗЯ-ны сайд нарын хамтарсан 310/290 тоот тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, доктарантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам” –аар зохицуулагдаж байсан. Харин 2008 онд Засгийн газраас 177-р тогтоол гаргаж дээрхи гурван журмыг нэгтгэн шинэчлэн баталсан юм.

Энэхүү журмын зохицуулалт болон гадаадын зарим орны боловсролын салбарт төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны эрх зүйн орчинг харьцуулан судалж манай улсын хувьд авч хэрэгжүүлэх болохуйц туршлага бий эсэхийг тодорхойлох үүднээс энэхүү харьцуулсан судалгааг хийлээ.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд Монгол улсад дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэг туслалцааны асуудлыг 1992 оноос хойш зохицуулж байсан эрх зүйн баримт бичиг болоод өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдийг хамруулсан болно. Түүнчлэн манай улсын төсвөөс 1994-2008 оны хооронд оюутны тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл, тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэлийг дэмжлэг, туслалцааны хэлбэр бүрээр харьцуулан үзүүлсэн юм.

Судалгаанд хамруулсан улс орнуудыг сонгохдоо тухайн орны хөгжлийн үзүүлэлт, сургалтын зээл болон бусад дэмжлэгийн талаархи туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, түүнчлэн сургалтын чанарын үзүүлэлт зэрэг шалгууруудыг голлон өндөр хөгжилтэй орон, Азийн орон, хуучин социалист зэрэг орнуудыг бүлэглэн авч үзсэн юм. Өндөр хөгжилтэй улс оронд Австрали, Их Британи, Турк, Швед, хуучин социалист орнуудад ОХУ, БНКаЗ Улс, БНБелУлс, Азийн орнуудад Энэтхэг, Япон, Солонгос зэрэг улс орныг багтаан тэдгээрийн холбогдох хууль, журмуудыг Монгол улсын хууль, холбогдох журмуудтай харьцуулан судалсан болно.

Монгол Улсын төрөөс дээд боловсролын салбарт баримталж буй бодлого, эрх зүйн орчны мэдээлэл

Монгол улсын төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогын баримт бичгийг 1995 онд УИХ-аас батлан гаргасан бөгөөд үүнтэй холбогдуулан 1997 онд Монгол улсын Засгийн газраас “Боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл”-ийг баталсан байна.

УИХ-аас баталсан бодлогын баримт бичигт төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогоо тодорхойлохдоо “Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн. Үүнийг үндэслэн боловсролыг төрөөс нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” хэмээн тодорхойлоод тус баримт бичгийн 2-р зүйлийн 1-ийн 1 дэх хэсэгт “боловсролыг төрийн ивээл, дэмжлэг, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад

байлгана” хэмээн заасан байдаг.

Ийнхүү төрөөс боловсролын салбарт баримтлах бодлогоо тодорхойлж түүндээ нийцүүлэн 2002 онд Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуулиудыг шинэчлэн баталсан. Өдгөө боловсролын салбарын аливаа харилцаа эдгээр хууль болон түүнтэй холбогдон гарсан бусад дүрэм журмуудын хүрээнд зохицуулагдаж байна. Харин төрөөс боловсролын салбарт тэр дундаа их дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны талаар үндсэн зохицуулалтыг Дээд боловсролын тухай хуулийн 18-р зүйлд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

18.1.Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 18.1.1.улсын төсвийн хөрөнгө;
- 18.1.2.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;
- 18.1.3.сургалтын төлбөр;
- 18.1.4.аж ахуйн үйл ажиллагааны орлого;
- 18.1.5.холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу тогтоосон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;
- 18.1.6.зээл, тусламж;
- 18.1.7.бусад эх үүсвэр.

18.2.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулах, багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрөөс зохих дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

18.3.Боловсролын байгууллагад хандивласан хөрөнгийг байгууллагын санхүүгийн тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглана.

18.4.Зайлшгүй шаардлагатай зарим мэргэжлээр гадаадад мэргэжилтэн бэлтгэх сургалтын зардлыг жил бүрийн улсын төсвөөс санхүүжүүлж болох бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хэрэгцээг үндэслэн төрөөс суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилан зохицуулна.

18.5.Өмчийн аль ч хэлбэрийн дээд боловсролын сургалтын байгууллага нь хоёр жил тутамд санхүүгийн үйл ажиллагаандаа аудитын хяналт хийлгэж, дүнг нийтэд ил тод байлгана.

Мөн хуулийн зохицуулалтаас гадна хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас хэд хэдэн тогтоолыг батлан /1-р бүлгээс тодорхой үзнэ үү/ гаргасан бөгөөд түүнд Монгол улсын төрөөс их, дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл хэлбэр тодорхойлогдоно.

Төрөөс үзүүлж буй дэмжлэг, туслалцааны аливаа үйл ажиллагаа тэр дундаа их, дээд сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг 1997 оны Засгийн газрын 179 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн байгуулагдсан Сургалтын Төрийн Сан /СТС/ эрхлэн гүйцэтгэж ирсэн байдаг.

СТС нь 1993 онд анх байгуулагдан, 1997 оны 179 дүгээр тогтоолоор шинэчлэгдсэн журмын дагуу үйл ажиллагаагаа 16 дахь жилдээ явуулж байгаа юм байна. Засгийн газраас холбогдох тогтоолуудаар батлагдсан журмуудын дагуу хагас болон бүтэн өнчин, амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагчид, хөржлийн бэрхшээлтэй суралцагчид, шагналын хэлбэрээр элсэгчид, төрийн албан

хаагчийн гэр бүлээс суралцагч, түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчидтай гурвалсан гэрээ байгуулан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгохын зэрэгцээ зээлийг буцаан төлүүлэх, санхүүжилтийн төсөв, тооцоо хийх, тайлагнах, хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна.

Практик нөхцөл байдалд Монгол Улсын хэмжээнд их, дээд сургуулиудад суралцаж буй нийт оюутнуудаас 28 мянга нь Төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар, 17 мянга нь төрийн албан хаагчийн хүүхэд гэдгээр суралцаж байгаа аж. Өөрөөр хэлбэл, гурван оюутан тутмын нэг нь төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжаар сурч байгаа гэж судлаачид үзсэн байна.¹

Бэрхшээл асуудал: Үүнээс боловсролын салбарт тулгараад буй гол бэрхшээл асуудал нь төрөөс олгогдож буй зээлийн эргэн төлөлт удаашралтай, хангалтгүй, СТС-ийн төсвийн зарцуулалт багатай байгаа явдал гэж салбарын мэргэжилтнүүд үзэж байна. Үүнд:

- Суралцагчдад олгож буй төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох шалгуур үзүүлэлт боловсронгуй бус
- Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид суралцагчдын сургалтын төлбөрийг тооцох нэгдсэн аргачлал мөрдүүлээгүй
- Гадаадад зэргийн түвшиний сургуульд /магистрантур, докторантур/ суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг зохих ёсоор тогтоогоогүй
- СТС-ийн бодлого тодорхой бусаас шалтгаалан сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсдын хүрээ хэт өргөжсөн
- Зээлийг төлүүлэх оновчтой механизм байхгүй гэж тодорхойлсон байна.

Үүнийг үндэслэн УИХТГ-ын СШОНХТ-ийн судалгааны баг дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн төрөл, хэлбэр, шалгуур үзүүлэлт болон зээлийн эргэн төлөлтийн нөхцөл зэргийг гадаадын зарим орны холбогдох хууль, эрх зүйн актуудаар хэрхэн зохицуулсаныг судалж харьцуулсан хүснэгтээр үзүүлэв.

* * *

Нэгдүгээр бүлэг: МОНГОЛ УЛСАД ТӨРӨӨС ОЛГОДОГ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХЭЛБЭРҮҮД, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН СУДАЛГАА

1.1. Төрөөс олгодог оюутны тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд /түүхчилсэн лавлагаа/

1990 -ээд оноос хойш Монголын дээд боловсролын тогтолцоо үндсэндээ өөрчлөгдөж, сургалтын төлбөртэй системд шилжсэн нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгосон. Сургалтын төлбөрийн тогтолцоог нэвтрүүлж, оюутнуудад зориулагдсан зээл, тусламжийн хөтөлбөр бий болгон, дээд боловсролын салбарт хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд үйл ажиллагаагаа явуулах бололцоог нээсэн шинэ шинэ өөрчлөлтүүд нь мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчилсэн чухал алхам болсон.

Засгийн газраас 1992 онд Мэргэжлийн Сургалтын Байгууллагуудыг Санхүүжүүлэх журмыг баталж, боловсролын байгууллагуудын төлбөрийн төвшинг тогтоосон. Үүний дагуу,

¹ ННФ, Зориг сан “Төрөөс боловсролын салбарт үзүүлж буй оюутны сургалтын тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаанд хийх мониторинг” төслийн тайлан, УБ., 2008 он

сургалтын төлбөр, багш ажилчдын цалингийн доод төвшинг тогтоож, 1992-1993 оны хичээлийн жилээс төрийн өмчийн бүх их, дээд сургуулиуд түүнийг мөрдөж эхэлсэн байна. “Төрийн өмчийн мэргэжлийн сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх тухай” Засгийн газрын 107 дугаар тогтоолоор Сургалтын Төрийн Сан /СТС/ байгуулагдаж, одоогийн сургалтын тусламжийн хөтөлбөрийн үндэсийг бий болгосон.

СТС нь 1992 онд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийг зохицуулах, мэргэжлийн боловсролын сургалтад зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, суралцагчдад төрөөс санхүүгийн баталгаат дэмжлэг үзүүлэх, сургалтын чанарыг урамшуулах, хувийн сургуулийг дэмжих зорилгоор байгуулагдсан байна. Төрөөс СТС-аар дамжуулан сургалтын зээл, буцалтгүй тусламжийг анх ЗГ-ын 107-р тогтоолд заасны дагуу олгож эхэлсэн бөгөөд ингэхдээ оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусалж дэмжих зорилгоор сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, амьжиргааны стипенди, хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн байна.

1995 онд СТС-ын үйл ажиллагааг зохицуулах зээл, тусламж үзүүлэх үйл ажиллагааг хуульчилсан ЗГ-ын 194 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн сургуульд суралцагчдад зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг баталж, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн 1 хүүхэд, өрхийн тэргүүн нь хөдөлмөрийн чадвараа алдсан өрхийн 1 хүүхэд, эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гарсан бага орлоготой өрхийн 2-оос илүүгүй хүүхэд, хагас өнчин хүүхдэд зээл, буцалтгүй тусламж олгохоор заажээ.

1997 онд ЗГ-ын 179 дүгээр тогтоолоор “Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй оюутнуудад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг баталж, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд тэнцсэн магадлан итгэмжлэгдсэн сургуульд элсэн суралцаж буй оюутнууд зээл, буцалтгүй тусламжид хамрагдах эрхтэй хэмээн өргөжүүлжээ. 2000 оны ЗГ-ын 96 дугаар тогтоолоор “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам” батлагдсаны дагуу нэн ядуу болон амьдралын түвшин доогуур суралцагчдыг нэмэн хамруулах болсон.

2000 оны ЗГ-ын 158 дугаар тогтоолоор “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” батлагдаж нэн ядуу, бүтэн өнчин, малчин, бага орлоготой, 3-аас дээш хүүхэдтэй айлын нэг хүүхдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон. Энэ нь нийт СТС-нд хамрагдагсдын 35хувийг эзэлж байсан байна. 2000 оны ЗГ-ын 201 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” баталж, бүх төрлийн их, дээд сургуульд бакалаврын болон дипломын боловсрол эзэмшихээр суралцаж байгаа төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даахаар болжээ. /2000 оноос өмнө төрийн албан хаагчдыг үр дүнтэй дэмжих зорилго бүхий тусгай хөтөлбөрийн хүрээнд тэдгээрийн оюутан хүүхдийн сургалтын зардлын тэтгэлгийг олгодог байжээ/

2001 онд БСШУЯ ба СЭЗЯ-ны сайд нарын хамтарсан 310/290 тоот тушаалаар “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам” баталж, сургалтын зээлд хамрагдагсдын хүрээг өргөжүүлж яамд, аймаг, дүүргийн улсын байгууллагуудад 2 буюу түүнээс олон жил ажилласан хүмүүсийг сургалтын зээл авах эрх олгожээ.

2002 онд “Дээд боловсролын тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу их, дээд боловсролын байгууллагуудыг **их сургууль, дээд сургууль** ба **коллежи** гэж 3 ангилсан. Коллежид 3 жилийн дипломын боловсрол эсвэл 4 жилийн бакалаврын зэрэг, дээд сургуулиуд магистрын зэрэг олгох 1,5-2 жил, их сургуулиуд эдгээрээс гадна докторын /3-5 жилийн/ зэрэг олгох эрхтэй гэсэн өөрчлөлт орсонтой холбогдуулан 2002 оны 10 дугаар сарын 8-ны 207 дугаар тогтоолоор дээрх өөрчлөлтөд зохицуулан өмнө гарсан

бүх тогтоолуудыг шинэчилсэн байна. **2002 оны 207 дугаар тогтоолоор** ядуу малчин өрхийн амьжиргааны үзүүлэлтийн 500 бог мал /2000 оны 158 дугаар тогтоол/ гэдгийг 700 бог мал гэж нэмэгдүүлсэн. Мөн сургалтын төлбөрийн зээлээ эргэн төлж барагдуулсан эсэхээс үл хамааран дипломын хуулбарыг төгсөгчдөд төгссөн даруйд нь олгоно гэсэн заалт оруулсан.

2006 оны 3Г-ын 55 дугаар тогтоолоор төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын гэр бүлээс нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд, мэргэжлийн сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд элсэн орсон 1 хүүхдийн нь сургалтын төлбөрийг төрөөс олгохоор нэмж тусгасан байна. 2008 оны 3Г-ын 177 дугаар тогтоолоор өмнө гарсан “Журам батлах тухай” 3Г-ын 96, 158, 207 дугаар тогтоолуудыг хүчингүй болгон дахин өөрчлөн боловсронгуй болгож, сурлагын амжилт гаргасан, амьдралын түвшин доогуур, хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцаж буй оюутанд монгол улсын иргэн, дотоодын сургуульд суралцагч гадаадын оюутныг хамруулахаар болжээ. Өнөөг хүртэл нийтдээ сургалтын байгууллагын тэтгэлэг, зээл, тусламжийн талаар 10 -аад журам батлагдан мөрдөгдөж ирсэн байх бөгөөд жил ирэх тусам зээл тусламжид хамрагдсагсдын төрөл, цар хүрээ улам өргөжин тэлсээр иржээ.

1.2. Тэтгэлэг, зээл, тусламжийн хэлбэрүүд, олгох шалгуур үзүүлэлт, эргэн төлөгдөх нөхцөл

СТС -гаас сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаа 1993 - 1995 онд оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусалж дэмжих чиглэлээр эхэлсэн бол 1996-1999 онд нэн ядуу болон амьдралын түвшин доогуур өрхийн 1 хүүхдэд, 2000 оноос хойш ядуу, өнчин, малчин, бага орлоготой, төрийн албан хаагчийн хүүхдэд зээл, буцалтгүй тусламж олгох, 2003 оноос сумдад төрийн албан хаагч бэлтгэх зардал гэх мэтээр сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдах оюутнуудын хүрээг өргөжүүлсэн байна.

Төрөөс СТС-аар дамжуулан олгож буй сургалтын зээл, буцалтгүй тусламж нь эргэн төлөгдөх хөнгөлттэй зээл, эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж гэсэн 2 үндсэн хэлбэрээр олгогдож байгаа боловч томьёололын хувьд 3 янз байна. Үүнд:

- Сургалтын төлбөр, зээл
- Сургалтын буцалтгүй тусламж
- Амьжиргааны тэтгэлэг/стипенди/

Сургалтын тэтгэлэг гэдэг нь төрөөс буцалтгүй тусламжийн хэлбэрээр л олгогдож буй оюутны амьжиргааны тэтгэлэг юм. Өөрөөр хэлбэр дээрх үндсэн 2 хэлбэрээр сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, төлбөрийн шагналыг олгодог гэсэн үг юм. Эдгээр зээл, тусламжийн хэлбэр, шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 1.2.1-д үзүүлэв.

Сургалтын төрийн сангаас үзүүлдэг зээл тусламжийн хэлбэр, шалгуур үзүүлэлт

Хүснэгт 1.2.1

Д/д	Тогтоолын он, сар, дугаар	Зээл тусламжийн хэлбэр	Шалгуур үзүүлэлт	Санхүүжүүлэх зардал	Эргэн төлөлт

1	3Г-1993-107 “Их сургууль, коллежийн зарим сургалтын төлбөрийн санхүүжилтийн тухай” Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Холбогдох яамдын захиалгын дагуу суралцагсдын сургалтын төлбөр -Онцгой авъяастай оюутнуудын стипенди -Хоёр улсын гэрээгээр суралцаж буй гадаадын болон дотоодын оюутнуудад -Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой суралцагчид	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг стипенди Нэрэмжит, шагналын стипенди Амьжиргааны тэтгэлэг, сургалтын төлбөр төрийн халамж болгон стипенди	-Захиалгаар бэлтгэгдсэн хүнийг захиалагч бус өөр байгууллага авч ажиллуулвал суралцсан хугацааны сургалтын төлбөрийг төрийн санд буцаан төлсөн байна. -Улсын захиалгаар суралцаад захиалагчийн шаардлагыг хангаагүй бол сургалтын төлбөрөө буцаан төлнө.
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	-Төрийн өмчийн мэргэжлийн сургуульд суралцагч Монгол улсын иргэнд -Хувийн сургуулийн тогтмол зардлын 50 хүртэл хувьд зориулж 30 хувийн хүүтэй зээл	Сургалтын төлбөр, стипендид олгоход /Зээлийг тухайн жилийн хэрэгцээнд тохируулан жил бүр олгоно/ Хувийн сургуулийн дотоод үйл ажиллагаанд зориулж олгодог.	-Төгссөнөөс 10 жилийн дотор төлж барагдуулах ба хугацаа хэтэрвэл арилжааны банкны хугацаа хэтэрсэн зээлийн нөхцлийг баримтлана. -Зээлийн хүү 3 хувь, стипендийн хүү 5 хувь байна.
2	3Г-1995-194 “Мэргэжлийн сургуульд суралцагчдад зээл, буцалтгүй тусламж олгох тухай” Хүчингүй болсон	Төрөөс санхүүжүүлэх /эргэн төлөгдөхгүй/	-Бүх хэлбэрийн их, дээд сургууль, коллежи, тусгай мэргэжлийн дунд сургуульд төрийн албан хаагчийн гэр бүлээс элссэн нэг оюутаны	Сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.	-Суралцагчийн буруугаас сургуулиа орхисон тохиодолд суралцсан хугацааны зардлыг эргүүлэн төлүүлнэ.
		Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Бүтэн өнчин асран хамгаалагчгүй, тахир дутуу суралцагчийн - бага орлоготой болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн буюу хагас өнчин суралцагчид	-Сургалтын төлбөр, тэтгэлэг, дотуур байрны зардал. -Амьжиргааны тэтгэлэг	Хамааралгүй
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	-Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагчид -Магистрантурт суралцагчид -Багшийн мэргэжлээр суралцагчид -Бага орлоготой суралцагчид -гадаад орны мэргэжлийн сургуульд суралцагчид	-Сургалтын төлбөр -сургалтын төлбөр -тэтгэлэг -сургалтын төлбөр, тэтгэлэг -сургалтын төлбөр, замын зардал	-Төгссөнөөс хойш нэг жилийн дараагаас эхлэн 1-3 хувийн хүүтэйгээр буцаан төлнө. -суралцагч 6 жилийн дотор, магистрант 3 жилд багтаан төлнө. -Зээлийн хүүг зарим нөхцлөөр хөнгөлнө. -Багшийн мэргэжлээр төгсөөд мэргэжлээрээ 6-гаас доошгүй жил ажиллавал тэтгэлгийн зээлийг бүр мөсөн чөлөөлнө. -Нас барсан, тахир дутуугийн 1,2-р зэрэг тогтоогдсон нөхцөлд зээлийн төлбөрийг хүүгийн хамт чөлөөлнө.



3	ЗГ-1997-179 “Их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр сурч буй оюутнуудад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох тухай” хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуугийн группт орсон суралцагч	Сургалтын төлбөр, тэтгэлэг	
			Сургалт, эрдэм шинжилгээний ажилд өндөр амжилт гаргасан онцгой авъяас чадвартай суралцагч	Сургалтын төлбөрийг нь 5-р улирлаас эхлэн	
			Олон улсын уралдаан, олимпиадаас эхний 3 байр эзэлсэн суралцагчийн	Эхний 2 жилийн сургалтийн төлбөр	
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Амьжиргааны түвшинээс бага орлоготой, нэн ядуу өрхийн 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон гишүүдтэй өрхийн 2-оос илүүгүй суралцагч	Сургалтын төлбөр	
			Оюуны болон хөдөлмөрийн чадвараа алдсан хараагүй, дүлий иргэд бүхий өрхийн 1 суралцагч	Сургалтын төлбөр	
			Багшийн мэргэжлээр суралцагч	Тэтгэлэг	
			ЗГ-ын гэрээгээр гадаадын суралцагч	Амьжиргааны тэтгэлэг	
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Амьжиргааны түвшинээс бага орлоготой, нэн ядуу өрхийн 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон гишүүдтэй өрхийн 2-оос илүүгүй суралцагч	Сургалтын төлбөр	
			Оюуны болон хөдөлмөрийн чадвараа алдсан хараагүй, дүлий иргэд бүхий өрхийн 1 суралцагч	Сургалтын төлбөр	
			Багшийн мэргэжлээр суралцагч	Тэтгэлэг	

4	ЗГ-2000-96 “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам” /хүчингүй болсон/	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн тахир дутуу суралцагч	Сургалтын төлбөр, тэтгэлэг	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой хагас өнчин суралцагч	Нэг жилийн сургалтын төлбөрийн 150.0 мянган төгрөгийг	
		Төлбөрийн шагнал /эргэн төлөгдөхгүй/	-Олон улсын хэмээнд зохиогдсон олимпиад, о.у-ын дээд зэрэглэлийн уралдаан тэмцээнд шагналт байр эзэлсэн, -ЕБС-ийг төгсөх жилээ улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн -Сурлагын амжилт үзүүлсэн суралцагч	Сургалтын төлбөрийн шагнал	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
		Хөнгөлөлттэй зээл /эргэн төлөгдөх нөхцөлтэй/	Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	
			Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч -Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч -Эцэг эх 2 нь өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч -Бага орлоготой өрхийн хагас өнчин суралцагч -Бакалаврын 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, доктрантурт суралцагч -ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч	Сургалтын төлбөр	

5	ЗГ-2000-158 “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” /нэмэлт өөрчлөлт орсон/	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-Нийт малыг нь богд шилжүүлснээр 700 хүртэл толгой мал бүхий зөвхөн малчин өрхийн -Бүсийн амьжиргааны түвшингийн 40 хувиас бага орлоготой ядуу өрхийн суралцагч -3 ба түүнээс дээш хүүхэд нь их дээд сургууль, коллежид зэрэг суралцаж буй өрхийн нэг суралцагч	Сургалтын төлбөрийг нь төрөөс санхүүжүүлнэ.	Хамааралгүй \жич: Хөнгөлөлттэй зээл болон бусад зүйлийн талаар заалт байхгүй байна\
	ЗГ-2000-201 “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” /дөгдөж байгаа/	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Төрийн албан хаагчийн их, дээд сургуульд суралцаж байгаа 1 хүүхдийн	Сургалтын төлбөрийг төрөөс даана.	Хамааралгүй /бүх хэлбэрийн их дээд сургуульд суралцаж буй суралцагчид хамрагдана/
6	БСШУЯ-ны сайд, СЭЗЯ-ны сайдын хамтарсан тушаал №310/290 /мөрдөгдөж байгаа/	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Өндөр хөгжилтэй оронд шалгаруулалтын дагуу суралцах эрх авсан суралцагчийн	Сургалтын зардал, тэтгэлэг	Хамааралгүй /“Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, доктарантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”/-аар зохицуулна.
	ЗГ-2000-201 “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам” /дөгдөж байгаа/	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Төрийн албан хаагчийн их, дээд сургуульд суралцаж байгаа 1 хүүхдийн	Сургалтын төлбөрийг төрөөс даана.	Хамааралгүй /бүх хэлбэрийн их дээд сургуульд суралцаж буй суралцагчид хамрагдана/

7	ЗГ-2001-195 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Хүчингүй болсон	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-500 хүртэл бог малтай малчин өрхийн -60 хувиас доогуур орлоготой ядуу өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөр	
				-Сумдаас ирсэн захиалгын дагуу эмч, багшаар ажиллахаар гэрээ хийсэн суралцагчийн	2 жилийн сургалтын төлбөр	
8	ЗГ-2002-207 Хүчингүй болсон	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж	-700 бог малтай малчин өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөр	Хамааралгүй
9	ЗГ-2003-61 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай/ Хүчингүй болсон	Хүчингүй болсон	Зээлээс чөлөөлөх	-	-	35-р зүйлийг “Суралцагч сургууль төгсөөд холбогдох яам агентлагаас өгсөн чиглэлийн дагуу төрийн захиргаан болон төрийн үйлчилгээний байгууллагад мэргэжлээрээ нийслэлд 8 жил, аймгийн төвд 5 жил, суманд 2 жил үр бүтээлтэй ажиллавал хөнгөлөлттэй зээл, түүний хүүгийн төлбөрөөс чөлөөлж болно ” гэж өөрчилжээ.
10	ЗГ-2006-55 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Хүчингүй болсон	Хүчингүй болсон	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	-төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын гэр бүлээс нь магадлан итгэмжлэгдсэн их дээд мэргэжлийн сургуульд 2005-2006 онд элсэн орсон 1 суралцагчийн	Сургалтын төлбөрийг төрөөс олгох	Хамааралгүй



11	11. Журам шинэчлэн батлах тухай, ЗГ-2008-177 Мөрдөгдөж байгаа	Буцалтгүй тусламж /эргэн төлөгдөхгүй/	Улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн оюутан	Сургалтын төлбөрийг	Хамааралгүй /суралцагчдын голч дүн 2,8-2,0-оос доошгүй байх шаардлага тавигддаг. /
			Олон улсын зэрэглэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд МУ-ыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа МУ-ын иргэнд	Амьжиргааны тэтгэлэг	
			Бүтэн өнчин суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	Сургалтын төлбөрийг	
			Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч	Сургалтын төлбөрийг	
			өрхийн нэг хүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
			Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 50 хүртэл толгой мал ногдох малчин өрхийн нэг суралцагчийн	Сургалтын төлбөрийг	
	Хөнгөлөлттэй зээл /Эргэн төлөгдөх нөхцөлтэй/		ЗГ хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэний	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг	
			Хяналтын тоонд багтаан сургуулиа төгсөөд орон нутагт 3-аас дээш жил ажиллахаар гэрээ байгуулсан суралцагчийн	Сүүлийн 2 жилийн сургалтын төлбөрийг	
			Хагас өнчин суралцагчид	Сургалтын төлбөр	
			Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 100 хүртэл толгой мал ногдох зөвхөн малчин өрхийн суралцагч	Сургалтын төлбөр	
			Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч	Сургалтын төлбөр	
			Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч	Сургалтын төлбөр	
			Олон улсын нэр хүндтэй гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	Сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг, э.ш-ний ажлын хамгаалах зардал	

* **

Эх сурвалж: МУ -ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Засгийн газрын тогтоолууд. УИХТГ-ын СШОНХТ 2009 он

Сургалтын төрийн сангийн зээл буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь орлого багатай ядуу боловч сурах чадвартай оюутнуудад санхүүгийн туслалцаа үзүүлэх явдал юм. Зээл тусламжид хамрагдах гол шалгуур үзүүлэлт нь амьжиргааны түвшин, төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхэд, сурлагын үзүүлэлт ба оюуны онцгой авьяас, чадвар зэргийг харгалзан тэдгээрт тавигдах шаардлагыг үндэслэл болгож байна. Мэргэжлийн сургуульд суралцагч нь сургалтын тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд хоёр төрлийн тусламж авах эрхтэй бөгөөд энэ нь эргэн төлөгдөх нөхцөлтэй **зээл**, эргэн төлөгдөх нөхцөлгүй **буцалтгүй тусламж** юм.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл ба эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламжийн аль аль нь сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг санхүүжүүлдэг. Нэг оюутанд ногдох тусламжийн хэмжээ нь сургалтын төлбөрийн хэмжээ, оюутны өрхийн орлогын төвшин болон гэртээ эсвэл гэрээсээ хол байдаг эсэхээс хамаардаг. Өөрөөр хэлбэл эргэн төлөгдөх зээл ба эргэн төлөгдөхгүй буцалтгүй тусламж хоёулаа сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх бөгөөд хамрагдах шалгуур нь сурлагын болон амьжиргааны төвшин дээр тулгуурладаг болно.

2000 оноос өмнө бүх хэвшлийн их дээд сургууль коллежид суралцаж буй суралцагчид зээл тусламжид хамрагдах боломжтой байсан бол 2000 оноос зөвхөн Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчид олгохоор болсон. 1993 оноос хойш төрөөс олгодог зээл, буцалтгүй тусламж нь хэлбэрийн хувьд дээрх эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламж, эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийн хэлбэрээр, нэр төрөл хамрах хүрээний хувьд Хүснэгт 1-д дурдсанчлан өргөн хүрээтэй олгогдсоор ирсэн байна. Тухайлбал:

- Хөнгөлөлттэй зээл- энэ нь суралцагчид төрөөс олгож буй тэтгэлгийн нэг хэлбэр бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогддог бага хувийн хүүтэй зээл юм. Хөнгөлөлттэй зээлийн хүү нь арилжааны банкны хүүгээс маш бага буюу 1-3 хувийн хэлбэлзлэлтэй байдаг байна. Хөнгөлөлттэй зээлийг 1993 оноос эхэлж олгосон. Өмнө нь суралцагч суралцах хугацаандаа авсан хөнгөлөлттэй зээлийг төгссөнөөс хойш 10 жилийн дотор төлж барагдуулдаг байсан бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЗГ-ын 2008 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 177 дугаар тогтоолоор төгссөнөөс хойш 5 жилийн дотор төлж барагдуулах журамтай болсон. Хөнгөлөлттэй зээлийг магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцаж буй хагас өнчин, амьжиргааны түвшин доогуур, гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хаасан зэрэг болзлыг хангасан 2,8 баллаас доошгүй голч дүнтэй суралцагч авах эрхтэй юм.
- Буцалтгүй тусламж- суралцагчид төрөөс олгож буй дэмжлэгийн нэг хэлбэр бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлгүй олгогддог тэтгэлэг юм. 1993 оноос ЗГ-ын 107 дугаар тогтоолын журмын дагуу буцалтгүй тусламж, тэтгэлгийг олгож эхэлсэн бөгөөд бүтэн өнчин, нэн ядуу, сурлагын амжилт үзүүлсэн суралцагчид олгож байсан бол 2000 оноос Төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг оюутан хүүхдэд сургалтын тэтгэлэг олгох болсноор буцалтгүй тусламжид хамрагдагсдын тоо эрс нэмэгдсэн байна. Буцалтгүй тусламжийн төрөл нь сургалтын төлбөрийн тэтгэлэг, амьжиргааны тэтгэлэг /стипенди/, сургалтын төлбөрийн шагнал, унааны зардал зэргээр олгогдож байна. 2008 оноос хойш буцалтгүй тусламж олгох шалгуур үзүүлэлтийг нарийвчилж, сургалтын ямар төрлийг санхүүжүүлэхийг тодорхой зааж өгсөн байна.


* **

1.3. Тэтгэлэг, зээл, тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээлэл.

Төрөөс дээд боловсролын салбарт сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаа 1993 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2008 он хүртэл нийт 414 мянган оюутанд 124 тэрбум 190 сая төгрөгийн зээл, буцалтгүй тусламж олгосон байна. СТС-аас 1994-

2008 онд зээл, тусламжид хамрагдсан оюутны тоо, санхүүжилтийг жил бүрээр харуулав.
Хавсралт 1.3.1, График 1.3.1/

График №1.3.1



Дээрх үзүүлэлтээс үзэхэд 1994 - 2000 он хүртэл CTC-аар дамжуулан зөвхөн сургалтын төлбөр, амжиргааны тэтгэлгийг санхүүжүүлэх эргэн төлөгдөх нөхцөлтэй **290,1 - 3928,8** тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг дунджаар 6000-8000 оюутанд олгож байсан бол 2000 оноос буцалтгүй тусламжийг төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхэд, нэн ядуу өрхийн суралцагчид, малчин бага орлоготой өрхийн суралцагчдад олгож эхэлснээр зээл, тусламжид хамрагдагсдын тоо, зардал эрс нэмэгдэж дунджаар 22455 - 51687 оюутанд 8183,5-18625,9 тэрбум төгрөгийн зээл буцалтгүй тусламжийг олгосон үзүүлэлттэй байна.



CTC -ын тэтгэлэг, зээл, тусламжийг ангилал тус бүрээр авч үзье:

/График №1.3.2/



Тайлбар: CTC-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

CTC -аар дамжуулан сургалтын зээл, тусламжийг олгосон байдлыг ангилал тус бүрээр авч үзвэл нийт 119377 оюутанд 22954.8 тэрбум төгрөгийн **хөнгөлөлттэй зээл**, 132321 оюутанд 35582.7 тэрбум төгрөгийн **буцалтгүй тусламж**, **төрийн албан хаагчийн 1 хүүхдийн сургалтын төлбөрийг** 137944 оюутанд 36583.3 тэрбум төгрөг, **өндөр хөгжилтэй оронд магистр, докторантурт суралцагч** 2715 оюутанд 28141.9 тэрбум төгрөгийг сургалтын зээл, буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон байна. Үүнээс гадна 2007 оноос баруун 5 аймгаас ирж суралцаж буй оюутнуудад амралтаараа гэртээ ирж буцах замын зардлын тал хувийг CTC-аар дамжуулан олгож ирсэн бөгөөд энэ хугацаанд 22615 оюутанд 756,3 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ.

2004 - 2008 төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сургуулиудад суралцагчдын санхүүжилтыг авч үзвэл:

/График 1.3.3/




Тайлбар: CTC-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

Одоогийн байдлаар Мэргэжлийн боловсролын сургалтын чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг 151 их, дээд сургууль, коллежи байгаагаас 48 нь төрийн өмчийн, 98 нь төрийн бус өмчийн сургууль байна.² Түүнээс 2004 - 2008 онд сургалтын зээл, тусламжид хамрагдсан байдлыг авч үзвэл төрийн өмчийн сургуульд суралцагчид нийт зээл тусламжид хамрагдагсдын 71 хувийг буюу 150871 оюутанд 41321791,3 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн сургуульд суралцагчид 29 хувь буюу 64599 оюутанд 16485415,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. /Хавсралт 2-оос дэлгэрэнгүй үзнэ үү/

Энэ нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчдаас зээл, тусламжид хамруулах болсонтой шууд холбоотой юм. Төрөөс дээд боловсролын салбарын сургалтын зээл, тусламжид зарцуулдаг хөрөнгө төсвийг сургалтын төрийн санд төвлөрүүлдэг байна.

БСШУС -ын төсвийн багцаас дээд боловсролын салбарын сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан байдлыг авч үзвэл: График №1.3.4



Тайлбар: СТС-аар гаргасан статистик мэдээлэлд үндэслэв.

БСШУС-ын төсвийн багцаас дээд боловсролын салбарын сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан байдлыг 2005-2008 оны төвийн гүйцэтгэлээр нь судлан үзэхэд нийт төсвийнхөө 8-9 орчим хувийг эзэлж байна.

1.4. Дүгнэлт

Төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааны нэг хэлбэр болох оюутны сургалтын зээл, тусламжийг **хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн** хэлбэрээр нэн ядуу, оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй суралцагчдыг дэмжих зорилгоор 1993 оноос хойш олгож ирсэн байна. Гэвч 2000 оноос нэн ядуу, өнчин, малчин, бага орлоготой, төрийн албан хаагчийн 1 оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцах болсноор зээл, тусламжид хамрагдах суралцагчдын цар хүрээг нэмэгдүүлжээ.

Сургалтын зээл, тусламж олгож эхэлсэнээс хойш “Мэргэжлийн сургуульд суралцагчдад

² www.pmis.gov.mn “Дээд боловсролын өнөөгийн байдал” танилцуулга. УБ., 2009 он

зээл, буцалтгүй тусламж олгох тухай” журмыг хэд хэдэн удаа шинэчлэн өөрчилж байсан бөгөөд одоогоор ЗГ-ын 2008 оны 177 дугаар тогтоол, 2001 оны 201 дүгээр тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өмнө гарсан журмуудад зээл, тусламжийг санхүүжүүлэх төрөл, нэр томъёолол нь бүрхэг, ерөнхий шинжтэйгээс гадна шалгуур үзүүлэлт оновчтой бус хэтэрхий өргөн хүрээг хамарсан, эргэн төлүүлэх журмыг тодорхой бус байдалтайгаар тусгасан байсан бол 2008 оны дээрх тогтоолд эдгээр асуудлыг тодорхой боловсронгуй болгон зохицуулжээ.

Сургалтын зээл, буцалтгүй тусламжийг олгохдоо магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцаж буй хагас өнчин, амьжиргааны түвшин доогуур, гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан зэрэг шалгуурыг хангасан 2,8 баллаас доошгүй голч дүнтэй суралцагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр **хөнгөлөлттэй зээл**, бүтэн өнчин, нэн ядуу, сурлагын амжилт үзүүлсэн суралцагч, төрийн албан хаагчийн гэр бүлийн нэг оюутан хүүхдэд сургалтын тэтгэлгийг **буцалтгүй тусламж** хэлбэрээр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгоно гэсэн шалгуур үзүүлэлтийг баримталдаг байна.

Одоогоор сургалтын зээл, тусламжийг төрийн сангаар дамжуулан суралцагчийн **сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийг** /зөвхөн гадаадад суралцаж буй оюутанд/ санхүүжүүлэхэд зориулан олгож байгаа бөгөөд 1993-2009 он хүртэл нийт 414 мянган оюутанд 124 тэрбум 190 сая төгрөгийн зээл, буцалтгүй тусламж олгосон байна. Олгож буй зээл, тусламжийн 40 гаруй хувийг Төрийн албан хаагчийн нэг хүүхдэд олгодог буцалтгүй тусламжийн тэтгэлэг эзэлж байгаа бол нэн ядуу өрхийн суралцах чадвар сайтай оюутанд олгож буй буцалтгүй тусламжийн тэтгэлэг зээл тусламжид хамрагдагсдын 35 хувийг, үлдсэн нь бусад төрөл болон зээлийн үйлчилгээнд хамрагдагсад эзэлж байна. Зөвхөн Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчид хамрагдах эрхтэй болсноос хойш зээл тусламжид хамрагдагсдын 70 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцагч, 30 хувь нь төрийн бус өмчийн сургуульд суралцагч байна.

Боловсрол болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын хяналтын тоог жил бүрийн 5 дугаар сард мэргэжил тус бүрээр баталдаг бөгөөд төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагч нэг оюутанг энэ тоонд хамруулдаггүй. Түүнээс гадна бодит нөхцөл байдлыг харгалзаагүйгээс СТС-ийн зээл, тусламжид хамрагдаж чадахгүй үлддэг байна. Тухайлбал: Төрийн өмчийн сургуулиудад хүсэлт гаргасан суралцагчдын 57,3 хувь нь сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан байна.³ Энэ нь сургалтын зээл, тусламжид хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан хэдий ч суралцаж буй сургуульд өгсөн хяналтын тооноос хамаарч түүнд хамрагдах оюутны тоо хязгаарлагддаг болохыг харуулж байна.

Төрийн албан хаагчдын нэг оюутан хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс буцалтгүй тусламжаар олгож байгаа нь нэг талдаа хавтгайруулан хамруулсан мэт боловч тодорхой шалгуурыг өндөрсгөж нүдээ олж өгвөл төсвийн багахан цалингаар амьдралаа залгуулдаг тэдэнд чухал нэмэр болдог нь илэрхий юм. Амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой боловч онцгой амжилт гаргаагүй ч суралцах чадвар сонирхолтой дундаж амьдралтай өрхийн суралцагчдад төрийн албан хаагчдын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даана гэсэн дэмжлэгээс өөр хамрагдах тодорхой дэмжлэг байхгүй байна.

Мөн төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг нь 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө СТС -ийн зээлээр суралцаж төгссөн 21 мянган төгсөгчийн 8 тэрбум төгрөгийн зээл, түүний хүүгийн төлбөрийг ЗГ-ын 2004 оны 22 дугаар тогтоолоор, Өндөр хөгжилтэй

³ УИХ -ын ЭЗБХ-ны саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. УБ., 2007 он

орны магистр, докторантурт хөнгөлттэй зээлээр суралцан ирээд эх орондоо үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлгийн зээл, түүний хүүгийн төлбөрийг 2008 оны ЗГ-ын 178 дугаар тогтоолоор тус тус чөлөөлсөн явдал юм. Сургалтын зээл, түүний хүүг төлүүлэлгүй чөлөөлсөн нь сургалтын зээлийн агуулга ач холбогдлыг бууруулсан хэдий ч оюутны CTC-ийн хөнгөлттэй зээлд хамрагдах сонирхолыг нэмэгдүүлсэн.

* * *

Хоёрдугаар бүлэг: ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

/Харьцуулсан судалгаа/

Судалгааны хоёрдугаар бүлэгт гадаадын зарим орны төрөөс дээд боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг, туслалцааны төрөл, түүний хэлбэр, оюутнуудад үзүүлэх зээл, тэтгэлэгийн төрөл, түүнийг олгох шалгуур үзүүлэлт, зээлийг эргэн төлөх нөхцөл журам, тэтгэлгээс хасагдах болон тэтгэлэг олгохгүй байх хууль зүйн үндэслэл болон төрөөс боловсролын салбарт үзүүлж буй дэмжлэг туслалцааг хариуцан зохион байгуулж хэрэгжүүлж буй бие даасан байгууллага байдаг эсэх талаар голлон анхаарч холбогдох хууль, журмуудын эрх зүйн зохицуулалтыг ерөнхийд нь харьцуулан судалсан болно.

Судалгаанд хамруулсан улс орнуудыг сонгохдоо тухайн орны хөгжлийн үзүүлэлт, сургалтын зээл болон бусад дэмжлэгийн талаархи туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, түүнчлэн сургалтын чанарын үзүүлэлт зэрэг шалгууруудыг голлон өндөр хөгжилтэй орон, Азийн орон, хуучин социалист зэрэг орнуудыг бүлэглэн авч үзсэн гэдгийг дээр дурьдсан билээ. Судалгаанаас үзэхэд, Эдгээр улс нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиас гадна тухайн орны эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарсан бие даасан хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмуудын дагуу дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийг зохицуулдаг байна. Түүнчлэн хууль тогтоомжоос гадна төрийн бус байгууллага болон бусад олон улсын статустай байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг сургалтын тэтгэлэг хөтөлбөр олныг хэрэгжүүлдэг бөгөөд тус судалгаанд зөвхөн төрөөс баримталж буй бодлогыг авч үзсэн учраас хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд нь асуудлыг судалсан юм.

Судалгаанд хамрагдсан улсуудын хууль тогтоомжоос үзэхэд дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийн хэлбэрийг дараахь байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж буй сургалтын төлбөрийг төр хариуцах. Ийм бодлого баримталж буй улс оронд Турк, Энэтхэг, Швед, ОХУ, БНКАз Улс зэрэг улс орон багтдаг байна.
- Төрийн өмчийн их дээд сургуулийн барилга, байгууламж, сургалтын орчны зардлыг төрөөс хариуцах. Турк, Энэтхэг, Швед гэх мэт улс орнууд
- Сургалтын төлбөрийн зээл:
 1. Хүүтэй зээл
 2. Хүүгүй зээл
- Оюутны дотуур байрны зардлыг төр хариуцах
- Сургалтын ном хэрэгсэлээр хангах
- Оюутны эрүүл мэндийн үйлчилгээ
- Унааны зардал
- Оюутны тэтгэлэг .

Судалгааны харьцуулалт хамрагдсан ихэнхи улс оронд оюутны тэтгэлэг олгох эрх зүйн

зохицуулалттай бөгөөд тэтгэлэг олгох шалгуур үзүүлэлт болон тэтгэлэг олгохгүй байх шалгуур үзүүлэлт, тэтгэлэгээс хасах үндэслэл зэрэг асуудлыг хууль болон харийвчилсан дүрэм журмуудаар зохицуулсан байна.

Түүнчлэн оюутанд олгох тэтгэлэгийн хэмжээ жил бүрд харилцан адилгүй байх ба судалгааны харьцуулалтанд хамрагдсан улс орны эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн жилийн амьжиргааны түвшин, инфляцийн хувь хэмжээг харгалзан Боловсролын яамтай зөвшилцөн Сангийн яам, Засгийн газраас тогтоодог байна. Сургалтын төлбөрийн зээл болон сургалтын тэтгэлэгт хамрагдах хуульд заасан шалгуур үзүүлэлтийн хувьд улс орон бүрт харилцан адилгүй шалгууруудыг хуульчилсан боловч үндсэн шалгуур нь амжилттай суралцсан болон өрхийн орлогоос хамаардаг болох нь харагдаж байна. Түүнчлэн Турк, Их Британи зэрэг улс орны хувьд сургалтын төлбөрийн зээл болон тэтгэлэг олгохоос татгалзах үндэслэлүүдийг хуульд тусгайлан заасан байна.

Энэхүү бүлэгт тухайн орнуудын их, дээд сургууль, тэдгээрт суралцаж буй оюутнуудад төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл, түүн дотроо оюутнуудын тэтгэлэгийн төрлийг ялгаж үзүүлэх зорилгоор “төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцааны төрөл”, “тэтгэлэгийн төрөл” гэсэн доорхи харьцуулсан хүснэгтээр үзүүлсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээлэл авахийг хүсвэл судалгааны эх сурвалж болж буй вэбсайт болон СШОНХТ-ийн холбогдох судлаачдаас судалгаанд хамрагдсан хууль тогтоомжийг бүрэн эхээр үзэж болох юм.

* * *



Гадаадын зарим орнуудын төрөөс оюутнуудад олгож буй тэтгэлэгийн төрлүүд,
эрх зүйн зохицуулалтын харьцуулсан хүснэгт

Хүснэгт 2.

Эрх зүйн актууд	Тэтгэлэгийн хэлбэр	Тэтгэлэг олгох шалгуур үзүүлэлт	Тэтгэлэгээс хасах, олгохгүй байх тохиолдол	Хариуцсан байгууллага
1. Турк Улс -Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль -Тэтгэлэг, зээлийн журам Эх Сурвалж: http://www.mevzuat.adalet.gov.tr/html/1051.html http://mevzuat.meb.gov.tr/html/88.html	-Гадаад оюутны тэтгэлэг -Дотоод оюутны тэтгэлэг -Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	Доорхи тохиолдлоос бусад үндэслэлээр тэтгэлэг олгоно: -Бусад улсын байгууллагуудаас тэтгэлэг авдаг бол -Цалингийн доод хэмжээ болон түүнээс дээш тогтмол цалинтай ажилд ажилладаг бол -Тэтгэлэгт бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил улиран суралцсан бол -Гадаадын сурагчид -Цагдаагийн академи болон бусад цэргийн сургуулийн сурагчид -Сургууль төгсөх болсон боловч төгсөлгүй нэмэлт жилдээ суралцаж байгаа сурагчид -Магистрантур болон докторантурын хэлний бэлтгэл бүлэгт суралцаж байгаа сурагчид -Тэтгэлэг авах шаардлагагүйд тооцогдсон сурагчид	Сургалтын амжилтыг харгалзан хасна. -Хэрэв оюутан гуравдугаар курстээ нэгдүгээр курсын мэргэжлийн хичээлүүдээс 3 болон түүнээс дээш хичээлд унасан тохиолдолд -Нэг улиралд 4 болон түүнээс дээш хичээлд унасан тохиолдолд	Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллага



2. Их Британи -Оюутныг дэмжих тухай хууль /Higher Education act, part4 Student support act/ Эх сурвалж: www.opsi.gov.uk/ACTS/acts2002/ukpga_20020032_en_1	-Сургалтын төлбөрийн тэтгэлэг -Амьдралын зардлын тэтгэлэг	-Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт байх -Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болон тус улсад чөлөөтэй орж гарах -Оюутан болон түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харъяат бол -Оюутан тус улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан бол -Боловсролын хуульд заасан бусад тохиолдолд	Оюутан доорхи нөхцөлүүдэд тэтгэлэг хамрагдах эрхгүй: -Тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагч өмнө нь ямар нэгэн тэтгэлэг авсан бол -Тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд зээлд хамрагдаж байгаа бол -Өмнө нь авсан зээлээ төлөхдөө доголдол гаргасан бол -Тухайн оюутныг тэтгэлэг болон зээл авах шаардлагагүй гэж үзсэн бол	-Засгийн газар -Ассамблей
3. Япон Эх сурвалж http://www2.jasso.go.jp/about_jasso/index_e.html http://www.mext.go.jp/english/reform/index.htm http://www.mn.emb-japan.go.jp/	-Гадаад оюутны тэтгэлэг	- Их дээд сургуулийн дүнгийн голч-3,2 - Өмнө нь Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байсан бол эх орондоо ирсэнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн байх - Өмнө нь Япон улсын тэтгэлэгт хамрагдаж байгаагүй байх -Эрүүл мэндийн хувьд эрүүл байх - Насны хязгаарт заасан насны дотор байх	- Японы их, дээд сургуульд суралцаж байгаа хүн хамрагдах боломжгүй. - Өмнө нь өөрийн Засгийн газар болон олон улсын байгууллагын ямар нэгэн тэтгэлэгээр суралцаж байгаагүй байх	Тухайн улсад нь байгаа Элчин сайдын яам



<p>4. Солонгос</p> <p>Боловсролын суурь хууль</p> <p>Тэтгэлэг олгох журам</p> <p>Эх сурвалж: www.studyinkorea.go.kr www.ied.go.kr www.klaw.co.kr</p>	<p>-Гадаад оюутны тэтгэлэг</p> <ul style="list-style-type: none"> Бүтэн тэтгэлэг /Сургалтын төлбөр, цалин, судалгааны зардал, эрүүл мэндийн даатгал, онгоцны зардал/ Хагас тэтгэлэг /зөвхөн сургалтын төлбөр хамаарна/ 	<p>Сургууль бүр харилцан адилгүй шалгуур тавидаг. Нийтлэг тавигддаг шалгууруудад:</p> <ul style="list-style-type: none"> Англи болон солонгос хэлний өндөр мэдлэгтэй /Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын 5 эсвэл 6-д тэнцсэн байх/ Эрүүл мэндийн хувьд эрүүл Өмнө нь БНСУ-д визний хугацаа хэтрүүлэн амьдарч байгаагүй 	<p>-Өмнө нь өөр тэтгэлэг хамрагдаж байсан</p> <ul style="list-style-type: none"> Амжилттай суралцаж чадаагүй Тэтгэлэгийн хугацаандаа чөлөө авсан бол 2 улсын харьяалалтай бол 	<p>Боловсрол, шинжлэх ухаан, Технологийн яам</p>
--	--	---	--	--



№	Улс	Эрх зүйн актууд	Төрийн дэмжлэгийн хэлбэр	Зээл болон бусад дэмжлэг хамрагдах шалгуур үзүүлэлт	Зээлийг эргэн төлөх журм	Хүснэгт 2.1 Харуулан хэрэгжүүлэх байгууллага
• Өндөр хөгжилтэй орнууд						
1. Турк улс Эх Сурвалж: http://www.meszi.at/adatlar/dor-trb06ml1051.htm http://netgazet.org.tr/2013/01/10/1051.htm	Үндэсний боловсролын тухай хууль	Сургалтын төлбөрийг улс дахь -Тэтгэлэг олгох -Зээл олгох -Оюутны дотуур байрны төлбөрийг улс дахь	-Сургалтын төлбөрийг улс дахь -Зээл олгох -Оюутны дотуур байрны төлбөрийг улс дахь	Ажилтай сурсан -Ажилгааны түвшин дотуур	Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хуульд заасан журмын дагуу	-Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам -Сангийн яам
Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллагын тухай хууль	Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллагын тухай хууль	-Их дээд боловсролын зээл олгох -Тэтгэлэг олгох -Оюутны дотуур байрны дэмжлэг	-Их дээд боловсролын зээл олгох -Тэтгэлэг олгох -Оюутны дотуур байрны дэмжлэг	-Их дээд сургуульд сурсан -Ажилтай сурсан -Зээл авах хэрэгцээ шаардлагатай эсэх	Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хуульд заасан журмын дагуу	-Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам
Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль -Тэтгэлэг, зээлийн журам	Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль -Тэтгэлэг, зээлийн журам	-Их дээд боловсролын зээл олгох -Тэтгэлэг олгох	-Их дээд боловсролын зээл олгох -Тэтгэлэг олгох	Хуульд заасан зээл олгохоос татгалзахаас бусад тохиолдолд сургалтын зээл олгоно. Зээл олгохоос татгалзан тохиролдол: -Бусад улсын байгууллагуудад тэтгэлэг авдаг бол -Цалингийн дээд хэмжээ болон түүнээс дээш төлбөр цалинтай ажилдаа ажилладаг бол -Тэтгэлэг бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил унгаран суралцсан бол -Гадаадын суралцагчид -Цагдаагийн академид болон бусад цэргийн сургуулийн суралцагчид -Сургууль төгсөх болсон боловч	-Бакалаврын сургалтын дараагаар заасаргүйгээр зэвсэглэгчид, магистр, докторын сургуулиа төгссөн 2 жилийн дараагаас эхлэн, -Бакалаврын сургалтын дараагаар заасаргүйгээр магистрын сургалтанд элсэн 4 жилийн дараагаас эхлэн, -Бакалавр болон магистрын сургалтын дараагаар зэвсэглэгчид, докторын сургалтанд элссэн суралцагчид төгссөнөөс хойш 2 жилийн	-Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллага -Үндэсний боловсролын нам -Сангийн яам

3. Австрали Эх сурвалж: www.austlii.edu.au/au/other/aufrdf/html/af/af1976307/af1976307.html	Дээд боловсролын төрийн дэмжлэгийн тухай хууль (State Grant (Advanced Education) Act 1976)	Дотоодын оюутанд үзүүлэх дэмжлэг: -Сургалтын төлбөрийн дээд буцаалтгүй тусламж: Амьжиргааны тэтгэлэг b) Сургалтын материал -Оюутны байр Гаднах оюутанд үзүүлэх дэмжлэг: -Сургалтын төлбөрийн тэтгэлэг (Lift-out) -Зуул мэндийн үйлчилгээ -Тэтгэлэг	Дээрх нэхдүүдийг хамгасан төсөлдөө оюутан нь эзлэх хэмжээгх эрхтэй: -Оюутан тухайн жилд нэгэн сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгаа бол -Оюутан нь тухайн хичээлийн жилд ABSTUDY-ийн схемд заагдсан тусламж дэмжлэгүүдийг авах эрхийг хамгасан бол -Оюутны эцэг, эх, асран хамгаалагчийн нийт орлого хуульд заасан шаардлагатай хэмжээндээ бага бол -Оюутан амжилттай суралцсан бол	Эзлүүлэх дараах журмаар эрхэн төлнө: -Эзлэж авсан оюутан эзлэх үндсэн эзлэлээ төлнө. ЗГ оюутны нэрийн өмчөөс үүгийн өрсөлд татаас төлнө. -Оюутан гэрээнд заасан үндсэн эзлэлээ гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш дараа жилийн 6-р сарын нэгдүгээс эхлэн төлнө. -Оюутан хүсвэл эзлэлээ гэрээний хугацаанаас нь өмнө төлж болно. -Оюутан эзлэлээ гэрээний хугацаанд бүрэн төлж чадаагүй тохиолдолд эзлэлээ оюутны өмчөөс ЗГ тэтгэж, оюутны орлого төлбөрийг түшигд хурсамь дараа татварын системээр эргүүлэн авч болно.	-Ажил эрхлэлт, боловсрол, сургалт, залуучын хэргийн нам (Department of Employment, Education, Training and Youth Affairs) -Эзлэлийн сан (Loan Fund) -Нэгдсэн орлогын сан (Consolidated Revenue Fund)
4. Швед	Боловсролын хууль (Act 2000)	- Тэтгэлэг - Амьжиргааны зардал	- 2 нарийн хэвлэлээр орны оюутан - Нэр заасан магистрын хөтөлбөрт хамрагдах зүсэлтэй	Шведийн институт	
5. ОХУ	№125-ФЗ Дээд болон дээд боловсролын дараах боловсролын тухай	-Сургалтын зардал -Харууша -Оюутны байрны төлбөр -Номын сангийн үйлчилгээ	2 бүтээл үзүүл. Оюутан дор дурдсан эрхтэй: 3 Төрөөс дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын алгуу байдлыг хамгаана.	Засгийн газар	15 бүтээл үзүүл. 2 дахь хэсэг 5 дүгээр сургуулийн номын санга ном болон мэргэжлийн сангаар төлбөртүй үнэмлүүлээ 3... Оюутны байр нь зуул эхгүйн нормыг хамгасан байна. ...

		<p>-Тэтгэлэг, 18.3.Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын өдрийн ангид сураацаж байгаа оюутнуудад сард тэтгэлэг олгоно. Зөвхөн тэтгэлгийг олгох журмыг Холбооны Засгийн газар тогтооно.</p>	<p>516.3. Төрийн өмчийн дээд мэргэжлийн боловсролын байгууллагыг Холбооны төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. ОХУ-д амьдарч байгаа 10000 хүн тутамд нэгдөх 176 оюутны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад сураацаахаар зардлыг санхүүжүүлэх зорилгоор Холбооны төсвийн хөрөнгийн 3 %-ээс доошгүй хөрөнгийг дээд мэргэжлийн боловсролд зориулна.</p> <p>-Төрийн дүүргийн ЦП туслахыг өмчийн эсвэл өмчийн асрамжгүй үлдсэн оюутны тэтгэлэг ердийнхөөс 50%-иар нүүр байна.</p> <p>ОХУ-ын зэвсэгт хүчний аль нэг байгууллагад нэрлэг, түрүүлч, ахлагчид алба хаасан өдрийн ангийн оюутнуудын тэтгэлэг ердийнхөөс 50%-иар нүүр байна. Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагын өдрийн ангийн оюутнуудын тэтгэлэг хэлбэрээр тэтгэлгийн фондыг 25%-иар нэмэгдүүлж олгоно. Нийтийг хамарсан соёл, спорт, урлагийн болон эрүүл мэндийн компанит ажилд хамрагдсан өдрийн ангийн оюутнуудад Холбооны төрийн өмчийн дээд боловсролын байгууллагаас 2 сарын тэтгэлэгтэй тэнцэх акадeмe-тэтгэлэг олгоно</p>	<p>Оюутны байрын төлбөр нь түүний тэтгэлгийн 5%-иас нүүргүй байна</p>	
5. Казахстан	Боловсролын тухай хууль	<p>-Тэтгэлэг -Улааны зардал -Сурааагчдын төлбөрийг төр хариуцна -Бүтэцтэй тусламж</p>	<p>535.1. ...Мэргэн шалгаруулалтын үндсэн дээр төлбөртэй боловсрол эзэмших эрхтэй</p> <p>547. Сураацагчдын эрх үүрэг:</p> <p>7. Боловсролын байгууллагад сураацаж байгаа зарим</p>	<p>-47 дугаар зүйл, 13. ... Улсын захиралгаар сураацагчдын өөлж, зуны амралтаар хот хоорондын төмөр зам, автозамын тасвинаас бусад, нь зардлыг хөнгөлнө.</p>	<p>Казахстан улсын Засгийн газар, ЗГ-ын бүрэн эрх, 151 "Болаша" олон улсын тэтгэлэгт хамрагчдыг</p>

			<p>категорын сураацагчид Казахстан улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрийн нэр заасан тэтгэлэг олгоно. Дээд боловсролын болон шинжлэх ухааны байгууллагад өдөрөөр сураацаж байгаа ахлагчид хичээнгүй магиструуд дээд боловсролын байгууллагад сураацаж байгаа оюутнуудад төрөөс нэр заан олгох тэтгэлгийг дээд боловсролын болон шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтдийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж олгоно.</p> <p>8. Төрийн шалгаруулалтаар үйл ажиллагаа нь тогтвортой болох нь тогтоогдсон төрийн өмчийн боловсролын байгууллагаас бага орлоготой гэр бүлийн сураацагчид тэтгэлэг олгоно.Тэтгэлэг олгох журмыг тэтгэлгийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p> <p>11. Өмчийн эсвэл өмчийн асрамжгүй үлдсэн хүүхдийн сурааагчдын зардлыг улсын төсвөөс бүрэн хэмжээгээр санхүүжүүлнэ.</p>		<p>шалгаруулах дүрмийг батлах</p>
7. БНБел Улс	Дээд боловсролын тухай хууль	<p>-Сурааагчдын төлбөрийн дээд тэтгэлэг</p>	<p>530. Дээд сургуулийн оюутны эрх үүрэг хариуцлага</p> <p>1. Оюутан дор дурсан эрхтэй: 1.1. Беларусь улсын хуулиар тогтоосон нөхцөл журмын дагуу тэтгэлэг авах</p> <p>2. Оюутан дор дурссан үүрэгтэй: а. ЦП шатны дээд боловсролыг улсын төсвийн хөрөнгөөр өдөрөөр, түүний дотор зориулт гаргахаар сураацагчид Беларусь улсын Засгийн</p>	<p>Засгийн эргэн төлөлт -Хулаар өөрсөж газарт 2 жил хуралгүй хугацаанд амжилтасан бол сураацагдаа зарцуулсан төсвийн хөрөнгийг нөхөн төлбөр, хулаарыг газартаа ажиллаж байгаа төсвөгч дээд боловсролын баримт бичиг авсан жилдээ магистрантур, докторантур зохиж журмын дагуу элсэн сураагсан бол төсвийн хөрөнгийг нөхөн төлбөөс чөлөөлөгдөнө</p>	<p>-Засгийн газар</p>

9. Солонгос	Боловсролын суурь хууль	Дотоодын оюутангуудад - Улс бүрэн даах - Тэтгэлэг олгох - Эзэл олох Гадаад оюутангуудад - Тэтгэлэг буюу буцалтгүй тусламж	- Багийн мэргэжлээр суралцагч - Шалдлагаар салбарын мэргэжлээр суралцагч болон судлаач - Адийн засгийн хувьд хүнд хэцүү	- Болговсрол, шинжлэх ухаан, технологийн ням - Мэдээлэл - Маркетингийн аам Боловсролын бизнесийн алба
	Боловсролын байгууллагын анхны калонд хууль			Сургалтын тэтгэлэг авсан этгээд Их сургууль төгссөөнөөс хойш 4 жилийн хугацаанд орон нутгийн бэлч нэрлэн шалгаруулалтад оролцож тавцсэн тохиолдолд тэтгэлэгт камрагдсан хугацааны хоёрны жилийн хугацаанд тухайн орон нутагт байлалч ботой.
	Сургалтын тэтгэлэг олгох журам		- Ахлаас чадвартай боловч төлбөрийн чадваргүй этгээд - Гоц аялаастай - Их сургуулийн газар тархалтын салбарт суралцаж төгссөөд тухайн салбарт ажиллах хүсэлтэй	
10. Япон	Боловсролын суурь хууль	- Хүүгүй эзэл - Хүүтэй эзэл - Тэтгэлэг - Амьдралын - Тэтгэлэг Гадаад оюутны буцалтгүй тусламж буюу тэтгэлэг - Багш арын - Магистрын - Докторын	- 2004 оны 4 сараас өмнө дунд сургууль болон мэргэжлийн боловсрол олгох коллеж, Их сургууль, тэнгисийн коллежид элсэн орсон баах - Адийн засгийн хувьд суралцаж боломжгүй	Сургууль төгссөний дараа автоматаар сар 2 сар, халас жагээр хэсчлэсэн төлөг. Төлөг хугацааг дараах тохиолдолд хойлуулж болно. 1. Гай зовлон болон өмчн эмгэг тохиолдсон, гэмтэн ботсөн 2. Түргэлжүүлэн суралцаж байгаа Хүүтэй эзэлхйн хувьд оюутан нь суралцаж хугацаандаа үр бүтээлтэй сайн суралцсан гэж JASSO-оос хүлээн зовшөөрсөн бол эзэлхйн хугацаа дуусахад

11. Монгол улс	Боловсролын тухай хууль 29.7-д /эрөнхий заалт/	Орсон нутгийг боловсон хүчээр хамгах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн амьсласыг дэмжж, орлого баатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшэхэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд гэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.		Бүтнээр болон хатгасан зээлээс чөлөөлнө. Хүүтэй зээлийн хувьд нэс барсан, бие махбодын болон сэтгэл мэдрэлийн чадваргүй бол төлөх боломжгүй болж зээлээс чөлөөлнө.
	Дээд боловсролын тухай хууль 119 дүгээр зүйлд хуульчилсан шалгуурыг 3Г-ын 177-р тогтоол, 201-р тогтоолд журамласнаар зохицуулна./	19.1. Боловсролын тухай хуулийн 43.2.1-д заасны дагуу дотуур байрлаар үнэмлэнэ. 19.2. хэлтэст, буцалтгүй тусламж, Суралцагчид	Оршин суугаа газраасаа сургуулиаа тогтмол нээх боломжгүй суралцагчид - Өнчрөн, тахир адуу болон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн болон бусад шаардлагатай суралцагчид - Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид	Суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох журмыг Засгийн газар тогтооно.

	Сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй зээл олгоно. 19.3. нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөхүүлэн дэмжнэ. 19.5. улирлын болон төгсөлийн шалгалт өгөх, дипломын хэлбэр бичиж хамгаалахад зориулж шалгалттай чөлөө олгоно.	Дээд боловсролын сургалтын байгууллагад эгнээ, өрхийн хэлбэрээр суралцагчид		Ажлын газар нь
3Г-ын 177-р тогтоол	- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжаар	Улсын хэмжээний олимпадад эхний 3 байр эзэлсэн оюутан -Олон улсын зэрэглэлийн олимпадад уралдаж, тэмцээнд МУ-ийг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн - Бүтэн өгчийн суралцагчийн -Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч -өрхийн нэг хүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн -өрхийн нэг хүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшиний 50 хувиас доогуур орлоготой өрхийн	Эргэн төлөх нөхцөлгүйгээр олгогдоно. Гэдгээр болохыг хангасан голч дүн 2.8-2.0-оос доошгүй байх шаардлага тавигддаг!	Засгийн газар -БШСУЯ -СЗЗЯ -СТС-г сургалтын төрлийн сангаар дамжин олгогддог!

Дүгнэлт, Санал Зөвлөмж

Дээрхи харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын хуулийн зохицуулалтаас дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Сургалтын төлбөрийг төр бүрэн хариуцдаг бөгөөд оюутны тэтгэлэг олгодог улс орон. Ийм бодлогыг баримталдаг улс оронд Турк, Энэтхэг, Швед, ОХУ, зэрэг улс орнууд багтаж байна. Тухайлбал Швед улс нь өөрийн орны оюутнуудын хувьд их сургуулийн үнсэн ангиудын сургалтын төлбөрийг төр хариуцах бөгөөд нийт оюутнуудад сар бүр тогтмол цалин олгодог байна. Тус цалин оюутны амьдрах зардалд зориулагдан олгогдох бөгөөд тэтгэлэгийг эхний ээлжинд нэг жилээр олгодог бөгөөд цаашид амжилттай сайн суралцсан тухай нотолгоо үзүүлсэн тохиолдолд цааш нь үргэлжлүүлэн олгодог. Гадаад оюутнуудын хувьд харилцан адилгүй шалгууртай байдаг бөгөөд оюутан солилцох гэрээ байгуулсан орнуудын хувьд шалгуур харьцангуй бага байдаг. Харин хуульд заасан болзол журмаар бакалавр болон магистрийн сургалтанд хамрагдаж байгаа гадаадын суралцагчид сургалтын төлбөр төлөхгүй боловч амьжиргааны тэтгэлэгт хамрагддаггүй байна. Турк улсын хувьд сургалтын төлбөрийг төр хариуцах бөгөөд оюутнуудын хувьд сургуульд бага хэмжээний хандив буюу “Contribution” төлдөг бөгөөд хуульд заасан үндэслэлийг хангасан оюутнууд сар бүрийн тэтгэлэгт хамрагдах эрхтэй болдог байна. ОХУ-д дээд боловсрол үндсэндээ төлбөргүй байх бөгөөд тодорхой нөхцөл шалгуур, журмын дагуу төлбөртэй сургалт явуулахыг л зөвшөөрдөг. Оюутанд тэтгэлэг өгдөг.
2. Сургалтын төлбөрийг оюутан хариуцах бөгөөд төрөөс оюутанд тэтгэлэг олгодог улс орон. Ийм улс оронд хууль болон журамд заасан үндэслэлийг хангасан оюутнуудын төлбөрийг улс хариуцах буюу буцалтгүй тусламж олгох бөгөөд бусад тохиолдолд оюутан сургалтын төлбөрийг өөрөө даадаг улс орныг хамруулж болно. Үүнд Япон, Солонгос, Казахстан, Австрали, Их Британи зэрэг улс орон багтаж байна. Тухайлбал, Англи улсын хувьд оюутны сургалтын төлбөрийн зээл болон, хоол байрны зардал зэрэг амьжиргааны тэтгэлэгийг Засгийн газраас “Grant” буюу дэмжлэг хэлбэрээр авдаг хуулийн зохицуулалт үйлчилж байна. Оюутны тэтгэлэгийн хэмжээг Higher Educatuin act, part4 Student support act-д заасны дагуу тухайн жилийн амьжиргааны түвшинг харгалзан Засгийн газраас тогтоодог байна. Австрали улсын хувьд оюутанд олгох тэтгэлэг болон бусад дэмжлэгийг гадаад, дотоодын оюутан тус бүрээр зохицуулсан Student assistance act, Education services for Overseas Students act зэрэг хуулиудаар тусгайлан зохицуулж байна.
3. Сургалтын төлбөрийг оюутан хариуцах бөгөөд тэтгэлэг олгодоггүй улс орон. Үүнд хууль болон Засгийн газраас тогтоосон дүрэм журманд тусгайлан зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн болон хувийн өмчийн аль ч сургуульд сургалтын төлбөрийг оюутан хариуцдаг. Түүнчлэн төрөөс бүх оюутанд хуульд заасан журмаар тэтгэлэг олгодоггүй улс орныг ойлгож болно. Үүнд Беларусь улс болон манай улсыг хамааруулж болно.

Сүүлийн жилүүдэд манай орны хувьд мэргэжлийн боловсрол олгож буй сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагчдад зориулсан сар бүрийн амьжиргааны тэтгэлэг болох 45 мянган төгрөгийг олгож байгаа юм. Энэ нь хүүхдүүдийн сурах идэвхийг нэмэгдүүлж, хичээлд хамрагдах нийт суралцагчдын ирцэд сайнаар нөлөөлж байгаа нь практикаас харагдаж байна.

Аль ч улс орны хувьд сурч боловсрох таатай орчин бүрдсэн тохиолдолд чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэх боломж хангагдах бөгөөд тэр хирээр ажил олгогчдын шаардлагыг хангасан ажиллах хүч нэмэгдэнэ гэж үзэх үндэслэлтэй юм. Түүнээс гадна оюутнуудыг хичээлдээ бүрэн хамрагдах нэг хүчин зүйл нь тэтгэлэг байхаар зохицуулж

Суралцагчийн Хангалтын тоонд багтаан сургуулиа хөгсөөд өрөн нутагт 3-аас дээш жил ажиллахаар гэрээ байгуулсан суралцагчийн	Эргэн төлөгдөх нөхцөлгүй олгогдох.	Засгийн газар -БШСУЯ -СЗЗЯ -СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогдох/
-3Г хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын байгууллагад амьжиргааны тэтгэлэгийг эргэн суралцаж байгаа МУ-ын иргэнд -3Г хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд	-төгссөнөөс хойш 5 жилийн дотор төлж барагдуулна, -ээдлийн гэрээгээ зөрчвөл ээдлийн хүүгийн хялт буцаан төлнө, -суралцагч нас барсан, хөдөлмөрийн чадвараа 70, түүнээс дээш хувиар алдсан бол ээдлийн төлбөрөөс чөлөөлнө, -нийслэлд төсвийн байгууллагад 5-аас доошгүй, орон нутагт ман 3-аас доошгүй жил ажилласан бол эзэлжээс чөлөөлнө.	Засгийн газар -БШСУЯ -СЗЗЯ -СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогдох/
Амьжиргааны тэтгэлэгийн буцалтгүй тусламжаар	-Халас өмчийн суралцагчид -Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч -Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар маасан суралцагч -Бог малд шилжүүлсэнээр өрхийн нэг гишүүнд 100 хургал тоотой мал ногдох зохих малчин өрхийн суралцагч -Олон улсын нэр хүндтэй гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчид	Засгийн газар -БШСУЯ -СЗЗЯ -СТС /сургалтын төрийн сангаар дамжин олгогдох/
ЗГ-ын 201-р тогтоол "Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журал"	Эргэн төлөгдөх нөхцөлгүй	Төр хариуцна, /санхүүжилт төрийн сангаар дамжин олгогдох/

болно гэж үзэж байна Иймд судалгаанд хамрагдсан Япон, Солонгос, Их Британи, Казахстан зэрэг улс орны эрх зүйн зохицуулалтын ерөнхий жишгийг харгалзан үзэж оюутнуудад ном сурах бичигтээ зарцуулахад нь зориулж, тодорхой шалгуураар олгох сар бүрийн, тогтмол тэтгэлэгт хамруулах бодлого баримтлах асуудлыг төрөөс анхаарч үзэх үндэслэлтэй юм.

* * *

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Боловсролын тухай хууль
2. Дээд боловсролын тухай хууль
3. Засгийн газрын тогтоолууд /ЗГ-1993-107,ЗГ-1995-194,ЗГ-1997-179,ЗГ-2000-96,ЗГ-2000-158,ЗГ-2000-201,2001-195,ЗГ-2002-207,ЗГ-2003-61,ЗГ-2003-139,ЗГ-2008-177,ЗГ-2008-178/
4. БСШУЯ-ны сайдын хамтарсан тушаал /2000-310/290тоот тушаал,2008-451/318тоот тушаал/
5. УИХ-ын ЭЗБХ-ны саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан 2007 он
6. МУ-ын Боловсролын тогтолцоо ба сургалтын төрийн сан: “Тогтвортой ирээдүйг бий болгох” судалгааны тайлан 2004 он
7. Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны тайлан 2008 он
8. Сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид зарцуулсан хөрөнгийн судалгаа 2008 он
9. Сургалтын төрийн сангийн зээл, тусламжид хамрагдагсдын судалгаа 2008 он
10. Монгол улсын дээд боловсролын мэдээлэл 2008 он
11. “Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн мониторинг судалгаа” 2007 он /Зориг сан Нээлттэй нийгэм Форум/
12. “Боловсрол” УИХТГ-ын номын сангийн сонингийн эмхэтгэл 1,2-р боть
13. “Боловсролын тогтолцоо олон улсад” Ч.Пүрэвдорж. УБ., 1999 он
14. “Америкийн дээд боловсрол” Д.Бадарч. УБ., 1999 он

Гадаад хэл дээрхи:

Турк улсын хуулиуд:

- Үндэсний боловсролын тухай хууль
- Дээд боловсролын зээл, оюутны дотуур байрны байгууллагын тухай хууль
- Дээд боловсролын зээл, тэтгэлэг олгох тухай хууль
- Тэтгэлэг, зээлийн журам

Их Британийн хуулиуд:

- Higher Education act, part4 Student support act
- Education act 2002
- The Education (Grant) Regulations 1990
- Education (Training Grants) Regulations 1990

Авсртали улсын хуулиуд:

- Student assistance act 1973
- Education services for Overseas Students (Assurance Fund Contributions) act 2000

- State Grant (Advanced Education) Act 1976

Энэтхэг улсын хуулиуд:

- Central Education Institutions (Reservation and Admission) Act 2006
- The University Grants Commission Act 1956, rules and regulation under the act

Швед улсын хуулиуд:

- Шведийн Боловсролын хууль

Бусад

- №125-ФЗ Дээд болон дээд боловсролын дараахь боловсролын тухай-ОХУ
- Боловсролын тухай хууль-БНКаЗУ
- Дээд боловсролын тухай хууль-БНБелУ
- Боловсролын суурь хууль -Солонгос
- Боловсролын байгууллагын албан хаагчдын хууль- Солонгос
- Сургалтын тэтгэлэг олгох журам-Япон
- Боловсролын суурь \үндсэн\ хууль- Япон

Website:

1. www.Edulaws.pmis.gov.mn
2. www.pmis.gov.mn
3. www.student.org.mn
4. www.iltod.gov.mn
5. www.forum.mn



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТӨРИЙН ОДОН, МЕДАЛЬ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР, ОЛГОХ ЖУРМЫН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ц. Норовдондог (Ph.D), А. Пагма (МА)
Ш. Хишигсүрэн, Г. Чулуун

СЭДВИЙН АГУУЛГА

1. Хуучин социалист системийн орнуудын төрийн шагналын систем, түүний шинэчлэл

- 1.1. ОХУ-ын төрийн шагналын систем, түүний шинэчлэл
- 1.2. БНКаЗУ-ын төрийн шагналын систем, түүний шинэчлэл
- 1.3. БНПУ, БНЧУ-ын төрийн шагналын системийн шинэчлэлийн тойм

2. Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал ба төрийн шагналын өнөөгийн систем

- 2.1. Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал
- 2.2. Монгол Улсын төрийн шагналын өнөөгийн систем

3. Бусад орнуудын төрийн одон, медалийн систем, түүний онцлог

- 3.1. Бүгд Найрамдах Турк Улсын төрийн шагналын систем, онцлог
- 3.2. Их Британи, ХБНГУ, АНУ-ын төрийн шагналын системийн тойм

4. Судалгааны дүгнэлт

Хавсралт 1.

- ОХУ, БНКаЗУ, БНПУ -ын төрийн шагналууд

Хавсралт 2.

- Монгол Улсын шагнал, одон медалийн өнөөгийн тогтолцоог төгөлдөршүүлэх чиглэлээр хэвлэгдэн гарсан ном, товхимол, өгүүлэл, нийтлэл, бусад мэдээллийн талаар лавлагаа, мэдээлэл

Хавсралт 3.

- Богд хаант Монгол Улсын Эрдэнийн очир одонгийн тухай товч танилцуулга

Ашигласан материалын жагсаалт

УДИРТГАЛ

“Төрийн одон, медаль, түүний хэлбэр, олгох журмын талаархи харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа шинжилгээ олон нийттэй харилцах төвийн судлаачдын баг гүйцэтгэв. Судалгааны багийг Улсын Их Хурлын Тамгын Газрын СШОНХТ -ийн дарга Ц. Норовдондог (Ph.D) удирдаж, референт-судлаач А.Пагма /Удиртгал, I бүлэг, дүгнэлт/ референт - шинжээч Г. Чулуун /II бүлэг/, референт - судлаач Ш. Хишигсүрэн /III бүлэг/ нар бэлтгэсэн болно.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал, төрийн

шагналын өнөөгийн системийг тодорхойлон, бусад орнуудын төрийн шагналын систем, онцлог, түүний дотор постсоциалист орнуудын төрийн шагналын системийн шинэчлэлийг харьцуулан манай улсын өнөөгийн төрийн шагналын системийн талаар нэгдсэн дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Хуучин социалист системийн орнуудын төрийн шагналын систем, түүний шинэчлэлийг харьцуулан судлах,
- Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал ба төрийн шагналын өнөөгийн системийг судлах, лавлагаа, мэдээлэл бэлтгэх
- Бусад орнуудын төрийн одон, медалийн систем, түүний онцлогыг харьцуулан судлах
- Төрийн шагналын системийн талаар харьцуулсан дүгнэлт хийх

Судалгааны аргачлал:

- Бусад улс орнуудын төрийн шагналын талаархи хууль, журмын харьцуулалт,
- Түүхчилсэн шинжилгээ,
- Бичиг баримтын контент анализын судалгаа

Судалгааны ажлын хүрээнд дараахи үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно.

Үүнд:

- Бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Төрийн шагналтай холбоотой бичиг баримтын контент анализ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

1. ХУУЧИН СОЦИАЛИСТ СИСТЕМИЙН ОРНУУДЫН ТӨРИЙН ОДОН, МЕДАЛИЙН ЖУРАМ, ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛ

1.1. ОХУ-ын төрийн шагналын систем, түүний шинэчлэл

ОХУ -ын төрийн шагнал нь Эх орноо хамгаалах үйлс, төрийн байгуулал, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл, урлаг, хүмүүжил, гэгээрэл, эрүүл мэнд, иргэдийн амьдрал, эрх чөлөө, буяны үйлсэд онцгой гавъяа байгуулсан иргэдэд төрөөс тэдний хөдөлмөр зүтгэл, онцгой гавъяаг үнэлэн олгодог шагнал, урамшууллын дээд хэлбэр юм.

Дараах шагналууд нь ОХУ-ын төрийн шагналууд болно. Үүнд:

- ОХУ -ын Баатар цол
- ОХУ -ын одонгууд
- ОХУ -ын медалиуд
- ОХУ -ын шалгарсны тэмдэг
- ОХУ -ын хүндэт цол эдгээр болно.

ОХУ-ын Ерөнхийлөгч төрийн шагнал бий болгох тухай болон төрийн шагналаар шагнах тухай зарлигыг гаргаж, шагналыг гардуулдаг. Түүнчлэн ОХУ-ын Ерөнхийлөгчийн даалгаснаар, түүний нэрийн өмнөөс дараах албан тушаалтнууд төрийн шагналыг гардуулж болно. Үүнд:

- Төрийн эрх мэдлийн холбооны байгууллага болон холбооны төрийн байгууллагын удирдах ажилтнууд
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн захиргааны газрын боловсон хүчин, шагнал хариуцсан газрын дарга
- ОХУ -ын субъектүүдийн төрийн байгууллагуудын удирдах ажилтнууд
- ОХУ -ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгчид
- ОХУ-ын элчин сайдууд
- Цэргийн дарга нар- /дивизийн командлагчийн хэмжээний эрх мэдэлтэй дарга нар/
- Бусад хүмүүс

ОХУ -ын төрийн шагналаар ОХУ -ын иргэд, гадаадын харъяат иргэд мөн харъяалалгүй хүмүүс шагнагдаж болно. Эр зориг, авхаалж самбаа гаргасны төлөө шагнагддаг зэрэг бүхий төрийн шагналаас бусад төрийн шагналаар нэг хүнийг давтан шагнадаггүй байна.

1.1.1. ОХУ-ын шагналын системийн шинэчлэлийн тойм

Хуучин ЗХУ -ын задралын дараа 1992 оны эхэн үеэс ОХУ-ын төрийн шагналын бие даасан шинэ систем бүрэлдэж эхэлжээ. ОХУ-ын шагналын тухай анхны эрх зүйн акт нь 1992 оны 3 дугаар сард гарсан ОХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдын “ОХУ-ын төрийн шагналын тухай” Зарлиг байсан бөгөөд уг зарлигын дагуу хуучин ЗХУ-ын зарим одон, медалийг хүчин төгөлдөр үлдээж ашиглаж болох тухай заасан байна.

Энэхүү зарлигийн дагуу дараах одон медалийг хэвээр үлдээжээ. Үүнд: “Суворовын” одон, “Ушаковын” одон, “Кутузовын” одон, “Нахимовын” одон, “Александр Невскийн” одон, “Ард түмнүүдийн найрамдлын” одон, “Эр зориг гаргасны төлөө” одон болон “Ушаковын” медаль, “Нахимовын” медаль, “Чин зоригийн” медаль зэрэг 9 медалийг хэвээр үлдээсэн болно. Мөн энэхүү зарилгаар Эзэнт оросын үеийн цэргийн одон болох “Ариун Зовлон эдлэгч ба Ялан дийлэгчийн” одон, түүний ялгах тэмдэг болох “Георгиевын загалмай” сэргээсэн байна.

Дээрх зарлигийг гарсан үеэс буюу 1992 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1994 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “ОХУ-ын төрийн шагналын тухай” зарлиг гарах хүртэл хугацаанд дээр дурьдсан одон, медалиудаар ОХУ-ын иргэдийг шагнаж байсан ба энэ үеийг ОХУ-ын шагналын системийн шилжилтын үе гэж нэрлэдэг.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1994 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “ОХУ-ын төрийн шагналын тухай” зарлиг гарсан үеэс ОХУ -ын орчин үеийн шагналын шинэ систем тогтож, баталгаажигд эхэлсэн гэж үздэг. Энэ зарлигийн дагуу 1992 оны зарлигаар үлдээсэн хуучин ЗХУ-ын зарим шагналыг үлдээсэн хэдий ч 1994 оны Ерөнхийлөгчийн зарлиг нь ОХУ-ын шагналын системд томоохон өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, “Эх орны өмнө байгуулсан гавъяаны төлөө” одон, “Жуковын” одон, “Нестеровын” медаль, “Албан үүргээ нэр төртэй биелүүлсний төлөө” тэмдэг зэрэг шинэ одон, медаль, шалгарсны тэмдгийг бий болгожээ.

ОХУ-ын шагналын системийн шинэчлэлийн нэг чухал үе шат нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1998 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн “Ариун айлдагч Андрей Первозваннын одонг сэргээх тухай” зарлиг бөгөөд энэхүү зарлигаар Б.Ельцин Хаант Оросын үеийн “Ариун айлдагч Андрей Первозваннын” одонг сэргээж, төрийн дээд шагнал болгон түүний Статут буюу журам, тодорхойлолтыг баталжээ.

1999 онд Ерөнхийлөгчийн зарилгаар Пушкины медалийг бий болгосон бол 2000 онд Ерөнхийлөгч В.Путин “Гэгээн Георгиевийн одонгийн Статут ба Георгиевийн загалмайн тэмдгийн журмын тухай” зарлигийг баталж, Гэгээн Георгиевийн одонг ОХУ-ын цэргийн дээд шагнал болгосон байна.

2008 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Д. Медведев зарлиг гаргаж хүүхдийн хүмүүжил, гэр

бүлийг бэхжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, гавъяаг үнэлж, урамшуулах зорилгоор “Эцэг, эхийн алдрын” одонг бий болгожээ. Энэхүү одон нь хуучин ЗХУ-ын үед эхчүүдийг урамшуулан шагнадаг байсан “Алдарт эхийн” одон, “Эхийн алдар” одон, Эхийн медаль зэрэг шагналын уламжлалыг өвлөн авчээ.

Хүндэт цолны хувьд 1992 оны ОХУ-ын хуулиар “ОХУ-ын сансрын нисгэгч”, “ОХУ-ын цэргийн гавъяат нисгэгч”, “ОХУ-ын цэргийн гавъяат штурман” зэрэг цолыг бий болгосон бол ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1995 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн зарлигаар эдүгээ ОХУ-д иргэдэд хүртээж буй цолнуудыг бий болгосон байна.

Ийнхүү орчин үеийн Оросын төрийн шагналын систем нь 1990-ээд оноос эхэлсэн улс төр-эрх зүйн өөрчлөлтийг тусгахын зэрэгцээ Оросын төр, нийгмийн олон зуун жилийн хөгжлийн өвөрмөц толь болж байдаг байна.

1.1.2. Эрх зүйн зохицуулалтын үндэс

ОХУ-ын төрийн шагналын эрх зүйн зохицуулалтын үндсийг ОХУ-ын Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлд “Оросын Холбооны Улсын төрийн шагнал, хүндэт цол нь... Оросын Холбооны Улсын мэдэлд байна”, 89 дүгээр зүйлд “Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч ... Оросын Холбооны Улсын төрийн шагналаар шагнаж, Оросын Холбооны Улсын хүндэт цолыг хүртээж, цэргийн дээд болон тусгай цолыг олгоно” гэж тодорхойлжээ.

Судлаачдын тодорхойлсноор ОХУ-ын Үндсэн хуулинд ОХУ-ын Ерөнхийлөгчийн төрийн шагналаар шагнах эрхийг хуульчилсан хэдий ч өнөөгийн төрийн байгуулалтын практикт энэ хэм хэмжээ өргөн хүрээнд тусгалаа олж, төрийн тэргүүн төрийн шагналыг баталж, шагнах ерөнхий дэг журмыг тогтоож, шагнах болон бусад төрийн шагналтай холбоотой асуудлыг зохицуулж байна. Ийнхүү төрийн шагналын хүрээний асуудлыг зохицуулж буй эрх зүйн баримт бичгийн үндэс нь ОХУ -ын Ерөнхийлөгчийн эрх зүйн актууд –зарлиг, захирамж юм.

Өнөөгийн байдлаар ОХУ-ын төрийн шагналаас цөөн тооны шагнал нь хуулиар тогтоогдсон байна. Үүнд:

- ОХУ-ын Баатар цол ба “Алтан од” медаль
- “Чөлөөт Оросын Хамгаалагчид” медаль
- “Эх орны Агуу их дайны 50 жилийн Ялалтын” медаль
- “ОХУ-ын сансрын нисгэгч” цол
- “ОХУ-ын цэргийн гавъяат нисгэгч” цол
- “ОХУ-ын цэргийн гавъяат штурман” цол эдгээр болно.

Бусад бүх төрийн шагналууд нь Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдаж, журам, тодорхойлолт нь гарчээ. Ерөнхийдөө судлаачид, мэргэжилтнүүд төрийн шагналын системийг хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үздэг байна. Өнөөдөр ОХУ-ын төрийн шагналын систем, статусыг зохицуулж буй гол эрх зүйн баримт бичиг нь 1994 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн зарлигаар батлагдсан “ОХУ-ын төрийн шагналын Журам” /удаа дараа нэмэлт, өөрчлөлт орсон/ юм. Энэхүү журмын зохицуулалтын гол заалтуудыг авч үзье.

Журмын дагуу ОХУ -ын төрийн шагналд ОХУ-ын Баатар цол, ОХУ-ын одон, медаль, шалгарсны тэмдэг, хүндэт цол хамаарна. Түүнчлэн ОХУ-ын төрийн шагналаар ОХУ-ын иргэд, гадаадын харъяат иргэд мөн харъяалалгүй хүмүүс шагнагдаж болно. Иймд социализмын үед буюу 1988 оноос өмнө үеийнх шиг хамт олноор нь шагнах боломжгүй болсон байна.

Төрийн, хувийн, орон нутгийн өмчийн үйлдвэр, албан байгууллагын хамт олон, нутгийн удирдлагын байгууллага төрийн шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлнэ. Ингэхдээ тус

тусын нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний дараа шат шатны холбооны чанартай улс, хязгаар, муж, хотын захиргаагаараа дамжуулан уламжилна.

Төрийн холбооны байгууллага болон холбооны төрийн байгууллагын ажилтнуудыг төрийн шагналд нэр дэвшүүлэхдээ харъяа төрийн холбооны байгууллага болон холбооны төрийн байгууллагууд тодорхойлно. Тэдгээрийг Ерөнхийлөгчид өргөн барихдаа төрийн холбооны байгууллага болон холбооны төрийн байгууллагын удирдлагууд харъяа шат шатны холбооны чанартай улс, хязгаар, муж, хотын удирдлагатай зөвлөлдөн өргөн барина. Эдгээр нэр дэвшүүлсэн өргөдлийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн холбооны тойрог дахь Бүрэн эрхт төлөөлөгч Ерөнхийлөгчид өргөн барина.

Зарим Холбооны чанартай байгууллагын, тухайлбал, цэргийн албан хаагчид, мансууруулах бодисын хяналтын байгууллага, гааль, шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудыг төрийн шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн өргөдлийг тухайн байгууллагын удирдлага Ерөнхийлөгчид өргөн барина.

ОХУ-ын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг ОХУ-ын төрийн шагналд нэр дэвшүүлэхдээ ерөнхий үндэслэлийн дагуу, харин хилийн чандад байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг ОХУ-ын Гадаад явдлын яам ОХУ-ын төрийн шагналд нэр дэвшүүлнэ. Ерөнхийлөгчийн нэр дээр шагналд нэр дэвшүүлэн ирүүлсэн баримт бичгийг авч үзэх үүргийг тусгай зөвлөлдөх байгууллага болох ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх төрийн шагналын Комисс гүйцэтгэдэг.

Тухайн төрийн одон, медаль, цолоор шагнагдах үндэслэл нь тэдгээр одон, медаль, цолны журамд тодорхойлогдсон байдаг. ОХУ-ын төрийн шагналын Журам, болон төрийн шагнал гардуулах зааврын дагуу ОХУ-ын төрийн шагналыг ОХУ-ын Ерөнхийлөгч гардуулах ба түүний нэрийн өмнөөс гардуулах эрх бүхий албан тушаалтнуудыг дээр дурьдсан. Мөн уг Журмаар төрийн шагнал хүртсэнээс хойш байгуулсан шинэ гавъяаны төлөө дахин шагнахдаа өмнө шагнагдснаас 3 жилийн хугацаа өнгөрсөн байх ёстой ба харин эр зориг, авхаалж самбаа гарган баатарлаг гавъяа байгуулсан бол хугацаа харгалзахгүй шагнахаар заажээ.

Эр зориг, баатарлаг гавъяа байгуулсны төлөө олгодог ОХУ-ын Баатар цол болон одон, медалиар нэхэн шагнаж болно. Төрийн шагнал, тэдгээрийн үнэмлэх, бичгийг нэхэн шагнагдсан хүний гэр бүлийн хүн, эцэг эх, үр хүүхдэд нь дурсгал болгон хадгалуулна. Төрийн шагналтан нас нөхцсөн тохиолдолд шагнал нь түүний өв залгамжлагчид үлдэх ба өв залгамжлагч үгүй бол ОХУ-ын Ерөнхийлөгчийн захиргааны газрын боловсон хүчин, шагнал хариуцсан газарт буцааж өгнө. Түүнчлэн нас нөхцсөн болон нэхэн шагнадагсан хүмүүсийн шагнал, үнэмлэхийг өв залгамжлагчид болон ОХУ-ын Ерөнхийлөгчийн захиргааны газрын боловсон хүчин, шагнал хариуцсан газрын зөвшөөрөлтэйгээр музейд хадгалуулж болно.

Төрийн шагнал, түүний үнэмлэхийг гэж, үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн болон сольж олгох журмыг мөн тодорхойлсон байна. ОХУ-ын төрийн шагналын журам нь төрийн шагналыг олгосон үндэслэл нь буруу, үндэслэлгүй нь тогтоогдвол ОХУ-ын Ерөнхийлөгч шагнасан тухай зарлигийг хүчингүй болгож болохыг тодорхойлсон байна. Түүнчлэн тухайн хүнийг төрийн шагналд үндэслэлгүй тодорхойлсон албан тушаалтан хуулийн дагуу хариуцлага хүлээхийг заажээ.

Түүнчлэн төрийн шагналтан хүнд болон онц хүнд гэмт хэрэг хийсний төлөө шийтгэгдсэн бол түүний төрийн шагналыг хасах шийтгэлтэй байна. Хэрэв шагналын эрхээ хасуулсан хүн цагаадсан, түүний хийсэн хэрэг нийгмийн аюултай шинжээ алдсан бол Ерөнхийлөгч шагналаа эдлэх эрхийг нь сэргээнэ.

ОХУ-ын төрийн шагналтан хүмүүст үзүүлдэг хөнгөлөлт, урамшууллын тухайд дараахи хуулиудаар зохицуулсан байна. Үүнд:

- “Зөвлөлт Холбоот Улсын Баатар, Оросын Холбооны Улсын Баатар, Алдрын одонтнуудын статусын тухай” -1993 он, №4301-1, /”Закон о статусе Героев Советского Союза, Героев Российской Федерации и полных кавалеров ордена Славы”/
- “Социалист хөдөлмөрийн Баатар, Хөдөлмөрийн алдар одонтнуудад үзүүлэх нийгмийн баталгааны тухай”-1997 он, №5-ФЗ, /”Закон о предоставлении социальных гарантий Героям Социалистического труда и полным кавалерам ордена Трудовой Славы”
- “Зөвлөлт Холбоот Улсын Баатар, Оросын Холбооны Улсын Баатар, Алдрын одонтнуудын статусын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”-2005 он, №122-ФЗ, /Федеральный закон ”О внесении изменений в Закон Российской Федерации ”О статусе Героев Советского Союза, Героев Российской Федерации и полных кавалеров ордена Славы”
- “Социалист хөдөлмөрийн Баатар, Хөдөлмөрийн алдар одонтнуудад үзүүлэх нийгмийн баталгааны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”-2006 он, №67-ФЗ, Федеральный закон ”О внесении изменений в Закон Российской Федерации ”О предоставлении социальных гарантий Героям Социалистического труда и полным кавалерам ордена Трудовой Славы”
- “Оросын Холбооны Улсын субъектүүдэд төрийн хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын зохион байгуулалтын ерөнхий зарчмуудын тухай”, “Оросын Холбооны Улсын нутгийн удирдлагын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий зарчмуудын тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”-2004, №122-ФЗ, /ФЗ РФ “О внесении изменений и дополнений в Федеральный закон “Об общих принципах организации законодательных и исполнительных органов государственной власти субъектов Российской Федерации” и “Об общих принципах организации местного самоуправления в Российской Федерации” зэрэг хуулиуд болно.

Дээрхи хуулиудын дагуу Зөвлөлт Холбоот Улсын Баатар, Оросын Холбооны Улсын Баатар, Алдрын одонтнууд, Хөдөлмөрийн алдрын одонтнууд болон хэрэв эдгээр шагналтнууд нас нөхцсөн бол тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг эх, гэр бүлийн гишүүд нь байр, орон сууцны /түүн дотор техникийн ба ашиглалтын үйлчилгээ/ төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөх буюу эсхүл сар бүр Зөвлөлт Холбоот Улсын Баатар, Оросын Холбооны Улсын Баатар, Алдрын одонтнууд **25000 рублийн мөнгөн төлбөр**, Социалист хөдөлмөрийн Баатар, Хөдөлмөрийн алдар одонтнууд сар бүр **20000 рублийн мөнгөн төлбөр** авч болно.

Эдгээр хүмүүс мөн нийтийн аж ахуйн үйлчилгээ/халуун, хүйтэн ус, суваг, хий, эрчим хүч, дулаан, бусад/-ний төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөх буюу эсхүл сар бүр Зөвлөлт Холбоот Улсын Баатар, Оросын Холбооны Улсын Баатар, Алдрын одонтнууд 25000 рублийн мөнгөн төлбөр, Социалист хөдөлмөрийн Баатар, Хөдөлмөрийн алдар одонтнууд сар бүр 20000 рублийн мөнгөн төлбөр авч болно.

Хуучин ЗХУ ба ОХУ-ын төрийн дээд одон, медаль, хүндэт цолоор шагнуулсан иргэд 2004 оны №122-ФЗ Холбооны хуулийн дагуу хөдөлмөрийн ахмад зүтгэлтэн хэмээн нэрлэгдэх ба орон сууцаар хангагдах, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ авах эрхээр хангагдсан байна.

1.2. БНКаЗУ-ын төрийн шагналын систем, түүний шинэчлэл

Бүгд Найрамдах Казахстан Улсад 1991 оны 12 дугаар сарын 16-нд “Казахстаны тусгаар тогтнолын тухай” хууль батлагдаж энэ өдрөөс БНКаЗУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхт

улс болон хөгжсөн. Тусгаар улс болон хөгжсөнөс хойш 1993 оноос Казахстаны төрийн шагналын систем шинэчлэл эхэлсэн байна. 1993 оны 4 дүгээр сарын 01-нд “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль батлагдсан ба сүүлд тус хуулинд гурван удаа нэмэлт, өөрчлөлт орж одонгууд зэрэгт хуваагдаж, тэдгээрийн статут буюу журам өөрчлөгдөж, одон, медалийн хэв загвар солигдон, төрийн шинэ шагналууд бий болжээ. Тухайлбал, “Отан”(Эх орон) одон, “Данк” (Алдар) одонгийн 1, 2 дугаар зэрэг, “Парасат” (Ариун Үйлс) одон, “Курмет” (Хүндэтгэл) одон, “Халык Кахарманы” (Ардын баатар) цол, олон хүүхэдтэй эхчүүдийг шагнах “Алтын алка” (Алтан унжлага) шагнал, “Кумис алка” (Мөнгөн унжлага) шагнал, “Ерлиги ушин” (Эр зоригийн төлөө) медаль, “Ерен енбеги ушин” (Хөдөлмөрийн алдар) медаль зэрэг шагналыг шинээр бий болгосон байна.

1995 оны 12 дугаар сарын 12-нд “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” шинэ хууль батлагдсан гарсан ба 1999, 2001, 2008 онуудад энэхүү хуульд нэмэлт өөрчлөлт орсон. Түүнчлэн 1999 оны 11 дүгээр сарын 08-нд “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналд нэр дэвшүүлэх, гардуулах заавар, төрийн шагналын үнэмлэхний загвар, төрийн шагналын тэмдэгний тодорхойлолтыг батлах тухай” Ерөнхийлөгчийн захирамж гарсан ба тус захирамжид 2006, 2007 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон ажээ.

1995 оны “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” шинэ хуулиар дараах одон, медалиуд шинээр хуульчлагдсан байна. Үүнд:

- “Алтын Кыран” (Алтан бүргэд) одон
- “Айбын” (Гавъяа) одон 1, 2, 3 дугаар зэрэг
- “Достык” (Найрамдал) одон 1, 2 дугаар зэрэг
- “Жауынгерлик ерлик ушин” (Цэргийн гавъяа) медаль зэрэг болно.

1999 онд тус хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр “Барыс” (Барс) одонгийн 1,2,3 дугаар зэрэг ба тус одонгийн таван хошуу од, 2008 онд “Казакстаннын Енбек Ері” (Казахстаны Хөдөлмөрийн баатар) цолыг шинээр бий болгож эдийн засаг, нийгэм-хүмүүнлэгийн салбарт гарамгай амжилт гаргасан хүмүүсийг шагнах болсон бөгөөд тус цолоор шагнагдагсдыг “Отан” одон ба онцгой шалгарсны тэмдэг болох “Алтан од” тэмдэг олгодог байна.

Мөн Казахстаны төрийн шагналын системд Казахстаны Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс олгодог 1941-1945 оны Эх орны Агуу их дайнд ялсаны 50 жилийн ойн медаль, 1941-1945 оны Эх орны Агуу их дайнд ялсаны 60 жилийн ойн медаль, Жуковын медаль ордог. Түүнчлэн 1993 онд “Казакстаннын енбек синирген кайраткеры” буюу Казахстаны гавъяат зүтгэлтэн, “Казакстанын гарышкер-ушкышы” буюу Казахстаны сансрын нисгэгч гэсэн 2 хүндэт цолыг баталсан байна. Ийнхүү БНКаЗУ-ын төрийн шагналын системд хамрагдаж буй бүх одон, медаль, хүндэт цол нь 1993 оноос хойш батлагдаж, олгогдож эхэлсэн бөгөөд Казахстан Улс төрийн шагналынхаа системг бүхэлд нь өөрчлөн шинэчлэсэн байна.

1.2.2. Эрх зүйн зохицуулалтын үндэс

1995 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль нь тус улсын төрийн шагналын эрх зүйн зохицуулалтын үндсийг тодорхойлж байна. Одоо энэ хуулийн гол заалтуудаас авч үзье.

Казахстан улсын иргэдийн төр, нийгмийн өмнө төр, нийгэм, уран бүтээл, хөдөлмөрийн салбарт байгуулсан гавъяаг нь үнэлэн төрийн шагналаар шагнана. Тэрчлэн Казахстан улсын өмнө гавъяа байгуулсан гадаадын харъяат болон харъяалалгүй иргэд төрийн шагналаар шагнагдаж болно. Төрийн шагналыг БНКаЗУ-ын Ерөнхийлөгч гардуулна гэж хуульчилжээ. “Алтын Кыран” одон, “Халык Кахарманы”, “Казакстаннын Енбек Ері” цол болон бусад одон, медаль, Казахстан улсын Хүндэт үнэмлэх нь Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагнал мөн болохыг хуульчилсан байна.

Төрийн шагналын тодорхойлолт, үнэмлэхний загвар, шагналд нэр дэвшүүлэх, шагнал гардуулах заавар, бусад баримт бичиг, зааврыг БНКаЗУ-ын Ерөнхийлөгч батлана. Төрийн дээд шагнал болох “Алтын Кыран” (Алтан бүргэд) одонд зөвхөн Ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ. Бусад төрийн шагналд Парламент, Засгийн газар, яамд, улсын хороо, бусад төв болон орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагууд, уран бүтээлийн холбоод, байгууллагууд нэр дэвшүүлнэ. Төрийн шагналд мөн хөдөлмөрийн хамт олноос хэлэлцэн нэр дэвшүүлж болно. Гадаадын харъяат иргэдийг Гадаад явдлын яам, бусад яам, улсын хороод ерөнхий үндэслэлийн дагуу нэр дэвшүүлнэ.

Олон хүүхэдтэй эхчүүдэд олгох шагнал болон онцгой баатарлаг гавъяа байгуулснаас бусад тохиолдолд төрийн шагналтан дахин шагнагдах бол өмнө шагнагдсанаас хойш 5 жилийн хугацаа өнгөрсний дараа дахин нэр дэвшүүлнэ. Нэг хүнийг зэрэг бүхий одон, медалиас бусад нэг төрлийн төрийн шагналаар дахин шагнахгүй. Казахстан улсын төрийн шагналаар эх орныхоо эрх ашгийг хамгаалан эр зориг, баатарлаг гавъяа байгуулсны төлөө нэхэн шагнана.

Төрийн шагналтай холбоотой асуулдыг авч хэлэлцэх, зохицуулах зорилгоор Казахстан улсын Ерөнхийлөгчийн дэргэд төрийн шагналын Комисс ажиллана. Түүнчлэн “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хуульд төрийн шагнал одон, медаль, хүндэт цолыг хэнд, юуны төлөө олгож болохыг шагнал тус бүрээр нь хуульчилсан болно. Тухайлбал, “Алтын Кыран” (Алтан бүргэд) одон нь БНКаЗУ-ын төрийн дээд шагнал болохыг тодорхойлж, Казахстан улсын өмнө байгуулсан төрийн онцгой гавъяаны төлөө олгоно гэжээ. Казахстан улсын Ерөнхийлөгч нь эрхэлж буй албан тушаалынхаа дагуу онцгой загварын “Алтын Кыран”(Алтан бүргэд) одонгоор шагнагдах ажээ.

Олон хүүхэдтэй эхчүүдэд олгодог “Алтын алка” (Алтан унжлага) шагнал, “Кумис алка” (Мөнгөн унжлага) шагналууд нь одонгийн зэрэгт тооцогдох ба “Алтын алка” шагнал нь 10, түүнээс дээш хүүхэд төрүүлж, хүмүүжүүлсэн эхчүүдэд, “Кумис алка” (Мөнгөн унжлага) шагнал нь 8 ба 9 хүүхэд төрүүлж, хүмүүжүүлсэн эхчүүдэд олгодог байна.

Тус хуульд мөн төрийн шагнал болон төрийн шагналтнуудын статусыг хуульчилжээ. Төрийн дээд одон, “Отан” одон, “Казахстаны анхны Ерөнхийлөгч Н.Назарбаев” одонгоор шагнагдсан тухай Засгийн газраас баталдаг БНКаЗУ-ын Алдрын Номонд тэмдэглэдэг байна. Олон хүүхэдтэй эхчүүдийн “Алтын алка” шагналтай эхчүүдыг тогтоосон журмын дагуу эхний ээлжинд орон сууцаар хангах, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийнх нь хамт орон сууц болон нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөрийг төрийн тусгай тэтгэмжээр төлдөг. “Кумис алка” шагналтай эхчүүдэд орон нутгийн төсвөөс хөнгөлөлт үзүүлэх тухай хуульчилжээ.

Онцгой тохиолдлоос бусад нөхцөлд төрийн шагналыг үрэгдүүлсэн бол сольж болон нөхөн олгохгүй. Төрийн шагналтан гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн дагуу тогтоогдсон бол БНКаЗУ-ын Ерөнхийлөгч төрийн шагналыг нь хасна. Хууль бусаар шийтгүүлсэн болон бүрэн цагаадсан иргэдийн шагналаа эдлэх эрхийг Ерөнхийлөгч сэргээнэ. Төрийн шагналыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, худалдан авах, солих зэрэг хууль бус үйл ажиллагааг хориглоно. Тус хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө “Отан”, “Данк” одонгоор шагнагдсан, дээд цол болох “Халык Кахарман” цол, хүндэт цол хүртсэн иргэдэд орон нутгийн төлөөллийн байгууллагууд орон нутгийн төсвөөс хөнгөлөлт үзүүлж болохыг мөн хуульчилжээ.

1.3. БНПУ -ын төрийн шагналын системн шинэчлэлийн тойм

XX зууны 80-аад оны сүүлчээс эхэлсэн коммунист системн задрал, уналтыг дагалдан Төв болон Дорнод Европын социалист орнуудын нийгмийн хөгжилд гүн гүнзгий эргэлт, өөрчлөлт гарсан бөгөөд Польшид 1989 оноос эхэлсэн энэ үйл явц Польшийн төрийн

шагналын системд мөн шинэчлэл, өөрчлөлт оруулсан байна.

Хуучин социалист Польшийн үеийн ихэнх шагнал үгүй болж, Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын /1990 оны 12-р сараас/ Хоёрдугаар Бүгд Найрамдах Улсын /1921-1947/ үеийн шагналыг шаардлагатай зарим өөрчлөлт оруулан сэргээжээ. Улмаар 1992 оны 10 дугаар сарын 16-ны өдөр БНПУ-ын парламент “Төрийн шагналын тухай” хууль батласан ба энэхүү эрх зүйн акт нь төрийн шагналын үндсэн зарчим, шагналын харилцааг зохицуулдаг. Хуучин Бүгд Найрамдах Польш Ард Улсын үед төрийн шагналаар шагнагдсан хүмүүсийг шагналаа зүүхийг хориглоогүй.

Польш улсын төрийн дээд шагнал Цагаан бүргэдийн одон (Order Orła Białego)-г 1921 оны 2 дугаар сарын 04-ны өдөр Польшийн сейм баталжээ. Уг одонг эх орон, ард түмний өмнө цэрэг, иргэний онцгой гавъяа байгуулсны төлөө олгодог ба 1992 оны “Төрийн шагналын тухай” хуулиар сэргээсэн байна. Энэ одонгоор нэг хүнийг зөвхөн нэг удаа шагнадаг, Польшийн Ерөнхийлөгч тус одонгоор шагнах тухай шийдвэр гаргаж гардуулдаг.

Гавъяаны одон (Order Zasługi Rzeczypospolitej Polskiej)- нь 1974 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр БНПАУ-ын парламентаар батлагдсан бөгөөд 1991 онд Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын шагналын системд статут, тодорхойлолтод нь өөрчлөлт оруулан бүртгэсэн. Гавъяаны одон нь 5 зэрэгтэй бөгөөд 1 дүгээр зэргийн одонгоор гадаадын төрийн тэргүүн, сайд нарыг шагнадаг байна. Энэ одонгоор Рональд Рейган, Джордж Буш, Жак Ширак, Франсуа Миттеран, II Елизавета нар шагнагдаж байжээ. 4, 5 дугаар зэргийн одонгоор гадаад орнуудын элчин сайд нар, дипломатуудыг БНПУ-ын олон улсын харилцааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэрийг нь үнэлэн шагнадаг.

Эр зоригтны Загалмай (Krzyż Walecznych)-г 1920 онд Польшийн батлан хамгаалах Зөвлөлийн шийдвэрээр батласан ба 1990 онд Польшийн Парламентын шийдвэрээр сэргээсэн байна. Энэ одонгоор дайны талбарт эрэлхэг гавъяа байгуулсан хүмүүсийг шагнадаг, өнөө үед энэ одонгоор НҮБ-ын энхийг сахиулагчдын бүрэлдэхүүнд оролцогч Польшийн Зэвсэгт Хүчний байлдагчдыг шагнадаг.

Гавъяаны сэлэмтэй загалмай одон (Krzyż Zasługi z Mieczami)- нь алтан, мөнгөн, хүрэл одонтой. 1942 онд Польшийн цагаачлагч Засгийг газрын шийдвэрээр бий болсон ба 1992 оны төрийн шагналын тухай хуулиар сэргээсэн. Энэ одонг Польшийн Ерөнхийлөгч олгох, гардуулах эрх эдлэнэ. Партизаны загалмай одон (Krzyż Partyzancki)- 1944 оны 4-дүгээр сарын 22-ны өдөр Польшийн үндэсний чөлөөлөх хорооны шийдвэрээр батлагдсан ба 1992 онд сэргээж, эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцож байсан боловч ямар нэг шалтгааны улмаас 1946-1989 онд шагнагдаж чадаагүй хүмүүст олгосон ажээ. Ер нь Польшийн төрийн шагналын системд дэлхийн хоёрдугаар дайны үйл явц, фашизмын эсрэг тэмцэл, ялалттай холбоотой шагнал, загалмай одон маш том байр суурь эзэлж байна. Тухайлбал, нийт 9 загалмай одон, 10 медаль эх орноо хамгаалах, фашизмын эсрэг дайнд гавъяа байгуулсны төлөө олгодог шагнал байна.

“Удаан жил хамт амьдарсны төлөө” медаль 1960 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Сеймийн хуулиар батлагдсан ба 1992 оны “Төрийн шагналын тухай” хуулиар сэргээж Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын төрийн шагналын жагсаалтанд бүртгэжээ. Энэ медалиар гэр бүл болоод 50 жил хамт амьдарсан, нэг, түүнээс дээш тооны өөрийн төрсөн болон өргөмөл хүүхдийг өсгөж хүмүүжүүлсэн гэр бүлийн хүмүүсийг шагнадаг байна.

1.4. БНЧУ -ын төрийн шагналын системн шинэчлэлийн тойм

1989 оны тайван хувьсгалын дараа тэр үеийн БНСЧСУ-д нийгмийн өөрчлөлт эхэлсэн. 1990 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Чехословакийн Холбооны улсын Холбооны Ассамблейн баталсан “Төрийн шагналын тухай” хуулиар төрийн шагналын системийг

өөрчлөн шинэчлэх эхлэлийг тавьсан байна. Тус хуулиар Холбооны Бүгд Найрамдах Чех-Словак Улсын төрийн шагнал нь одон, медаль гэсэн хоёр хэсгээс бүрдэхийг тодорхойлсон ба хуучин социализмын үеийн одон, медаль, хүндэт цолтой холбоотой 40 эрх зүйн баримт бичгийг хүчингүй болгосон байна.

1993 оны 1 сард Холбооны Чех, Словак улс аажмаар задран тусгаар тогтносон Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Словак Улс байгуулагдсан. 1994 оны 7 дугаар сарын 09-ны өдөр БНЧУ-ын парламент БНЧУ-ын төрийн шагналын тухай хууль баталсан ба энэхүү хуулиар төрийн шагнал нь одон, медаль гэсэн хоёр төрөлтэй, одон нь төрийн дээд шагнал болохыг хуульчилжээ. Чех улс нь Цагаан арслангийн одон, Томаш Гарриг Масарикийн одон гэсэн хоёр төрийн дээд шагналтай ба Чех улсын иргэд болон гадаадын иргэдийг шагнадаг.

Цагаан арслангийн одон нь анх 1922 онд батлагдаж байсан, 1990 он хүртэл 3 зэрэгтэй байсан бол 1992 оноос 5 зэрэгтэй болжээ. Цагаан арслангийн одонгоор чехийн төр, засгийн өмнө гавъяа байгуулсан гадаадын төр, нийгмийн зүтгэлтнүүд, олон улсын байгууллагын төлөөлөгчдыг шагнадаг байна. Томаш Гарриг Масарикийн одонгоор нийгмийн ардчилсан хөгжил, хүний эрх, хүмүүнлэгийн үйлст оруулсан гарамгай хувь нэмрийг үнэлэн олгодог байна. Түүнчлэн БНЧУ-ын төрийн шагналын системд “Баатарлаг үйлсийн төлөө”, Гавъяаны медалиуд орно. “Баатарлаг үйлсийн төлөө” медалиар дайны талбарт гавъяа байгуулсан болон хүний амь, материаллаг үнэт зүйлсийг авран хамгаалахад эр зориг, баатарлаг гавъяа байгуулсаны төлөө шагнадаг.

Гавъяаны медалиар төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын ажилтнуудыг албан үүргээ нэр төртэй биелүүлснээр нь төлөө шагнадаг байна. Төрийн шагналаар шагнах шийдвэрийг БНЧУ-ын Ерөнхийлөгч гаргаж мөн шагналыг гардуулдаг. Төрийн шагналаар шагнах тухай саналыг Ерөнхийлөгчид Төлөөлөгчдын танхим, Сенат, Засгийн газар гаргаж болно. Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс түүний томилсон хүмүүс шагналыг гардуулах эрхтэй. Ийнхүү бидний авч үзсэн хуучин социалист орнууд болох ОХУ, БНКау, БНПУ, БНЧУ-д 1990-ээд оноос хойш төрийн шагналын систем нь нийгмийн гүн гүнзгий өөрчлөлтийн үр дүн болж өөрчлөгдөн шинэчлэгдсэн байна.

ХОЁР. МОНГОЛ ТӨРИЙН ШАН ХАРАМЖ, ТҮҮНИЙ ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ (ОДОН ШАГНАЛЫН ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦООГ ТӨГӨЛДӨРШҮҮЛЭХ АСУУДАЛД)

2.1. Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал

Монгол төрийн түүхэнд одон–шагнал хэрэглэсэн явдал харьцангуй саяхны билээ. Одонгоор шагнах [шинэ] боловсон ёсон, монгол улсын хувьд XIX зууны “олноо өргөгдсөн” –ий он жилүүдээс эхтэй юм. Монголын сүүлчийн эзэн хаан, хамаг бүгдийн багш, оройн дээд очирдарын хувилгаан, нарангэрэлт түмэннаст Богд Жибзундамба хутагт бээр гадаад ертөнцийн дэвшилтэт зан заншлыг даган дуурайж, энэ тал дээр анхны “туршлага нэвтрүүлсэн” түүхэн гавъяатай. Түүний зарлиг лүндэнгээр 1913 онд “эрдэнийн очир” одон бүтжээ.

“Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал” гэсэн судалгааны чанартай эл өгүүлэлдээ бид “Ардын хувьсгал” –ын жилүүдэд бий болсон одон шагналын тухай дэлгэрүүлж авч үзээгүй, энэ нь доорхи шалтгаантай. Үүнд:

1. Одон шагналын шинэ түүхийн үргэлжилсэн хугацаа анхдугаар үндсэн хуультай бараг цацуу, цагийн алслал нь чухамдаа энүүхэн “хараа барааны газар” –т илхэн байна;

2. Ардын засгийн жилүүдийн шагналын систем өнөө хэр бараг хэвээрээ байгаагийн дээр, байнгын хэрэглээнд явж ирсэн болохоор, түүнийг, нийтийн ухамсарын түвшиндээ хүмүүс нилээн сайн мэдэж байгаа гэж үзсэн;
3. Социалист төрийн шан, шагнал түүнд холбогдох лавлагааны чанартай мэдээ мэдээлэл, ном хэвлэл, мөн, одон медалийн тогтолцооны өөрчлөлт хувирлын талаархи түүхчилж тоочсон, шүүмжилж гоочилсон өнгө агуулгатай материал нийтийн номын сан, электрон мэдээллийн сүлжээнд “хангалттай” их байгаа бөгөөд тэдгээрээс гол чухлыг нь ялгаж түүвэрлэн, эл өгүүллийн төгсгөлд нэрийн жагсаалтаар хавсаргав. (Хавсралт 1. – Улсын шагнал, одон медалийн өнөөгийн тогтолцоог төгөлдөршүүлэх чиглэлээр хэвлэгдсэн ном товхимол, өгүүлэл нийтлэл, бусад мэдээллийн түүвэр жагсаалт)

Өгүүлэлдээ бид монголын эзэнт гүрний үед холбогдох түүхэн сурвалжууд, ялангуяа манай түүхэн шастир – Монголын Нууц Товчоог гол эш болгон түших бөгөөд, инагшилж явсаар Монгол Улсын анхны Үндсэн хуультай учирах хүртэлх хугацаанд хамаарах “шан харамжийн эртний хуучин уламжлал” –ыг тухайлан авч үзэх болно.

Одонгийн хэрэгцээ (Түүхэн үүсэл)

Одон, түүнийг дагалдуулсан бэлэг сэлтээр улс орнууд гадаад түншийн харилцаагаа бэхжүүлдэг байсан нь түүх сурвалжаас тод харагддаг. Монголын анхны туршлага ч энэ байдлаас гажаагүй юм. Анх одон сэдэж хийлгэсэн гол шалтгаан нь, эхний ээлжинд оросын баатар цагаан хааныг шагнах, энэ ялдраа түүнд Богд хааны “илгээлт” (монголын талын гуйлт бичиг) –ийг хадаг яндар лугаа хамтатган барих явдал байв. Ингээд 1913 онд Монгол улс Эрдэнийн очир одонтой болов.

Чингэсийн үед “Алтан гэрэгэ” гэж байсан. Тэр бол авч яваа эзэндээ асар их хүндлэл, эрх дарх, тусгай статус олгож байсан, бүр одонгоос илүү бодит үнэ цэнэтэй, гэхдээ халдашгүй байдлын баталгааг хангах үүрэгтэй, нэг ёсны тусгай үнэмлэх, гадаад паспорт талдаа зүйл байсан. Түүнийг одон гэж үзэж болохгүй болов уу.

Одон гэж юу вэ? Ер нь ингэхэд, одонгүй байж болоогүй юм уу? Одон үүсээгүй эртэн балар цагт тэгээд, бидний ба тэдний улс яажуухан явж ирсэн б гэх зэрэг асуултанд юун түрүүн хариулах гэж оролдъё. Гэхдээ, улс гэр, засаг захиргааны түүхэн үйл явц дахь бэлэг шан, шан пүнлүү, хариу харамжийн ялгаа зааг заримдаа тун бүдгэсдэгийг энд заавал дурдмаар байна.

МОНГОЛ ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ ХИШИГ ШАН

Дорнын улсуудын эртний соёл уламжлал, түүх сударт, айл зэргэлдээ орших хөрш холбоотой улс орнууд бие биендээ хүндэтгэл, бас итгэл үзүүлж байгаагийн илэрхийлэл болгон, хоорондоо бэлэг солилцдог байлаа. Тэр бэлэг сэлт нилээн ахиухан хэмжээтэй. Өнөөдрийн бидний бэлэг шан гэдэг ойлголт дэргэд нь дэндүү дарууханд тооцогдоно. Эдүгээ, түүний хэмжээ нь багасаж өөр болсноос биш, хэлбэр нь ерөнхийдөө хадгалагдаад хэвээрээ яваад байгаа юм байна. Шагнал шийтгэл хоёр бол нэг зоосны хоёр тал. Монголын нууц товчоо агуулгадаа чухамхүү энэ гавъяа шийтгэлийн асуудлыг хангалттай өргөн дэлгэр хөнджээ. Тэнд гарч байгаа шагнал соёрхлын төрөл зүйл олон юм. Түүхэн судраа гол эш болгож, мөн, багцаа таацалдаа нийцүүлэн “баахан дураар” ангилан өгүүлэхүйд:

Эмс охидоор (хүнээр) шагнах ёсон

Улс гэр, орон гүрний төрийн тэргүүн, хаад ноёдууд, дээхэнтээгээ, харилцан итгэлцлээ гүнзгийрүүлэх, харилцаа холбоогоо улам сайжруулах баталгаа болгож үр хүүхэд, эмс охидоо хүртэл бие биендээ өгч авч байжээ. Ингэж ураг төрлийн холбоо тогтоох нь

урваж тэрслэхээс хамгаалсан нэг ёсны төрийн бодлого байсан бололтой.

- a. МНТ –нд (197 дугаар зүйл), хулгана жилийн намар увас мэргэдийн тэргүүн Дайр Үсүн [байлдах саналгүйгээ нотолж] өөрийн охин Хуланг авчраад Чингэс хаанд хатан болгож өгдөг. Алтан товч, Эрдэнийн товчид [болохоор] солонгос мэргэдийн Дайр улс нэгэн охиныг Чингэс хаанд авчирч өгсөн, манай хаан тэрийг нь авсан гэж гардаг; гэсэн. Энд гарч байгаа үйлдэл бол бэлэг шан гэхээсээ илүү **олз хахууль** талруугаа хэлбийх шинжтэй байна. Тэрхүү солонгос мэргэдийн тэргүүлэгч хамгийн ариун нандин юмаа урьдчилан өгч, түүнээсээ салж байж, улмаар учирч болох аюул түйтгэрийг зайлуулж чаджээ. Даруй, ая засалт мөнөөс мөн. МНТ –ийн мөн энэ зүйлд, “харь улсаас **олзолсон** хацар гоо охид ...” гэж гардагийг ч дурдалтай.
- b. 1266 онд Японыг дайлаар мордохдоо Хубилай хаан өөрийнхөө Хутулгэрмис охиныг зам зууртаа Солонгост аваачаад өгчихдөг. Дайны цагийн ийм дипломат ёс харилцааны мөн чанар нь Цежү арлаар дамжаад цаад үндсэн гол хэрэг зоригоо бүтээхэд чиглэгдсэн, байлдааны фронтын ар талаа батжуулж авах санаанд оршч байв. Тэр үед олигтойхон одон байсан бол хааны охин ингэж харь хадмын газарт бэлгэнд одохгүй байж ч болох байсан мэт
- c. МНТ (208 дугаар зүйл) –нд, дайсагнаж одсон Жаха-хамбыг нэхэн тонилгож, улмаар түүний улсыг талж дийлж ирсэн ач гавъяаг нь үнэлж, Чингэс хаан өөрийн Ибага бэх хатнаа Жорчидайд өгчихөж байна. Тэгэхдээ, Чингэс хаан Ибага хатандаа “... эрхэм Жорчидайн ачийг хариулж, их гавъяаг нь тэмдэглэхийн тулд чамайг түүнд соёрхов” гэж хэлдэг. Эртний манай ёс уламжлалд “хүнээр шагнах ёсон” үнэхээр [ийн] байжүхүй. Энд, дахиад л одон байсансан бол гэж бодогдов.

Гэхдээ, тухайн тохиолдолд Чингэс хаан ингэснээрээ “аюулыг дэргэдээсээ холтгож өөр этгээд рүү гулсуулсан” байх талтай юм. Яагаад гэхээр, Ибага бол алагдсан Жаха-хамбын [нэг] охин болтой байдаг. Жаха-хамбыг Жорчидай алсан болохоор “тухайн соёрхолыг” хааны даажигнал ч гэмээр санагддаг. Тийм бол, энэ хачин шан Жорчидайд баяр баясал авчраагүй нь лав. Ибага –ийн хувьд ч, тэр их эзэн хааны хүссэнээр эцгийгээ хороосон хүнтэй дэр нэгтгэх болж байна.

Иймэрхүү маягийн “нэг хүнийг нөгөө хүнээр барьцаалах” шинж сэдэлтэй хорон муу аргыг хожмын түүхийн “хэмжээгүй эрхт хаан” Иосиф Жугашвили (эцэг Сталин) гаргууд сайн хэрэглэдэг байв.

Газар нутгаар шагнах ...

МНТ –ны 219 дүгээр зүйлд, “Чиний ачийг би харанхуй шөнө зүүдэндээ, гэгээн өдөр цээжиндээ санасаар өдий хүрэв. Одоо танд соёрхол өгнө ... юу авах вэ” гэж Чингэс хаан Сорхан шараас асууж байна. Сорхан шар хөвгүүдтэйгээ нийлэн хамтарч “Бид мэргидийн нутаг Сэлэнгэд дархан дураар амьдрахыг хүснэ, хэрхэхийг хаан та мэдтүгэй” гэв. Чингэс хаан зарлиг болруун: “Тийн ахул ах дүү нараа цуглуулж хүссэн газартаа ургийн ураг хүртэл тааваараа амьдрагтун” гэжүхүй.

Байнгын нүүдэл суудалт уламжлалт эдийн засагтай нийгэмд хүссэн хүн нэг газраа суугаад байх боломж хомс тул энэ шан нэг их түгээмэл байсангүй. Харин язгуурын монгол овог аймгуудыг хоорондоо байлдахад хүргэж байсан олон шалтгааны нэг нь бэлчээр нутаг, нутаг усны төлөөх тэмцэл юм. Булаалддаг тэр зүйлээрээ бусдыг шагнана гэдэг бол шагналын дээд мөн буюу.

Дайны олзоор шагнах

Харин, гадагшаагаа хийсэн аян дайны авангард хүчийг зориуд зоригжуулах үүднээс

цэргийн жанжин, ханлигийн эздэд “... сайн байлд, тэгвэл та нарт эзэлсэн газрын чинь газар нутаг, эмс хүүхэдийг шагнал болгон өгье” амлан хэрэгжүүлэх явдал нилээн байжээ. Энэ нь өмнөхөөс тэс ондоон. Дайны олзоор шагнах гэмээр юм уу даа ...

Олон дайсанд довтолж олзоо бүрэн ав, ав хомрого зохиож алснаа бүрэн ав; гэсэн утга санаатай үг өгүүлбэр монголын эртний түүхэнд олонтоо тааралддаг. Бас ангийн олз шагнах ёсон байж. Нийгэм нь хоцрогдсон, төр засаг нь ядуу болохоор өгөх өөр юм амар олддоггүй байсан гэж үзнэ.

Цэргээр шагнах ...

Хүлэг хаан тухайн үеийн дэлхийн хамгийн хүчирхэг баян газар луу довтолж хамгийн том аян дайныг явуулсан байдаг. Хүлэгийн их цэрэг одоогийн Иракт төвлөрч, улмаар Сирийн тал хүрэв. Энэ амжилтыг Хубилай хаан онцлон үзсэн байна. “Хубилай хаан өөрийн нь үйл хэргийг тууштай дэмжин, үр дүнд хүрсний хариу хишиг болгож, Хүлэгт 30000 торгон цэрэг, Иль-Хаан цолоор шагнав” гэж түүхэнд бичиглэсэн нь бий [...] Энд байгаа “шагнав” гэдэг үгэнд акцент өгвөөс, цэрэг дайны бүхэл бүтэн арми хүртэл бэлэг шангийн нэгэн өвөрмөц төрөл хэмжээс болж харагдахаар байна.

Цэргээр шагнах ёсон түгээмэл байгаагүй. Чингэс хаан цэргийн бодлоготон байсан тул “байлдааны нөөц хүч” чухам хаана байрлаж байх нь зохилтойг мэдээж тооцсон байж таарна. Их цэргийг авах өгөх 2 талын хүсэл нь нэр бүхий жанжнуудын сонирхлын давхцал дээр оршиж байсан гэж үзнэ. Харагдах дүр нь өнгөц талаасаа шагнал мэт боловчиг, түүний цаад талд, цэргийн маневр, байлдааны стратегийн том асуудал оршиж байсан нь гарцаагүй. Үүнийг 100% шанал гэдэг утгаар нь ойлгож болохгүй байх. Их хаан их зүтгэлийг их итгэлээр хүлээн авч, хариуд үргэлж шан барьдаг хүн байжээ. Итгэлгүй хүнд их цэргийг өгөх нь дайсныхаа гарт илд атгуулах лугаа мэт осолтой. Хаан, Хүлэгт бүрэн итгэсэн байна.

Ирээдүй амлах (Хааны ивээлээр шагнах)

МНТ (205 дугаар зүйл) –нд, “Боорчи Мухулай 2 зөв явдлыг зөвшөөрөн тэтгэж, буруу явдлыг буцаан зогсоож, намайг өнөөдрийн энэ их сууринд хүргэв. Тэднийг одоо бүгдийн дээр суулгаж, есөн осол гаргавч ял хэлцэхгүй болгоё. Тэр 2 өөрсдийн түмнийг мэдэж захиртугай” гэснийг дурджээ.

Энд, эзэн хааны соёрхол хүртсэн түмтийн ноён, хөлөг баатар Боорчийн авсан тэр шан, хэдийгээр үзэгдэх биегүй хоосон зүйл мэт боловч ч эзнийнхээ ирээдүйг хангалттай сайн баталгаажуулжээ. Өөрөөр хэлбэл, эзэн хаан түүнийг яаж ч бүтэлгүйтэж байлаа гэсэн “том даргынх нь ажлаас хусахгүй байх”, “баталгаат ирээдүй” –гээр шагнаадахаар.

Тухайн этгээдэд төрийн хууль үйлчлэхгүй болно гэдэг бол “их том харж үзэлт” юм. Хэмжээгүй эрхт хаант засгийн “их итгэл дээр суурилсан их том эрх дарх” –ыг өнөөгийн нийгмийн хөгжлийн өндөрлөг дээрээс эргээд харахад сонин юм. Юутай ч олон хүний маазруулж бичдэг шиг “шагналаа авахын тулд эхлээд хэрэг хий” гэсэн утгагүйг нэмж хэлэх нь зөв болов уу. Соёрхолын төрөл зүйл нь этгээд өвөрмөц юм. Ирээдүйг ингэж “атгуулах” нь гарцаа байхгүй дээдийн дээд ивээл шан мөн.

Албан тушаалаар шагнах

Монголын нууц товчоонд (213 дугаар зүйл) –нд, Чингэс хаан Үнгэр буурчаас “Чи хангалттай гавъяа байгуулсан одоо ямар соёрхол авах вэ” гэж асуудаг. Тэгэхэд нь Үнгэр “... Хамаг баяд ах дүү нараа хаман цуглуулж захирья” гэв. Хариуд нь, Чингэс хаан “Тэг тэг, тэр мянганаа чи захиртугай” гэжээ. Мянганы ноён бол тухайн үеийн том албан тушаал юм.

“Харж үзэх” ёсны ийм “дураараа загнах” уламжлал олон зуун жил оршиж ирсэн байна. Уламжлал заншил хүчтэй тул, ийм байдал эдүгээ ч цухалзан илэрч болох талтай. Хэрэв тийн ахул Үндсэн хуульт дэг ёсонд нийцэмжгүй. Энд нэг сонин зүйл илэрч байна. Шан соёрхол горилогч тал нь юу авах, ямар шагнал хүсэл саналаа өөрөө хэлж болж байна!

Дахан эрхээр шагнах ...

НТ (228 зүйл) –нд, Чингэс хаан “Гадаад мянганы ноёдоос миний хишигтний ердийн хүмүүс илүү эрхэм. Тийн тул, гадаад мянганы ноён миний хишигтэнтэй тэнцэж хэрэлдвэл, би мянганы ноёныг шийтгэнэ” гэж гарч байна. Хишигтнүүд бол хааны “дэргэдийн хүмүүс” юм. Тэр бас “хишигтнийг миний зөвшөөрөлгүйгээр шийтгэж үл болно” гэжээ. Итгэлт хүмүүсийг дэргэдээ шилж түүж аваад, тэдэнд онцгой дархан эрх олгож байгаа нь, үйлдлийн мөн чанар талаасаа “хааны тусгай соёрхол” даруй мөн гэж үзнэ.

МНТ –ны дараагийн зүйлд, Сорхон шар, Бадай, Хишилиг нарыг “гурван дархан” гэсэн байдаг. Тэднийг хаан өөрийн шадар хорчоо болгож “дархан эрхтэйгээр жаргаж явтугай” гэсэн нь бий. Уул усаан хамгаалж дархалдаг шигээ, монголчууд хүнийг бас дархалдаг байжээ. Ингэхдээ хүний уг сурвалж угсаа гарвалыг онцолж төдийлэн хардаггүй байж.

Биеэр бараалхах эрхээр шагнах ...

МНТ –ны 219 дүгээр зүйлд, Чингэс хаан Чулуун Чимбай хоёрыг соёрхож хэлсэн нь: “Та хоёр санасанаа хэлье гэвэл, дутуугаа гуйя гэвэл үгээ дам хүнээр бүү хэлүүл, надтай өөрийн биеэр ирж уулзаж сэтгэлээ уудалж бай” гэж зарлиг болов. Нэр бүхий хүмүүс бол өмнө дурдсан “9 удаа ял хэлцэхгүй” гэх тэр шанг хүртсэн хүмүүс юм. Нэг төрлийн шагналын нэмүүрэг аж.

Цолоор хэргэмээр шагнах ...

Монголын төрт ёсны түүхэнд, дорнын уламжлалын дагуу хэргэм цол олгож гавъяа шагнадаг ёсон түгээмэл байлаа. Энд дурдахгүй байхын аргагүй нэг жишээ бол, монголчуудын их хаанаа өргөмжилж дээдэлсэн “Чингэс” цол юм. Нэмж тэмдэглэхэд, Тэмүжин монголын нэгдсэн тулгар төрийг үүсгэн ... их үйлийг бүтээж байж [сая] Чингэс хаан болоогүй, түүнээс 17 жилийн өмнө 1189 онд Хамаг монголын хан (зөвхөн нэг аймгийн ноён) байхдаа, өөрөөр хэлбэл, хожмын “гол гавъяа” –гаа байгуулаагүй байхдаа [аль хэзээний] “Чингэс хаан” болчихсон байв. Тухайн үедээ “чингэс” гэдэг цол нь өнөөгийн бидний ойлгодог шиг “хаадын хаан”, “хамгийн дээд хаан” гэсэн утгагүй байжээ.

МНТ–ны 132, 133 дугаар зүйлд, Улзын ... Хуст шүтээн гэдэг газар Чингэс хаан татаар түмнийг даран сөнөөж, тэдний удирдагч Мөөжин сүүлтийг алж, эд барааг нь олзолдог. Хятадын Алтан хаан “Мэгүжин сүүлтийг ийн сөнөөв” гэж Чингэст машид ихээр талархан, түүнд “чаутхури” цол хайрлав. Цолтой хүнд хүртэл цол нэмэн өгч, түүнийг нь дуртайяа мөн “авч” байгаагаас үзэхүл “цол” гэдэг чухамдаа тэр үеийн “одон” шахуу зүйл байжээ.

Монгол манжийн хараат байхдаа Чин гүрний “хэтэрхий дөрвөн хэргэм” (ван, бэйл, бэйс, гүн)–ийг хэрэглэж байсан. Чин династийн төлөө зүтгэсэн монголын ноёдыг шагнадаг эдгээр зэрэг хэргэмийг бүр сүүлд Богд хаант улсын үед ч үргэлжлүүлэн хэрэглэсээр байв. Чингисийн угсааны алтан ургийн хүн тайж цол авдаг, тайжид хүргэн орсон хүнд тавнан цол өгдөг байлаа. Цол хэргэм, хэргэм зэрэг бол “биегүй одон” мөн шиг байна.

Цолоор шагнах ёсон Богд хаант Монгол Улсын үед улам их дэлгэрсэн. Шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт эзэн, “амьд бурхан” Богд хааны зарлигаар баталгаажиж олгогдсон “Монгол Улсын баатар” цолтон 101 байдаг. Мөн Богд хаанаас цол шан авсан, “тулгар төр байгуулах тухайн хэрэгт онц хүчин зүтгэсэн” гавьяатай хүмүүс ч цөөнгүй

байсан бөгөөд, тэдгээрийн заримын цол “гуншин” – г энд, жишээлж тодотгон дурдвал,

- а) Түшээт хан аймгийн засаг Ханддорж,
 - үе улирах эрдэнэ дайчин цол, хошой чин ван, ханы ямба, давхар пүнлүү, шар хүрэм, улбар шар жолоо, нэгэн үед ногоон жууз;
- б) Монгол Улсын зарлигаар тохоогдсон (Батлан хамгаалахын) сайд, дэслэгч генерал, барон Роман Феодорович Унгерн – Штернберг,
 - “улсыг мандуулагч их баатар жанжин” цол, “ханы зэрэгт үе улирах дархан хошой чин ван” хэргэм, ногоон жууз, улбар шар хүрэм, шар жолоо, гурван нүдэт тогосын отго;
- в) Ховдыг чөлөөлөх байлдаанд өөрийн жанжнуудын хамт их цэргийг манлайлан байлдаж, эрийн зориг, хувилгааны шидийг үзүүлж түүхэн гарамгай гавъяа байгуулсан Жа богдон (Дамбийжанцан)
 - «догшин ноён хутагт, номун хаан»; ... гэх мэт.

Дээрх хэдэн жишээнээс, шагнал, цол хэргэм, эрх ямбын зааг ялгаа нилээн тод томруун харагдаж, тэдгээрт, улстөр, эдийн засаг, ёс суртахууны олон аспект бүхэлдээ “шан” гэсэн “нэгэн малгай дор” багцлагджээ. Дорнын ёс заншлын “калорит” хүчтэй мэдрэгдэж байна.

Цолоор шагнах ёсон монголыг манжийн эрхшээлд байх үед хөгжлийнхээ дээд оргилд хүрсэн шиг байна. Жишээлж дурдъя.

- а) (Мяндагтаны цол) Ачлалт ялгасан дагинын гэгээн, эрх цагаан дара эх, Улсын эх дагина Ц. Дондогулам хатан (Богдын өргөсөн хатан Ц. Дондогуламд Бээжингийн Монгол журганаас Эрдэнэ сэцэн цол шагнаж, тэмдэгт бичиг олгон хадгалуулжээ. Мөн, Бүгд Ерөнхийлөн Захирах сайд Т. Намнансүрэнгийн тушаалаар 1913 оны долдугаар сард хотлыг баясгагч эх дагина Ц. Дондогуламд 100 лан мөнгөний шагнал олгох болж, “Богдын ордны дэргэдэх Сангай аймаг гэгддэг уран хатгамалчин, барималчин, гуталчин, дархан зэрэг 120 урчуудын хэргийг эрхлүүлэх болсон аж.) Мэдээний URL: [\[http://www.bolod.mn/modules.php?name=News&file=article&sid=22953\]](http://www.bolod.mn/modules.php?name=News&file=article&sid=22953)
- б) Бадаргуулт төрийн ... дүгээр он (оны цол)
- в) Орхон түшээ гүн (Уул усны цол)
- г) Ялгуун баатар, бэйс, ардын журамт цэргийн дэд жанжин Лаварын Сумъяа (улсын баатрын цол)
- д) Сайн ноён хан аймгийн Эетэй Засгийн хошуу, хожмын Эрдэнэцогцолсон уулын хошуу, одоогийн Архангай аймгийн Жаргалант сум (засаг захиргааны нэгжийн “гоё” нэр)
- е) халхын хүчтэн, баатар зоригт, бардам түрэмгий (улсын) арслан Баатарын Төрбат (бөхийн цол, 1923)
- ж) Төрийн түмэнэ эх (хурдан морины цол)
- з) “Эртний бурхан сайдын байгуулсан дөрвөн их төрийн арван буянт номын цагаан түүх” нэрт судар оршвой (ном судрын нэр) Шашин төр хоёр ёсыг тэгш явуулах тухай хууль цаазны бичиг юм. ... гэх мэт.

Алдар цол, цол хэргэм, хэргэм зэргийн дуудах гуншин сүүлдээ утга уянгын зүйл яруу хэллэг болж хувирсны үлдэц өнөө хир энд тэндгүй оршоор байна. Улсын анхдугаар хурлаар баталсан БНМАУ -ын Үндсэн хуульд “ван, гүн, тайж нарын хэргэм зэргийг устгаваас зохимой” гэснээр энэ ёсны “пик” буурав.

Одонгоор шагнах

Одон бол боловсон шан. Монголын анхны одон нь дор бүрнээ өөр үнэлэмжтэй 12 төрөл зүйл байж. Эрдэнийн очир одон дотроо ийм олон зэргэмжтэй байгаа нь “хүнийг ангилан дугаарлах тэгшбүс феодалын ёс”-той ихээхэн холбоотой. Хамгийн дээд эрэмбийн эрдэнийн очирыг шижи алтаар үйлдэж, түүгээр эрхэм дээд язгууртан, гадаад гүрний хаад ноёдыг шагнах ба зэрэг зиндаа өөр өөр хүмүүст дорогшлон таарч тохирохоор бодолцож олон шаталбартай үйлджээ. Одонг монголчууд түүхэндээ анх удаагаа хийж, хэрэглэж үзэж байгаа нь энэ.

Хөгжил дорой нийгмийн зовлон их. Одонгоо өөрөө хийж чадахгүй болохоороо хөлс мөнгийг нь өгч хөрш “айл” –даа захиалж хийлгээд, тэнд нь очиж авангуутаа, түүгээрээ, тэр айлынх нь хүмүүсийг газар дээр шагнаж гарсан байдаг. (Анх 143 ш. –г Петербургт захиалсан) Энд гарсан өгүүлэмжийн утгын гажилтыг залруулахын тулд өмнө өгүүлснээ зориуд давтан тэмдэглэе. Эрдэнийн очир одонг хийлгэсэн гол сэдэл нь, орост төрийн дээд хэмжээний айлчлал хийх, Монголын Засгийн газрын тэргүүн оросын хаанд биеэр бараалхах, энэ үеэрээ оросын баатар цагаан хааныг Эрдэнийн очир одонгоор шагнахаа, Богд хааны “илгээлт” –ийг түүнд атгуулах явдал байсан. Богдын зарлиг ёсоор болсон. Монгол улс зэр зэвсэгээ ч, зээл тусламжаа ч авсан.

Монгол Улс ийнхүү одонтой болоод авлаа. Янз янзаараа алагласан 143 одон гар дор гялалзаад бэлэн байж байдаг ... тэгээд Ерөнхий сайд “ягаан ноён” Т. Намнансүрэн гуай мөнөөхөн айлчлалынхаа явцад, байрласан буудлынхаа зардал юмыг хэмнэх зорилгоор тэндэхийн тогоочийг Эрдэнийн очир одонгоороо бас шагнаадахаа. Ийм баримт байдаг юм байна. Гэтэл, Богд эзэн хааны зарлиг бол, ерөөсөө ганцхан Баатар цагаан хааныг шагнаарай гэж гарсан. Эрдэнийн очир одонгийн олон зэргэмжийн хэрэг тэнд ёстой гарсан байх аа. Ямар ч байсан зарлиг захирамжгүй “арга хэмжээ” болжээ гэсэн үг. Тэгэхээр, одон хэрэглэх үр чадвар гэхээр юм эхэндээ манайд үнэхээр байгаагүй юм. Яаж ч байх билээ!? Анхныхаа одонг ашигласан түүхэн туршлага, сургамж гэдэг үүднээс нь үүнийг энд сонирхуулан дурдав.

Одонгоор шагнах ёсон монголд бусдаас харьцангуй сүүлд эхлээд сүрхий эрчимтэй хөгжсөн байна. Одон медалийн “ашиглалт” охор богино хугацаанд үлэмж “дээшилж”, эхлээд түүгээр зөвхөн гавъяа байгуулсан хүнийг шагнадаг байснаа нэмсэн нэмсээр ... үйлдвэрийн газар, албан байгууллага, засаг захиргааны нэгжийг, бүр сүүлдээ, сайд дарга нар бие биенээ уралдан өрсөлдөн шагнадаг болсон түүхтэй.

Монголд одоогоор нийтдээ 26 төрлийн гавъяат цол, 7 – 8 төрлийн одон, “Төрийн шагнал”, “Улсын баатар” гээд 5 – 6 төрлийн төрийн шагнал “үйлчилж” байна. Орчин цагийн шинэ монголын “дээд” одонгууд, мэдээж дотроо эрэмбэ дараатай, гэхдээ тэр нь иргэндээ бус зөвхөн шагналдаа хамаатай юм. Одон медаль олон байна, олголт түгээлт нь ихдэж байна, тэр чинээгээрээ нэр сүргүй, үнэ хүндгүй байна гэсэн шүүмжлэл дунд бид 20 шахам жил явж ирлээ.

Цалин (цагаан) мөнгөөр шагнах

Хүрээний ядуу айл ямаан Чимидийн хvв бол Богдын дэргэд шадарлаж түүний хишгийг хвртсээр хөрөнгөжсөн хvн юм. Улмаар тэр Богд, Эх дагина хоёртой нэг жуузанд явах болжээ. Хvмvvc, хэн нь чухам Богд болохыг ялгаж салгахад бэрх боллоо хэмээн жиг жуг ярилцаар хэдэн жил өнгөрсний хойно нэг шөнө, хаан шанзавын яамны хүмүүсийг голын сүм дээр дуудуулж, тэдэнд “Тэр хүүг унтаж байхад нь барьж ав” хэмээн тушаав. Тэгээд хүүг баривчлан төмөр дотортой мөглөнд хийж шоронгийн дарга Хүрийн Дугаржаваар харгалзуулжээ. Хүү долоо хоноод нас барав. Энэ тухай Богдод айлтгахад тэрээр мөнөөх Х. Дугаржавт тавин лан шагнасан байна. [\[http://www.mglclub.com/freetime3/1914792\]](http://www.mglclub.com/freetime3/1914792) Эзэн

хааны энэ **шан** тусгай даалгавар биелүүлсний **хөлс** шинжэй байна.

Тэтгэмж, хишгээр шагнах

МНТ (185 дугаар зүйл) –д “Хуйлдарын зүтгэлийг үнэлж ... түүнд, ургийн ураг хүртэл нь өнчдийг тэтгэх хишгээс хувь хүртээ ... гэж зарлиг болгов; гэсэн байна. Энэ нь юуг хэлэв гэхээр өнөөгийн манай соёлт нийгмийн тэтгэвэр тэтгэмж маягийн юм тэр үед, нэгдүгээрт, байж, хоёрдугаарт, тэр нь нийт хүн ардад хамааралгүй, харин ганц нэгэн хүнд хааны үзэмжээр олгогддог байв. Аль ч өнцгөөс нь үүнийг харлаа гэсэн, энэ бол эзэн хааны соёрхолоор олгогддог нэг төрлийн шан харамж, хишиг ивээл мөн.

Ямба эдлүүлэх ... (Тусгай хангамж тогтоох)

Эрхэм дээдэс, ихэс мяндагтан, сайд дарга нарын тусгай хангамж, цалин пүнлүүний асуудал бол зөвхөн социалист төрийн тогтолцооноос үүдэж уламжилсан эд биш юм. Аль ч түүхийн үед байсан гэж итгэлтэй хэлж болохоор байдаг. Харин, хэр хэмжээ нь бол өөр асуудал аа. Ямба гэдэг бол тусгай хангамжийн тухай ойлголт гэдгийг ч тэмдэглэх нь зүйтэй. Ямбыг эдэлдэг. Жишээ дурдъя.

а) Чин сүжигт Да лам Гомбын Цэрэнчимэд

(дарга, сайдын цол) Богд хаан төрийн яамдыг зэрэглэж, Дотоод яамыг тэргүүн яам болгон, түүнийг толгойлсон сайд Гомбын Цэрэнчимэдээр Засгийн газрын хэргийг бүхэлд нь эрхлүүлж байв. Да лам Г. Цэрэнчимэд Ерөнхий сайдын албан тушаалд томилогдоогүй боловч, хэрэг дээрээ Засгийн газрын тэргүүний үүргийг гүйцэтгэж байлаа. Да ламыг гурван давхар магнаг дэвсгэр, түшлэг, ширээ, улбар шар жолоо, ногоон тэрэг, чин вангийн пүнлүү, үүрд хөрөнгөөс албан гаргуулахгүй болгон шагнаж, Шадар сайд, Дотоод Яамны сайд, Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайдын албан тушаалд тохоон талбингаа, түүгээр мөн шавийн харъяат албан хэргийг хавсран шийтгүүлсэн болой. Тэрээр хорлогдож насан хальсан.

Дүгнэлт

Энд бичиглэсэн санаанууд, “чингэсийн жишээ магтаалын жишиг” болж хэвшчихээд байгаа энэ цаг үед цаад ерөнхий дэвсгэр агуулгаараа “их эзнийг дагаж дуурайх нь зүйтэй” гэсэн буруу өнгөөр “уншигдах” вий гэсэн болгоомжлол төрч байна. Иймээс, энэхүү бэлтгэсэн материалыг бүхэлд нь “түүхэн сургамж” гэдэг талаас нь харахыг уншигч танаас хичээнгүйлэн хүсье.

1. Монгол төрийн эртний уламжлалт шан харамж, тэдгээрийн төрөл зүйл бүхэлдээ өнөөгийн үндсэн хуульт дэг ёсонд үл нийцэхээр ажээ. Хэлбэр талаас нь авч үзвэл, бидэнд тэдгээрээс авах юм нэгээхэн ч алга.
2. Харин, шан харамжийг эзэнжүүлж байсан арга зарчмын үүднээс бол хэд хэдэн ололттой, эерэг, бас сургамжтай зүйлс ажиглагдлаа. Үүнд:
 - а) Дундад зууны үед, монгол төрийн хишиг шан эзэнжих тал дээрээ ихээхэн “нүдээ олсон” шударга шинж төрхтэй байв;
 - б) Тиймээс, засаг төрийн шагналыг тэр үед хэн ч өөрөө гуйж хөөцөлдөж явах ёсон байсангүй ... түүнийг зөвхөн дээрээс шийдэж олгодог байв;
 - в) Их хааны шан соёрхол эзэндээ оройтолгүй “яг цагтаа” очдог байж. Ингэснээрээ, эртний манай эрхэм дээдсүүд эр зориг эрдэм чадалтай хүмүүнийг нийгэм төрийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгүүлэх аргыг олсон, тэдний хүчийг авах тал дээр гаргууд хүмүүс байжээ;

- д) Нэг удаагийн тусгай даалгавар гүйцэтгэсэн, амь дүйсэн чухал үүргийг нэр төртэй онц сайн биелүүсэн хүнийг ч хаан эзэн өөрөө мэдэн харамгүй сэтгэлээр том шагнадаг байв;
 - е) Шагналын нэгдэж тогтсон тодорхой хэлбэр зарчимгүйг “далимдуулаад” шагнах эрх бүхий субъект нь, түүнийг заримдаа “шийтгэл доромжлол болгон хувиргаж” хортойгоор ашиглах бололцоо ч бүрэн нээлттэй байв; (Их гавъяа байгуулсан хүнд зориуд нэн бага шан өгөх нь нэг төрлийн сануулга доромжлол болдог байна. Иймэрхүү үйлдлийг хэзээ хэн гэдгээсээ үл хамааран санамсаргүйгээр үйлдэх бололцоотой)
3. Эрт үедээ, хэнийг төрийн дээд албан тушаалд томилох, хэнд онцгой эрх ямба олгох эдлүүлэх асуудал ... энэ бүхэн их эзэн хааны тааллаар шийдэгддэг, нэг ёсондоо, бусдад шагнал болгон түгээдэг түүний “хувийн өмч” байсан байна. Гэхдээ, манжид дагаар орсон цаг үе, Богд хаант улсын үеийг эс тооцвол, тэдгээрийг алт мөнгө, эд агуурсаар арилжиж байсан нь үгүй ажээ;
 4. Бүх юман дээр нэг хүний хэмжээгүй эрхийн дур зорго үйлчилсэн тийм үед нийгмийн гишүүний гавъяаг үнэлэхэд “зүүдэг одон” ямар ч хэрэггүй, эрэлт хэрэгцээгүй учраас одон медаль үүсэхгүй, ө. х. түүний “тайзан дээр гарч ирэх цаг” яагаа ч үгүй байжээ. Энэ үед европод орден хэдийнэ бий болчихоод байв. *Орден гэдэг нь дундад зууны европын язгууртан, шашны мяндагтан, хуягт баатруудын бүлгэм юм. Европын орденууд голдуу 4 дэс дэвтэй, мөн янз бүрийн таних тэмдгээрээ хоорондоо ялгаатай. Ордене хүнд өгдөггүй, харин түүнд элсүүлдэг байжээ. Жишээ нь: рыцарууд гэх мэт. Өөрөөр хэлбэл орден нь байгууллага байж, зориуд зохион байгуулагдсан боловсронгуй тогтолцоо байжээ гэсэн үг. [...] XIII зуунд монголын улс овгийн байгууллагаасаа салж ядсан, аанай л мөн “хоцрогдлын туйл” нийгэм байсан. Уламжлалт эдийн засаг түүнд хөгжих бололцоог хэзээ ч олгож байсангүй. Юун одон!?*
 5. Харьцангуй хожуу, Богд хаант Монгол улс ерөнхийдээ “шагнал шийтгэлийн манжийн систем” –ийг хэвээр нь үргэлжлүүлэн хэрэглэж байсан ч, түүнд өөрийн гэсэн томоохон шинэтгэлийг цаг алдалгүй шуурхай оруулж чадсан байна. Ингэснээрээ “туурга тусгаар улс” мөн гэдгээ бусдад давхар харуулах, ялимгүй ч гэсэн сайхан шинэ боломжтой болсон, тэгж ч ашигласан байна.

Гэтэл, Зөвлөлт Холбоот Улс гэгдэж асан, эдүгээ нэгэнт үгүй болсон ХХ зууны социалист төртэй хэт гүрний одон медалийн “орчуулга”, тэдгээрийн хуулбар болсон олон шагналаас бидний улс өнөө болтол бүрэн салж чадаагүй явна. Энэ бол өнөөгийн манай эрх зүйн шинэтгэлийн “дундаж хурд” –ыг тооцоолж гаргахад сөрөг нөлөөтэй тусгүй явдал. Үүнийг одоо удаж ... удааж болохгүй, яарах хэрэгтэй.

Санал

1. Төрөөс олгодог цол, одон, медаль, тэдгээрийг дагалдах мөнгө төгрөг ... эд бүгдийг “төрийн дээд одон шагнал”, “төрийн шагнал” гэх зэргээр нэрлэж явж иржээ. Гэтэл энэ ухагдахуун дотор нь бусад олон одон медалийн зэрэгцээ “төрийн шагнал” гэж тусдаа нэртэй хамгийн том хүндтэй шагнал ч мөн орж байдаг юм. Товчдоо, төрийн шагнал, төрийн дээд одон медаль гэдэг нэр нэршил хоцрогджээ.

Үгийн утга оновчийг аль болохоор зөв дүйлгэх үүднээс монгол хэлний “шан”, “шан харамж” гэх нэршлийг бид зориуд энд олонтаа хэрэглэлээ. “Харамж” гэдэг бол “гавъяаны оронд хариу барьж өгдөг тийм зүйл” юм байна. Цаад шагналынх нь нэр, жишээлбэл. “Улсын баатар” гэсээр байхад хүртэл түүнд заавал “төрийн” гэсэн тодотгол уях нь зөрчилдөөнтэй. Тиймээс бид “Улсаас олгодог шан харамж” гэсэн шинэ нэр томъёог санал болгож, улмаар уг асуудалтай холбогдож гарах шинэ хуулийн төсөлд

авч хэрэглээсэй гэж хүсч байна.

- Одон шагналын тогтолцоог шинэчлэх асуудал удааширч ужгирсанаас, үйлчилж байгаа хууль тогтоомжийн агуулгыг хэсэгчлэн “цоолдож” өөрчлөөд явдаг, сайшаахад бэрхтэй арга ажиллагаа үргэлжилсээр байна. Үйл явцын өрнөл дунд Чингэсийн одон аль хэдийнэ бий болсон. Дараа дараагийн удаад Хубилай хааны, Өгөөдей хааны, Өэлүн эхийн одонгууд ч гараад ирж болох юм. Одонгийн төрөл зүйлд хаадын нэр [хүний нэр] зүүх нь тийм ч оновчтой хувилбар мөн үү биш үү гэдгийг төслийн хэлэлцүүлгийн явцад сайтар бодолцох ёстой болов уу.

Тиймээс, монголын анхны одонг “аль болохоор бүрэн дүүрэн” сэргээж, Эрдэнэнийн Очир одонгийн дотор багтаж байгаа Чингисийн одон ... бусад одонг дотоод эрэмбийнх нь дагуу 100% авч хэрэглээд явах бололцоотой гэж үзнэ. Ялангуяа эрдэнийн очир одонгийн гуравдахь эрэмбийг буюу 5 дэстэй түшмэдийн одонг төрийн албаны системд хэрэглэхэд нэн зохимжтой мэт. Мөн, малчин хүнд “... гавъяат малчин цол, тэмдэг” олгож байхын оронд “улсын сайн малчин мөн” гэсэн жуух батламж гардуулаад, эрдэнийн очир одонг энгэрт нь зүүж өгөлтэй.

Давтан тэмдэглэхэд, Эрдэнийн очироос өөр одон хэрэггүй юм. УБХ –ын 1991 оны 68 дугаар тогтоолоор “Эрдэнийн очир” –ыг дахин сэргээсэн гэдэг болов ч, тэр нь сэргээсэн ч биш шинэчилсэн ч биш нэг тийм дутуудуулсан “половинчатый” арга хэмжээ болжээ. (Богд хаант Монгол Улсын Эрдэнийн очир одонгийн товч танилцуулгыг хавсралтаас үзнэ үү.



2.2. Монгол Улсын төрийн шагналын өнөөгийн систем

ТӨРИЙН АЛДАР ЦОЛ, ОДОН МЕДАЛЬ

№	ШАГНАЛЫН НЭР, ТӨРӨЛ	Үйлчлэл, хугацаа □ хүчинтэй; ■ хүчингүй;	ЗАРИМ ТОДОТГОЛ
(1)	(2)	(3)	(4)
А. ОДОН • Түүхэн одон			
1.	Эрдэнийн очир одон • Чингис хааны одон • Автай сайн хааны одон • Өндөр гэгээний одон • ... бусад;	(1913 – 1922)	<ul style="list-style-type: none"> Богд хаант Монгол Улсын анхны одон. Хааны зарлигаар бий болсон, хийлгэх болсон гол сэдэл нь Их оросын Баатар цагаан хааныг шагнах явдал байв; Дотроо 12 дэстэй. Энд зөвхөн эхний 3 дэсийг дурдав. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1. –ээс үзнэ үү); Монгол орныг харийн түрэмгийлэгчдээс чөлөөлөх, тус улсын тусгаар тогтнол ард түмний эрх чөлөөг бататган хамгаалах, хөгжүүлэх 2 ард түмний ах дүүгийн ган бат найрамдлыг бэхжүүлэх үйл хэрэгт зүтгэж явсан Зөвлөлт Холбоот Улсын харьяат зарим хүмүүсийн байгуулсан гавьяаг Ардын Засгийн газраас цэргийн гавьяанд тэнцүүлэн, 1922 онд “Эрдэнийн Очир” одонгоор шагнаж байв.
2.	Бичгийн гавьяаны одон • Дотроо 3 зэрэгтэй • Энэ одон нэг хэсэг “Аж ахуйн гавьяаны одон” болж хувирсанаа, 1930 онд Аж үйлдвэрийн гавьяаны одон болж өөрчлөгдсөн.	(1926 – 1930)	<ul style="list-style-type: none"> Улсын III Их Хурлын шийдвэрээр бий болсон; 1927 оноос шагнаж эхэлсэн Тухайн үедээ, Бичгийн гавьяаны одонгоор шагнах асуудлыг Дотоод яам, Цэргийн гавьяаны одонгоор шагнах асуудлыг Цэргийн зөвлөл шийдэж байсан ба сүүлд УБХ –ын Тэргүүлэгчид, Засгийн газар “эрхлэн гүйцэтгэх” болжээ.
3.	Цэргийн гавьяаны одон • Цусан гавьяаны I, II зэргийн одон гэгдэж байсан ба онцгой гавьяа байгуулсан цэрэг дайчдыг шагнадаг байв.	(1926 – 1930)	<ul style="list-style-type: none"> Ялангуяа энэхүү одонгоор газар дээр нь шагнагдсан хүн бол бараг баатрын хэмжээнд үнэлэгдэж байсныг дурдах нь зөв болов уу. Одоогийн Байлдааны гавьяаны улаан тугийн одон юм)



4.	Цэргийн гавъяаны улаан тугийн одон	(1930)	<ul style="list-style-type: none"> Энэ 2 одонг мөнгөн шан дагадаг байв. Анх удаа шагнагдвал сар бүр 15, дахин шагнагдвал 25 төг. авдаг байлаа.
5.	Аж үйлдвэрийн гавъяаны одон	(1930)	<ul style="list-style-type: none"> Мөн, үр хvvхэд нь гадаадад сургуульд явбаас бусдаас онц ялгавартай вээх, алба татвараас хөнгөвчлөх, өртөөгөөр нэг удаа үнэ төлбөргүй зорчих, орон сууц, цахилгаан гэрлийн хөлсийг 25 хувиар хорогдуулах гэх зэрэг зvйлийн хөнгөлөлт вэvvлнэ. Энэ вeэс эхлэн эдгээр одонгоор зөвхөн гавъяа байгуулсан ард иргэдийг бус хөдөлмөрийн амжилт бүтээл гаргасан улсын байгууллагыг шагнаж эхэлжээ. Тухайлбал, Цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор 1931 онд МХЗЭ-ийн Төв Хороо, Аж үйлдвэрийн гавъяаны улаан тугийн одонгоор 1935 онд Хатгалын ноосны үйлдвэрийг тус тус шагнаж байжээ.
6.	Маршалын од <ul style="list-style-type: none"> Маршалын од нь шижир алтаар төвийлгөн хийсэн тал бүр тийшээ цацарсан 108 ширхэг алтан цацраг бүхий 12 талт хошуу хэлбэртэй. 12 талт хошууны үзүүрийн диаметр нь 75 мм байх бөгөөд 108 алтан цацрагийн гол дунд 40 мм диаметр өргөн хүрээтэй Очир алмааз чулуун шигтгээт улаан паалант таван хошуу байлаа. Таван хошууны уулзвар бүрт нарийн хүрээтэй гурвалжилсан үзүүртэй Очир алмааз чулуун шигтгээ байна. Таван хошууны голд 25 мм диаметртэй, өнгөт паалантай 1940 оны БНМАУ-ын төрийн сүлдийг байрлуулсан. 	1940	<ul style="list-style-type: none"> Маршалын од бол зөвхөн маршал цолтонд зориулсан одон мөн гэж үзэж энд оруулав. “Нар сар”, “наран саран” гэдэг шиг од, одон 2 бол, үгийн үндэсээрээ ижил, нэг зүйлийн нэр юм. 1940 оны сүүлчээр БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн дарга, ГЯЯ болон ЦЯЯ -ны сайд, МАХЦ -ийн Бүх Цэргийн Жанжин, Улсын өрлөг жанжин Х. Чойбалсанд Маршал цолтны онцгойлох тэмдэг - Маршалын од олгосон байна. БНМАУ-ын маршалын одны эх загварыг Урлагийн гавъяат зүтгэлтэн, төрийн шагналт зураач Д.Чойдог зуржээ. Энэ маршалын од нь одоо Үндэсний Түүхийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. http://www.soronzon.blogspot.com/
<ul style="list-style-type: none"> Одоо хэрэглээнд байгаа одон 			

7.	Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон	1931	<ul style="list-style-type: none"> Ардын хувьсгалын 10 жилийн ойгоор “хуучныг шинэчлэх замаар” дахин гаргасан; Ардын хувьсгалын 5 жилийн ойтой 1926 онд болсон болсон байдаг ба 1926 оны Бичгийн гавъяаны болон Үйлдвэрийн гавъяаны одонгийн хувирал хувьсал байсан;
8.	Алтангадас одон	1936	<ul style="list-style-type: none"> Ардын хувьсгалын 15 жилийн ойгоор бий болсон гэж үзнэ; Улс, нам, олон нийтийн болон хоршооллын байгууллага, үйлдвэрийн газарт он удаан жил идэвхи зүтгэлтэй ажилласан хүмүүсийг хүнлэг ардчилсан социалист нийгэм байгуулах болон улс орныг батлан хамгаалах үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг харгалзан ... урамшуулах зориулалттай;
9.	Сvхбаатарын одон	1945	<ul style="list-style-type: none"> Энэ одонгоор хамгийн анх И. В. Сталиныг шагнасан. Эндээс эхтэйгээр, Сvхбаатарын одонгоор ах дvв социалист орны нам төрийн удирдагчдыг шагнах жишиг тогтсон; И. Сталин, Л. Брежнев нар тус бүр хоёр удаа, Ким Ир Сен, Хо Ши Мин, Тодор Живков, Иосип Броз Тито, Янош Кадар, Рауль Кастро ... гээд гадаадын олон удирдагчийг шагнасан байдаг; Монгол иргэдээс Чойбалсан, Бумцэнд, Цэдэнбал, Янжмаа нар эхний ээлжинд шагнагдсан;
10.	Байлдааны гавъяаны улаан тугийн одон	1945	<ul style="list-style-type: none"> Японы милитаристуудыг бут цохисоний холбогдуулж, УБХ –ын Тэргүүлэгчдийн 1945.10.17 –ны 91 дүгээр тогтоолоор энэ одонг бий болгосон; (1930 оны хуучин “цэргийн гавъяаны улаан туг” –ийн одонгоо энэ шийдвэрээр шинэчилсэн)
11.	“Алдарт эх” одон	1957	<ul style="list-style-type: none"> Дотроо 2 зэрэгтэй, 1 дүгээр одонг 200 төг, 2 дугаар одонг 100 төг. дагадаг байв. 1 -р зэргийн одонгоор 8 ба тvvнээс олон хvvхэд төрvvлж өсгөсөн эхийг, 2 -р зэргийн одонгоор 5 - 8 хvvхэд төрvvлэн өсгөсөн эхийг тус тус шагнаж байхаар анх тогтоожээ.

12.	“Чингис хааны одон”-	2002	<ul style="list-style-type: none"> УИХ –ын 2002.5.17 –ны өдрийн 21 дүгээр тогтоолоор бий болсон. (Тогтоолын төслийг, Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан) Энэ одонгоор нэхэн шагнадаггүй; Одонг 9 цэн алттай тэнцэх мөнгөн шан дагалдана;
13.	“Эрдэнийн Очир” одон	1991	<ul style="list-style-type: none"> АИХ –тай байх үед Улсын Бага Хурлын тогтоол (1991, №68) –оор бий болгосон; Богд хаант Монгол Улсын Эрдэнийн очир одонг дахин сэргээсэн гэдэг ч уламжлалт одон жинхэнэ утгаараа сэргээгүй гэж үзнэ; Шийдвэр гаргах болсон сэдэл нь “Солонгос Улсын Ерөнхийлөгч Ро Дэ У –г шагнах явдал байв. Солонгос Улс манайд (хуучин, эдэлгээнд байсан) Боинг бэлэглэсэн.
В. ЦОЛ <ul style="list-style-type: none"> Түүхэн цол 			
14.	Богд хаант Монгол Улсын баатар, их баатар жанжин	1911	<ul style="list-style-type: none"> Олноо өргөгдсөний он жилүүдэд улс орноо хамгаалан тэмцэх үйлсэд баатарлаг гавъяа байгуулсан хvmvvc (бүгд 101) - т “баатар” цол олгож байв. Ховдыг чөлөөлөх тулалдаан болон Өвөр Монголыг чөлөөлөх тэмцэлд хвчин зүтгэж явсан олон хvнд, тухайлбал Дамдинсүрэнд “Манлайбаатар”, Магсаржавт “Хатанбаатар”, Баярт “Шударга баатар” цол олгожээ ... гэх мэт. Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны цагаан сарын арван найманд Богд хааны зарлигаар: Орос жанжин Барон Унгернд үе улиран хан, дархан хошой чин вангийн хэргэм, ногоон жууз, улбар шар хүрэм, шар жолоо, гурван нүдэт тогосын отго, улсыг мандуулагч их баатар жанжин цолоор шагнажээ ... гэх мэт;
15.	“Ардын засгийн” баатар	1922	<ul style="list-style-type: none"> Өмнөх уламжлалыг дагаж, Ардын Засгийн газраас Сvxбаатарт “Зоригт баатар” цолыг 1922 онд, Магсаржавт “Хатанбаатар цолыг 1924 онд тус тус шагнасан байна; 1945 он хүртэл энэ 2 баатар дээр хүн нэмэгдээгүй явж ирсэн байдаг.

16.	Улсын алдарт гавъяат жүжигчин, дуучин, хөгжимчин, уран зохиолч алдар цол <ul style="list-style-type: none"> Алдар гавъяат жүжигчин Алдар гавъяат дуучин Алдар гавъяат хөгжимчин Алдар гавъяат уран зохиолч (Хэрэв 1 хүн энд байгаа шагналын багцаас 2 цолыг зэрэг, эс бөгөөс цувуулан авбал, түүнийг, “Улсын алдар гавъяат дуучин бөгөөд жүжигчин” гэх жишээний ... байж)	1935	<ul style="list-style-type: none"> УБХ -ын Тэргүүлэгчдийн тогтоолоор бий болгож, урлагийнхнаас Д. Ичинхорлоо, Ж. Дорждагва, Д. Түдэв, зохиолчдоос С. Буяннэмэх, Ши. Аюуш ... нарыг анхлан шагнажээ. Энэ цолыг өнөөгийн “гавъяат цол” –той дүйлгэж арай боломгүй байна. Тэр үед алдар цол “гавъяат” ба “ардын” гэж салбарлан хөгжиж амжаагүй байсан. Тиймээс бид тухайн цолыг утгачилан ойлгож, зориуд эрэмбэ өргөн, дээш нь татаж жагсаав. Салбарын алдар гавъяатнуудыг тус тусад нь цоллон алдаршуулах эхлэл эндээс эхэлсэн гэж үздэг байна.
17.	Улсын эрхэм уран зохиолч	1940 – өөд онд	<ul style="list-style-type: none"> Энэ тухай Д. Самданмөнх, С. Цэдэндамба нарын “Төрийн сүлд ивээ” номонд (жишээгүйгээр) цухас дурдсан нь бий.
18.	Уран сайхны гавъяат үйлчин цол	1941	<ul style="list-style-type: none"> Ардын Хувьсгалын 20 жилийн ойгоор Э. Оюунд БНМАУ -ын уран сайхны гавъяат үйлчин цол олгосон байна. Энэ цолыг одоочилбол “Урлагийн гавъяат зүтгэлтэн” гэмээр байдаг ч албан ёсны нэрээр нь авч үзэхээр яах аргагүй түүхэн цол болж таарч байна
19.	Улсын өрлөг жанжин	1936	<ul style="list-style-type: none"> Энэ цол зөвхөн “цэргийн цол” –ноосоо давсан өргөн утга учиртай, улстөрийн гүн гүнзгий түүхэн агуулгатай байсан тул жагсаалтад зориуд оруулав. УБХТ, Ардын СнЗ -ийн 1936 оны хоёрдугаар сарын 21-ний өдрийн 14 -р тогтоолоор Ерөнхий сайдын I орлогч, Мал тариалангийн яамны сайд Х. Чойбалсан, Бүх цэргийн жанжин, ЦЯЯ -ны сайд Г. Дэмид нарт анх удаа БНМАУ-ын Өрлөг жанжин - Маршал хэмээх цэргийн дээд алдар цолыг олгожээ.
<ul style="list-style-type: none"> Одоо хэрэглээнд байгаа цол 			



20.	Улсын баатар • (Улсын баатар цолыг шагнахдаа Корпус командлан захирагчаас дээш тушаалтанд УБХ –аас, үүнээс доош тушаалын хүнд Бүх цэргийн жанжнаас тус тус олгодог журамтай байв) • Уг цолтонд Улсын 1946 оноос эхлэн Улсын баатарын “Алтан таван хошуу” медаль (одоо Монгол Улсын баатарын “Алтан таван хошуу” тэмдэг) гэж зүүж өгдөг болсон. Бас Сүхбаатарын одонгоор “давхар” шагнана.	1936	<ul style="list-style-type: none"> Улс хувьсгалын 15 жилийн ойг тохиолдуулан УБХ -ын Тэргүүлэгчид, Ардын СнЗ -ийн хамтарсан хурлаас МАХЦ -ийн дээд алдар цолыг буй болгох тухай 14 тоот тогтоол гаргаж, түүндээ “Улсын баатар цолыг улсын ба ард түмний төлөө дайсан этгээдийг онц баатарлагаар байлдан дарж цусан гавъяа байгуулсан хүмүүст шагнаж олгож байх” -аар тогтжээ. БНМАУ-ын баатар цолыг 1936 онд хилийн харуулын бага дарга Ш. Гонгор 24 насандаа анх хүртжээ. 1936 онд Д. Дэмбэрэлд “Агаа-рын зоригт баатар”, 1939 онд Л. Дандарт Гарамгай баатар цол тус тус шагнасан байдаг. 1966 онд Ю.Цэдэнбалын 50 насны ойг тохиолдуулан “БНМАУ-ын баатар”, 1976 онд БНМАУ -ын Хүндэт иргэн Л. Брежневт “БНМАУ -ын баатар” цолыг тус тус олгож байв. 1941 онд УБХ -ын Тэргүүлэгчдээс “Улсын баатар цол олгох журам”-д өөрчлөлт оруулж улмаар маршал Х.Чойбалсанд “БНМАУ-ын шалгарсан баатар”, сүүлд түүнд 1945 онд “хошой баатар” цол, Цэргийн гавъяаны улаан тугийн одон шагнажээ. И. В. Сталин 1949 онд, К. Е. Ворошилов 1957 онд Монгол Улсын баатар цолоор шагнагдсан байна.
21.	Хөдөлмөрийн баатар ¹ • (Энэ цолыг авсан хүнд Алтан соёмбо тэмдэг , Сүхбаатарын одон шагнадаг)	1956	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн 1956.12.31 –ний өдрийн 234 дүгээр зарлигаар бий болгосон; Аж үйлдвэрийн салбараас уурхайчин Д. Даваажав, малчдаас хоньчин З. Очир, тариаланчдаас тракторч Н. Бям-бацогт нар энэ цолыг анхлан хүртсэн; 1990 гэхэд энэ эрхэм алдрыг 301 хvн хүртжээ; 1961 онд нам, засгийн удирдагч Ю. Цэдэнбал осолд орж удаан хугацаагаар Москвад эмчлүүлсэн. Түүний “сэтгэл санааг сэргээхийн тулд” Ю. Цэдэнбал даргын 45 насны ойгоор 1961 онд “БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар” цол олгосноор ... нам засгийн удирдагчид бие биедээ “төрсөн өдрөөрөө” одон медаль олгох шинэ уламжлал тогтсон гэж үздэг байна. Тухайлбал, 1965 онд АИХ -ын Тэргүүлэгчдийн дарга Ж. Самбуугийн 70 насны ойгоор түүнд “БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар” цол шагнасан байна;



22.	Чойбалсангийн нэрэмжит шагнал • (Энэ шагналыг 1962 оноос төрийн шагнал, 1991 оноос төрийн соёрхол, 1997 оноос [эргээд] төрийн шагнал гэж нэрлэж иржээ) • Чойбалсангийн шагнал [нэг хэсэгтээ] төрөөс олгогддог хамгийн том шагналд тооцогддоггүй, эрэмбээрээ, “ардын ... цол” (1941) –ны ард ордог байсан байна.	1946	<ul style="list-style-type: none"> Төрийн шагнал бол гарцаа байхгүй цол юм. Авсан хүн нь “Төрийн шагналт ...” гэж цоллуулдаг. Тиймээс бид “хэрэглэнд байгаа цол” гэсэн ангилалд хамаатуулав. БНМАУ -ын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 2 -р сарын 7 –ны тогтоолоор соёл урлаг, утга зохиолын шилдэг бүтээл, шинжлэх ухааны нээлт, гарамгай бүтээл туурвисан хүмүүст Төрийн шагнал олгох болжээ. (1962 он хүртэл Маршал Чойбалсангийн нэрэмжит шагнал нэртэй байв) 1946 оноос олгож эхэлсэн; 1962 он хүртэл олгож ирсэн. 1962 оноос “төрийн шан” гэх болсон. 2006 он хүртэл төрийн шагналаар нийт 254 хүн шагнагдсан байв.
23.	Ардын жүжигчин	1941	<ul style="list-style-type: none"> “Сүхбаатар” киноны уран сайхны хэд хэдэн гол дүрд чадварлаг жүжиглэж урлагийн өндөр амжилт гаргасан гавъяат жүжигчин Ц. Цэгмидэд Ардын жүжигчин цолыг 1942 онд анхлан олгожээ.
24.	Ардын зураач	1962	<ul style="list-style-type: none"> 1965 оноос шагнаж эхэлсэн;
25.	“Ардын уран зохиолч	1979	<ul style="list-style-type: none"> Уран бүтээлийн гарамгай амжилт гаргасан зохиолч, яруу найрагч, утга зохиол судлаач, шүүмжлэгчдийн шагнал
26.	Ардын багш	1981	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн 1981 оны 281 дугаар зарлигаар бий болгосон; (Улс хувьсгалын 60 жилийн ой тохиож байсан цаг)
27.	Ардын эмч	1981	<ul style="list-style-type: none"> 1990 оноос шагнаж эхэлсэн;
28.	Гавъяат багш ²	1941	<ul style="list-style-type: none"> Улс хувьсгалын 20 жилийн ой болж байв. Улсын XXV Бага хурлын шийдвэрээр энэ цолыг бий болгосноор материаллаг үйлдвэрлэлийн болон нийгмийн бvх салбарт гавъяат цолтон төрж гарах эх үндэс бүрэлдсэн. 1940-1990 онд БНМАУ-ын Ардын болон гавъяат гэсэн 40 гаруй нэр бvхий хvндэт цолыг 800 гаруй хvн хүртсэн байна. Мөн Засгийн газрын хvндэт жуух бичиг, салбарын тэргvний ажилтан цол, тэмдгээр олон зуун хvнийг шагнаж байсан.

29.	Хүний гавъяат эмч	1941	<ul style="list-style-type: none"> Улсын эрүүлийг хамгаалах талаар онц гарамгай гавъяа байгуулсан хүнд олгох зориулалттай; Цолыг бий болгоод түүгээрээ хүн шагнахгүй их удсан бололтой байна; Энэ цолыг 1960 онд Улсын төв клиникийн мэдрэлийн их эмч Л. Дагзмаа анхлан ... бусад хүмүүсийн хамт авсан байдаг;
30.	Малын гавъяат эмч	1957	<ul style="list-style-type: none"> АИХ (УИХ) –ын Тэргүүлэгчдийн зарлигаар бий болгосон; 1961 оноос олгож эхэлсэн;
31.	Гавъяат зоотехникч (мал зүйч)	1957	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй хамт бий болгосон; Энэ цолыг, мах – ноосны чиглэлийн “Орхон” үүлдрийн хонь бий болгосон Т. Аюурзана анх авчээ;
32.	Спортын гавъяат дасгалжуулагч	1957	<ul style="list-style-type: none"> Энэ цолыг АИХ –ын Тэргүүлэгчдийн зарлигаар 1971 онд дахин шинээр баталгаажуулсан; Дээрх шийдвэр гарахаас өмнө энэ цолыг Монголын бийн тамир, спортын эвлэлийн төв зөвлөлөөс олон жилийн турш олгож ирсэн байдаг.
33.	Спортын гавъяат мастер (Гавъяат тамирчин)	1957	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй ижил, 1986 оноос Гавъяат тамирчин гэж болсон; Спортын ууган гавъяат мастер нь (1960) далай даян дархан аварга Б. Түвдэндорж болой.
34.	Гавъяат барилгачин	1963	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн зарлигаар бий болгосон; 1964 онд УБ хотын барилга трестийн шаварчин (ажилчин) Д. Эмээлийг анх шагнасан;
35.	Гавъяат тээвэрчин	1965	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн зарлиг (№164) –аар 1965.7.16 –нд бий болгосон;
36.	Гавъяат нисэгч	1965	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн зарлиг (1965, №223) –аар бий болгосон;
37.	Нисэхийн гавъяат техникч	1965	<ul style="list-style-type: none"> Дээрхтэй хамт бий болгосон; Цэргийн ба иргэний өгөөрын тээврийг хөгжүүлэх үйлсэд гарамгай амжилт гаргасан ... I зэргийн нисэгч ба техникч нарт олгох зориулалттай;



38.	“БНМАУ –ын Соёлын гавъяат зүтгэлтэн”	1966	<ul style="list-style-type: none"> Соёл гэгээрлийн байгууллагын гарамгай амжилт гаргасан тэргүүний хүмүүст олгох зориулалттай; Энэ цолыг 1966 онд анх улсын хэвлэх хорооны техник-редактор Ц. Содов авчээ.
39.	Гавъяат уурхайчин	1967	<ul style="list-style-type: none"> 1969 оноос олгож эхэлсэн;
40.	Гавъяат холбоочин	1967	<ul style="list-style-type: none"> Харилцаа холбооны салбарын үндсэн мэргэжлийн ажилчин, инженер, техникийн ажилтан нарыг шагнах зориулалттай;
41.	Гавъяат усжуулагч	1967	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн 1967 оны 174 дүгээр зарлигаар бий болгосон, 1968 оноос шагнаж эхэлсэн;
42.	Гавъяат хуульч	1970	<ul style="list-style-type: none"> Системийн байгууллагадаа 10 –аас доошгүй жил зүтгэл бүтээлтэй ажилласан, ... хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд гавъяа байгуулсан хуульчдад олгоно; гэж АИХ –ын Тэргүүлэгчдийн зарлигт дурдсан байна.
43.	Худалдааны гавъяат ажилтан	1970	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн 1970 оны 109 дүгээр зарлигаар бий болгосон;
44.	Гавъяат эдийн засагч	1971	<ul style="list-style-type: none"> Эдийн засаг, төлөвлөгөө, санхүү, зээл, статистик, нягтлан бодох, тоо бүртгэлийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан ажилтан нарт олгодог; Энэ цолыг 1971 онд Сангийн яамны ажилтан Б. Янжив анх авчээ.
45.	Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн” цол	1971	<ul style="list-style-type: none"> Шинжлэх ухаан, техникийн онц ач холбогдол бүхий нээлт хийсэн, гарамгай бүтээл туурвисан эрдэм шинжилгээний шилдэг ажилтанд олгоно; Судар бичгийн хүрээлэнгийн 50 жил, ШУА –ийн 10 жилийн ойг тохиолдуулан шийдвэрлэсэн;
46.	Гавъяат уурхайчин	1971	<ul style="list-style-type: none"> Олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан уурхайчдад олгох зориулалттай; “БНМАУ –ын гавъяат уурхайчин” цолыг анх Налайхын нүүрсний уурхайн уурхайчин, БНМАУ –ын Хөдөлмөрийн баатар, ОХУ –ын гавъяат уурхайчин Ж. Отгонцагаан 1971 онд хүртжээ.

47.	Ойн гавъяат ажилтан (хүчингүй)	1973	<ul style="list-style-type: none"> 1974 оноос шагнаж эхэлсэн; 2001 онд Байгаль орчны гавъяат ажилтан цол бий болсноор 1973 оны шийдвэрийг дагаж мөрдөхгүй болсон;
48.	Үйлчилгээний гавъяат ажилтан	1974	<ul style="list-style-type: none"> 1978 оноос шагнаж эхэлсэн;
49.	Гавъяат агрономч	1974	<ul style="list-style-type: none"> Агрономч, агротехникч нарт олгох зориулалттай;
50.	ХАА –н гавъяат механик-жуулагч	1974	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн тэргүүний инженер, механикч, техникч нарт олгоно;
51.	Аж үйлдвэрийн гавъяат ажилтан	1975	<ul style="list-style-type: none"> АИХ –ын Тэргүүлэгчдийн 1975 оны 153 дугаар зарлигаар бий болгосон; 1976 оноос шагнаж эхэлсэн;
52.	Ус цаг уурын гавъяат ажилтан (хүчингүй)	1976	<ul style="list-style-type: none"> Системийн байгууллагадаа 15 –аас доошгүй жил зүтгэл бүтээлтэй ажилласан ... салбартаа ажлын өндөр амжилт гаргасан хүнийг шагнах зориулалттай; Энэ шагналыг авсан хүний тоо бусдаас их цөөн. 2001 онд Байгаль орчны гавъяат ажилтан цол бий болсноор 1976 оны шийдвэрийг дагаж мөрдөхгүй болсон;
53.	Гавъяат нэгдэлчин	1978	<ul style="list-style-type: none"> Нэгдэлжих хөдөлгөөн ялсаны 20 жилийг ойг тохиолдуулан бий болгосон. 1979 оноос шагнаж эхэлсэн; Энэ цолоор 1993 оноос хойш хүн шагнаагүй. Энэ нь нэгдэл тарсантай холбоотой; (Тиймээс тэр хэрэг дээрээ, түүхэн цол болжээ)
54.	Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан	1981	<ul style="list-style-type: none"> Эрүүлийг хамгаалах байгууллагын тэргүүний ажилтан, ажилчинг шагнах зориулалттай; 1982 оноос хэрэглэж эхэлсэн;
55.	Байгаль орчны гавъяат ажилтан	2001	<ul style="list-style-type: none"> УИХ –ын тогтоолоор бий болгосон;
56.	“Монгол Улсын гавъяат малчин”	2001	<ul style="list-style-type: none"> УИХ –ын тогтоолоор бий болгосон;
• Бусад цол			
57.	Сансрын нисэгч цол	1981	<ul style="list-style-type: none"> АИХ –ын 1981 оны 89 дүгээр зарлигаар бий болгосон;



58.	“БНМАУ-ын Хүндэт иргэн” эрхэм алдар цол	1974	<ul style="list-style-type: none"> Улс тунхагласаны 50 жилийн ойгоор 1974.11.26 –нд АИХ –ын Тэргүүлэгчдийн 305 дугаар зарлигөөр бий болгосон; Энэ цолыг (зөвхөн) ЗСБНХУ –ын Коммунист намын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Л. Брежневийг шагнахаар 1974 онд бий болгож, хэрэглэсэн ... хожим энэ шагналыг үгүй болгожээ.
59.	Төрийн албаны гавъяат ажилтан (Батлагдаагүй. Лавлагааг аль болох бүрэн байлгах үүднээс жагсаалтад нэмж оруулав.)	2009	<ul style="list-style-type: none"> Ийм цол бий болгох тогтоолын төсөл явж байгаад буцсан. Шийдэгдээгүй. Одон шагналын тогтолцоог бүхэлд нь эргэж харах цаг болсон, түрүүчийнхээ олон цол шагналыг цэгцэлж амжаагүй байж шинээр нэмж цол бий болгох шаардлагагүй; гэсэн ерөнхий үндэслэл яригдсаар байгаа болно.
С. МЕДАЛЬ			
• Түүхэн медаль			
60.	“Улсын ударник” тэмдэг	1934	<ul style="list-style-type: none"> Цул мөнгө гангийн хольцоор бэхжүүлсэн сүрхий жинтэй, уран хийцтэй тэмдэг байлаа. Энэ тэмдгээр тун цөөн хүн шагнасан байдаг аж. (Юун тэмдэг?! Бараг медаль шахуу ...)
61.	Медаль (Ардын засгийн анхны тэмдэгийн нэг байсан)	1936	<ul style="list-style-type: none"> Улс хувьсгалын 15 жилийн ойг медаль буюу тэмдэг нь бараг цул алтаар хийгдсэн, мөлгөр таван дэлбээтэй алтан үсэг бүхий байв. (Бараг одон шахуу ...)
62.	Бид ялав	Эх орны дайны ялалтыг тохиолдуулан	
63.	Түүхт ойн медаль ((Ардын хувьсгалын ой, Халхын голын ялалтын ой ... гэх мэт)	Тухайн баярын өмнө, ихэнх тохиолдолд тэгш ойгоор гаргадаг.	
64.	Халх голын ялалтын дурсгалын тэмдэг	1940	
• Одоо хэрэглээнд байгаа медаль			
65.	Цэргийн хүндэт медаль		<ul style="list-style-type: none"> Зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдан сэргийлэх байгууллагад идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан цэргийн албан хаагчид, бусад хүмүүсийг шагнах зориулалттай;

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

66.	Хөдөлмөрийн хүндэт медаль		<ul style="list-style-type: none"> “Улс, нам, олон нийтийн болон хоршооллын байгууллага, үйлдвэр, аж ахуйн газарт идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн амжилт гаргасан хүмүүсийг шагнах” зориулалттай; Анх гарсан үедээ Хөдөлмөрийн хүндэт медаль нь сар бүр 5 төгрөг цалингийн нэмэгдэл дагуулж байв.
67.	Найрамдал медаль		<ul style="list-style-type: none"> “Дэлхий дахины энх тайвныг хамгаалах улс түмний хоорондын найрамдал, хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, тус улсын бүтээн байгуулалтад гар бие оролцон туслалцаж байгаа тэргүүний хүмүүсийг шагнах” зориулалттай;
68.	Атарчдын алдар медаль		
	Шударга журам медаль	1959	<ul style="list-style-type: none"> “Байгалийн гэнэтийн аюул, ус, гал түймрээс хүний амь бие, улс, олон нийт, хоршоолол, иргэдийн өмч хөрөнгийг авран хамгаалах, нийгмийн хэв журам сахиулахад амь бие хайрлалгүй зүтгэж гавьяа байгуулсан хүмүүсийг болон хүн ардын эрүүл мэндийг хамгаалахын төлөө гавьяа байгуулсан доноруудыг шагнах” зориулалттай;
69.	Ахмад дайчин медаль		<ul style="list-style-type: none"> Халх голын байлдааны ялалтын түүхэн ойн арга хэмжээнүүдэд төр, засгаас онцгойлон анхаарч тэгш ойн жил бүр ойн дурсгалын медаль, тэмдэг бий болгон уг байлдаанд оролцож явсан ахмад дайчид, манай орны эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахад тэмцэж явсан Зөвлөлтийн зэвсэгт хүчний дайчдыг шагнадаг уламжлалтай байжээ.
70.	Дайчин алдар медаль Дотроо 3 дэстэй		
71.	“Ардын хувьсгал - 80 жил” медаль	2001	
72.	“Халх голын ялалтын 70 жил” медаль	2009	<ul style="list-style-type: none"> Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль бий болгох тухай УИХ –ын 50 дугаар тогтоол 2009 оны 7 сард гарсан.



73.	“Ардчилсан хувьсгал – 20 жил” медаль	2009	<p>Медалийн тодорхойлолтоос:</p> <ul style="list-style-type: none"> Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль нь зүүлт, медаль гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Зүүлт, медалийг гуулиар хийж алтаар өнгөлнө. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалиар Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж шагнаан, үнэмлэх олгоно. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалиар Монгол оронд Ардчилсан хувьсгалыг анхлан эхлүүлж, манлайлан оролцсон, талархан хүлээн авч, ардчиллыг түгээн дэлгэрүүлэх, төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, эрдэмтэн, судлаач, зохиолч, урлаг, соёлын зүтгэлтэн, уран бүтээлч болон бусад иргэнийг шагнана. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалиар гадаадын иргэнийг шагнаж болно. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойгоор улсын цол хүртсэн, одон, медалиар шагнагдсан хүмүүсийг энэхүү ойн медалиар давхар шагнаж болно. Уг медалийг Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд нэг удаа олгоно. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалиар нэхэн шагнахгүй.
-----	--------------------------------------	------	---

* * *

БНМАУ -ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 148 дугаар зарлигаар баталсан “Цол, одон, медалийн тухай дүрэм” өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ дүрмийн хоёрдугаар бүлэгт зааснаар **Төрийн эрхэм дээд цол** гэдэгт “Улсын баатар”, “Хөдөлмөрийн баатар” цол, **Хүндэт цол** гэдэгт “Ардын зүтгэлтэн”, “Гавьяат зүтгэлтэн”, “Сансрын нисгэгч” цол орж байна.

Мөн дүрмийн гуравдугаар бүлэгт зааснаар дараахь төрлийн одон хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

1. “Сүхбаатарын одон”,
2. “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”,
3. “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”,
4. “Алтан гадас одон”,
5. “Цэргийн гавьяаны одон”,
6. “Алдарт эх I одон”,
7. “Алдарт эх II одон”

Дүрмийн дөрөвдүгээр бүлэгт хэрэглээнд байгаа медалийг тоочин заасан. Тэнд,

- Хөдөлмөрийн хүндэт медаль,
- Цэргийн хүндэт медаль,
- Шударга журам медаль,
- Найрамдал медаль,
- Атарчдын алдар медаль,
- Түүхт ойн медалиуд (Ардын хувьсгалын ой, Халхын голын ой гэх мэт),
- Ахмад дайчин медаль,
- Дайчин алдар I, II, III гэсэн медаль тус тус оржээ.

Дүрэмд бас одон медалийг зүүх заавар бий. Түүгээр, **одон медалийн эрэмбийг дам заажээ**. Одонг зүүхдээ эхлээд Сүхбаатарын одон, дараа нь Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, Алтан гадас одон, Алдарт эх нэг, хоёрдугаар одонг баруунаас зүүнш дараалуулан зүүх ба харин медалийг эхлээд Байлдааны хүндэт медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль, Шударга журам медаль, Найрамдал медаль, Халх гол медаль, Бид ялав медаль, түүний араас ойн медалиудыг улсын ой, Зэвсэгт хүчний ой гэхчилэн мөн л баруунаас зүүнш дарааллаар зүүнэ; гэсэн байна.

Зарим эргэцүүлэл

“Шагналын тогтолцоо”, “шагналын систем” гэж бид бүхний нэрлээд байгаа тэр зүйл маань яг бүлэглээд төрөлжүүлээд, бүртгээд тоолоод ирэхийн цагт, дотроо [нилээн тийм] эмх цэгцгүй, зүй тогтолгүй, хэтрүүлж хэлэхэд “ямар ч системгүй” байгаа нь анзаарагдав.

Нийгэм түүхийн урсгал дунд, цаг үеийн тулгамдсан шаардлагын дагуу “олон төрийн нүүрэн дээр” бий болсон үе үеийн баахан шагналыг хүмүүс янз бүрийн төвшинд өөр өөрийнхөөрөө ангилж гэж нилээн зүтгэсэн ч нэгдмэл нэг ойлголтонд хүрээгүй байна. Бидний энэхүү лавлагаа мэдээллээрээ тэдгээрийг аль болохоор зөв эрэмблэх, хороолол дарааллаар төрөлжүүлэн системчлэх, одоо мөрдөж байгаа болон хүчингүй болсноор нь бүлэглэх, төрөл зүйлийн дотоод хувирал хувьсал, хөгжил хөдөлгөөнийг харуулах, цаашид хэрэглэгдэх боломжийг тодруулахыг хичээсэн болно.

1. Хууль тогтоомжид заасан тухай тухайн шагналын тодорхойлолт, нэр томъёонууд нь ихээхэн эргэлзээтэй, үеэ өнгөрөөсөн, хоцрогдсон, бусадтайгаа авцалдаагүй тул шууд таблиц зохиогоод схемчлээд авах бололцоо хялбархан олдохгүй байгаа болтой юм. Ийм байдалд хүргэсэн саад бэрхшээл олон байна. Жишээ нь,
 - a. Төрөөс олгодог бүх одон медаль цол шагналынхаа дотроос нэгийг нь нэр зааж онцлонгуутаа “энэ бол төрийн шагнал” (государственная премия) гээд ялгаад гаргаад ирэхээр, төрөөс олгодог бусад олон шагналын нэр хүндэд “хохирол учирчирчихдаг” гэж үзэж болохоор байна. Улсын Ерөнхийлөгчийн олгодог хамгийн том шан – “төрийн шагнал” өөрөө цол, одон, тэмдэгийн алин болох нь тодорхойгүй байна.
 - b. Манайхан, шагнал урамшил олгох хэрэгжүүлэлтийн шатны баримт бичиг (дүрэм, журам, анкет, бүртгэл) –тээ [дээрээс олгодог] бүх шан, цол, одон, медалийг “төрийн дээд шагнал” гэж бичиж тэмдэглэж ирсэн байна. Энэ нь нийтийн ухамсрын түвшинд ойлгомжгүй байдал үүсгэжээ. Жишээлбэл, одонгоос эрэмбэ дээгүүр том цол авсан хүн үүнийгээ илтгэх “тэмдэг” –тэй явдаг бол, одонгүй хүн медаль зүүчих жишээний. Одон медаль гэсэн хэвшмэл ойлголтын хүрээнд “тэмдэг” –ийн орон зай тод сайн харагдахгүй байна. Эцсийн эцэст, шагнал бол “танигдах зүүлтээрээ” эрэмблэгддэг. Тэгэхээр зүүлт тэмдэгийг ч мөн дотор нь сайн эрэмблэх ... ядаж нэрийг нь цэгцлэх шаардлагатай байна. Орчин цагийн монгол шагналын түүхэнд одонгоос дутахгүй медаль ч байж, медалиас илүү

тэмдэг ч байж.

- c. Улсын сан хөмрөг ядмаг явж ирсэнтэй холбогдоод томоохон шагналд дагуулж өгөх зоос мөнгөний асуудал [дээгүүрээ] их том “зовлон удаж” байсан нь илт харагдаж байна. Энэ байдлаас үүсэлтэй гэмээр нэг сонин “тогтолцоо” бол, манайд, “шагнал дотор шагнал цохиж явдаг” гэж явдал юм. Улсын баатар хүн цолноосоо гадна, “улсын баатрын алтан таван хошуу” тэмдэг, Сүхбаатарын одонг зэрэг зэрэг авна. Хөдөлмөрийн баатар ч мөн ялгаагүй “хөдөлмөрийн баатрын алтан соёмбо” тэмдэг дээрээ нэмээд Сүхбаатарын одонгоо гардаж авна. Дээд эрэмбийн том шан “баахан шагналын нийлбэр” маягтай харагдах эрсдэл ил байна. Энд бас, “нэг гавъяаг нэг шангаар мялаах зарчим” ч зөрчигдөж байна.
 - d. Мэргэжлийн нэр (сансрын нисэгч) –ийг хүртэл улсын цол (шагнал) гээд бүртгээд авчихсан нь тун зохимжгүй арга хэмжээ болсон байна. Ниссэн хүн нь, угаасаа, улсаас цол шагнасан шагнаагүй “сансрын нисэгч” байна гэдэгт эргэлзэх явдалгүй юм.
 - e. 1912 оны Эрдэнийн очир одонг 1991 онд сэргээсэн гэдэг эргэлзээтэй байна. Эрдэнийн очир одон жинхэнэ утгаараа сэргээсэн бол түүний дотор багтаж байсан (тэргүүн зэргийн) Чингэсийн одон хэрэглээнд орсон байх учиртай. Гэтэл үгүй байна. Ийм байгаатай шууд холбон авч үзэж болох нотолгоо бол УИХ –аас “Чингисийн одон” –г 2002 онд дахин шинээр бий болгосон явдал юм.
 - f. Богд хаант Монгол Улсын үед бий болгосон Эрдэнийн очир одон бол **зөвхөн 1 нэр бүхий одон байгаагүй**, бүхэл бүтэн одонгийн багц ... шагналын [тэрүүхэндээ] цомхон цэгцтэй тогтолцоо байсан байна.
2. Социализмын үед нам – засаг бий болгосон зарим шагналаа хэнд ч өгөлгүй 10 хүртэл жил хав дарсан тохиолдол нэгбус гарч байж. Энэ нь, захиргаадальтын хаалттай нийгэмд, дороос, тэдгээрийг авна гэж нэхэж шаардах нь нэн ховор байсантай холбоотой байх;
 3. Улсаас олгодог шан харамжийн тогтолцоог бүхэлд нь эргэж харах сонирхол шаардлага тал талдаа нэгэнт бий болсон өнөө үед холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх “үндсэн зарчим” –уудаа эхлээд тодорхойлох нь зөв болов уу. Ялангуяа, шагнал түгээлтийг хэрэгжүүлэхдээ, тогтсон тодорхой зарчим шалгуур баримтлахгүй бол эцэс сүүлдээ тодорхой цөөн эрх мэдэлтний үзэмжийн, дур зоргын асуудал болж гажууддаг гашуун туршлага бэлэн байна. Тэгэхээр, энд ч мөн зарчим хэрэгтэй ажээ.
- Хуучин ЗХУ –аас бид шагналынх тогтолцоог бүхэлд хуулж, өөриймшүүлэн нутагшуулжээ. Тэнд, нэг балетчин бүсгүй 4 удаа төрийн шагнал, 7 удаа Лениний одон авах ... энэ тэр бол жирийн үзэгдэл байлаа. Манайхан гавъяат тамирчин бөгөөд гавъяат дасгалжуулагч хүндээ “ардын багш”, “хөдөлмөрийн баатар” цол олгож байгаа нь саяын дурдсан жишээтэй агаар ижил юм. Хичнээн зөв сайхан одон шагнал байлаа ч түүнийг хуучин зуршлаараа “буруу” хэрэглэх аваас ач тус нь илэрч гарахгүй.
4. Засаглалын салаа мөчрийн гол гол байгууллагын ажилтнууд харилцан бие биенээ (яам газрын салбарын тэргүүн цол тэмдгээр урамшуулах ... гэх мэт) шагнах ёсон олон жил үйлчилсээр ирэв. Жишээ нь, шүүх, прокурорын ажилтныг төрийн болон гүйцэтгэх эрх мэдлийн ямар нэгэн шагналаар шагнах нь засаглал хуваарилалтын зарчимд ноцтой хохирол учруулдаг гэх; үндэслэлийг ч гаргаж тавьж болохоор байна.
 5. Улсаас олгож байгаа хамгийн том, хамгийн нэр хүндтэй, хамгийн бодитой “мөнгөн шан” –г Засгийн газрын шугамаар түүгээрээ олгож, түүнийг тамирчин голцуу хүмүүс авчихаж байгаа нь зохимжгүй юм. Энэ мэт мөнгөн шагналаа цол ба одон тэмдэгтэйгээ уяж өгөх асуудлыг судалж үзэх хэрэгтэй мэт.

Гэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчөөс олгож байгаа цол одон медалийг мөнгө дагах нь зөв үү гэдгийг сайн тунгаан бодох хэрэгтэй юм. Зарим оронд мөнгө дагалддаг

байхад зарим улсад тухайлбал, японд эсрэгээр, мөнгө өгдөггүй. Үүнийг тэнд Үндсэн хуулиараа хориглосон байдаг байна. Учир нь, одон өөрөө маш их үнэ цэнэтэй хүндэтгэл учир түүнийг мөнгөөр үнэлж болохгүй гэж үздэг ажээ.

6. Одон шагналын тогтолцоог бүхэлд нь эргэн харж өөрчлөн шинэчлэхдээ, юуны өмнө, ирээдүйд хүчин төгөлдөр үйлчлэх тэр шагналуудаа дотор нь зөв эрэмблэн схемчилж ... шаталсан зөв дараалалд оруулах нь нэн чухал юм байна. Ингэхгүйгээр, хожим, шагналын системийнхээ чухам хаана нь орших нь мэдэгдэхгүй одон шагналууд цаг хугацааны уртад [олноор дахиад] гараад боломж нээлттэй хэвээр үлдэх магадлалтай.
7. Урьд өмнийн (одоогийн) **хөдөлмөрийн үнэлгээний** агуулгаар өгч байсан одон медалиас зоригтой түргэн татгалзаж, улмаар, хүндэтгэлийн одон медаль руу шийдвэртэй шилжих нь өнөөгийн нийгмийн нэг чухал тулгамдсан асуудал болсон байна.

ГУРАВ. БУСАД ОРНУУДЫН ТӨРИЙН ОДОН, МЕДАЛИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

3.1. Бүгд Найрамдах Турк Улсын төрийн шагналын систем, онцлог

Турк Улс нь төрийн одон, медалиг Медаль болон Одонгийн хууль /Хуулийн № 2933, Баталсан огноо: 1983.10.24/, Төрийн медаль болон одонгийн журмаар тус тус зохицуулдаг байна. Төрийн одон, медалиг зохион байгуулах ёслолын арга хэмжээгээр Ерөнхийлөгч, эсхүл түүний томилсон төлөөний этгээд гардуулдаг. Хэрэв шагнагдагч нас барсан бол түүний хамгийн том хүүд нь, хүү байхгүй бол охинд нь, хүүхэд байхгүй бол эцэгт нь, эцэг нь байхгүй бол ээжид нь, ээж нь байхгүй бол эхнэрт нь олгодог.

Төрийн одон, медальтай холбоотой бүх зардлыг ерөнхий сайдын төсвөөс гаргадаг ба шагналын бүртгэлийн асуудлыг Ерөнхий сайдын Боловсон хүчний ерөнхий захирлын ажлын алба хариуцдаг байна. Тус албанд шагналд нэр дэвшигчийн тодорхойлолт, төрийн байгууллагын уламжилсан санал, бусад мэдээллийг ирүүлдэг.

Төрийн одон, медаль авах Турк Улсын иргэдийн жагсаалтыг жил бүрийн 10 дугаар сарын 29-нд Ерөнхий сайдын ажлын албанаас мэдэгддэг бөгөөд тус мэдэгдэлд шагналыг хэзээ, хаана гардуулахыг товлон заадаг. Ерөнхийлөгчийн өөрийн гардуулах медаль болон одонг Ерөнхийлөгчийн Тамгын газар тогтоодог ба энэхүү ёслолын протоколыг Гадаад хэргийн яам хөтөлдөг.

Төрийн албан хаагчдад гадаад орны төрийн одон, медаль олгох тохиолдолд Турк Улсын зохих байгууллагын зөвшөөрөл авдаг байна. Төрийн албан хаагч бус Турк Улсын иргэн гадаадын төрийн одон, медаль авахад зөвшөөрөл шаардлагагүй бөгөөд харин гадаадын одон, медалиг Ерөнхий сайдын Боловсон хүчний ерөнхий захирлын ажлын албанд бүртгүүлснээр зүүх эрхтэй байдаг байна. Төрийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн улмаас шүүхээр шийтгүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэрт төрийн одон, медалиг эгүүлэн авахыг заадаг байна.

Дараахь эрх бүхий этгээд, байгууллага төрийн одон, медальд нэр дэвшүүлэх эрхтэй. Үүнд:

- Туркийн Үндэсний Их Хурлын дарга,
- Ерөнхий сайд,
- Туркийн Зэвсэгт хүчний жанжин штабын дарга,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл,

- Хууль зүйн ямаар дамжуулан Шүүхийн дээд ерөнхий хороо,
- Туркийн Үндэсний Их Хурлын даргаар уламжилан Төрийн аудитын дарга,
- Гадаад хэргийн ямаар уламжилан элчин сайдтай дүйцэх гадаадын төлөөлөгчид,
- холбогдох ямаар уламжилан төрийн байгууллага.

Харин Турк Улсын хууль тогтоох байгууллага болох Туркийн Үндэсний Их Хурлаас хүндэтгэлийн болон онц зүтгэлтэн шагнал гэсэн хоёр шагналыг олгодог байна. Туркийн Үндэсний Их Хурлын “Хүндэтгэлийн шагнал”-ыг жилд нэг удаа нэг хүнд уг шагналыг олгодог бөгөөд шагналд нэр дэвшигчид өөрсдийнхөө холбогдох материалыг шагналын тухай зарыг Туркийн Үндэсний Их Хурлын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлахад нь өөрийн биеээр болон шуудангаар хүргэдэг. Нэр дэвшигчдийн материалыг хүлээн авсны дараа Туркийн Үндэсний Их Хурлын Соёл, Урлаг болон Хэвлэлийн хороо урьдчилан сонгон шалгаруулалт хийгээд Туркийн Үндэсний Их Хурлын даргын ажлын албанд хүргүүлдэг.

Туркийн Үндэсний Их Хурлын “Хүндэтгэлийн шагнал”-ыг жил бүрийн 4 дүгээр сарын 23-ны өдрийн Үндэсний засаг ба Хүүхдийн баярыг тэмдэглэх долоо хоногт Туркийн Үндэсний Их Хурлаас зохион байгуулдаг ёслолд Туркийн Үндэсний Их Хурлын дарга олгодог байна. Туркийн Үндэсний Их Хурлын “Онц зүтгэлтэн” шагнал хувьд олгох цаг хугацаа, тооны ямар нэгэн хязгаарлалт байдаггүй. Уг шагналд нэр дэвшигчдийг Хотын захирагч, Дүүргийн захирагч, эсхүл Засаг даргын саналаар мужийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтооно.

Шагналыг Туркийн Үндэсний Их Хурлын Соёл, Урлаг болон Хэвлэлийн хорооны тогтоосон хугацаанд зохион байгуулах арга хэмжээнд Туркийн Үндэсний Их Хурлын дарга олгодог. “Биеийн тамир болон онц зүтгэл гаргагчдыг шагнах тухай” журмын дагуу дотоодын болон олон улсын биеийн тамирын уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчид, тэдгээрийн клуб, дасгалжуулагч, амжилт гаргахад хөдөлмөр нь оролцсон бусад этгээдэд олгодог. Энэхүү шагнал нь мөнгөн буюу эд хөрөнгийн хэлбэрээр олгодог бөгөөд тэмцээнд оролцогчдод хийсэн допингийн дүн гарахаас өмнө шагнал олгодоггүй. Мөн уралдаан тэмцээний дүнгээс шагнал авах клуб, шагнал авах амжилт гаргасан тамирчин уралдаан тэмцээн эхлэхээс хамгийн багадаа 6 сарын өмнө тус клубд бүртгэгдсэн байх ёстой байна. Шагналыг биеийн тамирын нийгэмлэгийн даргын санал, шагналыг үнэлэх комиссын санал, Залуучууд болон Бие тамирын ерөнхий хорооны даргын шийдвэрээр олгодог байна.

3.2. Их Британи, ХБНГУ, АНУ-ын төрийн шагналын системийн тойм

Их Британи Улсын хувьд одон, медаль, цол нь нэлээд уламжлагдан ирсэн хэдэн зуун жилийн түүхтэй, тэдгээрийг тусгай комиссийн шийдвэрийг үндэслэн Хатан хаан олгодог. Тухайлбал, Гартерийн хамгийн дээд одонг Эзэн хаан, Хатаны гэр бүл, Уэлсийн хунтайж болон бусад 24-өөс илүүгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс олгохоор шийдвэрлэдэг бөгөөд Англи, Уэлсд 1348 оноос уг шагналыг олгож эхэлсэн байна.

Их Британи Улсад төрийн одон, медаль, хэргэм цолыг дагалдан хэдий хэр хэмжээний мөнгөн урамшуулал олгодог талаархи мэдээлэл хомс ч Викторийн загалмайг дагалдаж жилд 1495 фунт стерлингийн тэтгэлэг олгодог бөгөөд тус загалмайг батлан хамгаалах салбарт байгуулсан гавьяаг үнэлэн олгодог, энэ салбарын хамгийн дээд одон юм. Уг одонг 1856 оноос эхлэн олгож байгаа бөгөөд нийт 1356 хүнд олгосон байна.

Харин Британий эзэнт гүрний сүр жавхлант дээд одонг Британийн эзэнт гүрний медаль дагалддаг /The British Empire Medal/ бөгөөд шагнал хүртэгсэд өөрийн нэрний урд “Sir”-эр, “Dame”-эм цол авах эрхтэй болдог. Уг шагналыг нийгмийн бүх салбарынханд (нийгэм ба

батлан хамгаалах салбарынханд голлон) 1917 оноос эхлэн олгож байгаа юм байна. Их Британи Улс нь эзэн хаант улс тул уламжлагдан ирсэн хэргэм, цол, одон, медальтай бөгөөд хэргэм, цолыг ихэвчилэн удам дамжуулдаг ба язгууртнуудад олгодог уламжлалтай.

Герман Улсын хувьд Дэлхийн II дайны дараагаар одон, медаль, цолыг шинэчилэн олгох болсон байна. Нэр цол, одон, алдарын тухай хууль болон холбогдох тогтоомжоор ХБНГУ-ын төрийн одон, медалийг зохицуулсан бөгөөд улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны салбарт өндөр амжилт гаргасан, ХБНГУ-ыг энхийн замаар хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүнд Гавьяаны одонг олгодог. Гавьяаны одонг анх ХБНГерман Улсын Ерөнхийлөгч Теодор Хеусс 1951 онд бий болгосон байна. Уг шагналд дараахь эрх бүхий этгээд санал гарган нэр дэвшүүлнэ. Үүнд:

- Мужын захиргаа
- Гадаад Харилцааны Яам
- Холбооны сайд
- Албан газрууд
- Аж ахуйн болон спортын холбоод санал гаргах эрхтэй.

Герман Улсад төрийн одон, медалийг Ерөнхийлөгч олгодог байна. Герман Улсын Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд гадаадын гурван улсын төрийн тэргүүн, түүний гэргийд “Дээд зэрэглэлийн агуу загалмай” олгох эрхтэй байдаг байна. Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс хуучин социалист дэглэмийн хүрээнд нэлээд олон төрлийн төрийн одон, медаль, цол гавьяатай байсан ба хоёр Герман нэгдснээс хойш Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн одон, медаль, цолны хууль тогтоомж үйлчлэх болсон байна.

Герман Улсын төрийн одон, медаль нь Хар бүргэдийн зураг бүхий дугуйг загалмай дээр байршуулсан хэлбэртэй байдаг байна. Статистик тоогоор Герман Улсын Гавьяаны одонгоор нийт 1951 оноос хойш өнөөг хүртэл 210.000 хүн шагнуулсан байна. Харин 1990-2007 оны хооронд:

	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
1990	642	3343	4085
1991	795	4301	5096
1992	591	3425	4016
1993	714	3546	4260
1994	726	3400	4126
1995	750	3375	4125
1996	727	2777	3504
1997	833	3015	3848
1998	801	2926	3727
1999	799	2885	3684
2000	718	2604	3322
2001	706	2550	3256

2002	829	2527	3356
2003	754	2536	3290
2004	797	2650	3447
2005	625	1883	2508
2006	563	1749	2312
2007	733	684	2417

* * *

Хоёр Герман Улс нэгдснээс хойш Ардчилсан Герман Улсын шагналын системийг хэрэгсэхгүй болгож Холбооны Герман Улсын шагналын системийг голчлон хэрэглэх болсон байна. ХБНГерман Улсын одон, медаль нь эрэгтэй, эмэгтэй хүнийхээр хэмжээ болон хэлбэрийн хувьд ялгаатай байдаг байна.

Германы одон, медаль болох загалмайг ихээхэн олгодог байна. Тухайлбал, 1914 оноос Төмөр загалмай, Дайны гавьяаны загалмай. Мөн Герман Улсын бусад төрийн шагнал зэрэг нь Германы шагналын тогтолцооны нэг хэсгийг бүрдүүлдэг байна. Загалмай нь дотроо зэргээр ангиллагддаг байна. Тухайлбал, нэгдүгээр зэргийн төмөр загалмай гэх мэт. Герман Улсад төрийн шагнал авсан этгээд нэг жилээс дээш хугацааны ялтай гэмт хэрэг үйлдсэн, эсхүл эх орноосоо уравсан, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн зэрэг нь шүүхийн шийдвэрээр тогтоогдвол төрөөс олгодог шагналыг эргүүлэн авдаг байна.

Америкийн Нэгдсэн Улсын төрийн шагналын систем нь нэгдсэн улсын болон муж улсын гэсэн онцлогтой бөгөөд судалгаанд Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч болон төрийн дээд байгууллага болох Конгрессоос олгодог шагналыг товчлон сийрүүлэн судалсан болно. Америкийн нэгдсэн улсын Ерөнхийлөгчийн албанаас олгодог шагнал, одон, медалиудыг сийрүүлбэл:

Ерөнхийлөгчийн Эрх чөлөөний медаль

- Энэхүү медалийг АНУ-ын Ерөнхийлөгч олгодог бөгөөд Конгрессийн алтан медальтай дүйцдэг. Энэ медаль нь цэргийн бус, иргэдэд олгодог дээд шагнал юм. Гэхдээ цэргийнхэнд ч бас олгодог байна. Тус медалийг АНУ-ын аюулгүй байдал, дэлхийн энх тайвны төлөө, соёл болон бусад чухал ач холбогдолтой нийтийн болон хувийн хүчин чармайлтаар улс үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан онцгой гавьяанд олгодог байна. Уг шагналыг 1945 онд Ерөнхийлөгч Ханри С.Труман энгийн иргэдийн бахархал, гавьяаг үнэлэх үүднээс анх бий болгосон.

Ерөнхийлөгчийн Иргэний медаль

- Энэхүү медаль АНУ-ын Ерөнхийлөгчийн олгодог хамгийн дээд шагналын хоёрдахь шагнал юм. Уг меадлийг Ерөнхийлөгч олгодог бөгөөд өөрийн улс орныхоо эсхүл иргэдэд үлгэр ажил болон үйлчилгээ үзүүлсэн иргэдэд олгодог. Иргэний нас барсны дараа хүртэл олгож болдог.

Нийтийн аюулгүй байдлын албан хаагчийн эр зоргийн медаль

- Уг медалийг АНУ-ын нийтийн аюулгүй байдлыг хариуцсан албан хаагчид баатарлаг үйлсийнх нь төлөө олгодог. Үүнийг АНУ-ын Цэргийн дээд шагналын нэг болох Хүндэтгэлийн медальтай адилтгаж болно. 2001 оны 5 дугаар сарын 30-ны өдөр бий болгосон шагнал бөгөөд АНУ-ын Ерөнхийлөгч АНУ-ын Конгрессийн нэрийн өмнөөс нийтийн аюулгүй байдлын албан хаагчдад /цагдаа, гал сөнөөгч, гэх мэт/ Ерөнхий

прокурорын тодорхойлсноор Эр зоргийн медалийн шалгах хорооноос тогтооно. Медалийн нас барсны дараа ч олгож болдог.

Холбооны Иргэний албаны алдартанд олгодог ерөнхийлөгчийн шагнал

- 1957 онд Ерөнхийлөгч Двайт Д.Ейзэнхвэр бий болгосон. Холбооны засгийн газар болон төрийн албан тушаалд хичээл зүтгэл гаргаж олон жил ажилласан хүнд олгодог байна.

Математик болон Байгалийн шинжлэх ухааны хичээл заагчийн ур чадварын

Ерөнхийлөгчийн шагнал

- Бага болон ахлах 12 дугаар ангид математик болон байгалийн шинжлэх ухааны хичээл заадаг ур чадвартай багшид олгодог. 1983 онд уг шагналыг конгресс бий болгосон бөгөөд жилд 108 багшид олгодог. Шагналд нэр дэвшигч нь улсын болон хувийн бага, дунд, ахлах сургуулийн цагаар биш, байнга ажиллаж байх ёстой бөгөөд 5 жилийн математик, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр багшилсан туршлагатай багш байх ба өмнө нь уг шагналыг авч байгаагүй хүн байна. Мөн түүнчлэн АНУ-ын Ерөнхийлөгчийн албанаас **Холбооны энергийн менежментийн удирдагчийн Ерөнхийлөгчийн шагнал, Ерөнхийлөгчийн хамгаалалтын шагнал, Ерөнхийлөгчийн залуу байгаль орчны** шагнал зэрэг шагналыг олгодог байна.

АНУ-ын Конгрессийн шагналыг дурдвал:

Конгрессийн алтан медаль

- АНУ-ын Конгрессоос олгодог байна. Уг шагнал нь Ерөнхийлөгчийн эрх чөлөөний медальтай дүйцэхүйц иргэний дээд шагнал юм. АНУ-ын аюулгүй байдалд онцгой гавъяа байгуулсан, улсын эрх ашгийг хамгаалж хангалуун сайхан байхад хүчин зүтгэсэн хүнд олгодог бөгөөд шагналд нэр дэвшигч нь АНУ-ын иргэн байх албагүй. Шагналыг ямар нэг гавъяа, бодит явдал зэргийг тохиолдуулан олгодог бөгөөд анхандаа жүжигчин, зохиолч, нисгэгч, хамгаалагч, хөгжимчин зэрэг байсныг дараа нь өргөн хүрээтэй болгож тамирчин, хүмүүнлэгийн үйлстэн, төрийн албан хаагч гадаадын иргэн, ангаах ухааны салбар зэрэгт гавъяа байгуулсан хүнд олгодог болсон байна.

Конгрессийн мөнгөн медаль

- Холбогдох мэдээлэл байхгүй

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Бидний авч үзсэн посткоммунист орнуудын төрийн шагналын систем нь 1990-ээд оноос хойш бүхэлдээ өөрчлөгдөн шинэчлэгдсэн байна. Одон, медалийн хувьд хуучин социализмын үеийн шагналыг халж, өөрийн түүхийн онцлог үеийн одонгуудыг сэргээсэн байна. Төрийн хүндэт цолны хувьд ОХУ⁴-аас бусад орнуудад энэ цолыг цөөлсөн болон хүчингүй болгосон байна. БНКАЗУ-д Ардын баатар, Казахстаны гавъяат зүтгэлтэн, Казахстаны сансрын нисгэгч цолыг 1993 онд бий болгосон. БНПУ, БНЧУ-д хүндэт цол үгүй байна. Социализмын үеийн одон, медаль, хүндэт цолыг төрийн шагнал болгон хэвээр нь үлдээсэн улс алга байна.

⁴ Трофимов.Е.В Правовое регулирование государственных наград в РФ, автореферат диссертации на соискание ученой степени кандидата юридических наук, М., 2006 г.

- Төрийн шагналтнуудын статус, тэдэнд үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын хувьд БНКАЗУ-д 90-ээд оны эцсээр, ОХУ 2004 онд бүхэлдээ төрөөс үзүүлдэг хөнгөлөлт, тэтгэмжийн тогтолцоогоо шинэчлэн монетизаци буюу мөнгөн хэлбэрээр үзүүлэх тогтолцоонд шилжсэн байна. Тухайлбал, хуулийн дагуу хуучин ЗХУ-ын Баатар, ОХУ-ын Баатар, Алдрын одонтнууд, Хөдөлмөрийн алдрын одонтнууд болон хэрэв эдгээр шагналтнууд нас нөхцсөн бол тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг эх, гэр бүлийн гишүүд нь байр, орон сууцны /түүн дотор техникийн ба ашиглалтын үйлчилгээ/ төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөх буюу эсхүл сар бүр ЗХУ-ын Баатар, ОХУ-ын Баатар, Алдрын одонтнууд 25000 рублийн мөнгөн төлбөр, Социалист хөдөлмөрийн Баатар, Хөдөлмөрийн алдар одонтнууд сар бүр 20000 рублийн мөнгөн төлбөр авч болно.
- Эдгээр орнуудын төрийн шагналын системд олон хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийг бэхжүүлэх үйлсийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн хандлага байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, ОХУ-д энэ зорилгоор “Эцэг, эхийн алдрын” одон, БНКАЗУ-д олон хүүхэдтэй эхчүүдэд олгодог “Алтан, Мөнгөн унжлага, БНПУ-д “Удаан жил хамт амьдарсны төлөө” медаль зэрэг шагналыг олгож байна.
- Өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд төрийн шагналын системд нь төрийн хүндэтгэл, бахархалыг бэлэгдсэн, улс орны өмнө байгуулсан гавъяа, нийгмийн салбарт удаан жил, үр бүтээлтэй ажиллагсад, гадаад харилцаанд гавъяа байгуулсан дипломатууд, дайны баатрууд, цэргийнхэнд олгодог одон, медалиуд гол байр суурийг эзэлж байна.
- Улс орон бүр өөр өөрийн онцлог, төрийн удирдлагын хэлбэрийг харгалзан төрөөс олгодог шагналын системийг эрх зүйн хувьд зохицуулсан хэдий ч ихэнх улс оронд эл харилцааг хуулиар зохицуулан төрөөс олгодог шагналуудаас аль нь тухайн улсын төрийн дээд шагнал болохыг тодорхойлон, төрийн одон, медаль, хүндэт цолны төрөл хэлбэр, статус, хэнд, юуны төлөө олгох, бүртгэх, хэрхэн зүүх, эргүүлэн авах, эрхийг сэргээх, ямар хүндэтгэл хүлээх, урамшуулал, хөнгөлөлт эдлэх зэрэг олон талт харилцааг зохицуулсан байна.
- Монгол Улсын төрийн шагналын систем нь 1990-ээд оноос өмнөх үе буюу социализмын үеийнхээрээ бараг хэвээр үлдсэн бөгөөд эрх зүйн зохицуулалтын хувьд ч хангалтгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Тухайлбал, төрийн одонгийн тухайд 1991 онд УБХ-ын 62 дугаар тогтоолоор “Эрдэнийн очир” одонг сэргээсэн, 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын 21 дүгээр тогтоолоор “Чингис хаан” одонг шинээр бий болгосноос бусад бүх одонгууд, 2009 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн УИХ-ын 89 дүгээр тогтоолоор баталсан “Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль”-иас бусад бүх медаль, 2001 онд УИХ-ын тогтоолоор баталж, бий болгосон “Гавъяат малчин”, “Байгаль орчны гавъяат ажилтан” цолноос бусад бүх хүндэт цол социализмын үед тухайн үеийн АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар бий болсон байна.
- Улсын цол, одон медаль, цэргийн дээд цол бий болгох, ... зэрэг дэвийг тогтоох нь Улсын Их Хурлын бүрэн эрх боловч УИХ уг бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаа нь хангалттай бус бөгөөд төрийн одон, медалийн нэгдсэн нэгдмэл эрх зүйн зохицуулалт хангалттай бус байна. УИХ өнөөг хүртэл нэгдсэн байдлаар төрийн одон, медаль, хүндэт цолны жагсаалтыг албан ёсоор гаргаагүй бөгөөд хуучин социализмын үед олгож байсан ихэнх одон медаль, хүндэт цол хэвээр байгааг дээр дурьдсан.
- Өнөөдөр манай улсад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 71 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах” журмаар төрийн шагналын харилцааг зохицуулж байна. Уг журам нь Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх зэрэг харилцааг зохицуулсан. Гэсэн хэдий ч төрийн шагналыг эргүүлэн авах, эрхийг сэргээх, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, хууран мэхлэх аргаар шагнал авсан тохиолдолд үүсэх харилцааг эрх зүйн хувьд зохицуулах механизм тусгалаа олоогүй байна.

9. Төрийн одон, медаль, хүндэт цолоор шагнагдсан иргэдэд үзүүлэх урамшуулал, хөнгөлөлт, нэмэлтийн хувьд манайд зөвхөн Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон өндөр настанд төрөөс олгох нэмэлт, үзүүлэх хөнгөлөлт, мөнгөн тусламжийг “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хууль, бусад эрх зүйн баримт бичгээр тогтоосон байна. Бусад төрийн одон, медаль, шагнал хүртсэн хүмүүсийн хувьд ялангуяа нэмэлт, мөнгөн олговор өгөх талаар зохицуулсан зүйл үгүй байгаа нь тус төрийн шагнал болон шагнагдагсдын нэр, хүнд, статусыг өндөрт өргөхөд саад болж байна.
10. Монгол Улс төрт ёсны арвин баялаг түүхтэйгээ бодолцож, XIII зууны үеийн Монголын их эзэнт гүрний үеийн уламжлалт шан шагналыг зарчмын үүднээс тухайлан сонирхож үзсэн болно. Басхүү, шинэ түүхийн босгон дээрх Богд хаант Монгол Улсын одон шагналын туршлагыг ч анхаарч авч үзлээ. Тэдгээрийг энэхүү судалгааныхаа тусгай дэд бүлэг болгон оруулж санал дүгнэлтийг тэнд нь тусгав. Мөн, (орчин цагийн) Монгол Улсын одон шагналын тогтолцооны дотоод бүрдэл хэсгүүдийг хүчинтэй эсэхээс нь үл хамааруулан нэгбүрчлэн “тоолж”, хоронолог дараалалд оруулан жагсаах замаар өнөөгийн баримталж ирсэн одон шагналын системийн хөгжил хөдөлгөөн хувирал хувьсалыг харуулахыг хичээв. Үүнд холбогдох санал дүгнэлтийг тухайн дэд бүлэг өөртөө агуулсан болохоор тэдгээрийг ерөнхий дүгнэлтэд дурдаагүй болно.



Хавсралт 1.

ОХУ-ын төрийн шагналууд⁵

№	Шагналын нэр	Эрх зүйн баримт бичиг
1.	ОХУ-ын Баатар	ОХУ -ын Хууль, 1992 оны 3 дугаар сарын 20. № 2553 - I
2.	Одон ба медалиуд: <ul style="list-style-type: none"> • Ариун айлдагч Андрей Первозванного одон /орден Святого апостола Андрея Первозванного/ • Эх орны өмнө байгуулсан гавъяаны төлөө одон /орден “За заслуги перед Отечеством”/ • Жуковын одон /орден Жукова/ • Эр зоригийн одон /орден Мужества/ • “Дайнд байгуулсан гавъяаны төлөө” одон /орден “За военные заслуги” / • Хүндэтгэлийн одон /орден Почета/ • Найрамдлын одон /орден Дружбы/ • “Эцэг, эхийн алдрын” одон /орден Родительская слава/ • Онцгой шалгарсны тэмдэг-Алтан од медаль /знак особого отличия - медаль “Золотая Звезда”/ • Эх орны өмнө байгуулсан гавъяаны төлөө одонгийн медаль /медаль ордена “За заслуги перед Отечеством”/ • Чин зоригийн медаль /медаль “За отвагу”/ • “Чөлөөт Оросын хамгаалагчид” медаль /медаль “Защитнику свободной России” / • “Хүний амь аварсны төлөө” медаль /медаль “За спасение погибавших”/ • Суворовын медаль /медаль Суворова/ • Ушаковын медаль /медаль Ушакова/ • “Нестеровын” медаль /медаль Нестерова/ • Пушкины медаль /медаль Пушкина/ • “Улсын хилийг онц хамгаалсны төлөө” медаль / “За отличие в охране государственной границы”/ • “Нийгмийн хэв журмыг онц хамгаалсны төлөө” медаль /медаль “За отличие в охране общественного порядка”/ • 1941-1945 оны Эх орны Агуу их дайнд ялсаны 50 жилийн ойн медаль /юбилейная медаль “50 лет Победы в Великой Отечественной войне 1941 - 1945 гг.”/ • Жуковын медаль /медаль Жукова/ • Оросын флотын 300 жилийн ойн медаль /юбилейная медаль “300 лет Российскому флоту”/ • Москвагийн 850 жилийн ойн дурсгалын медаль /медаль “В память 850-летия Москвы”/ • “Албан үүргээ нэр төртэй биелүүлсний төлөө” тэмдэг /знак отличия “За безупречную службу”/ • Ариун Георгийн , Суворовын, Ушаковын, Кутузовын, Александр Невскийн, Нахимовын цэргийн одонгуудыг хэвээр үлдээсэн. 	

⁵ Үүний зэрэгцээ ОХУ-д салбар бүрийг хамарсан нийт 64 хүндэт цол байна.

3.	Төрийн хүндэт цол: <ul style="list-style-type: none"> ОХУ-ын сансрын нисгэгч ОХУ-ын Ардын жүжигчин ОХУ-ын Ардын зураач ОХУ-ын Ардын архитектор ОХУ-ын Ардын багш ОХУ-ын гавъяат агроном ОХУ-ын гавъяат жүжигчин ОХУ-ын гавъяат архитектор ОХУ-ын гавъяат малын эмч ОХУ-ын гавъяат цэргийн нисгэгч ОХУ-ын гавъяат цэргийн мэргэжилтэн ОХУ-ын гавъяат цэргийн штурман ОХУ-ын гавъяат эмч ОХУ-ын гавъяат геологч ОХУ-ын урлагын гавъяат зүтгэлтэн ОХУ-ын шинжлэх ухааны гавъяат ажилтан ОХУ-ын газрын гавъяат зохион байгуулагч ОХУ-ын гавъяат зоотехникч ОХУ-ын гавъяат зохион бүтээгч ОХУ-ын гавъяат ойжуулагч ОХУ-ын гавъяат туршин нисгэгч ОХУ-ын үйлдвэрлэлийн сургалтын гавъяат мастер ОХУ-ын гавъяат машин үйлдвэрлэгч ОХУ-ын гавъяат усжуулагч ОХУ-ын гавъяат металлургч ОХУ-ын гавъяат цаг уурч Заслуженный метролог Российской Федерации ОХУ-ын гавъяат нисгэгч ... зэрэг салбар бүрээр нийт 64 хүндэт цол бий. 	ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1995 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Зарлиг № 1341 (нэмэлт, өөрчлөлт орсон: 1996 оны 1 дүгээр сарын 25., 1997 оны 5 дугаар сарын 28., 1998 оны 3 дугаар сарын 30., 1999 оны 11 дүгээр сарын 21., 2000 оны 3 дугаар сарын 2., 2001 оны 12 дугаар сарын 23.)
----	---	---

БНКаЗУ-ын төрийн шагналууд

№	Шагналын нэр	Эрх зүйн баримт бичиг
1.	Төрийн дээд шагналууд: <ul style="list-style-type: none"> “Алтын Кыран” (Алтан бүргэд) одонгийн Од “Алтын Кыран” (Алтан бүргэд) одон Халык Кахарманы” (Ардын баатар) цол 	<ul style="list-style-type: none"> “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль, 1995.12.12. “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль, 1993.04.01.

2.	Одон: <ul style="list-style-type: none"> “Отан” (Эх орон) одон “Данк” (Алдар) одонгийн Од “Данк” (Алдар) одон, 1,2 дугаар зэрэг “Парасат” (Ариун үйлс) одон “Курмет” (Хүндэтгэл) одон “Алтын алка” шагнал “Кумис алка” шагнал “Айбын” (Гавъяа) одон, 1,2,3 дугаар зэрэг “Достык” (Найрамдал) одонгийн Од “Достык” (Найрамдал) одон, 1,2 дугаар зэрэг “Барыс” (Барс) одонгийн Од “Барыс” (Барс) одон, 1,2,3 дугаар зэрэг Медалиуд: <ul style="list-style-type: none"> “Астана” “Бүгд найрамдах Казахстан Улсын Зэвсэгт хүчний ахмад дайчин” “Албан үүргээ нэр төртэй биелүүлсний төлөө” “Цэргийн гавъяа” “Эр зоригийн төлөө” “Онц хөдөлмөрийн төлөө” “Буяны үйлсийн төлөө” “Цэргийн нөхөрлөлийг бэхжүүлсний төлөө” “Энх төлөө үйлсд оролцсны төлөө” “Бүгд найрамдах Казахстан Улсын Зэвсэгт хүчний 10жил” “Бүгд найрамдах Казахстан Улсын Парламентын 10жил” “Бүгд найрамдах Казахстан Улсын тусгаар тогтнолын 10жил” “Бүгд найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн 10 жил” “1941-1945 оны Эх орны Агуу их дайнд ялсаны 50 жилийн ойн медаль” “Казахстаны төмөр замын 100 жил” “1941-1945 оны Эх орны Агуу их дайнд ялсаны 60 жилийн ойн медаль” “Астаны 10 жил” Хүндэт цол: “Казакстаннын енбек синирген кайраткеры” (Казахстаны гавъяат зүтгэлтэн) “Казакстанын гарышкер-ушкышы” (Казахстаны сансрын нисгэгч) 	<ul style="list-style-type: none"> “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль, 1993.04.01. “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль, 1995.12.12. “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хуульд 1999 онд орсон нэмэлт, өөрчлөлт Ерөнхийлөгчийн Зарлиг, 1998.06.02. Ерөнхийлөгчийн Зарлиг, 2002.05.07. Ерөнхийлөгчийн Зарлиг, 2005.11.07. Ерөнхийлөгчийн Зарлиг, 2001.08.27. Ерөнхийлөгчийн Зарлиг, 2005.04.20. Ерөнхийлөгчийн Зарлиг, 2008.05.06. “Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн шагналын тухай” хууль, 1993.04.01.
----	---	--

БНПУ-ын төрийн шагналууд

№	Шагналын нэр	Эрх зүйн баримт бичиг
1.	Төрийн дээд шагнал: Цагаан бүргэдийн одон (Order Orła Bialego)	“Бүгд Найрамдах Польш Улсын төрийн шагналын тухай” хууль, 1992.10.16.
2.	Одон: <ul style="list-style-type: none"> Гавъяаны одон (Order Zasługi Rzeczypospolitej Polskiej)- нь Эр зоригтны Загалмай (Krzyz Walecznych)-г Гавъяаны сэлэмтэй загалмай одон (Krzyz Zaslugi z Mieczami)- Партизаны загалмай одон (Krzuz Partyzancki) Великопольскийн бослогын загалмай восстания (Wielkopolski Krzyz Powstanczy) Варшавскийн бослогын загалмай (Warszawski Krzyz Powstanczy) Баруунд тулалдсан Польшийн цэргийн загалмай (Krzyz Czynu Wojowego Polskich Sil Zbrojnych na Zachodzie) Фашистын концлагерьт хоригдогсдын загалмай (Krzyz Oswiecimski) “Шуураг” ажиллагааны загалмай (Odznaka pamiatkowa Akcji “Burza”) Медалиуд: <ul style="list-style-type: none"> Медаль “Эр зориг” (Medal Za Ofiarnosc i Odwage) “1939 он” цэргийн медаль (Medal Za Udzial w Wojnie Obronnej 1939) Армийн медаль. 1939 - 1945 (Medal Wojska za Wojne 1939 - 1945) Нисэх хүчний медаль. 1939 - 1945 (Medal Lotniczy za Wojne 1939 - 1945) Усан цэргийн медаль. 1939 - 1945 (Medal Morski za Wojne 1939-1945) Худалдааны усан цэргийн медаль. 1939 - 1945 (Medal Morski Polskiej Marynarki Handlowej za Wojne 1939-1945) “Варшавын төлөө” медаль 1939-1945” (Medal Za Warszawe 1939-1945) “Одра, Нисса, Балтикийн төлөө” медаль (Medal Za Odre, Nyse i Baltyk) “Эрх чөлөө, Ялалтын төлөө” медаль (Medal Zwyciestwa i Wolnosci) “Зэвсэгт хүчин эх орныхоо төлөө” (Medal “Sily Zbrojne w Sluzbie Ojczyzny”) “Удаан жил хамт амьдарсны төлөө” медаль 	<ul style="list-style-type: none"> 1974 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр БНПАУ-ын парламентаар батлагдсан бөгөөд 1991 онд Гуравдугаар Бүгд Найрамдах Улсын шагналын системд статут, тодорхойлолтод нь өөрчлөлт оруулан бүртгэсэн. 1920 онд Польшийн батлан хамгаалах Зөвлөлийн шийдвэрээр батласан ба 1990 онд Польшийн Парламентын шийдвэрээр сэргээсэн байна. “Бүгд Найрамдах Польш Улсын төрийн шагналын тухай” хууль, 1992.10.16. “Бүгд Найрамдах Польш Улсын төрийн шагналын тухай” хууль, 1992.10.16.

* * *

Хавсралт 2.

Ашигласан материал болон Улсын шагнал, одон медалийн өнөөгийн тогтолцоог төгөлдөршүүлэх чиглэлээр хэвлэгдэн гарсан ном товхимол, өгүүлэл нийтлэл, бусад мэдээллийн түүвэр жагсаалт

	Эх сурвалжийн нэр	Нэмэлт тодотгол
1.	Ч. Тамир (МУИС -ийн багш, бодлого судлаач), “Хөдөлмөрийн одон медалиас хүндэтгэлийн одон, нийтлэл, 2009.01.05;	http://www.mongolnews.mn/unuudur.php?n=34220
2.	Ц. Тэрбиш, “БНМАУ -ын одон медаль, алдар цол, түүнийг анх хүртэгчид (50 жилийн түүхэн тойм, 1926 - 1976), УБ, Улсын хэвлэлийн газар, 1977;	
3.	Д. Баярхүү, “Одон тэмдэгт ховсдуул-сан хоёрхон үндэстний нэг нь бид!”, нийтлэл, 2008.02.20;	
4.	Г. Чулуун, “Чихрийн хүүхдийн араншин”, Төрийн соёрхол олгох арга ажиллагааны тухай нийтлэл, Улаанбаатар таймс сонин, 1998,	
	Одон медаль, гавъяа шагналын системийг шинэчлэх тухай, судалгааны материал, 2008; <ul style="list-style-type: none"> http://mashbatotgonbayarsarlagtay.blogspot.com/2008/06/blog-post.html 	Энэ бол гадаад дотоодыг өргөн хүрээний эх сурвалжийг ашиг-лаж бэлтгэсэн, тухайн асуудлыг сонирхогчийн анхааралд өртүүштэй үнэлгээ дүгнэлт ихтэй материал юм. Түүнд ашигласан материалын жагсаалтыг дор үзүүлэв. (Жагсаалтыг товч байлгах үүднээс давхардсан эх сурвалжийн нэрийг хассан болно) Түүнд ашигласан материал <ul style="list-style-type: none"> Academy Award. (n.d.). Retrieved from Wikipedia: http://en.wikipedia.org/wiki/Academy_Award Cross of Honor of the German Mother. (n.d.). Retrieved from Wikipedia: http://en.wikipedia.org/wiki/Cross_of_Honor_of_the_German_Mother Knighthood and Nobility. (1996, 09). Retrieved 04 24, 2008, from Knighthood and Chivalry: http://www.heraldica.org/topics/orders/knights.htm Order of St. Andrew. (n.d.). Retrieved from Wikipedia: http://en.wikipedia.org/wiki/Order_of_St._Andrew Order of the Garter. (n.d.). Retrieved from Wikipedia: http://en.wikipedia.org/wiki/Order_of_the_Garter#The_Order Pulitzer Prize. (n.d.). Retrieved from Wikipedia: http://en.wikipedia.org/wiki/Pulitzer_Prize Purple Heart. (n.d.). Retrieved from http://www.tioh.hqda.pentagon.mil/Awards/PH1.html Saint George's Chapel. (n.d.). Retrieved from Order of the Garter: http://www.stgeorges-windsor.org/history/hist_garter.asp

4.	Д. Баярхүү, “Үхэл тойрох гавъяатын дон”, нийтлэл, 2008.4.24,.	• http://www.oloo.mn/modules.php?name=News&file=art&sid=76845 [6], (2007, 11 17)
5.	БНМАУ -ын цол, одон, медалийн дүрэм, УБ, 1990;	
6.	Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам, хавсралт, 1999;	
7.	Монгол одонгийн үүсэл хөгжил, нийтлэл;	• http://origo.mn/24tsag/2006/01/10/1728
8.	Д. Дэмбэрэл, Нийслэлийн СХД -ийн XVIII хорооны иргэн, “Төрийн хүндэт-гэл түмнээс онцлог баймаарсан”, нийтлэл, 2009.8.21;	• http://www.dandaa.mn/index.php?pageID=78&type=one&msg=one&catID=111&objID=11932
9.	“Төрийн одон медаль, шагнал, жуух”, нийтлэл;	• http://www.human.mn/index.php?module=menu&cmd=content&menu_id=406&start=10
10.	“Ардын хувьсгалын эхний жилүүдэд хэрэглэж байсан одон тэмдэг”, 2006.01.10;	• http://origo.mn/24tsag/2006/01/10/1727
11.	Монгол төрийн шагналуудын тухай, Mongolwiki.-ийн мэдээлэл	• http://wiki.ecm-outsourcing.com/index.php?title=%
12.	Соронзон, “Монгол төрийн одон медалийн түүх”, 1913 – 2008;	• http://soronzon.blogspot.com/search/label/

Хавсралт 3.**БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНИЙН ОЧИР ОДОНГИЙН ТУХАЙ**
(Товч танилцуулга)

Эрдэнийн Очир” одонгийн бичмэл тодорхойлолтоос үзвэл:

1. Тэргүүн зэргийн “Эрдэнийн Очир” одонг гадаад улсын хаад, феодалын дээд хэсгийг шагнахад зориулсан ба дотроо гурван зэрэгтэй. Үүнд:
 - a. Тэргүүн зэргийн нэгдүгээр одон нь мөнгөн дэвсгэр дээр жинхэнэ алтаар үйлдсэн. Одонгийн дунд болон очирт титмийн оройд улаан чулуун шигтгээтэй. Энэ одонг Чингис хааны одон гэж нэрлэж гадаад улсын хаадыг шагнахад зориулжээ.
 - b. Тэргүүн зэргийн хоёрдугаар одон нь одонгийн дунд улаан чулуу очир титмийн дунд шүрэн шигтгээтэй. Энэ одонг “Автай сайн” хааны одон гэж нэрлэж гадаад улсын хаад, тайж, агь вангуудыг шагнахад зориулжээ.
 - c. Тэргүүн зэргийн 3-р одон нь одонгийн дунд улаан чулуу, очир титмийн дунд хээтэй шүрэн шигтгээтэй. Энэ одонг “Өндөр гэгээний” одон гэж нэрлэж байжээ.

Эдгээр одон нь шар өнгийн өргөн тууз оосортой, улаан өнгийн хайрцагтай байв.

2. Дэд зэргийн “Эрдэнийн Очир” одонг мөн феодалын дээд хэсгийг шагнахад зориулсан бөгөөд дотор нь жүн ван, бэйл, бэйс, гүнгийн дөрвөн зэрэгтэй. Үүнд:
 - a. Жюй вангийн зэргийн одон нь хар зэсээр дэвсгэр хийж, алтан шармал одонгийн дунд улаан чулуу, очирын дунд гэрэлтэй хөх чулуу шигтгээтэй.
 - b. Бэйлийн зэргийн одон нь одонгийн дунд улаан чулуу, очирын дунд гэрэлгүй хөх чулуу шигтгээтэй.
 - c. Бэйсийн зэргийн одон нь одон ба очирын дунд хээтэй улаан шүрэн шигтгээтэй.
 - d. Гүнгийн зэргийн одон нь мөн жинсний өнгөтэй адил.
 Эдгээр одон нь улаан өнгийн тууз оосортой ногоон өнгийн хайрцагтай байжээ.
3. Гуравдугаар зэргийн “Эрдэнийн Очир” одонг дотор нь түшмэлийн 5 зэрэг, мөн жинсний өнгөөр ялган нэрлэж байжээ. Үүнд:
 - a. Тэргүүн зэргийн түшмэдийн 1-р одон нь цагаан зэсээр дэвсгэр хийсэн алтан шармал жижгэвтэр очир титэмтэй. Одонгийн дунд хөх чулуу, очирын дунд хээтэй цулгүй шүрэн шигтгээтэй.
 - b. Дэд зэргийн түшмэдийн 2-р одон нь дундаа сийлбэртэй шүрэн шигтгээтэй.
 - c. Гуравдугаар зэргийн түшмэдийн 3-р одон нь дундаа биндэрья гэрэлтэй хөх чулуу шигтгээтэй.
 - d. Дөрөвдүгээр зэргийн түшмэдийн 4-р одон нь номин хөх чулуу шигтгээтэй.
 - e. Тавдугаар зэргийн түшмэдийн 5-р одон нь цагаан чулуу шигтгээтэй байжээ.
 Эдгээр одон нь хөх өнгийн өргөн тууз оосортой, хөх өнгийн хайрцагтай байжээ.

Энэхүү монгол одонг “Эрдэнийн Очир” гэж нэрлэсэн нь Монгол үндэсний түүх соёлын дурсгал, зан заншлын учир холбогдолтой байна. “Эрдэнэ” гэдэг үг нь энэтхэгийн самгард хэлний “ратна” буюу “ховор, үнэт зүйл” гэсэн үгнээс гаралтай бөгөөд уйгураар дамжиж монгол хэлний үгсийн санд орохдоо дуудлага нь сунжирч “эрдэнэ” болжээ. “Эрдэнэ” гэдэг үгийг монголчууд эрт дээр үеэс эрхэмлэн газар нутаг, засаг захиргааны нэгжийг нэрлэж ирсний гадна орчин үеийн утга зохиолын хэлэнд одоог хүртэл өргөн хэрэглэсээр байна. “Очир” гэдэг үг нь “бат бэх” гэсэн самгард хэлнээс гаралтай үг юм. Түүнчлэн энэхүү очир хэмээх тэмдэг нь буддын шашны тусгай зориулга бүхий билэгдлийн зүйл учир шарын шашны ихэс дээдсийн ямбаны тэмдэг, орон хийд орд барилгын чимэглэлд түгээмэл хэрэглэж байжээ. Ийм учраас очир одонг дүрсэнд оруулсан байх. Ер нь монголчууд эрдэнийн зүйлийг биедээ зүүж явбал өлзийтэй гэж үздэг тийм заншилтай.

Автономитын үед монголын төр нийгмийн бүх амьдрал хуучны хоцрогдмол бурангуй ёс харилцаанд үндэслэж байсан учраас “Эрдэнийн Очир” одонг язгууртны зэрэг хэргэмийн нэрээр нэрлэж, түүнийг тэргүүн, дэд, гуравдугаар гэж ерөнхий гурван зэрэг, мөн зэрэг тус бүрийг дотор нь дэс дараалуулан, нийт 12 ялгасан байна. “Эрдэнийн Очир” бол монголын Богд хаант улсын үед хийгдсэн монголын анхны одон юм. Тэр үед феодал язгууртанууд л зэрэг хэргэм шагнагдахаас биш харц ардын дотроос хэн ч засгийн шагнал хүртэх эрхгүй байсан цаг үе. Богд хааны нэгэн зарлигт “... тайж гэдэг нь Чингисийн угсаа төрлийн нэр мөн гэж тэмдэглээд, харц хүнд тайж нэр өгөхийг нийтээр цаазлахыг анхааруулсан байдаг. Гэвч автономитын үед баян чинээлэг хүмүүс үлэмж хөрөнгө мөнгөөр зэрэг хэргэмийг хахуульдана авах явдал гарч байжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль. 2005 он
3. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль. 2008 он
4. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам. 1999 он
5. Төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай. УИХ-ын тогтоол, 2008, №33
6. БНМАУ-ын цол, одон, медалийн дүрэм. УБ., 1990 он
7. Положение о государственных наградах Российской Федерации. /www. award.adm.gov.ru
8. Закон Республики Казахстан “О государственных наградах”. /www.parlam.kz
9. The Act on the State Decorations of the CR. /www.senat.cz
10. Наградная система Польши. /www. ru.wikipedia.org
11. “О внесении изменений и дополнений в Федеральный закон “Об общих принципах организации законодательных (представительных) и исполнительных органов государственной власти субъектов Российской Федерации” и “Об общих принципах организации местного самоуправления в Российской Федерации” . /www.duma.gov.ru
12. Государственные награды Российской Федерации. /www. rusorden.ru
13. История наградной системы современной России. /www. ru.wikipedia.org
14. Трофимов.Е.В Правовое регулирование государственных наград в РФ, автореферат диссертации на соискание ученой степени кандидата юридических наук, М., 2006 г. ru.wikipedia.org
15. Государственные награды Казахстана. /www. ru.wikipedia.org
16. Д. Самданмөнх, С. Цэдэндамба Төрийн минь сүлд ивээ. УБ., 2004 он
17. Ш. Хэнмэдэх, П. Төмөрбаатар Алдар гавъяаны өргөө. УБ., 2007 он
18. Ц. Тэрбиш БНМАУ-ын одон, медаль, алдар, цол, түүнийг анх хүртэгчид. УБ., 1977 он
19. Г. Чулуун “Чихрийн хүүхдийн араншин”, Улаанбаатар таймс сонин, 1998 он
20. <http://www.bundespraesident.de/The-role-of-the-Federal-Presid/Work-in-Germany-11180/The-Order-of-Merit-of-the-Fede.htm>
21. http://en.wikipedia.org/wiki/Awards_and_decorations_of_the_United_States_government#Office_of_the_President_of_the_United_States- аас мэдээллийг бэлтгэв. /2009.11.17/
22. <http://www.tbmm.gov.tr>
23. http://en.wikipedia.org/wiki/Orders,_decorations,_and_medals_of_the_United_Kingdom

* * *

(Footnotes)

¹ Хөдөлмөрийн баатар цолоор 1990 гэхэд 301 хүнд шагнагдсан байдаг. Академич Ж. Болдбаатарын судалгаагаар 1940 - 1990 оны хооронд улс орны улс төр, нийгэм эдийн

засаг, соёл, боловсролын салбарт гавьяа байгуулж, амжилт гаргасан сайчуулыг 7 одон, 19 төрлийн медалиар шагнаж иржээ. Мөн хугацаанд Ардын болон Гавьяат 40 гаруй нэр төрлийн хүндэт цолыг 800 гаруй хүнд хүртээжээ. <http://www.mongolnews.mn/unuudur.php>

² Ш. Хэнмэдэх, П. Төмөрбаатар, “Алдар гавъяатны өргөө”, УБ, 2007; номд Монгол Улсын Гавьяат зүтгэлтэн цолыг хүртэгсэдийн талаархи зарим статистик мэдээлэл нэгтгэгдэж орсон нь бий;



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2

БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛД

Ц. Норовдондог (Ph.D), Б. Буяндэлгэр, Ш. Хишигсүрэн,
Ц. Түвшинзаяа

СЭДВИЙН АГУУЛГА

1. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
 - 1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт
 - 1.2. Шүүхийн тухай хууль болон бусад хуулийн зохицуулалт
2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИЖИЛ ТӨСТЭЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
3. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ
4. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ШҮҮХИЙН БИЕ ДААСАН, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙХ ЗАРЧИМД НИЙЦҮҮЛЭХ НЬ
 - 4.1. Ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх нь
 - 4.2. Ерөнхий зөвлөлийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс томилох нь
 - 4.3. Ерөнхий зөвлөлийн даргыг Улсын Их Хурлаас томилох нь

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛД

Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаярын захиалгын дагуу “Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэхүү судалгааны хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн эрх зүйн орчин, түүний тулгамдсан асуудал, гадаадын зарим орны ижил төстэй байгууллагуудын зохион байгуулалт, бүтэц, удирдлага, Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлагыг томилох асуудал нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгаа болж чадаж байгаа эсэх асуудлыг хөндсөн болно. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг томилох асуудал нь Үндсэн хуулийн зарчимтай хэрхэн нийцэж байгаа эсэх талаар судлан үзэн боломжит зарим хувилбарыг авч үзэв.

1. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг хэрхэн зохицуулсаныг тусгав.

1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”, мөн зүйлийн 49.4 дэх хэсэгт “Шүүхийн

ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай бие даасан хууль хараахан батлагдаж гараагүй байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүрэлдэхүүн, бүрэн эрх зэргийг харин Шүүхийн тухай хуулийн⁶ 6 дугаар бүлэгт тусгайлан зохицуулсан байна.

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно” гэж заасан нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн нэг чиг үүргийг Үндсэн хуулиар тодотгосон байна. Үндсэн хуульд Шүүх эрх мэдэл засгийн гурван салааны нэгийн хувьд бие даасан байх, шүүгч нь түүний бүрэлдэхүүний хувьд бусдаас хараат бус байхыг онцгойлон зохицуулсан бөгөөд үүний хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл нь төрийн бүх л байгууллага, албан тушаалтан, бусад хүний хөндлөнгийн оролцоо, болзошгүй дарамтаас шүүхийг сэргийлэхэд үйл ажиллагааныхаа голыг чиглүүлэх утгыг агуулж байгааг илэрхийлсэн байна⁷.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахын тул шүүхийг, шүүгчийг эрх мэдэлтэн, эд баялагтны зэрэг аливаа хөндлөнгийн оролцоо, нөлөөнөөс хамгаалах шаардлагатай байдаг. Иймд шүүхийн зорилго, чиг үүргийг Үндсэн хуульд зөвхөн хууль зүйн бус, бас зохион байгуулалт-эдийн засгийн утгаар өргөсгөн тодорхойлсон байна⁸.

1.2. Шүүхийн тухай хууль болон бусад хуулийн зохицуулалт

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүрэлдэхүүн, бүрэн эрхийн талаар зохицуулсан байна. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүхийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага мөн” гэж заасан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн шүүх эрх мэдлийн дотоод гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүрэг: Шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж сонгох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа: Шүүхийн ерөнхий зөвлөл нь хамтын удирдлагын байгууллага бөгөөд түүнд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх орон тооны ажлын албатай байх ба Гүйцэтгэх нарийн бичгийн дарга тус ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангадаг.

Ерөнхий зөвлөл нийт 14 гишүүнтэй бөгөөд түүний бүрэлдэхүүнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилогдсон тус бүр нэг хүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор албан тушаалаараа, Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон Улсын дээд шүүх, аймаг, анхан шатны шүүхээс тус бүр 2, нийслэлийн шүүхийн нэг шүүгч тус тус ордог. Ерөнхий зөвлөлийн

⁶ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, дугаар 29, 2002 он.

⁷ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэвтэр, УБ, 2004 он, 143 дахь тал.

⁸ Б.Чимид, н.д.н, Хоёрдугаар дэвтэр, 144 дэх тал.

гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба энэ хугацаа нь албан тушаалаараа Ерөнхий зөвлөлд орсон гишүүдэд үл хамаарана.

Ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байна. Гэвч Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын асуудал маргаантай байдаг бөгөөд зарим хуульчид, эрдэмтэд Ерөнхий зөвлөлийн дарга хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх нь зүйтэй гэж үздэг бол Ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ч биш, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ч биш, харин Монгол Улсын Ерөнхийлөгчөөс томилогдсон хүн байх нь илүү зохимжтой гэсэн байр суурьтай хуульчид, эрдэмтэд ч байдаг⁹.

Ерөнхий зөвлөлийн хуралдаан: /Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйл/ Ерөнхий зөвлөл бүрэн эрхээ хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлдэг бөгөөд хуралдааныг хоёр сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд Ерөнхий зөвлөлийн даргын саналаар ээлжит бус хуралдаан явуулна. Ерөнхий зөвлөлийн хуралдаан гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ирснээр хүчинтэйд тооцогдох бөгөөд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх: /Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйл/

1. Зохих байгууллага, албан тушаалтантай зөвшилцөн Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршил, нутаг дэвсгэрийн харьяалалыг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
2. Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
3. Шүүхийн төсвийг хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;
4. Шүүгчийг томилуулах, сэлгэн ажиллуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;
5. Шүүгчийг шилж сонгох, шалгаруулах, мэргэшлийг нь дээшлүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;
6. Шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг тогтоох, Мэргэшлийн хороог байгуулах;
7. Шүүгч, шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төрийн дээд шагналд тодорхойлох, шүүхийн шагналын журам тогтоох;
8. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргыг томилж, чөлөөлөх;
9. Тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор шүүхийн тамгын газар, хэлтсийн даргыг томилох, чөлөөлөх;
10. Хууль тогтоомжийн дагуу шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын зэрэг дэвийн болон бусад нэмэгдэл тогтоох;
11. Ерөнхий зөвлөлийн ажлын албаны болон шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны ажилтан, түүнчлэн шүүгчийн туслахын орон тоог тогтоох;
12. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Мөн түүнчлэн Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар; Ханнс - Зайделийн сан, Эрх зүйн боловсролын академи, УБ, 2009 он, 227 дахь тал.

“Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийг аймаг, нийслэлийн Засаг даргатай, дагнасан шүүхийг Улсын дээд шүүхтэй тус тус зөвшилцөн гаргасан

Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/-ийн саналыг үндэслэн Улсын Их Хурал байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана”, хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Шүүх хуралдааны танхимын загварыг Ерөнхий зөвлөл батална”, хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөл Мэргэшлийн хороог есөн гишүүний бүрэлдэхүүнтэй, гурван жилийн хугацаагаар байгуулна”, мөн зүйлийн 30.9 дэх хэсэгт “Мэргэшлийн хорооны дүрмийг Ерөнхий зөвлөл батална” зэрэг хэд хэдэн бүрэн эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасан байна.

Шүүхийн зөвлөл ажлын албатай байх ба түүний зохион байгуулалт бүтэц, орон тоо, ажиллах журмыг өөрөө тогтоохоор заасан зохицуулалт нь тус зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад чиглэсэн байна. Мөн Ерөнхий зөвлөл соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд түүний зардлыг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулжээ.

Үндсэн хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн зорилго, чиг үүргийг заасан бөгөөд Шүүхийн тухай хуулиар тус зөвлөлийн бүрэн эрхийг тодорхой нарийвчилан тогтоосон байна. Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийг тодорхой заасан боловч уг зөвлөлд өөр хуулиар бүрэн эрх хэрэгжүүлэх боломжийг нээлттэй үлдээсэн байна. Тухайлбал: Авилгын эсрэг хуульд: Уг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь хэсэгт Улсын дээд шүүхээс бусад бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгалахаар зохицуулсан байна. Мөн Авилгын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд мэдээлэхээр тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд: Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар Үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв түүний гүйцэтгэлийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулахад Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг байлцуулж, УИХ-ын гишүүдийн асуусан асуултад хариулах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэгт заасан байна. Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулахаар зохицуулжээ. Уг асуудлаар УИХ-ын хуралдаанаар санал хураалт явуулахгүй ба харин Шүүхийн зөвлөлийн даргаас УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлэх бүрэн эрхтэй.

Төрийн албаны тухай хуульд: Шүүхийн ерөнхий зөвлөл нь төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд Төрийн албаны зөвлөлийн орон тооны нэг гишүүний нэрийг Шүүхийн ерөнхий зөвлөл дэвшүүлэх эрхтэй. Мөн Төрийн албаны зөвлөлийн орон тооны бус гишүүн нь албан тушаалаараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга байхыг Төрийн албан тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8.4 дэх заалтад тусгайлан зохицуулсан байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагч байх ба Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийн ерөнхий менежер байхаар уг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8, 16 дугаар зүйлийн 16.2.9-д тус тус зохицуулсан байна.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИЖИЛ ТӨСТЭЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн газар /Судебный департамент при Верховном Суде Российской Федерации/ нь шүүх болон шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах нөхцлийг бүрдүүлж, бүх шатны шүүхийн зохион байгуулалт, захиргаа, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй¹⁰.

Шүүхийн газрын Ерөнхий захирлыг Дээд шүүхийн дарга ОХУ-ын Шүүгчдийн зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлдөг. ОХУ-ын Шүүгчдийн зөвлөл нь Шүүгчдийн их хурлаас байгуулагддаг байнгын ажиллагаатай байгууллага юм. Тус газрын Ерөнхий захирлын орлогчдыг Ерөнхий захирлын санал болгосноор ОХУ-ын Дээд шүүхийн дарга томилж, чөлөөлнө. Шүүхийн газрын удирдах бүрэлдэхүүнд Шүүхийн даргын орлогчид, зарим ажилтнууд орох бөгөөд Дээд шүүхийн дарга, орлогчид, Шүүгчдийн зөвлөлийн гишүүд үйл ажиллагаанд нь оролцох эрхтэй байдаг¹¹.

2.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадын шүүхийн тогтолцооны эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн 123-128 дугаар зүйл болон Ардын шүүхийн зохион байгуулалтын тухай 1979 оны хуулиар тус тус зохицуулж шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хуульчилсан байна. Хятад Улсын шүүн таслах ажиллагааг ердийн болон тусгай шүүхийн байгууллагууд гүйцэтгэх ба Ердийн шүүхүүдэд Ардын дээд шүүх, орон нутгийн Ардын шүүх хамаарна.

Шүүгчдийг холбогдох түвшиний Ардын хурлаас хоёр таван жилээс илүүгүй хугацаагаар сонгох буюу томилно. Ардын дээд шүүхийн даргыг Бүх Хятадын хурлаас, шүүгчдийг нь түүний Байнгын хорооноос сонгоно. Шүүхийн тогтолцооны захиргааны удирдлагыг Хууль зүйн яам хэрэгжүүлнэ. Тус яамыг 1959 онд татан буулгаж, 1979 онд дахин байгуулжээ. Яам нь шүүгчдийг бэлтгэх ба шүүхийн санхүүжилтийн асуудлыг хариуцдаг байна.

2.3. Япон Улс

Японы өнөөгийн шүүхийн тогтолцоо нь 1947-1948 оны Үндсэн хуулийн дараах шинэтгэлийн үр дүнд бүрэлдэн тогтсон байна. Энэ тогтолцоо нь Дээд шүүх, дээд, орон нутгийн, гэр бүлийн шүүхүүд болон анхан шатны шүүхээс бүрдэнэ. Японы шүүгчийг арван жилийн хугацаагаар томилно. Улсын Дээд шүүхээс гаргасан нэр дэвшигчийн жагсаалтыг үндэслэн Сайд нарын танхимаас шүүгчдийг томилно. Улсын Дээд шүүхийн даргыг Япон Улсын эзэн хаан томилно. Шүүгч нь арван жил өнгөрсний дараа хуульд заасан тэтгэвэрийн насанд хүртэл дахин томилогдож болно.

Шүүгчийн эсрэг гаргасан гомдлыг парламентын тусгай байгууллага импичментийн журмаар шалгасны эцэст шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлнө. Төлөөлөгчдийн танхимын ээлжит сонгууль явуулах үед Улсын дээд шүүхийн томилгоо “ард түмнээр хянагдана”. Сонгогчдын олонх нь аль нэг шүүгчийг өөрчлөх санал гаргавал, тухайн шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөнө.

¹⁰ ОХУ -ын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн газрын тухай Холбооны хууль, 1998 он, 1;4;6 дүгээр зүйл.

¹¹ ОХУ-ын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн газрын тухай Холбооны хууль, 1998.01.08, 11 дүгээр зүйл.

2.4. Бүгд Найрамдах Сингапур Улс

Сингапурын шүүхийн тогтолцоо нь тангарагтны шүүхийн институтээс бусад Британий эрх зүйн уламжлал, практикийг тусгасан байдаг. Үндсэн хуульдаа шүүх эрх мэдлийг хараат бус гэж заасан хэдий ч практикт энэ нь шүүхийн хяналтыг хязгаарласан хууль тогтоомж болон шүүгчдийн томилгоонд тавих Засгийн газрын хяналтаар хязгаарлагддаг.

Ерөнхий шүүгч болон Дээд шүүхийн гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Харин Ерөнхий сайд Дээд шүүхийн гишүүнд нэр дэвшигчийн талаар Ерөнхий шүүгчтэй зөвлөлдөнө. Түүнчлэн Ерөнхийлөгч Ерөнхий шүүгчийн санал болгосноор доод шатны шүүгчдийг томилдог. Шүүгчийг томилох хугацааг Ерөнхий шүүгчийн даргалдаг Хууль зүйн албаны талаарх комисс тогтооно.

2.5. Израиль Улс

Израилийн шүүхийн тогтолцоо нь 1984 онд батлагдсан Шүүх эрх мэдлийн тухай хуулийн дагуу иргэний болон шашны шүүхээс бүрддэг. Иргэний шүүхийн тогтолцоонд эвлэрлийн шүүх, тойрогийн шүүх, Дээд шүүх болон онцгой шүүхүүд хамаарна. Шүүгчдийг томилох хорооны санал болгосноор шүүгчийг Ерөнхийлөгчөөс томилно. Мэргэшил болон боловсон хүчний асуудлаарх энэхүү дээд байгууллага нь 9 гишүүнээс бүрдэнэ. Үүнд: гурван шүүгч / Дээд шүүхийн дарга 2 гишүүн/, хоёр сайд, үүнээс нэг нь Хууль зүйн сайд /саналын эрхгүй/, Кнессетын 2 төлөөлөгч байна. Хороог Хууль зүйн сайд тэргүүлнэ. Шүүгчдийг улс төрийн бус зөвхөн мэргэжлийн үүднээс томилно.

2.6. Бүгд Найрамдах Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улсын Үндсэн хуулийн 159 дүгээр зүйлд Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны чиг үүрэг, бүрэн эрхийг тогтоосон бөгөөд уг хороо нь шүүхийн бие даасан байдал шүүгчийн хараат бус байх зарчмын үндсэн дээр байгуулагдаж, чиг үүргээ хэрэгжүүлэхээр заасан байна.

Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны дарга нь Хууль зүйн сайд байна. Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга албан тушаалаараа тус хорооны гишүүн байна. Хорооны үндсэн орон тооны болон орон тооны бус гурав гурван гишүүнийг Дээд Шүүхийн нийт гишүүний хурлаас, орон тооны хоёр болон орон тооны бус хоёр гишүүнийг Захиргааны Дээд шүүхийн нийт гишүүний хурлаас сонгох бөгөөд тухайн гишүүний орон тоон дээр гурван хүний нэрийг дэвшүүлнэ. Ерөнхийлөгч тэдгээр гурван нэр дэвшигчээс нэгийг нь дөрвөн жилийн хугацаатай сонгон томилно. Хугацаа нь дууссан гишүүн дахин сонгогдож болно. Хороо сонгогдсон орон тооны гишүүдээс дэд даргыг сонгоно.

Шүүгчдийн болон Прокурорын дээд хороо ердийн болон захиргааны шүүхийн шүүгч болон прокурорыг мэргэжлээр нь хүлээн зөвшөөрч, томилох, сэлгэн ажиллуулах, түр бүрэн эрх олгох, зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох, орон тоо хуваарилах, мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол шийдвэр гаргах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх шийдвэр гаргана.

Шүүх, шүүгч, эсхүл прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх асуудлаарх Хууль зүйн сайдын саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Түүнчлэн Үндсэн хууль болон хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хорооны шүүх, шүүгч, эсхүл прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх зэрэг шийдвэрийг уг шийдвэртэй холбогдох этгээд эсэргүүцэж шүүхэд хандаж болохгүй. Хорооны чиг үүргээ хэрэгжүүлэх, сонгууль болон үйл ажиллагааны дотоод журам, шийдвэрийн эсэргүүцлийг Хорооны дотоод бүтцийн хянан шалгах үндэсийг

хуулиар тогтоосон байдаг. Хууль зүйн сайд яамны аппаратад түр болон байнга ажиллах шүүгч, прокурорын зөвшөөрлийг аван, тэдгээрийг томилох бүрэн эрхтэй.

Турк Улсын Үндсэн хуулийн 159 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шүүхийн бие даасан болон шүүгчийн хараат бус байдлын баталгааны үндсэн дээр байгуулахаар заасан Шүүгчдийн болон Прокурорын дээд хороог 1981 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 2461 дугаар Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хорооны тухай хуулиар¹² байгуулсан бөгөөд 2461 дугаар хуулийн 4 дүгээр зүйлд Хороо дараахи чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн гишүүнийг сонгох
2. Шүүх, шүүгч, прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх асуудлаархи Хууль зүйн яамны саналыг шийдвэрлэх.
3. Шүүгч болон прокурорын:
 - а/ мэргэжлээр нь хүлээн зөвшөөрөх
 - б/ зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох
 - в/ түр бүрэн эрх олгох
 - г/ томилох, сэлгэн ажиллуулах
 - д/ орон тоо хуваарилах
 - е/ мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол зохих шийдвэр гаргах
 - ё/ сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх.
1. Үндсэн хууль болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Шүүгч, прокурортой холбоотой дээр дурдсанаас бусад үйл ажиллагааг Хууль зүйн яам хэрэгжүүлнэ. Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хороо нь бие даасан байна.

ГУРАВ. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн тулгамдсан асуудлыг тодруулж гаргахдаа УИХ-ын хуралдааны тэмдэглэл, хуульч, эрдэмтэдийн нийтлүүлсэн ном, өгүүлэл, төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааг түлхүү ашиглав. Эдгээр эх сурвалжаас түүвэрлэж авсан асуудлуудыг тоймлон харуулбал:

- Өнөөгийн нийгэмд үүсээд байгаа шүүгчдийн хараат бус байдал алдагдаж, шүүхийн бие даасан байдал хангагдахгүй байгаагийн нэг шалтгаан нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдлыг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу бүрэн тогтоогүйд оршиж байна гэж үздэг. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдал Үндсэн хуулийн байгууллага болох өндөр түвшин, онцгой үүрэг зорилгод нь хүргэж тодорхойлох шаардлагатай байна¹³.
- Шүүхийн ерөнхий зөвлөл Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын дээд шүүхийн шүүгчдээс бусад шүүхийн шүүгчийг томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгодог. Ерөнхий зөвлөлийн санал болгосон хүнийг Ерөнхийлөгч томилоогүй тохиолдолд Ерөнхийлөгч эргээд Ерөнхий зөвлөлд ямар нэг тайлбар өгөх эрх зүйн үндэслэл байхгүй, мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын төлөөлөл оролцож шийдвэр гаргадаг зэрэг нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж байна гэж үздэг.

¹² Тус хорооны албан ёсны вэб хуудас: <http://www.hsyk.gov.tr> /2009.9.10/

¹³ <http://www.mevzuat.adalet.gov.tr/html/545.html> /2009 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр татаж авсан/

- Шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийн тухай Үндсэн хуулийн заалтыг үзэл баримтлалынх нь үүднээс нарийвчлан дэлгэрүүлж заалгүй, үгчлэн хуулж бичсэн байгаа бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл чухам ямар ямар эрх, үүрэгтэй байх талаар дэлгэрүүлэх учиртай билээ¹⁴. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах хамгийн гол үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа бөгөөд энэ нь тус Зөвлөлийн бүрэлдэхүүн болон тэнд ажиллагсдын хариуцлага санаачлага, тогтолцооны согог, эрх зүйн зохицуулалтын хомсдлоос шалтгаалж байна гэж үзэх үндэслэлтэй юм.
- Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг бүрдүүлэн хангаж, үйлчлэх байгууллага болохын хувьд төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон аж ахуйн нэгж, байгууллагатай өдөр тутмын харилцаатай ажиллах хэрэгцээ шаардлагатай. Иймд Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах болох захиргааны байгууллагатай, түүний харилцах эрх зүйн үндэслэл, журам, юуны өмнө тулган заасан шинжтэй эрх, үүргийг нь хуулиар тод томруун тогтоож өгөх нь чухал юм¹⁵.
- Шүүхийн төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль зэрэг төсөвтэй холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх бус харин шүүх эрх мэдлийн өөрийн онцлогт тохируулан хуулиар зохицуулах нь чухал юм.
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн жилийн төсвийг боловсруулахад Шүүгчдийн зөвлөлийн саналыг заавал авдаг журмыг хуульчлах, шүүхийн төсвийн төслийг Засгийн газарт Шүүхийн ерөнхий зөвлөл бие даан оруулж хэлэлцүүлэх, хэрэв Сангийн ямаар дамжина гэвэл санал илэрхий зөрсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга өөрийн санал дүгнэлтийг УИХ -д зэрэгцүүлэн оруулж хэлэлцүүлдэг журмыг хуульчилж болох юм¹⁶. Мөн Нээлттэй нийгэм форумын санаачилгаар хийсэн “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”-д “Шүүхийн төсөв нь шүүхээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд байдаг” гэсэн асуултад “санал нийлэхгүй” 33 хувь, “санал нийлж байна” 29 хувь, “хэлж мэдэхгүй” 38 хувь нь тус тус үнэлсэн байна¹⁷.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын албан тушаалыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хавсруулсан нь Засгийн газрын гишүүнд хавсруулж байснаас дутахааргүй сөрөг үр дагавартай, том алдаа болсон¹⁸. Учир нь уг зохицуулалт нь шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулах, шүүхийн мэргэжлийн удирдлагыг захиргааны удирдлага болгосон шинжтэй зохицуулалт болсон. Нэг үгээр хэлбэл, Шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад саад болж байгаа нэг гол хүчин зүйл бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын албан тушаалыг Монгол улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хавсруулсан буруу тогтолцоонд оршиж байна.
- Тогтолцооны энэ согог нь Ерөнхий шүүгч шүүхийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх

¹⁴ Б. Чимид, н.д.н, хоёрдугаар дэвтэр, 151 дэх тал.

¹⁵ Б. Чимид, н.д.н, хоёрдугаар дэвтэр, 152-153 дахь тал.

¹⁶ Б. Чимид, н.д.н, хоёрдугаар дэвтэр, 155 - 156 дахь тал.

¹⁷ Н. Лүндэндорж, “Шүүх эрх мэдлийн хямрал” нийтлэл, “Либерти” сэтгүүлийн №2, “Өдрийн сонин” 2006 оны дугаар.

¹⁸ Нээлттэй нийгэм форум, “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”, Улаанбаатар хот, 2009 он, 13 дахь тал.

нэрийдлээр шүүгчдийг өөрийн хараанд байлгах, захирагдаагүйнх нь төлөө шийтгэл ногдуулах, тодорхой нэг хэрэгт холбогдол бүхий этгээд “дарга шүүгч” /Ерөнхий шүүгч/-ээр дамжуулан шүүгчид нөлөөлөх боломжийг хуулиар олгож байна. “Нээлттэй нийгэм форум”-аас гаргасан тайланд¹⁹ дурдсанаар “анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэр гаргах явцад дээд албан тушаалын шүүгчээс “жишээ нь: Ерөнхий шүүгчид, Дээд шүүхийн шүүгчид...гм” ямар нэг зохисгүй нөлөө байдаггүй” гэсэн санал асуулгад оролцогчдын 64 хувь нь “санал нийлэхгүй буюу огт санал нийлэхгүй байна”, 14 хувь нь “санал нийлж байна” гэж хариулжээ.

- Шүүгчдийн цалин хангамж сүүлийн жилүүдэд нэмэгдэж, анхан шатны шүүхийн шүүгч сард 300-400 ам. доллар /ойролцоогоор 435.000-580.000 төгрөг/, Дээд шүүхийн шүүгч 1 сая гаран төгрөгийн цалин хөлс авч байгаа нь шүүгчийн ар гэрээ тэжээн тэтгэж, боломжийн аюулгүй орчинд амьдрахад хүрэлцэх төдий л байна. Энэ нь хувийн секторт ажиллаж байгаа зарим хуульчийн цалинтай харьцуулахад том ялгаатай байна. Улаанбаатарт томоохон компанийн хуульч цагт 300.000 мянган орчим төгрөгийн хөлс авч байгаатай харьцуулж үзвэл шүүгчийн цалингийн хэмжээ нь хэр байгаа нь тодорхой байна²⁰.
- “Шүүгчийг сонгож томилох үйл ажиллагаа нь хараат бус, голч хандлага бүхий шүүгчийг гаргаж ирэх нөхцөлийг бүрдүүлдэг” гэсэн асуултад “санал нийлэхгүй байна” 54 хувь, “санал нийлж байна” 32 хувь, “хэлж мэдэхгүй” 14 хувь гэсэн үзүүлэлттэй хариулсан байна²¹. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний асуудал ч анхаарал татдаг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон бүх шатны шүүхээс 7 шүүгч нийт 8 шүүгч орж байгаа нь бүрэлдэхүүний олонхи болж байгаа бөгөөд хамтран ажилладаг шүүгчдийнхээ талаар хараат бус шийдвэр гаргахад эргэлзээ төрүүлж байгаа юм.
- Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд албан тушаалаараа ордог дарга нар шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангах талаар идэвх санаачлагатай ажиллахын оронд шүүгчдийг томилуулах санал хэлэлцэхэд “идэвхтэй оролцох” хандлага байдаг. Иймээс Шүүхийн ерөнхий зөвлөлийг байгуулж байгаа арга хэлбэр, бүрэлдэхүүн, удирдлага, зохион байгуулалтыг шүүх эрх мэдлийн хараат бус байх зарчимд нийцүүлэх эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болж байна.

* * *

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ШҮҮХИЙН БИЕ ДААСАН, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙХ ЗАРЧИМД НИЙЦҮҮЛЭХ НЬ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн нь Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу 14 гишүүнтэй байх бөгөөд эдгээр нь:

- Улсын Их Хурлаас томилсон -1,
- Ерөнхийлөгчөөс томилсон -1,
- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч,
- Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн,
- Улсын ерөнхий прокурор,
- Шүүгчдийн зөвлөлөөс сонгосон нийт 9 шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлийг

¹⁹ Н. Лүндэндорж, н.д.нийтлэл.

²⁰ Нээлттэй нийгэм форум, н.д.т, 18 дахь тал.

²¹ Нээлттэй нийгэм форум, н.д.т, 14 дэх талаас утгаар нь авав.

бүрдүүлж байна.

Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байна” гэж тогтоосон. Шүүхийн тухай хуулийн зохицуулалтаас үзэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний 14 гишүүнээс доод тал нь 10 шүүгч байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаан гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ирснээр хүчинтэйд тооцогдох ба өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэхээр Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан. Үүнээс үзэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 14 гишүүний гуравны хоёроос доошгүй гэдэг нь 9,3 буюу 10 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдан шийдвэр гаргах бүрэн боломжтой юм.

Иймд зарим асуудлаар дан шүүгчид хуралдан шийдвэр гаргах боломжтой бөгөөд энэхүү зохицуулалт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалтай нийцэж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна. “Олгой хагаравч тогоондоо” гэдгийн адил Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ нэг талыг барьсан, шүүгчийн хараат бус байдлыг хангах бус харин сонирхлын зөрчлийн нөлөөнд автах шийдвэр гаргах боломжтой болно. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн дэх шүүгчийн тоог багасгах, аль болох хөндлөнгийн гишүүдийн тоог нэмэх асуудлыг анхаарууштай юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн дэх шүүгчийн тоо нь илт давуу байдалтай байх нь хэлэлцэж буй асуудалд мэргэжлийн явцуу байдлаар хандах боломжтой. Нөгөө талаар өнөөгийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний тоог хэт олон байна гэж үздэг. Гадаадын зарим орны ижил төстэй зөвлөл, хороо нь 7 эсхүл 9 гэх мэт цөөн тооны гишүүнтэй байдаг. Аливаа хороо, зөвлөлийн бүрэлдэхүүн сондгой тоотой байх нь шийдвэр гаргахад санал тэгш хуваагдахгүйгээр олонхиор шийдвэрлэхэд тохиромжтой байдаг гэж үздэг.

Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд УИХ-аас Шүүхийн ерөнхий зөвлөлд томилох хүнийг хэн нэр дэвшүүлж, хэрхэн томилох тухай нарийвчилан зохицуулаагүй бөгөөд уг асуудлаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль зэрэг хууль тогтоомжид тусгай зохицуулаагүй бөгөөд энэ асуудлыг УИХ Хууль зүйн байнгын хорооны даргаа томилдог жишиг тогтсон байдаг байна.

Харин Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа өмнө нь үүрэг гүйцэтгэж байсан Хууль зүйн байнгын хорооны даргын Ерөнхий зөвлөл дэх гишүүний бүрэн эрхийн хугацаа үргэлжилж байдаг бөгөөд үүнээс үзэхэд УИХ-аас Ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилох процессийн зохицуулалт дутмаг бөгөөд уг асуудалд УИХ-ын дарга хуулиар олгогдоогүй бүрэн эрх хэрэгжүүлэх боломжтой байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байхаар хуульчилсан байгааг шүүмжилдэг ба асуудлыг хэрхэн зохицуулж болох талаархи зарим хувилбарыг авч үзье.

4.1. Ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх нь

Зарим хуульчид, эрдэмтэд Ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх нь зүйтэй гэж үздэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг 1993 оны Шүүхийн тухай хуульд анх Ерөнхий зөвлөлийн гишүүд дотроос олонхийн саналаар сонгодог байсныг 1996 оны Шүүхийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна” гэж

тогтоосон²². Уг өөрчлөлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс хэрхэн хэлэлцэж баталсныг сийрүүлбэл²³;

Д. Лүндээжанцан: ...Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 33-р зүйлийн 3 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроос олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно гэж зааж өгсөн. Энэ бол харьцангуй зөвшилцөлд хүрч энэ яагаад гэвэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг гүйцэтгэх засаглалын төлөөлөгч шууд гардан эрхлэх юм уу, эсвэл Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч шууд толгойлох юм уу гэдэг энэ туйлшралгүйгээр дотроосоо сонгож шийдье²⁴.

Ингэвэл шүүх эрх мэдэл яг биеэ даасан шүүхийн боловсон хүчний асуудлаа энэ Ерөнхий зөвлөлд хэрэгжүүлэх үйл ажиллагаа шүүхээ удирдлагаар хангах үйл ажиллагаа гольдрилдоо орж, шүүхийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх юм гэдэг үндэслэлээр энэ асуудал шийдэгдсэн. Тэгвэл өнөөдөр Хууль зүйн сайд шууд толгойлно гэвэл бүх шатны шүүгчид Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн сайдын үйл ажиллагаатай шууд холбогдож ирэхнээ.

Шүүхийн үйл ажиллагаа, шүүн таслах үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглал бас хөндлөгөөс нөлөөлөх ийм боломж бүрдэх юм гэсэн ийм асуудал яригдаж таарна. Яахав сонгуулиар дотроосоо сонгогдоод гараад ирвэл өөр хэрэг. Энэ нь нээлтэй байж байгаа. Шууд хүчээр хуулиар дээрээс нь захиргаадах маягаар хүчиндэж ингэж Хууль зүйн сайдыг шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байлгана гэдэг маань шүүхийн тогтолцоог анх ярьсан энэ асуудал эвдрээд ингээд шүүхийн барилга сууринаасаа эхлээд ганхаж эхлэж байна.

Тийм учраас Шүүхийн ерөнхий зөвлөлийг Хууль зүйн сайд толгойлох нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчимд нийцэхгүй, шүүх түүний байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглалын байгууллага, түүний албан тушаалтан оролцох, шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангах Үндсэн хуулиар захиргаадаж даргыг нь тавьж өгч байгаа явдал бол зохимжгүй байна.

А.Болат: ...Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг энэ үндсэн байгууллага маань өөрийнхөө ач холбогдолыг алдаж шүүхийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа болдог тэр чанар нь алдагдах гэж байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт үйл ажиллагааны явцдаа ч гэсэн нэлээд бэрхшээл тохиолдоно гэж ойлгож байна. Хэрвээ өнөөдрийнхээ байдлыг өөрчилж Шүүхийн ерөнхий зөвлөлийг хуулийн сайд толгойлохоор болбол өнөөдрийн Ерөнхий зөвлөлийн аппаратын үүргийг гүйцэтгэх тийшээ хандах юм шиг байна. Яг энэ чанараараа шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг маань нэг ёсондоо гүйцэтгэх засаглалын бүтцэд орсон байгууллагын шинжтэй болох юм шиг байна.

Дээрх тэмдэглэлээс үзэхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хэн байх асуудалд УИХ-ын зарим гишүүн нэлээд шүүмжлэлтэй хандаж байсан боловч Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан хуулийн 1 дүгээр зүйлийг 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд оролцсон 55 гишүүний 67,3 хувийн саналаар баталж байжээ. 1993 оны Шүүхийн тухай хуулийг 2002 оны Шүүхийн тухай хуулиар өөрчилж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч байхаар зохицуулсан байна.

²² Нээлттэй нийгэм форум, н.д.т, 15 дахь тал.

²³ Уг 1993 оны Шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн харьцуулалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

²⁴ УИХ-ын нэгдсэн хуралдааны 1996 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн тэмдэглэлээс.

Турк Улсад манай Шүүхийн ерөнхий зөвлөлтэй төстэй байгууллага болох Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооных нь даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь албан тушаалаар шууд хариуцдаг хуулийн зохицуулалттай бөгөөд энэхүү зохицуулалтыг нь судлаачид шүүх эрх мэдэлд гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөлөл их байх болон иймд шүүхийн бие даасан байдал алдагдаж, шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангахгүй болно гэж шүүмжилдэг байна.

4.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчөөс томилох нь

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ч биш, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ч биш, харин Ерөнхийлөгчөөс томилсон хүн байх нь илүү зохимжтой гэсэн байр суурьтай хуульчид, эрдэмтэд ч байдаг. Ерөнхийлөгчийн томилсон хүн илүү хараат бус байж, аливаа асуудалд хөндлөнгөөс орж хөндлөнгийн байр суурьтай байх болно гэж үздэг.

Уг асуудлыг Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааруулах тохиолдолд Ерөнхийлөгч шүүх эрх мэдэлд томоохон бүрэн эрхтэй болох бөгөөд шүүх болон шүүгчид Ерөнхийлөгчийн нөлөөлөл ихэссэж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгааг Шүүхийн ерөнхий зөвлөл алдана гэсэн шүүмжлэлтэй байдаг.

2009 онд “Нээлттэй нийгэм форум”-аас гаргасан “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”-д “... Ярилцлага өгсөн мэргэжилтний дунд нийтлэг байгаа зүйл бол төрийн өндөр албан тушаалтнууд (ялангуяа Ерөнхийлөгч) Дээд шүүхийн болон Цэцийн шийдвэрт хүчтэй нөлөөлдөг хэмээн үзэж байгаа явдал юм...” гэж дурьдсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Ерөнхийлөгч тодорхой нөхцөл, шаардлагыг хангасан хүний өөрөө шууд томилох эсхүл Ерөнхийлөгчид аль нэг этгээдийн санал болгосон нэр дэвшигчдээс сонгон томилох гэдэг асуудал гарах боломжтой. Нэг талаас Ерөнхийлөгч шууд өөрөө томилоход тухайн томилогдсон хүнийг Ерөнхийлөгчийн хүн гэх шүүмжлэл гарах бөгөөд харин бүх шүүгчдийн бүгд хурал гэх зэрэг аль нэг этгээдээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргад 3 нэр дэвшигчийг эхлээд сонгон эдгээр 3 нэр дэвшигчийн аль нэгийг нь Ерөнхийлөгч өөрийн үзэмжээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаар томилох нь илүү зохимжтой хувилбар талтай гэж үздэг.

4.3 Ерөнхий зөвлөлийн даргыг Парламентаас томилох нь

Ерөнхий зөвлөлийн даргыг Парламентаас томилсон хүн байх нь оновчтой гэж үздэг үзэл байдаг. Ерөнхий зөвлөлийн даргыг Парламент томилоход хэд хэдэн тохиолдол байна. Нэгдүгээрт Ерөнхий зөвлөлийн даргад нэр дэвшигчийг Парламентад Ерөнхийлөгч санал болгож Парламент түүнийг томилох, хоёрдугаарт, Парламентад Ерөнхий зөвлөлийн даргыг Парламентын дарга санал болгож, түүнийг томилох, мөн Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч санал болгох, Ерөнхий сайд санал болгох зэрэг олон хувилбар байна. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын удирдлагын эрх зүйн зохицуулалтын тухайд хийсэн харьцуулалтыг Хавсралт -2-оос харна уу.

Ерөнхий зөвлөлийн даргыг Парламентаас томилох нь илүү зохимжтой бөгөөд шүүмжлэл багатай байх болно гэж зарим судлаачид үздэг байна. Учир нь Парламент зөвлөлийн даргыг зөвхөн томилох бөгөөд эргээд түүнээс ямар нэг тайлан шаардахгүй тул Парламентаас Ерөнхий зөвлөлийн дарга хараат бус байх бүрэн боломжтой юм. Хэрэв Ерөнхий зөвлөлийн дарга томилсон газартаа эргээд ямар нэг тайлан гаргаж өгдөг бол тухайлбал Парламентад ажлаа тайлагнадаг байгууллагуудын удирдлагын адил тайлан тавьдаг бол шүүх эрх мэдэлд хууль тогтоох эрх мэдлийн нөлөө орно гэсэн шүүмжлэл гарах болно.

Ерөнхий зөвлөлийн даргыг хугацаанаас нь өмнө чөлөөлөх, огцруулах асуудлыг Парламентад даргыг санал гаргасан субъект оруулахаар зохицуулах нь илүү нийцтэй болов уу. Нөгөө талаас Ерөнхий зөвлөлийн даргыг Парламентаас томилох тохиолдолд олонхи болсон намын “санал”-аар тухайн нэр дэвшигч томилогдох бөгөөд энэ байдал нь эргээд шүүх эрх мэдэл улс төржих, шүүхүүд улс төрийн шийдэлтэй шийдвэр гаргахад хүргэхэд сөрөг талтай юм.

* * *

Дүгнэлт

Гадаадын зарим орны Шүүхийн ерөнхий зөвлөлтэй ижил төстэй зөвлөл, хороо, комиссийн даргыг томилох асуудлыг өөр өөрийн онцлогоор зохицуулсан байна. ОХУ-д Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн газрын захирлыг манайтай адил Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь албан тушаалаараа байдаг, Сингапур Улсын хувьд шүүгчдийг томилох хугацаа зэрэг асуудлыг Ерөнхий шүүгчийнх нь даргалсан Хууль зүйн албаны комисс хариуцдаг бол Турк Улсад Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны дарга нь Хууль зүйн сайд, Израиль Улсад мөн адил шүүгчдийг томилох хороог Хууль зүйн сайд нь албан тушаалын хувьд даргалдаг байна.

Өнөөгийн манай эрх зүйн зохицуулалтын хувьд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч албан тушаалаараа шууд хариуцаж байгаа нь шүүгч шүүгчээсээ буюу дотоод хараат бус байдлыг алдагдуулсан гэж шүүмжилдэг ч энэхүү шүүмжлэлээс зайлсхийх хэд хэдэн хувилбар байдаг. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Ерөнхийлөгч томилох, Парламентаас томилох эсхүл бүх шүүгчдийн хурлаас сонгох гэх мэт. Энэхүү судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн өнөөгийн эрх зүйн зохицуулалт, удирдлагын хувьд авч үзсэн бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, удирдлага, бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

* * *

Ашигласан эх сурвалж

1. Б. Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, Хоёрдугаар дэвтэр, УБ., 2004 он
2. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Ханнс - Зайделийн сан, Эрх зүйн боловсролын академи, УБ., 2009 он
3. ОХУ -ын Дээд шүүхийн дэргэдэх шүүхийн газрын тухай Холбооны хууль, 1998 он
4. <http://www.hsyk.gov.tr>
5. <http://www.mevzuat.adalet.gov.tr>
6. Н. Лүндэндорж, “Шүүх эрх мэдлийн хямрал” нийтлэл, “Либерти” сэтгүүлийн №2
7. Нээлттэй нийгэм форум, “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”, УБ хот., 2009 он
8. Хууль зүйн үндэсний төв. “Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо” УБ хот., 2005 он



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Ш. Хишигсүрэн, Ц. Түвшинзаяа

АГУУЛГА

Нэг. Монгол Улсын Их Хурлын Байнгын болон дэд, түр хороодын талаархи хууль тогтоомжийн харьцуулалт

- 1.1 Байнгын хорооны үндсэн бүрэн эрхийн талаархи харьцуулалт
- 1.2 Байнгын хорооны бүрэн эрхийн талаархи харьцуулалт
- 1.3 Байнгын хороодын талаархи харьцуулалт
- 1.4 Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын талаархи харьцуулалт
- 1.5 Дэд хорооны талаархи харьцуулалт
- 1.6 Түр хорооны талаархи харьцуулалт

Хоёр. Монгол Улсын Их Хурал дах нам, эвслийн бүлэг, олонхи, цөөнхийн асуудлын талаархи зохицуулалт

- 1.1 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зохицуулалт
- 1.2 Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн эрх зүйн зохицуулалт
- 1.3 Бусад хууль тогтоомжийн харьцуулалт

* * *

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД, ТҮР ХОРООДЫН ТАЛААРХИ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Байнгын хорооны үндсэн бүрэн эрхийн талаархи харьцуулалт:

Парламентын байнгын хороо нь аливаа нэг асуудлыг Парламентын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө хэлэлцэн боловсронгуй болгодог парламентын зохион байгуулалт юм. Байнгын хороо өөрт нь шилжүүлсэн ажлаар дүгнэлт гаргадаг байна. Парламентын байнгын хороо нь парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр мөн ба, Байнгын хорооны нийтлэг чиг үүрэг нь нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал боловсруулах, хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг, сонсгол явуулж, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, эрхлэх асуудлынхаа хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэх юм.

Францад Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслийг Парламентын байнгын хороо буюу комисс хянан үзээд завсарлаж дараа нь ассамблейн буюу парламентынхаа хуралдаанд оруулдаг байсныг 1958 оны Үндсэн хуулиараа цэгцэлж, эх хувилбараар нь хэлэлцүүлдэг болсон байна. Өөрөөр хэлбэл, Францын парламентын байнгын хороо нь Засгийн газрынхаа өргөн барьсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийдэггүй бөгөөд анхны хэлэлцүүлгийг парламентын нэгдсэн хуралдаанаар шууд хийдэг болж өөрчлөгдсөн байна. БНТурк Улсын парламентын байнгын хороо буюу комиссууд нь өөрт нь шилжүүлсэн хуулийн төслийг шууд болон өөрчлөн хүлээн авах эсхүл буцаадаг байна.

Комиссууд нь өөр өөрийн асуудыг нэгтгэн хэлэлцэж болох ба парламентынхаа байранд хуралддаг байна. Парламентын байнгын хороо буюу комисс хууль санаачилдаггүй гэж үздэг. Гэхдээ АНУ-ын Конгрессын байнгын хороод хууль санаачлагчийн зөвшөөрөлгүй

хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байдаг байна²⁵. Ерөнхийдөө Парламентын байнгын хороо нь парламентад өргөн барьсан хууль, бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахаас бус хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй байдаг байна.

Байнгын хороо буюу парламентын комисс нь Парламентын чуулганаар хэлэлцэх хуулийн төсөл, саналыг судлах, нийтийн хэлэлцүүлгийг бэлтгэх тухайд Британий болон Францын уламжлалт гэсэн хоёр тогтолцоо байдаг бөгөөд Британий тогтолцоонд төрөлжсөн Байнгын хороо байдаггүй ба төрөл бүрийн асуудлаар түр хороо байгуулдаг байна²⁶. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо нь төрөлжсөн байнгын хороотой бөгөөд Байнгын хороодын хугацаа нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаатайгаа адил байдаг. Ихэнхи улс орны парламентын байнгын хороо танхимын чуулганы хуралдааны үеээр зохион байгуулагдан ажиллаж, дараагийн чуулган дээр дахин шинээр байгуулагддаг байна²⁷.

Зарим улс оронд /Франц, Норвеги зэрэг/ парламентын гишүүн зөвхөн нэг байнгын хорооны гишүүн байх зохицуулалттай бол зарим улс орны хувьд парламентын гишүүн нь нэгэн зэрэг хэд хэдэн байнгын хорооны гишүүн байхаар зохицуулсан байна. Францын Үндсэн хуулинд Үндэсний ассамблей нь 6 Байнгын хороотой байхаар заасан бол Турк Улс Үндэсний Их Хурлын дэгээр 16 үндсэн Байнгын хороотой байхаар заасан байна. Манай улсын хувьд 2006 оны Улсын Их Хурлын тухай хуульд 7 Байнгын хороотой байхаар зохицуулсан байна. 1990 оноос өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль тогтоомжийн хүрээнд Улсын Их Хурлын Байнгын хорооны үндсэн бүрэн эрхийг харьцуулбал:



²⁵ Д. Лүндээжанцан, Л. Өлзийсайхан, “Парламентын ёс” Улаанбаатар хот - 2005, 101 дэх тал.

²⁶ М.ДЮВЕРЖЕ, “Улс төрийн байгууламж Үндсэн хуулийн эрх зүй”, Улаанбаатар хот 2007, 465 дахь тал. Франц Улсын Үндэсний ассамблейн Байнгын хороотой холбоотой мэдээллийг уг номоос авсан тул цаашид эшлэл хийх шаардлагагүй гэж үзлээ.

²⁷ Д. Лүндээжанцан, Л. Өлзийсайхан, “Парламентын ёс” Улаанбаатар хот-2005, 101 дэх тал.

Монгол Улсын Бага Хурлын тухай хууль	Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/ Монгол	Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/	Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/	Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/	Улсын Их Хурлын тухай хууль өргөн барьсан төсөл/
15 дугаар зүйл. Улсын Бага Хурлын байнгын хороо 1.Улсын Бага Хурлын байнгын хороо /цаашид байнгын хороо гэх/ нь Улсын Бага Хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангах, түүний шийдвэрлэх асуудлаар бодлого боловсруулах, санал, дүгнэлт гаргах түүнчлэн тус тусын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Бага Хурлын хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилго бүхий ажлын байгууллага мөн. 17 дугаар зүйл. Байнгын хорооны үндсэн бүрэн эрх Байнгын хороо эрхлэх ажлынхаа хүрээнд дор дурдсан үндсэн бүрэн эрх эдэлнэ. 1.хууль санаачлах 2.Улсын Бага Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар санал өгөх, дүгнэлт гаргах 3.БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг шалгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах 4.шаардлагатай гэж үзвэл саналаа БНМАУ-ын Засгийн газарт оруулах, БНМАУ-ын Засгийн газрын гишүүд БНМАУ-ын Ардын Их Хурлаас байгуулагддаг бусад байгууллагын удирдах албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, тэдэнд асуулга асуулт тавих бөгөөд асуулгын хариуг 30 хоногийн дотор бичгээр шаардан авах, энэ талаар гарсан маргааныг Улсын Бага Хурлаар шийдвэрлүүлэх.	13 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц, бүрэлдэхүүн 1.Улсын Их Хурлын Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	12 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц 1.Улсын Их Хурлын Байнгын хороо / цаашид “Байнгын хороо” гэх/ нь Улсын Их Хурлын ажлын зохион байгуулалтын хэлбэр мөн. Байнгын хороо нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.	16 дугаар зүйл.Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц 16.1.Улсын Их Хурлын Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр мөн. Байнгын хороо нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.	19 дүгээр зүйл. Байнгын хороо 19.1.Байнгын хороо нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана.	16 дугаар зүйл. Байнгын хороо

ДҮГНЭЛТ

Улсын Бага Хурлын Байнгын хорооны үндсэн бүрэн эрх нь нэлээд өргөн агуулгатай байсан байна. Тухайлбал, Улсын Бага Хурлын Байнгын хороо хууль санаачлах бүрэн эрхтэйг хуулиар тогтоож өгч байсан бол Улсын Их Хурлын Байнгын хороо нь хууль санаачлах бүрэн эрхгүй юм. 1990 оны Улсын Бага Хурлын Байнгын хороог УБХ-ын тасралтгүй ажиллагааг хангах тодорхой зорилго бүхий ажлын байгууллага гэж тодорхойлж байсан бол 1992 онд Үндсэн хууль батлагдан гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын тухай хуулийг баталж гаргасан. Улсын Их Хурлын тухай 1992 оны хуульд Байнгын хороо нь чуулганаар хэлэлцэх асуудлыг боловсруулах, санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хянан шалгах гэсэн үндсэн гурван бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Гэвч дээрх байдлаас дүгнэхэд Улсын Их Хурлын тухай хуулиудад Байнгын хорооны чуулганаар хэлэлцэх асуудлыг боловсруулах, санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хянан шалгах гэсэн үндсэн гурван бүрэн эрхийг агуулгын хувьд төстэй боловч томъёолол нь өөрчлөгдөн гарсан байна.

Байнгын хорооны үндсэн гурван бүрэн эрхийн томъёолол нь өөр өөр байгаа нь тус бүрэн эрхийн үйлчлэх цар хүрээг мөн тодруулж байна. Тухайлбал, 1992 оны Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороо нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах бүрэн эрхтэй байсан бол 2006 оны Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороо нь эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах гэж томъёологдсон байгаагийн нэг нь асуудал боловсруулах бүрэн эрхийг илэрхийлж байхад /1992 оны Улсын Их Хурлын тухай хууль/ нөгөө зөвхөн төрийн бодлого, УИХ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах бүрэн эрх болж томъёологдож УИХ-ын Байнгын хорооны бодлого боловсруулах бүрэн эрх /2006 оны Улсын Их Хурлын тухай хууль/ явцуу утгатай болж өөрчлөгдөж байсан байна.

Харин Хуулийн төсөлд уг бүрэн эрх засгийн бодлогыг боловсронгуй болгох санал боловсруулах болон өөрчлөгдсөн байна. Нөгөө талаас Улсын Их Хурлын Байнгын хорооны үндсэн бүрэн эрхийг дээрх хуулиадад янз бүрээр илэрхийлсэн байна. Тухайлбал, бүрэн эрх, үүрэг, чиг үүрэг, нийтлэг чиг үүрэгтэй гэх мэт эдгээрийг нэг мөр болгож хэрэглэх шаардлагатай байна.

Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргахгүйгээр шууд нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлах нь Үндсэн хууль зөрчсөн асуудал мөн эсэх өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах Үндсэн хуулийн шаардлага мөн эсэх талаар тодорхойгүй байна. Улсын Их Хурлаас хяналт шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ 1996-2009 оны /хаврын чуулганы/ байдлаар нийт 244 ажлын хэсэг байгуулж ажилласнаас 211 нь Улсын Их Хурлын Байнгын хороодын тогтоолоор байгуулж ажиллаж байсан байна²⁸. Үүнээс үзэхэд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг Байнгын хороод ихэвчлэн хэрэгжүүлсэн байна.

Одоогоор өргөн барьсан Улсын Их Хурлын тухай хуулийн төсөлд Өргөдлийн Байнгын хороог тусгайлан авч үзсэн бөгөөд өргөдлийн байнгын хороо нь иргэдээс Улсын Их Хуралд гаргасан өргөдлийг хянан шинжиж, шийдвэрлэх үүрэгтэйгээр ажиллахаар заасан байна. Хуулийн төсөлд зөвхөн иргэдээс ирсэн өргөдлийг хянан шалгахгаар заасан бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан өргөдлийг Улсын Их Хурлын өргөдлийн Байнгын хороонд хамаарахгүйгээр ойлгогдож байна.

²⁸ “УИХ-ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи статистик мэдээлэл” УИХ-ын ТГ-ын СШОНХТ. 2009 он, 3 дахь тал.

2. Байнгын хорооны бүрэн эрхийн талаархи харьцуулалт:

1. Монгол Улсын Бага Хурлын тухай хууль
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)

БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН БАЙНГЫН **ХОРООНЫ ДҮРЭМ** / БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 15 дугаар тогтоолын хавсралт/

(2)

1992 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хорооны үндсэн бүрэн эрх гэж заасан бөгөөд түүнчлэн Улсын Их Хурлын 1993 оны 73 дугаар тогтоолоор Байнгын хорооны дүрмийг батлаж, Байнгын хорооны тодорхой бүрэн эрхийг уг дүрэмд тусгасан байна.

(6)

Байнгын хороог Өргөдлийн, Бодлогын гэж ялгаж өөр өөр тодорхой бүрэн эрхтэй байхаар хуулийн төсөлд заасан байна.

(1)

7 дугаар зүйл. Байнгын хороо нь Улсын Бага Хурлын хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэхэд ажлаа бүрэн чиглүүлж дор дурдсан үндсэн үүрэг гүйцэтгэнэ:

- 1/ Улсын Бага Хурлын чуулган, түүний хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;
- 2/ Улсын Бага Хурлаар хянан хэлэлцэх хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг боловсруулах;
- 3/ Улсын Бага Хурлаар хянан хэлэлцэх хууль, тогтоолын төсөл болон бусад асуудлыг судалж өөрийн дүгнэлт, саналыг гаргах;
- 4/ БНМАУ-ын хууль, Ардын Их Хурлын тогтоол, Улсын Бага Хурлын тогтоол болон бусад шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч, шалгаж дүгнэх;
- 5/ иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хянан үзэж шийдвэрлэх талаар арга хэмжээ авах.

8 дугаар зүйл. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлаар дор дурдсан эрх эдэлнэ:

- 1/ Улсын Бага Хурлаас батлагддаг албан тушаалтнуудыг сонгох, томилох, чөлөөлөх тухай саналаа Улсын Бага Хуралд оруулах;
- 2/ Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн дарга, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын дэргэдэх тусгай газрын дарга, орон нутгийн хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны даргын илтгэл, сонсголыг хэлэлцэх, тэдэнд асуулга тавих;
- 3/ байгууллага, иргэдээс Улсын Бага Хуралд ирүүлсэн хуулийн төсөл болон бусад асуудлыг хянан үзэж Улсын Бага Хуралд хэлэлцүүлэхээр оруулах;
- 4/ БНМАУ -ын хууль, Ардын Их Хурлын тогтоол, Улсын Бага Хурлын тогтоол болон бусад шийдвэрийн биелэлтийг дангаараа буюу мэргэжлийн байгууллагыг таран оролцуулж хянан шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд гэм буруутай этгээдийг хариуцлага хүлээлгэхээр зохих байгууллагад шилжүүлэх;
- 5/ өөрийн эрхлэх асуудалд шаардагдах судалгаа, тайлан мэдээ, тодорхойлолт зэрэг баримт бичгийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- 6/асуудлыг шалган судлах, сайтар бэлтгэх зорилгоор холбогдох байгууллагын

ажилтан болон эрдэмтэн, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсгийг дэргэдээ байгуулах.

(2)

14. дүгээр зүйл. Байнгын хорооны үндсэн бүрэн эрх 1.Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлаар дараахь үндсэн бүрэн эрхтэй:

- 1/Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн болон бусад шийдвэрийн төсөл, эрх бүхий байгууллагаас чуулганд хэлэлцүүлэхээр оруулж буй аливаа асуудлаар санал, дүгнэлт гаргах,
- 2/Улсын Их Хуралд санал, дүгнэлт оруулах, илтгэл, хавсралт илтгэл тавих,
- 3/Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг шаардлага хангаагүй гэж үзвэл чуулганы хуралдаанд оруулахгүй зохих үндэслэлээ зааж, гүйцээн
- Улсын Их Хурлын Байнгын хорооны үндсэн болон тодорхой бүрэн эрх
- 8 дугаар зүйл. Байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн бүрэн эрхээс гадна тус тусын эрхлэх асуудлаар дараахь тодорхой бүрэн эрх эдэлнэ:
- 1/салбарын төрийн бодлогын чиглэлийг тодорхойлох;
- 2/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах. Энэ зорилгоор ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- 3/улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт санал, дүгнэлт өгөх;
- 4/улсын төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөх;
- 5/Ерөнхийлөгчийн хоригийг урьдчилан хэлэлцэж, саналаа Улсын Их Хуралд оруулах;
- 6/Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг урьдчилан хэлэлцэж саналаа Улсын Их Хуралд оруулах;
- 7/ард нийтийн санал асуулга явуулах тухай саналыг Улсын Их Хуралд оруулах;
- 8/эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлаас томилогддог, сонгогдсон албан тушаалтны илтгэл, сонсголыг авч хэлэлцэх, мөн тэдгээрийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах;
- 9/хууль, Улсын Их Хурлын болон бусад шийдвэрийн биелэлтийг дангаараа буюу мэргэжлийн байгууллагыг татан оролцуулж хянан шалгах. боловсруулахаар буцаах,
- 4/Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Засгийн газарт санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэх талаар шаардлага тавих,
- 5/Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг хянан шалгах,
- 6/Засгийн газар, түүний гишүүн Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагын эрх баригчдын мэдээлэл сонсож хэлэлцэх, тэдэнд асуулт, асуулга тавьж, хариулж авах,
- 7/Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний

мэдээллийг сонсох,

- 8/Хуулийн төслийн талаар мэргэжлийн олон нийтийн санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.
- 2.Байнгын хорооны чиг үүрэг, тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДҮРЭМ /Монгол Улсын Их Хурлын 1993 оны 73 дугаар тогтоолын хавсралт/ Хоёрдугаар бүлэг

(3)

- 13 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэн эрх, эрхлэх асуудал
- 1.Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхтэй:
- 1/Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;
- 2/Улсын Их Хурлаар хэлэлцэх тодорхой асуудлуудаар санал, дүгнэлт гаргах;
- 3/Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэх талаар шаардлага тавих;
- 4/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;
- 5/Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагын эрх баригчдын мэдээллийг сонсож хэлэлцэх, асуулт, асуулга тавьж, хариулт авах, тэднийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах;
- 6/Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;
- 7/Улсын Их Хурлаас тавих хяналтыг хэрэгжүүлэх, хуулийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах зорилгоор мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

(4)

17 дугаар зүйл.Байнгын хорооны бүрэн эрх, эрхлэх асуудал

- 17.1. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхтэй:
- 17.1.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийн талаар санал дүгнэлт гаргах;
- 17.1.2. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлуудаар санал дүгнэлт гаргах;
- 17.1.3. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар санал дүгнэлт гаргах;
- 17.1.4. Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэхийг шаардах;

- 17.1.5.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;
- 17.1.6.Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх, тэднийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах;
- 17.1.7.Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, санал дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;
- 17.1.8.Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын хэсэг байгуулж ажиллуулах;
- 17.1.9.Улсын Их Хурлын хууль, бусад шийдвэрийн төслийн талаар санал дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

(5)

19 дүгээр зүйл. Байнгын хороо

- 19.2. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 19.2.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;
- 19.2.2.нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах;
- 19.2.3.Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар санал, дүгнэлт гаргах;
- 19.2.4.Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-т санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэхийг шаардах;
- 19.2.5.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;
- 19.2.6.Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх, тэднийг томилох, сонгох, чөлөөлөх, огцруулах тухай санал, дүгнэлт гаргах;
- 19.2.7.чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, санал, дүгнэлт зэрэг баримт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;
- 19.2.8.Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- 19.2.9.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- 19.2.10.Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар гишүүд болон Байнгын хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хуралдаанаараа хэлэлцэх;

- 19.2.11.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын гаргасан эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах.

(6)

18 дугаар зүйл. Бодлогын байнгын хороо, түүний бүрэн эрх

- 18.3.Бодлогын байнгын хороод тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 18.3.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах;
- 18.3.2.нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах;
- 18.3.3.Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар санал, дүгнэлт гаргах;
- 18.3.4.Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/, засаг захиргааны байгууллагад санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелүүлэлтийг хянах;
- 18.3.5.Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллага, тэдгээрийн удирдлагын тайлан, мэдээллийг сонсож хэлэлцэх, тэднийг томилох, чөлөөлөх, огцруулах тухай санал, дүгнэлт гаргах;
- 18.3.6.чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, санал, дүгнэлт зэрэг баримт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;
- 18.3.7.Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
- 18.3.8.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах, нийтийн хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулах;
- 18.3.9.Өргөдлийн байнгын хорооноос шилжүүлсэн өргөдлийг хуралдаанаар хэлэлцэж нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлт оруулах.

17 дугаар зүйл. Өргөдлийн байнгын хорооны бүрэн эрх

- 17.1.Өргөдлийн байнгын хороо Улсын Их Хуралд гаргасан иргэдийн өргөдлийг хянан шинжиж, шийдвэрлэхдээ Засгийн газар болон засаг захиргааны байгууллагуудаас бичиг баримтуудыг гаргуулж авах, мэдээллээр хангуулах, тэдгээрийн байр, байгууламжид нэвтрэх эрхтэй.
- 17.2.Энэ хуулийн 17.1 дэх заалт нь Засгийн газрын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч болох нийтийн эрх зүйн байгууллагууд, сангууд, улсын өмчийн үйлдвэрийн газруудад нэгэн адил үйлчилнэ.
- 17.3.Бичиг баримтуудыг гаргаж өгөх, мэдээллээр хангах, өөрийн байр, байгууламжид нэвтрүүлэхээс зөвхөн хуульд заасан нууцтай холбоотой тохиолдолд татгалзахыг зөвшөөрнө.
- 17.4.Татгалзсан шийдвэрийг салбар хариуцсан засгийн газрын гишүүн гаргах ба шийдвэрийн үндэслэлийг заавал тусгасан байна.
- 17.5.Өргөдлийн байнгын хороо нь өргөдөл гаргагч, гэрч мөн шинжээчийг сонсгох эрхтэй.
- 17.6.Байнгын хороо дуудагдсан өргөдөл гаргагч, гэрч болон шинжээчид урамшуулал өгч болно.
- 17.7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу

Өргөдлийн байнгын хороо нь тодорхой тохиолдолд энэ хуулиар өөрт олгогдсон бүрэн эрхээ нэг болон хэд хэдэн гишүүндээ шилжүүлж болно.

ДҮГНЭЛТ

Улсын Бага Хурлын болон 1992 оны Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хорооны үндсэн бүрэн эрх гэж заасан бөгөөд харин Улсын Их Хурлын Байнгын хорооны дүрмийг тогтоолоор батлаж, Байнгын хорооны тодорхой бүрэн эрхийг уг дүрэмд тусгасан байна. Өөрөөр хэлбэл, 1992 оны Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд Байнгын хорооны чиг үүрэг, тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу 1993 оны Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын Байнгын хорооны дүрмийг баталсан байна. Харин 1997, 2001, 2006 оны Улсын Их Хурлын хуульд болон хуулийн төсөлд Байнгын хорооны чиг үүрэг тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тусгайлан тогтоогоогүй байдаг.

Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно гэж заасан байдаг. Үндсэн хуулийн уг заалт нь Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал сонголттой /алтернатив/ хэлбэрээр тогтоох боломжийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Парламентын Байнгын хороо нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулах, Парламентын хяналтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллахыг 1992, 1997, 2001, 2006 болон Хуулийн төсөлд заасан байна. Гэвч эдгээр хуулиудад Байнгын хорооны үндсэн 3 бүрэн эрхийг нарийвчлан тодорхой бүрэн эрхийг тусгайлан заасан.

Байнгын хорооны тодорхой бүрэн эрхийг хуулиудад төстэй хэлбэрээр заасан байна. Тухайлбал, ямар асуудлаар санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын шийдвэрийг биелүүлэхийг шаардах, санал, оруулах, асуулт, асуулга тавьж, хариулт авах, тодорхой албан тушаалтны мэдээллийг сонсох, ажлын хэсэг байгуулж ажиллуулах, холбогдох байгууллагад тавих хяналтыг хэрэгжүүлэх, баримт сэлт, мэдээлэл гаргуулах авах зэрэг бүрэн эрхийг өөр хоорондоо ижил утга санаатайгаар зохицуулсан байна. Харин 2006 оны буюу өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороо нь Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын гаргасан эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах гэж оруулсан байна. Гэвч энэ зохицуулалт нь нэлээд маргаантай асуудлыг бий болгох боломжтой гэж үзэж байна.

1992 оны Улсын Их Хурлын Байнгын хороо нь ард нийтийн санал асуулга явуулах тухай саналыг Улсын Их Хуралд оруулах бүрэн эрхтэй байсан байна. Хуулийн төсөлд тусгайлан бий болгосон Өргөдлийн байнгын хороо нь Улсын Их Хуралд гаргасан иргэдийн өргөдлийг хянан шинжиж, шийдвэрлэхдээ Засгийн газар болон засаг захиргааны байгууллагуудаас бичиг баримтуудыг гаргуулж авах, мэдээллээр хангуулах, тэдгээрийн байр, байгууламжид нэвтрэх, өргөдөл гаргагч, гэрч мөн шинжээчийг сонсох, хороо дуудагдсан өргөдөл гаргагч, гэрч болон шинжээчид урамшуулал өгч болох зэрэг бүрэн эрхтэй байхаар зохицуулсан байна. Мөн түүнчлэн дээрх Улсын Их Хурлын тухай хуулиад, Байнгын хорооны дүрэмд Байнгын хорооны тодорхой бүрэн эрхийг тусгайлан зохицуулсанаас гадна Байнгын хороо бүрийн эрхлэх асуудлыг хүрээг тодорхой заасан байдаг.

БНТурк Улсын Үндэсний Их Хурлын дотоод дэг /1973 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 584 дугаар тогтоолоор баталсан/-д парламентын байнгын хороодыг дурдсан байдаг

бөгөөд үндсэн болон тодорхой бүрэн эрх гэж тусгайлан зохицуулалт байдаггүй байна. Харин уг дэгийн 35 дугаар зүйлд “Байнгын хороод өөрт нь шилжүүлсэн хуулийн төсөл, эсхүл саналыг байгаагаар нь, эсхүл өөрчлөн, эсхүл үл хүлээн авч болно. Өөр хоорондоо холбоотой гэж үзсэн асуудлыг нэгтгэн хэлэлцэж болно” гэж заасан байна. Үүнээс үзэхэд Туркийн парламентын Байнгын хорооны бүрэн эрх нь манай Байнгын хорооны бүрэн эрхтэй харьцуулахад товч байна гэж үзэж болно.

Харин Туркийн парламентын дотоод дэгийн 38 дугаар зүйлд “Байнгын хороо өөрт нь шилжүүлсэн хуулийн төсөл эсхүл саналыг хамгийн түрүүнд Үндсэн хуулийн бичвэр болон амин сүнстэй зөрчиж байгаа эсэхийг шалгах үүрэгтэй бөгөөд хороо хуулийн төсөл, саналыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл үндэслэлээ тогтоон зүйл ангийг хэлэлцүүлэгт оруулалгүй үл хүлээн авна” гэж заасан. Үүнээс санаа авахад Улсын Их Хурлын Байнгын хороо хуулийн төслийг анхлан Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шалгасны дараа хэлэлцэж санал, дүгнэлт гарах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зааж өгвөл хууль Үндсэн хууль зөрчих явдал багасана гэж үзэж байна.

3. Байнгын хороодын талаархи харьцуулалт:

1. Монгол Улсын Бага Хурлын тухай хууль
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)

Улсын Бага Хурлын 1991 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тогтоолоор БНМАУ-ын Бага Хурлын Байнгын хорооны дүрэмд Улсын Бага Хурал 5 байнгын хороотой байхаар заасан байна. Эдгээр нь:

- 1.Төрийн байгуулалтын байнгын хороо,
- 2.Хууль зүйн байнгын хороо,
- 3.Эдийн засгийн байнгын хороо,
- 4.Нийгмийн бодлогын байнгын хороо,
- 5.Эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын асуудлын байнгын хороо.

(2)

13 дугаар зүйл: Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

- 2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр байгуулах ба нийт 10 Байнгын хороотой байхаар хуульд заасан байна.:
- 1.Байгаль орчныг хамгаалах,
- 2.Боловсрол, шинжлэх ухаан, соёлын,
- 3.Гадаад бодлого, аюулгүй байдлын,
- 4.Дотоод асуудлын,
- 5.Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын,
- 6.Хурал, захиргааны,
- 7.Хууль зүйн,
- 8.Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн,
- 9.Хүнс, хөдөө аж ахуйн,
- 10.Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын гэсэн байнгын хороо.

(3)

12 дугаар зүйл: Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц

- 2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:
 1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
 2. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн;
 3. Нийгмийн бодлогын;
 4. Төрийн байгуулалтын;
 5. Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын;
 6. Хууль зүйн
 7. Эдийн засгийн

(4)

2001 оны Улсын Их Хурлын тухай хуулиар анх Улсын Их Хурал Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 7 Байнгын хороотой байсан бөгөөд 2004 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар дараахь Байнгын хороодтой болсон байна. 16 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц 16.2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
2. Байгаль орчны;
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны;
4. Дэд бүтцийн;
5. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн;
6. Нийгмийн бодлогын;
7. Төрийн байгуулалтын;
8. Төсвийн;
9. Хууль зүйн;
10. Хүнс, хөдөө аж ахуйн;
11. Эдийн засгийн.

2001 оны Улсын Их Хурлын тухай хуулиар анх Улсын Их Хурал Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 7 Байнгын хороотой байсан бөгөөд 2004 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар дараахь Байнгын хороодтой болсон байна.

16 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц. 16.2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
2. Байгаль орчны;
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны;
4. Дэд бүтцийн;
5. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн;
6. Нийгмийн бодлогын;

7. Төрийн байгуулалтын;
8. Төсвийн;
9. Хууль зүйн;
10. Хүнс, хөдөө аж ахуйн;
11. Эдийн засгийн.

(5)

19 дүгээр зүйл. Байнгын хороо

19.3. Байнгын хороог төрийн бодлогын салбар, чиглэлээр гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;
4. Төрийн байгуулалтын;
5. Төсвийн;
6. Хууль зүйн;
7. Эдийн засгийн.

(6)

16 дугаар зүйл. Байнгын хороо

16.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 1-д заасны дагуу Улсын Их Хурал нь өөрийн үйл ажиллагааны зохих салбар, чиглэлээр өргөдлийн болон бодлогын байнгын хороодтой байна. 17 дугаар зүйл. Өргөдлийн байнгын хорооны бүрэн эрх 17.1.Өргөдлийн байнгын хороо 18 дугаар зүйл. Бодлогын байнгын хороо, түүний бүрэн эрх 18.1.Улсын Их Хурал дараахь Бодлогын байнгын хороодтой байна:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын;
2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;
4. Төрийн байгуулалтын;
5. Төсвийн;
6. Хууль зүйн;
7. Эдийн засгийн.

* * *

ДҮГНЭЛТ:

Парламентын Байнгын хороог ихэвчлэн яамдын салбар, чиглэлтэй параллель байхаар зохицуулдаг байна. Тухайлбал, ХБНГерман Улсын Парламент болох Бундестаг нь Байнгын хороогоо Засгийн газрын бүтэцтэй параллель хэлбэрээр байгуулдаг²⁹. Өнөөг хүртэл Улсын Их Хурлын Байнгын хороодын тоо харилцан адилгүй байсан байна. Түүнчлэн Байнгын хороодын гишүүний бүрэлдэхүүний тоо ч бас адилгүй байсан нь харагдаж байна. Харин 2006 оны Улсын Их Хурлын тухай хууль болон 2009 оны 11 дүгээр сард өргөн баригдсан Улсын Их Хурлын тухай хуулийн төсөлд Байнгын хороог 17-21 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар зохицуулсан байна. 1997 оны Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хороондын бүрэлдэхүүний тоог заагаагүй бөгөөд Хууль зүйн байнгын хороо-14,

²⁹ http://www.bundestag.de/htdocs_e/bundestag/committees/function.html /2009 оны 12 дугаар сарын 16-ны өдөр татсан мэдээлэл/

Эдийн засгийн байнгын хороо - 28 гэх мэт гишүүний бүрэлдэхүүнтэй хэт харилцан адилгүй байсан байна.

Франц Улсын Үндсэн хуульд Үндэсний Ассамблейн 6 Байнгын хороотой байхаар хязгаарласан бол, Туркийн Үндэсний Их Хурлын дотоод дэгт 16 Байнгын хороотой, Германы Бундестаг 22 Байнгын хороо³⁰-той байна. Харин Франц Улсын Байнгын хороод 60, 90, 120 гишүүний бүрэлдэхүүнтэй байдаг бөгөөд энэ нь нэг байдлаараа Парламент доторхи жижиг парламент гэсэн байдлыг бий болгодог байна.

Германы Парламент Байнгын хороодын тоогоо сонгууль болгоноор өөрчлөх боломжтой гэж үздэг байна. Тухайлбал, Германы парламент болох Бундестагийн анхны сонгуулийн дараа 40 Байнгын хороо байсан бол Бундестагийн 6 дахь сонгуулийн дараа зөвхөн 17 Байнгын хороо байгуулж байсан байна³¹. Өнөөгийн Бундестаг нь 16 дахь сонгуулиар сонгогдсон бөгөөд Байнгын хорооны гишүүний бүрэлдэхүүний тогтоохдоо Бундестагд суудал авсан намын гишүүдийн хувиар тооцож тогтоодог байна. Өнөөгийн байдлаар Бундестагийн Байнгын хороод 13-41 гишүүнээс бүрдэж байна.

Улс орны парламентын байнгын хороодын тоо болон гишүүний бүрэлдэхүүн харилцан адилгүй байдаг байна. Иймд Улсын Их Хурлын Байнгын хороодын тоо, гишүүний бүрэлдэхүүний тоог тухайн үеийн нөхцөл байдлыг харгазлан уян хатан байхаар зохицуулах боломжтой бол Франц Улсын адил хатуу тогтоох ч боломж байна гэж үзэж байна.

4. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын талаархи харьцуулалт:

1. Монгол Улсын Бага Хурлын тухай хууль болон Байнгын хорооны дүрэм
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)

Байнгын хорооны ажлын зохион байгуулалт. Дүрмийн 14 дүгээр зүйл.

- Байнгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Гишүүдийн олонхи нь ирснээр Байнгын хорооны хуралдаан хүчин төгөлдөр болно. Байнгын хорооны дарга, гишүүд хуралдаанд таслах эрхтэй оролцоно.
- Хуралдааныг сард хоёроос доошгүй удаа хийх бөгөөд шаардлагатай гэсэн тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн олонхи нь хүсвэл, эсхүл Байнгын хорооны даргын саналаар хуралдааныг зарлан хуралдуулж болно.
- Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал нийлээгүй гишүүн саналаа Улсын Бага Хурлын чуулганд танилцуулах эрхтэй.
- Байнгын хорооны хуралдааны явц болон гаргасан шийдвэрийг протоколд тэмдэглэнэ. Байнгын хороо шаардлагатай асуудлаар тогтоол гаргана.
- Байнгын хорооны хуралдааны талаарх бусад асуудлыг БНМАУ-ын Бага Хурлын үйл

³⁰ http://www.bundestag.de/htdocs_e/bundestag/committees/index.html /2009 оны 12 дугаар сарын 16-ны өдөр татсан мэдээлэл/

³¹ http://www.bundestag.de/htdocs_e/bundestag/committees/function.html /2009 оны 12 дугаар сарын 16-ны өдөр татсан мэдээлэл/

ажиллагааны дэгд заасны дагуу зохицуулна.

- 15 дугаар зүйл. Байнгын хороо хэтийн болон жилийн төлөвлөгөөтэй ажиллана. Хэтийн төлөвлөгөөг Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаагаар хийнэ. Хэтийн болон жилийн төлөвлөгөөг Байнгын хорооны хуралдаанаар батална.

(2)

15 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

- 1.Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.
- 2.Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг Байнгын хорооны бүх гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр тооцно.
- 4.Байнгын хороо шийдвэрлэсэн асуудлаараа дүгнэлт, тогтоол гаргана
- Хуралдааныхаа явцыг протоколд нэгбүрчлэн тэмдэглэнэ.

Харин УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДҮРЭМ -д

- 24 дүгээр зүйл. Байнгын хорооны хуралдаан болох газар, цагийг 3 хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд мэдэгдэнэ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төсөл, баримт бичгийг Улсын Их Хурлын гишүүдэд дээрх хугацаанд тараана.

Дөрөвдүгээр бүлэг Их Хурлын Байнгын хорооны ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 20 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Байнгын хорооны хуралдааныг долоо хоногийн лхагва, Бямба гаригт хийнэ. Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд баасан гаригт, түүнчлэн Байнгын хорооны дарга шаардлагатай гэж үзвэл, тухайн өдрийн чуулганы хуралдааны дараа тус тус хуралдаан хийх болно. Улсын Их Хурлын даалгавраар Дотоод асуудлын байнгын хороо чуулганы үеэр хуралдаан хийж болно.
- 21 дүгээр зүйл. Хуралдааныг Байнгын хорооны даргын товлосноор хийнэ. Тухайн Байнгын хорооны гишүүдийн олонхи шаардсанаар, эсхүл Улсын Их Хурлын дарга, дэд даргын санал болгосноор Байнгын хорооны хуралдааныг хийж болно.
- 22 дугаар зүйл. Хуралдааныг Байнгын хорооны бүх гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно. Хуралдаанд тухайн Байнгын хорооны гишүүн бус Улсын Их Хурлын гишүүд зөвлөх эрхтэй оролцоно.
- 23 дугаар зүйл. Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ дүрэмд заасан Байнгын хорооны бүрэн эрхэд хамаарах асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

(3)

14 дүгээр зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

- 1.Байнгын хорооны ажлын зохионбайгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.
- 2.Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.
- 3.Байнгын хороо шийдвэрлэсэн асуудлаараа дүгнэлт, тогтоол гаргана.
- 4.Байнгын хорооны хуралдааны явцыг протоколд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

(4)

18 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

- 18.1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.
- 18.2. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.
- 18.3. Байнгын хороо нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх тодорхой асуудлыг хэлэлцэн санал дүгнэлт гаргана. Эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хороо хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаараа тогтоол гаргаж болно.
- 18.4. Байнгын хорооны хуралдааны хуваарийг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн мягмар, лхагва гаригт зохион байгуулна.
- 18.5. Байнгын хорооны хуралдааны явцыг протоколд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

(5)

21 дүгээр зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

- 21.1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 21.2. Байнгын хорооны нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 21.3. Байнгын хорооны хуралдааныг чуулганы чөлөө цагт зохион байгуулж болно.
- 21.4. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 21.5. Ажлын хэсэг байгуулах, түүнчлэн бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай бол Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд тогтоол гаргаж болно.
- 21.6. Хууль, дагаж мөрдөж байгаа журамд өөрөөр заагаагүй бол ээлжит ба ээлжит бус чуулганы хугацаанд Байнгын хорооны хуралдааныг долоо хоног бүрийн Мягмар, Лхагва гаригт зохион байгуулна.
- 21.7. Байнгын хорооны хуралдааны явцыг хуралдааны тэмдэглэлд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

(6)

21 дүгээр зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

- 21.1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 21.2. Байнгын хорооны хуралдааныг чуулганы чөлөө цагт зохион байгуулж болно.
- 21.3. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 21.4. Байнгын хорооны хуралдаан болон сонсголд төсөл санаачлагч, ажлын хэсгийн гишүүд, бие даасан шинжээч, гэрч, дуудагдсан албан тушаалтан, түүнчлэн Тамгын газар, Байнгын хорооны ажлын албаны ажилтнууд ажил, үүргийн дагуу оролцоно.

* * *

ДҮГНЭЛТ:

1992 оны Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх ба хуралдааныг Байнгын хорооны бүх гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр тооцно гэж заасан бол 1993 оны Улсын Их Хурлын Байнгын хорооны дүрмийн 22 дугаар зүйлд хуралдааныг Байнгын хорооны бүх гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцохоор Улсын Их Хурлын тухай хуулиа зөрчиж зохицуулсан байна. Түүнчлэн Хуралдаанд тухайн Байнгын хорооны гишүүн бус Улсын Их Хурлын гишүүд зөвлөх эрхтэй оролцохоор заасан байна. Харин дараа дараагийн Улсын Их Хурлын тухай хуульд тухайн Байнгын хорооны гишүүн бус Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны хуралдаанд оролцож болох эсэх талаар чимээгүй өнгөрсөн байна.

2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг ... Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулсан байна. Харин 1997 оны Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хорооны хуралдааныг нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцож, хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэдэг байсан байна.

Мөн 2009 оны 11 дүгээр сард өргөн барьсан Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлд Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж заасан бөгөөд Байнгын хорооны хуралдааны хүчин төгөлдөр байх ирцийн талаархи зохицуулалтыг заагүй байна.

Хорооны гишүүд хуралдаанд оролцох үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ тодорхой хэмжээгээр зөрчвэл хариуцлага хүлээлгэдэг систем Франц, Турк зэрэг улс оронд үйлчилдэг байна. Харин Улсын Их Хурлын тухай хууль тогтоомжид уг асуудлыг нарийвчлан тусгаагүй байна.

5. Дэд хорооны талаархи харьцуулалт:

1. Монгол Улсын Бага Хурлын тухай хууль болон Байнгын хорооны дүрэм
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)

18 дугаар зүйл. Улсын Бага Хурлын бусад байгууллага

- Улсын Бага Хурал ажлынхаа шаардлагыг харгалзан түр, дэд хороо, ажлын хэсэг байгуулж тэдгээрийн эрх, үүрэг үйл ажиллагааны журмыг тогтоож болно.
- Дүрмийн 2 дугаар зүйл. Байнгын хорооноос гадна түр хороо, дэд хороог Улсын Бага Хурлаас тухайн үед нь шийдвэр гарган байгуулж болно.

(2)

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

- 5. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны дотор дэд хороо байгуулж болно. Дэд хороо нь харьяалах Байнгын хорооныхоо үйл ажиллагааны тодорхой

чиглэлийг эрхлэн хариуцаж, туслах үүрэгтэй байна. Дэд хороо нь эрх хэмжээнийхээ хүрээнд хамаарах асуудлыг зөвхөн Байнгын хороондоо хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй бөгөөд Улсын Их Хуралд тухайн асуудлыг уул Байнгын хороогоор уламжлан оруулна.

(3)

15 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд хороо 1. Улсын Их Хурал зохих Байнгын хороонд харьяалагдах дор дурдсан дэд хороотой байна:

1/ Төрийн байгуулалтын байнгын хороонд:

- а/ Ёс зүйн;
- б/ аюулгүй байдлын;

2/ Хууль зүйн байнгын хороонд:

- Хүний эрхийн.

3/Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд:

- Төсвийн зарлагын хяналтын,

2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.

3. Дэд хороо нь харьяалагдах Байнгын хорооныхоо эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж асуудал боловсруулах, санал, дүгнэлт гаргах, түүнийгээ харьяалагдах Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд оруулах болон хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5. Ёс зүйн болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрсдийн эрхэлж буй асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд бие даан оруулж болно.

6. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээллийг авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан бүрэлдэхүүн бүхий ажлын хэсгээр хяналт, шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаар тогтоол, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хорооныхоо, эсхүл Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх эрх хэмжээтэй байна.

7. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

8. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Дэд хороо эрхэлсэн асуудлаа хуралдаанаараа хэлэлцэж гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг дэд хорооны гишүүдийн дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.

(4)

19 дүгээр зүйл. Улсын Их Хурлын дэд хороо

19.1. Улсын Их Хурал зохих Байнгын хороонд харьяалах дор дурдсан дэд хороотой байна: 19.1.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд:

- 1/ Тусгай хяналтын;

19.1.2. Төрийн байгуулалтын байнгын хороонд:

- 1/ Ёс зүйн;
- 2/ Нутгийн өөрөө удирдах ёсны;

19.1.3. Төсвийн байнгын хороонд:

- 1/ Төсвийн зарлагын хяналтын.

19.1.4. Хууль зүйн байнгын хороонд:

1/ Хүний эрхийн.

19.1.5. Эдийн засгийн байнгын хороонд:

- 1/ Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн.

19.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл өөр дэд хороо байгуулж болно.

19.3. Дэд хороо нь харьяалах Байнгын хорооныхоо эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж асуудал боловсруулах, санал дүгнэлт гаргах, түүнийгээ харьяалах Байнгын хорооны хуралдаанд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хянан шалгах бүрэн эрхтэй байна.

19.5. Ёс зүйн болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрсдийн эрхэлж байгаа асуудлаар гаргасан санал дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.

19.6. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж Байнгын хорооныхоо, эсхүл Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй байна.

19.7. Дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна. Хэрэв дэд хорооны бүрэлдэхүүнд байгаа Улсын Их Хурлын гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарсан тохиолдолд тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс гарсанд тооцно.

19.8. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхийн саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгож болно. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

19.9. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Дэд хороо эрхэлсэн асуудлаа хуралдаанаараа хэлэлцэж гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг дэд хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

(4)

24 дүгээр зүйл. Дэд хороо 24.1. Байнгын хорооны бүрэлдэхүүнд дор дурдсан дэд хороо байгуулж болно: 24.1.1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд

- Тусгай хяналтын;

24.1.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд

- Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын;

24.1.3. Төрийн байгуулалтын байнгын хороонд

- Ёс зүйн,
- Нутгийн удирдлагын,
- Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын;

24.1.4. Төсвийн байнгын хороонд

- Төсвийн зарлагын хяналтын;

24.1.5. Хууль зүйн байнгын хороонд

- Хүний эрхийн;

24.1.6. Эдийн засгийн байнгын хороонд

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн.

24.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл бусад дэд хороог байгуулж болно.

24.3. Дэд хороод нь харьяалах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, түүнчлэн хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй...

24.4. Ёс зүйн, Төсвийн зарлагын хяналтын, Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороод өөрсдийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.

24.5. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэд, байгууллагаас тайлбар авах, өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй.

24.6. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүний тоо нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.

24.7. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж ~~санал нэгдсэн дүгнэлт гарган~~ зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна. /Энэ хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/.

24.8. Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.

24.9. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхийн саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно.

24.10. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба түүнийг улируулан сонгож болно.

24.11. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд түүнд дэд хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.

24.12. Дэд хороо асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

24.13. Нэг нам, эвсэл олонхийн суудал аваагүй тохиолдолд Зөвлөл нам, эвслийн бүлгийн зөвшилцлийн үндсэн дээр Байнгын хороо, дэд хорооны даргын суудлыг хуваарилна.

(6)

22 дугаар зүйл. Дэд хороо

- 22.1. Улсын Их Хурал, Бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналтыг хэрэгжүүлж, сонсгол хийх чиг үүрэгтэйгээр дэд хороо ажиллана.
- 22.2. Дэд хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ Өргөдлийн байнгын хорооны адил Засгийн газар болон засаг захиргааны байгууллагуудаас бичиг баримтуудыг гаргуулж авах, мэдээллээр хангуулах, тэдгээрийн байр, байгууламжид нэвтрэх, гэрч, шинжээчийг

сонсгох, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах эрхтэй.

- 22.3. Дэд хороо өөрийн харьяалах асуудлаар Улсын Их Хурлын хяналтын бие даасан байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, түүний үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулна.
- 22.4. Улсын Их Хурлын хяналтын бие даасан байгууллагын дарга, гишүүдийг томилох санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 22.6. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл бусад дэд хороог байгуулж болно.

23 дугаар зүйл. Дэд хороод, тэдгээрийн ажлын зохион байгуулалт

- 23.2. Дэд хороо нь тухайн эрхэлсэн асуудлаараа өөрийн байгуулсан дагнасан буюу хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалт хийлгэхээс гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хяналтын бие даасан байгууллагаар хяналт шалгалт хийлгэж болно.
- 23.3. Тусгай хяналтын, Ёс зүйн, Хүний эрхийн, Төсвийн зарлагын хяналтын дэд хороод өөрсдийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.
- 23.4. Ёс зүйн дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Бодлогын байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүний тоо нь тухайн Бодлогын байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.
- 23.5. Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.
- 23.6. Ёс зүйн дэд хороо нь олонхи, цөөнхөөс адил төлөөлөлтэйгээр бүрдсэн 6 гишүүнтэй байх бөгөөд Улсын Их Хурлын гишүүний мандатын эрхийг түдгэлзүүлэх, гишүүнийг эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж, санал, дүгнэлт гарган Хууль зүй, Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна.
- 23.7. Дэд хорооны даргыг тухайн дэд хорооны гишүүдээс харьяалах Бодлогын байнгын хорооны хуралдаанаар сонгох бөгөөд Ёс зүйн, Хүний эрхийн, болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн гишүүдээс сонгоно.
- 23.8. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа 2 жил байх ба түүнийг улируулан сонгож болно.
- 23.9. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд түүнд дэд хорооны гишүүдийн олонхи хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцож, олонхийн саналаар шийдвэр гаргана.

1992 оны Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Улсын Их Хурал 1993 оны 82 дугаар тогтоолоороо Хүний эрхийн дэд хороог 7 гишүүний, Хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх дэд хороог 6 гишүүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулж байсан байна.

6. Түр хорооны талаархи харьцуулалт:

1. Монгол Улсын Бага Хурлын тухай хууль болон Байнгын хорооны дүрэм
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992 - 1997/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997 - 2001/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001 - 2006
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006 -/
6. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)

18 дугаар зүйл. Улсын Бага Хурлын бусад байгууллага

- Улсын Бага Хурал ажлынхаа шаардлагыг харгалзан түр, дэд хороо, ажлын хэсэг байгуулж тэдгээрийн эрх, үүрэг үйл ажиллагааны журмыг тогтоож болно.

Дүрмийн 2 дугаар зүйл.

- Байнгын хорооноос гадна түр хороо, дэд хороог Улсын Бага Хурлаас тухайн үед нь шийдвэр гарган байгуулж болно.

(2)

16 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо, ажлын хэсэг

- 1. Улсын Их Хурал хууль тогтоох, хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтооно. Түр хороо эрхлэх асуудлаараа Байнгын хороотой адил бүрэн эрх эдэлнэ. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.
- 2. Түр хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.

(3) 16 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо, ажлын хэсэг

- 1. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой асуудлыг судлан боловсруулах, шийдвэрлэх, дүнг Улсын Их Хуралд оруулах зорилгоор түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтооно. Түр хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хороотой адил эрх эдэлнэ.
- 2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн асуудлаар холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

(4)

- 20 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо, ажлын хэсэг
- 20.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой асуудлыг судлан боловсруулах, шийдвэрлэх, дүнг Улсын Их Хуралд оруулах зорилгоор түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтооно. Түр хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хороотой адил эрх эдэлнэ.
- 20.2. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзсэн асуудлаар холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Ажлын хэсэг тодорхой мэргэжлийн шинжээч, ажилтныг зохих хөлсийг нь олгон ажиллуулж болно.

(5)

25 дугаар зүйл. Түр хороо

- 25.1. Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно.
- 25.2. Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно.
- 25.3. Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ.
- 25.4. Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гаргуулмагц түүнийг Улсын Их Хурал татан

буулгана.

(6) 24 дүгээр зүйл. Түр хороо, түүний бүрэн эрх

- 24.1. Тодорхой асуудлыг шалган судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно.
- 24.2. Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно.
- 24.3. Түр хороо хариуцсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ.
- 24.4. Түр хороо хариуцсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гарсан даруйд түүнийг Улсын Их Хурал татан буулгана.

НАМ, ЭВСЛИЙН БҮЛЭГ, ОЛОНХИ, ЦӨӨНХИЙН АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын ... үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн нь Улс Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг Улсын Их Хурлын гишүүд ямар бүрэн эрхтэй; бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ямар баталгаагаар хангагдсан байх, ямар тохиолдолд энэхүү бүрэн эрхээ алдах; Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц /хэдэн байнгын, дэд, түр хороотой байх, ямар чиг үүрэгтэй байх, хэдэн гишүүнтэй байх, хэдэн гишүүнтэй байх, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын дэд хорооны даргыг ямар журмаар сонгох, Улсын Их Хуралд дахь олонхи, цөөнх, нам, эвслийн бүлэг гэдгийг хэрхэн тодорхойлох, ямар бүрэн эрхтэй байх/ зэрэг Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох асуудал гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын үйл ажиллагааны тодорхой эрх зүйн хэм хэмжээг тогтоож өгсөн юм.

Нам, эвслийн бүлэг нь Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр бөгөөд Улсын Их Хурлын бүтцэд хамаарч байдаг тул түүний эрх, үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын бусад асуудлыг нэгэн адил Улсын Их Хурлын тухай хуулиар зохицуулж байдаг. Ардчилсан, эрх зүйт төрийн засаглалын нэгэн хэлбэр болох хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намууд парламентад сонгогдон суудал авсан гишүүдээрээ дамжуулан парламент дахь тухайн намын бүлэг, зөвлөл, фракц байгуулан ажилладаг нь аль ч улсын парламентад нийтлэг жишиг болсон зүйл юм.

Харин парламент дахь улс төрийн намын бүлгийн талаарх эрх зүйн зохицуулалтын арга хэлбэр, хэм хэмжээ нь улс орнуудад зарим онцлог ялгаатай байдаг байна. Тухайлбал, Парламент дахь улс төрийн намын фракцийн эрх зүйн байдлын зохицуулалт нь гадаадын зарим оронд эсхүл тусгай хуулиар (Швейцарь), эсхүл тогтсон жишиг, хэм хэмжээгээр (АНУ) зохицуулагддаг байна.

Гадаадын парламентуудын үйл ажиллагааны зарчимд депутатуудын бүлэг, нэгдлийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх үндэс нь:

- Парламент, түүний танхимд намын харъяаллаар депутатын бүлэг болон нэгдэх эрхийг хүлээн зөвшөөрөх түвшин
- Намын харъяаллаар нэгдэхэд байх ёстой нэг намын гишүүдийн тооны доод хэмжээ

БНЭУ болон Австрали Улсын хууль тогтоох байгууллагад ямар нэг улс төрийн намын бүлэг, хэсгийг байгуулах талаар зохицуулдаггүй, учир нь депутатуудыг Засгийн газрын олонх болон албан ёсны сөрөг хүчинд хуваах ёс түүхийн удаан хугацаанд хэвшин тогтсон байна. ОХУ-д 2003 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн ОХУ-ын субъектуудын хууль

тогтоох байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намуудын оролцооны эрх зүйн үндсийг тодорхойлсон шинэ хууль тогтоомж үйлчилж эхэлжээ. Энэ дагуу хууль тогтоох байгууллага болон фракцууд, депутатууд, депутатын бүлгүүд, сонгогчдын хооронд эрх зүйн шинэ харилцаа үүсч байна. Улс төрийн олон намуудын зарчмын хэрэгжилт нь хууль тогтоох байгууллага дахь депутатын бүлгүүд, фракцийн эрх тэгш байдлыг хангахад гол нь чиглэгджээ.

ОХУ-ын субъектуудын хууль тогтоох байгууллагад депутатуудын фракцад ороогүй үлдсэн депутатууд “депутатын бүлэг” байгуулах эрхтэй байна. Бүлгийн гишүүдийн доод хэмжээг тухайн парламентын дэгээр зохицуулна.

Францын Сенат нь парламентын дээд танхим бөгөөд 331 гишүүн буюу сенатчаас бүрдэнэ. Сенатын одоогийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн олонхийн холбоо нам 150 суудалтай бөгөөд бусад жижиг намуудтай нэгдэн Сенатын олонхийг бүрдүүлэн ажилладаг байна. Францын Үндэсний Хурал нь парламентын доод танхим бөгөөд 577 гишүүнтэй. Үндэсний Хуралд 289 суудал авсан улс төрийн нам олонхи болдог бөгөөд ҮХ-ын олонхийн бүрэлдэхүүнд “Ардын хөдөлгөөний төлөөх холбоо” нам 313 суудалтай байдаг байна.

НЭГ. УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ НАМ, ЭВСЛИЙН БҮЛГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

1.1. Монгол Улсын УИХ-ын тухай хуулийн зохицуулалт 2009.12.1

1. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(1)
УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэр

(2)
7 дугаар зүйл. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэр

- 7.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

(3)
7 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

- 7.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 3. Чуулганы хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан хуралдааныг чуулганы ажиллагаанд тооцно.

(4)
8 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

- 8.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 8.3. Чуулган нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан хуралдаан, нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ.

(5)
13 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

- 13.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, Байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 13.3. Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ.

(6)
11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр

- 1.1. Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин долдугаар зүйлийн 1-д заасны дагуу чуулган байх ба Улсын Их Хурал чуулганаа Үндсэн Хуулийн Хорин долдугаар зүйлийн 4-д заасан анхдугаар чуулган, мөн зүйлийн 2-т заасан ээлжит чуулган, 3-т заасан ээлжит бус чуулган, 5-д заасан онцгой чуулган гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

(ДҮГНЭЛТ: 11.1-т чуулганы хэлбэрт Байнгын болон дэд, түр хороодын хуралдааныг дурьдаагүй байж 11.2-т дурьдсан мөн нам эвслийн бүлгийн хуралдааныг хассан байна)

- 1.2. Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын дагнасан буюу хамтарсан, түүнчлэн Түр хороо, Дэд хороодын хуралдаанаас тус тус бүрдэнэ.

(ДҮГНЭЛТ: чуулганаас гадна Байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр зохион байгуулагдаж болохыг орхигдуулсан байна)

* * *

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ ОЛОНХИ БА ЦӨӨНХИЙГ ТОДОРХОЙЛСОН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

1. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992-1997/
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1997-2001/
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2001-2006/
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006-/
5. Монгол Улсын Их Хурлын тухай хууль /өргөн барьсан төсөл/

(А)
Олонхи болон эрх хэмжээ

(1)
5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

- 5.3 -т УИХ-ын нийт гишүүний ердийн олонхи буюу 39 -өөс доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нам, эсхүл эвслийг УИХ дахь олонхийн суудал авсан нам буюу эвсэлд тооцно.

(2)
19 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

- 19.1. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 38-аас дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи”/-д тооцно.

(3)
23 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

- 23.1. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 39 ба түүнээс дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи”/-д тооцно.
- 26.1. Улсын Их Хуралд олонхийн суудал авсан нам буюу эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй. Хэрэв аль ч нам буюу эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам буюу эвсэл, бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлэх эрхтэй.

(4)

8 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

- 8.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлгийг Улсын Их Хурал дахь олонхи (цаашид “олонхи” гэх) гэнэ.

(5) 6 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь олонхи ба цөөнх

- 6.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи” гэх/ гэнэ.
- 6.3. Улсын Их Хурал дахь олонхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох бөгөөд үүнд бусад нам, эвслээс болон бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг оруулж тооцохгүй.
- 6.4. Аль ч нам, эвсэл олонхи болоогүй, эсхүл олонхи болсон нам, эвсэл хамтарч засгийн газар байгуулах санал тавьсан нөхцөлд засгийн газрын танхимд кабинетэд багтаж буй нам, эвсэл, бие даагч олонхи болно.

(B)

Цөөнх болон эрх хэмжээ

(2)

19.2. Улсын Их Хурлын нийт гишүүний 39-өөс доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид “цөөнх”/-д тооцно.

(3)

23.2. Улсын Их Хурлын нийт гишүүний 38-аас доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид “цөөнх”/-д тооцно.

(4)

- 8.2. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвслийн бүлэг, гишүүнийг цөөнх (цаашид “цөөнх” гэх) гэнэ.

(5)

- 6.2. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвсэл, бие даагчийг цөөнх /цаашид “цөөнх” гэх/ гэнэ.
- 6.5. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг байгуулах хэмжээний суудал аваагүй намаас, мөн бие даагчаас цөөнх бүрдэж байвал цөөнх Улсын Их Хурал дахь гишүүдийн бүлэг байгуулж болно.
- Гишүүдийн бүлэг намын бүлэгтэй адил эрхтэй.

* * *



1.2. Бусад хууль, хууль тогтоомжийн эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хууль /1992 дүгээр сарын 13-ны өдөр/	МУ -ын УИХ -ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр/	Улс төрийн намын тухай МУ-ын хууль /2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр/
Хорин дөрөвдүгээр зүйл 1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. <i>/Энэ хэсгийг 1999 оны 12 дугаар сарын 24- ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд Үндсэн Хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Мөн 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/</i>	13 дугаар зүйл. Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсаныг зарлах 13.1. Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын тухай хуулийн 26.1-д заасан суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ. 13.2. Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг байгуулах тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдаанд уншин танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.	22.1. Улсын Их Хуралд суудал бүхий нам дараахь эрхтэй 22.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчид өөрийн гишүүн, дэмжигчдээсээ нэр дэвшүүлэх; 22.1.2. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаархи асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах; 22.1.3. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих; 22.1.4. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ БА ШАЛГАЛТ

Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа

Монгол Улс нийгмийн шинэ харилцааны хөгжлийн тодорхой үеийг нэгэнт туулаад байгаа өнөө үед УИХ –ын ажлын чадамжийг бүх талаар дээшлүүлэх, түүний дотор, ялангуяа хянах ба шалгах ажлын талбарт нь хяналт, шинжилгээ, үнэлгээг нэвтрүүлэх боломж хэрэгцээ хэр зэрэг байгааг тандан тодруулах явдал нэн чухал юм.

Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд³² туссан үндсэн 5 зорилтын 2 –т, “Парламентын хянан шалгах ажлын арга механизмыг төгөлдөршүүлж, үр нөлөөг дээшлүүлнэ, гэж заасан нь бий. Урт хугацааны уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон чухал зорилго дурдагдсаны дотор,

- а) Парламентын хянан шалгах чиг үүргийн хэрэгжилтийн байдалд судалгаа шинжилгээ хийж, улмаар, шаардлагатай бол, эрх зүйн талаас нь тусгайлан зохицуулж шийдвэрлэх;
- б) Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй болгох; ... зэрэг олон тодорхой заалтууд орсон байна.

Улсын Их Хурлын процедур ажиллагааг зохицуулсан холбогдох багц хуулийн агуулгыг дээрх чиглэлээр улам төгөлдөршүүлэх арга боломжийг судлах үүргийг Улсын Их Хурлын Тамгын газрын Нарийн бичгийн дарга, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн удирдлагаас³³ өгсний дагуу бид доорхи материалыг боловсруулж бэлтгэв.

* * *

1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх үүрэг, түүний хэрэгжилтийн талаар товч өгүүлэхүйд

Төрийн эрх барих дээд байгууллага буюу Монгол Улсын Их Хурлын өөртөө хадгалж хэрэгжүүлдэг нэг чухал “онцгой бүрэн эрх” нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд 1 –ийн 8 –д заасан ёсоор, төрийн хууль, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах явдал юм. Энд гарч байгаа “биелэлт” гэдэг нь хууль тогтоомжийн “хэлбэрэлтгүй хэрэгжилт” –ийг хэлж байгаа бөгөөд харин, “хянан шалгах” гэдэг нь, тэрхүү хэрэгжилтийн байдал хэр зэрэг байгааг явц дунд нь хянаад зогсохгүй, шаардлагатай бол бүр лавшруулан шалгана гэсэн нилээн өргөн утгатай юм.

Улсын Их Хурал, НҮБ –ын Хөгжлийн хөтөлбөрийн [газрын] хамтарч хэрэгжүүлсэн “Ардчилсан парламентыг бэхжүүлэх” төслийн хүрээнд багагүй хөрөнгө мөнгө заран монголын парламентын үйл ажиллагаанд цогц судалгаа хийж нэгдсэн тайлан, санал зөвлөмж гаргасан байдаг. Тэнд, “Монгол Улсын Их Хурал нь дэлхийн ардчилсан улс орнуудын парламентын нийтлэг жишгээр, өөрийн бүрэн эрхийн хүрээнд,

1. хууль тогтоох;
2. хянан шалгах;
3. төлөөлөх;

³² Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолоор;

³³ 2009.11.09 –нд Улсын Их Хурлын Тамгын Газрын Нарийн бичгийн дарга С. Магнайсүрэн, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн дарга Д. Насанжаргал;

гэсэн 3 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Гэтэл, Улсын Их Хурал өөрийн хянан шалгах чиг үүргээ хангалттай биелүүлж чадалгүй явсаар олон жил боллоо; гэсэн шүүмжлэл олон түмний зүгээс байнга гарсаар ирэв. УИХ –ын Тамгын газрын Судалгааны төвөөс гаргасан “УИХ –ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны талаархи статистик мэдээлэл” (1996 – 2009) –д, хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн “үр дүнгээ хэлэлцсэн байдал” –ыг тоон үзүүлэлтээр харуулсан. Тэнд, өнгөрсөн 13 жилийн хугацаанд байгуулагдсан 244 ажлын хэсгийн 14 нь “ажиллаагүй”, 60 нь “ажилласан эсэх нь тодорхойгүй” гэж тэмдэглэгджээ. Тэгэхээр, УИХ –аас байгуулсан 3 ажлын хэсэг тутмын бараг 1 нь буюу 30.3% нь “үр дүнгээ өгөөгүй” сул үзүүлэлттэй байна.

Ийм байдалд хүргэсэн дор хаяж 7 шалтгаан байгаагийн нэг нь, тэнд дурдсанаар, “хяналт шалгалтын үр дүнг үнэлэх нэгдсэн хэмжүүр, шалгуур үзүүлэлт байхгүй” –д оршиж байгаа ажээ. Энэ нь, парламентын хянах ба шалгах чиг үүргийг нарийвчлан тодорхойлох чиглэлд үндсэн ойлголтууд жигдрээгүйн үр дагавар байж блох талтай.

Гадаадын улс гүрнүүд парламентын хяналтад, ... ялангуяа, парламентын шалгалтад онцгой ач холбогдол өгч, түүнийг олон оронд тусгай хуулиар зохицуулсан байдаг. Дэлхийн олон улс орны парламент иргэдийн анхааралд нэгэнт өртсөн, нийгмийн хурц маргаан дэгдээсэн “ноцтой халуун” асуудлыг “өөрөө шалган тодруулж, холбогдох арга хэмжээг авах” эрхээ өөр өөрийн үндсэн хуулиндаа тусгасан байдаг. Манайх ч уг нь тэгсэн байна.

Манай орны хувьд, Монгол Улсын Үндсэн хуулийн өмнө дурдсан 25.1.8 –ыг, парламентын хяналт талд нь түлхүү хамаатуулж ойлгоод, “парламентын шалгалт” талд тун бага акцент өгч иржээ. Энэ байдал олон баримтаас ил харагддаг. Жишээ нь, УИХ –ын Тамгын газраас 2008 онд эрхлэн хэвлүүлсэн “УИХ –ын гишүүний гарын авлага (шинэчилсэн, 2 дахь хэвлэл) –д, монголын парламентын хянан шалгах үйл ажиллагааны хэлбэрүүдийг нэгд нэгэнгүй тоочин жагсаахдаа, дотор нь доорхи 7 ажилбарыг оруулсан байна. Үүнд:

1. Асуулга тавьж хариу сонсох;
2. Бичгэн асуулт тавьж хариу сонсох;
3. Засгийн газар болон шууд тайлагнадаг байгууллагууд УИХ –ын шийдвэрийг хэрхэн биелүүлж байгааг **хянан шалгаж** дүнг хэлэлцүүлэх;
4. Төрийн [зарим] өндөр албан тушаалтантай холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг **шалгаж**, санал дүгнэлт гаргах;
5. Нэр бүхий зарим байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох;
6. Ерөнхий сайдын мэдээллийг сонсч, түүнд аман асуулт тавьж хариулт авах; (Засгийн газрын мэдээллийн цагаар)
7. Улсын төсвийн гүйцэтгэлийг хянан хэлэлцэх;

Энд, “шалгана” гэсэн санаа зорилгоо илэрхийлсэн ердөө 2 –хон заалт байгаагийн нэг нь ёс зүйн тал руу яваад өгч байна. Парламентын хяналт (Parliamentary control) гэдэг нь Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт юм. Үүний арга хэрэгсэл нь асуулт, асуулга тавих, илтгэл тайлан сонсох, мэдээлэл авах, төсөв хэлцэх, ёс зүй ярих ... хүрээгээр хязгаарлагдаад [чухамдаа, зөвхөн **хянах** талаа барьж явсаар] дуусч байна. Эд бүгд урсгал шинжтэй байнга явагддаг байнгын хяналт [тэртэй тэргүй явж байдаг зүйл] гэж ойлгогддог. Парламентын шалгалтаас ангид тасархай орших парламентын хяналт гэдэг бол өөрөө анхнаасаа ийм сул зүйл билээ.

Энэ жагсаалтад, Засгийн газарт итгэл үзүүлэх асуудлыг ямар нэгэн байдлаар дурдаагүй байна. Мөн, парламентын байцаан дүгнэх үүрэг боломжийг огт дурдалгүй орхигдуулжээ.

Парламентский контроль

- Парламентский контроль - форма государственного контроля над деятельностью правительства. Методами и формами парламентского контроля являются: постановка вопроса о доверии, резолюция порицания, интерпелляция, письменные и устные вопросы правительству (парламентские вопросы), парламентское расследование.

Парламентын хяналтын сул талыг улам тодотгосон заалтууд Улсын Их Хурлын үйл ажиллагааны процедурын хуулиудад олон таардаг. Жишээ нь, УИХ –ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 48 дугаар зүйлд,

- Ерөнхий сайд сар бүрийн 1 ба 3 дахь долоо хоногийн баасан гарагт, УИХ –ын чуулганы нэгдсэн хуралдаан дээр мэдээлэл хийж гишүүдийн асуултад хариулна. Ерөнхий сайдын мэдээллийг УИХ –ын Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй;
- Ерөнхий сайд “[мэдээлэл өгөх] шаардлагагүй” гэж үзвэл **мэдээлэл хийхгүй байж болно** ... гэхдээ асуулт хариултыг энэ хуулиар тогтоосон хугацаа (1 ба 3 дахь долоо хоногийн баасан гараг) –нд байнга явуулна;

Тэмдэглэх нь:

- [Энд, хууль тогтоох байгууллагын шийдвэрт гүйцэтгэх засаглалын зүгээс “тааллаараа” хандах боломж нээгдсэн байна. Түүнийг хэдийгээр мөн хуулиар нээсэн ч гэлээ ... [тухайн асуудал дээр] парламент өөртөө хадгалдаг хяналтын эрхээ өөрөө мэдэн бусдад шилжүүлжээ гэж үзэж болохоор байна. Зохицуулалтын байдал ийм байхад “мэдээлэл авдаг парламентын цаг” тасалдах өндөр магадлалтай]

Мөн хуулийн 36 дугаар зүйлд,

- Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна;
- Улсын Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд уг тайланг нэгдсэн хуралдаанаар нэг сарын дотор сонсоно; [хэлэлцэнэ гээгүй сонсоно; гэжээ]
- Улсын Ерөнхийлөгчийн тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж болно. [Хэнээс ...?! гэдэг нь сонин. Улсын Ерөнхийлөгч Их Хурлын чуулганы хуралдаанд тааллаараа оролцдог тул тайлангаа ирүүлчихээд өөрөө хүрэлцэн ирэхгүй, “асуугдахгүй байх” магадлалтай]

“Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль” –ийн 50 –ийн 1 –т,

- Гишүүн асуулт тавих, түүний хариуг хэлэлцэхдээ дор дурдсан журмыг баримтална. Үүнд:
 - асуултын хариулт нь бичгийн А4 хэмжээний 1 хуудаснаас илүүгүй байна; ... гэх мэт.

Тэмдэглэх нь:

- Энд ирүүлж болох мэдээлийн багтаамжийг хязгаарласан нь ... тухайн асуудлыг лавшруулан сонирхох боломжийг багасгаж, хэт богино хариултаар “ам хаах” нөхцлийг бүрдүүлсэн шинжтэй байна. Асуугдагч тал боловсруулж цэгцэлсэн, нэгтгэж дүгнэсэн, үнэн зөв, бүрэн, тодорхой хариулт ирүүлэх ёстой. Ирүүсэн [тэр] хариу зарим тохиолдолд судалгааны төдийгүй хяналтын эцсийн шатны хэрэглэгдэхүүн ч болж болох юм.
- Асуултаар тавигддаг хяналтын эцсийн шат гэдэгт бид юуг хамаатуулж ойлгож байгаа вэ гэхээр, тухайн тавигдсан асуултаас сэдэвлэн босч ирж болох “Засгийн газарт итгэл үзүүлэх эсэхийг шийдвэрлэх” парламентын

хэлэлцүүлэгийг хэлж байгаа юм.

- Парламентын гишүүний асуулт (интерпелляц) нь Засгийн газрын тодорхой үйл ажиллагаа төрийн бодлогод харш байгааг олж илрүүлж, улмаар түүнийг өлгөг авч “хөгжүүлэх” нилээн “холын” бодол сонирхлын үүднээс тавигддаг тийм “арга механизм” юм. Тэгж байж асуулт “парламентын хяналт” гэдэг цаад утгандаа дүйж очно. Гэсэн ч парламентын гишүүний асуулга ба асуулт нь, туршлагаас харахад, “ажил сайжруулах чиглэл, хугацаа” заасан [нэг] тогтоолоос цааш хэтэрдэггүй ... хэрэг дээрээ бас л парламентын хяналтын сул хэлбэрт тооцогдохоор байна.

2. Парламентын хяналт ба шалгалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага

Олон орны хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны туршлагаас үзэхэд, парламентын хянан шалгах бүрэн эрх нь,

- хянах (сул хэлбэр)
- шалгах (хүчтэй хэлбэр)

гэсэн 2 үндсэн бүрдэл хэсэгтэй байдаг гэж үзэж болохоор байна. Энэ хоёрын нэгдэл нийлбэрээр түүний илэрцийн байдал хэмжээ тодорхойлогдоно. Манайх сул талыг нь улам сулруулан хэрэглээд, хүчтэй талыг нь төдийлэн сайн хэрэглэж хэрэгжүүлж ирсэнгүй. Сул хяналтын механизм нь процедурын хуулиудаар зохицуулагдсан байдаг бол хүчтэй хяналтын механизм бие даасан тусдаа хуулиар зохицуулагддаг юм байна. Сүүлчийнх нь манайд [хэрэг дээрээ] алга.

Парламентын байцаан дүгнэх (гардан шалгах) үйл ажиллагаа (parliamentary examination, parliamentary investigation, парламентское расследование) нь Засгийн газрын болон болон УИХ –ын өөрийнх нь харъяаны байгууллагын үйл ажиллагаанд гардаг ... гарсан, ихэнх тохиолдолд нийтэд хэдийнэ анзаарагдаж, улмаар нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, иргэн, олон түмний идэвхтэй тэмцлийн сэдэв, “нийтийн анхаарлын гол бай” болсон [тийм] хэрэг зөрчлийн үнэн мөнийг тогтооход чиглэдэг ажилбар юм.

Парламентское расследование

- Парламентское расследование проводится в отношении незаконных действий подконтрольных парламенту органов исполнительной власти, если допущенные нарушения имеют политический характер. [http://www.glossary.ru/cgi-bin/gl_sch2.cgi?RPgwrgsltyxqor!qutywur]

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд, төрийн хяналт шалгалтын тогтолцоо, түүний хүрээг тодорхойлсон байдаг бөгөөд, тэнд зааснаар, төрийн хяналт шалгалт гэдэг нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт³⁴, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналт ... эд бүгдийг хамардаг; гэсэн байна.

Хууль тогтоомж ёсоор парламентын байцаан дүгнэх ажиллагаа нь төрийн хяналт шалгалтын тогтолцооны нэг бүрэлдүүн хэсэг мөн мэт харагдавч ... Улсын Их Хурал өөрөө төрийн байгууллага мөн үү биш үү гэдэг бол тусдаа их нарийн, чухамдаа, улстөрийн философийн талбарт хамаатах, маргаантай асуудал юм.

Улстөрийн дүгнэлт гаргаж, улмаар Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг чуулганы хэлэлцүүлгийн сэдэв болгон босгож ирэх чадамжтай, үүгээрээ засгийн бүх эрх монголын

³⁴ Мэргэжлийн хяналтын байгууллагыг хэлж байна;

ард түмний мэдэлд байгааг “шаардлагатай бол” нотлон харуулж байх “үүрэгтэй”, үнэмлэхүй эрхийн дээд байгууллага (Улсын Их Хурал) –ын шалган дүгнэх үйл ажилбарыг засаг төрийн системийн дотоод шалгалттай “нэг эгнээнд оруулж жагсаах” нь, зарим талаасаа, эргэлзээтэй үйлдэл юм.

Государственный контроль

- Государственный контроль - форма осуществления государственной власти, обеспечивающая соблюдение законов и других нормативных актов, издаваемых органами государства.

Бас, “төрийн хяналт шалгалтын үндсэн зарчим” гэсэн ухагдахуун байдаг. Төрийн хяналт шалгалт нь зөвхөн хуулийг дээдлэх, нийгмийн шударга ёсыг хангах, бодитой бөгөөд ил тодын зарчимд үндэслэсэн байдаг бол парламентын шалгалт нь, зөвхөн хуулийг төдийгүй “зарчмын зарчим” –ыг, ө. х., үндсэн хуульт дэг ёсны тулгуур ойлголтуудыг эрхэмлэн, үзэл санааг “шүтэж” ажиллах шаардлагад тулгуурлах болдогоороо онцлогтой.

Парламентын шалгалт (байцаан дүгнэх үйл ажиллагаа) нь үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийн дагуу хийгддэг, заримдаа **улстөрийн дүгнэлт** ... хүртэл гаргах болдог, шаардлагатай бол засаг төрийг ч буруутгаж мэдэх онцгой ажилбар юм. Дэлхийн олон улс орон парламентын энэ өвөрмөц эрх мэдлийг олон янзын арга хэлбэрээр хуульчлан хэргэжүүлж байна.

Парламентын шалгалтын дүн, тухайн улс орны дотоодын амьдралд төдийгүй заримдаа бүр дэлхийн бодлогод нөлөөлөхүйц хэмжээний үр дагаварт хүргэж байсан тохиодол олон улсын практикт гарч байжээ. Украины “Гонгадзе”³⁵ –гийн хэрэг” (2000), тэнд гарсан “жүржийн хувьсгал” –д түлхэц өгч, америкийн уотергейтийн хэрэг³⁶ (1972) ерөнхийлөгч Р. Никсоныг огцроход хүргэсэн удаатай. 2005 онд Узбекистаны Андижанд гарсан олон нийтийн эмх замбараагүй байдал, манай “7 сарын 1” –ний асуудал ... [энэ тэр] гээд чухамхүү парламентын байцаан дүгнэх үйл ажиллагааг нэхэж шаардсан улстөрийн хэрэг явдлууд цөөнгүй гардаг.

Нийгмийн зүгээс ирж байгаа энэ мэт нэхэлт шаардлагыг зохих ёсоор боловсон зөв хүлээн авч, [урлагтайхан] шийдэх чиглэлд шуурхай ажилладаг хууль эрх зүйн механизм аль ч улс оронд тавигдсан, тэр нь үргэлж “байнгын бэлэн байдалд” байх учиртай. Манайд ийм зүгширсэн механизм, хэрэг дээрээ, байхгүй байна. Тэрхүү механизмыг хуулиар тавьдаг, өөрөөр хэлбэл, бидэнд парламентын шалган дүгнэх үйл ажиллагааг зохицуулсан тусгай хууль үгүйлэгдэж байна.

Парламентын шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн механизм нь, гадаадын туршлагаас харахад, бүхэлдээ үндсэн хууль ба хууль тогтоох ажиллагааны дэг процедурыг тогтоосон багц хуулийн холбогдох заалтуудын нийлбэр агуулгаар, мөн түүнчлэн бие даасан тусгай хуулиар ... гэх мэт олон аргаар тодорхойлогддог гэж үзнэ. Жишээ нь,

- Үндсэн хуулийн агуулгын тухайлсан тодорхой заалтаар парламентын шалган дүгнэх үйл ажиллагааны үндсийг тавьж, эрхийг нээж өгсөн байх;
- Улсын үндэсний хурал (parliament) –ын тухай хуулийн агуулгад парламентын шалгалтын эрхийг нээсэн заалт оруулаад зогсохгүй, тухайн шалгалтыг чухам яаж зохион байгуулж явуулах тухай дэлгэрүүлж тодруулсан байх;
- Төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр гаргах процесс (Дэг) –ийн тухай

³⁵ Аллагад өртсөн украины сэтгүүлчийн нэр;

³⁶ хууль бусаар тагнаж чагнасан асуудалтай холбоотой улстөрийн скандал;

хуулийн агуулгад парламентын байцаан дүгнэх ажиллагааны талаар тусгаж хуульчилсан байх;

- Төрийн дээд байгууллагаас парламентын шалгалт хийх, байцаан дүгнэх үйл ажиллагааг явуулах горимыг бүхэлд нь нэгтгэж зохицуулсан тусгай хуультай байх; ... гэх мэт.

* * *

Гурав. Гадаадын зарим орны туршлага

3.1. ОХУ

ОХУ –ын конституцид, [тэдний] хууль тогтоох байгууллага нь байцаан шалгах үйл ажиллагаа явуулна гэсэн заалт байхгүй. Гэхдээ, парламентын байцаан шалгах үйл ажиллагааг зохицуулсан тусгай хуультай юм. Ийм хуультай болохоосоо өмнө [тэнд] 3 ч удаа янз бүрийн хэлбэрээр “парламентын байцаан дүгнэх ажилбар” –ыг явуулсан туршлага байдаг. Тэдгээр нь, дараахь хэрэг явдлын учир шалтгааныг ухаж тогтооход чиглэсэн байв. Үүнд:

- СССР –ийн Дээд зөвлөлөөс томилсон парламентын комисс 1989.4.9 –нд Тбилисс –д болсон эмгэнэлт³⁷ явдал;
- ОХУ –ын Дээд зөвлөлөөс томилсон Парламентын комисс 1991 оны 8 сард гарсан “бүтээгүй төрийн эргэлт”;
- ОХУ –ын Дээд зөвлөлөөс томилсон Парламентын комисс 2004.9.01 –нд Хойд Осетийн Беслан хотод гарсан алан хядах ажиллагаа;

Дээр дурдсан парламентын байцаан шалгах ажилбаруудын нэг нь ч олон нийтийн хүсэн хүлээсэн [тэр] үр дүндээ хүрээгүй; гэж үздэг байна. Бесланы эмгэнэлт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох парламентын комисс, хэрэг явдал болсноос хойш 2 долоо хоногийн дараа байгуулагдсан, комиссыг, парламентын дээд танхимын вице-спикер Александр Торшин удирдсан. Уг комисс их нууцлаг арга барилаар 20 шахам хоног ажилласан боловч эцийн дүн нь хэнд зориулагдсан болох нь тодорхойгүй үлджээ; ... гэх мэт.

ОХУ –ын хууль №196 “О парламентском расследовании” 2005 оны 12 дугаар сард батлагджээ. Олон жил маргалдаж, тээнэгэлзэж, эргэлзэж байж, эцсийн эцэст ийм хууль “хэрэгтэй” гэдэг дээр улстөрийн хүчнүүд санал нэгдсэн байна. Тухайн хууль батлагдаад 4 жил гаран болж байгаа ч ОХУ –д Парламентын шалган дүгнэх [ийм] комисс ердөө 2 удаа [гарч] ажилласан ... сүүлийнх нь ажлаа хараахан дуусгаагүй байна.

ОХУ –ын Парламентаас шинэ хуулийн үйлчлэлийн хүрээнд хийсэн 2 дахь шалгалт нь 2009.8.17 –нд Саяно–Шушенскийн усан цахилгаан станцад гарсан осол гамшгийн учир шалтгааныг эрэлхийлэхэд чиглэжээ. Оросын эрчим хүчний системийн хамгийн том тэр объект 2009.8.17 –нд аварт орж ажил нь зогссон. Ослын дүнд 75 хүний амь нас энджээ. Учирсан хохирлын хэмжээ 40 тэрбум рубл. –р хэмжигдэж, түүний сэргээн босголтын ажил 4 – 5 жил үргэлжилнэ; гэж зарим шинжээчид үзэж байгаа.

Шалгалтын комиссыг хэрэг явдал болсноос хойш 1 сарын дараа байгуулав. Шалгалтын комиссыг Төрийн Думын эрчим хүчний асуудал эрхэлсэн Байнгын хорооны дарга, “нэгдсэн орос” –ын депутат Юрий Липатов ахалжээ. Тэрээр энэ комиссыг ахлахаасаа

³⁷ 1989.4.04 –нд Тбилисийн төв талбайд, тусгаар тогтносон Гүржийн [хожмын] Ерөнхийлөгч Звиад Гамсахурдия ... нарын удирдлага дор болсон олон мянган хүний зөвшөөрөлгүй цуглааныг зөвлөлт төрийн эсрэг арга хэмжээ гэж үзэж Улаан армийн хүчийг хэрэглэн цус асгаруулан дарсан;

өмнө уг ослын учир шалтгааныг олж тогтоох Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан байв. Парламентын тусгай комисс [ийн] ажиллах болсонтой холбогдуулж зарим хүмүүс, комисст итгэхгүй, бүр "... энэ комисс аваарын цаад үнэн бодит шалтгааныг хаацайлах зорилготой, сүржигнэж сүржигнэж эцсийн дүндээ хэлбэрийн төдий мэдэгдэл хийхээс хэтрэхгүй" гэж хүртэл ярьж бичиж байлаа.

Парламентын шалгалтын Комисс эхний ээлжинд, үйл явдлын халуун мөрөөр [газар дээр нь] ажилласан Засгийн газрын комиссын шалгалтын дүнг судлан шинжилжээ. Комисс дээр ОХУ –ын Эрчим хүчний сайд, "Русгидро" нэгдлийн дарга удирдлага, осол болсон усан цахилгаан станцын дарга инженерүүд, Засгийн газрын комиссыг ахалсан даргыг ... мөн шаардлагатай гэж үзсэн холбогдох бусад олон албан тушаалтныг нэгбүрчлэн дуудаж сонсов. Парламентын шалгалтын комисс ажлын үр дүнгээ илтгэл хэлбэрээр гаргах бөгөөд тэр нь одоо болтол бэлэн болоогүй байна. Хугацаа нь болоогүй байгаа.

Эрүүгийн хэргийн шинжтэй, эрх зүйн маргаантай асуудлаар энэ Комисс ямар нэгэн шийдвэр гаргаагүй, гаргахгүй, хуулиараа ч тэгэх боломжгүй юм. Харин, хаана төрийн хууль зөрчигдсөнийг, чухам ямар хуулийн заалт амьдралд нийцэхгүй байгааг, улмаар тэдгээрийг цаашид хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд яаж даруй зохицуулан шийдвэл зохилтойг албан ёсоор хэлэх бөгөөд, түүнчлэн, ажлын харицлагын талаасаа осолд буруутай гэж үзсэн зарим албантушаалтныг ажлаас нь чөлөөлөх санал оруулах эрхтэй юм.

Парламентын комисс томилогдон ажилласан нь тухайн хэргийг эрүүгийн талаас нь шалгаж байгаа Улсын прокурорын газрын мөрдөн байцаах албаны ажилд огтхон ч саад болоогүй. Харин ч, ОХУ –ын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах газрын дарга нь (парламентын шалгалтын комиссыг ид ажлаа өрнүүлж байхад) "... гарсан аваар бол манай улсын эрчим хүчний системийн өнөөгийн бодит ерөнхий байдлын үнэн нүүр царайг илчлэн харуулсан, зүй ёсны үр дагавар мөн гэж урьдчилан хэлж болохоор байна" гэж мэдэгдэж байв.

Хэрвээ Парламентын байцаан дүгнэх комисс энэ удаад өөрийн өргөн мэдүүлэх Илтгэлээ "утга уянгын" тал руу нь хэт хэлбийлгэж тухайн хэргийг [уламжлал ёсоор] эзэнгүйдүүлж орхивол, "Орос эх орон одоо ба ирээдүйдээ [нэг хэсэгтээ] засаг төрөө хянах "ном ёсны механизм"³⁸ –гүйгээр, зоргоороо явах нь ямар ч эргэлзээгүй ил болно. Ингэж дүгнэхээс өөр аргагүй. Энд, эртний философчдын туслалцаа ердөөсөө хэрэггүй юм. Байдал дэндүү тодорхой ..." гэсэн тойм санаа хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдээр ч цухалзаж эхэлжээ.

3.2. АНУ

Гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянан шалгах нэг чухал хэлбэр болсон парламентын байцаан дүгнэх ажилбар гадаадын улс орнуудад түгээмэл хэрэглээтэй юм. Тухайн [нэг] улсын парламент нь 2 танхимтай байлаа ч, тэд бие биенээсээ хамааралгүйгээр өөр өөрийн байцаан дүгнэх эрхээ чөлөөтэй эдэлж болдог. АНУ –д парламентын байцаан дүгнэх ажиллагааг Байнгын хороо, дэд хорооноос болон 2 палатаас тус тус томилсон тусгай комисс хэрэгжүүлдэг ажээ. АНУ –д парламентын байцаан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тухайн асуудлыг эрхэлсэн Сенатын байнгын дэд хорооны дэг – дүрмийг баримтлан явуулдаг.

Хууль тогтоох байгууллага нь засаглалын бусад салаа мөчрийн үйл ажиллагааны талбарт байцаан шалгах ажилбар явуулж болох тухай заалт, уг нь, АНУ –ын Үндсэн хуулинд ч байхгүй юм. Хэдий тийм боловч Конгрессийн томилсон байцаан шалгах комисст АНУ –ын төр засгийн дээд албан тушаалтнууд, тэр байтугай АНУ –ын Ерөнхийлөгч хүртэл

³⁸ Резолюция Сената США № 62 от 28 февраля 1991 г.;

"дуудагдан" ирж мэдүүлэг өгч байхаар хуульчилагджээ. Байцаалт авна хэмээн зарлан дуудсаар атал ирээгүй албан тушаалтан гарвал, тэрээр "Конгрессийг хүндэтгээгүй" –д тооцогдож, шүүхэд дуудагдах нь "гарцаагүй" шахуу болдог байна.

Тэнд, тухайн хэрэг явдлыг байцаан шалгасан комисс эцсийн шийд гаргадаггүй. Комисст авагдсан мэдээлэл Сенат руу, эсвэл төлөөлөгчдийн танхим руу илгээх Комиссын илтгэлийн үндэс болдог. Харин, асуудалд холбогдсон байх магадлалтай тодорхой албан тушаалтны "хэрэг" –ийг шалгалтын комисс шүүхэд [түүгээрээ шууд] өгч болдог ба Улсын Ерөнхийлөгчийн тухайд бол импичментийн асуудлыг босгож ирдэг байна.

Конгрессийн шалган байцаах Комисст үнэн зөв мэдүүлэг өгсөн гэрчүүд нэр төртэй шударга байсныхаа төлөөх "шан" –д эрүүгийн хэргээс мултрах боломжтой. Парламентын байцаан шалгах ажилбар АНУ –д байнгын байдлаар "тогтмол" явагддаг, тэдгээрийн ихэнх нь олон нийтийн болон хэвлэл мэдээллийн анхааралд төдийлэн өртөлгүй өнгөрдөг ажээ.

3.3. Бусад улс орон

Германы Үндсэн хуулинд парламентын байцаан шалгах комиссыг хэрхэн томилох, засаглалын бусад механизмтай комиссын үйл ажиллагааг холбох, комиссын ажлын дүнг ашиглах талаар заасан байна. Иймэрхүү утга санаа бүхий зүйл заалтууд Грек, Испани, Итали, Швейцарь, Япон, Португалийн болон бусад олон орны Үндсэн хуулинд суужээ.

Парламентын байцаан дүгнэх үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулдаг улс орнууд ч байна. Орос, Дани, Люксембург, Литва –д асуудал тусгай хуулиар, эсхүл тухайн орны үндэсний парламентын тухай хуулийн холбогдох бүлэг заалтаар зохицуулагддаг. Ер нь парламентын шалган байцаах чиг үүргийг хуульчлан хэрэгжүүлдэг улс болгон парламентын явуулах процедур үйлдлийг зааж зохицуулсан Дэгийн тухай хуульдаа асуудлыг бас нарийвчлан тусгадаг ажээ. Парламентын [өөрийнх нь] бие даасан шалган байцаах эрхийг Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн Беларусь, Гүрж, Молдав, Украин, Узбекистан, Армен зэрэг орнуудад баталгаажуулсан байна.

Европын Холбоо (хамтын нийгэмлэг) –ны эрхийг гажуудуулсан болон эрхийг зөрчсөн байж болзошгүй асуудлыг нягтлан шалгах Түр комиссыг байгуулж болох тухай, түүнийг анх үүсэхэд нь байгуулсан анхдагч гэрээний 193 дугаар зүйлд зааж өгчээ. Цаашлаад шаардагдах процедурын нарийн ширийн зүйлийг, сүүлд, 1995 оны 4 сарын 19 –ний өдрийн шийдвэрээр нэмж дэлгэрүүлсэн байдаг.

Парламентын байцаан шалгах эрх үүргийг хэрэгжүүлэх талаар баруун европын орнуудыг ба АНУ –г бусдаас илүү туршлагажсан гэж үздэг юм байна. Иймээс, тэдний хууль эрх зүйн зохицуулалтын зарим онцлогийг тухайлан дурдъя. Үүнд:

- Хамгийн гол асуудал бол парламентын шалгалтын сэдэв ба зорилгыг тодорхойлох явдал юм. Гэхдээ зорилгыг [бол] баримт бичигт тодорхой зааж тусгах нь ер нь ховор талдаа. Европын холбооны улсын ... өмнө дурдсан Гэрээний 193 дугаар зүйлд, томилогдсон Түр комисс "дэвшүүлсэн таамаглалыг шалгана" гэсэн санаа туссан байна.

Австрийн конституц асуудал үүсэхэд хүргэсэн өмнөтгөл "нөхцөл байдал", "анхаарал татсан нөхцөл байдал" –ыг тухайлан сонирхохын зэрэгцээ шалгалтын комиссын бүрэлдэхүүний асуудлыг ч хөндсөн болтой байна. (Үүнийг тухайлан нягтлах цаг боломж туйлын хомс байв)

Гэхдээ, ихэнх тохиолдолд парламентын дүн шинжилгээ нь "нийгмийн нэхэл" –тэй асуултад хариу өгөхөд чиглэсэн "нийгмийн хурц асуудлыг хөндсөн", "төр засгийн анхаарлыг татсан" ... гэх мэт хөвөмтгий, барьцгүй томъёолол руу хальтрах

шинжтэй, тухайн улс орны тухайн цагийн нийгмийн уур амьсгалд хөтлөгдөх хандлагатай байдаг ажгуу.

- Хоёр дахь чухал асуудал бол парламентын шалгалтыг хэрэгжүүлэх тэрхүү эрх бүхий “завсрын” бөгөөд “түр байгууллага” –ыг зөв тодорхойлох явдал юм. Шалгалтын эрх хэрэгжүүлэгчийг, гол төлөв, байцаан дүгнэх комисс, парламентын комисс, парламентын **ажлын хэсэг**, тусгай хороо ... гэх мэтээр нэрлэдэг. Яаж ч нэрлэлээ гэсэн тухайн байгууллага нэг удаагийн даалгавар гүйцэтгэх “түр” статустай байдаг ба дээд шатны ардын төлөөлөгчид (депутатууд) –ийн шахалт шаардлагаар үүсэн байгуулагддаг нь нэгэнт ил байна. Үүнээс өөрөөр байж болох бас нэг вариант нь, байцаан дүгнэх ажилбар” –ыг парламентын өөрийнх нь дотоод зохион байгуулалтын бүтцийн аль нэг Байнгын хороонд хариуцуулан даалгах явдал юм.

Америкт бол үүнийг Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Сенатын Байнгын дэд хорооны ажлын дүнг нягтлан шалгах байдлаар хэрэгжүүлдэг. Нэг үгээр хэлбэл, шалгадаг байгууллагын үйл ажиллагааг шалгах тухай энд яригдаж байна. Ийм аргын төсөөтэй хэрэглээ зарим улсын практикт ч бий. Жишээ нь, Орос бол “цагдаагийн цагдаатай” улс юм. Жишээ нь, хэн нэгнийг айлган сүрдүүлэх замаар гортоолон, түүнээс хахууль “салгаж” байгаа цагдааг жирийн иргэд байтугай, цагдаа нь өөрөө ч барих чадваргүй ... хүчин мөхөсдөг онцлогтой учраас тэнд, арга буюу “дараагийн шатны цагдаа” тайзан дээр гарч ирэх хэрэгтэй болдог байна.

- Парламентын шалгалтыг хэрэгжүүлэх 3 дахь вариант бол түүнийг байнгын ажиллагаат тусгай байгууллагад хариуцуулах явдал юм. ХБНГУ –д энэ үүгийг мэргэшсэн тусгай мөрдөн байцаах хороо, мөн түүнчлэн, батлан хамгаалах асуудал эрхэлсэн хороонд хариуцуулдаг.
- Дараагийн нэг зүйл бол парламентад шалгалтыг эрхлэн явуулах түр комиссыг тусгайлж олгосон бүрэн эрхээр хангаж өгөх асуудал юм. Эн тэргүүнд авч үзэх асуудал энд,

- а) Төрийн өндөр албан тушаалтныг гэрчийн мэдүүлэг заавал өгдөг болгох, тэднийг дуудаж ирүүлдэг хуулийн заалт чухал. Тусгайлсан тодорхой заалт, хуулийн заалт хэрэгтэй. Ингэж зохицуулаагүй бол шалгалтын комисст ирж мэдүүлэг өгөх хүн олдохгүй, улмаар парламентын шалгалт зорилгодоо хүрэхгүй. Ийм байдал нь парламентын байцаан дүгнэх ажиллагааг саатуулдаг гэж үзэж, үүнийг Францад 1977 онд хуулиар зохицуулжээ.

Парламентын шалгалтын комисст мэдүүлэг өгөхөөс зайлхийх, ташаа мэдээллээр төрөгдүүлэх, дутуу мэдээлэл өгөх ... зэргээр тухайн асуудлыг шийдэхэд элдэв төрлийн саад тотгор учруулсан албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцдог эрх зүйн зохицуулалттай орнууд бий.

- б) Парламентаас томилсон эрх бүхий комисс тухайлан сонирхож байгаа асуудалдаа хамаатай албан ёсны мэдээллийг шууд шуурхай цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх хэрэгтэй болдог. Зарим мэдээлэл нууцын зэрэглэлтэй байдгаас болж “төвөг” учруулах нь ч бий. Иймээс, Комиссыг, түүний шаардсан мэдээллээр хангах үүргийг “шалгагдагч” талд хуулиар ногдуулах хэрэг гарна. Хэрэгтэй мэдээллийг авах ба авсны дараа нягтлан шалгах арга ажиллагаа ч холбогдох хуулийн агуулгад нарийсган зааж өгдөг.

[Дашрамд тэмдэглэхэд, гүйцэтгэх болон засаглалын бүтцийн бусад ямар ч байгууллагаас тодорхой сэдвээр сайтар “боловсруулж нэгтгэсэн” багц мэдээлэл гаргуулж авах байнгын зайлшгүй хэрэгцээ төрийн эрх барих дээд байгууллагын ажлын албанд ч үйгүйлэгдэж байдаг юм. Үүнийг ч бас УИХ –ын тухай хуулийн “Тамгын газар” –ын талаар заасан тэр хэсэгт нэмж тусган

хамтад нь нэгмөр шийдмээр байна]

- с) Парламентын шалгалтын комиссыг сонсох, комиссын илтгэлийг нэгдсэн чуулганаар хэлэлцэх, улмаар холбогдох шийдвэр гаргах дэг процедурын олон асуудлыг хуулиар зохицуулдаг.

Дөрөв. Улстөрийн дүгнэлтийн тухайд

Парламент улстөрийн дүгнэлт гаргадаг байгууллага мөн гэж гэж хаана заасан байна, хэн тэгж байна; гэсэн асуудлыг зориуд гаргаж тавъя. Төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр нь хууль ба тогтоол гэсэн 2 үндсэн хэлбэртэй байдаг. Хууль тогтоомжид энэ бүхэн бий. УИХ –аас аль нэг асуудлаар ямар нэг дүгнэлт гарч гэмээнэ, тэр нь тогтоол хэлбэртэй, эсхүл тухайн тогтоолын агуулгад “заавал тэмдэглэгдэж” үлдсэн байх нь гарцаагүй юм. Ийм практик манайд олон байжээ. Жишээ нь,

- 1) УИХ –ын тогтоол, 1999.5.27, №37 нь “... Үндсэн хуулийн цэцийн дүгнэлийг хүлээн зөвшөөрсүгэй” гэсэн агуулгатай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай шийдвэр юм; (Хөндлөнгийн субъектийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрнө гэдэг бол тэрхүү дүгнэлтэд парламент өөрөө “нэгдэж” байгаагаа илэрхийлж байгаа хэрэг мөн болов уу)
- 2) “Шалгалтын дүнгийн тухай” УИХ –ын 1994.01.17 –ны №19 дугаарт тогтоол. Тэнд, “Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын бүртгэлд авагдсан төрийн зарим өндөр албан тушаалтантай холбоотой гэх мэдээ, **мэдээлэл устгагдсан нь тогтоогдоогүй**, түүнчлэн эдгээр мэдээ, мэдээлэлд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдээс албан тушаалаа урвуулан ашигласан, хээл хахууль авсан, өмч хөрөнгө ашигласан гэх **баримт байхгүй**, Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газарт нууцын хадгалалт, хамгаалалт муу байгаагаас батлагдаагүй мэдээлэл хэвлэлд гарах, нийтийн дунд цуурхал байдлаар тарах, зарим албан тушаалтны нэр төрийг гутаахад ашиглагдах явдал гарсаар байна гэж УИХ –ын **ажлын хэсгээс дүгнэснийг** үндэслэн Улсын Их Хурлаас холбогдох шийдвэрийг тогтоол хэлбэрээр гаргажээ. (Парламентын шалгалтын хэсгийн дүгнэлтийг үндэслэн нэгдсэн чуулганаар шийд гаргаж байна гэдэг нь шалгалт хийсэн ажлын хэсгийн дүгнэлт явсаар байгаад УИХ –ын дүгнэлт болон хувирч байгааг харуулж байна)
- 3) “Шалгалтын дагуу авах арга хэмжээний тухай” УИХ –ын 1994.12.06 –ны №91 дүгээр тогтоол. Тэнд, Улсын Их Хурлын тогтоолын дагуу ... улсын төвлөрсөн төсвийн зарцуулалт, хуваарилалтын байдлыг Сангийн яаманд шалгасан шалгалтын дүнгийн тухай Төсөв, санхүү, мөнгө-зээлийн бодлогын байнгын хорооны мэдээллийг нэгдсэн чуулганаар хэлэлцээд гаргасан тогтоол шийдвэртээ,
 - а) Засгийн газар ... төсөл хэрэгжүүлэх хүрээнд төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах чиглэлээр олгогдсон эрх хэмжээг хэтрүүлсэн журам тогтоон мөрдөж, уг журмын хэрэгжилтэд тавих хяналтыг орхигдуулснаас их хэмжээний мөнгийг эргэж төлөгдөх төсвийн хөрөнгө гэсэн нэрээр олон аж ахуйн нэгж, байгууллагад бага хүүтэй удаан хугацаагаар судалгаа, тооцоо муутай олгосон байна;
 - б) Энэ нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, зарим тохиолдолд зээлийн гэрээнд заагдаагүй зориулалтаар хувь хүн, хувийн компанид улсын хөрөнгөөр бизнес хийх боломж олгожээ; гэж юун түрүүнд **онцлон тэмдэглэсэн** нь “УИХ –ын дүгнэлт” гэж харагдахаар байна.
- 4) “Улсын Их Хурлын ажлын хэсэг байгуулах тухай” УИХ –ын 1998.12.02 –ны 121 дугаарт тогтоол. Тэнд, монголын ардчилсан хөдөлгөөний нэрт удирдагч, Монгол

Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч агсан Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хэрцгийгээр бүрэлгэсэн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд тусламж, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Улсын Их Хурлын ажлын хэсгийг ... байгуулсугай; гэжээ. (Энэ тогтоол, парламентаас томилогдсон ажлын хэсэг болгон [заавал] **шалгах, дүгнэх** үүрэг хүлээхгүй байж болдогийг бас харуулж байна, үүгээрээ тэр онцлог байна)

- 5) “Айлчлалын дүнгийн тухай” УИХ –ын 1994.3.29 –ний 24 дугаарт тогтоол. Тэнд, Улсын Ерөнхийлөгчийн [гадаад оронд] хийсэн албан ёсны айлчлалын дүнг сайшаасугай; гэжээ. (Тогтоолын агуулгад, болсон үйл явдлыг сайшаасан байна. Сайшаана гэдэг бол “сайн” гэсэн дүн гэсэн тавьлаа гэсэн үг. Дүн тавина гэдэг нь нэг төрлийн “дүгнэлт” болоод явчихна; ... гэх мэт)
- 6) “Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай тогтоолын төсөл буцаах тухай” УИХ –ын 2002.5.16, №17 тогтоол. Тэнд, 2000 оны сонгуулиас хойш төрийн албан хаагчдыг улстөрийн үзэл бодлоор нь ялгаварлан ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй тул ... УИХ –ын нэр бүхий гишүүдийн өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг санаачлагчид нь буцаасугай” гэжээ. (Энэ тогтоолын агуулгад байгаа “... алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй” гэдгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гэж үзэв)

[Төрийн тухайлсан салбарын ажилд] алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй; гэсэн санаа төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрт тусгалаа олно гэдэг бол төр [бүр] улстөрийн дүгнэлт гаргажээ; гэж ойлгогдохоор байгаа юм. Асуудал нь ч угаасаа шууд улстөрийн агуулгаар тавигджээ. Дүгнэлтийн ... тэр тусмаа улстөрийн дүгнэлтийн зөв бурууг энд бид тухайлан авч яриагүй, төрийн албан хаагчийнхаа хувьд тэгэх ч ёсгүйг нь зориуд тэмдэглэх хэрэгтэй болов уу.

- 7) 2008 оны 7 дугаар сарын 01 –ний өдөр болсон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас онц байдал тогтоох үед нийгмийн дэг журам сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд хэрхэн ажилласан үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг УИХ –ын даргын 2009 оны 7 сарын 24 –ны өдрийн 126 тоот захирамжаар байгуулагдсан.
- 8) (Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УИХ –ын нэр бүхий гишүүдээс гадна Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх, бусад зарим ажилтан орсон. Энэхүү ажлын хэсэг ... хүчний байгууллагынхан хуулийн дагуу ажилласан эсэх, галт зэвсэг, байлдааны зэвсэг, химийн хорт бодис, тэсрэх дэлбэрэх бодис хэрэглэсэн эсэхийг шалган тогтоох зорилготой байв. Мөн, үүнээс гадна цагдаа, хүчнийхэн онц байдлын үед эрх мэдлээ хэтрүүлсэн, албан үүргээ зохих ёсоор нь биелүүлээгүй зөрчил гарсан эсэх зэрэг асуудлыг судлан, шинэжилж дүгнэлт гаргах ... УИХ –д ажлаа тайлагнах үүрэг хүлээсэн байв)

Дурдсан цөөн жишээнээс үзэхэд монголын ардчилсан парламент түүхэндээ олон чиглэлийн асуудлаар янз бүрийн дүгнэлтийг гаргасаар иржээ. Парламент дүгнэлт гаргадаг нь нэгэнт ийнхүү тодорхой байна. Дүгнэлт нь харин ердийн дүгнэлт үү, улстөрийн дүгнэлт үү гэдэг бол шийдвэр тогтоолын нэрийн тодотгол, ердөө хэлбэр төдий зүйл аж. Улстөрийн дүгнэлтийг ч [зүгээр] ердийн дүгнэлт гээд гаргачихаж болно. Ерөөсөө парламент бол өөрөө

алхам тутамдаа улстөрийн шийдвэр гаргадаг тийм байгууллага билээ. (Шалгалтын ажлын хэсэг бол дүгнэлт гаргадаг, энэ тухай УИХ –ын тухай хуульд тухайлсан заалт бий)

Энэхүү дэд гарчгийн дор бид улстөрийн дүгнэлтийн тухай эхэлж ярьсан нь бас учиртай юм. Нийгмийн амьдралд, заримдаа чухамхүү улстөрийн дүгнэлт гаргахгүйгээр шийдэж болдоггүй асуудлууд гардаг. Тодруулж өгүүлэе. Манайд, улстөрийн хэлмэгдэгсэдийг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын Комисс шинэ Үндсэн хуулийн орчинд 20 шахам жил ажиллаж байна. Ардчилсан хувьсгалын эхэн үед, тэртээх 60 –аад жилийн өмнө болсон 1932 оны “Шамбалын дайн” –д оролцож [тал талаас] хохирсон хүмүүс, тэдний үр сад өөрсдийгөө улстөрийн золиос болсон, хэлмэгдсэн гэж үзэж, 1937 оны хэлмэгдэгсэдийн нэгэн адил “юм нэхэж” тус Комисст мэр сэр ханддаг байсан ч, тухайн үйл явдалд улстөрийн дүгнэлт өгөгдөөгүй учраас хэнийг нь, (аль талыг нь) чухам хэлмэгдсэн гэж үзэх нь тодорхойгүй гэх маягийн хариуг тэдэнд өгч, өргөдлийг нь зохих ёсоор авч үзэлгүй буцаасаар ... сүүлдээ цаг хугацааны эрхээр асуудал аяндаа өөрөө жинхэнэ утгаараа түүх болон хувирч, одоо бараг “хаагдсан” гэж хэлж болно.

Уг үйл явдлыг, тэр үед шинэ тутам үүсч байгуулагдан улмаар парламентад суудалтай болсон зарим улстөрийн нам хүчин “ардын бослого”, зарим нь “иргэний дайн” гэж үзэж байв. Иргэний дайн, ардын бослогын аль нь ч байлаа гэсэн тухайн үеийн засаг төрийн бурангуй бодлого, алдаа гажуудал, нугалаа завхралаас эхтэй нь мэдээж. Түүнийг, улстөрийн талаас нь нэгмөр хэлцэж дүгнээд “Цагаатгалын комисс” –ыг “хэлэх үгтэй”, хийх ажлын шинэ талбартай болгож өгч болох байсан ч тэгээгүй өнгөрсөн. Олон хүний ... олон иргэний гомдол барагдаагүй хоцорсон. Ганц жишээ дурдахад ийм буюу.

Улстөрийн дүгнэлт заримдаа ус агаар шиг хэрэгтэй болох тийм нөхцөл байдал нийгэмд хааяа үүсдэг, үүссэн тэр үед нь түүнийг цаг алдалгүй гаргаж байх нь ардчилсан төрийн тогтолцоо, олон урьгалч үзлийн орчинд бүр ч чухал юм. 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн шинэ орчинд ажиллаж байгаа ардчилсан парламент үйл ажиллагааныхаа явцад олон дүгнэлт гаргадаг ч, чухамхүү улстөрийн дүгнэлт гаргах тал дээр өнөө хэр хангалттай туршлагажиж амжаагүй байна.

Тав. Дүгнэлт, санал

УИХ –ын үйл ажиллагааг төгөлдөршүүлэх чиглэлд анхаарлаа нэгэнт хандуулж байгаа болохоор, дор бид зөвхөн парламентын **хяналт шалгалтын асуудлаар** гэж явцууралгүй, “дашрамд” хөндөгдөж болох бусад санааг ч хамруулж тусгах боломжийг ашиглав.

А. Бүтэц зохион байгуулалтын талаар

1. Улсын Их Хурлын тухай хуулинд ... Байнгын хороодыг төрийн бодлогын салбар, чиглэлээр байгуулна; гэж дурдаад, “одоогийн бүтэц” –ийг зааж тусгасан байдаг нь зарим талаар төдийлэн оновчтой болоогүй, түүнийг сайжруулах өргөн боломжтой. Жишээ нь, УИХ –ын нийтлэг үйл ажиллагаанд нэгэнт хийгдсэн “орчны шинжилгээ” –нд тулгуурлан хуульд өөрчлөлт оруулах замаар парламентын дотоод зохион байгуулалтад байвал зохих **ерөнхий чиг үүргийн хороодыг** төвөггүй тодорхойлж болно. Эдгээр нь,
 - Хууль зүйн хороо; (УИХ –ын хууль тогтоох Ерөнхий чиг үүргийн дагуу)
 - Хяналт шалгалтын хороо; (УИХ –ын Хянан шалгах Ерөнхий чиг үүргийн дагуу)
 - Өргөдлийн хороо; (УИХ –ын төлөөлөх Ерөнхий чиг үүргийн дагуу)

2. Өмнө дурдсан 3 салбар бүтэц нь УИХ –ын **ерөнхий чиг үүргийн** (Байнгын) **хороод** байна. Ерөнхий чиг үүргийн Байнгын хороодыг ямар ч тохиолдолд “татан” буулгахгүй. Мөн, УИХ –ын бусад Байнгын хороодыг “**чиглэлийн хороод**” гэж ялгамжтайгаар нэрлэх нь зөв болов уу.
3. УИХ –ын Байнгын хороодыг [зүгээр л] “... хороо” гэх нь зүйтэй юм. Байнгын ажиллагаатай парламентын дотоод бүтцийг “Байнгын ...” гэж дахин тодотгох хэрэгцээ алга. Байнга бусаар ажилладаг байсан Ардын Их Хурал [байнгын бус парламент] -тай байх үеийн “постоянный комитет” –ийн хуулбар нэрийг өөрчлөх нь зөв болов уу.
4. УИХ –ын тухай хуулийн 19 –ийн 3 –т нэр заагдсан чиглэлийн байнгын хороодыг олон хувааж нарийсган задлах нь чухал байна. “Эдийн засгийн ...” гэх мэт хэт ерөнхий талбартай нэгж-бүтэц парламентын зохион байгуулалтын дотоод нэгжийн эрхийн тэнцвэр, ачааллын тэнцвэр, нөлөөллийн тэнцвэрийг алдагдуулдаг байж магадгүй шинж байдал ажиглагдлаа.

Үүнийг, УИХ –ын үйл ажиллагааны зарим статистик үзүүлэлийг үндэслэн хэлж байгаа юм. УИХ –ын хянан шалгах чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1996 – 2009 оны хооронд парламентаас албан ёсоор байгуулагдсан боловч **ажиллаагүй, ажилласан эсэх нь тодорхойгүй**, үйл ажиллагааных нь үр дүн гараагүй ажлын хэсгийн нийт тоо 76 байгаагийн 32 нь буюу 42% нь эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байна. Товчдоо, зарим Байнгын хорооны хэт ачааллыг зохион байгуулалтын арга замаар багасган, УИХ –ын чиглэлийн хороодыг ... тээврийн, татварын гэх мэтээр нарийсган задалсан шинэ тогтолцоонд оруулах асуудлыг судалж үзэх хэрэгтэй юм. Жишээ нь, ОХУ –ын Төрийн дум 32 байнгын хороо, 4 комисстой байдаг.

В. Хяналт шалгалтын талаар

1. УИХ –ын хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжилт нь дээр үеийн “ардын хянан ...” ч биш, чухамдаа бас төрийн хяналт ч юм. Парламентын зүгээс явуулдаг энэ чиглэлийн үйл ажиллагааг зарим талаас нь төрийн хяналтад хамаатуулж авч үзэж болох болов ч түүнийг бүхэлд нь 100% төрийн механизмын дотор байдаг гэж үзэж боломгүй байна. Учир нь тэр заримдаа бас “шалгадаг төрийн байгууллагыг өөрийг нь [ард түмний нэрийн өмнөөс] шалгах” үүрэгтэйгээ олон түмэнд нотлон харуулах хэрэгтэй болдог; гэж үзнэ.
2. Парламентын хянан шалгах чиг үүргийг дотор нь дор хаяж 2 ангилан, нэгийг нь нөгөөгөөс нь ялган салгаж, хооронд нь тодорхой зааглах хэрэгтэй юм байна. **Парламентын хяналтын дээд хэлбэр нь, чухамхүү “парламентын шалгалт” мөн юм** байна.
3. Парламентын хяналтын дээд хэлбэр болсон “парламентын шалгалт” –ыг зохион байгуулах, төрийн эрх барих дээд байгууллагын байцаан дүгнэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд, дэлхийн бусад зарим орны жишгийг дагаж УИХ –аас бие даасан тусгай хууль гаргах шаардлагатай байна. Хууль “төртөл” цаг алдахгүй байх, УИХ –ын хянан шалгах чиг үүргийг илүү эффект сайтай хэрэгжүүлэхийн тулд, эхлээд, одоо хэлэлцэн батлахаар зэхэж байгаа УИХ –ын тухай хуулийн шинэчилсэн найруулга (төсөл) –ын хүрээнд парламентын байцаан дүгнэх үйл ажиллагааг тусгайлан сонирхож авч үзэх, нэн тэргүүнд хэрэг болох зүйл заалтуудыг хуульд зориуд суулгаж өгмөөр байна.

4. Улмаар, УИХ –ын Хянан шалгах **Ерөнхий чиг үүргийн** дагуу парламентын зохион байгуулалтын дотоод бүтцэд Хяналт шалгалтын хороог шинээр байгуулж, түүнд, Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг зохион байгуулах ажлыг хариуцуулах шинэ боломж байна. Дашрамд тэмдэглэхэд, УИХ –ын Ерөнхий чиг үүргийн Байнгын хороо тус бүрийг (эс бөгөөс ядаж Хяналт шалгалтын хороог) УИХ –ын [нэг] Дэд дарга удирдаж байхаар зохион байгуулж, парламентын хяналтын чиг үүргийн **чухлыг** онцлон тэмдэглэж, түүний гадагшаагаа “үзэгдэх статус” –ыг зориуд нэгтгэж өргөж өгмөөр байна.
5. 1996 – 2009 оны хооронд монголын парламент хянан шалгах чиг үүрэгтэй ажлын хэсэг олон (жилд дунджаар ~20) –ыг байгуулжээ. Парламентад **хяналт шалгалтын асуудал эрхэлсэн тусгай Байнгын хороо** байгуулагдсанаар УИХ –аас, УИХ –ын Байнгын хорооноос, УИХ –ын даргын [тэндээс] томилогддог олон арван ажлын хэсгийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ [мониторинг] хийгдэх анхдагч нөхцөл боломж бүрдэх эхлэл тавигдана; гэж үзэж байна.
6. Одоо бол, УИХ –ын тухай хуулийн 33.11 –т,
 - Улсын Их Хурлын дарга,
 - Байнгын хороо,
 - Дэд хороо,
 - Түр хороо
 [тэд бүгд] өөр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тус тусдаа, “... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэгтэй ажлын хэсгийг парламентын гишүүд, бусад мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болно” гэсэн заалттай. Дээр нь нэмээд, УИХ –ын тогтоолоор ажлын хэсэг бас байгуулагддаг. УИХ –ын тухай хуулийн сая дурдсан, 33.11 –т “УИХ [өөрөө] ажлын хэсэг байгуулж болно гэж тодотгож оруулаагүй” –г ч мөн асуух тайлбарлах хэрэг гарч болно.
7. Парламентын, ялангуяа **шалгалтын** комиссыг байгуулдаг арга механизмыг боловсронгуй болгож, ажлын хэсэг байгуулахыг дэмжсэн саналын доод босгыг нийт (гадаадын туршлага) –ийн жишигт нийцүүлэх чиглэлд анхаарах шаардлага байна.
8. “Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий **Зөвлөл** Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана” гэсэн утга санаа УИХ –ын тухай хуулийн 11.3 –т бий. Парламентын шалгалт нь их төлөв нийгмийн резонанс өгсөн, Үндсэн хуулийн агуулгыг хөндсөн том асуудлыг хөнддөг тул энэ чиглэлээр зохион байгуулах шалгалтыг, шаардлагатай бол харин, [журмын дагуу ажилладаг энэ Зөвлөлөөс өөр] Үндэсний аюулгүй байдлын [хуулийн дагуу ажилладаг] зөвлөлийн ажилтай холбох, уялдуулах албан ёсны арга замыг УИХ –ын тухай хуульд тов тодорхой нэмж суулгаж өгмөөр байна.
9. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд “хяналт шалгалтын байгууллага хяналт шалгалт хийхдээ төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэгийг авч болно” гэж заасан. Энд оролцооны зарчим хөндөгдөж байна. “7 сарын 1” –ний асуудлаар хийсэн парламентын нээлттэй хэлэлцүүлэгт чухамхүү энэ зарчмыг аж амьдрал дээр бодитойгоор хэрэглэжээ. Энэхүү “иргэдийн оролцооны зарчим” ... санааг парламентын үйл ажиллагааны дэг процедурын хуульд нэг тодорхой заалт болгон нэмж оруулмаар байна.
10. Парламентын нээлттэй хэлэлцүүлэг бол, зөвхөн, тодорхой сэдэв зорилгоор албан ёсоор явагдаж байгаа парламентын [тухайлсан тодорхой] шалгалтын ерөнхий

дэвсгэр дээр суурилж өрнөх нь илүү зохимжтой. Шалгалтын биш хэлбэрээр, дугуй ширээний ярилцлага маягийн нээлттэй хэлэлцүүлэх өрнүүлэх нь парламентын хянан шалгах чиг үүрэгийн дагуу хийгдэж байгаа нэн чухал ажилбарыг [зүгээр нэг] семинарын хэлбэрлүү гулсгах эрсдэл үүсгэнэ. Ийм эрсдлийг тойрох агуулга бүхий зүйл-заалтыг УИХ –ын тухай хуульд оруулж өгмөөр байна.

11. Парламентын хяналтын дээд хэлбэр болсон парламентын шалгалтыг хэрэгжүүлэгч түр хирнээ хангалттай өндөр өндөр статустай тэр байгууллагаа "... ажлын хэсэг" гэж хэт даруухан нэрлэх нь зохимжтой биш байна. Шалгалтын байгууллага, шалгадаг шаарддаг ... бүр "шалгадагыг шалгадаг" байгууллага гэдэг нь нэрээсээ хүртэл тод сайн харагдаж байвал зүгээр. "Ажлын хэсэг" гэдэг жол нэр эдүгээ дээр доргүй хаа сайгүй хавтгайрчээ. Иймээс, парламентын шалгалтыг хэрэгжүүлэгч [тэр] түр байгууллагыг **"УИХ –ын байцаан дүгнэх комисс"** гэж нэрлэх нь зөв болов уу.



“МАНДАТЫН ЭРХ, УИХ -ЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРОО, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, ХҮНИЙ ЭРХИЙН ОМБУДСМЭН, АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ОМБУДСМЭН, ТӨСВИЙН АУДИТ” -ЫН ТУХАЙ
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

*У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн
Ц. Түвшинзаяа, К.Пүрэвсүрэн*

Агуулга

НЭГ. МАНДАТ БОЛОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ТУХАЙД

1. Нэр томъёо, ойлголтын хувьд:
2. Эрх зүйн зохицуулалт

ХОЁР. БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРООНЫ ТАЛААР

1. Бүгд Найрамдах Турк Улс
2. Бүгд Найрамдах Болгар Улс
3. Бүгд Найрамдах Унгар Улс

ГУРАВ. ТӨСВИЙН АУДИТ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

1. Ерөнхий ойлголт:
2. Үндсэн ойлголт:
3. Оросын Холбооны Улс
4. Бүгд Найрамдах Турк Улс

ДӨРӨВ. ОМБУДСМЭНИЙ ТУХАЙ

1. Үндсэн ойлголт, чиг үүрэг
2. Омбудсмэнийг томилох ба түүний эрх зүйн байдал
3. Үйл ажиллагааны хамрах хүрээ
4. Санал гомдол гаргах, түүнийг шалгах хэрэг үүсгэх. Омбудсмэний бүрэн эрх
5. Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр

* * *

НЭГ. МАНДАТ БОЛОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ТУХАЙД

Нэр томъёо, ойлголтын хувьд:

Мандат буюу "mandate" /англи хэлээр/ бүрэн эрх, даалгавар /поручение/ гэсэн утгатай ба харин бүрэн эрх нь оросоор "полномочие", англиар "authority", германаар "Vollmacht" хэмээн утгын хувьд орчуулагдана. Эндээс "мандат" нь өөрөө бүрэн эрх гэсэн утгыг илэрхийлж буй тул "мандатын эрх" гэсэн томъёолол нь оновчгүй байна. Улсын орнуудын хууль тогтоомж, бусад мэдээллийн эх сурвалжаас судлан үзэхэд "мандат", "гишүүний мандат" гэснээс биш, "мандатын эрх", "гишүүний мандатын эрх" гэсэн нэр томъёо, агуулга байхгүй байна.

Мандат нь сонгуулийн эрхээр тодорхойлогдон ард түмэн буюу сонгогчдоос нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх зорилготой төлөөлүүлэх бүрэн эрх ба харин полномочие буюу бүрэн эрх нь хууль тогтоох чиг үүрэгт үндэслэсэн төрийн байгууллага, албан тушаалтны эдлэх, хэрэгжүүлэх эрх, үүргийн нэгдэл юм.

Хууль зүйн тайлбар толь, үндсэн хуулийн эрх зүйн ном, бүтээлд дараахь байдлаар тайлбарласан байна:

- Мандат (лат. *mandatum* англи. *mandate; credentials*) нь төлөөллийн хууль зүйн харьцаа, түүнчлэн эл төлөөлөл хууль ёсны болохыг нотолсон баримт бичиг. Парламентын гишүүний буюу депутатын мандат нь ямар нэгэн төлөөлөгчдийн байгууллагын гишүүний бүрэн эрхийн хууль ёсны байдал, бүрэн эрхийн хэр хэмжээ, тэдгээрийн эрх ба үүрэг, түүнчлэн Үндсэн хууль болон үндсэн хуулийн эрх зүйн бусад актаар тодорхойлсон парламентын гишүүний буюу засаг төрийн сонгуульт төлөөллийн бусад байгууллагын гишүүнд хүлээлгэсэн нийтийн чиг үүргийг нотолсон баримт бичиг. Мандат нь гишүүн ба түүний сонгогчдын хоорондын харилцааны шинж чанарыг тодорхойлно. Орчин үеийн улсуудад нийт улсын хэмжээний мандатыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өөрөөр хэлбэл, парламентын гишүүн нь ямар нэгэн тодорхой *сонгуулийн тойргийн бус*, харин нийт улсын хэмжээний төлөөлөгч гэж үздэг.
- Чөлөөт мандат – ардчилсан дэглэмтэй орнуудад парламентын гишүүд чөлөөт мандаттай байдаг. Өөрөөр хэлбэл, тэр өөрийг нь сонгосон тодорхой тойргийн сонгогчдоо бус, харин нийт ард түмнээ парламентад төлөөлдөг. Тийм ч учраас сонгогчид итгэл хөсөрдүүлсэн гэсэн үндэслэлээр түүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татах журам байдаггүй.³⁹
- ... нэгдүгээрт, сонгуульд ялсан нэр дэвшигч (сонгогдогч) УИХ-д ард түмнийг төлөөлөн суух бүрэн эрхийг сонгогчдоос хүлээн авдаг. Энэ тухай хуульд <<хамгийн олон гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцож>> тойргийн хороо бүртгэж, түр үнэмлэх олгоно /УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.4, 50.5/ гэж заасан. Энэ бол сонгогчдын өөрийн төлөөлөгчид олгож буй бүрэн эрх юм. Сонгогчдын олгосон бүрэн эрхийг нийтийн жишгээр **мандат** гэдэг. Хоёрдугаарт, сонгогдогч маань энэхүү мандатын үндсэн дээр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж, түүний өргөн мэдүүлснээр УИХ-ын чуулган хэлэлцэж гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч улмаар тангараг өргөснөөр хууль тогтоогчийн бүрэн эрх эхэлнэ. Сонгогчид нь өөрийн элчийг УИХ-д илгээхдээ олгодог бүрэн эрх нь парламентын шинж чанараас шууд хамаарч захирагдмал /"императив"/ мандат, чөлөөт мандат гэсэн 2 янз байдаг.
- Парламентын гишүүн нь гагцхүү тойргийнхоо сонгогчдын захиа даалгаврыг биелүүлэх үүрэгтэй, тийм учир тойргийн буюу нутгийн иргэдийн бүрэн эрхшээлд байдаг. Захиа даалгавар биелүүлээгүй гишүүнийг сонгогчид дуртай цагтаа огцруулдаг зарчимтай бол захирагдмал мандаттай гэнэ.⁴⁰ Тухайлбал: Германд парламентын гишүүний чиг үүрэг, ажлыг/албан тушаалыг Мандат гэх ба чөлөөт мандат, императив мандат ялгаатай байдаг. Бүлэг, эсхүл намын заавраар, эсхүл сонгогсдоос гишүүнд үүрэг хүлээлгэсэн бол императив мандат бий болно. Харин чөлөөт мандатын хувьд гишүүн журам, заавраас хамаарахгүйгээр зөвхөн өөрийн ухамсар, оюун ухаанд захирагддаг.

Бундестагийн гишүүд нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу чөлөөт мандатыг хэрэгжүүлдэг. Чөлөөт мандат нь нам, фракцууд, улс төрийн болон эдийн засгийн бусад бүлэглэлүүд, сонгогчдын бүлэглэл, мөн

³⁹ Д.Алтангэрэл. Англи-монгол толь. УБ., 2002 он, 298 дахь тал;

⁴⁰ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. /Анхны хэвлэл/ УБ., 2007 он, 274 дэх тал; <http://www.uraljude.lawmix.ru/termins.php?id=1132>

сонгогчид гэх мэтийн нөлөөллөөс гишүүдийг хамгаалдаг ба түүний халдашгүй байдлыг баталгаажуулдаг.

Ийнхүү мандат, бүрэн эрх гэсэн 2 нэр томъёо нь ялгаатай бөгөөд зарим тохиолдолд хууль зүйн талаасаа давхцаж байна. Манай улсын хувьд давхцаж буй тэр байдлаар нь хууль тогтоомжид тусгасан. Өөрөөр хэлбэл, сонгогчдоос олгосон мандатыг гишүүний “бүрэн эрх” гэдэг агуулгаар нь хуульчилсан ч төрийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гишүүний бүрэн эрхээс нь ялгаж, гаргаж зохицуулаагүй юм.

Монгол Улсын Үндсэн хууль, УИХ-ын тухай хуульд “мандат” гэж үгчлэн тусгаагүй, гэхдээ “гишүүний бүрэн эрх”-ийн талаархи зохицуулалтаас “мандат”-ын агуулгыг харж болно. Жишээ нь: Монгол Улсын Үндсэн хуулийн 21, 23.2, 29.3 дахь хэсгээр дээр дурдсанчилан “чөлөөт мандат”-ын мөн чанарыг тодорхойлжээ. Хэдийгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.2, 12.1, 12.2, 25.1.2, 25.1.3, 25.6, 28.1, 47.3, 49.1.3-д “мандат”-ын талаархи шууд зохицуулттай харагдахаар байгаа ч энэ нь зөвхөн “хэлбэр”-ийг илэрхийлж, сонгуулийн тойргийг олон мандаттай байх тухай агуулгаар тусгажээ. Зарим нэг ялгааг энд дурдая. Үүнд:

- Мандат /түүнд агуулагдсан бүрэн эрх/ нь сонгуулийн үр дүнд буюу сонгогчдоос хийсэн сонголтыг нотолсон баримт бичиг /манайхаар бол УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.5 дахь хэсэг/ -ийг сонгогдсон иргэнд олгосноор эхлэх ба харин парламентын гишүүний бүрэн эрх /төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой/ нь тангараг өргөсөн (Монгол Улсын Үндсэн хуулийн 23.2 дахь хэсэг)-өөр эхэлдгээрээ ялгаатай байх боломжтой. Тухайлбал, Туркэд эхний тохиолдолд гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл үүсдэг.
- Зарим үед дээрх ойлголтууд нь давхцах тухай тэмдэглэсэн билээ. Учир нь гишүүний бүрэн эрх нь мандатын үндсэн дээр үүсч, парламентын гишүүний тангараг өргөснөөр “мандат” болон “гишүүний бүрэн эрх” цаг хугацааны хувьд нэг цэгт холбогдон хуулиар тогтоосон парламентын чиг үүрэг хэрэгжүүлэх, бодлого тодорхойлоход оролцон, үүнтэй холбоотой халдашгүй байдал олж авах, цалин, хангамж эдлэх болдог.
- Мөн бас нэг ялгагдах зүйл гэвэл хэрвээ гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлвэл /тодорхой хугацаагаар/ түүний мандат нь түдгэлзэхгүй, хэвээр хадгалагдаж байх явдал юм. Өөрөөр хэлбэл, УИХ-ын тухай хуулийн 6.9-д заасан үндэслэлээр түдгэлзсэн бөгөөд шүүхийн шийдвэрээр гэм буруугүй нь тогтоогдвол бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба хэрэв гэм буруутай нь тогтоогдвол “гишүүний мандат”, “гишүүний бүрэн эрх” нь аль аль нь хугацаанаасаа өмнө дуусгавар болох үндэслэл болно гэсэн үг.
- Судалгаанаас харахад мандатыг түдгэлзүүлэх гэсэн ойлголт, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Харин мандат эхлэх, дуусах /дуусгавар болох/, мандат хүчин төгөлдөр болох, мандатаа алдах талаар⁴¹ улс орнууд хууль тогтоомждоо харилцан адилгүй зохицуулжээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6.9-д заасан гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх 2 үндэслэл нь бусад зарим улсын Үндсэн хууль, холбогдох хуульд парламентын гишүүний халдашгүй байдал /immunity/-ыг хасах, хязгаарлах үндэслэл болдог байна. Ийнхүү халдашгүй байдалд нь төрийн эрх бүхий байгууллагаас хууль ёсоор “халдах”-даа эрх бүхий субъектээс заавал зөвшөөрөл авах тохиолдол нь зонхилно. Өөрөөр хэлбэл, баривчлах, мөрдөн байцаах ажиллагааг явуулах, үргэлжлүүлэхийн тулд эхлээд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон гишүүний халдашгүй байдлыг нь хасуулах буюу хязгаарлуулах алхамыг хийх ба манайхаар бол Улсын ерөнхий прокурор (ихэнхи улс орнуудын хувьд ч)-оос саналаа оруулж зөвшөөрөл авснаар гишүүнийг хувь хүнийх нь хувьд

⁴¹ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он, 226 дахь тал

гэмт хэрэг үйлдсэн, эсэхийг шалган тогтооно.

Энэ тохиолдолд мөн л мандатыг нь түдгэлзүүлэх тухай яригддаггүй, харин зарим тохиолдолд парламентын чиг үүрэгтэй холбоотойгоор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх боломжтой байна. Жишээ нь: ОХУ-ын Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд “Холбооны зөвлөлийн гишүүн болон Төрийн думын депутат нь түүний бүрэн эрхийн нийт хугацаанд халдашгүй байна. Тэдгээрийг гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдах тохиолдлоос бусад үед сатуулах, баривчлах, нэгжих, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хуулиар тогтоосноос бусад тохиолдолд хувийн нэгжлэг хийж болохгүй”-г зааснаас харвал дээрх ойлголтыг буюу УИХ-ын тухай хуулийн 6.9-д заасан үндэслэлүүд нь юуны түрүүнд гишүүний халдашгүй байдалтай шууд хамааралтай, харин “гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх”-тэй шууд бус хамааралтайг нотолж байна.

Эрх зүйн зохицуулалт

Дээрх асуудалтай холбоотойгоор эрх зүйн тогтолцоо төдийгүй төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, парламентын нэг танхимтай харьцангуй төсөөтэй зарим улсад эрх зүйн зохицуулалтын хувьд ямар байгааг товч гаргалаа.

Словак Улс

Тус улсын праламентын гишүүн нь төлөөллийн чөлөөт мандатыг хэрэгжүүлдэг. Мандат буюу бүрэн эрхийн талаар Үндсэн хууль, Үндэсний зөвлөл /парламентын/-ийн үйл ажиллагаа /процесс/-ны журмын тухай актаар зохицуулсан байна. Тухайлбал: мандат эхлэх, дуусах, парламентын гишүүд мандатаа алдах гэх мэт. Словакийн Үндсэн хуулийн 78, 81А дугаар зүйлд гишүүний мандатыг дуусгавар болох, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгохтой холбогдох асуудлыг зохицуулжээ.

Гишүүний бүрэн эрх болон мандатыг ялгаж ойлгохтой холбоотойгоор Үндсэн хуулийн 78.5 дахь хэсэгт “Хэрвээ гишүүн нь баривчлагдвал түүний мандат нь дуусгавар болохгүй ба зөвхөн хэрэгжүүлэхгүй.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, мандат нь дуусгавар болохгүй ч түүгээр олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй гэсэн агуулга юм. Үндсэн хуулийн 78.3-т зааснаар “Словак Улсын Үндэсний зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн болон сахилгын мөрдөн байцаах болон баривчлах ажиллагааг Депутатын хувьд явуулж болохгүй. Хэрэв Словак Улсын Үндэсний зөвлөл зөвшөөрөл олгохгүй бол депутатын мандатын үйлчлэх хугацаанд эрүүгийн мөрдөн байцаах болон баривчлах ажиллагааг явуулж болохгүй.” юм.

Люксембург

Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар “Ээлжит хуралдааны хугацаанд гэмт хэрэг үйлдэж буй газар дээрээ баригдсанаас бусад тохиолдолд нь зөвхөн Танхимын зөвшөөрлөөр депутатын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулж болно. Танхимын шаардсанаар чуулганы хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл байцаан шийтгэх ажиллагааг явуулахыг түр зогсооно.” гэжээ.

Турк улс

Үндсэн хуульд тодорхой зааж өгөөгүй боловч Парламентын гишүүний сонгуулийн тухай хуулийн 36.2 дахь хэсэгт зааснаар гишүүнээр сонгогдсон тухайн тойргийн сонгуулийн хорооноос гишүүнээр сонгогдсон тухай үнэмлэх олгосноор мандат нь эхэлнэ. Туркт парламентын тухай хууль байхгүй бөгөөд Үндсэн хуулийн 83, 84 дүгээр зүйлээр гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан ба 83.2-т “сонгуулиас өмнө болон дараа нь ямар нэг гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан

гишүүнийг Парламентын шийдвэргүйгээр барих, мэдүүлэг авах, баривчлах, шүүн таслахгүй. Хүнд гэмт хэргийг үйлдэл дээр нь болон сонгуулиас өмнө мөрдөн шалгаж эхэлсэн байх нөхцөлтэйгээр Үндсэн хуулийн 14 дүгээр заалтад заасан тохиолдлууд энэхүү заалтаас тусдаа байна. Гэвч энэ байдлыг холбогдох эрх бүхий байгууллага даруй, шууд Туркын Үндэсний Их Хуралд мэдэгдэнэ.”, 83.3-т “Гишүүний талаар сонгуулиас өмнө эсхүл дараа нь гарсан эрүүгийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг гишүүнчлэлийг нь дуусгавар болтол хойшлуулна.” гэж тус тус зохицуулжээ.

ХОЁР. БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРООНЫ ТАЛААР

1. Бүгд Найрамдах Турк Улс

Ерөнхий сайд болон сайд нарын талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үйлдсэн гэмт хэрэгтэй нь холбогдуулан байцаан шалгах ажиллагааны талаар Парламентын мөрдөн шалгах ажиллагаа нэр дор Туркын Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд онцгой тохиолдлыг зохицуулсан байна. Уг зүйлд Ерөнхий сайд болон сайд талаар Туркын Үндэсний Их Хурлын бүх гишүүдийн аравны нэгээс багагүй гишүүн мөрдөн шалгах хүсэлт гаргаж болох бөгөөд ТҮИХ уг хүсэлтийг нэг сарын дотор хэлэлцээд, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Парламентын мөрдөн шинжих шийдвэр гарсан тохиолдолд парламент дахь улс төрийн намуудын, эвсэл хүчний харьцаагаар бүрдүүлсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй хороо мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Ерөнхий сайд, сайдын эрүүгийн хариуцлагатай холбоотой хянан шалгах механизм болох парламентын мөрдөн шалгах ажиллагаа нь мөн улс төрийн хариуцлагыг хамаарч байдаг. Учир нь Туркын Үндсэн хуулийн 113 дугаар зүйлийн дагуу ТҮИХ-ын шийдвэрээр Үндсэн хуулийн шүүхэд шилжсэн сайд сайдын албан тушаалаасаа огцрох ба Ерөнхий сайд Үндсэн хуулийн шүүхэд шилжсэн тохиолдолд Засгийн газар огцорсонд тооцдог байна.

Туркын Үндсэн хуульд парламентын мөрдөн шалгах ажиллагааг Ерөнхий сайд болон сайдын хувьд авч үзсэн байдаг боловч Туркын Үндэсний Их Хурлын дотоод дэгийн 107 дугаар зүйлд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа болон өмнө бүрэн эрх хэрэгжүүлж байсан Ерөнхий сайд, сайд нарын хувьд комисс байгуулан парламентын мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Парламентын мөрдөн шалгах хороог байгуулах:

Мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх шийдвэрийг ТҮИХ-аас гарсан тохиолдолд Үндсэн хуулийн дагуу нэр суглах замаар байгуулах 15 хүний бүрэлдэхүүнтэй комисс буюу хороог байгуулна. Хороо гишүүд дотроосоо дарга, орлогч дарга, хэвлэл, мэдээллийн төлөөлөгч, нарийн бичиг тус тус сонгоно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шүүгчийн шүүх хурлаас татгалзах тохиолдол, парламентын мөрдөн шалгах хүсэлт гаргасан, эсхүл өмнө нь ТҮИХ-д эсхүл хуралдаанаас тухайн асуудлаар гадна саналаа илэрхийлсэн гишүүнийг хорооны гишүүнээр сонгодоггүй. Хорооны ажиллах ажилтан, шинжээчдэд энэхүү шаардлага тавигдана.

Парламентын мөрдөн шалгах хорооны ажиллах журам болон хугацаа:

Хороо гишүүдийн олонхиор хуралдаж, хуралдаан оролцсон гишүүдийн олонхиор шийдвэр гаргана. Хорооны ажиллагаа нууц байна. Хорооны ажиллагаанд хорооны гишүүн бус парламентын гишүүн оролцож болохгүй. Тус хороо мөрдөн шалгах асуудлаарх тайланг хоёр сарын дотор ТҮИХ-д хүргүүлнэ. Хэрвээ мөрдөн шалгах ажиллагаа дээрх хугацаанд дуусаагүй тохиолдолд хоёр сарын хугацаа өгөх бөгөөд уг хугацаа эцсийнх байна. Энэ хугацаанд тайланг ТҮИХ-д хүлээлгэн өгөх шаардлагатай.

Парламентын мөрдөн шалгах хорооны бүрэн эрх: Хороо төрийн болон хувийн байгууллагаас асуудалтай холбоотой мэдээлэл, баримтыг хүсэх эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл хураан авч болно. Засгийн газрын бүх л хэрэгслийг ашиглаж болно, Засгийн газрын гишүүд, холбогдох бусад этгээд, гэрч, шинжээчийг сонсоно. Хороо төлөөлөгчөөр дамжуулан шүүхээр дэмжлэг хүсч болно. Түүнчилэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу гэрч, шинжээч, хураах, нэгжлэг хийхтэй холбоотой шүүхийн эрх чөлөөг хязгаарласан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг үндэслэлийг нь мэдэгдэн холбогдох шүүхээс бичгээр хүсч болно.

Хороо мөрдөн шалгах ажиллагаа хийгдэх талаар хүсэлт гаргуулсан Ерөнхий сайд, сайдын тайлбар /өөрийгөө хамгаалах/-ыг авна. Үүнтэй холбоотой хүссэн баримтыг нь бүрдүүлүүлнэ. Хороо шаардлагатай гэж үзвэл дэд хороо байгуулан Анкарагийн гадна үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргаж болно.

Мөрдөн шалгах ажиллагаа дуусгавар болох: Хороо тухайн асуудлаар тайлан гаргах бөгөөд уг тайланг ТҮИХ-ын даргад хүргүүлснээс өдрөөс 10 хоногийн дотор тараах ба тарааснаас эхлэн 10 хоногийн дотор хэлэлцүүлнэ. Энэхүү хэлэлцүүлэгд хороо болон тухайн хүний нэрийн өмнөөс 6 гишүүн мөн тухайн үед бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа эсхүл хэрэгжүүлээгүй байгаа өөрт нь парламентын мөрдөн шалгах ажиллагаа хийхээр хүсэлт гаргуулсан Ерөнхий сайд, сайд уг хэлэх бөгөөд сүүлийн үгийг асуудалд холбогдсон Ерөнхий сайд, сайд хэлэх ба хугацааг нь хязгаарлахгүй.

Хэлэлцүүлэг дууссаны дараа хорооны тайланг Нэгдсэн хуралдаанаар нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Хорооны Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх талаархи тайлан, Нэгдсэн чуулганаар Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх шийдвэрт эрүүгийн хуулийн ямар зүйлийг үндэслэж буйг дурдана. ТҮИХ бүхий гишүүдийн олонхийн нууц саналаар Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх шийдвэрийг гаргана. Парламент дахь улс төрийн намын бүлгүүд парламентын мөрдөн шалгахтай холбоотой хэлэлцүүлэг хийхгүй ба шийдвэр гаргахгүй. ТҮИХ Үндсэн хуулийн шүүхэд асуудлыг шилжүүлэх шийдвэр гаргасан тохиолдолд баримтыг 7 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхийн даргын ажлын албанд илгээнэ.

1. Бүгд Найрамдах Болгар Улс

БНБУ-ын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт Үндэсний Ассамблей нь байнгын болон түр хороодтой байхаар заасан 79.3 дахь хэсэгт мөрдөн, байцаан шалгах түр хороог гэж сонгохоор заасан байна. Болгарын Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, процедурын дүрэм /дэг/-ийн 99 дүгээр зүйл парламентын мөрдөн, байцаан шалгах болон сонголыг тусгайлан зохицуулсан байна. Төрийн болон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар Үндэсний Ассамблей мөрдөн, байцаан шалгах түр хороог сонгоно.

Засгийн газрын бүх л харъяа байгууллага, төрийн байгууллага, захиргааны байгууллага, гишүүд Үндэсний Ассамблейн мөрдөн шалгахад шаардлагатай мэдээлэл, баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Түүнчилэн шүүх, төрийн нууцтай холбоотой мэдээллийг хүртэл гаргуулна.

Засгийн газрын бүх бүрэлдэхүүнүүд, төрийн захиргааны болон хотын удирдагууд, олон нийтийн байгууллагууд, түүний гишүүд бүгд мөрдөн, байцаан шалгахтай холбогдох баримтууд болон мэдээлэл, лавлагаанууд, түүнчилэн тухайн мэдээлэл улсын, албаны эсвэл шүүхийн нууцлалтай байсан ч бэлэн байлгах үүрэгтэй. Мөрдөн, байцаан шалгахтай холбогдох мэдээллийг гаргах журмыг Үндэсний Ассамблей эсхүл мөрдөн, байцаан шалгах түр хороо тогтоох бөгөөд Үндэсний Ассамблейн тухайн хороо олон нийтийн байгууллагын гишүүд, албаны хүмүүсийг урьж мэдээлэл авах

ба эдгээр этгээд нь хороог шаардлагатай баримт, мэдээллийг хангана. Тус уулзалт, хурлыг Үндэсний Ассамблейн ажлын албад зохион байгуулахаар элхицуулсан байна.

1. Бүгд Найрамдах Унгар Улс

БНУУ-ын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт Парламент байнгын хороог парламентын гишүүдээсээ сонгох бөгөөд аливаа асуудлыг мөрдөн шалгах зорилгоор хорооны гишүүнийг томилохоор заасан байна. Үндсэн хуулийн тус заалтын дагуу Унгарын Парламентийн Байнгын хорооны дүрэм /46/1994 (IX.30.)/-ийн 34 дүгээр зүйлд түр хорооны асуудлыг зохицуулсан байна. Аливаа асуудлыг мөрдөн, хянан шалгахад Парламентаас мөрдөн шалгах хороо томилон ажиллуулах бөгөөд тодорхой хугацааны дотор хороо байгуулах тухай тогтоол гарган уг тогтоолд тодорхойлогдсон асуудлуудыг хариуцуулахаар түр хороо томилж болно. Мөн түр хороо байгуулах тухай тогтоолд дараахь асуудлаар өөрчлөлт оруулах саналыг дэвшүүлж болохгүй:

- Мөрдөн, хянан шалгах асуудал, Хянан шалгах хорооны нэр,
- Түр хорооны нэр болон зорилтуудын хүрээнд багтсан асуудал.

Мөрдөн, хянан шалгах биетийн тодорхойлолт, нэр, үйл ажиллагаа, батлах болон хянан шалгах хороог татан буулгах, мөн үүнтэй адил түр хорооны зохицуулалт зэрэг нь Парламентын тогтоолд тусгайлан заагаагүй бол Дүрмийн 36 зүйл үйлчилнэ. Парламентын гишүүдийн 5-ны нэгээс багагүй нь дэмжсэн тохиролдолд хянан шалгах хороог байгуулж болох бөгөөд тус хорооны гишүүдийг зөвхөн Парламентын гишүүдээс сонгоно. Хянан шалгах хороог байгуулахдаа Дүрмийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн үндэс болгоно. Засгийн газар, аль нэг Засгийн газрын агентлаг эсвэл яамны үйл ажиллагаа, эсхүл сайдын талаар мөрдөн шалгах хянан шалгах хороог Парламентын сөрөг хүчний гишүүн даргалана. Хэрэв мөрдөн шалгах нь хамтарсан Засгийн газрыг хамаарах бөгөөд Засгийн газрын сөрөг хүчин нь тэгш бус тохиолдолд хянан шалгах хороог Засгийн газрын сөрөг намуудад харъяалагдах гишүүд хамтран удирдана.

Хамтарсан удирдлагууд хорооны хуралдааныг хамтран бэлтгэх ба хуралдааныг ээлжээр даргална. Тэд Хурлын даргын бусад үүргүүдийг хамтран гүйцэтгэх бөгөөд хамтарсан удирдлагын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ. Хянан шалгах хороо нь дараахь агуулга бүхий үйл ажиллагааныхаа тайланг гаргана:

- Хорооны зорилго,
- Хорооны үйл ажиллагааны журам, мөрдөн шалгахтай холбоотой баримтыг олж авах процедур, арга зүйг тогтооно,
- Хорооны олж тогтоосон фактууд болон хорооны үйлдсэн хууль зүйн баримт бичиг,
- Чиг баримжаануудыг гаргахад үндэслэсэн нотолгооны танилцуулга,
- Мөрдөн шалгахад тогтоосон асуудлын талаар хувь хүн эсвэл албан байгууллагын гаргасан тайлбар,
- Мөрдөн шалгахтай холбоотой тогтоосон асуудал нь хорооны үйл ажиллагааны зорилгод хамаарсан тохиолдолд хорооноос авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ.

Унгар Улс нь аливаа нэг асуудлаар хянан шалгах талаар парламентын гишүүдээсээ сонгосон түр хороог байгуулж ажилладаг байна. Уг хороог сөрөг хүчний гишүүн эсхүл хамтран даргалдаг байна. Хороо тайлан бэлтгэн гаргадаг байна.

ГУРАВ. ТӨСВИЙН АУДИТ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

1. Ерөнхий ойлголт:

Төсөв нь өөрийн шинж төрхөөрөө улс төрийн баримт бичиг юм. Төсвийн санал гарах, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын чиг үүргийг хязгаарлах зэрэг нь төсвийг улс төрийн баримт бичгийн шинжтэй болгодог. Энэ нь парламентаас гүйцэтгэх засаглалд олгож буй ирээдүй үеийн удирдлагын төлөвлөгөө буюу удирдлагын хөтөлбөр юм.

Парламентын засаглалтай орнуудад төсвийг дэмжсэн санал өгөх нь парламентын гишүүдийн олонхийн зүгээс Засгийн газарт итгэл үзүүлж буйн илрэл гэж үздэг.⁴² Төсөв гэдэг нь “Төрийн байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хэлбэр”, “мөнгөн хөрөнгийн төвлөрсөн үндсэн сан”⁴³, “...санхүүгийн төлөвлөгөө, ... санхүүгийн чухал зохицуулагч, ... мөнгөн харилцааны нийлбэр цогц ... юм.”⁴⁴

Төсөв нь өргөн хүрээний санхүүгийн категори учир санхүүд хамаарах бүх чиг үүргийг *нэгдүгээрт*, төсвийн санг бүрдүүлэх /орлого/, *хоёрдугаарт*, төсвийн санг зарцуулах /зарлага/, *гуравдугаарт*, хянах чиг үүргийг гүйцэтгэдэг.

2. Үндсэн ойлголт:

Төрийн хяналтын нэг хэлбэр бол Парламентын хяналт юм. Парламентын хяналтын онцгой төрлийн нэг бол санхүүгийн болон санхүүгийн эдийн засгийн хяналт юм байна. Үүнийг парламентын тусгай байгууллагаар буюу тооцооны танхим /төсвийн аудит/, тооцооны шүүхээр хэрэгжүүлдэг. Парламентын хяналт захиргааны шинжтэй.⁴⁵ Сүүлийн арваад жилд хүний эрхийг Парламентын хяналтаар хангадаг болсон байна.

Оросын Холбооны Улс

1995 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр баталсан ОХУ-ын тооцооны танхимын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Тооцооны танхим /төсвийн аудит/ нь ОХУ-ын Холбооны хурлаар байгуулагдаж, улсын санхүүгийн хяналтыг тогтмол хийж, дээрхи хуралд ажлаа тайлагнана.”

Тооцооны танхим: Холбооны Улсын төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэг хэрэгжүүлэхдээ хуулийн үндэслэлтэй, бодит, хараат бус болон ил тод байх зарчмыг баримтлан гүйцэтгэнэ. Мөн дээрхи хуулийн 2 дугаар зүйлд:

- Холбооны Улсын төсөв болон төсвийн бус Холбооны Улсын сангуудын орлого зарлагын гүйцэтгэлийн хэмжээ, бүтэц, зориулалтыг хянах ажлыг зохион байгуулна;
- Улсын хөрөнгийн зарцуулалт болон улсын өмчийн ашиглалтын үр дүнг зохитой эсэхийг тодорхойлох;
- Холбооны Улсын төсөв болон төсвийн бус сангуудын төслүүдийн орлого зарлагын үндэслэлийг үнэлэх;
- Холбооны Улсын хуулийн төсөл болон төрийн байгууллагуудаас гаргаж буй эрх

⁴² Б. Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008 он, 208 дахь тал

⁴³ <http://www.ipu.org/parline-e/parlinelist.asp?newquery=yes&typeform=Search>

⁴⁴ Отгонтуяа. Л. Төсвийн зарлагын удирдлага, төлөвлөлт. УБ., 2007. 4 дэх тал

⁴⁵ Основы теории финансов /Под ред. Л.А. Дробозиной, М., Банки и Брижи: ЮНИТИ, 1995.с.32

зүйн актуудад санхүүгийн дүн шинжилгээ хийнэ. Энэхүү зардал нь Холбооны Улсын төсөвт суусан байх ёстой.

- Холбооны Улсын төсөв болон Холбооны Улсын төсвийн бус сангуудыг төсвөөс тогтоосон үзүүлэлтээс хэтэрсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж тэдгээрийг арилгахад чиглэсэн, мөн төсвийн үйл ажиллагааг бүхэлд нь боловсронгуй болгох саналыг бэлтгэх;
- ОХУ-ын Төв банк, ОХУ-ын бүрэн эрхт томилогдсон банк болон санхүү, зээлийн бусад байгууллагуудын хөрөнгийг цаг тухайд нь хөдөлгөж буй болон хуулийн үндэслэлтэй байгаа эсэхийг хянах;
- Холбооны Улсын зөвлөл болон Төрийн Думд Холбооны Улсын төсвийн гүйцэтгэл болон хяналтын үйл ажиллагааны тайланг тогтмол гаргана гэж Тооцооны танхимын эрх хэмжээг тодорхойлжээ.

Бүгд Найрамдах Турк Улс

БНТурк улсын хувьд нь төсвийн аудитыг Тооцооны шүүхийн тухай 1967 оны 832 дугаар хуулиар зохицуулсан бөгөөд уг шүүх нь ерөнхий болон холимог төсөвтэй газрын орлого, зарлага болон эд хөрөнгийг нь ТҮИХ-ын нэрийн өмнөөс хянан, хариуцлагыг тооцоо болон ажиллагааг нь шүүн таслах журмаар эцэслэн шийдвэрлэж, хуулиар олгосон хянан судалж, шалгаж, шийдвэрлэх ажлыг гүйцэтгэх үүрэгтэй байдаг байна. *Тооцооны шүүхийн зохион байгуулалтад хамаарагдах нэгжүүд:*

1. Тойрогууд;
2. Тойргын зөвлөл;
3. Давж заалдах хороо;
4. Ерөнхий хороо;
5. Дээд сахилгын хороо;
6. Албан хаагч сонгох болон Сахилгын хороо.

Төрийн сангийн нэрийн өмнөөс прокурор энэхүү байгууллагад хамаарагдана. Тооцооны шүүхийн чиг үүрэг: Ерөнхий болон холимог төсөвтэй байгууллагын, тус байгууллагын хөрөнгийн хагас болон хагсаас нь илүүг хувийг оролцуулах хэлбэр бүхий тогтсон болон эргэлтийн хөрөнгөтэй эсхүл сан хэлбэрээр байгуулсан байгууллага, бусад хуулиар Тооцооны шүүхийн хяналтад хамааруулсан бусад байгууллагын орлого, зарлага, эд хөрөнгө, бэлэн мөнгө, өрийн бичиг, үнэт цаас зэрэг үнэт зүйлсийг авч, өгөх, хадгалах болон ашиглахыг нь хянан шалгана. хариуцлагыг тооцоо болон ажиллагааг нь шүүн таслах журмаар эцэслэн шийдвэрлэнэ.

Төрд холбогдох тооцоо, төрөл бүрийн эх сурвалжаас хандив, тусламж зэргээр орж ирсэн бэлэн болон бэлэн бус материаллаг үнэт зүйлсийг, Төрийн боно, батлан даалт, зээл, төрийн авансийн бүртгэлийн хянаана. Ерөнхий болон холимог төсөвтэй байгууллагатай холбоотой ерөнхий хэрэгжилтийн мэдэгдлийг Үндсэн хуульд заасан хугацаанд ТҮИХ-д хүргүүлнэ. Тооцооны шүүх хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тооцооны шүүхийн бүрэн эрх: Тооцооны шүүх хуулиар тогтоосон үүргээ хэрэгжүүлэхдээ яамд, байгууллага, нутгийн захиргааны удирдлага, тооцооны ажилтан бусад холбогдох хариуцлагатай ажилтнаас шууд бичгээр, шаардлагатай баримт, дэвтэр, бүртгэлийг үзэх, хүсвэл газар дээр нь авчруулах, амаар мэдээлэл авах, зэрэг бүх л зэрэг дэвтэй төрийн албан хаагчийг дуудах, яамд байгууллагаас төлөөлөгч илгээхийн хүсэх эрхтэй. Тооцооны шүүхийн хянан шалгах ажиллагаатай холбоотой бүх л төрлийн мэдээлэл, баримтыг Төрийн бүх байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, зэрэг бүх л төрийн байгууллага, болон бусад хувь хүн, хуулийн этгээд /банк хамаарна/-ээс хүсэж авна.

ДӨРӨВ. ОМБУДСМЭНИЙ ТУХАЙ

Омбудсмэн – эрх зүйн тайлбар толь болон бусад эх сурвалжид бичсэнээр, “янз бүрийн захиргааны байгууллагаас хүний эрхийг сахин хангаж байгаад хяналт шалгалт хийхээр тусгайлан сонгогдсон /томилогдсон/ албан тушаалтан, гадаадын зарим улсад хувь хүн ба нэгдэл”, мөн “нийтийн эрх ашгийг хохироосон үйл ажиллагаанд иргэдээс гаргасан гомдол, хүсэлтэд хариу өгөх, шинжлэн судлахаар төрөөс томилогдсон албан тушаалтан”⁴⁶, “төрийн байгууллага болон албан тушаалтны хүнд суртал, шударга бус үйл ажиллагааны талаар иргэдээс гаргасан гомдлыг магадлан шалгадаг хараат бус, олон нийтийн албан тушаалтан”⁴⁷ гэжээ.

Улс бүхэнд нэрлэх нэр томъёоны хувьд өөр байдаг ч явуулж буй үйл ажиллагааны хувьд бүгд төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаа хүний эрхийг зөрчсөнтэй холбоотой бүхий л гомдлыг хариуцдаг.

Хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгч

Хүний эрхийг хамгаалах институт болох омбудсмэны институт нь анх 1809 онд Засаг захиргааны тухай Актын 6 дугаар зүйлийг үндэслэн байгуулагдсан. Энэхүү Актаар хууль бусад шийдвэрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих нэг юмуу хэд хэдэн омбудсмэныг сонгох үүрэг Шведийн парламент Риксдагт оногдсон болно. Хожим омбудсмэний институт өргөжин тэлж эхэндээ хойт Европын орнуудад, тухайлбал 1919 онд Финландад, 1954 онд Данид, 1960-1980-аад онд дэлхий нийтэд түгээмэл дэлгэрсэн хяналтын тогтолцоо болж хөгжсөн байна.

Гэхдээ Данийн омбудсмэний тогтолцоо Шведийнхээс арай өөр бөгөөд дэлхий нийтэд түгэн тархсан омбудсмэний тогтолцооны суурь загвар болжээ. 1962 онд Шинэ Зеландад, 1967 онд Их Британи болон Канадын зарим мужид, 1969 онд Хавайн арлуудад, 1971 онд АНУ-ын мужуудад, Австралийн хойт, өмнөд Мужид, 1973 онд Францад, 1976 онд Португали, 1981 онд Испани, 1982 онд Голландад тус тус байгуулагджээ. Харин сүүлийн жилүүдэд Польш (1988), Унгар (1989) зэрэг шилжилтийн үеийн улс орнуудад болон Ази, Африкийн хөгжиж буй орнуудад ч байгуулагдаж байна.

Омбудсмэний тогтолцооны онцлог:

Бүтцийн хувьд маш уян хатан, амар хялбар өөрчлөгдөж байдаг. Скандинавын улсуудад “Омсудсман”, Испани, Колумбид “ард түмний хамгаалагч”, Их Британид “парламентын Бүрэн эрхт элч”, Энэтхэгт “ардын элч” буюу локпал, Францад “зуучлагч”, Румынд “ард түмний өмгөөлөгч”, Нигерид “Олон нийтийн санал гомдлын хороо”, Австри зэрэг зарим оронд хяналтын талаархи үндсэн зарчмыг хадгалсан хамтын удирдлагын тогтолцоо ч болж өөрчлөгдөн хөгжсөн байдаг. Өөрөөр хэлбэл омбудсмэний тогтолцоо нь эрх зүйн ямар ч тогтолцоонд зохицдог өвөрмөц онцлогтой юм.

Ардчилсан нийгэмд омбудсмэн нь төрийн захиргааны байгууллага болдоггүй. Омбудсмэны тогтолцоо нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хэрэгжүүлдэг нэлээд үр нөлөөтэй байгууллага болдог байна. Гэхдээ төрийн байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих биш, гагцхүү тэдгээрээс иргэд, олон нийттэй харилцах харилцаанд иргэдийн эрх зөрчигдөж буй тохиолдолд хяналтын үүргээ хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Янз бүрийн улс оронд омбудсмэний тогтолцоо, түүний чиг үүрэг харилцан адилгүй байвч ерөнхийдөө араг яс нь адил гэж хэлж болно. Иргэдийн

⁴⁶ Финансы и кредит/ Под ред. А.Ю. Казака. Екатеринбург, 1994.с.170

⁴⁷ <http://www.uraljude.lawmix.ru>

санал гомдлыг барагдуулах талаархи омбудсмэний нийтлэг чиг үүргийн талаар гэвэл:

1. Хяналтын үйл ажиллагаа
2. Төр, иргэний хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд тус дэм болох үйл ажиллагаа (function of conflict-resolution)
3. Өөрчлөн байгуулах, шинэчлэх үйл ажиллагаа гэсэн үндсэн гурван чиглэлтэй байдаг.

Зарим тайлбар хийхэд омбудсмэн хяналтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага шиг биш харин иргэдийн эрх зөрчигдөж байгаа талаар гаргасан гомдлын мөрөөр хяналт хийх болон зарим тохиолдолд омбудсмэний өөрийнх нь санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаа явуулдаг байна. Үйл ажиллагааны хоёр дахь чиг үүргийн тухайд гэвэл тус дэм, нөлөө үзүүлэх гэдэг нь илүү оновчтой томъёолол байж болох талтай. Учир нь омбудсмэний гаргасан шийдвэр нь тухайн зөрчлийг зайлшгүй шийдвэрлэх императив хүчинтэй баримт бичиг болдоггүй бөгөөд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд уг зөрчлийг хэрхэн арилгах талаар зөвлөмж болдог. Тиймээс энэ нь үнэн чанартаа шүүхийн шийдвэр шиг заавал биелүүлэх хүчинтэй биш харин зөрчлийг арилгахад тус нөлөө үзүүлэх чиг үүрэгтэй гэж үзэж болох юм.

Гурав дахь чиг үүргийн тухайд тодруулахад омбудсмэний үйл ажиллагааны өөрчлөх, шинэчлэх чиг үүрэг нь түүний арга ажиллагаатай салшгүй холбоотой гарч ирдэг өвөрмөц онцлог юм. Яагаад гэвэл омбудсмэний нөлөө нь түүний эрх мэдэлд бус, харин парламент, олон нийтийн санаа бодол болон өөрийнх нь нэр хүндэд тулгуурладаг юм. Тиймээс түүний энэ чиг үүрэг маш чухал нөлөөтэй байдаг ажээ. Ихэнхи улс оронд омбудсмэн нь парламентын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, парламентад жил бүр тайлангаа тавьдаг. Ингэснээр иргэдийн санал гомдол гардаг, иргэдийг бухимдуулж буй “зөрчилтэй газар” нийгмийн харилцаа хаана байгааг мэдээлэх хийгээд тэнд төрийн аппаратыг өөрчлөн сайжруулах шаардлагатайг мэдээлдэг ач холбогдолтой юм.

Омбудсмэний үйл ажиллагаа нь дээд зэргээр нээлттэй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийттэй нягт холбоотой явагддаг. Иймд омбудсмэний үйл ажиллагаа нь иргэд, төрийн байгууллагуудын харилцааг илүү ойр дөт болгох, харилцан ойлголцолыг бэхжүүлэх, төрийн түшмэлүүдийн иргэдтэй харилцах харилцааг өөрчлөн сайжруулах үр нөлөөтэй хүчин зүйл болдог юм. Омбудсмэний тогтолцоо улс орон бүрт харилцан адилгүй, олон хэв шинж, хувилбартай байдаг. Гэсэн ч тэдгээрээс нийтлэг шинж байдлыг авч үзвэл:

1. Омбудсмэнийг томилох ба түүний эрх зүйн байдал

Омбудсмэний тогтолцооны олон хувилбарт, хэв шинжит байдал ба онцлог нь түүнийг сонгох процедурт нэгэн адил тусгалаа олдог байна. Түүнийг томилдог хамгийн их түгсэн “сонгодог” хэлбэр нь гэвэл парламентаар томилдог хэлбэр юм. Олон оронд албан тушаалтны жагсаалтад омбудсмэнийг Парламентын Омбудсмэн (Финланд), Фолькетингетс Омбудсмэн (Дани), Парламентын Бүрэн эрхт элч (Их Британи) зэргээр оруулсан байдаг.

Омбудсмэний бүрэн эрхийн хугацаа нь гол төлөв парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаатай дүйцэх буюу 4-6 жил байдаг. Финландад эхэндээ нэг жилийн хугацаатай сонгогддог байснаа 1933 оноос гурван жилээр, 1957 оноос 5 жилийн хугацаатай болжээ. Харин Испанид 5 жилийн хугацаагаар сонгодог бол Туркэд парламентын сонгуулийн 5 жилийн хугацаанд 2 удаа буюу эхний гишүүн 2, дараагийн сонгогдох гишүүн 3 жилийн хугацаатай тус тус сонгогддог байна.

Зарим улс оронд омбудсмэнийг томилдог процедур нь арай өөр, омбудсмэний тогтолцоо нь гүйцэтгэх засаглалдаа илүү ойртсон шинжтэй байдаг. Жишээ нь, Шинэ Зеландад омбудсмэнийг парламентын санал болгосноор генерал-губернатор томилдог ажээ.

Европын орнуудаас гүйцэтгэх засаглалдаа илүү ойр байдаг нь Францын хэлбэр юм. Францад Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр Медиаторыг (посредник буюу холбогч, зуучлагч) 6 жилийн хугацаагаар томилдог байна. Харин Суданаас бусад Африкийн ихэнхи оронд омбудсмэнийг Засгийн газар эсхүл Ерөнхийлөгч томилдог байна. Намибид ерөнхийлөгчөөс томилдог байна.

Харин Туркийн “Хүний эрхийн хянан шалгах хороо”-г Үндэсний Их Хурлын /ҮИХ/ байнгын хорооны хэлбэрээр байгуулахаар дотоод дэгийн хуулиндаа тусгасан байдаг бөгөөд үйл ажиллагааных нь зарчмыг бие даасан хуулиар тусгайлан зохицуулдаг. Тус хорооны гишүүдийн тоог Туркийн ҮИХ-ын даргын дэргэдэх Зөвлөх хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар тогтооно. Хорооны бүрэлдэхүүнийг улс төрийн намын бүлгүүд болон бие даагч нарыг бүх гишүүний тоонд харьцуулан гарах хувиар тооцон тохирохоор төлөөлнө. Ихэнхи орны омбудсмэний тухай хуулиудад түүнийг томилоход тусгай шаардлага тавьдаггүй.

Харин омбудсмэнээр ажиллахад нэлээдгүй хязгаарлалтыг хуульчилсан байдаг байна. Тухайлбал, Польшоос бусад оронд омбудсмэн нь парламентын гишүүн байж болохгүй, улс төрийн, арилжааны чиглэлийн үйл ажиллагаа болон ямарваа нэг өөр ажил алба эрхлэхгүй байх гэх зэрэг. Омбудсмэний парламентын болон олон нийтийн өндөр статус нь парламентын гишүүний халдашгүй байдалтай адил зарим төрлийн баталгаа, халдашгүй байдлын баталгааг хуулиар зохицуулсан байдаг. Түүнчлэн Омбудсмэний тухай хууль тогтоомжуудад түүний үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулж өгсөн байдаг.

Ялангуяа үүнд санхүүгийн болон улс төрийн талаар хараат бус байх зарчмыг онцлон авч үздэг байна. Тухайлбал, омбудсмэн хүнд хэнч тодорхой санал гомдлын мөрөөр шалгах, барагдуулахад ямарваа нэг зөвлөмж өгөх эрх байхгүй гэдгийг хуульчилж өгсөн байх жишээтэй. Тиймээс омбудсмэнүүд зөвхөн парламентад ажлаа хариуцаж тайлагнадаг байна. Засгийн газраас томилогддог омбудсмэнүүд Засгийн газартаа тайлагнана. Харин хуульд омбудсмэнийг хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь чөлөөлөх, өөрийн хүсэлтээр огцруулах, цаашид үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй гэж үзэх, гэмт хэрэг үйлдэх зэрэг зохицуулалтыг нэлээд сайн оруулж өгдөг байна.

Үйл ажиллагааны хамрах хүрээ /Юрисдикция/

Омбудсмэний үйл ажиллагааны хамрах хүрээ нь улс орнуудад харилцан адилгүй байдаг. Швед, Финланд зэрэг оронд анх омбудсмэний тогтолцоо үүсч хөгжихдөө үйл ажиллагааны хүрээ нь зөвхөн гүйцэтгэх засаглалын засаг захиргааны байгууллагаар хязгаарлагдахгүй шүүх, хорих газар, цэргийн байгууллагыг хүртэл хамарч байсан. Тэгвэл өнөө үед ихэнхи оронд омбудсмэн нь зөвхөн Засаг захиргааны төв болон төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хүрээг хамардаг.

Дани, Финланд, Канадын зэрэг зарим оронд омбудсмэний хяналтын үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын гишүүд, прокурорын байгууллага хамрагддаг. Их Британи, Франц, Шинэ Зеланд зэрэг оронд орон нутгийн засаг захиргааны удирдлагын үйл ажиллагааг хамрана. Их Британи, Испани зэрэг оронд улсын ерөнхий омбудсмэний ажил бүс нутгийн болон орон нутгийн омбудсмэнүүдийн үйл ажиллагаатай уялдаа холбоотой байдаг.

Зарим оронд омбудсмэний төрөлжсөн байгууллага байгуулагдах практик нэвтэрч байна. Тухайлбал, Норвеги, ХБНГУ, Финлянд, Португал, Австрали зэрэг оронд батлан хамгаалахын омбудсмэн, Израйльд цэргийн талаар ирүүлсэн өргөдөл гомдол хариуцсан офицер, Канадын Үндэсний батлан хамгаалах департамент болон зэвсэгт хүчний омбудсмэн, АНУ зэрэг улсуудад пенитенциарын системд тавих хяналт, Шведэд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр гэх мэт.

Зарим орон дахь батлан хамгаалахын омбудсмэний хяналт

Улс	Эрх мэдэл	Үүрэг	Тайлан ба улс төрийн албан тушаалтны үүрэг
Австрали	Батлан хамгаалах хүчний омбудсмэн сайд нарын шийдвэрээр томилно	Австралийн батлан хамгаалах хүчний гишүүдийн аливаа буруу үйлдлийг хянах	Парламентад суугаа төлөөний сайдад жилийн ажлын тайланг тавих
Канад	Батлан хамгаалахын омбудсмэн сайд нарийн зөвлөлийн шийдвэрээр томилно	Үндэсний батлан хамгаалах департаментийн ажилтан, албан хаагчид ба Канадын Зэвсэгт хүчний гишүүдийн эрхийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> Онцгой тохиолдолд Үндэсний батлан хамгаалахын Департамент буюу Канадын Зэвсэгт хүчинд тайлан тавих, үйл ажиллагааны талаар сайдад жилийн тайланг тавих; Төвийг сахигч ба бодит зөвлөл. Батлан хамгаалахын сайдын удирдлагаас хараат бус байх
Норвеги	Батлан хамгаалахын омбудсмэн Норвегийн парламентын хүрээнд сонгоно	Цэргүүдийн эрх ашгийг хамгаалах, батлан хамгаалах байгуулалтын төрөл бүрийн салбарын хүрээнд үүссэн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд анхаарлаа төвлөрүүлэх	Сайн дураар холбогдох олон нийтийн байгууллагад зөвлөмж, үнэлгээ, шүүмжлэл өгөх

* * *

Сүүлийн 10 жилд Орост хүний эрхийг хамгаалах тухай асуудлыг парламентын хяналт буюу омбудсмэнээр хэрэгжүүлэх болсон. Тодруулбал, Аюулаас хамгаалах салбар болон батлан хамгаалах салбар дахь захиргааны гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагаа албан хаагчдын болон иргэдийн эрх ашигтай зөрчилдөж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулахад тус салбарыг хариуцсан омбудсмэн чухал үүрэг гүйцэтгэдэг.⁴⁸ Харин омбудсмэнүүд хувь хүн, төрийн бус болон төрөөс хараат бус бусад байгууллага, пүүс, компанийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг авч үздэггүй.

3. Санал гомдол гаргах, түүнийг шалгах хэрэг үүсгэх, Омбудсмэний бүрэн эрх

Ихэнх тохиолдолд омбудсмэний хянан шалгах ажлын үндэслэл нь омбудсмэний хамрах хүрээний байгууллага, албан тушаалтны гаргасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн шийдвэр, үйл ажиллагааны талаархи хувь хүний гомдол болдог. Эдгээр зөрчил нь харилцааны болоод үйл ажиллагааны нэлээд өргөн хүрээний үйлдлийг хамардаг байна. Жишээ нь, иргэдтэй бүдүүлэг харьцах, шударга бус, ялгавартай хандах, тэр бүү хэл Их Британид удирдлагын “муу” арга ажиллагаа ч иргэдийн гомдлын үндэс болдог байна.

⁴⁸ www.se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf

Мөн зарим улс оронд иргэдийн гомдлоос гадна омбудсмен өөрийн санаачлагаар холбогдох хууль бусад актад тусгагдсаны дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Жишээ нь, Туркийн Хүний эрхийн хяналтын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор яам, агентлаг болон бусад төсвөөр санхүүждэг байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, их сургуулиуд, бусад нийтийн удирдлагын байгууллагууд болон хувийн секторын байгууллагуудаас мэдээлэл хүсэх, тэдгээрт хяналт шалгалт хийх, холбогдох этгээдийг дуудан мэдээлэл авах бүрэн эрхтэй байхаас гадна шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын үеэр илэрсэн зөрчлийг үнэн зөв магадлах үүднээс тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнээс мэдээлэл авч болдог.

Омбудсмен нь иргэдээс гаргасан гомдлын дагуу хяналтын үйл ажиллагаа явуулдаг ч зарим оронд гурав дахь этгээд болон хувийн байгууллагын гомдлыг ч хүлээн авч болдог байна. Ихэнхи улсад аливаа иргэн омбудсменд шууд хандах эрхтэй. Хүний эрх зөрчсөн доголдол дутагдал ба эрх мэдлээ урвуулан ашиглах, алдаа зөрчилтэй, шударга бус шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох, төрийн удирдлага ба түүний албан хаагчдыг олон нийтийн өмнө хариуцлага хүлээлгэдэг болгох үүрэгтэй байдаг.

Уг зөрчил байдал илэрвэл омбудсмен нь энэ тухай зохих байгууллага буюу албан тушаалтанд тэдгээрийг мэдэгдэж түүнийг арилгахыг заана. Тэрээр татгалзсан тохиолдолд шүүн таслах ажиллагааны байгууллага буюу парламентад хандаж болно. Гэхдээ омбудсмен засгийн газар заавал биелүүлэх шийдвэрийг гаргах эрхгүй байдаг ба харин өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгдөг.

Төрийн байгууллагуудыг харьяалсан омбудсмен эдгээр байгууллагуудад хамаарах өргөн эрхтэй байдаг. Зарим оронд шүүх, цагдаа, цэрэг зэргийг хамаардаг байхад зарим газар эдгээр нь омбудсмэны харъяалалд хамаардаггүй. Улс орнуудад омбудсмэны байгууллага гүйцэтгэх үүргээсээ хамааран бүрэн эрх нь янз бүр байх боловч дараахь бүрэн эрхийн хувьд нийтлэг байна:

1. Төрийн байгууллагын удирдлагын хуульд нийцээгүй буюу шударга бус үйл ажиллагаа хийсэн эсэхийг шалгах
2. Шалгалтын явцад захиргаа зохисгүй үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол энэ байдлыг арилгах зөвлөмж өгөх
3. Онцгой тохиолдолд хууль тогтоох байгууллагад хандах эрхтэй. Омбудсмен нь жилийн ажлын тайлангаа олон нийтэд мэдээлэх ба хууль тогтоох байгууллагад тайлагнадаг.⁴⁹

Ихэнх оронд Парламентын комисс болон тодорхой депутатуудын санал хүсэлт омбудсмэны хянан шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх үндэслэл болж өгдөг байна. Мөн ихэнхдээ омбудсменүүд өөрсдийн санаачилгаар хянан шалгах үйл ажиллагаагаа эхлүүлдэг. Болгарт анх 1998 онд Омбудсмэнийг байгуулах тухай хууль батлан гаргасан боловч 2005 онд анхны Омбудсмэнийг улсын болон мужийн гэсэн үйл ажиллагааны статустай байхаар сонгосон. Болгарт омбудсмэний талаар Үндсэн хуульдаа тусгаж өгсөн байх ба хуулийн 5 дугаар бүлэгт тус улсын парламентын хүний эрхийн омбудсмен, үндэстний болон үндэстний цөөнхийн эрхийн парламентын омбудсмэны үйл ажиллагааны талаар зааж өгсөн.⁵⁰

Улс орнуудын хууль тогтоомжид гомдол гаргахад тавигдах шаардлагын талаар зарим зүйлийг оруулсан байдаг. Үүнд нэргүй гомдлыг хүлээж авахгүй байх, гомдлыг бичгээр гаргах, (АНУ, Канадын зарим мужид утсаар гомдол гаргаж болдог), гомдолд татвар ногдуулахгүй

⁴⁹ se2.dcaf.ch/.../Files/.../ipu_hb_mongolian.pdf

⁵⁰ <http://net.jogtar.hu/jr/gen/getdoc.cgi?docid=94900020.tv&dbnum=62>

байх гэх мэт. Нөгөө талаар омбудсменд хандаж гаргасан гомдол нь тухайн асуудлаар урьд өмнө нь шүүхээр авч хэлэлцсэн эсхүл шүүхээр хэлэлцэхээр хүлээгдэж байгаа асуудал, гомдол байж болохгүй. Ер нь эрхийг хамгаалах бусад аргатай давхардахгүй байхыг хуульчилсан байдаг. Ихэнхдээ хуулиар тухайн асуудлыг хянан авч үзэх цаг хугацааны талаар заалт оруулсан байдаг. Тухайлбал ихэнхдээ эрх нь зөрчигдснөөс хойш 1-2 жилийн хугацаанд гомдлыг авч үзсэн байхаар заадаг.

Омбудсменд гаргасан гомдол бүрийг авч үзээд байдаггүй. Гомдлыг авч үзэх, эсэхийг омбудсмен өөрөө шийддэг. Түүний энэ шийдвэр эцсийн байх бөгөөд энэ талаар ямар нэг санал гомдлыг хүлээн авахгүй. Их Британид гомдлыг хүлээн авах өвөрмөц дэгийг тогтоосон нь аливаа гомдол гаргагч этгээд түүнийгээ заавал парламентын гишүүнээр дамжуулан тавих ёстой ажээ. Энэ нь нэг талаас ирж буй гомдлын тоо хэмжээг бууруулан парламентын шүүлтүүрээр орох хүндрэлтэй боловч нөгөө талаар омбудсмэний анхаарлыг хүний эрхийг зөрчиж буй нэлээд түгээмэл, тархмал болон анхаарал татсан асуудалд хандуулах ач холбогдолтой гэж үздэг.

Омбудсмэний бүрэн эрх нь мэдээж түүний чиг үүргийн зорилтоос шалтгаална. Нийтлэг шаардлага нь гэвэл тухайн гомдолтой холбогдол бүхий аливаа шаардлагатай баримт бичгийг шаардаж гаргуулж авах, төрийн бусад хяналтын байгууллагад зарим тодорхой ажиллагаа зохион байгуулж хийхийг шаардах, шаардлагатай тохиолдолд омбудсмэний оффисоос санхүүжүүлэн шаардлагатай мэргэжилтэнг хянан шалгах үйл ажиллагаандаа татан оролцуулах эрхтэй байдаг байна. Хянан шалгах явцдаа төрийн тодорхой албан тушаалтаны үйл ажиллагаа нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байдал илэрвэл хэргийг шүүхэд шилжүүлнэ. Харин тухайн хэрэгтэй холбогдох баримт бичгийг омбудсмэний цуглуулсан мэдээлэл, материал зөвхөн түүний мэдлийн байх бөгөөд шүүх тэдгээрийг хэргийн баримт болгон ашиглах боломжгүй юм.

4. Омбудсмэний үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр

Ихэнх улс оронд омбудсмен үйл ажиллагаагаа ганцаарчилсан байдлаар явуулдаггүй. Гол төлөв батлагдсан төсөвтөө багтаан оффис, товчоо байгуулан ямар орон тоотой ажиллахаа тодорхойлон гаргаж, түүнийгээ өөрөө удирдан ажилладаг байна. Оффис нь ихэвчлэн хэд хэдэн төрөлжсөн хэлтэс, байцаагчид болон шаардлагатай техник ажилтнуудаас бүрддэг. Гэхдээ тухайн орны хүн ам, хөгжил, уламжлал, гаргаж буй санал гомдлын тоо зэргээс шалтгаалж омбудсмэний оффисийн ажилтнуудын тоо харилцан адилгүй байдаг. Тухайлбал, АНУ-ын Айова мужид медиатор нь 5-6 хүнтэй оффистой байхад Нигер Улсад 1780 хүнтэй байсан тухай тэмдэглэгдсэн байдаг.

Зарим орны хуульд омбудсмэний оффист гаргасан санал гомдлыг ямар журмаар шийдвэрлэдэг дэгийн талаар товч оруулсан байдаг. Жишээ нь Канадын Колумбийн Британи мужийн Омбудсмэний тухай Актын 14, 15 дугаар зүйлд зааснаар гаргасан санал гомдлыг шалган тогтоох явцад болон эцсийн байдлаар шийдвэр гаргахаас өмнө талуудын хооронд харилцан эвлэрэх үе шат байхаар заасан байдаг байна.

Омбудсмен гаргасан санал гомдлын мөрөөр шалгаад ямарваа нэг заавал биелүүлэх эрхийн хүчинтэй шийдвэр гаргадаггүй өвөрмөц онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага болон холбогдох албан тушаалтны буруутай үйл ажиллагааны уршгаар иргэний эрх зөрчигдсөн болох нь тогтоогдсон тохиолдолд омбудсмен нь захиргааны буруутай шийдвэрийг өөрчлөх, эсхүл уг буруутай шийдвэрийн улмаас иргэнд учирсан хохирлыг төлүүлэхийг шаардсан зөвлөмж гаргах эрхтэй байдаг. Нөгөө талаар бас захиргааны байгууллагаас гаргаж байгаа шийдвэрийг илүү энэрэнгүй, боловсронгуй болгох талаар арай өргөн хүрээтэй зөвлөмж ч гаргаж болдог байна.

Туркын хувьд Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцитай Туркын Үндсэн хууль, бусад

хууль тогтоомж, хэрэгжүүлэлтийг нийцүүлэх зорилгоор шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тогтоож, эл зорилгоор хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санал болгох зэрэг бусад улсын адил нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна шаардлага гарвал гадаад орны хүний эрхийн зөрчлийг өөрийн санаачлагаар болон тухайн орны эрх бүхий байгууллагын хүсэлтээр хянан шалгаж гарсан үр дүнг тухайн улсын парламентад шууд эсхүл эрх бүхий байгууллагад хүргэдэг бөгөөд жил бүрийн тайландаа үйл ажиллагааны үр дүн, дотоодод болон гадаадад Хүний эрхийн хүндэтгэл, хэрэгжилтийн байдлын агуулгыг тусган бэлтгэдэг байна.

Мөн түүнчилэн омбудсман нь шалгасан санал гомдлынхоо дагуу тухайн асуудлаар холбогдох хууль тогтоомж, шийдвэрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Парламент болон Засгийн газарт хандсан санамж бичиг гаргаж болдог байна. Үүний зэрэгцээ зарим оронд омбудсман Үндсэн хуулийн шүүхэд шууд хандаж болдог жишиг ч бий. Харин омбудсмэний үйл ажиллагааны талаархи тайланг жил бүр парламентад бичгээр гаргаж тайлагнах асуудлыг заавал гүйцэтгэх ажлын нэг болгож хуульчилдаг байна.

Омбудсмэний бүрэн эрхийн хугацааны талаархи харьцуулалт

Хугацаа	2 жил	3 жил	4 жил	5 - 6 жил	10 жил	Хязгаар байхгүй
Улс	Австрали	Финланд, Шинэ Зеланд, АНУ-ын зарим муж	Швед, Норвеги, Дани, АНУ-ын зарим муж	Канадын болон АНУ-ын зарим муж, Израль, Испан, ОХУ Турк	Канадын Нью Брансуик муж	Их Британи, Хойд Ирланд

Омбудсмэнийг томилох

Томилох байгууллага	Парламент	Ерөнхий сайдын санал болгосноор Парламент	Парламентын санал болгосноор Ерөнхийлөгч, Амбан захирагч, Хатан хаан	Амбан захирагч	Засгийн газар, Сайд нарын Зөвлөл
Улс	Швед, Финланд, Норвеги, Дани, АНУ-ын зарим муж, Португали, Испани, ХБНГУ-ын Рейнальд-Пфальц, Австри, ОХУ	Канадын Квебек муж	Их Британи, Хойд Ирланд, Шинэ Зеланд, Канадын зарим муж, Израиль	АНУ-ын зарим муж	Франц

Омбудсманы үндсэн шинж нь олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх явдал бөгөөд манай улсад Хүний эрхийн үндэсний комиссыг адилтган үздэг. Харин манай улстай ижил төстэй эрх зүйн тогтолцоотой зарим улс орнуудын холбогдох хууль тогтоомжийг судлан үзэхэд авлигын асуудлаархи омбудсман гэсэн бүтэц байхгүй байна. Тухайлбал: Турк, Унгар, Словак, Болгар зэрэг улс. Харин авлигатай тэмцэх төрийн бие даасан статустай байгууллага байх бөгөөд энэ нь төр, төрийн байгууллагын үйл ажиллагаа ард түмэнд хүрэхдээ албан тушаалын хууль бус хүндрэлгүйгээр хүрч үйлчилдэг байхад хяналт тавьж ажиллах, төрийг авлигын сүлжээнд автуулахгүй байх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

СОНГУУЛИЙН СИСТЕМИЙН ХАРЬЦУУЛАЛТ: ДАВУУ БА СУЛ ТАЛ

Ч. Базар (Ph.D), А. Пагма (MA)


Оршил

Энэхүү судалгаагаар 1992 оноос явагдсан нийт 5 удаагийн сонгуулийн дүнг нэгтгэн тоймлож үзүүлээ. Эндээс тухайн сонгуульд оролцсон намууд хэдэн хувийн санал авч, Засгийн газраа бүрдүүлж байсныг харах боломжтой юм. Үүний зэрэгцээ нийт 5 удаагийн сонгууль нь сонгуулийн ямар системээр явагдсан болон тэрхүү системийн давуу болон сул талыг харьцуулан үзүүлэв. Мөн өмнөх сонгуулиудын туршлага, үр дүнгээс сонгуулийн системийг өөрчлөх шаардлага урган гарч байгаа гэж үзэж буй өнөөгийн тохиолдолд Монгол улс сонгуулийн ямар системийг авч хэрэглэх нь сонгогч, нам, эвсэл болоод цаашид парламентын бүтэц хийгээд Засгийн газраа бүрдүүлэхэд давуу талтайг олон улсын экспертүүд санал болгож буйг энэхүү судалгаанд эх сурвалж болгон ашиглав.

1. Сонгуулиудын нэгдсэн дүнгийн тойм

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан 1992 оноос хойш Монгол Улсад УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгууль тус бүр таван удаа явагджээ. УИХ-ын сонгууль 1992, 1996, 2000, 2004, 2008 онд явагдсан. 1990 оны 6 дугаар сард Монгол Улсын түүхэнд анх удаа олон нам өрсөлдөн оролцсон бүх нийтийн чөлөөт сонгууль болсон билээ. Энэхүү сонгуулийн үр дүн болсон БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаан 1990 оны 9 дүгээр сарын 12-ноос хуралдаж түүгээр Улсын Ерөнхийлөгчийг сонгож, Улсын Бага Хурлын бүрэлдэхүүнийг баталж, Засгийн газрыг шинээр эмхлэн байгуулсан байна.


Ардын Их Хурлын суудлын хуваарилалт⁵¹



Жич:

Бусад намд МҮДН, МСДН, ЧХН ба МХЗЭ -ийн төлөөллийг оруулсан болно.

⁵¹ Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006, 71 дэх тал


Улсын Бага Хурлын суудлын хуваарилалт⁵²

Жич: МөАН, МҮДН, НН-ын Эвсэл

1992 оны УИХ-ын сонгууль нь Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан, УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн дагуу явагдсан анхны сонгууль байлаа. 1992 оны сонгууль мажоритор системээр олон мандаттай тойрогт явагдсан.

1992 оны сонгуульд МАХН УИХ-д үнэмлэхүй олонхи болсноор Засгийн газрыг дангаараа бүрдүүлсэн. 1996 оны УИХ-ын сонгууль нь цэвэр мажоритор системээр явагдсан ба түүний үр дүнд Ардчилсан Холбоо эвсэл парламентын олонхи болж Засгийн газрыг “Ардчилсан Холбоо” Эвсэлд багтсан МҮАН, МСДН-ын гишүүд бүрдүүлсэн билээ.

1996 - 2000 оны УИХ-ын суудлын хуваарилалт



2000 оны УИХ -ын сонгууль мөн цэвэр мажоритор системээр явагдсан бөгөөд энэ сонгуульд МАХН үнэмлэхүй олонхи болж Засгийн газраа дангаараа бүрдүүлсэн.




⁵² Мөн тэнд,

2000 - 2004 оны УИХ -ын суудлын хуваарилалт



2004 оны УИХ-ын сонгууль өмнөх хоёр сонгуулийн нэгэн адил мажоритор системээр явагдсан ба тус парламентын сонгуульд аль ч нам олонхи болоогүй учраас хамтарсан Засгийн газрыг МАХН болон Эвсэлд багтсан намын төлөөллөөс бүрдүүлсэн билээ.


2004 - 2008 оны УИХ -ын суудлын хуваарилалт



2004 онд УИХ-д сонгогдсон гишүүдийн 36 нь төрийн захиргааны байгууллагад, 19 нь улс төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургуульд, 19 нь бизнесийн салбарт ажиллаж байсан ба тэдний 73 нь дээд боловсролтой, нэг гишүүн дунд боловсролтой байна. УИХ-ын гишүүдийн тав нь буюу 6.7 хувь нь эмэгтэйчүүд байна. 2008 оны УИХ-ын сонгууль нь мажоритор системээр олон мандаттай тойрогт явагдсан. Энэхүү сонгуульд МАХН олонхи болсон хэдий ч тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдлын улмаас хамтарсан Засгийн газар байгуулагдсан юм.

СУДАЛГААНЫ САН



2008 - 2012 оны УИХ-ын суудлын хуваарилалт⁵³**Сонгуулийн системийг өөрчлөх хэрэгцээ, шаардлага**

Өмнөх сонгуулийн үр дүн болон 2008 оны сонгуулийн туршлага нь “сонгуулийн шинэчлэлийн зоримог алхам хийх цаг нь болсон гэдгийг харуулсан” хэмээх дүгнэлтийг эрдэмтэн судлаачид, энэ чиглэлээр мониторинг хийдэг ТББ, олон улсын байгууллагууд хийдэг. Шалгарсан буюу хамгийн сайн систем гэж байдаггүй бөгөөд гагцхүү 1992 оноос хойш туулж ирсэн зам, Монгол орны онцлог, нөхцлүүдийг сонгуулийн системд тавигддаг ерөнхий шаардлагуудтай хослуулах хэрэгцээ, шаардлага байна. “Тухайн орны нөхцөл байдалд хамгийн сайн тохирсоныг л хамгийн сайн систем”⁵⁴ гэдэг ажээ.

Сонгуулийн системийн дараах функцүүдийг нэн түрүүнд анхаарахыг экспертүүд санал болгож байна. Үүнд:

- Төлөөлөх чадвар: санал ба мандатын хооронд тодорхой хэмжээний хувь тэнцүүлсэн харьцаа хадгалагдаж байх;
- Төвлөрөл ба нөлөө: Сонгогчдын хүсэл ба парламент дахь улс төрийн намуудын бүтцэд тодорхой хэмжээгээр төвлөрүүлэх нөлөөг үзүүлэх;
- Оролцоо: Сонгогчдод зөвхөн улс төрийн намуудын хооронд төдийгүй нэр дэвшигчдийн хооронд сонголт хийх боломж нээлттэй байх;
- Хялбар буюу нээлттэй байдал: Сонгогчдод тэдний санал нь ямар үр дүнд хүрсэн нь тодорхой байх
- Хууль ёсны байх: Сонгуулийн системийн бүтээмжийн чадвар, ардчилсан чанарт итгэх итгэл байх ёстой.

1. Мажоритар системийн тухайд

Мажоритар системээр явуулсан сонгуулийг дотор нь харьцангуй мажоритар сонгууль, үнэмлэхүй мажоритар сонгууль гэж 2 хуваадаг. Харьцангуй мажоритар сонгуулиар тухайн сонгуулийн тойрогтоо хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгодог. Үнэмлэхүй мажоритар сонгуулиар тэр тойргийн нийт сонгогчийн талаас илүү хувийг авсан хүнийг сонгогдсон гэж үздэг. Хэрэв ингэж чадаагүй бол хоёр дахь шатны сонгууль шаардлагатай болдог. Энэхүү системийн давуу тал нь Засгийн газраа байгуулах олонхийг бүрдүүлж чаддаг оршдог бол сул тал нь парламентын бүрэлдхүүнд сонгогчдын хүсэл зориг шууд тусгалаа олж чаддаггүйтэй холбоотой.

⁵³ www.open-government.mn

⁵⁴ Экхард Эссе. ХБНГУ-ын Кеми

2. Пропорциональ системийн тухайд

Ялгаатай хэлбэрүүд байдаг бөгөөд цэвэр пропорциональ систем нь саналын тоо мандатын тооны харьцаа шууд хамааралтай байдаг бол, хязгаарлагдмал пропорциональ систем нь саналын тоо мандатын тооны хооронд зөрүүтэй хамааралтай байдаг. Энэхүү тогтолцооны давуу тал нь сонгогч түмний нийт эрх ашгийн төлөөлөл парламентад бүрдэж чаддагаар илэрдэг. Харин сул тал нь:

- Парламентын төлөөллийн задралыг идэвхжүүлдэг /сул тал/
- Үндэстний хэмжээний нэгдсэн нэг тойрогт хөдөлгөөнгүй нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан нөхцөлд л хэрэглэж болдог / Улс төрийн намуудын хатуу нэрсийн жагсаалт, тус бүрдээ 76 нэр дэвшигчийн нэрстэй байх ёстой / зэрэг болно.

3. Хосолмол буюу холимог системийн тухайд

Сонгуулийн хувь тэнцүүлсэн ба мажоритар системийн зааг дээр орших сонгуулийн систем бас байдаг. Үүнийг хосолмол буюу холимог систем гэж нэрлэдэг. Энэхүү системд босгын хэмжээ хэдийчинээ өндөр байна, төдийчинээ хувь тэнцүүлсэн сонгуулийн загвараас хөндийрдөг байна. Мөн хэдийчинээ олон мандаттай тойрог олон байна, тэр хэмжээгээр хувь тэнцүүлсэн сонгуулийн систем давамгайлдаг ажээ.

Монгол оронд сонгуулийн ямар систем тохиромжтой вэ?

Монголд тохирсон сонгуулийн систем бол хосолмол буюу холимог систем юм. Зөвхөн холимог систем л төлөөлөл, төвлөрөл, оролцооны хоорондоо харилцан уялдаа бүхий төрөл бүрийн шаардлагуудыг хамгийн сайнаар биелүүлж чадна.”⁵⁵ Манай орны хувьд мажоритар системийн хуримтлуулсан туршлага, тэдгээртэй холбоотой шүүмжлэлүүд дээр үндэслэн сонгуулийн системүүдээс дараах хүлээлт үүсээд байна. Үүнд:

- Аль нэг намын хэт давуу ялалтыг бууруулах, жижиг намуудын мандатад хүрэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд сонгогчдын санал ба мандатын хувиарлалтын хоорондын хувь тэнцүүлсэн харьцааг нэмэгдүүлэх
- Улс төрийн намуудыг задралд хүргэхгүй байхын тулд хувь тэнцүүлсэн харьцааг хязгаарлах /тодорхой босго тавих/
- Сонгогчдын төлөөллийн тухай өнөөгийн төсөөллийг хангахын тулд хувь хүмүүс буюу нэр дэвшигчдийг сонгодог сонголтыг эхний зорилтын хэрэгжүүлэлтэнд нөлөөлөхгүй байх хэмжээнд хадгалах
- Парламент дахь нийгмийн төлөөллийг сайжруулахын тулд улс төрийн намуудын нэр дэвшигчдийг дэвшүүлэхэд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Улс төрийн шийдвэр гаргалтанд улс үндэсний ашиг сонирхлыг хүчтэй болгохын тулд улс төрийн хүсэл сонирхлыг бүрдүүлэгч бүтэц гэдэг утгаар нь улс төрийн намуудыг бэхжүүлэх зэрэг болно.

4. Цэвэр пропорциональ болон Холимог системийн тухайд

Цэвэр пропорциональ системээр бол 1/ улс төрийн намуудын хатуу нэрсийн жагсаалт, 2/ тус бүрдээ 76 нэр дэвшигчийн нэрстэй байх ёстой уг жагсаалт нь Монгол улсад төлөөллийг хувь хүнтэй хатуу холбосон улс төрийн соёл бүрдэн тогтсон өнөөгийн нөхцөлд төдөж удалгүй нэргүй жагсаалт гэдэг шүүмжлэлд өртөх болно. “Монголын сонгогчид аль нэг намд бус хувь хүний төлөө саналаа өгөхийг хүсдэг. Үүний зэрэгцээ Монгол улс хүн ам цөөтэй, 2.6 сая хүн амтай, нийгэмд хувь хүмүүсийн холбоо чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг

⁵⁵ Диетер Ноолен. ХБНГУ -ын Хайдельбергийн Их сургуулийн доктор, профессор

мартаж болохгүй. Иймээс хатуу жагсаалт бүхий пропорциональ сонгууль хууль ёсны байх үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ.”⁵⁶ гэжээ.

Нөгөө талаар, Үндсэн хуулийн шууд сонгох зарчим нь сонгогч нэр дэвшигчид шууд саналаа өгөх сонгуулийн системтэй байхыг хуульчилсан гэдэг нотолгоотой дүйнэ. Гэхдээ шууд сонгууль гэдгийг хүнээ шууд сонгох бус “Ямар нэгэн төлөөлөх байгууллагагүйгээр Их Хурлыг бүрдүүлнэ гэсэн ерөнхий зарчим”⁵⁷ гэж тайлбарлах хуульчид байдаг. Тэдний үзэж буйгаар намд санал өгөх замаар Их хурлаа байгуулах, хүн сонгох замаар Их хурлаа байгуулах энэ хоёрын зохистой хувилбарыг юм уу, эсхүл манай нөхцөлд хосолсон хувилбараар байж болно болох бөгөөд чадвартай Парламент, хариуцлагатай Засгийн газрын үндсэн зарчим хэрэгжнэ гэж үздэг.

Манай улс сонгуулийн холимог хувилбарыг сонгон хэлэлцэх тохиолдолд “нэг мандат-нэг тойрог зарчмаар явагдах тойргуудын мандат ба нэрсийн жагсаалтын мандатыг хооронд нь хооронд нь хэрхэн холбох нь “ гол анхаарах асуудал юм. Хэлэлцэх үед анхаарах хэд хэдэн чухал асуудал бий бөгөөд үүнд:

- Хэдэн мандат сонгуулийн тойргоор, хэдэн мандат намуудын нэрсийн жагсаалтаар хувиарлагдах вэ?
- Тойргийн шууд мандат ба жагсаалтын мандатууд хоорондоо огт холбоогүй, тусдаа байх уу?
- Эсвэл парламент дахь улс төрийн намуудыг хатуу хувь тэнцүүлсэн бүтэцтэй мэт харагдуулахын тулд жагсаалтын мандатыг тойргийн мандатыг нөхөх зарчмаар хувиарлах уу? зэрэг болно.

Германы доктор Диетер Ноолены санал болгож буй сонгуулийн холимог системийг сонгон авбал “нэг талаас парламент дахь улс төрийн намуудын бүтэц ба тэдний сонгуульд авсан саналуудын хоорондын хувь тэнцүүлсэн харьцаа хадгалагдаж нөгөөтэйгүүр сонгогчид саналаа аль нэг намаас нэр дэвшсэн хэн нэгэн нэр дэвшигч хувь хүнд өгөх болно. Улс төрийн намууд авсан мандатаа өөрийн намаас нэр дэвшигчид хувиарлахдаа нэр дэвшигч нэг мандат зарчмаар явагдах сонгуулийн тухайн тойрогт хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчид хамгийн түрүүнд хувиарлана.” гэсэн хувилбар ажээ. Энэ системийн онцлог нь:

- Сонгогч зөвхөн нэг саналтай байна. Сонгогч өөрийн харьяалагдах сонгуулийн тойргийн сонгохыг хүссэн зөвхөн нэг намын нэг нэр дэвшигчийн төлөө л саналаа өгнө. Ингэснээр шууд сонгуулиар хувь хүмүүс буюу УИХ-ын гишүүнийг сонгох сонгууль баталгаажна.
- Бүх намын бүх нэр дэвшигчийн улс орон даяар авсан саналыг нэгтгэн дүгнэнэ. Тухайн нэр дэвшигчийн авсан санал нь нэр дэвшигчийн намын улс даяар тоологдох саналын нийлбэр дүнд нэгэн зэрэг тооцогдоно. 76 мандатыг пропорцоор улс төрийн намуудад хувиарлана. Ингэснээр хувь тэнцүүлсэн сонгуулийн үндсэн зарчим баталгаажна.
- Парламентын намуудад босго тавина. Нийт сонгогчдын .../энд тодорхой хувь/ хувийн саналыг авч чадаагүй улс төрийн нам мандатын хувиарлалтад оролцохгүй. Зөвхөн босгыг давж чадсан улс төрийн намууд л хувиарлалтад оролцоно. Энэ нь парламентыг улс төрийн намын задралаас ангид байлгаж чадна.
- Хувь тэнцүүлэх хялбар зарчим баримтлана. Улс төрийн намууд парламентад хэдэн мандат авах нь тодорхой болсны дараа улс төрийн намууд тойрогт хэдэн

⁵⁶ Диетер Ноолен. ХБНГУ-ын Хайдельбергийн Их сургуулийн доктор, профессор. 2008. УБ

⁵⁷ Гавьяат хуульч Б. Чимэд. “Сонгуулийн үндсэн зарчим, түүнийг сонгуулийн хуулиар баталгаажуулахуй”, 2002. УБ

мандат авсныг тооцно. Улс төрийн намуудын хувь тэнцүүлэх зарчмаар намуудад хувиарлагдсан нийт мандатын тооноос намуудын тойргуудад авсан мандатын тоог хасна.

- Нэрсийн жагсаалт хатуу, хөдөлгөөнгүй байна. Хөдөлгөөнгүй нэрсийн жагсаалт намуудыг бэхжүүлдэг. Уг жагсаалтыг гаргахдаа зэрэгцэн улс төрийн намууд парламент дахь төлөөллөө төлөвлөж болдог. Жагсаалтаар намууд өөрсдийн нийгмийн, жендэрийн төлөөллийг хангаж тэнцвэрт байдлыг жагсаалтын дараалалд харгалзан оруулна.
- Мандатын тоог тогтоох. Нэг мандат – нэг тойрог зарчмаар хувиарлагдах мандатын тооны хувьд 38 мандатаас хэтрэхгүй байвал зохино. /Монголын хувьд/ Аль болох бага байх тусмаа сайн. /Хөдөө орон нутагт 20 мандат, 10 эсвэл 12 тойрог Улаанбаатар хотноо хувиарлагдахаар байвал хүн амын тоо, мандатын тооны харьцааны тэнцвэртэй бус байдлыг тэнцвэржүүлж болох юм/.
- Сонгуулийн хороодын санал тооллого илүү хялбар байна. Сонгогч зөвхөн нэг саналтай байдгаараа тоолоход хялбар зэрэг давуу талтай ажээ.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэхэд, шалгарсан буюу хамгийн сайн систем гэж байдаггүй бөгөөд гагцхүү 1992 оноос хойш туулж ирсэн зам, Монгол орны онцлог, нөхцлүүдийг сонгуулийн системд тавигддаг ерөнхий шаардлагуудтай хослуулах хэрэгцээ, шаардлага байна. “Тухайн орны нөхцөл байдалд хамгийн сайн тохирсоныг л хамгийн сайн систем” гэдэг байна.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛЫГ БУСАД ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ (Харьцуулсан судалгаа)

Б. Товуусүрэн, Ю. Эрдэнэтуяа, Б. Буяндэлгэр,
К. Пүрэвсүрэн, Ш. Хишигсүрэн, Б. Хатантуул

1. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛААРХИ АЗИЙН ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ (Харьцуулсан хүснэгт)

1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (Ерөнхийлөгчийн засаглалтай)⁵⁸

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Батлагдсан: 1987.10.29 Бүтэц: 10 бүлэг, 130 зүйлтэй.	128 дугаар зүйл (1) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхи эсхүл Ерөнхийлөгч гаргана.	130 дугаар зүйл (1) Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг нийтэд зарласнаас хойш 60 хоногийн дотор Үндэсний Ассамблей (ҮА) хэлэлцэж, нийт гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар шийдвэрлэнэ. (2) Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ҮА-аар хэлэлцэж дэмжигдсэнээс хойш 30-аас доошгүй хоногийн дараа ард нийтийн санал асуулга (national referendum) явуулна. Санал асуулгын дүнг Үндэсний ассамблейн сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдын олонхийн өгсөн саналаар батална. (3) Энэхүү зүйлийн 2 дэх заалтын дагуу санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт дуусгавар болж, нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг Ерөнхийлөгч нэн даруй гаргана.	128 дугаар зүйл (2) Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг сунгах тухай болон Ерөнхийлөгчийг дахин сонгох тухай Үндсэн хуульд оруулах санал нь уг өөрчлөлтийн тухай санал дэвшүүлэх үед үүргээ гүйцэтгэж буй Ерөнхийлөгчид үл хамаарна. 129 дүгээр зүйл Энэхүү өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах тухай саналыг Ерөнхийлөгч олон нийтэд 20-иос доошгүй хоногийн өмнө мэдэгднэ.
ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ SOUTH KOREA - CONSTITUTION { Adopted on: 17 July 1948} { ICL Document Status: 29 Oct 1987 } http://www.servat.unibe.ch/icl/ks00000.html	Chapter X Amendments to the Constitution Article 128 [Initiative] (1) A proposal to amend the Constitution can be introduced either by a majority of the total members of the National Assembly or by the President.	Article 130 [Majority, Referendum] (1) The National Assembly decides upon the proposed amendments within sixty days of the public announcement, and passage by the National Assembly requires the concurrent vote of two-thirds or more of the total members of the National Assembly. (2) The proposed amendments to the Constitution are submitted to a national referendum not later than thirty days after passage by the National Assembly, and are confirmed by more than one half of all votes cast by more than one half of voters eligible to vote in elections for members of the National Assembly. (3) When the proposed amendments to the Constitution receive the concurrence prescribed in Paragraph (2), the amendments to the Constitution is finalized, and the President promulgates it without delay.	Article 128 (2) Amendments to the Constitution for the extension of the term of office of the President or for a change allowing for the re-election of the President are not effective for the President in office at the time of the proposal for such amendments to the Constitution. Article 129 [Publication] Proposed amendments to the Constitution are presented to the public by the President for twenty days or more.

⁵⁸ Парламентын нэг танхимтай.

2. ЯПОН УЛС (Хязгаарлагдмал бүрэн эрхт хаант засаглалтай. Төрийн эрх барих дээд байгууллага нь парламент)⁵⁹

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Батлагдсан: 1946.11.03 Хүчин төгөлдөр үйлчилсэн: 1947.03.03 Батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт оруулаагүй. Бүтэц: 11 бүлэг, 103 зүйл.	9 ДҮГЭЭР БҮЛЭГ 96 дугаар зүйл Санаачлах эрхийг зөвхөн парламент эдэлнэ. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төлөөлөгчдийн танхим буюу доод танхим, Зөвлөхүүдийн танхим буюу дээд танхим тус бүрийн гишүүдийн 2/3-оос доошгүйн санал авсан байх шаардлагатай.	96 дугаар зүйл ...Ийнхүү гишүүдийн 2/3-ын саналаар зөвшөөрөгдсөн төслийг ард нийтийн санал асуулга явуулж шийдвэрлэнэ. Санал асуулгад оролцогчдын олонхийн дэмжлэг авсан нэмэлт, өөрчлөлтийг ард түмний нэрийн өмнөөс Эзэн хаан хуульчлах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг нь болно.	Тайлбар: Нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол Үндсэн хуулийн 9 дүгээр бүлгийн 96 дугаар зүйлд заасан журмыг баримтална. Ард нийтийн санал асуулга хамгийн чухал үндэслэл байхаар зохицуулсан байна. Санал асуулга явуулахгүйгээр Үндсэн хуульд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахыг хязгаарлажээ.
ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ THE CONSTITUTION OF JAPAN <i>November 3, 1946</i> http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html	CHAPTER IX: AMENDMENTS Article 96: Amendments to this Constitution shall be initiated by the Diet, through a concurring vote of two-thirds or more of all the members of each House and shall thereupon be submitted to the people for ratification, which shall require the affirmative vote of a majority of all votes cast thereon, at a special referendum or at such election as the Diet shall specify. 2) Amendments when so ratified shall immediately be promulgated by the Emperor in the name of the people, as an integral part of this Constitution.		

⁵⁹ Хязгаарлагдмал бүрэн эрхт хаан - Японы Эзэн хаан нь Үндсэн хуульд заасны дагуу «Бүрэн ард түмнийхээ хүсэл бодлыг илэрхийлэн, төр улс, хүн ардынхаа эв нэгдлийн бэлэг тэмдэг» нь болж байдаг ажээ. Эзэн хаан нь Төрийн тэргүүний хувьд Үндсэн хуулийн дагуу. «парламентаас сонгогдсон Ерөнхий сайдыг томилон батламжлах, Сайд нарын Танхимын саналаар Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох, Парламентын чуулганыг зарлан хуралдуулах, төлөөлөгчдийн танхимыг тараах, бүх нийтийн сонгуулийг зарлах зэрэг гол гол үүргийг гүйцэтгэдэг байна. Түүнчлэн Эзэн хаан төр засгийн хууль, зарлиг, гэрээний батламж зэргийг зарлан тунхаглах, Үндсэн ба бусад хуулийг нийтлэх, засвар оруулах гэх мэтийн үйл ажиллагаанд оролцдог байна.

3. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал)⁶⁰


Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Үндсэн хуулиа 4 удаа шинэчлэн баталсан. Баталсан: 1982.12.04 Одоогийн мөрдөж буй Үндсэн хуульд 4 удаа өөрчлөлт оруулсан. Өөрчлөлт оруулсан огноо: 1988.04.12, 1993.03.29 1999.03.15 Бүтэц: 4 бүлэг, 138 зүйлтэй.	62 дугаар зүйл Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал / БХАТИХ/ дараахь эрхийг хэрэгжүүлнэ: 1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах 2. Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих... зэрэг 15 заалттай. 67 дугаар зүйл БХАТИХ-ын Байнгын хороо дараахь эрхийг хэрэгжүүлнэ: 1. Үндсэн хуульд тайлбар хийж, Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, 2. БХАТИХ-аас батлан гаргахаас бусад дүрмийг батлах, өөрчлөлт оруулах 3. БХАТИХ-ын чуулганы завсарлагаар БХАТИХ-аас баталсан хууль, тогтоомжийн үндсэн зарчим, үзэл баримтлалыг өөрчлөхгүйгээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, хавсралтыг батлан гаргах; 4. Хуулийн тайлбар гаргах ... 7. Төрийн Зөвлөлөөс гаргасан зарлиг, захирамж зэрэг захиргааны эрхийн акт нь Үндсэн хуулийн үзэл санаатай үл нийцэхээр бол тэдгээрийг хүчингүй болгох; 8. Үндсэн хууль болон төрийн засаг захиргааны шийдвэртэй үл нийцэх муж, өөртөө засах орон, шууд харьяа хотын төрийн эрх бүхий байгууллагын тогтоосон орон нутгийн чанартай тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох	64 дүгээр зүйл Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад БХАТИХ-ын Байнгын хороо, эсхүл БХАТИХ-ын депутатуудын 1/5-ээс доошгүй депутат санаачлан БХАТИХ-ын нийт депутатын 2/3 -оос доошгүйн саналаар батална. Дүрэм, тогтоолыг БХАТИХ-ын нийт депутатын олонхийн саналаар батална.	

⁶⁰ БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурал бол төрийн дээд эрхт байгууллага мөн. Түүний байнгын байгууллага бол Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хороо мөн. (Үндсэн хуулийн 3 дугаар бүлэг, 57 дугаар зүйл)

ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ CONSTITUTION OF THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA БНХАУ-ын Хуулийн эмхтгэл, цуврал-1. УБ, 2008 он. БНХАУ-ын Үндсэн хууль 5-51 дэх тал. CONSTITUTION OF THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA (Adopted on December 4, 1982) http://english.peopledaily.com.cn/constitution/constitution.html	CHAPTER III. THE STRUCTURE OF THE STATE SECTION 1. THE NATIONAL PEOPLE'S CONGRESS Article 62. The National People's Congress exercises the following functions and powers: (1) To amend the Constitution; (2) To supervise the enforcement of the Constitution; ... Article 67. The Standing Committee of the National People's Congress exercises the following functions and powers: (1) To interpret the Constitution and supervise its enforcement; (2) To enact and amend statutes with the exception of those which should be enacted by the National People's Congress; (3) To enact,when the National People's Congress is not in session, partial supplements and amendments to statutes enacted by the National People's Congress provided that they do not contravene the basic principles of these statutes; (4) To interpret statutes; ... (7) To annual those administrative rules and regulations, decisions or orders of the State Council that contravene the Constitution or the statutes; (8) To annul those local regulations or decisions of the organs of state power of provinces, autonomous regions and municipalities directly under the Central Government that contravene the Constitution, the statutes or the administrative rules and regulations; ... Article 64. Amendments to the Constitution are to be proposed by the Standing Committee of the National People's Congress or by more than one-fifth of the deputies to the National People's Congress and adopted by a majority vote of more than two-thirds of all the deputies to the Congress. Statutes and resolutions are adopted by a majority vote of more than one half of all the deputies to the National People's Congress.
---	---

4. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС
(Парламентын удирдлагатай Бүгд Найрамдах, нэгдмэл Улс)

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
------------------------------------	---	----------------------------	--



<p>1982.10.18-ны өдөр баталж, 1982.10.20-ны өдөр ард нийтийн санал асуулга явуулахаар Төрийн мэдээлэлд нийтэлж, 1982.11.07-ны өдрийн хуулиар ард нийтийн саналаар хүлээн зөвшөөрсөнийг баталсан.</p> <p>Өнөөг хүртэл 1987, 1993, 1995, 1999 онд 2 удаа, 2001 онд 2 удаа, 2002, 2004 он нийт 9 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.</p> <p>Турк Улсын Үндсэн хууль нь эхлэл хэсэг болон 7 хэсэг /хэсэг нь дотроо бүлэгт хуваагдана/, нийт 177 зүйлтэй. Мөн 6 дугаар хэсэгт түр үйлчлэх 16 зүйлтэй.</p>	<p>I. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, сонгуульд болон ард нийтийн санал асуулгад оролцох</p> <p>175 дугаар зүйл</p> <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналыг Туркийн Үндэсний Их Хурлын нийт гишүүний хамгийн багадаа 1/3-ээс доошгүй нь бичгээр гаргана.</p>	<p>175 дугаар зүйл</p> <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай саналыг нэгдсэн чуулганаар хоёр удаа хэлэлцэнэ. Өөрчлөх саналыг нийт гишүүний 3/5-ын нууц санал хураалтаар хүлээн зөвшөөрнө.</p> <p>Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг удаа дахин хэлэлцүүлэхээр Туркийн Үндэсний Их Хуралд буцааж болно. Ийнхүү буцаасан төслийг нийт гишүүний 2/3 буюу түүнээс дээшхийн саналаар дахин хэвээр баталвал Ерөнхийлөгч уг хуулийн төслөөр ард нийтийн санал асуулга явуулж болно.</p> <p>Үндэсний Их Хурлын бүх гишүүний 3/5, эсхүл 2/3-оос доошхийн саналаар баталсан Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Ерөнхийлөгч Их Хуралд буцаагаагүй тохиолдолд ард нийтийн санал асуулга явуулахаар Төрийн мэдээлэлд нийтлэнэ.</p> <p>Шууд эсхүл Ерөнхийлөгчийн буцааснаар Их Хурлын нийт гишүүний 2/3 буюу түүнээс дээшхийн саналаар баталсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төслийн аль нэг зүйлээр Ерөнхийлөгч ард нийтийн санал асуулга явуулж болно. Ард нийтийн санал асуулга явуулахааргүй төсөл, эсхүл холбогдох зүйлийг Төрийн мэдээлэлд нийтлэнэ.</p> <p>Ард нийтийн санал асуулга явуулсан хуулийг мөрдөж эхлэхийн тулд ард нийтийн санал асуулгын хүчин төгөлдөр саналын олонхийн дэмжлэгийг авсан байх шаардлагатай.</p> <p>Үндэсний Их Хурал Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлахдаа энэхүү хуулиар ард нийтийн санал асуулга явуулахад Үндсэн хуулийн өөрчилж буй заалтуудаас алийг хамтад нь, алийг нь тус тусад нь санал хураах талаар шийдвэрлэнэ.</p>	<p>IV. Өөрчилж болохгүй зүйл</p> <p>4 дүгээр зүйл</p> <p>Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд заасан Төрийн хэлбэр нь Бүгд найрамдах болох тухай заалт, 2 дугаар зүйлд заасан Бүгд Найрамдахын шинжүүд, болон 3 дугаар зүйлд заасан заалтууд өөрчлөгдөшгүй ба өөрчлөх санал тавьж болохгүй.</p> <p>175 дугаар зүйл</p> <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцэх болон батлах нь энэхүү зүйлд зааснаас гадна хууль хэлэлцэх, болон батлах тухай заалтад хамаарна.</p>
---	--	---	--

<p>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</p> <p>THE CONSTITUTION OF THE REPUBLIC OF TURKEY</p> <p>http://www.anayasa.gov.tr/images/loaded/pdf_dosyalar/the_constitution_of_the_republic_of_turkey.pdf</p>	<p>PART SEVEN</p> <p>FINAL PROVISIONS</p> <p>I. Amendment of the Constitution, Participation in Elections and Referenda</p> <p>ARTICLE 175.</p> <p>(As amended on May 17, 1987)</p> <p>The constitutional amendment shall be proposed in writing by at least one-third of the total number of members of the Turkish Grand National Assembly. Proposals to amend the Constitution shall be debated twice in the Plenary Session. The adoption of a proposal for an amendment shall require a three-fifths majority of the total number of members of the Assembly by secret ballot.</p>	<p>ARTICLE 175.</p> <p>The President of the Republic may refer the laws related to the Constitutional amendments for further consideration. If the Assembly adopts the draft law referred by the President by a two-thirds majority, the President may submit the law to referendum.</p> <p>If a law is adopted by a three-fifths or less than two-thirds majority of the total number of votes of the Assembly and is not referred by the President for further consideration, it shall be published in the Official Gazette and shall be submitted to referendum.</p> <p>A law on the Constitutional amendment adopted by a two-thirds majority of the total number of members of the Turkish Grand National Assembly directly or if referred back by the President for further consideration, or its articles as considered necessary may be submitted to a referendum by the President. Laws or related articles of the Constitutional amendment not submitted to referendum shall be published in the Official Gazette</p> <p>Laws related to Constitutional amendment which are submitted to referendum, shall require the approval of more than half of the valid votes cast.</p> <p>The Turkish Grand National Assembly, in adopting the laws related to the Constitutional amendment, shall also decide on which provisions shall be submitted to referendum together and which shall be submitted individually.</p> <p>Every measure including fines shall be taken to secure participation in referenda, general elections, by-elections and local elections.</p>	<p>IV. Irrevocable Provisions</p> <p>ARTICLE 4.</p> <p>The provision of Article 1 of the Constitution establishing the form of the state as a Republic, the provisions in Article 2 on the characteristics of the Republic, and the provision of Article 3 shall not be amended, not shall their amendment be proposed.</p> <p>ARTICLE 175</p> <p>The consideration and adopting of proposals for the amendment of the Constitution shall be subject to the provisions governing the consideration and adoption of legislation, with the exception of the conditions set forth in this article.</p>
--	---	---	---

5. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

(Парламентын 2 танхимтай, Парламентын Бүгд Найрамдах Улс)

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
------------------------------------	---	----------------------------	--



<p>Баталсан: 1949.11.26</p> <p>Нийт 94 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Бүтэц: 22 хэсэг, 395 зүйл, 12 хавсралт, 2 нэмэлт хэсэгтэй</p>	<p>20 дугаар хэсэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах</p> <p>368 дугаар зүйл (2) Хуулийн төсөл нь танхим бүрээр хэлэлцэгдэж, тухайн танхимын гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр санал хураалт явуулж, танхимийн нийт гишүүдийн олонхиор зөвшөөрөгдсөн тохиолдолд Парламентын аль нэг танхимаас хуулийн төсөл өргөн барьснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг өргөн мэдүүлж болно.</p>	<p>368 дугаар зүйл (2) Хуулийн төслийг Ерөнхийлөгч зөвшөөрснөөр төсөлд тусгасны дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ба дараахь нөхцлийг хангана. Хэрэв дээрхи өөрчлөлт нь,</p> <p>(a) 54, 55, 73, 162 дугаар заалт, эсхүл 241 дүгээр заалт;</p> <p>(b) V хэсгийн IV бүлэг, VI хэсгийн V бүлэг, эсхүл XI хэсгийн I бүлэг;</p> <p>(c) Долдугаар зүйлд заасан жагсаалтаас аль нэг нь,</p> <p>(d) Парламент дахь Мужуудын төлөөлөл;</p> <p>(e) Энэхүү заалтад өөрчлөлт оруулахаар бол уг хуулийн төслийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээс өмнө Мужуудын хууль тогтоогчдын 1/2-ээс доошгүйн саналаар хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.</p> <p>(4) Энэхүү заалтад орсон Үндсэн хуулийн аливаа өөрчлөлтийн (III хэсэг), 1976 оны Үндсэн хуулийн актын 55 дугаар хэсэг (Дөчин хоёр дахь өөрчлөлт)-ийг мөрдөж эхэлснээс өмнө, эсхүл дараа нь бүх шатны шүүхэд маргаан үүсгэхгүй.</p>	<p>368 дугаар зүйл (1) Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийнхээ хүрээнд Парламентаас хууль хэлэлцэн батлах дэгийн дагуу Үндсэн хуулийн аливаа заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгож болно.</p> <p>(3) 13 дугаар заалтын нөхцөл нь энэхүү заалтанд орсон аливаа өөрчлөлтөнд үл хамаарна.</p> <p>(5) Аливаа асуудлыг шийдвэрлэх үүднээс, энэ заалтад заасны дагуу Үндсэн хуулийн зүйл, заалтыг нэмэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох талаар Парламентад Үндсэн хуулиар олгосон эрхэд ямар нэг хязгаарлалт байхгүй.</p>
ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ National Constitution of the Republic of Peru 1993-12-31 http://pdba.gerogetown.edu/constitution	TITULO XI REFORMA DE LA CONSTITUCION Artículo 206 La iniciativa de reforma constitucional corresponde al Presidente de la República, con aprobaciyn del Consejo de Ministros; a los congresistas.	Art.206. Toda reforma Constitucional debe ser aprobada por el Congreso con mayorna absoluta del número legal de sus miembros, y ratificada mediante referendum.	Art.206. La ley de reforma constitucional no puede ser observada por el Presidente de la Republica.

* * *

53. ДОМИНИКАНЫ БҮГД НАЙРАМДАХ УЛС

(Ерөнхийлөгчийн засаглалтай Ардчилсан Бүгд Найрамдах Улс)

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
ДОМИНИКАНЫ БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ Баталсан: 1966.11.28 16 анги, 122 зүйлтэй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухайлсан зүйлтэй. (116-120)	АРВАНЗУРГААДУГААР АНГИ ҮНДСЭН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ 116 дугаар зүйл Үндэсний Ассамблей нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.	117 дугаар зүйл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хуулиар зохицуулна. Дээд, доод 2 Танхимын нийт гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэйгээр хуралдаж шийдвэрлэнэ. Уг хуулийн төсөлд Гүйцэтгэх засаглал санал оруулахгүй.	119 дугаар зүйл. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчимд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно. 120 дугаар зүйл. Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг ямар нэгэн эрх бүхий байгууллага өөрчлөхгүй ба энэ нь хүчин төгөлдөр зүйлчлэгдэнэ.
ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ National Constitution of the Dominican Republic 1966-11-28 http://pdba.gerogetown.edu/constitution www.servat.unibe.ch/law/icl/index.html	TITULO XVI REFORMA DE LA CONSTITUCION ART. 116.- Esta Constitucion podra ser reformada si la proposiciyn de reforma se presenta en el Congreso Nacional con el apoyo de la tercera parte de los miembros de una u otra Camara, o si es sometida por el Poder Ejecutivo.	ART.117.- La necesidad de la reforma se declarara por una ley. Esta ley, que no podra ser observada por el Poder Ejecutivo. Para resolver acerca de las reformas propuestas, la Asamblea Nacional se reunirá dentro de los quince días siguientes a la publicaciyn de la ley que declare la necesidad de la reforma, con la presencia de más de la mitad de los miembros de cada una de las Cbmaras.	T. 119.- Ninguna reforma podrá versar sobre la forma de Gobierno, que deberá ser siempre civil, republicano, democrático y representativo. ART. 120.- La reforma de la Constituciyn solo puede hacerse en la forma que indica ella misma, y no podrá jamás ser suspendida ni anulada por ningun poder ni autoridad ni tampoco por aclamaciones populares.

* * *

АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Б. Чимид. "Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал" I, II. УБ, 2008 он
2. Дэлхийн улс гүрний товч лавлах. УБ, 2006
3. Саркыт Зульфикар. Францын төрийн тогтолцоо УБ, 2004
4. Британийн төрийн тогтолцоо УБ, 2003
5. Д. Цолмон, Ч. Лхагважав. Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль УБ, 2000
6. Конституционное право зарубежных стран
7. У. Мөнхбат. "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудалд", Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2005, №2
8. "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хуулийн эмхтгэл" цуврал-1, УБ 2008

Вэб хуудас:

- <http://www.constitution.org/cons/natlcons.htm>
- <http://www.constitution.garant.ru/>
- <http://www.servat.unibe.ch/law/icl/index.html>
- <http://asiapacific.narod.ru/countries/japan/>
- <http://pdba.georgetown.edu/Comp/comparative.html>
- <http://www.fas.org/>
- <http://www.ipu.org/>
- <http://catalaw.com>
- <http://www.freeality.com>
- <http://www.zakon.ru>
- <http://www.law.nyu.edu/library/research/foreign.int>
- <http://www.confunder.richmond.edu>
- <http://countrystudies.us>
- <http://www.lexadin.nl>
- <http://www.tbmm.gov.tr>
- <http://www.meclis.gov.az/>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

(Footnotes)

- 1 Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлыг нарийвчлан заагаагүй тул хууль, тогтоолын төсөл санаачлах, өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах журмын зохицуулалтыг оруулав.
- 2 Мөн адил

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛЭГТ ЗОХИЦУУЛСАН ХЭЭЛ ХАХУУЛИЙН
ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**
(Судалгаа, мэдээлэл)

У. Мөнхбат

Ерөнхий мэдээлэл

Албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын талаар 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн 263 - 273 дугаар зүйлд тус тус заажээ. Тухайлбал, 268 дугаар зүйлд хээл хахууль авах, 269 дүгээр зүйлд хээл хахууль өгөх, 270 дугаар зүйлд хээл хахууль зуучлах гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага тусгагдсан байдаг нь энэ төрлийн гэмт хэрэг тухайлбал, авлигын шинжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн буюу хээл хахууль өгсөн нь, авсан нь ч, мөн зуучилсан нь ч ялгаагүй зохих шийтгэлтэй байх ёстой гэсэн зарчмыг агуулсан байна. Уг хуульд 2008 оны 2 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө хээл хахууль өгсөн, зуучилсан этгээд энэ тухайгаа сайн дураараа эрх бүхий байгууллагад илчилсэн, мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхөөр зохицуулсан байв.

Харин хээл хахууль авсан этгээд хээл хахууль авснаа мэдэгдсэн, илчилсэн ч эрүүгийн хариуцлагаас эс чөлөөлөгдөхөөр зохицуулжээ. Үүнээс гадна тэдгээр гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын хэмжээ ч харилцан адилгүй байгаа нь нийгэмд үзүүлэх хор аюулаас хамааран тогтоосон явдал билээ. Хээл хахууль авах, өгөх болон зуучлах гэмт хэрэгт оногдуулах хариуцлагыг харьцуулан⁷⁴ авч үзвэл хээл хахууль авах гэмт хэргийн хувьд хариуцлагын хэмжээ нь хээл хахууль өгөх, зуучлахаасаа их, харин хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд хариуцлагын хэмжээ нь хээл хахууль авахаасаа бага, зуучлахаасаа их байхаар Эрүүгийн хуульд хуульчилсан нь дээрхтэй шууд холбоотой юм.

1. Монгол Улсын хэмжээнд авлигын шинжтэй гэмт хэргийн тоо ямар учраас буурахгүй байгаа вэ? Хууль нь муу байна уу? эсхүл хуулийн хэрэгжилт муу байна уу?

Энэ асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газараас гаргасан зарим тоон мэдээллийг авч үзэв. Тус газрын Мөрдөн шалгах хэлтэс нь 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж эхэлснээс мөн оныг дуусталхи хугацаанд харъяаллын 86 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас нийт 15 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг гэмт хэргийн төрлөөр ангилж үзвэл үйлдлийн давхардсан байдлаар:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 1;
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 4;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулсан гэмт хэрэг 1;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлсэн гэмт хэрэг 3;
- хээл хахууль авах гэмт хэрэг 7;
- хээл хахууль өгөх гэмт хэрэг 8;

- хээл хахууль зуучлах гэмт хэрэг 1;
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 2 тус тус эзэлж байна.

Харин 2008 оноос 2009 оны хооронд 192 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 58 хэргийг буюу 30.2 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг авч үзвэл давхардсан байдлаар:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 18;
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 9;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулсан гэмт хэрэг 8;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлсэн гэмт хэрэг 1;
- хээл хахууль авах гэмт хэрэг 29;
- хээл хахууль өгөх гэмт хэрэг 18;
- хээл хахууль зуучлах гэмт хэрэг 5;
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 2 тус тус байна.

Албан тушаалын гэмт хэргийн хувьд тухайн жилд шийдвэрлэгдсэн нийт гэмт хэрэгт эзлэх хувь, шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлтийг Монгол Улсын Дээд шүүхээс 2002-2008 оны байдлаар гаргасныг нэгтгэн харуулбал:

Албан тушаалын гэмт хэрэг улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн байдал			
Огноо	Шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Тухайн жилд нийт хэрэгт эзлэх хувь	Тайлбар
2002	36	0.4%	1986 оны хуулиар 28 гэмт хэрэг, 2002 оны хуулиар 8 гэмт хэрэг
2003	19	0.3%	
2004	19	-	28 хүн шийтгүүлсэн. Үүний дотор хахууль өгсөн 2 гэмт хэрэгт 2 хүн, хахуулийг зуулчилсан гэмт хэрэгт 1 хүн, хахууль авсан гэмт хэрэгт 5 хүн тус бүр шийтгүүлсэн.
2005	23	0.3%	
2006	15	0.3%	
2007	34	0.6%	
2008	25	0.4%	

Дээрх үзүүлэлтээс харахад албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал нь 2002 оноос 2008 оныг дуусталхи хугацаанд өссөн, буурсан, эсхүл тогтмолжсон **нийтлэг хандлага** ажиглагдахгүй байна. Харин Монгол Улсын Дээд шүүхийн Судалгааны төвөөс албан тушаалын гэмт хэрэг дотроос зөвхөн хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэргийн шүүхээр шийдэгдсэн байдлыг тухайлан авч дараахь хүснэгтээр үзүүлбэл хээл хахууль

⁷⁴ <http://www.iaac.mn/index.php?cid=22> /2009 оны 9 дүгээр сарын 7 -ны өдрийн байдлаар/

авах гэмт хэргийн хувьд 2008 онд 2 дахин өссөн, хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд тогтмол буюу 2007 онд, 2008 онд ч 2 гэмт хэрэг шийдэгдсэн байна.

	2007 он		2008 он		2009 оны эхний хагас жилд	
	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч
• Хээл хахууль авах гэмт хэрэг	6	8	13	14	3	6
• Хээл хахууль өгөх гэмт хэрэг	2	3	2	4		1
• Хээл хахууль зуучлах гэмт хэрэг		5				
Нийт	8	16	15	18	3	7

Авлигатай тэмцэх газар, Улсын Дээд шүүхээс гаргасан эдгээр судалгааны үзүүлэлтээс харахад Монгол Улсад авлигын шинжтэй гэмт хэргийн тоо тогтвортой буурахгүй байгааг Эрүүгийн хуулийн зохицуулалт болон уг хуулийн хэрэгжилттэй шууд холбон авч үзэж болохгүй юм.

2. Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсноор нийгэмд ажиглагдаж байгаа эерэг ба сөрөг тал юу вэ? Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсноор авлигын хэрэг илрүүлэлтэд хэрхэн нөлөөлсөн бэ?

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн даргатай уулзаж, энэ талаар асуухад тухайн тайлбарыг хүчингүй болгосон нь энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт цаашид буурах шалтгаан болохыг дурдаж байсан. Өмнө дурдсанаар Мөрдөн шалгах хэлтэс нь 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс 15 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснээс хээл хахууль авах гэмт хэрэг 7, хээл хахууль өгөх гэмт хэрэг 8, харин 2008 оны тайлант хугацаанд 58 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг авч үзвэл хээл хахууль авах гэмт хэрэг 29, хээл хахууль өгөх гэмт хэрэг 18 байх боловч дурдсан хугацаанд шүүхээр шийдүүлсэн нь хээл хахууль авах гэмт хэргийн хувьд 2, хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд 2 байна.

Гэтэл 2009 оны эхний хагас жилийн байдлаар шүүхэд хээл хахууль авах гэмт хэрэг 3, хээл хахууль өгөх гэмт хэрэг огт шийдвэрлэгдээгүй, харин 1 этгээд өөр гэмт хэрэгт давхар зүйлчлэгдэн шийтгүүлсэн мэдээлэлтэй байна. Эдгээр тоон үзүүлэлтээс Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсноор хээл хахууль авах, өгөх гэмт хэргийн илрүүлэлт, тэдгээрийн шийдвэрлэлтэд нөлөөлсөн хэмээн дүгнэх боломжгүй юм.

3. Дээрх тайлбарыг ямар үндэслэлээр хүчингүй болгосон бэ?

Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг, мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг⁷⁵, тухайн асуудлыг

⁷⁵ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607

хэлэлцсэн УИХ-ын чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг судлан үзэв. Засгийн газрын санаачилсан 2002 оны Эрүүгийн хуулийн төслийг хэлэлцэх явцад Цагдаагийн ерөнхий газар⁷⁶-аас ирүүлсэн саналд тусгагдсанаар “хээл хахууль өгсөн этгээд хэргээ сайн дураараа илчилж ирсэн бол гэмт хэргээс чөлөөлөх” тайлбарыг оруулсан байна. Гэвч Эрүүгийн хуульд 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэсэн тайлбарыг хүчингүй болсонд тооцсон байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас боловсруулан 2006 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэхдээ уг төслийн 5 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн “Тайлбар”-ыг хүчингүй болгохоор санаачилжээ. Гэвч Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгад 269 дүгээр зүйлийн “Тайлбар” гэснийг хүчингүй болгох асуудлыг оруулаагүй байна. Тодруулбал, танилцуулгын 2 дахь хэсэг /Эрүүгийн хуулийн тусгай ангийн талаар/-ийн 2, 13, 15-д албан тушаалын гэмт хэрэгт хамааралтай өөрчлөлтүүдэд⁷⁷ тусгагдаагүй юм.

Тодруулбал: 15-д “Эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсгийн заалт Захиргааны хариуцлагын тухай, ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн эрхийг хамгаалах, Эрүүл мэндийн, Жагсаал цуглаан хийх журмын, Хувь хүний нууцын, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн, Харилцаа холбооны тухай хуулийн холбогдох заалтаас хэрхэн ялгагдах нь тодорхойгүй байна. Иймд дараахь өөрчлөлтийг хийлээ. 104.1, 104.2, 132.1, 136.1, 181.1, 227.1, 231.1, 242.1-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар, 103.1, 128.1, 167.1, 230.1, 239.1, 240.1, 244.1-ийг хүчингүй болсонд тооцохоор тус тус тусгаж, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулав” гэжээ.

Мөн УИХ-ын гишүүн Ц. Шаравдорж, Р. Эрдэнэбүрэн нарын санаачилсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 269 дүгээр зүйлийн “Тайлбар”-ыг хүчингүй болгох асуудал тусгагдаагүй байна. Улмаар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос тогтоол гарган, дээрх 2 төслийг нэгтгэх, УИХ-ын чуулганаар хэлэлцэх бэлтгэлийг хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулснаар анхны хэлэлцүүлэгт оруулах саналын томъёоллыг гаргажээ.

Дээрх асуудалтай холбоотойгоор дараахь баримт бичигтэй танилцлаа:

1. 2007 оны 1 дүгээр сарын 3, 9-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1421/;
2. 2007 оны 5 дугаар сарын 22, 23, 29-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1422 /;
3. 2008 оны 1 дүгээр сарын 9, 30, 31-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1779 /
4. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 20-ны өдөр (Пүрэв гараг)-ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл;
5. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр (Баасан гараг) -ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл;

⁷⁶ Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг. I боть. МУИХ-ын Тамгын газрын архив. Д №5, ХН №727

⁷⁷ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607, 18-24 дэх тал

6. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр (Баасан гараг) -ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл.

Дээрхээс харахад Засгийн газраас 2006 оны 9 дүгээр сарын 12-нд, мөн УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж, Р.Эрдэнэбүрэн нараас 2007 оны 1 дүгээр сарын 2, 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус УИХ-д өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг 2006 оны 12 дугаар сарын 14, 2007 оны 1 дүгээр сарын 4, 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн ба Хууль зүйн байнгын хороо 2007 оны 1 дүгээр сарын 9, 2007 оны 5 дугаар сарын 22, 23, 29, 2008 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулжээ. Хэлэлцүүлгээр:

- 2007 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд гишүүд хээл хахууль өгөх, авахыг хэвээр нь үлдээх тухай ярисан боловч шийдэлд хүрсэнгүй, хойшлуулсан байна. /Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлтэй холбоотойгоор/- 59,60 дахь тал;
- 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн ХЗБХ-ны хуралдааны тэмдэглэлд 43 дахь санал буюу төслийн 5 дугаар зүйлийн талаар хэлэлцсэнийг сийрүүлжээ. 63 дахь талд төслийн 5 дугаар зүйлийн 269 дүгээр зүйлийн “Тайлбар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжиж байгаа эсэхээр нь санал хураажээ. /73-78 дахь талд/

4. Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсонд ямар байр суурьтай байдаг вэ?

Хэд хэдэн байгууллага, хувь хүнээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар судалгаа, санал, зөвлөмжөө ирүүлсэн ба тэдгээрийн зарим нь Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг хүчингүй болгох эсэх тухай ямар ч санал ирүүлээгүй, тэр талаар дурдаагүй байдаг. Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, Гаалийн ерөнхий газар, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газар, Монгол банк, Монголын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Монголын сонинуудын холбоо, Монголын эмнести интернэшнл байгууллага, 2 иргэн саналаа ирүүлжээ.

Харин 2 байгууллагаас 269 дүгээр зүйлийн “тайлбар”-тай холбоотой санал, судалгааг ажлын хэсэгт ирүүлсний нэг нь Ерөнхийлөгчийн Тамгын газар, нөгөө нь Авлигатай тэмцэх газар байна. Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын олон улсын гэрээ болон Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаанд⁷⁸ Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийг Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц⁷⁹-ын 15, 16 дугаар зүйлтэй харьцуулсан байх бөгөөд “хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” тухай тайлбарыг олон улсын гэрээтэй уялдуулахдаа өөрчлөх, хүчингүй болгох биш, харин хэвээр нь байлгах агуулгатай саналыг уламжилжээ.

Мөн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн саналдаа “Эцэст нь хээл хахууль өгөх гэмт хэргийн буюу 269 дүгээр зүйлийн тайлбарыг хэвээр үлдээх нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой тул хэвээр үлдээх саналтай байна”⁸⁰

⁷⁸ Энэхүү судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны сектор хийсэн.

⁷⁹ Төрийн мэдээлэл эмхтгэл. 2005 он, №43(424), 855-888 дахь тал

80 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын

гэж тодорхой тусгасан байна. Дээр дурдсанаар Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг хэвээр үлдээх саналтай байгаагаа илэрхийлсэн байна.

5. Эрүүгийн хуулийн хээл хахуультай холбоотой зүйл, заалтыг боловсронгуй болгох тал дээр олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд болон иргэдээс ирүүлсэн санал, зөвлөмж, дүгнэлт байдаг эсэх?

Асуултад дурдсанаар зөвхөн хээл хахуультай холбоотой зүйл, заалтыг боловсронгуй болгох талаар ирүүлсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг дараахь баримт бичиг, судалгаанаас түүвэрлэн авч Хавсралтаар гаргав. Үүнд:

1. Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг. I боть. МУИХ-ын Тамгын газрын архив. Д №5, ХН №727;
2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607;
3. Монгол Улс дахь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн захиалгаар хийсэн “Монгол Улс дахь авлигалын байдалд хийсэн үнэлгээ” судалгааны тайлан /2005 он/;
4. Авлигатай тэмцэх газраас 2008 онд хийсэн “Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны дүн”;
5. Транспэрэнси Интернэшнлийн (ТИ) 2009 оны Дэлхий Нийтийн Авлигын Хэмжүүр (Барометрийн судалгаа) нь авлигын тухай иргэдийн ерөнхий ойлголт болон хээл хахууль өгч, авч буй байдлын талаарх олон нийтийн төсөөллийг судалсан судалгаа;
6. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2001.1.24-2005.5.6/, Боть 1, 2008 он-106;
7. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2005.5.10-2005.11.3/, Боть 2, 2008 он-132;
8. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2005.11.3-2006.4.26/, Боть 3, 2008 он-135;
9. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2006.4.26-2008.4.30/, Боть 4, 2008 он-92.



Хавсралт 1

- Эрүүгийн хууль дахь хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын хэмжээний харьцуулалт

268 дугаар зүйл. Хээл хахууль авах	269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх	270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах	Тайлбар
268.1.Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	269.1.Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	270.1.Хээл хахууль өгч авахад зуучилсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	Эндээс харахад хээл хахууль авах нь хээл хахууль өгөх, зуучлахаасаа хариуцлагын хэмжээ нь их байгаа бөгөөд нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнээс хамааран 268.1., 269.1.-д заасан гэмт хэрэг нь “хүндэвтэр”, 270.1.-д заасан гэмт хэрэг нь “хөнгөн” гэсэн ангилалд багтаж байна.
<ul style="list-style-type: none"> Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох таван жил хүртэл хугацаагаар хорих 	<ul style="list-style-type: none"> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох гурван жил хүртэл хугацаагаар хорих 	<ul style="list-style-type: none"> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах 	



268.2.Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	269.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	270.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Харин дээрх гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн ангилал өөрчлөгдөх буюу 268.1., 268.2.-т заасан гэмт хэрэг “хүнд”, 270.2.-д заасан гэмт хэрэг нь “хүндэвтэр” гэмт хэрэг болно.
<ul style="list-style-type: none"> Эд хөрөнгийг хураах Таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих 	<ul style="list-style-type: none"> Таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих 	<ul style="list-style-type: none"> Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, таван жил хүртэл хугацаагаар хорих 	
Тайлбар: Хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. /Энэхүү тайлбарыг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хүчингүй болсонд тооцсон./	Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.	Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.	Авлигын шинжтэй гэмт хэрэг илрэх нь ховор байдаг бөгөөд энэ утгаараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал нь тухайн гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хавсралт 2.

- Эрүүгийн хуулийн хээл хахуультай холбоотой зохицуулалтын талаархи байгууллага, иргэдийн санал, зөвлөмжийн түүвэр

Субъект	Санал, зөвлөмж
2008 оны 2 дугаар сарын 1 -ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт, санал, зөвлөмж	
Ерөнхийлөгчийн тамгын газраас ирүүлсэн	Судалгаагаар Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийг Авлигын эсрэг конвенцын 15, 16 дугаар зүйлтэй харьцуулсан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн төрийн албан хаагч хээл хахууль авах, түүнд хээл хахууль өгөх тухай зүйлийн “албан тушаалтан” гэсэн субъектын хүрээг тодотгож, үүнд гадаад улсын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийг хамруулах шаардлагатай. Ингэхдээ гадаад улсын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчид хэнийг хамруулахыг нарийвчлан тодорхойлох.
	Авлигын эсрэг конвенцын 20 дугаар зүйлд “Хууль бусаар баяжих” талаархи зохицуулалт тусгагдсан ба Монгол Улсын Эрүүгийн хуульд ийм агуулгатай заалт байхгүй. Монгол Улс олон улсын гэрээний энэхүү хэм хэмжээг Эрүүгийн хуульдаа тусгалгүй Үндсэн хуульд заасан “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” үүргээ зөрчиж байна. Иймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт конвенцын заалтын агуулгаар “Хууль бусаар баяжих” гэмт хэргийг нэмж хуульчлах.
Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба	Одоогийн үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэгт заасан албан тушаалын гэмт хэргийн 263, 264 дүгээр зүйл, 272.1 дэх хэсэгт зөвхөн хохирол учруулсан тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгохоор хуульчлагдсан тул гэмтлийг үндэслэн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээр зүйлчилж байгаа ч гэсэн энэ нь хууль хэрэглэх хүрээнд ихээхэн бэрхшээл учруулж байна. Зарим тохиолдолд гэм буруутай албан тушаалтан ямар ч хариуцлага хүлээхгүй байх нөхцлийг бий болгож байна. Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263, 264 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн диспозицид хохирлоос гадна “бага бус гэм хор”, “ хүнд хор уршиг” учруулсан байхаар нэмэлт, өөрчлөлт оруулах. Мөн Эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйлд заасан “Төрийн албан тушаалтан” гэдэгт хамаарах тайлбарыг хүчингүй болгох.
	Монгол Улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нэгдсэн орсон төдийгүй УИХ-аас Авлигатай тэмцэх тухай хуулийг батлан гаргаад байна. Төрийн албан тушаалтан авлигад автсан гэх үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй хардлага газар авч байна. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт заасан гэмт хэргийн агуулга, бүтцийг НҮБ-ын дээрх конвенц, Авлигатай тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх шаардлага бий. Тухайлбал, “Албан тушаалтан хууль бусаар баяжих” гэсэн зүйл хэсгийг “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт шинээр хуульчлах нь авлигатай хийх тэмцлийн үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн сэтгэл зүй дэх хардлагын хөөрөгдлийг таслан зогсооход ач холбогдолтой байж болох юм.
	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр заасан үндэслэл бүхий хэргүүд болон мөн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн, мэдэгдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр хуульчлагдсан хэрэг /Эрүүгийн хуулийн 269, 270 дугаар зүйл гэх мэт/-ийн сэжигтэн, яллагдагчийн үйлдлийг мөрдөн байцаалтын шатнаас хялбаршуулан шийдвэрлэх журмыг хуульчлан тогтоох.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар	Эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйлүүдийн диспозицид хохирлоос гадна “гэм хор”, “хүнд хор уршиг” учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэмэлт оруулах шаардлагатай байна. учир нь төрийн албан хаагч албаны эрх мэдэл, албан тушаалынхаа байдлыг буруугаар ашиглан бусдын амь бие, эрүүл мэндэд халдан гэмтэл учруулсан хэргүүдийг албан тушаалын эсрэг гэмт хэргээр бус, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээр зүйлчлэгдэж байгаа буруу практик тогтоод байна.
Монголын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр / USAID/	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан “Авлигын гэмт хэргийн ойлголт” гэх 263 ¹ дүгээр зүйлийн үг хэллэг нь Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийн үг хэллэгтэй давхцаж байна. Авлигын хэргээр эрүүгийн хариуцлагад татах бүх нөхцөл байдлыг бүрэн тусгахын тулд энэ бүлгийг бүхэлд нь эргэж харах /дахин хянах/ шаардлагатай. Энэ хуульд албан тушаалтан ашиг хонжоо олох зорилгогүйгээр эрх мэдлээ хэтрүүлж, урвуулан ашиглаж /цагдаагийн албан хаагч хүч хэтрүүлэн хэрэглэх гэх зэрэг/ бусдад хохирол учруулсан тохиолдолд түүнийг эрүүгийн хариуцлагад татах заалт огт байхгүй бололтой. Мөн хууль бус үйлдэл, ажиллагаа нь зөвхөн их буюу онц их хэмжээний санхүүгийн хохирол учруулсан тохиолдолд л гэмт хэрэгт тооцогдож байгаа нь зүйд нийцэхгүй, мөн түүнчлэн бага хэмжээний ашиг хонжоо олсон бол авилгын гэмт хэрэг бус өөр төрлийн гэмт хэрэг болох талтай байна. Үүний зэрэгцээ шийтгэлийн төрлүүдийг эргэж харах (дахин хянах) шаардлагатай. Тухайлбал, албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашигласанд 3-6 сарын баривчлах ял шийтгэж, хээл хахууль авсанд 5 жил хүртэл хорих ял шийтгэж байна. Мөн торгуулийн хэмжээг орлогын хэмжээгээр бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож байгаа нь өндөр орлоготой хүмүүст хөнгөн, харин орлогогүй буюу бага орлоготой хүмүүст илүү хатуу шийтгэл оногдуулж байна гэсэн үг. Энэ нь Эрүүгийн хуулийн нийт зүйл, заалтад хамааралтай. Мөн бизнесийн хүрээнд дэх авилгын гэмт хэргийн зохицуулалт байхгүй бололтой.
	Мөнгө угаах гэдэг нь дийлэнх улс оронд хүнд, онц хүнд, зарим төрлийн (ашиг олох зорилготой) хүндэвтэр (хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, хууль бус мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулах гэх зэрэг) гэмт хэрэг үйлдэн олж авсан эд хөрөнгийг гүйлгээнд оруулсан гэмт хэрэг юм. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаахад бэрхшээлтэй тул бага хэмжээний мөнгө, жижиг хэргийн хойноос хөөцөлдөх нь үр ашиггүйгээс гадна олон нийтийн эрх ашигт нийцэхгүй. Үүнийг тусгах шаардлагатай болов уу. Үүнээс гадна бусад орны мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжид байдаг, нэн ялангуяа хууль бус болон мөнгө угааж олсон эд хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд саад учруулахгүй байх тухай бүхий л арга хэмжээг тусгаагүй байна. Түүнчлэн гэмт хэргийн бүрэлдэхүүн нь илт хууль бусаар олсон эд хөрөнгийг нуун далдлахын зэрэгцээ хууль ёсны болгох гэж ойлгогдож байна. Иймээс энэ заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх болно.
Монголбанк	Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулах саналтай байна. Ингэхдээ “Хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эсхүл хууль бусаар олсон эд хөрөнгө гэж сэжиглэх хангалттай үндэслэл байвал түүний эх үүсвэрийг нуун далдалж, хууль ёсны болгох зорилгоор эзэмшсэн, хүлээн авсан, ашигласан, шилжүүлсэн, эсхүл нуусан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-ээс 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчлөх.

Авлигын сэдвээр өдөр тутмын сонингийн нийтлэл, ярилцлагад дэвшүүлсэн санал, зөвлөмж	
“Өнөөдөр” сонин, 2001.11.1 “Авлигатай нийтээрээ тэмцье.” / уулзалт, ярилцлага/	Эрүүгийн хуулийг шинэчлэхдээ авлигын талаархи ойлголтыг дэлхий нийтийн жишигт ойртуулах нь чухал. Авлигад холбогдосон компани, аж ахуйн нэгжид эдийн засгийн томоохон хариуцлага хүлээлгэх механизмыг хуулиар бий болгох нь их ач холбогдолтой. /акадеимч С.Нарангэрэл/
“Өнөөдөр” сонин, 2002.4.23 “Авлигатай тэмцэх арга замууд” / нийтлэл/	Эрүүгийн болон авлигын тухай хуульд авлига өгөгч, авагч, зуучлагч, бусад субъектүүдэд ногдуулах хариуцлагын хэмжээг өөрчлөх, авлигын субъектүүдийн гүйцэтгэх буюу үүргийг зөв оновчто тодорхойлж, түүнд тохирсон арга хэмжээ оногдуулж байх./Д.Чулуунбаатар/
Өдрийн сонин, 2004.12.14 “Хээл хахуулийн хэрэг далд нууцаар үйлдэгддэг учраас тэр бүр шүүхэд ирдэггүй” / ярилцлага/	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд зааснаар албан тушаалын гэмт хэргийн бүлэгт хамаарах хэргүүдэд оногдуулах ял шийтгэлийн хэмжээ хөнгөх биш. Бусад улс оронд ялын хэмжээг өөрчлөх ялангуяа хүндрүүлэх зэрэгт урт хугацааны, өргөн цар хүрээтэй судалгаа, шинжилгээний ажлыг янз бүрийн хэлбэрээр явуулж байж, эрдэмтэд судлаачид олон нийтээр хэлэлцүүлж байж хуулиа өөрчилдөг юм билээ. /УДШ-ийн Судалгааны төвийн захирал П.Цэцгээ/
Өнөөдөр сонин, 2005.8.29 “Засаглалын шинэчлэл ба авилгатай тэмцэх нь” / илтгэл/	Авлигын эсрэг эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр доктор Д.Зүмбэрэлхам авлигын хэргийг илрүүлэх, нотлоход дөхөм үзүүлэх үүднээс авлигын үйлдлүүд нотлогдвол санаа зорилго нь нотлогдсон гэж үзэж гэм буруутайд тооцох, албан ёсны орлогоос хэт давсан хөрөнгийнхөө эх сурвалжийг тайлбарлах үүргийг иргэдэд ногдуулах, өндөр албан тушаалын этгээдийг баривчлах, байцаахад шат дамжлага багатай, чирэгдэлгүй журам тогтоох зэрэг заалтыг холбогдох хуульд тусгах. /МУИС-ийн багш, докторант М.Ганзоригийн илтгэл/
Үнэн сонин. 2005.11.10 “Зөвхөн хээл хахууль авсан хүнийг шийтгэх заалт хуульд оруулъя” / Авлигатай нийтээрээ тэмцье хэлэлцүүлэг/	... Хээл хахуулийг 3 жилий дотор арилгах бүрэн боломж байна. Үүнд хуульд зөвхөн хахууль авсан хүнийг шийтгэхээр заалт оруулах хэрэгтэй. Хахууль өгч байгаа хүн бол тухайн үедээ хахууль авагчийн дарамт эрхшээлд орж байгаа хэрэг гэж үзвэл зохино. Тэгээд хахууль өгсөн хүн нь эрт орой хэзээ нэгэн цагт өгсөн хахуулиа эргүүлж авахаар нэхэмжилж болох, хахууль өгснөө мэдээлэх эрхтэй байхаар заалт оруулах хэрэгтэй. тэгвэл хэн ч хахууль авч зүрхлэхгүй... /ХУД-ийн II хорооны иргэн Ц.Гэндэнжамц/



Монголын мэдээ 2007.9.22 “Авлигатай тэмцэхэд улс төрөөс ангид байхыг сануулав”	..Авилгатай тэмцэх газар хууль бусаар баяжих, хөрөнгө орлогын мэдүүлгийг санаатайгаар худал мэдүүлэх, өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зэрэг асуудлыг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдүүлэх хүсэлтэй байгаагаа Ерөнхийлөгч /энэ үгийг агуулгаар нь оруулав./-д танилцуулав. / Ерөнхийлөгчийн Хэвлэл, мэдээллийн албанаас мэдээллээ./
---	---



УИХ -ЫН ХЯНАЛТ ШАЛГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

*Б. Мөнхцэцэг, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл
Б. Ариунжаргал, Д. Золбоо*

АГУУЛГА**ТАНИЛЦУУЛГА****1. 1996-2000 оны хугацаанд УИХ-аас хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн нэгдсэн дүн**

- 1.1. НЭГДСЭН ТОЙМ
- 1.2. СУДАЛГААНЫ ДҮН

ДҮГНЭЛТ**АШИГЛАСАН МАТЕРИАЛ****ХАВСРАЛТ**

Хавсралт - 1

- Улсын Их Хурлын даргын захирамжаар хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2008 он

Хавсралт - 2

- Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээ 1996 - 2009 он

Хавсралт-3

- Улсын Их Хурлын Байгаль орчин Хүнс Хөдөө Аж Ахуйн Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 4

- Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 5

- Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2007он

Хавсралт - 6

- Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

• Хавсралт - 7

- Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996 - 2008 он

Хавсралт - 8

- Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл 1996-2008 он

Хавсралт - 9

- УИХ-аас 1992-2008 он дуусталх хугацаанд УИХ-ын тогтоолоор хийсэн хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгтгэл

* * *

ТАНИЛЦУУЛГА

Судалгаа мэдээллийн зорилго нь УИХ -ын гишүүн Х.Тэмүүжингийн 2009.10.19-ний өдрийн 11/6723 тоот албан бичгээр ирүүлсэн УИХ-аас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нийт хичнээн ажлын хэсгийг хэдийд хэрхэн байгуулан ажиллуулж байсан тэдгээр ажлын хэсгийг байгуулах хууль зүйн үндэслэл, зохицуулалт нь юу байгаа, түүнчлэн тухайн үед байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан ажлын хэсгүүдийн ажлын үр дүн, шийдвэрүүдийн талаархи товч мэдээлэл бэлтгэх захиалгын дагуу судалгааны төвийн судлаач Б.Мөнхцэцэг, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Д.Золбоо, Б.Ариунжаргал нар 2009 оны 10-р сарын 20-ноос 11 дүгээр сарын 5 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв. Мөн УИХ-ын хяналт, шалгалтын ажлын хэсгүүдийн шалгалтын дүнг хэлэлцсэн байдал, гаргасан шийдвэрийн биелэлтийг холбогдох Байнгын хороодоос гаргуулж авсан болно.

Судалгааны мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлсэн байдал: Судалгаа мэдээллийг хяналт, шалгалтын хэлтсийн жилийн тайланд тусгасан статистик мэдээлэл, Байнгын хороодын тогтоол, хуралдааны тэмдэглэл, ажлын хэсгүүдийн ажлын тайлан болон архивын нэгжүүдийг нэг бүрчлэн түүвэрлэн, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олдоцын хэрээр ашиглав.

Судалгааны арга зүй: 1996 - 2009 онуудын УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороодын тогтоол, УИХ -ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтсийн ажлын тайлан, хуралдааны тэмдэглэлүүдээс хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн тогтоол, үр дүнгийн талаархи материалуудыг шүүн статистик мэдээлэл бэлтгэж нэгтгэн дүгнэв.

Хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх, статистик мэдээлэл бэлтгэх явцад гарсан бэрхшээл, хүндрэлтэй асуудлууд:

- Зарим хяналт шалгалтын ажлын хэсэг илтгэх хуудас болон тайлангаа харъяалагдах Байнгын хороонд өгсөн эсэх нь тодорхойгүй
- УИХ -ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтэс тус ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны талаарх статистик мэдээг гаргахдаа УИХ-ын тогтоол болон УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын явц, шалгалтын үр дүнгийн биелэлтэнд анхаарч Байнгын хороодын тогтоолоор байгуулагдсан Хяналт шалгалтын ажлын хэсгийн шалгалтын үр дүнг төдийлөн анхаараагүй, дэлгэрэнгүй статистик бүртгэл мэдээлэл байгаагүй нь тухайн ажлын хэсгийг байгуулахдаа Тамгын газраас шийдвэрийн биелэлтийг хариуцсан хяналт тавих ажилтанг томилдоггүй, хариуцах эзэн тодорхойгүй
- Зарим Байнгын хороодын тогтоол, хуралдааны тэмдэглэл нь архивт өгөгдөөгүй, орхигдсон, архивын хавтаст оруулах материалын иж бүрдэл дутуу
- Хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн тайлан мэдээг Байнгын хороод нэгтгэх үү, хяналт шалгалт хариуцсан ажилтан хариуцах уу гэдэг нь тодорхойгүй, ажлын хэсгүүдийн ажлын үр дүнд хяналт тавих эрх бүхий субъект түүний эрх үүрэг тодорхой бус зэрэг асуудлууд байгаа нь харагдаж байна.

УИХ -ын хяналт шалгах чиг үүргийн эрх зүйн үндэслэл: УИХ-ын хяналт шалгах үйл ажиллагаа нь УИХ-ын тухай хууль, УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн холбогдох зүйл заалтуудад үндэслэн УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хорооны тогтоолоор ажлын хэсэг

байгуулах журмаар хэрэгжиж байгаа бөгөөд хяналт шалгалт болон судлан танилцах ажлын чиглэлээр ажлын хэсгүүд ажиллаж, хууль тогтоомжийн хэрэгжилт, зарим тодорхой асуудлаар шалгалт хийж иржээ.

1. 1996 - 2009 оны хугацаанд УИХ -аас хяналт, шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн нэгдсэн дүн /мэдээлэл/

1.1. Нэгдсэн тойм

УИХ -ын 1996 - 2009 оны ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр

- УИХ -ын даргын захирамжаар 31
- УИХ -ын тогтоолоор 2
- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 28
- Эдийн засгийн байнгын хороо 38
- Төрийн байгуулалтын байнгын хороо 30
- Хууль зүйн байнгын хороо 21
- Нийгмийн бодлогын байнгын хороо 25
- Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо 46
- Төсвийн байнгын хороо 26

... ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллажээ. (График – 1.1.)




График –1.1.

Тайлбар:

УИХ -ын 1996 - 2009 он хүртэлх ээлжит чуулганы хугацаанд хяналтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгүүд (УИХТГ -ын СШОНХТ 2009)

Энэ хугацаанд байгуулагдан ажилласан хяналт шалгалтын ажлын хэсгийг Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээгээр нь авч үзвэл Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороод харьцангуй ачаалалтай ажилласан үзүүлэлт харагдаж байна.

1.2. Судалгааны үр дүн:

Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн ажлын үр дүнг хэлэлцсэн байдлыг Хүснэгт 1.2.1-д гаргасан үзүүлэлтээс авч үзэхэд нийт байгуулагдсан 244 ажлын хэсгийн шалгалтын дүнг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 21 удаа, холбогдох байнгын хороодоор 125 удаа /Давхардсан тоогоор/ ямар нэг байдлаар хэлэлцэж УИХ-ын 7 тогтоол, байнгын хорооноос 62 тогтоол гарган биелэлтэнд нь хяналт тавьж ажиллажээ. Үүнээс гадна хяналтын чиглэлээр байгуулагдсан боловч ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй 60, огт ажиллагаагүй 14 ажлын хэсэг тус тус байна.

Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн нэгдсэн дүн /УИХ-ын чуулганы бүрэн эрхийн хугацаагаар/

Хүснэгт -1.2.1.

Хугацаа		Байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсгийн тоо				Гаргасан тогтоол шийдвэрийн тоо		Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал			
		УИХ-ын тогтоолоор	УИХ-ын даргын захирамжаар	Байнгын хорооны тогтоолоор	Бүгд	УИХ-ын	Байнгын хорооны	УИХ-ын нэгдсэн хуралдаанаар	Байнгын болон дэд хорооны хуралдаанаар	Ажлын хэсэг ажилаагүй	Ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй
II дахь удаагийн чуулган	1996-2000	2	7	77	86	2	12	4	40	10	14
III дахь удаагийн чуулган	2000-2004	-	9	58	67	2	10	6	17	2	21
IV дахь удаагийн чуулган	2004-2008	-	13	55	68	0	22	23	40	2	25
V дахь удаагийн чуулган	2009 онд	-	2	21	23	3	18	9	28	0	0
Дүн		2	31	211	244	7	62	21	125	14	60

Тайлбар:

УИХ -ын чуулганы бүрэн эрхийн хугацаагаар авч дүгнэлээ. УИХТГ -ын СШОНХТ 2009



УИХ -ын чуулганы бүрэн эрхийн хугацаанд хяналт, шалгалтын ажлын хэсэг байгуулагдан ажилласан байдлыг авч үзвэл: /График-1.2.1./




График-1.2.1.

* * *

1996-2009 оны хугацаанд хийгдсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн үр дүнг хэлэлцсэн байдлыг авч үзвэл: /График-1.2.2./




График-1.2.2.

* * *

1996 - 2009 оны хугацаанд ажилаагүй, ажилласан эсэх нь тодорхойгүй ажлын хэсгийн тоог авч үзвэл: /График-1.2.3./




График-1.2.3.

* * *

Дүгнэлт

УИХ-ын 1996-2009 оны чуулганы хугацаанд УИХ-ын даргын захирамж, УИХ-ын тогтоол болон Байнгын хорооны тогтоолоор нийт 244 ажлын хэсэг байгуулагдан ажиллажээ. Шалгалтын дүнг хэлэлцэж шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл нийт байгуулагдсан ажлын хэсгийн 70 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хэлэлцэгдэн шийдвэрлэгдсэн байна.

Үүнд:

- УИХ-ын тогтоол гарсан
- Байнгын хорооны тогтоол гарсан
- Байнгын хороогоор хэлэлцэж протоколд тэмдэглэсэн
- Засгийн газарт санал хүргүүлсэн
- Харъяа яамны сайдад үүрэг өгсөн
- Байнгын хороонд шалгалтын дүнг илтгэх хуудсаар танилцуулсан
- Холбогдох газарт албан тоот явуулсан зэрэг болно.

Мөн хяналт шалгалт явуулж буй асуудлын онцлогоос хамаарч шалгалтыг хойшлуулах, ажлын хэсгийн хүсэлтээр хугацааг сунгах, дахин мэргэжлийн шинжээч оролцуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх гэх мэтчилэн шийдвэрлэж иржээ. Үлдсэн 30 хувь нь ажиллаагүй болон ажилласан эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь дараах хүчин зүйлээс шалтгаалж байна.

Үүнд:

- УИХ-ын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөгдсөн
- УИХ-ын чуулганы бүрэн эрхийн хугацаа дамжсан
- Байнгын хорооны хурлаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн
- Ажлын хэсэг шалгалтын ажлын онцлогоос хамаарч дахин шинээр зохион байгуулагдсан
- Шалгалтын ажлын мэдээлэл нууцын зэрэглэлд хамаарсан
- Ажлын хэсэг ажилдаа хайнга хандсан
- Хяналт, шалгалтын ажлын үр дүнг үнэлэх нэгдсэн нэг ойлголт, шалгуур үзүүлэлт байхгүй зэрэг болно.

Жич:

Хяналт шалгалтын ажлын хэсгийн 1996-2009 оны статистик мэдээллийг УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороод тус бүрээр ангилан дэлгэрэнгүй байдлаар хавсаргав.

* * *

Ашигласан материал

УИХ-ын даргын захирамж:

1. Данс: 4. ХН-84, 213, 258, 193, 212, 140, 141, 117, 196, 182, 170, 176, 251, 259, 125, 251, 156
2. Данс: 5. ХН-164, 125, 209, 185, 205, 254, 261, 252, 178, 182, 274, 285, 200, 194, 200, 230, 161, 228,
3. Данс: 6. ХН-193, 285, 249, 264, 250, 230, 90, 200, 153, 289, 296, 200, 146, 250, 324, 103, 245,

УИХ-ын тогтоол болон Байнгын хороодын хуралдааны тэмдэглэлүүд:

- <http://intra.parliament.mn> 2001-2008 он

Хавсралт - 1

УИХ -ын үйл ажиллагааны тайлан:

1. Данс 4: ХН-1576 1996-2000 онд хийсэн Хяналт шалгалтын дүнгийн танилцуулга мэдээ
2. Данс 5: ХН-1844 УИХ-ын үйл ажиллагааны нэгдсэн тойм
3. Данс 6: ХН-1880 УИХ-ын Хянан шалгах чиг үүргийн чиглэлээр зохион байгуулсан ажлын тухай танилцуулга
4. Данс 6: ХН-619 2000-2004 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны нэгдсэн тойм
5. Данс 6: ХН-1874 2004-2008 оны УИХ-ын үйл ажиллагааны тайлан, нэгдсэн тойм
6. Данс 6: ХН- 1788 Байнгын хорооны ажлын тайлан 2004-2008 он
7. Данс 6: ХН- 1772 Байнгын хорооны ажлын тайлан 2004-2008 он
8. Данс 6: ХН- 1590 Хянан шалгах үйл ажиллагааны статистик мэдээ 2005-2006 он

Байнгын хорооны тогтоолууд:

1. Данс 5: ХН- 494	28. Данс 5: ХН- 594	55. Данс 6: ХН- 1405
2. Данс 5: ХН- 996	29. Данс 5: ХН- 1101	56. Данс 6: ХН- 1775
3. Данс 5: ХН- 1449	30. Данс 5: ХН- 1526	57. Данс 6: ХН- 154
4. Данс 5: ХН- 1751	31. Данс 5: ХН- 1792	58. Данс 6: ХН- 483
5. Данс 5: ХН- 494	32. Данс 5: ХН- 198	59. Данс 6: ХН- 937
6. Данс 5: ХН- 142	33. Данс 5: ХН- 609	60. Данс 6: ХН- 1398
7. Данс 5: ХН- 513	34. Данс 5: ХН- 1114	61. Данс 6: ХН- 1769
8. Данс 5: ХН- 1013	35. Данс 5: ХН- 1548	62. Данс 6: ХН- 119
9. Данс 5: ХН- 1461	36. Данс 5: ХН- 1428	63. Данс 6: ХН- 119
10. Данс 5: ХН- 1461	37. Данс 5: ХН- 1968	64. Данс 6: ХН- 160
11. Данс 5: ХН- 1759	38. Данс 6: ХН- 119	65. Данс 6: ХН- 495
12. Данс 5: ХН- 150	39. Данс 6: ХН- 887	66. Данс 6: ХН- 946
13. Данс 5: ХН- 523	40. Данс 6: ХН- 1363	67. Данс 6: ХН-1420
14. Данс 5: ХН- 1041	41. Данс 6: ХН- 1751	68. Данс 6: ХН-1778
15. Данс 5: ХН- 1476	42. Данс 6: ХН- 132	69. Данс 6: ХН-163
16. Данс 5: ХН- 1765	43. Данс 6: ХН-472	70. Данс 6: ХН-507
17. Данс 5: ХН- 164	44. Данс 6: ХН-896	71. Данс 6: ХН-960
18. Данс 5: ХН- 554	45. Данс 6: ХН- 1377	72. Данс 6: ХН-1428
19. Данс 5: ХН- 1061	46. Данс 6: ХН- 1756	73. Данс 6: ХН-1783
20. Данс 5: ХН- 1504	47. Данс 6: ХН- 137	74. Данс 6: ХН-436
21. Данс 5: ХН- 1778	48. Данс 6: ХН- 452	75. Данс 6: ХН-907
22. Данс 5: ХН- 181	49. Данс 6: ХН- 909	76. Данс 6: ХН-441
23. Данс 5: ХН- 574	50. Данс 6: ХН-1387	77. Данс 6: ХН-446
24. Данс 5: ХН-1081	51. Данс 6: ХН-1763	78. Данс 6: ХН-503
25. Данс 5: ХН- 1517	52. Данс 6: ХН- 145	79. Данс 6: ХН-933
26. Данс 5: ХН- 1786	53. Данс 6: ХН- 465	
27. Данс 5: ХН- 191	54. Данс 6: ХН- 918	


Улсын Их Хурлын даргын захирамжаар хийсэн хяналт шалгалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл (1996-2008)

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо • Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	УИХ-ын даргын 1996.07.23-ны 43 тоот захирамж • Ардын эрх сонин төрийн төв хэвлэхээс татгалзсан нь хууль зүйн үндэстэй эсэх	Т.Эрдэнэбилэг Д.Баттулга Л.Лувсан-Очир Ч.Отгонбаяр Д.Цогт-Очир Ц.Шаравдорж	1996.09.03-ны өдөр Байнгын хорооны болон чуулганы хуралдаанаар хэлэлцсэн	УИХ-ын 1996.09.03-ны өдрийн 45 тоот тогтоол гаргасан	1996.08.07-ны дотор УИХ-д танилцуулах (ТББХ)
14.	2003.04.04 -ний №3/3 тогтоол • Орчны бохирдлыг бууруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг Нийслэлийн нутаг дэвсгэрт танилцаж холбогдох дүгнэлт, санал боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: Л.Даваацэдэв Гишүүд: 8 бүрэлдэхүүнтэй.	2003 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцэв.	2 Байнгын хорооны хамтарсан тогтоол гарсан.	
15.	2005.02 -ний №4 тогтоол • Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах тухай Улсын Их Хурлын 2002 оны 28 дугаар тогтоолын биелэлтийн явц байдалтай холбогдох яам, газруудад танилцаж, дүгнэлт гаргах	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Дашдорж Гишүүд: Ц.Баасанжав нарын 8 бүрэлдэхүүнтэй.	Тодорхойгүй	Тодорхойгүй	Удирдамжтай
16.	2005.04.12 -ны №07 тогтоол • Монголбанкны 2004 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Монголбанкны хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2004 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүн, УИХ, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор Монголбанкнд өгөгдсөн үүргийн хэрэгжилтийн байдлыг судалж дүгнэлт гаргах	Ажлын хэсгийн ахлагч: Л.Пүрэвдорж Гишүүд: Ц.Батаа Ж.Батхуяг Л.Гүндалай Г.Занданшатар Т.Очирхүү Д.Одхүү Ц.Сүхбаатар	Тодорхойгүй	Тодорхойгүй	-

17.	2005.11.22 -ны №21 тогтоол • Монголбанкны үйл ажиллагаа болон Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, Төв банкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар хийж буй ажлыг шалгаж танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Г.Занданшатар –УИХ-ын гишүүн Гишүүд: А.Бакей –УИХ-ын гишүүн Нарын 6 бүрэлдэхүүнтэй.	Тодорхойгүй	Тодорхойгүй	-
18.	2006.01.03 -ны №01 тогтоол • Газрын тухай Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын 2005 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдлын талаар болон Нийслэлийн захирагчийн албанаар 1997 оноос хойш нийслэлд газар эзэмшүүлж, ашиглуулс, өмчлүүлсэн тухай асуудлыг шалгаж танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Сүхбаатар –УИХ-ын гишүүн Гишүүд: Б.Батбаяр Р.Буд П.Гүндалай Ц.Цэнгэл	Тодорхойгүй	Тодорхойгүй	2006 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Эдийн засгийн Байнгын хорооны хуралд танилцуулах
19.	2006.02.29 -ний №05 тогтоол • Монголбанкны үйл ажиллагаа, Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Монголбанкны дэргэдэх Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар хийж буй ажлыг хянан шалгах	Ажлын хэсгийн ахлагч: Л.Пүрэвдорж –УИХ-ын гишүүн Гишүүд: Ч.Авдай –УИХ-ын гишүүн 4 бүрэлдэхүүнтэй.			2006 оны 3 дугаар сард багтаан дуусгаж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулах
20.	2006.02.07 -ны №07 тогтоол • Газрын тухай хууль, Улсын Их Хурлын 2005 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц болон Нийслэлийн захирагчийн албанаас 1997 оноос хойш нийслэлд эзэмшүүлсэн, ашиглуулсан, өмчлүүлсэн газрын тухай асуудлыг шалгаж танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Н.Батбаяр Гишүүд: Б.Батбаяр Р.Буд Ц. Дамиран Ц.Жаргал			2006 оны 5 дугаар сарын 20-ны дотор Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах



21.	2006.11.08 -ны №17 тогтоол • Ашигт малтмалын тухай хууль, түүний дотор уг хуулийн долдугаар бүлэг буюу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, шилжүүлэх, барьцаалах, дуусгавар болгох, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн буцаан өгөхтэй холбогдсон хуулийн зохицуулалтууд болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийн явц, тухайн хуулиудтай холбогдож эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журамтай танилцаж, эдгээрийг цаашид боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: Д.Одхүү -УИХ-ын гишүүн Гишүүд: Ч.Авдай -УИХ-ын гишүүн Ц.Баярсайхан -УИХ-ын гишүүн Р.Буд -УИХ-ын гишүүн А.Мурат -УИХ-ын гишүүн Б.Нямсүрэн -Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Одсүрэн -УИХ-ын Тамгын газрын хуулийн зөвлөх А.Пүрэвсүрэн -УИХ-ын Тамгын газарт Эдийн засгийн байнгын хороо хариуцсан референт	Ажлын хэсэг шалгалтын ажлыг хийж, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт бэлтгэж, Байнгын хороонд сонсохоор бэлдсэн.		2006 онд багтаан бэлэн болгож, тус Байнгын хороонд танилцуулах
22.	2006.11.16 -ны №19 тогтоол • Ашигт малтмалын тухай хууль, түүний дотор уг хуулийн долдугаар бүлэг буюу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, шилжүүлэх, барьцаалах, дуусгавар болгох, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн буцаан өгөхтэй холбогдсон хуулийн зохицуулалтууд болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийн явц, тухайн хуулиудтай холбогдож эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журамтай танилцаж, эдгээрийг цаашид боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: А.Мурат Гишүүд: Ч.Авдай Ц.Баярсайхан Р.Буд Д.Одхүү Б.Нямсүрэн Д.Одсүрэн А.Пүрэвсүрэн	2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцэв.	Цаашид ажлын хэсгийг өргөтгөн ажиллуулж, хуулийн төсөлд оруулах саналаа бэлтгэх нь зүйтэй гэж үзсэн.	2006 онд багтаан бэлэн болгож, тус Байнгын хороонд танилцуулах
23.	2007.01.15 -ны №24 (С4) тогтоол • Авто замын салбарт төрөөс явуулж буй бодлого, хөрөнгө оруулалт, түүний эх үүсвэр, ашиглалт, замын сангийн зарцуулалт, иргэний нисэх, төмөр замын аюулгүй ажиллагааг хангах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, орлого, санхүүжилтын болон эдийн засгийн үр ашгийн байдал, эдгээр салбарт холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг шалгах, үйл ажиллагаатай газар дээр нь танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Г.Батхүү Гишүүд: Д.Бат-Эрдэнэ Ц.Баярсайхан Р.Буд М.Зоригт Б.Мөнхтуяа Л.Пүрэвдорж Нарын 12 бүрэлдэхүүнтэй.			-

24.	2007.02.15 -ны №07 тогтоол • Бичил уурхайн болон Ашигт малтмал гар үйлдвэрлэлийн аргаар олборлох тухай хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэхээр УИХ-ын хуралдаанаар шийдвэрлэж, уг төслийг дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд ашигт малтмал гар аргаар олборлох үйл ажиллагаатай газар дээр нь шалгаж танилцах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: З.Энхболд			2007 оны 4 дүгээр сарын 20-ны дотор багтаан Байнгын хороонд танилцуулах
25.	2007.03.30 -ны №08 тогтоол • Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын "бүтээгдэхүүн" гэснийг хассантай холбогдуулан "Хаягдал хөнгөн цагаан, төмрөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллагуудын үйл ажиллагаа болон хуримтлагдаад байгаа хаягдал хөнгөн цагааны хайлш, бусад бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцлөгдсөн байдалтай газар дээр нь танилцах, санал, дүгнэлт боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: Ц.Дамиран Гишүүд: Ч.Авдай Ц.Жаргал А.Мурат Б.Мөнхтуяа Д.Баасан Б.Доеддорж А.Пүрэвсүрэн Б.Идүүр П.Рина	2007 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэв.	Ажлын хэсгийн дүгнэлтийг Байнгын хороогоор сонсож, чуулганаар сонсох шаардлагагүй гэж үзэв.	2008 оны 4 дүгээр сарын 15-ны дотор багтаан гүйцэтгэх
26.	2007.07.04 -ний №21 тогтоол • Замын-Үүд боомт дэх ачааны бөөгнөрлийг зохицуулах, Төмөр замын байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үүсээд байгаа хүндрэлийн шалтгааныг газар дээр нь судалж санал, дүгнэлт гаргах	Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхтуяа Гишүүд: Ч.Авдай Б.Батбаяр Ц.Дамиран Ц.Жаргал	2007 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцэв.	Байнгын хорооны санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлсэн.	2007 оны 7 дугаар сарын 10-ны дотор Эдийн засгийн байнгын хороонд танилцуулсан.
27.	2008.03.26 -ны №06 тогтоол • Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн явц, үүнтэй холбогдуулан мөрдөж буй дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, төмөр замын аюулгүй ажиллагааг хангах, тус салбарын тээх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хийсэн ажлын үр дүн, татан авалт, хангамж, хөрөнгө оруулалт зэрэгтэй холбогдуулан төмөр замын үйл ажиллагааг холбогдох яам газарт танилцаж, дүнг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах	Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхтуяа Гишүүд: Ц.Дамиран Ц.Жаргал	Тодорхойгүй	Тодорхойгүй	2008 оны 4 дүгээр сарын 15-ны дотор багтаан гүйцэтгэх

28.	2008.03.26 -ны №07 тогтоол • Эрчим хүчний болон Сэргээг-дэх эрчим хүчний тухай хууль, хөтөлбөр болон 2007 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын үр дүн, чанар, Эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын сонгон шалгаруулах ажиллагааны бэлтгэл, явцыг холбогдох яам, байгууллагуудтай танилцаж, дүнг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах	Ажлын хэсгийн ахлагч: 3.Энхболд	Тодорхойгүй	Тодорхойгүй	2008 оны 4 дүгээр сарын 15-ны дотор багтаан гүйцэтгэх
29.	2008.03.27 -ны №08 тогтоол • Автозамын тухай хууль болон Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсвийн тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын үр дүн, 2008 оны автозамын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явц, 2008 оны хөрөнгө оруулалтын сонгон шалгаруулалт, замын ажлын бэлтгэл хэрхэн хангагдаж байгаатай холбогдох яам, агентлаг, орон нутгийн автозамын ажилтай зарим газарт танилцаж, дүнг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах	Ажлын хэсгийн ахлагч: Н.Батбаяр Гишүүд: Р.Буд Ц.Жаргал	Тодорхойгүй	Тодорхойгүй	2008 оны 4 дүгээр сарын 15-ны дотор багтаан гүйцэтгэх
30.	2008.04.01 -ний №09 тогтоол • Иргэний нисэхийн ерөнхий газар болон МИАТ компанийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, техник, зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт, борлуулалт, өртөг, зардлын байдал болон эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын үр дүн, сонгон шалгаруулалтын байдалтай газар дээр нь танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Ч.Авдай Гишүүд: Д.Ганхуяг Г.Батхүү Ц.Жаргал Д.Тэрбишдагва	Тодорхойгүй	Тодорхойгүй	2008 оны 4 дүгээр сарын 15-ны дотор багтаан гүйцэтгэх
31.	2008.10.08 -ны №04 тогтоол • 2008 онд Монголбанкнаас мөнгөний бодлого болон хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлах талаар явуулж буй үйл ажиллагааны хэрэгжилтэд дүгнэлт хийх	Ажлын хэсгийн ахлагч: Д.Тэрбишдагва Гишүүд: 9 бүрэлдэхүүнтэй.	Шалгалтын дүнг БХ-ны 2008.11.28-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан.	Шийдвэр гараагүй	

32.	2008.12.19 -ны №11 тогтоол • Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын 2008 оны Үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, 2009 оны зорилт, цахилгаан, дулааны шинэ эх үүсвэр, шугамны зураг төслийн боловсруулалт, бэлтгэл ажлын явцтай танилцаж, санал дүгнэлт боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: Н.Батбаяр Гишүүд: 9 бүрэлдэхүүнтэй.	-	-	Дууссан
33.	2008.12.19 -ны №12 тогтоол • Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж санал дүгнэлт боловсруулах	Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганхуяг Гишүүд: 6 бүрэлдэхүүнтэй.	2008.01.08-ны өдрийн БХ-ны хуралдаанаар ажлын хэсгийн дүнг хэлэлцсэн.	БХ-ны 2008.01.08-ны №17 тоот тогтоол гарсан.	
34.	2008.12.19 -ны №13 тогтоол • Ажил нь дууссан боловч санхүүжилт нь дутуу, 2009 онд баригдах барилга байгууламж арга хэмжээний санхүүжилтийн байдал, үр дүн болон гадаад зээл тусламжийн эх үүсвэрээр барихаар төсөвт тусгагдсан объект, арга хэмжээний зураг төсөв, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын байдалтай танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Г.Занданшатар Гишүүд: 7 бүрэлдэхүүнтэй.	-	-	Дууссан
35.	• 2009 оны Хүнсний хөтөлбөр, мах үр тарианы хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, малчдын орлогын эх үүсвэрийг дэмжих чиглэлээр улсын төсвөөс урьд жилүүдэд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн олон ХХААЯ-нд хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт, бэлтгэл ажлын явцтай танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Д.Балдан-Очир Гишүүд: 6 бүрэлдэхүүнтэй.	-	-	Дууссан
36.	2008.12.19 -ний №14 захирамж • Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах	Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганхуяг Гишүүд: 8 бүрэлдэхүүнтэй.		Ажил үргэлжилж байгаа	

* * *

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН



Хавсралт - 9

УИХ-аас 1992-2008 он дуусталх хугацаанд УИХ-ын тогтоолоор хийсэн хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгтгэл

Д/д	Ажлын хэсэг байгуулсан шийдвэр, огноо • Ямар асуудлаар шалгалт хийсэн	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /УИХ-ын гишүүд, бусад албан хаагч/	Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал	Гаргасан шийдвэр	Тайлбар
1.	1993.07.16 №65 • Орон сууц хуваарилалт, хувьчлалын ажилд хяналт тавих, иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах асуудал боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Ш.Батбаяр Гишүүд: Д.Батбаатар, Ж.Бямбажав, Б.Ганболд, Г.Ганболд, Т.Ганди, Ж.Жадамбаа, С.Зориг, Г.Зуунай, Д.Мөнхөө, С.Төмөр, Н.Тогтох, Ж.Уртнасан, Р.Цагаанхүү	Тодорхойгүй		
2.	1993.12.27 №98 • УАБХЕГ бусад тусгай албадаас УАБХ тухай хуулийн заалтыг хэрхэн биелүүлж байгааг болон нууц баримт материалын бүрэн бүтэн байдлын хадгалалт, хамгаалалттай холбоотой асуудлыг хянан шалгах	Ахлагч: Д.Лүндээжанцан Гишүүд: Г.Ганболд, М.Зэнээ Д.Базарсад, А.Ганбаатар, Ч.Зоригтбаатар, Ц.Шарав-Дорж, Ц.Элбэгдорж	Хэлэлцсэн		1994.01.12 ны дотор УИХ болон УАБЗ-д танилцуулах
3.	1999.07.16 №52 • МУЕСайд Ж.Наранцацралтаас 199901.19-ний өдөр ОХУЗГ-ын ЕС-ын орлогчид хаяглан захидал бичсэн нөхцөл байдал, үүнээс үүсч болох үр дагаврыг шалган тодруулах	Ахлагч: Ц.Төмөртоого Гишүүд: С.Төмөр Л.Лувсан-Очир	Тодорхойгүй		
4.	1999.10.07 №60 • МУ, ОУ-ын Хөгжлийн ассоциацийн хооронд 1999.06.18-ны өдөр байгуулсан Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн тухай Хөгжлийн зээлийн гэрээний хэрэгжилтэнл хяналт тавих	Ахлагч: Ц.Ганхуяг, Гишүүд: Н.Алтанхуяг С.Баярцогт, Ц.Нямдорж О.Дашбалбар, Ч.Улаан, Я.Эрхэмбаяр	Тодорхойгүй		2000.06.15-ны дотор УИХ-д танилцуулах
5.	2004.09.06 №11 • УИХ-ын Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдхүүн батлах	Р.Амаржаргал Р.Гончигдорж Н.Энхболд			



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНГИЛАЛЫН ТУХАЙ
(Лавлагаа, мэдээлэл)

У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, К. Пүрэвсүрэн

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой лавлагаа, мэдээлэл

Төрийн албаны тухай хуулийн 3.3 -т төрийн албыг, 5.1 -д төрийн албан тушаалыг тус тус төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний гэж ангилсан юм. Харин тус хуулийн 7.1.7 -т зааснаар “Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, яам болон хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал, төсвийн бусад байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга (захирал, эрхлэгч)” -ыг төрийн захиргааны, 9.1.2 -т зааснаар “боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга (захирал, эрхлэгч)-аас бусад удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал” -ыг төрийн үйлчилгээний алба, албан тушаалд хамааруулахаар зохицуулсан байна. Эдгээрийг 2008 оны 5 дугаар сарын 6 -ны өдрийн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөн найруулсан.

Оросын Холбооны Улс

Тус улсад 2003 оны Төрийн албаны тогтолцооны тухай болон 2004 оны Төрийн иргэний албаны тухай хуулиар гол харилцааг зохицуулсан байх бөгөөд төрийн алба, албан тушаалыг дараахь байдлаар ангилжээ.

Нэг. ОХУ-ын Төрийн албаны тогтолцооны тухай хууль

Энэхүү хуулийн 2.1-т зааснаар “Төрийн албаны тогтолцоо нь дараахь төрийн албаны төрлүүдийг агуулна” гээд үүнд төрийн иргэний алба, цэргийн алба, хууль сахиулах /хамгаалах/ албыг багтаасан байна. Төрийн иргэний алба нь дотроо Холбооны /улс/ төрийн иргэний алба, ОХУ-ын субъектүүд /муж улс/-ийн төрийн иргэний алба гэж хуваагдана. Хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд дээрх 3 төрлийг тодорхойлсноос үзвэл манай улсын төрийн албаны ангилалтаас өөр байгаа юм. Харин уг хуулийн 8 дугаар зүйлд төрийн албаны албан тушаалыг Холбооны төрийн иргэний албаны албан тушаал, ОХУ-ын субъектүүдийн төрийн иргэний албаны албан тушаал, цэргийн албан тушаал, хууль хамгаалах албаны албан тушаал гэж хуваагдахаар тодорхойлсон байна.

Хоёр. ОХУ-ын Төрийн иргэний албаны тухай хууль

Уг хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар төрийн иргэний албаны албан тушаал нь төрөл /категор/ болон бүлэг /групп/-т хуваагдах ба удирдах албан тушаал, зөвлөхүүдийн, мэргэжилтнүүдийн, гүйцэтгэх /хангах/ мэргэжилтнүүдийн албан тушаал гэсэн төрөлтэй байна. Харин дараахь бүлэгт хуваагдана:

- Төрийн иргэний албаны дээд албан тушаал
- Төрийн иргэний албаны ерөнхий албан тушаал
- Төрийн иргэний албаны тэргүүлэх албан тушаал
- Төрийн иргэний албаны ахлах албан тушаал
- Төрийн иргэний албаны дэд /доод/ албан тушаал

Албан тушаалын төрөл, бүлэг нь хоорондоо дараахь байдлаар уялдсан байдаг. Үүнийг дээрх хуулийн 9 дүгээр зүйлийн 4, 5, 6 дахь хэсэгт тодорхой зохицуулсан.

Удирдах албан тушаал	Зөвлөх албан тушаал	Мэргэжилтэн	Гүйцэтгэх мэргэжилтэн
Дээд албан тушаалын бүлэг	Дээд албан тушаалын бүлэг	Дээд албан тушаалын бүлэг	
Ерөнхий албан тушаалын бүлэг	Ерөнхий албан тушаалын бүлэг	Ерөнхий албан тушаалын бүлэг	Ерөнхий албан тушаалын бүлэг
Тэргүүлэх албан тушаалын бүлэг	Тэргүүлэх албан тушаалын бүлэг	Тэргүүлэх албан тушаалын бүлэг	Тэргүүлэх албан тушаалын бүлэг
		Ахлах албан тушаалын бүлэг	Ахлах албан тушаалын бүлэг
			Дэд/доод албан тушаалын бүлэг

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ -ын Төрийн албатны хууль)

Хятад Улсын Төрийн албатны хуулийн дагуу төрийн албаны ангиллыг тогтооно. Төрийн албаны ангилалыг тогтоохдоо албан тушаалын шинж чанар, онцлог, гүйцэтгэх үүргийн хамаарлыг харгалзан:

- ерөнхийлөн хамаарах төрөл,
- тусгай мэргэжлийн төрөл
- засаг захиргааны хууль хэрэгжүүлэх гэсэн 3 төрөлд хуваана.

Төрийн явдлын хороо нь уг хуулийг үндэслэн төрийн албаны онцлог, шаардлагыг харгалзан ангилалын төрлийг нэмэгдүүлж болно. Ийнхүү ангилалын төрлийг нэмэгдүүлэх тохиолдолд хөрөнгө зардлын хэмжээг төрөөс тогтооно. Албан тушаалын ангиллын төрлийг үндэслэн албан тушаалын дэс дараалалыг дараах байдлаар хуульд тусгажээ. Албан тушаалыг удирдах тушаал болон удирдах бус /гүйцэтгэх/ тушаал гэж ангилна

- Удирдах тушаалын дэсийг улсын дэсийн жинхэнэ тушаал
- Улсын дэсийн дэд тушаал
- Муж яамны дэсийн жинхэнэ тушаал
- Муж яамны дэсийн дэд тушаал
- Тэнхим товчооны дэсийн жинхэнэ тушаал
- Тэнхим товчооны дэсийн дэд тушаал
- Сиян газрын дэсийн жинхэнэ тушаал (Сиян - засаг захиргааны нэгжийн нэр)
- Сиян газрын дэсийн дэд тушаал
- Сум салааны дэсийн жинхэнэ тушаал
- Сум салааны дэсийн дэд тушаал гэж хуваана.

Гүйцэтгэх /удирдах бус/ тушаалын зэрэг дэвийг /дэс/ буурах дарааллаар /тэнхим товчооны дэсээс эхлэн/ тохируулна. Мөн хуулийн 17 дугаар зүйлд, “ерөнхийлөн захирах төрлийн удирдах тушаалыг үндэслэн хууль, холбогдох бусад хууль цааз, тушаалын зэрэг дэв болон байгууллагын гүйцэтгэх үүргийг үндэслэн тогтооно” гэжээ. Ерөнхийлөн хамаарах

төрлийн гүйцэтгэх албан тушаалыг:

- тойрон байцаагч,
- дэд тойрон байцаагч,
- байцаан судлагч,
- дэд байцаан судлагч,
- эрхлэгч,
- дэд эрхлэгч,
- албачин гэж ангилна.

Ерөнхийлөн захирах төрлөөс бусад албан тушаалын зэрэг дэвийг албан тушаалын дэс дараалалыг тус хуулийг үндэслэн улсаас тусдаа /хуулиар/ тогтооно.

- 18 дугаар зүйлд, “энэ байгууллагууд тогтоосон үүрэг тушаал, зэрэг дэв /дэс баримжаа/, орон тооны хязгаарлал, албан тушаалын тоо, зарцуулагдах төсвийн /жич бодогчийн/ харьцааг үндэслэн тус байгууллагынхаа албан тушаалтны байж болох бодит тоог тогтоох ба үүний үндсэн дээр мөн тэдний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын хэм хэмжээг тогтооно.”
- 19 дүгээр зүйлд, “албан тушаалтны гүйцэтгэх үүрэг нь түүний зэрэг дэвд тохирсон байна. Албан тушаалтны ажил болон зэрэг дэвийн тохирох харьцааг төрийн явдлын хорооноос тогтооно. Албан тушаалтны эрхлэх ажил болон зэрэг дэв бол албан тушаалтны цалин болон бусад хангамжийг тогтоох үндэслэл болно. Албан тушаалтны зэрэг дэвийг гүйцэтгэж буй үүрэг болон тус төрийн албанд тохирох ёс зүй, ажлын гүйцэтгэх бодит чадвар, хүлээх хариуцлага зэргийг үндэслэн тогтооно. Төрийн албан хаагч бүр хуулиар тогтоосон шалгуур журмын дагуу нэгэн адил зэрэг дэв дэвшиж болно.”
- 20 дугаар зүйлд, “Улсаас ардын цагдаа болон боомт, гадаадад суугаа гадаад харилцааны ажилтны ажлын онцлогийг үндэслэн албан тушаалтай нь дүйцэхүйц цолын дэсийг гаргана” гэж заажээ.

Бүгд Найрамдах Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улсын төрийн албан хаагчдын эрх зүйн асуудлыг 1965 оны 7 дугаар сарын 14-ны өдрийн 657 дугаар Төрийн албан хаагчдын хуулиар тусгайлан зохицуулсан байдаг. Уг хуулийн агуулга нь Нэгдсэн болон холимог төсөвтэй байгууллага, мужийн тусгай захиргаа /мужийн өөрөө удирдах байгууллага/, дүүрэг, мужийн тусгай захиргааны болон дүүргүүдийн байгуулсан нэгдэл, эдгээрийн оролцоотой эргэлтийн хөрөнгө бүхий байгуулалт, хуулиар байгуулсан сангууд, батлан даасан үйлдвэрчний эвлэлүүд, биеийн тамир хүмүүжлийн бүсийн удирдлагад ажиллаж буй албан хаагчдыг хамаарна.

Гэрээ болон түр ажилтанд энэхүү хуулиар тогтоосон тусгай заалтууд хэрэгжинэ. Туркын Төрийн албан хаагчдын үндсэн зарчмыг Төрийн албан хаагчдын хуулийн 3 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан бөгөөд энэхүү хуулийн үндсэн зарчим нь,

- Ангилах: Төрийн албаны үүрэг болон энэхүү үүргийг хэрэгжүүлж буй төрийн албан хаагчийг үүргийнх нь шаардлагын шинж болон мэргэжлээр нь ангид хуваарилах,
- тушаал дэвших: Төрийн албан хаагчид гүйцэтгэж буй ажлынх нь шаардлагатай мэдлэг болон боловсрох болзолд нийцсэн байдлаар ангилал дотроо хамгийн дээд зэрэгт хүрэх боломжийг олгох,
- сайшаах: Төрийн албанд орох, ангилал дотор дэвших, дээшлэх, үүргээ дуусгавар болгохыг нь сайшаах тогтолцоогоор болон энэхүү тогтолцооны тэгш боломжийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчийн итгэлийг хангах.

Төрийн албан хаагчдын хуулийн 2 дугаар хэсгийн гарчиг нь ангилал гэсэн байх бөгөөд уг хуулийн 36 дугаар зүйлд энэхүү хуульд хамаарагдсан байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчийн анги нь дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

1. Ерөнхий захиргааны албаны анги/бүлэг
2. Техникийн албаны анги
3. Эрүүл мэндийн албан болон эрүүл мэндийн туслах албаны анги
4. Боловсрол болон сургалтын албаны анги
5. Өмгөөллийн албаны анги
6. Шашны албаны анги
7. Хамгаалалтын /Цагдаа/ албаны анги
8. Туслах албаны анги
9. Нутгийн захиргааны удирдлагын албаны анги
10. Үндэсний тагнуулын албаны анги гэж ангилжээ.

Гэхдээ эдгээр нь салбар чиглэлээр төрийн албанд хамаарагдаж буй боловч албан тушаалтнуудын ангилал нь дотроо тусгайлсан хуулиар цааш нарийвчлан зохицуулагдсан байна. Харин ХБНГУ-д өнөөдөр “төрийн алба” гэх ойлголт байхгүй бөгөөд Дэлхийн нэгдүгээр дайны дараа “нийтийн алба” гэсэн нэр томъёо гарч ирсэн. “Нийтийн алба” гэсэн ойлголт нь 3 төрлийн этгээдийг агуулах ба үүнд түшмэл, албан хаагч, ажилтан орно. Түшмэлийн үйл ажиллагааг зохицуулах гол хэм хэмжээний акт нь 1971 оны Түшмэлийн тухай Холбооны хууль юм. Энэхүү хуулийн дагуу түшмэл гэдэгт төрийн аппаратын түшмэл, шүүгч нар, сургууль болон дээд боловсролын байгууллагын багш нар, цэргийн албан хаагч, шуудангийн ажилтнууд гэх мэт этгээд тооцогдохоор зохицуулжээ.

Эдгээрээс үзэхэд улс орнуудын төрийн байгуулал, төрийн албаны тогтолцоо нь улсуудын онцлогоос хамааран харилцан адилгүй байгаагаас шалтгаалан төрийн албаны болон албан тушаалын ангилал нь мөн ялгаатай байна. Захиалгын дагуу боловсрол, эрүүл мэндийн салбарын албан тушаалтан төрийн албаны ямар ангилалд хамаарахыг судлан үзэхэд ихэнхдээ төрийн үйлчилгээний албанд хамаарах ба зарим улсын хувьд эдгээр албан хаагчдын талаархи нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Мөн манай улсад хэрэглэж буй төрийн захиргааны алба гэх нэр томъёо бидний судласан улсуудын эрх зүйн актад байхгүй байна.

Хэдийгээр гадны хууль тогтоомж, зохицуулалтыг судлан үзэж зохих санаа авах нь зүйн хэрэг боловч судлан үзсэн зарим орнуудын эрх зүйн нарийвчилсан зохицуулалт нь өөр өөрийн орны онцлогтой, хоорондоо нэлээд ялгаатай байна. Иймд эдгээр төрийн албан хаагчдын ангилалыг өөрчлөхөд улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, одоогийн энэ ангилалд байснаар гарч буй бодит сөрөг болон эерэг талуудыг жишин үзэж ангилалыг тогтоох нь илүү үр дүнтэй байж болох юм.



ЦААЗААР АВАХ ЯЛЫН БАЙДАЛ, ХАНДЛАГА, БАЙР СУУРЬ

Б.Хатантуул, У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, Ю. Эрдэнэтуяа

Агуулга

1. Цаазаар авах ялыг халах тухай олон улсын баримт бичгүүд
2. Цаазаар авах ялын дэлхий нийтийн байдал
3. Монгол Улсын хууль тогтоомж дахь ялын дээд хэмжээ
4. Цаазаар авах ялын талаарх олон нийтийн санаа бодол
5. Хавсралт. Цаазаар авах ялыг халсан болон хэрэглэж байгаа орнууд

* * *

Нэг. Цаазаар авах ялыг халах талаарх олон улсын баримт бичгүүд

Цаазаар авах ялыг халах тухай олон улсын дөрвөн гэрээ, хэлэлцээр байдгийн нэг нь дэлхий нийтийн, гурав нь бүс нутгийн улс орнуудад үйлчлэх баримт бичгүүд байна. Улс орнууд эдгээр баримт бичгийн үзэл санааг хүлээн зөвшөөрч соёрхон баталснаар тухайн гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон *оролцогч улс* болно. Ингэснээр олон улсын эрх зүйн хүрээнд заасан нөхцлүүдийг хамгаалах, хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Мөн улс орнууд гэрээ, хэлэлцээрийн үзэл санааг дэмжиж *гарын үсгээ зурж* болдог бөгөөд энэ нь тухайн баримт бичгийн зорилго, зорилтыг үгүйсгэх ямар нэг зүйл хийхгүй байхыг хүлээж буй хэрэг юм.

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хоёр дахь нэмэлт Протокол

Цаазаар авах ялыг халах зорилго бүхий энэхүү баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд баталжээ. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халахыг хангадаг бөгөөд оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд энэ ялыг дайны цагт хэрэглэхийг зөвшөөрдөг байна. Тухайлбал, 2008 онд Аргентин, Чили, Гондурас, Руанда, Узбекистан зэрэг 5 улс уг Протоколд нэгдэн орсноос Чили улс дайны үеийн онц ноцтой цэргийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял хэрэглэж болзошгүй хэмээн урьдчилан тайлбар хийсэн байна. Хүний эрхийг хамгаалахын төлөөх олон улсын хөдөлгөөн Эмнести Интернэшнл байгууллагаас гаргасан судалгаагаар 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү Протоколд оролцогч 70 орон⁸¹, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан боловч хараахан соёрхон батлаагүй байгаа 4 орон байгаа ажээ (Гвиней-Бисау, Никарагуа, Польш, Сан-Томе ба Принсипи).

Хүний эрхийн Америкийн конвенцийн Протокол

Америкийн улсуудын байгууллагын Ерөнхий Ассамблей 1990 онд баталсан бүс нутгийн

⁸¹ Албани, Андорра, Аргентин, Австрали, Австри, Азербайжан, Белги, Босни Герцеговин, Болгар, Канад, Кабо Верде, Чили, Колумб, Косто Рика, Хорват, Кипр, Чех, Дани, Жибути, Эквадор, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Грек, Гондурас, Унгар, Исланд, Ирланд, Итали, Либер, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальт, Мексик, Молдав, Монако, Монтенегро, Мозамбик, Намиби, Непал, Голланд, Шинэ Зеланд, Норвеги, Панам, Парагвай, Филиппин, Португаль, Румын, Руанда, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Сэйчэллийн арлууд, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцари, Зүүн Тимор, Турк, Туркмен, Украин, Их Британи, Уругвай, Узбекистан, Венесуэл

улс орнуудад үйлчлэх баримт бичиг. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халахыг хангадаг бөгөөд оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд энэ ялыг дайны цагт хэрэглэхийг зөвшөөрдөг байна. 2008 оны байдлаар Өмнөд Америкын 11 орон уг Протоколыг хүлээн зөвшөөрч баталснаар оролцогч орон (Аргентин, Бразил, Чили, Коста Рика, Эквадор, Мексик, Никарагуа, Панам, Парагвай, Уругвай, Венесуэл) болжээ.

3. Хүний эрхийн Европын конвенцийн 6 дугаар Протокол

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн цаазаар авах ялыг халах талаарх заалтыг хэрэгжүүлэхээр Европын зөвлөлөөс 1982 онд батлан гаргасан баримт бичиг. Энэ нь энх тайван цагт цаазаар авах ялыг халахыг хангадаг боловч оролцогч улс дайны болон дайн бүхий байдлын цагт энэ ялыг хэрэглэх боломжтой ажээ. 2008 оны байдлаар уг Протоколд Хүний эрхийн Европын конвенцид оролцогч 46 орон уг Протоколд оролцогч орон, ОХУ хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байна.

4. Хүний эрхийн Европын конвенцийн 13 дугаар Протокол

Энэхүү баримт бичгийг Европын зөвлөлөөс 2002 онд батлан гаргажээ. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халах буюу дайны болон дайн бүхий байдлын цагт ч хэрэглэхийг хориглодог байна. 2008 оны байдлаар уг Протоколд оролцогч 40 орон⁸², гарын үсэг зурсан 5 орон байна. (Армени, Итали, Латви, Польш, Испани)

Цаазаар авах ялыг халах тухай олон улсын дээрх үндсэн баримт бичгүүдээс гадна 2008 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей цаазаар авах ялаас түр хугацаагаар түдгэлзэхийг уриалсан хоёр дахь тогтоолоо батлан гаргажээ. НҮБ-ын нийт гишүүн орнууд хамтран цаазаар авах ялаа түр зогсоохыг уриалсан тогтоолыг баталсан нь нийт улс орнууд болон бүс нутгийн хэмжээнд зарим чухал алхам хийхэд зохих түлхэц болж байна. Жишээ нь, Африкийн Хүний эрхийн хорооноос цаазаар авах ялыг хэрэглэж байгаа Африкийн улсуудад хандан бүс нутгийн хэмжээнд энэ ялыг халах чиглэлийг баримтлан цаазаар авах ялын гүйцэтгэлийг түр хугацаагаар түдгэлзүүлэхийг уриалсан байна.

Мөн Арабын иргэний нийгэм, Арабын орнуудын холбоо, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар ба түүнчлэн олон улсын төрийн бус байгууллагуудын (Эмнести Интернэшнл г.м) төлөөлөгчид 2008 оны 5 дугаар сард Египетэд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2007 оны 62/149 тоот тогтоолын хэрэгжилтийн тухай хэлэлцэж, цаазаар авах ялыг аажимдаа халах, 18-аас доош насныханд энэ ялыг оноохгүй байхын тулд бодит алхамыг авч хэрэгжүүлэхийг Арабын орнуудаас уриалсан хамтарсан тунхаглал гаргажээ. Түүнчлэн 2010 оны 10 дугаар сард болох НҮБ-ын 65 дахь удаагийн Ерөнхий Ассамблейн чуулганд цаазаар авах ялыг түр зогсоох тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2007, 2008 оны хоёр тогтоолын хэрэгжилтийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргын тайланг хэлэлцэх юм.

2010 оны 2 дугаар сард Женев хотноо болсон “Цаазаар авах ялын эсрэг дэлхийн 4 дүгээр конгресс” –оос дараах 5 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Иргэний нийгмийн байгууллагууд болон улс орнуудын төр, засгийн газрын цаазаар авах ялын эсрэг хамтын ажиллагааг өргөжүүлэх

⁸² Албани, Андорра, Армени, Австри, Азербайжан, Белги, Босни Герцеговин, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальт, Молдав, Монако, Монтенегро, Голланд, Норвеги, Польш, Португаль, Румын, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи

2. Африк, Ази, Өмнөд Америк болон Карибын орнуудын цаазаар авах ялын эсрэг байр суурийг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах
3. Улс орнуудын цаазаар авах ялын эсрэг хийж буй алхамуудыг дэмжих, уг ялыг бүрмөсөн халахад нь урам зориг, бодит дэмжлэг үзүүлэх
4. Цаазаар авах ялыг халахын төлөөх эндэстэн хийгээд бүс нутгийн, дэлхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх
5. Олон улсын түвшинд олон нийтийн санаа бодлыг илүү сонсч, цаазаар авах ял шийтгэгдсэн, мөн хилс хэрэгт баривчлагдан уг ялаар шийтгүүлсэн боловч гэм буруугүй нь нотлогдон цагаадсан хүмүүсийн үгийг сонсч хүмүүст бодитой мэдээлэл өгөх зэрэг зорилтууд оржээ.

Цаазаар авах ялыг бүх нийтээр устгахын төлөө санал санаачилга, тэмцэл, хөдөлгөөн дэлхий нийтэд эрчимтэй өрнөсөөр байна.

Хоёр. Цаазаар авах ялын дэлхий нийтийн байдал

Хүний эрхийг хамгаалахын төлөө кампанит ажил явуулдаг 150 гаруй улс орны 2,2 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий нийтийн хөдөлгөөн Эмнести интернэшнл (Amnesty International) нь 1977 оноос эхлэн цаазаар авах ялыг бүх нийтээр халахын төлөө тууштай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цаазаар авах ялын дэлхий нийтийн байдлын талаарх судалгааг 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгтгэн гаргажээ. Уг судалгаагаар⁸³ дэлхийн улс орнуудын гуравны хоёроос илүү хувь нь буюу нийт 138 оронд цаазаар авах ялыг халж, харин 59 орон энэ ялыг хэрэглэж байгаа ажээ. Үүнийг доорхи байдлаар ангилан харуулбал:

- Бүх төрлийн гэмт хэрэгт халсан - 92
- Ердийн гэмт хэрэгт халсан - 10
- Практикт халсан - 36 орон тус тус байна.

2008 онд цаазаар авах ялыг хэрэглэж байгаа 59 орноос 25 нь цаазаар авах ялыг гүйцэтгэснийг Эмнести интернэшнл судлан тогтоосноос Хятад (наад зах нь 1718), Иран (346), Саудын Араб (102), АНУ (37), Пакистан (36), Ирак (34), Вьетнам (19), Афганистан (17), Хойд Солонгос (15), Япон (15), Йемен (13), Индонез (10), Ливи (8), Бангладеш (5), Беларусь (4), Египет (2), Малайз (1), Монгол (1), Арабын Нэгдсэн Эмират (1), Бахрейн (1), Бостван (1), Сингапур (1), Гэгээн Киттс ба Невис (1) байна. Энэ нь нийт дүнгээр авч үзвэл 2008 онд 52 оронд 8864 хүнд энэ ялыг оногдуулж, 25 оронд 2390 хүнд уг ялыг гүйцэтгэжээ. Ялын гүйцэтгэлд толгойг нь авах, цахилгаанаар цохиулах, дүүжлэх, хортой тариа хийх, буудах болон чулуудан хороох зэрэг аргыг хэрэглэжээ.

Эмнести Интернэшнлийн судалгаанаас үзэхэд сүүлийн таван жилийн туршид цаазаар авах ял гүйцэтгэсэн Хятад, Бангладеш, Беларус, Индонез, Иран, Япон, Хойд Солонгос, Пакистан, Саудын Араб, Сингапур, Вьетнам, Йемен, АНУ зэрэг 13 орон байна. Мөн өмнөх жилүүдийн адил 2008 онд хамгийн олон цаазаар авах ял гүйцэтгэсэн 5 орны тоонд Хятад, Иран, Саудын Араб, Пакистан, АНУ оржээ.

Цаазаар авах ялын гүйцэтгэлийг бүс нутгийн байдлаар авч үзвэл:

2008 онд нийт бүртгэгдсэн цаазаар авах ялын гүйцэтгэлийн 1,838 (76%) –ыг Ази тивийн

⁸³ Албани, Андорра, Австри, Белги, Босни Герцеговин, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальта, Молдав, Монако, Монтенегро, Голланд, Норвеги, Португаль, Румын, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Словак, Словени, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи

орнууд эзэлж байна. 16 оронд Хятад (7003), Пакистан (236), Бангладеш (185), Афганистан (131), Энэтхэг (70), Вьетнам (59), Япон (27), Малайз (22), Индонез (10), Тайван (8), Сингапур (5), Тайланд (3), Хойд Солонгос (+), Өмнөд Солонгос (2), Шри Ланка (2), Лаос (2) нийт 7767 хүнд энэ ял оноосноос 11 оронд Хятад (1718), Пакистан (36), Вьетнам (19), Афганистан (17), Хойд Солонгос (15), Япон (15), Индонез (10), Бангладеш (5), Монгол (1), Малайз (1), Сингапур (1) нийт 1838 цаазаар авах ял гүйцэтгэжээ.

Хятадад ялын дээд хэмжээ авч байгаа хүмүүс нь шударга шүүхээр шүүлгэж чадахгүй байх, өмгөөлөгчтэй холбоо тогтоож чадахгүй байх, гэм буруугүй гэдэгт нь үл итгэх, шүүх үйл ажиллагаанд улс төрийн оролцоо их, эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг алдаа, дутагдлууд гарсаар байгааг судалгаанд тэмдэглэсэн байна. Хятадын Хууль зүйн яам болон Ардын дээд шүүх хамтран цаазаар авахуулах хэрэгт оролцох өмгөөлөгчдийн үүргийг тодорхойлсон хуулийн тайлбарыг 2008 оны 5 дугаар сард гаргаснаар шүүхийн байгууллага болон засгийн газрын хяналтад байдаг өмгөөлөгчдийн холбоонд цаазаар авах ялтай хэргүүдэд удирдамжаар хангаж хөндлөнгөөс оролцох эрх олгожээ.

Энэтхэгт цаазаар авах ялын хэрэгт мөрдөн байцаах, шүүх, ял оноох болон давж заалдах бүх шатанд дур зоргоороо, дүрэм журмыг үл даган, хууль дүрмийг зөрчих, түүнчлэн цаазаар авах ялыг ихэвчлэн үндэсний цөөнх, ядуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй эмзэг бүлгийнхэнд түлхүү хэрэглэж байгааг судлан тогтоожээ. Харин 2008 онд Энэтхэгт нэг ч цаазаар авах ялыг гүйцэтгээгүй боловч 70 гаруй хүнд цаазаар авах ял оноосон байна.

2008 онд цаазаар авах ял гүйцэтгэсэн бүс нутгуудын хоёрдугаарт Ойрхи Дорнод болон Хойд Африкийн улс орнууд (21%) оржээ. Энэ бүс нутгийн Ирак (285), Алжир (200), Египет (87), Иордан (14), Сири (7), Кувейт (6), Баруун Сахар (4), Иран, Саудын Араб зэрэг 10 оронд нийт 609 хүнд цаазаар авах ял оноосноос Иран (346), Саудын Араб (102), Ирак (34), Йемен (13), Ливи (8), Египет (2), Бахрайн (1), Сир (1), Арабын Нэгдсэн Эмират (1) зэрэг 9 оронд нийт 508 цаазаар авах ял гүйцэтгэжээ. Түүнчлэн зарим оронд чулуугаар шидэж алах, дүүжлэх, олон нийтийн өмнө толгойг нь авах зэрэг хамгийн харгис, хүнлэг бус аргуудыг нийт 346 хүн цаазлахад хэрэглэснийг тогтоожээ.

Мөн энэ бүс нутгийн зарим орны хувьд насанд хүрээгүй хүн болон эмэгтэйчүүдийг цаазлах, мөн шударга бус шүүхээр шүүгдэх, Африк, Азиас ирсэн ядуучууд, цагаач иргэдэд орчуулга, өмгөөллийн үйл ажиллагаа авах эрхийг нь үл хүндэтгэх зэрэг зөрчил, доголдол нийтлэг байгаа ажээ.

2008 онд Америкт нийт 38 цаазаар авах ял гүйцэтгэсний 37-г нь АНУ, 1-ийг нь ихэр арал болох Гэгээн Киттс ба Невист тус тус гүйцэтгэжээ. 2008 онд Америк тивийн 6 оронд нийт 125 цаазаар явах ял оноосноос АНУ (111), Тринидад Тобаго (10), Багамын арлууд (1), Гэгээн Киттс ба Невист (1), Гэгээн Винсент ба Гренадс (1) ба Ямайка (1) тус тус байна.

АНУ цаазаар авах ялаас ангижрах чиг хандлага руу шилжиж байгаа хэдий ч 2008 оны байдлаар Америк тивд цаазаар авах ялыг гүйцэтгэсээр байгаа цорын ганц орон нь байсаар байна. 1995 оноос хойш энэ ялыг гүйцэтгэсэн жилүүдтэй харьцуулахад 2008 онд АНУ-д цаазаар авах ялын гүйцэтгэл буурчээ. Мөн АНУ дахь цаазаар авах ялыг дарангуйлал, ялгаварлан гадуурхал, шүүхийн алдаатай багагүй холбоотой байдаг хэмээн хүний эрхийн талаарх тайлан илтгэлүүдэд тэмдэглэжээ. Тухайлбал, 2008 онд 4 эрэгтэй гэм буруугүй нь тогтоогдож цаазаар авахуулах ялаас чөлөөлөгдсөн бөгөөд ингэснээр 1975 оноос хойш цагаадсан хүний тоо 120 болсон байна.⁸⁴

⁸⁴ Цаазаар авах ял ба гүйцэтгэл, 2008 он. <http://www.ya.com/penademuerte/listapaises.htm>

Латин Америкийн Улс орнуудын хувьд:

- Цаазаар авах ялыг бүх төрлийн гэмт хэргүүдэд халсан 12 орон (Доминиканы Бүгд Найрамдах Улс, Коста Рика, Эквадор, Мексик, Никарагуа, Панам, Парагвай, Уругвай, Венесуэл, Гондурас, Колумб)
- Дайны байдал зэрэг тусгай нөхцөл байдлаас бусад үед Цаазаар авах ялыг халсан 5 орон (Бразил, Боливи, Чили, Сальвадор, Перу)
- Цаазаар авах ял хэрэглэдэг 2 орон (Куба, Доминикан) тус тус байна.

Латин Америкийн улс орнуудын тухайд цаазаар авах ялын талаарх зохицуулалтыг гол төлөв Үндсэн хуулиараа зохицуулсан байна. Тухайлбал, Аргентин Улс Үндсэн хуулийн 18 дугаар зүйлдээ “Цаазаар авах ялыг бүх төрлийн гэмт хэрэгт бүр мөсөн халсан” гэж заасан байхад Венесуэл Улсын Үндсэн хуулийн 43 дүгээр зүйлд “Хүний амьд явах эрх халдашгүй дархан байна. Аливаа нэгэн хуулиар эсхүл, төрийн байгууллага болон албан тушаалтан цаазаар авах ялыг тогтоон хэрэгжүүлэхгүй” гэж заажээ. Тэгвэл цаазаар авах ял хэрэглэдэг Куба Улс нь Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиндаа “Хуульд заасан зөвхөн онц хүнд гэмт хэрэгт ялын дээд хэмжээг онооно. Уг ялыг эмэгтэйчүүд болон 20 нас хүрээгүй хэрэгтэнд оноохгүй” гэж заажээ. Куба нь 2000 онд цаазаар авах ялд мориторум тогтоосон хэдий ч 2003 онд буцаан хэрэглэсэн байна. Кубад цаазаар авах ялын талаар гаргасан албан ёсны статистик тоо баримт олдохгүй боловч цаазаар авах ял авсан бараг бүх хоригдлуудын ялыг хөнгөлсөн тухай Хүний эрхийн байгууллагуудын зарим мэдээлэлд дурьдагджээ⁸⁵.

Доминикан Улсын Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйлд “Ялын дээд хэмжээ авсан хоригдол нь Ерөнхийлөгч гүйцэтгэл товлон хүртэл тусгай хамгаалалтанд байж зөвхөн тодорхой хэсэг хүн уулзах эрхтэй. Гүйцэтгэлийн үед хорих газрын албаны хүмүүс болон хоригдолын гэр бүлийнхэн байлцана” гэж заажээ.

Карибд гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаагаас үүдэн цаазаар авах ял дахин хэрэглэж эхлэхийг уриалсан, Ямайт хууль тогтоох 2 танхим хоёулаа цаазаар авах ялыг хэвээр үлдээхийг дэмжсэн, Аргентин болон Барбудад хохирогч үхсэн ч, үхээгүй ч галт зэвсэг оролцсон гэмт хэрэгт цаазаар авах ял оноох хууль санаачилсан, Гайаны Засгийн газар далайн дээрэмд цаазаар авах ял оноохыг зөвшөөрсөн, Тринидад Тобаго, Гэгээн Винсент ба Гренадинс дүүжлэх ялыг дахин сэргээхийг дэмжсэн зэрэг нь цаазаар авах ялыг халах талаар энэ бүс нутгийн улс орны санаачилга хангалтгүй байгааг харуулж байна.

Африкийн 19 оронд нийт 362 цаазаар авах ял оноосноос: Уганда (114), Судан (60), Ардчилсан Бүгд Найрамдах Конго (50), Нигери (40), Этиоп (39), Мали (15), Чад (12), Мавритан (8), Ботсвани (4), Гана (3), Гаяна (3), Сьерра-Леоне (3), Гамби (2), Буркина Фасо (1), Бурунди (1), Нигер (1), Кени, Мадагаскар, Танзани-д тус тус бүртгэгджээ. Харин Баруун Сахарын Африкт Ботсвани, Суданд тус тус нэг цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. 2008 онд цаазаар авах ялыг дахин хэрэглэж эхэлсэн ганц орон нь Либер байна.

Нигерит цаазаар авахуулахаар хүлээгдэж байгаа хэрэгтний тоо 735 болж байгаа бөгөөд тэдний 11 нь эмэгтэй байна. Хэдэн зуун хүн шударга шүүхээр шүүлгэж чадаагүй бөгөөд бараг 140 хүн цаазаар авахуулах ял сонсоод 10-20 жил болжээ. Тэдний 40 нь хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй хүүхэд байжээ. 2008 оны 7 дугаар сард дээрэм ба галт зэвсгийн Актаар цаазаар авах ял оноох эрхийг халж, бүх насаар нь хорих ял болгох хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим батлаагүй аж.

Европ нь цаазаар авах ялыг халах хандлагыг ганцаараа тууштай барьж чадсан бүс

⁸⁵ Цаазаар авах ял ба гүйцэтгэл. 2008 он. <http://www.worldcoalition.org>

нутаг юм. ОХУ цаазаар авах оноох, гүйцэтгэхээ зогсоогоод арав гаруй жил болж байгаа боловч цаазаар авах ял хуулийн заалтанд нь хүчинтэй хэвээр байсаар байна. 2008 онд 4 хүнийг цаазаар авч, нэг хүнд цаазын ял оноосон Беларусыг эс тооцвол Европ нь дэлхий дээрх цорын ганц цаазаар авах ялгүй бүс нутаг юм. Беларусь нь Европт болон хуучин Зөвлөлт Холбоот Улс дахь цаазаар авах ял гүйцэтгэж байгаа хамгийн сүүлчийн орон юм. Беларусьд цаазаар авах ялын тоо баримтын талаар мэдээлэл нууц байгаа боловч 1991 онд Беларусь тусгаар тогтносноос хойш дор хаяж 400 хүн цаазаар авахуулсан хэмээн Эмнести Интернэшнл үзжээ.

Төв Азид цаазаар авах ялыг халах томоохон алхмууд гарсаар байна. Тухайлбал, Казахстан, Кыргызстан, Тажикстан, Туркменистан, Узбекистан нь 1991 онд тусгаар тогтнохдоо цаазаар авах ялаа хэвээр үлдээсэн боловч 2008 оны 9 дүгээр сард Казахстан, Кыргызстан, Туркменистан, Узбекистан цаазаар авах ялыг бүрэн халсан бөгөөд Тажикстан гүйцэтгэлээ түр зогсоогоод байна.

Цаазаар явах ялын байдал дэлхий нийтэд хэдийгээр иймэрхүү дүр зурагтай байгаа хэдий боловч “цаазаар авах ял нь хүний эрхийг хүндэтгэн сахиулахад нийцэхгүй байна” хэмээн үзэж уг ялыг хуулиар болон практикт хэрэглэхээс түдгэлзээд байгаа улс орнуудын тоо сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. 2008 онд энэ ялыг хэвээр хадгалан хэрэглэж байгаа орнуудын тоо ч мөн адил буурав. Узбекистан болон Аргентин цаазаар авах ялыг бүх хэргүүдэд халжээ. Бурунди, Мали болон Того зэрэг орнуудад цаазаар авах ялыг халахад чиглэсэн шинэчлэл боловсруулалтын шатандаа явж байна. Ливаны Хууль Зүйн сайд нь цаазаар авах ялыг халах хуулийн төслийг өргөн мэдүүлэв.

Алжирт сөрөг хүчний бүлэг Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг тохиолдуулан цаазаар авах ялыг халах тухай хуулийн төслийг парламентад өргөн барьжээ. Вьетнам зэрэг хэд хэдэн орон цаазаар авах ялын хүрээг багасгаснаар тодорхой арга хэмжээ авч буй. Вьетнамын Эрүүгийн хуулиас 17 хэрэгт цаазаар авах ял оноох зүйл заалтыг хасах саналыг хэдийгээр Үндэсний Ассамблей нь дэмжээгүй боловч энэ нь цаазаар авах ялыг халах чиглэлд хийсэн анхны томоохон алхам байсан бөгөөд хэд хэдэн ялыг хорих ял болгон хөнгөлөөд байна.

Гурав. Монгол Улсын хууль тогтоомж дахь ялын дээд хэмжээ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтад “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно,” гэж заасан бөгөөд ялын дээд хэмжээг Эрүүгийн хуульд заасан байх үндсэн шаардлага тавигдаж байна. Үндсэн хуулийн заалт нь ялын дээд хэмжээг тогтоосон Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл болох бөгөөд уг заалтын дагуу ялын дээд хэмжээг оногдуулах нь нэлээд хэдэн шалгууртай байна. Эдгээрийн тоймлон жагсаавал:

- Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг байх,
- Эрүүгийн хуульд заасан тухайн онц хүнд гэмт хэргийг үйлдсэн байх,
- Уг үйлдлийг шүүхээс тогтоосон хүчин төгөлдөр тогтоол байх,
- Шүүхийн уг тогтоол нь ялын дээд хэмжээг оногдуулсан байх гэх зэрэг шалгууртай байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ялын хэмжээгээр нь ангилсан бөгөөд мөн зүйлийн 5 дахь заалтад онц хүнд гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангид арван жилээс дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих, онцгой тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэрэг гэж тодорхойлсон байна.

Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд ялыг торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн 7 төрөлд хуваасан байдаг. Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай хэрэглэхийг Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байдаг.

Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд ялын дээд хэмжээ болох цаазаар авах ялын талаар зохицуулсан байна. “Зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болох бөгөөд уг ялыг буудаж гүйцэтгэнэ” гэж Эрүүгийн хуульд тусгайлан зохицуулсан байна. /Эрүүгийн хуулийн 53.1, 53.2/

Эрүүгийн хуульд хэдийгээр цаазаар авах ял оногдуулахаар заасан боловч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх, Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучлах зэрэг уг ялаас хэтрүүлэн өөр ялаар солих боломжийг өгч хүний амьд явах эрхийг хангахад чиглэсэн зохицуулалтыг хуульд заасан байна. /Эрүүгийн хуулийн 53.3/

Түүнчлэн цаазаар авах ялыг зөвхөн насан хүрсэн 60-аас доош насны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй хүнд оногдуулж болох бөгөөд уг хэргийг насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд үйлдсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болохгүйг Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг заасан байна.

Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүйг Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан байна. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй гэж заасан байна /Эрүүгийн хуулийн 72.4/ Цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдэд ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй болохыг Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан байна.

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд буй цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулахаар заасан байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид цаазаар авах ялыг төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах, хорлон сүйтгэх, хүнийг санаатай алах, хүчиндэх, зандалчлах, терроризм, төрлөөр устгах гэсэн 7 хэрэгт зүйлчлэн оруулсан байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

81 дүгээр зүйл. Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах

- 81.1. Улс төрийн үйл ажиллагаанд нь саад учруулах, Монгол Улсын засаг төрийг бусниулан доройтуулах зорилгоор улс төр, олон нийтийн үйл ажиллагаатай нь холбогдуулан төр, нийгмийн зүтгэлтний бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 81.2. Энэ хуулийн 81.1-д заасан зорилгоор төр, нийгмийн зүтгэлтнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах**

ял шийтгэнэ.

84 дүгээр зүйл. Хорлон сүйтгэх

- 84.1.Монгол Улсын эдийн засгийн хүчин чадлыг сулруулан доройтуулах зорилгоор үйлдвэр, байгууламж, зам харилцаа, холбооны хэрэгсэл, бусад эд хөрөнгийг тэслэх, дэлбэлэх, галдан шатаах болон бусад аргаар хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хүн, мал, ургамлын гоц халдварт өвчин тараасан, олон хүнийг хордуулсан, түүнчлэн хүн, мал, амьтныг үй олноор нь устгасан бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах

- 91.1.Энэ хуулийн 91.2-т заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 91.2.17.албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

126 дугаар зүйл. Хүчиндэх

- 126.1.Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 126.3.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан, эсхүл бага насны, өөрөөр хэлбэл арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

177 дугаар зүйл. Зандалчлах

- 177.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахад шууд буюу шууд бус нөлөөлөх зорилгоор, олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн нийтэд аюултай хүч хэрэглэсэн буюу хэрэглэхээр заналхийлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 177.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэлтгэхэд идэвхтэй оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсхүл энэ үйлдлийг таслан зогсооход идэвхтэй оролцсон бөгөөд түүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

178¹ дүгээр зүйл. Терроризм

- 178¹.1.Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэхээр заналхийлсэн, энэхүү үйлдлээрээ гоц халдварт өвчин, гал түймэр

болон гамшгийн нөхцөлийг бүрдүүлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- 178¹.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

302 дугаар зүйл. Төрлөөр устгах

- 302.1. Үндэс, угсаа, арьсны өнгө болон хүн ам, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, бие махбодид нь хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг нь бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, хүчээр сураггүй алга болгосон бол хориос хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл **цаазаар авах** ял шийтгэнэ.

Тайлбар:

- Монгол Улс түүхэндээ хэсэгхэн хугацаанд цаазаар авах ялыг халсан байна. Энэ нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн “Алах ялыг өөрчлөх тухай” 93 дугаар зарлигт “БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс энх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ” заажээ. Энэ зарлигаар БНМАУ-д дагаж шийтгүүлж байгаа хуулиудаар тогтоосон алах ялыг хэрэглэхгүй болгож, зөвхөн эх орноос урвагчид, тагнуулчид, хорлон сүйтгэгч нарт хэрэглэж байхаар тогтоосон билээ. Харамсалтай нь цаазаар авах ялыг хүчингүй болгосон энэ заалт дөнгөж 10 орчим сар хэрэгжиж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар тогтоожээ.⁸⁶

Дөрөв. Цаазаар авах ялын талаарх олон нийтийн санаа бодол

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж 2010 оны 1 дүгээр сарын 15 -нд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэгжүүлэхийг түр хугацаагаар түдгэлзүүлэн татгалзах санал гаргаж үг хэлсэнтэй холбогдуулан энэхүү ялын талаар олон нийт санаа бодлоо илүү их илэрхийлэх болсон. Тиймээс энэ хугацаанаас хойш өдөр тутмын зарим сонинд гарсан нийтлэлд цаазаар авах ялыг халах асуудлаарх олон нийтийн санаа бодол, байр суурийг нэгтгэн үзэв. Түүвэр хийж авсан 23 нийтлэлд үзэл бодлоо илэрхийлсэн улс төрч 4, хүний эрхийг хамгаалахын төлөө ажилладаг ТББ-ын ажилтан 2, хууль, хяналтын байгууллагын ажилтан 8, иргэд 7, сэтгүүлч 3 байна. Эдгээрээс зарим гол санааг хураангуйлан авч үзвэл:

- Ардчилсэн, хүмүүнлэг нийгэмд гэмт хэрэг хийсэн хэмээн бусдыг цаазаар авах нь дэндүү харгислал гэдгийг Ерөнхийлөгчийн гаргасан энэхүү санаачилга олон нийтэд төдийгүй бусад улс гүрэнд ч харууллаа.
- Цаазаар авах ялыг хэрэглэж байгаа орнуудын чиг хандлагаас харахад уг ялын хэрэглээг зөвтгөхдөө ихэвчлэн онц ноцтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эсхүл, олон нийтийн сэтгэл зүй бэлтгэгдээгүй гэсэн шалтаг хэлдэг. Гэвч энэ нь зөв шийдвэр болохын нотолгоо болж чадаагүй.
- Цаазаар авах ял нь хүний амьд явах эрхийг зөрчиж байгаа хүнлэг бус ял

⁸⁶ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял. Монголын Эмнести интернешнл, 2006;

шийтгэл, төрийн харгислал юм.

- Ардчилсан нийгмийн нэг зарчим нь төрийн эрх ард түмний мэдэлд байдаг. Монгол Улсад ч мөн адил үүнийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Тиймээс хүн өөртөө байхгүй эрхийг төр засагт шилжүүлж болохгүй.
- Цаазаар авах ялаас түдгэлзэхэд эрүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөөс илүү нийгмийн уур амьёгал эрүүлжиж, гэгээрнэ.
- Амийг нь хөнөөхөөс илүү ялыг нь үүрүүлж хорих, учруулсан хохирлыг нь төлүүлж, барагдуулах нь шудрага ёсонд илүү нийцнэ.
- Цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ялаар солих нь гэмт хэрэгтэнд гэмшил төрүүлж, хийсэн бузар үйлдэлдээ харамсах, гашуудах, ухаарч, ойлгох боломжийг олгох магадлалтай.
- Цаазаар авах ялыг халас, эсэхээ иргэдийнхээ санал асуулгаар, ялангуяа хохирогчдын ар гэрийнхнийх нь саналыг харгалзаж байж шийдэх ёстой.
- Цаазаар авсан гүйцэтгэлийн зарим мэдээг ил болгож, цааз тойрсон эргэлзээ, тээнэглээг арилгах ёстой. Мөн цогцсыг хүний ёсоор хөдөөлүүлэх эрхийг төрөл төрөгсдөд нь олгох нь зүйтэй.
- Цаазын ялаас амийг нь хэлтрүүлэх нь арга зам биш, гэмт хэрэг үйлдэгдэх болсон учир шалтгаантай биш, үр дагавартай нь тэмцэж байгаа хэрэг. Харин нийгмээ бүхэлд нь хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлдэг байлгахын тулд гэмт хэрэг үйлдсэн хойно нь бус, гэмт хэрэг гарахаас өмнө нь тэрхүү хөрс, дэвсгэрийг нь арилгах, ядуурал, гуйланчлал, ажилгүйдэл, архидалт, боловсролын болоод ёс суртахууны хоцрогдол, доголдлыг арилгаж, хүн шиг амьдарч болох нөхцлийг нь бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй юм.
- Цаазаар авах ялыг халах нь ардчилсан, хүмүүнлэг талдаа зөв зүйтэй алхам боловч Монгол Улсын иргэний амьд явах, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах хуулиар олгосон эрхийг хөсөрдүүлнэ.
- Эрүүгийн нөхцөл байдал хүнд байгаа үед захиалгат аллага нэмэгдэх аюул дагуулж болзошгүй.
- Цаазаар авах ялыг хамгийн их эрсдэл дагуулсан ялын хувьд гэм буруу нь нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон тохиолдолд гагцхүү шүүх оногдуулах, хүний хувь заяа нэгэнт эцэслэн шийдвэрлэгдсэн онцгой нөхцөл байдал үүсдэг учраас туйлын хянамгай хэрэглэх хэрэгтэй.
- Цаазаар авах ял оногдуулах хэргийн тоог цөөрүүлэх, хэтдээ ялын төрлөөс хасах чиглэл баримтлахыг УИХ 2003 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг батлахдаа төрийн бодлогын хэмжээнд тодорхойлсон. Тиймээс цаазаар авах ялыг устгах нь зөв бөгөөд дэлхий нийтээрээ энэ ялаас татгалзаж байгаа чиг хандлагаас Монгол Улс ангид байх учиргүй.
- Цаазаар авах ялыг халах хэд хэдэн арга зам байна. Нэгд, санаачилга гаргаад хууль баталж, хуулиар шууд халах арга. Хоёр дахь арга зам нь ард түмнээс санал авч болно. Гуравт цаазлах ял оногдуулахаа багасгаж болно.
- Энэ ялаар шийтгэх, түүнийг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л харилцааг зөвхөн хуулиар зохицуулж байгаа. Иймд Монгол Улсын Үндсэн хуулиас эхлээд Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай, Төрийн нууцын тухай гэх мэт олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

* * *

Хавсралт 1.

Цаазаар авах ялыг халсан болон хэрэглэж байгаа орнууд (2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

1. Бүх төрлийн гэмт хэрэгт халсан орнууд: (нийт 92 орон, улсын ард энэ ялыг халсан оныг оруулав)

Албани 2007, Андорра 1990, Ангол 1992, Аргентин 2008, Армени 2003, Австрали 1985, Австри 1968, Азербайжан 1998, Белги 1996, Бутан 2004, Босни Герцеговин 2001, Болгар 1998, Камбож 1989, Канад 1998, Кабо Верде 1981, Колумб 1910, Күүкийн арлууд 2007, Косто Рика 1877, Кот д'Ивуар 2000, Хорват 1990, Кипр 2002, Чех 1990, Дани 1978, Джибути 1995, БНДоминикан Улс 1966, Эквадор 1906, Эстони 1998, Финланд 1972, Франц 1981, Гүрж 1997, Герман 1987, Грек 2004, Гвиней-Бисау 1993, Гайти 1987, Гондурас 1956, Унгар 1990, Исланд 1928, Ирланд 1990, Итали 1994, Лихтенштейн 1987, Литва 1998, Люксембург 1979, Македони 1991, Мальт 2000, Мексик 2005, Молдав 1995, Монако 1962, Монтенегро 2002, Мозамбик 1990, Намиби 1990, Непал 1997, Голланд 1982, Шинэ Зеланд 1989, Никарагуа 1979, Норвеги 1979, Панам 1922, Парагвай 1992, Филиппин 2006, Польш 1997, Португаль 1976, Румын 1989, Руанда 2007, Самоа 2004, Сан Марино 1865, Сан-Томе ба Принсипи 1990, Сенегал 2004, Серб (Косовог оролцуулан) 2002, Сэйчэллийн арлууд 1993, Словак 1990, Словени 1989, Өмнөд Африк 1997, Испани 1995, Швед 1972, Швейцари 1992, Зүүн Тимор 1999, Турк 2004, Туркмен 1999, Украин 1999, Их Британи 1998, Уругвай 1907, Узбекистан 2008, Венесуэл 1863.

2. Ердийн гэмт хэрэгт халсан орнууд: (10)

Боливи 1997, Бразил 1979, Чили 2001, Сальвадор 1983, Фижи 1979, Израил 1954, Казахстан 2007, Кыргызстан 2007, Латви 1999, Перу 1979.

3. Практикт халсан орнууд: (36 орон, хамгийн сүүлд гүйцэтгэл явуулсан он)

Алжир 1993, Бенин 1987, Бруней 1957, Буркино Фасо 1988, Камерун 1997, Төв Африкийн БНУ 1981, Конго 1982, Эритрей 1989, Габон 1981, Гамби 1981, Гренад 1978, Кени 1987, Лаос 1989, Либер 2000, Мадгаскар 1958, Малави 1992, Малдивийн арлууд 1952, Мали 1980, Мавритани 1987, Марокко 1993, Мьянмар 1980, Нигер 1976, Папау-Шинэ Гвиней 1950, ОХУ 1999, Өмнөд Солонгос 1997, Шри ланк 1976, Швейцари 1983, Суринам 1982, Тажикистан 2004, Танзани 1995, Того 1978, Тонга 1982, Тунис 1991, Замби 1997.

4. Цаазаар авах ял хэрэглэж байгаа орнууд: (59)

Афганистан, Антигуа ба Барбуда, Бахрейн, Багамын арлууд, Бангладеш, Барбадос, Беларусь, Белиз, Бостван, Бурунди, Чад, Хятад, Коморын арлууд, Куба, Конго, Доминика, Египет, Экваторын Гвиней, Этиоп, Гватемал, Гвиней, Гана, Энэтхэг, Индонез, Иран, Ирак, Ямайка, Япон, Йордан, Кувейт, Ливан, Лесото, Ливи, Малайз, Монгол, Нигер, Хойд Солонгос, Оман, Пакистан, Палестин, Катар, Сент-Киттс ба Невис, Сент Люсия, Сент-Винсент ба Гренадин, Саудын Араб, Сьерра-Леоне, Сингапур, Сомали, Судан, Сири, Тайвань, Тайланд, Тринидад ба Тобаго, Уганда, Арабын Нэгдсэн Эмират Улс, АНУ, Вьетнам, Йемен, Зимбабве.

5. 2008 онд цаазаар авах ял оноосон байдал: (51)

Хятад (7003+), Ирак (285+), Пакистан (236), Бангладеш (185+), Афганистан (131), Уганда (114), АНУ (111+), Египет (87+), Энэтхэг (70+), Судан (60), Вьетнам, (59+) Конго (50+), Нигер (40+), Этиоп (39), Япон (27), Малайз (22+), Мали (15+), Йордан (14+), Чад (12+),

Индонез(10+), Тринидад ба Тобаго(10), Тайвань(8+), Мавритани(8), Сири(7+), Кувейт(6+), Сингапур(5), Марокко, (4+) Бостван(4+), Тайланд(3+), Гана(3), Гвиней(3), Сьерра-Леоне(3), Өмнөд Солонгос(2+), Гамби(2), Лаос(2), Шри Ланка(2), Багамын арлууд(1+), Сент-Киттс ба Невис(1+), Сент-Винсент ба Гренадин(1+), Беларусь(1), Буркина Фасо(1), Бурунди(1), Ямайка(1), Нигер(1) Иран(+), Кени(+), Ливи(+), Мадагаскар(+), Хойд Солонгос(+), Саудын Араб(+), Танзани(+).

6. 2008 онд цаазаар авах ялын гүйцэтгэсэн байдал: (25)

Хятад (1718+), Иран(346+), Саудын Араб(102+), АНУ(37+), Пакистан(36+), Ирак(34+), Вьетнам(19+), Афганистан(17+), Хойд Солонгос(15+), Япон(15), Йемен(13+), Индонез(10), Ливи(8+), Бангладеш(5), Беларусь(4), Египет(2+), Малайз(1+), Монгол(1), Сингапур(1+), Судан(1+), Сири(1+), Арабын Нэгдсэн Эмират Улс(1+), Бахрейн(1), Бостван(1), Сент-Киттс ба Невис(1).

Тайлбар:

- Энэ хавсралтад байгаа тоо баримтыг Эмнести Интернэшнлийн судалгаанаас авсан ба улс орнуудын дараа “+” тэмдэг бичсэн нь тухайн оронд цаазаар авах ял оноосон ба гүйцэтгэсэн тухай тоо баримтыг хамгийн багаар илэрхийлсэнийг харуулах бөгөөд түүнээс илүү байх магадлалтай байхыг илэрхийлнэ.

Ашигласан материалын жагсаалт:

1. Цаазаар авах ялыг халах тухай олон улсын гэрээ хэлэлцээрийг баталсан байдал. Эмнести интернэшнл
2. Цаазаар авах ялыг халсан болон хэрэглэж байгаа орнуудын жагсаалт (2008 оны 12 дугаар сарын 31)
3. Цаазаар авах ял ба гүйцэтгэл. 2008, Эмнести интернэшнл
4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2007 оны байдлын талаарх илтгэл. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2008 он
5. Хүний амьд явах эрх ба цаазаар явах ял. 2006 он

Сонин хэвлэлийн нийтлэл:

1. Цаазалсан хүнийхээ тоогоор Хятадаас 2.6 дахин илүү гарчээ. Шаабар. Өдрийн сонин 2010.01.06
2. УИХ –ын гишүүн Д.Загджав: Ерөнхийлөгч цаазын ялтай хүн бүрийг уучлах нь ардчилсан зарчмыг алдагдуулна. Зууны мэдээ, 2010.01.05
3. Амийг амиар солих хатуу ялыг халах нь ээ. Д.Дорждагва. Өдрийн сонин 2010.01.16
4. Цаазыг алгасах алхам, дэлхийг цочоосон шилгээлт. Г.Энхтөр, Д.Ганчимэг. Өнөөдөр, 2010.01.16
5. Цаазын ялаас татгалзах нь буюу үр дагавараас учир шалтгааныг хайхуй. Б.Сэмүүн. Ардын эрх, 2010.01.18
6. Цаазын цаана, наана... Н.Наран. Зууны мэдээ, 2010.01.19
7. Ц.Элбэгдорж та хэнийг өршөөж байгаагаа тасаалж байна уу? Н.Батжаргал. Зууны мэдээ, 2010.01.20
8. Тэнгэрийн дор төрж, хуулийн дор амьдардаг. Х.Индра. Монголын мэдээ,

2010.01.18

9. Х. Тэмүүжин: Ерөнхийлөгч цаазаар авах ялыг насаар нь хорих болгоно шүү гэдэг дохио өгсөн. Монголын мэдээ, 2010.01.19
10. Ерөнхийлөгч хүний амьд явах эрхийг баталгаажуулах эхний алхмыг хэрэгжүүлж чадлаа. Ч.Бүжин. Адрийн сонин, 2010.01.24
11. Монгол цаазаар авах ялыг халах нь зөв үү? буруу юу? Өнөөдөр, 2010.01.21
12. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дэвшүүлж буй саналд нэг санаа. С.Алимаа. Үнэн, 2010.01.21
13. Улс төрийн хүн хар гөрөөс. Д.Төмөрбаатар. Зууны мэдээ, 2010.01.26
14. Доктор И.Дашням: Цаазлах ялыг шүүх оногдуулдаг. Ерөнхийлөгч шууд шийдэхгүй шүү дээ. Зууны мэдээ, 2010.01.27
15. Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж байна. Өдрийн сонин, 2010.01.30
16. Цаазын ялыг халах нь улс төрийн илтгэл тавихаас өөр. Н.Батжаргал. Зууны мэдээ, 2010.02.04
17. Цаазлуулах ялтан бүрийг судалж байж өршөөх эсэхээ шийдэх ёстой. Г.Мөнхболд. Зууны мэдээ, 2010.02.10
18. Хүний эрх зөрчсөн аллагыг бүрмөсөн халъя. Хууль зүйн Lexus төв. Өдрийн сонин, 2010.02.11
19. Цаазаар авах нь хүсэх зүйл биш ч, түүнийг халах цаг нь болоогүй. Өнөөдөр, 2010.02.23

Цахим хаяг:

- <http://www.ya.com/penademuerte/listapaises.htm>
- http://www.amnestyusa.org-abolish-annual_report
- <http://www.deathpenalty.org>
- <http://www.amnesty.mn>
- <http://www.bookrags.com>
- <http://www.saber.ula.ve/bitstream/123456789/19135/articulo8.pdf>
- <http://www.worldcoalition.org>



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

3

БҮЛЭГ

ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОТЖИЛТЫН БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа, Б. Буяндэлгэр

а) Эрх зүйн орчны тойм ажиглалт

Хот тосгоны эрх зүйн байдал, хот тосгоны хөгжил нь монголын нийгмийн хөгжлийн нарийн төвөгтэй асуудлын нэг юм.⁸⁷ Тиймээс, Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлогын гол үндсэн тулгуур баримт бичгүүдэд хот тосгоны хэтийн хөгжлийг тэтгэхэд чиглэсэн агуулгаар олон тодорхой заалт орсон байдаг. Тэдгээрийг холбогдох хууль тогтоомжийн агуулгаас түүвэрлэсэнийг дурдвас:

1. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого.⁸⁸

- Хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг мөн;
- Хүн амын нутагшлын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулж, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурласан хот байгуулалтыг эрчимжүүлнэ;
- “Хотууд” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ;
- Хот байгуулалтын эрх зүйн орчинг сайжруулж, хот төлөвлөлтийн норм, нормативыг боловсронгуй болгоно;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын бодлогоор дэмжинэ;
- Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэн, бүсийн тулгуур төвүүдийг эрчимтэй хөгжүүлэн, бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийг эхний шатанд тус бүр 50000 мянгаас доошгүй хүн амтай, цаашид тус бүр 100000 орчим хүн амтай хотууд болгон хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлнэ;
- Нийслэлийн хүн амын хэт бөөгнөрлийг задалж, дагуул хот (Багануур, Налайх, Багахангай) –уудыг хөгжүүлж, тэдгээрт зохистой төвлөрөл бий болгоно;
- Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, томоохон орд газрыг түшиглэн дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хот тосгодыг байгуулна;
- Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ;
- Бүсийн тулгуур төв – Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ;
- Бүс нутгийн удирдлагын оновчтой тогтолцоо, бүтцийг бүрдүүлж ажиллуулна;
- Тавантолгой, Оюутолгой зэрэг стратегийн томоохон орд газруудыг түшиглэн орчин үеийн шийдэл бүхий 10 – 20 мянган хүнтэй хот бий болно;
- Ойр байршилтай сумдыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд нэгтгэж томсгоно;
- Бүлэг суурингийн тогтолцоог бий болгож, тэдгээрийн зах зээлийн чадамжийг эрс нэмэгдүүлнэ; ... гэжээ.

2. Орон нутгийн олон хот тодорхой чиг үүрэггүй, хөгжлийг тэтгэх үйл явдлын гадна

⁸⁷ Бэлтгэсэн 2009.5.29⁸⁸ Үндэсний хөгжлийн цогц бодлогыг 2008 оны 12 дугаар сард УИХ –ын тогтоолоор баталсан;

үлдэж, үүнээс үүдэлтэйгээр нийгмийн хөгжлийн тэнцвэр алдагдах хандлага илэрч, хүн амын суурьшлыг дагаад үйлдвэр үйлчилгээний газрууд ерөнхийдөө төвийн бүсийн том хотуудад хэт бөөгнөрсөн нь улсын нийт хүн амын амьдрах орчны чанар үзүүлэлтийг муутган, нийгмийн зарим хурц асуудлыг шийдвэрлэхэд төвөг чирэгдэл учруулж, ажилгүйдэл, ядуурал ихсэхэд ихээхэн сөрөг нөлөөтэй байна” гэж **Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд** онцлон тэмдэглэсэн нь бий.

3. Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегийн баримт бичигт:

- Эдийн засгийн бүсүүдийн хүрээнд хөгжлийн ирээдүй сайтай байрласан хот, тосгоны сүлжээнд үндэслэн Баруун бүсэд Ховд, Улиастай; Хангайн бүсэд Хархорин, Эрдэнэтийг, төвийн бүсэд Дархан, Зуунмодыг, зүүн бүсэд Чойбалсан, Өндөрхааныг тухайн бүсийн хөгжлийн тулгуур төвөөр тогтоож, тэдгээрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж эхлэх, бусад аймгийн төв хотуудыг орон нутгийн хөгжлийн төвийн жишгээр хөгжүүлж, хөдөө орон нутагт сум дундын төвүүдийг [шинээр] үүсгэх замаар хот байгуулалтын орчин бүрэлдэх эхлэлийг тавина;
- Баруун бүсэд ОХУ–тай хил залгаа Цагааннуур (Баян–Өлгий), Боршоо (Увс), Арцсуурь (Завхан), БНХАУ–тай хил залгаа Булган (Ховд), Бургастай (Говь–Алтай), Хангайн бүсэд ОХУ–тай хил залгаа Бага–Илэнх (Булган), Ханх (Хөвсгөл), БНХАУ–тай хил залгаа Шивээхүрэн (Өмнөговь), төвийн бүсэд ОХУ–тай хил залгаа Сүхбаатар–Алтанбулаг, БНХАУ –тай хил залгаа Замын–Үүд; Зүүн бүсэд ОХУ–тай хил залгаа Ульхан, Эрээнцав (Дорнод), БНХАУ–тай хил залгаа Хавирга, Нөмрөг (Дорнод), Бичигт (Сүхбаатар)–ийн боомт, гарцыг эхний ээлжинд тохижуулж, ОХУ, БНХАУ –ын хил зэргэлдээ муж улс, өөртөө засах орнуудтай харилцан дэмжиж хамтдаа хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Дархан–Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, аймгийн төвүүд байрласан сумд болон бусад аймаг, сумдын хоорондын зохистой харьцаа, хамаарлыг тогтоох, бие дааж хөгжих чадвар султай сум багуудыг зэргэлдээх сум багтай нь хоршин нэгтгэж, орон нутгийн чадавхийг дээшлүүлнэ; ... гэж тус тус заажээ.

4. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай Монгол Улсын хуульд:

- Тухайн хуулийн зорилт нь улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- Бүсийг гадаад, дотоод зах зээлтэй холбоход байгаль, эдийн засгийн нөхцөлийн хувьд тохиромжтой байрласан улсын зэрэглэлтэй хотыг тухайн “бүсийн хөгжлийн тулгуур төв” гэнэ;
- Бүс нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн хөгжилд голлох үүрэгтэй, үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтэц бүхий аймгийн зэрэглэлтэй хотыг, “орон нутгийн хөгжлийн төв” гэнэ; тус тус заасан.

5. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд:

- Улсын зэрэглэлтэй бүсийн тулгуур төв хотын захирагчийн ажлын алба нь аймгийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна ... гэх зэргээр тодотгосон олон зохицуулалт (өнгөц ажиглалтаар) харагдаж байна.

6. Хот байгуулалтын тухай Монгол Улсын хууль нь хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харилцан уялдаатай, харьцангуй бие дааж хөгжих бүс нутгийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоны хөгжлийг тодорхойлох, барьж байгуулахад төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулах зориулалттай. Тэнд, Хот байгуулалтын

чиглэлээр төр засгийн бүрэн эрхийг тодотгохдоо:

- Хот байгуулалтын талаархи төрийн бодлогыг тодорхойлох;
- Хот, тосгоныг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх талаар шийдвэр гаргах;
- Хотод улсын зэрэглэл тогтоох;
- Хот байгуулалтын төрийн бодлогын хүрээнд улс, бүс нутаг, хот, тосгоны тогтвортой хөгжлийг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах; ... тухай заажээ.

7. **Зарим хотыг сумдад нэгтгэх тухай Улсын Их Хурлын тогтоол** (1994.5.06, №36) –д:

- а) Дор дурдсан хот, хороодыг засаг захиргааны хувьд дэргэдэх суманд нь нэгтгэн харьяалуулсугай. Үүнд (жишээлж дурдвал):

- ...
11. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа **хотыг** мөн аймгийн Мандал суманд;
 12. Хөвсгөл аймгийн Хатгал **хотыг** мөн аймгийн Алаг-Эрдэнэ суманд;
 13. Хэнтий аймгийн Бэрх хороо (уурхайн хот) –г татан буулгаж мөн аймгийн Батноров суманд;
 14. Хэнтий аймгийн Хэрлэн хороо (үйлдвэрийн хот Бор–Өндөрийг хэлж байна) –г татан буулгаж мөн аймгийн Дархан суманд; ...

гэж заасан ёсоор тус тус харьяалуулсан.

Мөн, засаг захиргааны хуучин хуваарьт нийцэн гарч, он удаан жил үйлчилж ирсэн “хот байгуулсан олон шийдвэр” –ийг хүчингүйд тооцсон байна. Үүнд, жишээлбэл:

- ...
5. “Тосонцэнгэл **сумын төвийг хот** болгох тухай” 1963 оны 4 дүгээр сарын 5 –ны өдрийн 81 дүгээр зарлиг;
 - ...
 8. “Налайх хотыг Улаанбаатар хотод харьяалуулах тухай” 1965 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 250 дугаар зарлиг;
 - ...
 10. “Зүүнбаян **хотын** зохион байгуулалтыг өөрчлөх тухай” 1971 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 49 дүгээр зарлиг;
 - ...
 16. “Хатгал хороог орон нутгийн хот болгох тухай” 1975 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлиг; ... г. м. (Тогтоолыг бүрэн эхээр нь ард хавсаргав. Хавсралт 1.)

8. **Шинээр байгуулсан аймаг сумын Засаг даргын Тамгын газар, хот тосгодын захирагчийн ажлын албаны тухай Засгийн газрын тогтоол** (1994.7.14, №128) –оор:

- Аймгийн төв болон Хэнтий аймгийн Бэрх, Хэрлэн, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл, Өвөрхангай аймгийн Хархорин хотуудыг аймгийн зэрэглэлтэй хот болгосон.
- Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нь тухайн аймгийн төв-хотын захирагч байхаар, бусад аймгийн төв - хотуудын хувьд түүний оршин байгаа сумын Засаг дарга нь хотын захирагч байхаар зохицуулсан.

- Сум, багийн төв болж байгаа тосгоны хувьд түүний оршин байгаа тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга тосгоны захирагч байх нь зүйтэй; гэж үзсэн. (Тогтоолыг бүрэн эхээр нь хавсаргав. Хавсралт 2.)

Төр засгийн аливаа бодлого шийдвэр бүхэн хууль тогтоомжоороо дамжин илэрч, улмаар амьдралд хэрэгждэг. Энэ үүднээс нь бид Засгийн газрын дээрх 2 тогтоолыг бодлогын баримт бичигт хамаатуулж үзсэн болно.

* * *

б) **Хууль эрх зүйн зохицуулалтын “анхаарал татсан” заалтууд, харьцуулалт**

Энэ дэд гарчгийн дор бид Хот тосгоны эрх зүйн байдалд холбогдох хууль тогтоомжийн эргэлзээтэй гэж үзэж болохуйц зарим заалтыг “... шинэчилсэн найруулгын төсөл” –д тодорхой хэмжээгээр холбон хамаатуулж тухайлан сонирхохыг зорьсон болно.

<ul style="list-style-type: none"> • Үндсэн хуулийн 57 дугаар зүйл 	<p>...</p> <ol style="list-style-type: none"> 2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурлын [ба] иргэдийн санал –ыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ;
--	---

Тэмдэглэх нь:

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн заалтын хүрээнд боловсруулсан гээд байгаа. Уг нь бол Үндсэн хуулиндаа “хотыг нутаг дэвсгэр – засаг захиргааны нэгж байлгах” тийм зохицуулалтыг эхэлж оруулчихаад дараа нь энэ чиглэлийн хуримтлагдсан бүх асуудлаа тухтайхан барьж авсан бол төрийн бодлогын чанартай эрх зүйн холбогдох зохицуулалтууд их тодорхой, шийдэхэд амар хялбар болох мэт санагдана.
- Монгол Улсын орон нутгийн захиргааны нэгжүүд нь нутгийн өөрөө удирдах ёс ба төрийн удирдлагыг зэрэгцүүлэн уялдуулж хэрэглэдэг бөгөөд нэгж бүрт хурал, Засаг дарга байдаг. Үндсэн хуулийн үзэл санаа ийм тул засаг захиргааны нэгжийн “хосмол удирдлагын тогтолцоо” Үндсэн хуулиар баталгаажсан. Засаг дарга нь төрийн төлөөллийг орон нутагт хэрэгжүүлж ... дээд шатны Засаг дарга болон Засгийн газарт үйл ажиллагаагаа тайлагнадаг (дээрээс удирдах үүрэгтэй) бол Хурал нь нутгийн иргэдийн төлөөллийн (оролцооны аргаар дороос удирдах) байгууллага байдаг. Хотыг нутаг дэвсгэр – засаг захиргааны нэгж” –д тооцсон Үндсэн хуулийн зохицуулалт үгүйсгэсэнээс болж хот тосгоны хөгжил төлөвлөлтийн чиглэлээрх бодлого зохицуулалтын асуудалд байнгын шинжтэй зохиомол хүндрэл бэрхшээл үүссээр олон жил үргэлжилж улам ужгирч байна.



Кейс 1.

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Н. Мөнхцас:¹

- Манай дүүрэг 150000 хүнтэй. Энэ хэмжээний хүн амтай аймаг манай улсад бараг үгүй. Монгол Улсын хууль тогтоомжид **дүүргийн статусыг сумтай адилтган үздэг нь төрийн албан хаагчийн ангилал зэрэглэл, цалин хөлсөнд сөргөөр нөлөөлдөг.**
- Дүүргийн Тамгын газрын ажилтнууд нь төрийн албаны тухай хуулиар хөдөө сумын Тамгын газрын ажилтнуудтай ижил зэрэглэлд багтаж байна. Бодит байдал дээр дүүргийн ажилтнуудын ачаалал маш их. Ийм атал, өөрөөр хэлбэл, дүүрэг нь хүн амын хувьд сумтай байтугай аймагтай жишихээргүй их атлаа, ажилтнуудынх нь авдаг цалин нь сумын албан хаагчтай адил байдаг.

с) Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 –т “Засаг захиргааны нэгжийг өөрчлөх асуудлыг ... иргэдийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ” гэж заасан. Мөн тэнд, “Хурлын санал бол иргэдийн санал биш” гэсэн нэг зарчмын сонин санаа суусан байна. Энэ бүхэн Үндсэн хуулийн агуулгын асуудал юм. Хот, тосгоны хөгжил төлөвлөлтийн асуудлыг дан ганц дээрээс эсвэл дороос шийдэх гэж хүчлэн оролдох нь Үндсэн хуулийн үзэл санаанд харш үйлдэл болж мэдэх тул хууль тогтоогчид үргэлж “орон нутагтай зөвшилцөх” –ийн төлөө байх нь чухал.

* * *

• Үндсэн хуулийн 58 дугаар зүйл	1. “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэсэн заалттай.
---------------------------------	--

Тэмдэглэх нь:

Эндээс харвал, “аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ... цогцолбор”, харин (үлдэж байгаа) баг, хороо нь (зүгээр л) “засаг захиргааны нэгж” мэтээр ойлгогдохоор болчихож байна. Хуулийн агуулгыг бодолцолгүй, үг үсэг талд нь хэт их акцент өгвөл “засаг захиргааны нэгж” –д хамаарах нэгж нь явж явж ердөө “баг, хороо” л болж таарах гээд байгаа юм. Тэгэхээр, энд буй “цогцолбор” гэх нэр томъёо нь засаг захиргааны зарим нэгжийг шоовдорлохоос өөр ач холбогдолгүй, үүрэггүй, шинжлэх ухаанч бус нэр томъёо гэж үзэж болохоор байна. 1992 оны Үндсэн хууль, Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (1993) амьдралд хэрэгжиж ирсэн олон жилийн туршлагаас энэ байдал тод харагдсан.

Хуулийн заалт дахь “... засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор” гэх хэвшиж өгөхгүй байгаа энэ нэршил логик утга зүйн талаасаа ихээхэн учир дутагдалтай байна. Үндсэн хуулийн эл заалтын хэл найруулга ч сайн болоогүй мэт. Үндсэн хуулийн энэ заалтыг бүр халчихаж болдоггүй юм бол, ядаж “... аймаг, нийслэл, сум дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй, өөрийн удирдлага, засаг захиргаа, нутаг дэвсгэртэй, эдийн засаг – нийгмийн цогцолбор мөн” гэж засамжлахсан.

Энд “нутаг дэвсгэртэй” гэсэн тодотголыг хасаад хаячихсан ч болно. Яагаад гэхээр, “засаг захиргааны нэгж” –ийн оршин байхын гол үндсэн болзол нь “нутаг дэвсгэр”⁸⁹

⁸⁹ Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2 –т, аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн

учраас “засаг захиргааны нэгж” гэх ухагдахуун нь дотроо “нутаг дэвсгэр” гэсэн ойлголтоо давхар багтааж байдаг билээ.

Засаг даргатай, иргэдийн Нийтийн хуралтай засаг захиргааны нэгж – баг, хороо нь засаг захиргааны нэгж юм бол тэдгээр нь заавал нутаг дэвсгэртэй байх ёстой. Хорооны нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нийслэлийн дүүргүүд түүгээрээ шийдээд яваад байдаг, харин багийн нутаг дэвсгэрийн тухайд бол байдал нилээд бүрхэг тодорхойгүй талруугаа болчихож байна. Засгийн газрын ХЭГ –ын зарим мэргэжилтнүүдийн өгүүлж буйгаар бол, “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” л хилийн цэстэй байна, (зүгээр) “засаг захиргааны нэгж” –ийн тухайд (бол) хилийн цэс гэж ярих нь “зөв биш” гэх. Энд (нэг) ойлголтын зөрүү гарч ирээд байгааг хууль тогтоогчид маань анзаарч цэгцлэх биз ээ.

* * *

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (1992) –ийн 3 дугаар зүйл: (Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж)

- ...
2. **Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн;**
 3. **Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.**

Тэмдэглэх нь:

Манай Үндсэн хуулийн агуулгад нилээд дэлгэрэнгүй тусгалыг олж, түүний бүхэл бүтэн нэг бүлгийг⁹⁰ дагнан эзэлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай асуудалд (одоо) анхаарлаа зориуд хандуулъя.

- Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд “Монгол улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана, Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэж заасан. Төрийн байгууламж “нэгдмэл” байх ийм нөхцөлд төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр улс даяар ямар нэгэн шат дамжлаггүй шууд хэрэгждэг учраас Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдаж байгаа юм. Энд байгаа “зөвхөн” гэсэн тодотгол нь “өөр нэрийн нэгж байж болохгүй” –г хэлсэн хэрэг. Гэтэл ...

Гэтэл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 –т “... цогцолбор бол ... засаг захиргаан нэгж мөн” гэсэн заалт байдаг. Энэ заалт нь, хэрэг дээрээ, энэ хуулийн ч заалт биш, харин Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх заалтын “сору” юм. Тэгэхээр, манай Үндсэн хуулийн агуулгад “дотоод зөрчил” энэ мэтээр нилээд байх шиг байна.

Дашрамд тэмдэглэхэд, манайхан хууль хийхдээ Үндсэн хуулийн заалтыг “үндсэн биш хууль” –ийн (уг эхээсээ шал өөр номер дугаартай) тодорхой нэг заалт болгож давтан хуулаад яваад байдаг юм. Энэ яав ч сайн арга биш. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйл дотор байгаа 4 заалтын 3 нь буюу 75% нь Үндсэн хуулиас дугаараа солин “нүүж” ирсэн байна. Ийм замаар Үндсэн хуулийн агуулга, үнэлэмжид

газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална; гэж заажээ.

⁹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн IV бүлэг;

“хохирол” учруулж болохгүй. Үндсэн хуулийн үг бол зөвхөн Үндсэн хуулийн л үг байх ёстой болов уу.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (1993) –ийн 3 дугаар зүйл (Хот ба тосгон)	
• Тухайн заалтын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бичиглэл	• Шинэчилсэн найруулгын төсөлд орж ирээд байгаа тухайн заалтын шинэ бичиглэл (Хэлэлцэгдээгүй байгаа төслөөр)
1. Хот нь 15000 –аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн;	■ Хот нь 10000 –с доошгүй байнгын оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, оршин байгаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт үйлдвэр, дэд бүтцийн хувьд илүү хөгжсөн эдэлбэр газар, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн;
2. Тосгон нь 500 – 15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн;	■ Тосгон нь 10000 хүртэл байнгын оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь буюу тэдгээр нь хослон хөгжсөн, эдэлбэр газар, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн;
3. Улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг нь харгалзан шаардлагатай гэж үзвэл тосгоныг хотод тооцох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ;	■ Улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, онцлог байдлыг нь харгалзан, шаардлагатай гэж үзвэл тосгоныг хот гэж нэрлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ;

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйл (Хотын зэрэглэл)	
• Тухайн заалтын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж бичиглэл	• Шинэчилсэн найруулгын төсөлд орж ирээд байгаа тухайн заалтын шинэ бичиглэл (Хэлэлцэгдээгүй байгаа төслөөр)
1. Хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна.	■ Хот нь оршин суугчдын тоо, дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын болон орон нутгийн зэрэглэлтэй байна;

2. 50000 -аас дээш (шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл) оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно.	■ Тосгон нь 10000 хүртэл байнгын оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь буюу тэдгээр нь хослон хөгжсөн, эдэлбэр газар, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн;
2. Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, аймгийн зэрэглэл тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөн мэдүүлснээр Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.	■ Улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, онцлог байдлыг нь харгалзан, шаардлагатай гэж үзвэл тосгоныг хот гэж нэрлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ;

Хот тосгоны ... тухай хуулийн 5 дугаар зүйл (Хот тосгоны засаг захиргааны харъяалал)	
Тухайн заалтын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бичиглэл	Шинэчилсэн найруулгын төсөлд орж ирээд байгаа тухайн заалтын шинэ бичиглэл (Хэлэлцэгдээгүй байгаа төслөөр)
1. Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяалагдана.	■ Энэ заалт хэвээрээ явж байгаа;
2. Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж болох бөгөөд шаардлагатай бол тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлэнэ;	■ Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж болох бөгөөд энэ тохиолдолд засаг захиргааны хувьд хот, тосгоны төв нь оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяалагдана;

Тэмдэглэх нь:

- Хотод улсын зэрэг, эс бөгөөс орон нутгийн зэрэг [заавал] “олгох” гээд байгаа нь Үндсэн хуулийн холбогдох бүлэг заалтад “хот” гэдэг үг дутагдсантай ч зарим талаараа холбоотой. Энэ нь учирсан саад бэрхшээлийг эвтэйхэн тойрч гарах гэсэн арга чаргаас өөр юм биш. Сүүлд байгуулсан 3 аймгийг “бий болгох” –д хүргэсэн үндсэн шалтгаан нь мөн нэг иймэрхүү. Тэрнээс биш аймаг байгуулах дуртайдаа, эсбөгөөс “аймаг нь илүү түргэн хөгждөг” гэж үзсэндээ тэгээгүй юм. (Энэ байдлыг гадаадын улс орны засаг захиргааны нэгжийн зохион байгуулалттай яаран жишиж тайлбарламааргүй байна)
- Үндсэн хуулинд “хот” гэдэг үгийг зүгээр ч нэг “хаячихаагүй”, дээр нь нэмээд, бас “нийслэл” гэдэг үгээр давхар дарчихсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нэртэй албан тушаалыг харахад хүртэл “нийслэл бол хот мөн” гэсэн санаа гарч ирээд байдаг. Хамгийн аюул нь “хот болгон нийслэл биш” байдаг л оршиж байгаа бөгөөд нийслэл нь, энэхүү өөрийн “хэт чухалчлагдсан байдлаараа” бусад хотуудын эрх ашигт санаандгүйгээр хор

хохирол учруулсаар байна.

Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд “аймаг, нийслэл” –д бус “аймаг ба хот” –д хуваагддаг байх зарчмын зохицуулалт үгүйлэгдэж байна. Үндсэн хуулийн 57 зүйлийн заалтыг дахин найруулах замаар хот тосгоныг засаг захиргааны нэгж болгон зохицуулах боломжтой. Мөн тэнд хаа нэгтээ нь, засаг захиргааны нэг нэгжийн дотор, түүнд харъяалагддаггүй өөр нэгж байж таарахгүй гэдгийг ч тодотгоод хэлээд өгөх хэрэгтэй. Ингэснээр, “их гэрийн доторхи бага гэр ...” –ийн оньсого (аймаг дотор аймаг, суман дотор хот ... гэх мэт) –ыг бид бүрэн зөв тайлах болно.

Үндсэн хуулийг өөрчлөх замаар хотыг засаг захиргааны нэгж болгочих юм бол тэдгээрийг (дотор нь) ангилж зэрэглэх хэрэгцээ шаардлага бараг аяндаа алга болно. 21 аймагтаа бид зэрэглэл тогтоогоогүй. Тэгэх ч ёсгүй, яагаад гэвэл, ялгаварласан болно. Бүсийн төвийн асуудал бол энд хамаарахгүй зарчмын өөр тэс зүйл гэдгийг нэмж тэмдэглэмээр байна.

Хот байгуулалтын тухай Монгол Улсын тухай хууль (1998)

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- Энэ хуулийн зорилт нь хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харилцан уялдаатай, харьцангуй бие дааж хөгжих бүс нутгийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоны хөгжлийг тодорхойлох, барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Тэмдэглэх нь:

- Аливаа хуулийн зорилтыг тодорхойлсон тэргүүн хэсэг (голдуу бүх хуулийн нэгдүгээр зүйл байдаг) бол уг хуулийн нэг ёсны малгай юм. Хот байгуулалтын тухай хуулийн агуулгыг өнгөцхөн харахад, түүгээр, нэгэнт байгуулагдсан хотын хөгжлийн процедурыг тогтоохыг зорьжээ, гэмээр байна. Гэтэл хуулийн зорилтыг тодорхойлсон дээрх 1 дүгээр зүйлд,
 - Хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшлыг тогтоох;
 - Харилцан уялдаатай, харьцангуй бие дааж хөгжих бүс нутгийн зохистой бүтэц бүрдүүлэх;
 - Хот, тосгоны хөгжлийг тодорхойлох; ...
 –д төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулна; гэж хуулийнхаа ерөнхий агуулгаасаа нилээд давсан шинжтэй, өөрөөр хэлбэл “малгай нь томдсон”, бусад хуулиар голчлон зохицуулагдах олон “амлалт” –уудыг өөртөө нэгтгэж хүлээсэн маягтай болсон байна. Үүнийг засч залруулах байх.
- Хот байгуулалтын дотоод асуудал төдийгүй хот тосгоны хөгжлийн тухай асуудал бүхэлдээ манайд хичнээн чухлаар тавигдаж байгаа нь зөвхөн тухайн чиглэлээр байгуулагдан ажиллаж байгаа “хотын төлөөх” төрийн бус байгууллагуудын нэрийн жагсаалтаас харж болохоор байдаг.

Статистикийн тухай Монгол Улсын хууль –д заагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний статистикийн хороо “Хүн ам, орон сууцны улсын тооллого” –д зориулсан “Хотын хүн ам, өрх” ухагдахууны талаархи тодорхойлолтыг өгч, мөн Монгол Улсын тосгон ба хот маягийн суурингийн жагсаалтыг гаргасан нь бий.

Тэмдэглэх нь:

- БНМАУ –ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар **улсын суурин газруудыг** хот болгох нэгдмэл хэмжүүрийг 1960 онд би болгож тогтоосон байна. Энэ нь манай орны нийгмийн амьдралд хот хүрээ газрын эзлэх байр суурь өсч буйг харуулсан анхны хуульчилсан баримт бичиг байв.
- 1973 онд орон нутгийн харъяалалтай хотын хэмжүүрийг дахин хянан үзэж “6000 доошгүй хүн амтай, тэдгээрийн олонхийн орлогын эх үүсвэр нь цалин хөлс болдог, засаг захиргаа, үйлдвэр, соёлын нэгжүүд бүхий суурин газрыг хот болгож байх” –аар заасан.
Харин 1983 онд энэ зарлигийг хүчингүй болгосноор манай улсад суурин газрыг хотод тооцох нэгдсэн журам байхгүй болж, 10 жилийн дараагаас буюу 1994 оноос үйлчилж эхэлсэн “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуульд зааснаар “Хот нь 15000 –аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар байна” гэж тодорхойлсоныг өмнө бид дурдсан.
1993 оны хуулийн “тосгон” гэсэн тодорхойлолтод тосгоны хүн амын тоог 15000 хүртэл байхаар заасан. Энэ нь нутаг дэвсгэр уудам, хүн ам цөөтэй манай орны хувьд хэт хатуу хэмжүүр болсон юм.
- Үндэсний статистикийн газраас “хот маягийн суурин” –г өөрсдийн гаргасан шалгуураар ангилахдаа ч тосгодын хүн амын тоог гол шалгуур болгоогүй байна. Үндэсний статистикийн газраас 22 тосгоныг хот маягийн суурин гэж ангилсан ба тэнд тухайн үедээ 500 хүрэхгүй хүнтэй тосгод ч байсан.
Статистикийн тухай хуулийн “Үндэсний статистикийн газар, түүний бүрэн эрх” гэсэн 12 дугаар зүйлийн 3 –ын 2 –т “албан ёсны статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, мэдээлэх хугацааг тогтоох”, тус зүйлийн 3 –ын 5 –д “статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх” эрхтэй гэж заасны дагуу, Статистикийн хороо “хотын хүн ам” гэдэг ухагдахууныг албан ёсоор тодруулсан байдаг.

“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хууль (1994) –д:

- Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг, захиргаа, нутаг дэвсгэр, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн.
- Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амыг хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот (алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон) –той байж болно; гэж заасан.

Тэмдэглэх нь:

- Улаанбаатар нь тэртэй тэргүй Үндсэн хуулиар тусгай статусаа нэгэнт

тогтоолгон “нийслэл” нэрээ анхнаасаа зүүгээд авсан ... хэт өргөмжлөгдсөн энэ байдлаараа бусад хотуудыг доош нь дарж “үгүй хийсэн” манай улсын цорын ганц хот. Ийм байсаар атал, түүний дахиад дээр нь “тусгай статус бүхий хот” зааж өгөх нь утгагүй явдал юм.

- Нэг хуулийн агуулгаар баталгаажин гарч ирж “гүйлгээнд” шинээр орж байгаа нэр томъёог дараагийн хуулиар дахин нэр томъёо үүсгэн тайлбарлах явдал их байна. Үүнээс аль болохоор зайлхийх хэрэгтэй мэт. Дээр дурдсан хуулийн заалтын жишээнээс харахад, “хаяа хот бол дагуул хот”, “тосгон бол бас дагуул хот” гэж уншигдахуйц будлиантай санаанууд гарахаар байна.
- Улаанбаатарын хэт төвлөрөлийн хурдцыг сааруулахад дагуул хот хувь нэмэртэй нь дамжиггүй боловч Налайх, Багануур гэсэн алслагдсан дүүргүүдээс өөр “дагуул хот” гээд нэрлэхээр суурин газар үгүй. Мөн, эдгээр дагуул хотуудын байршил ч гэсэн оновчтой зөв зохицуулагдаагүй, тодруулбал, хот ба дагуул хотуудын хоорондын газар нутаг нь Төв аймаг хамаардаг учраас хотын зааг нутгийг ялган тодорхойлох, тэр бүү хэл хүн амын нягтралыг үнэн зөв тооцоход ч сөргөөр нөлөөлж байгаа юм.

* * *

Ер нь хот тосгоны хөгжлөө тэтгэх чадамжийг тухайн газарт хичнээн хүн аж төрж амьдарч байгаатай нь хамаатуулж авч үзэхээс өөр аргагүй. Өөрөөр хэлбэл хүний тоо гол шалгуур үзүүлэлт юм. Гэхдээ энэ хот тосгоны оршин суугчийн жишиг тоог монголынхоо нийт хүний тоотой харьцуулж процентлон, түүний доод хязгаарыг аль болохоор намсгаж авмаар санагдана. Ингэж байж бид “цэвэр монгол тоо” –той болно. Бүсийн төв 60000 –аас дээш хүнтэй байвал “нэн сайн”, төд байвал “сайн” ... төд байвал “дунд” гээд үнэлгээжүүлнэ. Энэ нь эдийн засгийн бие даасан байдлаа бүрэн хадгалж чадна гэсэн “мон. итгэлцүүр” –ийг бодож гаргахад өгөгдөл болж ашиглагдана.

Мөн монголын хотын дундаж жишээг орон нутгаар нэгбүрчлэн явж газар дээр нь очиж үзэж визуаль байдлаар тодорхойлох оролдлого хийх хэрэгтэй юм. Хэнтийн Бор-Өндөр бол монголын хувьд том ч биш жижиг ч биш дундаж хот мөн байх. Эрдэнэт, Дархан бол манай монголын супер хотууд. Монголын дундаж тосгон дунджаар 10000 мянган хүнтэй байна гэдэг бол (төсөлд ийм тоо явж байгаа) манайдаа ахадсан үзүүлэлт болж тун мэднэ. Төсвийн татаасгүйгээр амьдарч чадах тосгоноо хот гэж үзээд үлдсэн дээр нь нэмээд сумын төв болгоныг тосгоноор тооцох нь бас нэг (байж болох) хялбар бөгөөд шулуун арга юм.

Энэ бүхнээс болон бусад холбогдох мэдээ судалгаанаас үзэхэд, олон улсын хэмжээнд **хотыг нэгмөр тодорхойлох** [тийм нэг] **нэгдмэл хэмжүүрт дэлхий нийтээрээ хараахан хүрч чадаагүй** байна. Иймээс орон бүр өөрийн гэсэн үзэмжээр гол шалгуур хэмжигдэхүүнээ гаргаж хэрэгжүүлж хуульчилдаг гэж хэлж болмоор ажээ. Гэхдээ, 3 сая хүрэхгүй хүнтэй улс байж, тус тус 100000 шахам хүн нэг дор бөөгнөрсөн монголын хуруу дарам цөөн хэдэн хотын тэргүүн манлайлагчид (Дархан, Эрдэнэт) – ыг аймгийн төв дээрх “сум” гээд явж ... ярьж байгаа улс орон манайхаас өөр хаана ч үгүй болов уу.

Тэмдэглэх нь:

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” гэсэн хэллэгийн талаар эргэцүүлэе. Энд, таслал тавин тоочсончлон “засаг захиргааны нэгж” ба “нутаг дэвсгэрийн нэгж” гэсэн 2 тусдаа ойлголт оршиж байна уу, аль эсвэл “засаг захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгж”⁹¹ гэсэн нэг л нэгжийн тухай яриад байна уу гэдэг нь их сонин. Хуульч эрдэмтдийн эмхтгэж гаргасан Үндсэн хуулийн агуулгын талаархи судалгаа – хэрэглээний албан ёсны бус тайлбар сэлтэд, мөн энэ чиглэлээр гарсан бусад ном товхимолд бидний эрэлхийлж буй ялгааны талаар тодотгон өгүүлсэн нь ер үгүй. Үндсэн хуульд “аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо нь засаг захиргааны нэгж” гээд тодорхой зааж өгсөн боловч, тэнд “нутаг дэвсгэрийн нэгж” –ийг тодорхойлоход хэрэг болохоор холбогдох бусад мэдээлэл бас хангалттай сайн тусч өгөөгүй юм. Энэ мэт нөхцөл байдлаас үүдэн доорхи хэдэн санааг дурдаж байна. Үүнд:

- Засаг захиргааны нэгжид төрийн эрх мэдлийн зэрэгцээ хуулийн хүрээнд нутгийн удирдлагын эрх мэдэл хэрэгждэг, тэдгээрийг орон нутгийн удирдлага хэрэгжүүлдэг учраас “засаг захиргаа – нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага” гэж ярихад хүргэсэн бололтой.
- Үндсэн хууль ёсоор, нутаг дэвсгэр (п) засаг захиргааны нэгжид хуваагддаг тул “нутаг дэвсгэрийн (хуваагдмал тэр) нэгж” гэдэг нь чухамдаа яг үнэндээ бол “засаг захиргааны нэгж” –ийг хэлж буй хэрэг юм. Хэрэв ийм юм бол “засаг захиргаа, (таслалтай) нутаг дэвсгэрийн нэгж” гэх хэллэгийг “засаг захиргаа – (тиретэй) нутаг дэвсгэрийн нэгж” болгон бичиж хэвшүүлж заншууштай байна;
- Үндсэн хуулийн 59 –ийн 2, 60 –ын 1 дэх заалтууд нь засаг захиргааны алив нэгжид «нутгийн удирдлага» (local governance), «төрийн удирдлага» гэсэн хосмол гэхээсээ илүү зэрэгцээ функциональ үүрэгтэй 2 байгууллага заавал ажиллах ёстойг ахин дахин тодотгодог. «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага» –ын тухай Үндсэн хуулийн IV бүлгийн нэрийг хүртэл янзалж «Засаг захиргааны нэгж дэх төрийн ба нутгийн удирдлага» болгон өөрчилж, илүү товч бөгөөд ойлгомжтой гарчиг зүүмээр санагддаг.

* * *

Дүгнэлт

1. Монгол Улсын Үндсэн хууль, тодруулбал, түүний агуулга дахь “... Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага” гэсэн нэртэй дөрөвдүгээр бүлэг нь Хот тосгоны эрх зүйн байдлыг боловронгуй болгоход саатуулагч механизмын үүрэг гүйцэтгэх болсон байна;
2. Эн тэргүүнд, 1992 оны Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх заалтыг дараахь байдлаар бүхэлд нь өөрчлөн, (утгачлан) найруулахыг зүйтэй гэж үзнэ. Үүнд (тойм төдий жишээлбэл):
 - Монгол Улсын нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгж болгон аймаг ба хотод, аймаг нь балгад ба сумдад, сум нь тосгод ба багт, хот нь дүүрэгт, дүүрэг нь хороонд тус тус хуваагдана. Балгад бол хот мөн бөгөөд хотын зохион байгуулалттай байна. Зарим хот балгад тусгай статустай байж болно;
 - Аймгийн төв, мөн, хотын алслагдсан дүүргийн төв, үйлдвэр үйлчилгээ дагасан суурин газрууд нь балгад, сумын төв нь тосгон, багийн төв нь гацаа байна.

⁹¹ Судлаач, удирдлагын магистр Д. Оюунтуяа “Нутгийн удирдлагын онол, практикийн асуудалд” өгүүлэлдээ ингэж томъёолсон байв. [“Нутгийн удирдлага” сэтгүүл, 2000, №1 (12)];

- Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт түүнд харьяалалгүй өөр нэгж оршихыг хориглоно; ... г. м.

3. Хот тосгоныг жинхэнэ утгаар нь засаг захиргааны нэгж байх боломжийг хангасан чанарын үзүүлэлт талаас нь авч үзвэл, тухайн асуудал дээр, 1960 оны Үндсэн хууль сүүлчийн (1992) –хэсгээ харьцангуй дээр байсан байна;

4. Монголчууд хот тосгон байгуулж хөгжүүлдэг уламжлалгүй шахуу, өвлөсөн эртний түүхэн туршлага хомс улс юм. Энэ нь манай хүн амын нийт тоотой, уламжлалт эдийн засагтай холбоотой. Иргэншиж нийгэмшээд ирэхийн цагт “хот” гэдэг үг нь ганцдачихаад, бусад зарим үгээн сайн дураараа “голчихоод”, оноосон нэр усаа ч олигтойхон жигдэлж чадаагүй будилж явна. Засаг захиргааны нэгжээ дээд эрэмбэнд нь “хот, аймаг” гээд салгачихаад, дахиад аймаг дотор нь хот гэдэг үг ба нэгж оруулаад ирэхээр [зэрэг] будилаад эхэлдэг бололтой юм. Тиймээс, ялангуяа хотыг янз янзаар утга төгөлдөр онож нэрлэх “шинэ үг” –ийн эрэлд мордоход арга буюу хүрч байна.

Эдүгээ, Өвөрмонголчууд хошууны төвөө балгас, бригадын төвөө гацаа гэдэг. Өвөрмонголын Хөлөнбуйр аймгийн Шинэбарга баруун хошууны төвийг Алтан-Эмээл балгас, зүүн хошууны төв нь Амгалан балгас, Зүүн-Үзэмчин хошууных нь Улиастай балгас аж. Тэгэхээр, “сүүдрээ харж бүсээ зас, нөхрөө харж биеэ ...” гэгчээр, бид ч мөн аймгийн төвөө **балгас**, сумын төвөө **тосгон**, багийн төвөө **гацаа** гээд хэвшчих нь зүйтэй юм болов уу.


Аймгийн төв, сумын төв, баг - бригадын төв, орон нутаг, хот газар, суурин газар, хот суурин газар, төвлөрсөн суурин газар, хөдөө тосгон, хөдөө орон нутаг, ... тасаг, ... завод, ... уурхай, ... үйлдвэр, ... хороо, ... өртөө, дагуул хот, хаяа хот, **аймгийн төвийн сум**, сумын төвийн суурин, сумын төвийн баг, орон нутгийн хот, улс аймгийн зэрэгтэй хот, улсын чанартай хот, нийслэл хот, нийслэл, тусгай статустай хот, Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Орхон аймаг (бараг сумгүй аймаг), чөлөөт бүсийн хот, бүсийн төв, бүсийн хөгжлийн төв, бүсийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, алслагдсан дүүрэг, жишиг хот, нинжаг дагасан явуулын хөдөлгөөнт төр, хилийн боомт, хилийн гарц, засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэр – засаг захиргааны нэгж, нийгмийн цогцолбор ... [энэ тэр] гээд оноосон бус хэлбэрийн есөн шидийн тайлбартай албан ба албан бус үй олон нэрнээс аль болохоор татгалзахын тулд, будлиан тарьсан элдэв олон нэр томъёог цөөлөхийн тулд ядаж эхлээд ингэмээр байна. Засгийн газраас УИХ –д өргөн мэдүүлсэн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд энэ чиглэлээр “ажилласан” нь ер анзаарагдсангүй.

- Хот тосгоны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг Үндсэн хуулийн холбогдох бүлэг заалттай нягт уялдуулан цогц байдлаар авч үзэх шаардлага хэрэгцээ тулгамдсан шинжтэй болсон байна;
- Монголын хот тосгоны өнөөгийн тогтолцоог ... ер нь аливаа юмыг шүүмжлэх амархан, үй түмэн аргумент гаргаж ирж болно. Хамгийн гол нь, яаж зохицуулах тухай шийдлийн хувилбар санал болгох нь амар даалгавар биш ажээ. Хэдийгээр төгс бус хэлбэртэй ч гэлээ, бид дараахь шийдвэрийн загварчилсан төслийг санал болгож байна. (Хавсралт 3, 4 –ийг үзнэ үү.)



Хавсралт 3.

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНЫ БҮДҮҮВЧ (Одоогийн загвар)



Зарим тайлбар:

- 1992 оны Үндсэн хууль батлагдаад бараг 20 жил болох гэж байна. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтыг схемчилсэн тохиолдол энд тэнд ер таарсангүй. Хэрэв байдаг бол тэр их ховор эд байх. Эсбөгөөс, ийм байдал нь схем зурахаасаа хүмүүс залхуурсандаа биш, харин түүнийг зөв зурж зөв тайлбарлахад ихээхэн төвөгтэй байсан ... байгаагийн илрэл ч байж болох юм.
- Хавсралтаар үзүүлсэн энэ бүдүүвчийг халт харахад, “монголын “икс хот – тосгон” –ыг нийслэл, дүүрэг, хорооны аль эрэмбэд дүйцүүлэн жишвэрлэх вэ гэдгийг шууд хэлэх ямар ч бололцоогүй байна. Энэ нь, монголд, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын дотоод зүй тогтол [хотын тухайд] бүрэн алдагдсаны, эс бөгөөс тийм зүй тогтол ерөөсөө байхгүй байгааг гэрчилнэ.
- Одоо баримталж байгаа эргэлзээтэй энэ сонин “зарчмаар” бол баг дотор ч “хот” үгүй юмаа гэхэд “тосгон” байж байх бүрэн бололцоотой мэт. Гэвч үүнийг Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд “хүний тоо” –ны босго тавьж “хоригложээ”. Ингэсэн нь, тухайн асуудлаархи Үндсэн хуулийн “үзэл санаа” гэж хэрэвзээ байдаг бол түүнтэй харшилдсан байх магадлалтай. Тосгон бол угтаа жижиг размерийн хот юм. Гэтэл манай зарим тохиолдолд, сумын төв нь тосгон биш, хот бол бүр биш. Тэгээд тэр ЮУ юм бэ гэж асууж хүртэл болохоор нөхцөл байдал бий болжээ. (Одоо үйлчилж байгаа Хот тосгоны ... хуульд тосгоны хүн амын доод хязгаарыг заасан байдаг)
- Олон зуун сая хүнтэй, тоолж барахгүй олон хоттой юм шиг хот хүрээндээ улсын зэрэг, орон нутгийн зэрэг олгох гээд байгаа нь монголд, хот тосгоныг харъяалж удирдах асуудал ихээхэн хэмжээний зохиомол хүндрэлтэй тулгарсны гор юм. Үндсэн хуулийн эргэлзээтэй зохицуулалтыг эвтэйхэн тойрох гэсэндээ ингэж

байгаа гэж үзнэ.

- Дархан, Эрдэнэт, Чойрыг аймаг үүссэн нь эдгээр нэр бүхий хотуудыг засаг захиргааны нэгж болгон биеийг нь даалгахын тулд “арга буюу хийсэн ажил” байв. Өөрийн гэсэн нутагтаа бусдаас хараат биш “амьдрах” –ын тулд хот заавал “хот биш” болоход хүрдэг ийм сонин хуваарь 1960 оны Үндсэн хуульд ч байгаагүй ажээ. 1992 оны Үндсэн хуулийн зохицуулалт, энэ тал дээр, бодлогын талаасаа их алдсан. Уг нь, аливаа зөв бодлого зөв нэрээс эхэлдэг гэдэгсэн. Шинээр үүссэн аймгууд уртаашаа 2 - 3 сумтай. ГСА дугаартай тээврийн хэрэгслэлийг харсан нутгийн иргэд “Гурван Сумтай Аймаг” –ийн машин давхиж одов хэмээн шоолон шогшрон ярилцах нь нэг хэсэгтээ үнэхээр “байсан явдал” билээ.
- Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн голд өөр нэрийн нэгж, аймаг, нийслэл “ирээд буучихаж” болдог өнөөгийн боломжийг Үндсэн хуулиар хаах хэрэгтэй. Энэ бол зайлшгүй анхаарч үзэх том дутагдал. Ингэх нь, тухайн аймгийн нутаг дээрх өөрийнх нь “геополитик” –ийг алдагдуулдаг. “Их гэрийн доторхи бага гэр” –ийн энэ оньсыг нэгмөсөн тайлах чиглэлд олон санал санаачилга гарч байжээ. [Жишээ нь, Булган аймгийн төвийг Эрдэнэт хотод шилжүүлж, Орхон аймгийг татан буулгах, Сэлэнгэ аймгийн төвийг Дархан хотод шилжүүлж, Дархан – Уул аймгийг татан буулгах (манай зарим судлаачийн санал) ... гэх мэт.] Дашрамд дурдахад, одоогийн үйлчилж байгаа Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд саяын дурдсанчлан “аймгийн төвийг өөрчилж зарлах” арга ажиллагаа тун таарамжтай байх байсан. Нэр бүхий 3 аймгийг байгуулах үед ашиглагдаагүй өнгөрсөн энэ боломж одоо ч нээлттэй хэвээр байна.
- Энэ бүх цогц асуудал 1992 оны Үндсэн хуулийн агуулгын хүрээнд зохистой шийдэгдэх боломжгүй.




(Footnotes)

¹ Л. Золзаяа, Л. Лувсанжамц, Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал, Судалгааны тайлан, УБ, 2003;

Хавсралт 4.

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООНЫ БҮДҮҮВЧ
(ШИЙДЛИЙН ШИНЭ ХУВИЛБАР - САНАЛ)



Зарим тайлбар:

- Дурдсан схемийг баримталбал, Засаг захиргааны удирдлагын шаталбарын зохист байдал (байрлал) хангагдана. “Дүүргийн статусыг сумтай адилтган үзэж байна” ... гэхчилэнгийн гомдол тэмцэл арилна. Монгол Улс жинхэнэ ёсоороо “хот” гэсэн засаг захиргааны нэгжтэй болно, хот гэдэг их айл бусдаас “хараат бус” болно.
- Засаг захиргааны нэгж дэх төрийн удирдлагын түвшний дүйцүүлэн жиших ранг зурагт үзүүлсэн байдлаар тодорхойлогдоно. (Аймаг талаасаа: А-1, А-2, А-3, хот талаасаа: Х-1, Х-2, Х-3) Засаг захиргааны нэгж заавал газар нутагтай байх ёстой. Сумын доторхи нэгжүүд одоогоор хилийн зааггүй байгаа (газар нутаггүй гэсэн үг биш) нь, тэдгээрийг энэ схемд өвөрмөцөөр байршуулахад нэмэлт нөхцөл болж өгөв.
- Балгас бол аймгийн төв мөн бөгөөд хотын статустай байна. Армонголчууд нурж эвдэрсэн, хаягдаж гээгдсэн суурингийн туурийг “балгас” гэх хандлагатай байдаг. Ийм ойлголтын үүсэл түүхэн талаасаа харьцангуй хожуугийх болов уу. Харин, Өвөрмонголчууд эдүгээ, оршин байгаа суурин газар гэсэн агуулгаар нь эл үгийг зөв хэрэглэж байна. Тэгэхээр, “балгас” гэдэг бол муухай үг биш ажээ. Балгад гэдэг нь олон балгасыг хэлж байгаа юм. Дашрамд тэмдэглэхэд хот гэдэг үгийг ч өөлж гоочилж болно. Хот айл, хоттой хонь ... гэх зэргээр “бөөгнөрсөн”, “түр цугласан” гэх аястай, нүүдэлчин ахуйг ямар нэг хэмжээгээр илтгэх утга түүнд бий. Уг нь монголчууд хотыг хүрээлэн буусан баахан олон гэр бараатай том газар болохоор нь “хүрээ, их хүрээ”, “хэрмэн хүрээ”, “зүүн хүрээ” гэдэг байж.

- Тосгон бол сумын төв мөн. Сум болгон 1 төвтэй байх бөгөөд сумын төвтэй өрсөлдөх хэмжээний ба түүнээс давсан үзүүлэлттэй үйлдвэрийн суурин тухайн сумын нутгаг дэвсгэрт бий болох аваас түүнийг, шаардлагатай бол, хот болгон “өргөмжилж” газар нутаг тасдан өгч, засаг захиргааны зөрчилдөөнгүй байлгах нөхцлийг хангана, шуудхан хэлэхэд, түүнийг сумын харъяаллаас гаргана. Шинэ сум, эсвэл шинэ хот ингэж төрж бий болно. Газраа хотод булаалгасан сум бие даан орших нь утгагүй хэмжээнд хүрч хэт жижгэрэх аваас, тэрбээр, төрүүлж “бойжуулсан” 1 дүүрэгтэй шинэ хотынхоо салбар хороодын нэг болж “амьдрах” боломжтой.
- Ирээдүйд багийн “под хийсэн” төвүүд хаа сайгүй бий болно. Тэдгээрийг одооноос зөв эрэмбээр ялган нэршүүлэх хэрэгтэй. Иймээс, багийн төвийг, сумын төвтэй андуурагдахгүй байлгах үүднээс “гацаа” гэж нэрлэх (судлаач Б. Мөнхцэцэгийн санал) нь зөв болов уу. Мөн, 1930 –аад оны зарим түүхэн хүмүүсийн дурсамж дурдатгалд “хондого” гэдэг хуучны сайхан монгол нэр тааралддагийг дурдалтай.
- Балгасан ба жижиг ба жижгэвтэр хотыг ганц хүрээтэй гэж үзнэ. Ийм тохиолдолд илүү орон тоо, шат дамжлага байлгахгүйн тулд тухайн балгасан ба хотын [доторхи] **хүрээний** Засаг даргын чиг үүрэг балгадын ба хотын ба даргад автоматаар шилжинэ. Балгасун ба хот 2 ба түүнээс дээш хүрээтэй байх тохиолдолд л хүрээний Засаг дарга “орон тооных” байна.
- Дэвшүүлсэн саналын өөр нэг дурдууштай онцлог бол Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дээр түүнд харяалалгүй өөр нэрийн нэгжийг байлгахыг хязгаарласан, мөн, одоогийн байгаа ийм “дутагдал” –ыг арилгахад чиглэсэн явдал юм. (Жишээ нь, Улаанбаатар хот Төв аймгийн голд биш, харин дор хаяж 2 аймагтай хиллэнэ ... г. м.)
- Зурагт үзүүлсэн дээрх бүдүүвч нь зарчмын хувьд орших “боломжит нэгэн хувилбар” ... Үндсэн хуулийн агуулгын өөрчлөлтийн тухайлсан нэг асуудал юм.



ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

(Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд)

Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа

Улс орон ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үйл явцад гарсан нийгмийн нэг томоохон үзэгдэл бол хүн зон хот суурин газарт ихээр төвлөрч, улмаар монголын хотуудын хөгжил төлөвшилд холбогдох эдийн засаг, нийгмийн зохицуулалт шаардсан нарийн төвөгтэй шинэ шинэ харилцаанууд үүсч гарч ирсэн явдал юм.

УИХ –ын 2009 оны хаврын ээлжит чуулганаар,

- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Эртний Хар хорин⁹² хотыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай УИХ –ын тогтоолын төсөл;

–ийг хэлэлцэхээр тус тус төлөвлөсөн. Эдгээрээс гадна, хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлсэн, мөн хэлэлцүүлгийн шатандаа хүлээгдэж байгаа энэ чиглэлийн шийдвэрүүдийн жагсаалтад⁹³ жишээ нь, улсын зэрэглэлтэй зарим⁹⁴ хотын тухай тогтоолын төсөл ч орсон байгаа. “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга) –ийн төсөл нь УИХ –ын 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан (дарааллын №27 -д) тул бид доорхи нэмэлт танилцуулгыг бэлтгэв.⁹⁵

Хот тосгоны эрх зүйн байдлыг эргэж харах хэрэгцээ, шаардлага

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль анх 1993 онд батлагдаж, өнгөрсөн хугацаанд агуулгад нь 2 удаа (1995, 2003) өөрчлөлт оржээ. Мөн, хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн Газраас УИХ –д 2006 оны 12 дугаар сард өргөн мэдүүлж, холбогдох үндэслэл танилцуулгыг хамтатган ирүүлсэн байна. Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хүрээнд ч энэ хуулийн шинэчилсэн найруулгыг батласан байхаар төлөвлөсөн⁹⁶ байдаг.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай асуудал нь Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль ... бусад олон хуулийн агуулгатай шууд болон шууд бусаар холбогддог тул түүнийг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, орон нутгийн удирдлага хамтын оролцоогоороо олон санал санаачилга дэвшүүлсээр иржээ. Тэгэхээр, хот тосгоны эрх зүйн байдлыг дахин тодотгох, хуулийн агуулгыг бүхэлд нь эргэж харах хэрэгцээ нийгмийн амьдралаас урган гарсан гэж үзэж бүрнээ болохоор байна. Зарим үндэслэлийг тодруулбал:

⁹² Зарим судлаачдын нотолж байгаагаар, хотын хуучин нэр нь Хар хэрэмт балгас, Хар хэрмэн хот гэж байсан болтой байдаг. Хар хүрэм гээд байгаа нь “түүхэн үнэнээс хол” буруу нэр юм. Хэрмэн хашаатай хот бол түүхэнд хаа сайгүй түгээмэл байсан, харин “хүрэм өмссөн” хот гэж ер дуулдаагүй. Гэтэл, Улсын Их Хурлын нэг тогтоолд түүхэн талаасаа нэн эргэлзээтэй буруу нэрийг баталгаажуулаад “Хар хүрэм” гээд биччихсэн явж байна лээ.

⁹³ УИХ –ын Тамгын газар, 2009.01.05;

⁹⁴ Замын – Үүд;

⁹⁵ Бэлтгэсэн огноо: 2009.4.29;

⁹⁶ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төсөл нь УИХ –ын 2007 оны намрын чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд [бас] орсон байв.

- Монгол Улсын нэр бүхий том хотууд засаг захиргааны нэгжийн хувьд “сум” ангилалд хамаарч, үүнээс үүдэлтэйгээр ... сумын хэмжээний удирдлага зохион байгуулалт, орон тоо, төсөв нөөцөөр “хот гэдэг их айл” –ын үйл ажиллагааг зохих ёсоор авч явахад хүндрэл бэрхшээл учирах болсон;
- Улсын зэрэглэлтэй хотыг сумын харъяаллаас гаргаж, тэдгээрийн удирдлагын нөөцийг өргөтгөн бэхжүүлэх шаардлага үүссэн;
- Мөн, төрийн бодлогын [бусад холбогдох] баримт бичгүүдэд заагдсаны дагуу аймаг, сум бүсчилж томсгох үйл явц [удахгүй] хэрэгжиж эхлэнэ. Энэ тохиолдолд олон тооны хот суурин газар бие даасан хот тосгоны хэлбэртэй үлдэх магадлал өндөр байгаа. Тиймээс, бие даасан хот тосгоны [хожмын] хэвийн үйл ажиллагааны эрх зүйн нөхцлийг хангах “угтуулсан” шинжтэй зарим зохицуулалт хэрэгтэй болоод байна; ... г. м.
- Сүүлийн жилүүдийн мөнгөний ханшны уналт, амьжиргааны өртөгийн өсөлтөөс шалтгаалан өөрийгөө тэтгэх чадваргүй болсон засаг захиргааны олон жижиг нэгжүүд улсын төсөвт ихээхэн дарамт учруулах болов. Эдийн засгийн хямралт байдлаас болж орон нутгийн чанартай хот суурин газрын аж амьдрал ч зогсонги шинж байдалд шилжих аюул нүүрлээд байна.

Иймээс, засаг захиргааны нэгж дэх өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газрыг Үндсэн хуульд заасан ёсоор аль болох нийгэм – эдийн засгийн цогцолбор байлгах талаас нь тусгайлан авч үзэх хэрэгцээ шаардлага байнга гарч, улмаар, хот тосгоны эрх зүйн асуудал ахин дахин хөндөгдөхөд хүргээд байгаа юм.

Монголын нийгмийн хотжилтын түвшнийг илтгэх зарим үзүүлэлт

Монгол улс өнөөдөр 2,7 сая хүнтэй, [21 аймаг, 331 сум, 1538 багтай, нийслэл хот 9 дүүрэг, 132 хороотой байна. Хүн амын тооллогын дүнгээс үзэхэд, монголын нийгмийн хотжилтын түвшин 56.6% –д хүрчээ. Энэ үзүүлэлт **дэлхийн дунджаас давж байгаа** ч, монголын хот газрын нийт хүн амын 67,7% нь зөвхөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэтэд хотод төвлөрсөн байдаг. Төмөр замын дагуу байршсан зургаан хотод хотын нийт хүн амын 73% амьдарч байхад бусад 20 хотод дөнгөж 27 хувь нь ногдож байна. Нэг аймаг дунджаар 70000, нэг сум дунджаар 4400 хүн амтай.]⁹⁷

Хотжилтын төвшин өндөр хувьтай гарч байгаа нь монголын хүн ам цөөн, тархан суух нутаг газар их, нягтшил нэн сийрэг байгаатай холбогдох нэг төрлийн “сөрөг эффект” бөгөөд, мөн чанар талаасаа ихээхэн **хуурмаг үзүүлэлт** тул түүнд болгоомжтой хандах хэрэгтэй. Үнэндээ бол монгол нь хотожсон гэхээсээ илүү, бүхэлдээ “хөдөөжсөн” ихээхэн өвөрмөц онцлогтой улс юм.

[Манайд 1500 хүрэхгүй хүнтэй сумд ч олон. Аймгийн төвөөсөө 30 хвртэл км зайтай 22 сум, 50 хвртэл км зайтай 20 сум, хоорондоо 30 хвртэл км зайтай 24 сум, хоорондоо 50 хвртэл км зайтай 72 сум байна. Нийт сумдын 51.7 хувь нь жижиг буюу 3000 –аас доош, 30.1 хувь нь жижгэвтэр буюу 3001 – 5000 хүртэл, 8.5 хувь нь дундаж буюу 5001 – 7000 хүртэл, 9.7 хувь нь том буюу 7000 –аас дээш хүн амтай байгаа юм. Хамгийн олон хүн амтай аймаг нь Хөвсгөл (120000 хүнтэй), хамгийн цөөн хүнтэй нь Говьсүмбэр (12000 хүнтэй) байна. Монголын нэг сум дунджаар 4500 – 5000 хүнтэй, бүр 1000 хүнтэй сум ч байна.]⁹⁸

⁹⁷ Энд дурдсан зарим тоон мэдээллийг Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг. Байгаль орчны суурь судалгаа (2008) –ны тайлангаас авав.

⁹⁸ Л. Золзаяа, Л. Лувсанжамц (Бүсийн хөгжлийн санаачилга), Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдлын үнэлгээ, Судалгааны тайлан © RDI, УБ, 2003;

[Одоогийн байдлаар, хотын нийт хүн амын 15.0% нь төвийн бүсэд, 6.3% нь зүүн бүсэд, 13.1% нь хангайн бүсэд, 9.1% нь баруун бүсэд, харин дийлэнх хэсэг нь буюу 56.5% зөвхөн Улаанбаатар бүсэд оршин сууж байна. Улсын хэмжээнд, хөгжлийн бүсийн тулгуур төвөөр товлож тогтоосон нэр бүхий 8 хотод хотын нийт хүн ам –ын дөнгөж орчим 20% нь амьдардаг]⁹⁹. Энэ мэтчилэнгийн олон тоо баримтаас монголын томоохон хотуудын хөгжлийн төвшин газарзүйн байршлаасаа хамаараад хоорондоо ихээхэн ялгамжтай, жигд бус байгаа нь шууд харагдана.

Монголын хотуудын хоорондын алслалтын дундаж зай хол, олонхи хотуудын аж ахуйн нөлөө бүхий чиглэл тогтож тодроогүй, хот суурин газрууд төмөр зам болон чанар сайтай засмал замаар холбогдоогүй, иргэд богино хугацаанд бага зардлаар чирэгдэл багатай зорчих боломж нөхцөл хангалттай бүрдээгүй зэргээс шалтгаалаад манай томоохон хотуудын хоорондын эдийн засгийн харилцаа өргөжин хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал байдалтай байна.

Сумын төвийн суурин газруудын ихэнх хэт жижиг, бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн чадавхгүй, зах зээлийн багтаамж бага, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих боломж хязгаарлагдмал, үүнтэй уялдан, тэнд, ажилгүйдэл ядуурлын төвшин огт буурахгүй байна. Байдал ийм байгаагаас шалтгаалан хөдөө, орон нутгаас хот суурин газар луу шилжих их нүүдэл үргэлжилсэн хэвээр байна. [Зөвхөн 2004 онд орон нутгаас 80400 хүн шилжин улс нутгийнхаа гүн рүү явсны 94% нь Нийслэл, Дархан – Уул, Орхон, Төв аймагт ирж суурьшчээ.]¹⁰⁰

Иймд асуудлыг олон талаас нь тухайлан шинжиж, хүн төрөлхтөний хотжиж ирсэн түүхэн туршлага, алдаа оноог цэгнэн, монголчуудынхаа зан заншил, аж ахуй эрхлэлт, амьдралын хэв маягт таарч тохирсон, байгалийнхаа нөөц баялагт түшиглэн хотжин хөгжих алс хэтийн цэгцтэй бодлого боловсруулж эрчимтэй хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлын нэг юм.

Хотжилтын асуудлаар гадаад орнуудад баримталж буй бодлого чиглэл

[Хүн төрөлхтний түүхэнд анх удаа дэлхийн хүн амын талаас илүү хувь нь хот суурин газарт амьдардаг болов гэсэн мэдээ ноднин зун (2008.5.23) гарч байсан. Эдүгээ, хүн амынх нь талаас илүү хувь нь хот суурин газарт амьдардаг улсын тоонд Монгол Улс ч багтаж байна] Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн чиг хандлага нь хот суурин газар өргөжих, тэнд амьдарч буй хүмүүсийн тоо өсөн нэмэгдэх үйл явцтай шууд холбоотой байна гэж үзэж болно. Нийгмийн хөгжлийн голомт болсон орчин үеийн хотуудыг төрийн бодлогоор дэмжин хөгжүүлэх нь зөвхөн Монгол Улсын төдийгүй дэлхийн нийт улс орнуудын Засгийн газрын үйл ажиллагааны нэг үндсэн зорилт болоод байна.

НҮБ –ын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт “Том хот руу шилжин суурьших явдлыг зөв арга бодлогоор зохицуулж багасгахын тулд аливаа улс орон хөдөөгийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бус нутгийн төв, дагуул хотуудын хөгжлийг дэмжихийг Засгийн газрын үйл ажиллагааны нэг тулгамдсан чиг зорилт мөн” гэж заагаад, бүс нутгийг хөгжүүлэх асуудлаар тодорхой хөтөлбөр боловсруулж, эрчимтэй бүтээлч алхам хийхийг дэлхийн улс оронуудад уриалсан. Мөн, Стамбулд болсон НҮБ –ын II бага хурлаас, нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангах нь Засгийн газар болгоны үүрэг байх ёстой” гэж тунхагласан байдаг.

Монгол Улс НҮБ –ын гишүүн орныхоо хувьд тухайн чиглэлээр хвлээх үүргийнхээ дагуу

⁹⁹ <http://www.umnugovi.mn/static/229.shtml?menu=337>;

¹⁰⁰ мөн тэнд;

холбогдох шийдвэрийг дээд түвшиндээ цаг алдалгүй гаргасан. УИХ –ын 2001 оны 57 дугаар тогтоолоор¹⁰¹ “Бүсүүдийн төв, Монгол Улсын хотуудын зэрэглэлийн асуудлыг тухайлан судалж санал боловсруулан, Хот ба тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт УИХ –ын 2001 оны намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэх үүргийг Засгийн газарт өгч, хэрэгжүүлж байв.

Европын улс орнуудад 1970 он хүртэл олон тооны жижиг засаг захиргааны нэгжүүд байсныг 1980 он гэхэд улс бүрийн хувьд дунджаар 30 – 80 хувиар бууруулсан байна. Жишээ нь, Дани улс 80 хувиар, Германд коммунны тоо 24500 байсныг 8600 болгож, [засаг захиргааны] тойргийг 425 –аас 235 хүртэл, Нидерландад 1209 –өөс 647 болтол тус тус цөөрүүлжээ. Энэ өөрчлөлтийн дараа европын дундаж улс 289 – 641 захиргааны нэгжтэй, нэг нэгж нь дунджаар 25000 орчим хүн амтай болсон байдаг. Тэдний энэхүү нэгдэн нягтрах үйл явц нь өнөөг хүртэл тасралтгүй үргэлжилсээр байна.

Суурьшмал амьдралтай, засаг захиргааны олон жилийн түүхтэй хөгжилтэй орнууд ХХ зууны сүүлч, шинэ мянганы эхээр засаг захиргааны хуучин тогтолцоогоо өөрчилж, үеэ өнгөрөөсөн хэт жижиг хэсэгт хуваагддаг, улс орны хүч чадлыг тарамдуулдаг ... зэрэг олон үндэслэлээр нутаг дэвсгэрийн нэгжийнхээ шинэчлэлийг тууштай зоримог хийж байна. Тухайлбал Франц Улс олон зуунаар уламжилж ирсэн засаг захиргааны 96 нэгжээ 22 болгосон, польшууд 49 воеводьгоо 16 болгон цомхотгосон, өдгөө түүнийгээ дахиад цөөлнө гэж ярьж байгаа, Япон Улс 50 гаруй мужаа арван хэд болгосон бол, манай хойт зэргэлдээх хөрш ОХУ засаг захиргааны 89 субъектээ 28 болгох гэж мэрийж байна. Мөн БНХАУ –д засаг захиргааны шинэчлэлийг аажмаар хэрэгжүүлсээр байна.

Өөр бусад орны туршлагаас ч харсан, жижиг нэгжүүдийг бие даасан коммун болгохоосоо өмнө тэдгээрийг нэгтгэн хэмжээг нь томсгож эдийн засгийн баазыг нь өргөтгөх замаар энэ асуудлыг амжилттай шийддэг байна. Жишээ нь: Швед Улс 10000 –аас доош хүн амтай засаг захиргааны нэгжид улсаас төсөв хуваарилахгүй байх шийдвэр гаргаж, үүнээс бага хүн амтай нутаг дэвсгэрийн нэгжүүдийн сайн дураараа нэгдэн нийлэх эцсийн хугацааг нь 1980 он гэж бүр 1974 онд хуулиар зааж тогтоож өгч байжээ. 1974 оны энэ хуулиар 1980 оноос хойш нэгдэж чадаагүй нутаг дэвсгэрийн нэгжүүдийг хүчээр нэгтгэх эрхийг Засгийн газартаа олгосон байдаг. Ингээд 1989 он гэхэд сайн дураараа болон Засгийн газраас хүчээр нэгтгэсний үр дүнд Шведийн коммуну тоо 2900 орчмоос 289 болж даруй 10 дахин цөөрчээ. Коммунуудыг нэгтгэсний хамгийн гол ач холбогдол нь бие даан өөрийн нийгэм, эдийн засгийн асуудлаа шийдэж чаддаг бүтэц бий болдог явдал юм.

Энэ мэт засаг захиргааны хуваарийн өөрчлөлт, шинэ зохион байгуулалтын чиглэлээр олон улсын хэмжээнд явагдаж байгаа ерөнхий үйл явц бүхэлдээ хот тосгонжилтыг дэмжих чиг хандлагатай байна. Манайх ч мөн гадаадынхантай төстэй ийм арга замаар сумдаа нэгтгэж цөөлөн, орон нутгийн бие даан хөгжих боломжийг нэмэгдүүлэн, нийгэм эдийн засгийн асуудлаа тухайн засаг захиргааны нэгж, хот тосгон өөрсдөө түүгээрээ аль болохоор бие даан шийддэг орчин үеийн шинэ тогтолцоонд шилжих боломжтой гэж гүйцэтгэх засаглалын түвшиндээ үзсээр иржээ.

Монголын хотууд “хот биш” болж хувирсан зарим шалтгаан

Монголд барилгажсан орчин үеийн хот хүрээ олонгүй. Харин сумын төв маягийн суурин газар бол нилээн олон бий. Түүхэн уламжлал тал руу нь хөөж үзсэн ч уламжлалт эртний манай суурингууд¹⁰² нь засаг захиргааны нэгжийн хуваарь төдийг илтгэх эсгий хотоос

¹⁰¹ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай;

¹⁰² Энэ ба өмнөх хуудсанд дурдсан тоон мэдээлэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга асан, УИХ –ын гишүүн Су.Батболдын “Сумдын тоог

нэг их хэтрээгүй байдаг юм. Харин 1960 –аад оноос нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг өөрчлөн жижигрүүлэх замаар гаднын их гүрний хараат байдлыг улам лавшруулж, уг зорилго эхэн үедээ нүүдэлчдийн хөдөлгөөнийг хязгаарлан хянах, ардын аж ахуйтнаас мал мах, арьс шир, ноос ноолуур, түүхий эд, татвар гувчуурыг нэн шуурхай хураах механизм бий болгоход чиглэгдэж, “зам зууртаа” хөдөө орон нутагт хот тосгонжилтыг захиргаадалтын аргаар хүчтэй эхлүүлж ... улмаар зарим биет өгөөжөө өвлүүлж үлдээснээр бид хот тосгон хэмээн тоочиж нэрлэх нилээн олон газартай болоод авсан билээ.

Гэвч 1990 –ээд оноос монголын “хуучин” хотууд хот биш болж хувирсан. Хамгийн гол урхагт шалтгаан нь бидний байн байн дурдаад байгаа Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтад оршиж байгаа юм. Нэгэнт хот нь засаг захиргааны нэгж биш учраас, түүнийг засаг захиргааны нэгж байлгах, бас болгохын тулд “сум” болгох хэрэгцээ шаардлага гараад ирсэн. Тэгээд ч зогсохгүй, Үндсэн хуульдаа захирагдан, хотыг хот гээд нэрлэхийг хэмжээний алдаа гаргачих вий гэсэн сэтгэхүйн далд болгоомжлол үүсч, монгол улсын хотыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг 1993 оны хуулиар зориуд өндөрсгөж “чангалсан” бололтой байна.

Удаах нэг шалтгаан нь, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд оршиж байгаа юм. Дээр үед, хотын хуучин статустай явж ирсэн газрууд “хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжөөгүй” ... гэх зэргээр тухайн хуулийн хотод хамаатуулж заасан шалгуур үзүүлэлтүүдийг нь давж “дийлэхгүй” байгаа. Тийм учраас, бас, олон хот “сум” нэрийг зүүхээс өөр аргагүйд хүрээ болов уу. “Хот бүрдүүлэгч дэд бүтэц” гэдэгт юуг хэлж байгаа нь ч хуулийн агуулгаас харагдаж өгөхгүй байна.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 –д:

- “хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна”,
- мөн зүйлийн 2 –т “50000 –аас дээш (шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл) оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно” ... гэжээ.

Гэтэл, одоогоос 10 жилийн өмнө 2000 онд Орхон аймаг 72525 хүнтэй, Дархан – Уул аймаг 83270 хүнтэй байсан, тэгээд ч зогсохгүй энэ 2 аймгийн нийт хүн амын 79 – 96 хувь нь статистик тооллогын мэдээгээр “хотын хүн ам” гэж тооцогдоод байхдаа ч улсын зэрэглэлтэй хот ч биш, зөвхөн, аймгийн доторхи сумын статустайгаа явж ирсэн байдаг юм.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хэр зэрэг оновчтой хуваагдсан эсэхийг шалгах шалгуурууд бас байдаг бөгөөд тэдгээрийг багцлан авч үзвэл:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нь удирдлагын түвшин бүрд харилцан уялдсан нэгдмэл байдлыг хангасан байх;
- Бүс нутгийн хөгжлийг нийгэм, эдийн засаг, экологийн иж бүрэн хандлагаар үр ашигтай явуулах нөхцлийг бүрдүүлсэн байх;
- Засаг захиргааны нэгжүүд, тэдгээрийг бүрдүүлэгч хэсгүүд нь удирдлагын чиг үүрэг, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хялбар дөхөм байхаар зохион байгуулагдсан байх;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламж нь бүхэлдээ бүс нутгийн болон улс орны чанартай томоохон зорилтыг хэрэгжүүлэн байгаль, эдийн засгийн нөөц, боломжоор хангагдсан байх; –ыг шаарддаг.

цөөлөх боломжтой” ярилцлагаас хэсэгчилж (Ярилцсан Р. Жаргалант, 2006.11.30) авав.

Манай засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нь дээрх шалгууруудыг бүрэн хангаж чадахгүй байгаагийн дээр одоогийнхоо энэ хэлбэрээрээ цааш явах нь тодорхой хэмжээний мухардмал байдлыг үүсгэж хотын ирээдүйн жам ёсны хөгжилд хохирол учруулж мэдэхээр байна. Дээр нь, холбогдох хуулиудын нэр томъёо цэгцрээгүй, хууль эрх зүйн үүднээс зохих журмын дагуу тодруулан тайлбарлаагүй зөнд нь орхисон зүйл заалт олон байгаа нь энэ чиглэлийн хуулийг ерөнхийдөө дагаж мөрдөхгүй аргацааж байх, бүр, өөр хоорондоо уялдаагүй хууль журам олноор нэмэгдэж гарах урьдач нөхцлийг бүрдүүлж байна.

Хотын талаарх ерөнхий ойлголт, тодорхойлолт¹⁰³

Хотын талаар нэгдмэл, бөгөөд зөв оновчтой ойлголттой болох нь хотжилтоос үүдэн гарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн тустай гэж үзнэ. Бас, дэлхийн улс орны туршлага сэлтийг харах хэрэгтэй юм. Хотыг шинжиж тодорхойлох үндсэн үзүүлэлт байдаг байна. Тэдгээр нь: Үүнд:

1. Хотын хүн амын тоо;
2. Хотын газар нутгийн хэмжээ;
3. Хотын хүн ам, нутаг дэвсгэрийн харьцаа (нягтшил буюу төвлөрөл);
4. Хотын эдийн засгийн чадавхи;

Гэхдээ, дэлхийн хэмжээнд хотыг нэгмөр ягштал тодорхойлсон нэгдмэл ойлголт ухагдахуун үгүй. Иймээс, улс орон бүр тухайн өөр өөрийн үндэсний хэмжүүрийг ашиглах хандлагаар явж ирсэн байна. Харин манай улсын хувьд хотыг “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль” –д зааж тодорхойлсон байдаг ч, тухайн асуудал нь, дан ганц энэ хуулийн хүрээгээр хязгаарлагддаггүй.

Хот тосгоны эрх зүйн байдалд холбогдох хуулийн заалтуудаас үзэхэд өнөөгийн манай улсын хотуудын онцлог дараахь байдалтай байна. Үүнд:

- Хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэг нэгжийн нутаг дэвсгэрт оршдог;
- Хот, тосгон нь хуулиар олгосон нутаг дэвсгэргүй;
- Хот нь улсын, аймгийн зэрэглэлээсээ үл хамааран засаг захиргааны хувьд аль нэг аймаг суманд харъяалагддаг.
- Хот, тосгоны удирдлага нь засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрхгүй. (Засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрх нь бүх шатны засаг даргад хадгалагддаг)

Аливаа зүйлийг хэмжих нэгдсэн нэг шалгуур хэмжүүртэй байх нь ажил асуудлын зохицуулалтыг хөнгөвчилдөг ч хот суурин газрыг тодорхойлсон дэлхийн хэмжээний нэгдсэн нэг стандарт гаргах явдал маш хүндрэлтэй, боломжгүй асуудал юм. Жишээ нь, 5000 хүнтэй хөдөөгийн тосгоныг хот гэж нэрлэдэггүй ч, 2500 хүнтэй жуулчны бааз, эсвэл рашаан сувиллын газрыг “хот” гэж үзэх явдал байдаг. Хятад, Энэтхэг ... зэрэг хөдөө нутагтаа ч хүн ам ихтэй улс оронд зөвхөн хотыг зөвхөн хүн амын тоогоор бус хотын бусад шалгуур үзүүлэлтээр авч үзэх шаардлагатай болдог байна.

НҮБ –аас жил бүр гаргадаг “Хүн ам зүйн жилийн эмхэтгэл” –д дэлхийн 226 улсын “хотын тодорхойлолт” –ын талаар авч үзжээ. Хүн ам зүйч Мартин Брокерхоф шинжилснээр, нийт улсын 50% нь хотыг тодорхойлохдоо засаг захиргааны нэгжийн асуудлыг гол үзүүлэлт

¹⁰³ Манж нар 1715 онд гэхэд монголд эзэмшлээ бүрэн тогтоосноор монголын нутаг дэвсгэр 3 [чигийн] замд хуваагдаж, тэдгээрийг Хүрээ, Улиастай, Ховдын амбаны газар тус тус захирч байв.

болгон, засаг захиргааны нэгжийн төвөө шууд хотоор тооцжээ. Мөн, 51 орон хот, хөдөөгөө зааглахдаа хүн амын тоо ба нягтшлаар нь ангилсан байна. 39 улс “хот” –ыг тухайн газар нутгийн эдийн засгийн чадавхийг гол шалгуур болгосон байна. Гэтэл 22 улс хотын тухай ямар нэгэн хэмжүүр тодорхойлолтгүй явж байгаа ба үлдсэн 8 улс нь хүн амаа бүгдийг нь “хотынх” гэж үзжээ.

Улс орнууд хотоо хэрхэн тодорхойлж байгааг жишээ болгон Хойд Америкийн 3 улсаар авч үзвэл:

- АНУ –ын Тооллогын товчооны мэдээнд, 2000 онд тойргууд болон тойргийн бүлгүүд нь дор хаяж нэг кв. миль газарт 1000 хүн ногдох шаардлагыг хангах, мөн түүний эргэн тойрны газар нутагт нэг кв. миль газарт 500 хүн ногдож байх; тухай дурджээ. Энэ шалгуурыг хангасан тохиолдолд дээрх газар нутгууд хотын нутаг дэвсгэрт хамаардаг. Тэнд, наанадаж 2500 хүн амтай сууринг хот гэж нэрлэх бөгөөд “хот маягийн суурин” гэж нэрлэгдээгүй бусад бүх газрыг “хөдөө” гэж тооцдог байна.
- Канад улсын хувьд Канадын Статистикийн газраас явуулсан 1996 оны тооллогоор “хот газар” (хотын бүс), “хотын нутаг дэвсгэр” (хотын бүс) гэдгийг дор хаяж 1000 хүн амтай, хүн амын нягтшил нь 1 кв. миль газарт 1000 хүн ногдож байхаар авч үзсэн байна.
- Мексикийн хувьд 2500 –гаас дээш хүн амтай ямар ч газрыг “том хот”, “хот маягийн суурин” /жижиг хот/ гэж ялган тооцдог. Гэхдээ Канадын адил хотын бүс гэдгийг дор хаяж 100 000 оршин суугчтай байх шалгуур баримталдаг.
- АНУ, Канад хоёр хүн амын тоо, нягтшил ... зэргийг үндэслэн тухайн суурингийн “хот мөн” болон “... биш” –ийг тодорхойлж байхад Мексикийн хувьд зөвхөн хүн амын тоог харгалзаж, тухайн суурингийн нийгэм, эдийн засгийн ямар ч шинж чанарыг авч үзээгүй орхисон байна.
- Солонгос Улс¹⁰⁴ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн 9 мужид хуваагдахын зэрэгцээ бие даасан орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлдэг 6 том хоттой. (Энд нь мэдээж хэрэг нийслэл Сөүл хот орно) Том хотын тоонд багтдаг Тэчжон ба Кванчжу 1 саяас дээш хүнтэй, Пусан 4 сая, Тэгу 2,5 сая, Инчхон 2,3 сая оршин суугчтай аж.

Солонгосын орон нутгийн удирдлагын тогтолцоо, ялангуяа нийслэлийнх нь засаглалын систем манай монголынхтой нэлээд төсөөлөг юм. Нийслэл (Сөүл) –ийн хуралд сонгогдсон төлөөлөгчид нь хуучин ажлаасаа бүрэн чөлөөлөгдөн “орон тоо” –гоор ажилладаг, давхар ажил алба эрхэлдэггүй. Тэд сонгуулийн бүрэн эрхийн хугацаандаа нийслэл хотынхоо аж амьдралын бүхий л асуудалд анхаарч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг байнгын байдлаар “авч явдаг” нь манайхаас ялгарах нэг томоохон онцлог юм. Энд зарим зүйлийг сонирхуулахад, Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч бүр хотын захиргаан дээрээ ажлын тусгай өрөөтэй, орон тооны туслахтай байдаг байна. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч сард 6 сая вонн (~6.000.000 төг.) цалинтай юм.

Эдүгээ, Солонгосын нийслэлийн удирдлага төрөлх хотоо дэлхийн шилдэг нийслэл болгох зорилт дэвшүүлэн, “Хүн төвтэй, халуун дулаан Сөүл” гэсэн уриатайгаар ажиллаж байна. Сөүлийн нутаг дэвсгэрийн хэмжээ 605.5 км² кв.м байгаа нь улсынхаа нийт газар нутгийн 0.6% –тай тэнцүү. Гэсэн ч, нийт хүн амын 25% нь нийслэл хотдоо төвлөрчээ. Сөүл 11 сая орчим оршин суугчтай Сөүл хот засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь дотроо 25 дүүрэг, 522 хороонд хуваагддаг.

Дашрамд тэмдэглэхэд, Сөүлийн мэр дороо 3 орлогчтой ... тус хотод нийт 16000 гаруй

¹⁰⁴ Энэ дэд гарчгийн агуулгыг Т. Навч, Л. Ариунболор (Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургууль) нарын хийсэн судалгааны материалд тулгуурлав.

төрийн албан хаагч ажилладаг. Солонгосын нийслэл төсвийнхөө ~25% –ийг байгаль орчны чиг баримжаатайгаар төлөвлөн зарцуулдаг ажээ.

* * *

Ер нь тухайн хот тосгоны өөрийнхөө хөгжлийг тэтгэх чадамжийг тухайн газарт хичнээн хүн аж төрж амьдарч байгаатай нь холбон авч үзэхээс өөр аргагүй. Өөрөөр хэлбэл хүний тоо гол шалгуур үзүүлэлт юм. Гэхдээ энэ хот тосгоны оршин суугчийн жишиг тоог монголынхоо нийт хүний тоотой харьцуулж процентлон, түүний доод хязгаарыг аль болохоор намсгаж авмаар санагдана. Ингэж байж л бид сая “цэвэр монгол тоо” бий болгоно.

Бүсийн төв 60000 –аас дээш хүнтэй байвал “нэн сайн”, төд байвал “сайн” ... төд байвал “дунд” гэх зэргээр дүгнэн үнэлгээжүүлж болно. Энэ нь эдийн засгийн бие даасан байдлаа бүрэн хадгалж чадна гэсэн эцсийн “жинхэнэ монгол итгэлцүүр” –ийг бодож гаргахад нэг өгөгдөл маягаар ашиглагдана. Ер нь, тусгай өөрийн гэсэн аргачлал боловсруулах нь мэргэжлийн хүмүүст тийм ч төвөгтэй биш ажилбар байх болов уу.

Мөн, монголын хотын дундаж жишээг орон нутгаар нэгбүрчлэн явж газар дээр нь очиж үзэж визуаль байдлаар тодорхойлох оролдлого хийх хэрэгтэй юм. Хэнтийн Бор–Өндөр бол монголын супер хотууд. Монголын дундаж тосгон дунджаар 10000 мянган хүнтэй байна гэдэг бол (төсөлд ийм тоо явж байгаа) манайдаа ахадсан үзүүлэлт болохоор байна. Төсвийн татаасгүйгээр амьдарч чадах тосгоноо “хот” гэж үзээд, үлдсэн хэсэг дээр нь нэмээд **сумын төв болгоныг тосгоноор тооцоод явах** нь хамгийн хялбар бөгөөд энгийн шулуун “аргачлал” гэж үзнэ.

Энэ бүхнээс болон бусад холбогдох мэдээ судалгаанаас үзэхэд, олон улсын хэмжээнд хотыг нэгмөр тодорхойлох [тийм нэг] **нэгдмэл цогц хэмжүүрт дэлхий нийтээрээ хараахан хүрч чадаагүй байна.** Тэгэхээр, бид заавал бусдыг дуурайх гэсний хэрэггүй мэт.

Иймээс ч орон бүр өөрийн үзэмжээр гол шалгуур хэмжигдэхүүнээ гаргаж хэрэгжүүлж хуульчилдаг гэж хэлж болно. Гэхдээ, 3 сая хүрэхгүй хүнтэй улс байж, тус тус 100000 шахам хүн нэг дор бөөгнөрсөн монголын хуруу дарам цөөн хэдэн хотын тэргүүн манлайлагчид (Дархан, Эрдэнэт) – ыг аймгийн төв дээрх “сум” гээд явж ... ярьж байгаа улс орон манайхаас өөр хаана ч үгүй болов уу.

* * *

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” гэсэн хэллэгийн талаар эргэцүүлъя. Энд, таслал тавин тоочсончлон “засаг захиргааны нэгж” ба “нутаг дэвсгэрийн нэгж” гэсэн 2 тусдаа ойлголт оршиж байна уу, аль эсвэл “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж”¹⁰⁵ гэсэн нэг л нэгжийн тухай яриад байна уу гэдэг нь сонин. Хуульч эрдэмтдийн эмхтгэж гаргасан Үндсэн хуулийн агуулгын талаархи судалгаа – хэрэглээний албан ёсны бус тайлбар сэлтэд, мөн энэ чиглэлээр гарсан бусад ном товхимолд бидний эрэлхийлж буй ялгааны талаар тодотгон өгүүлсэн нь ер үгүй.

Үндсэн хуульд “аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо нь засаг захиргааны нэгж” гээд тодорхой зааж өгсөн боловч, тэнд “нутаг дэвсгэрийн нэгж” –ийг тодорхойлоход хэрэг болохоор холбогдох бусад мэдээлэл бас хангалттай сайн тусч өгөөгүй юм. Энэ мэт нөхцөл

¹⁰⁵ Судлаач, удирдлагын магистр Д. Оюунтуяа “Нутгийн удирдлагын онол, практикийн асуудалд” өгүүлэлдээ ингэж томъёолсон байв. [“Нутгийн удирдлага” сэтгүүл, 2000, №1 (12)];

байдлаас үүдэн доорхи хэдэн санааг дурдаж байна. Үүнд:

- Засаг захиргааны нэгжид төрийн эрх мэдлийн зэрэгцээ хуулийн хүрээнд нутгийн удирдлагын эрх мэдэл хэрэгждэг, тэдгээрийг орон нутгийн удирдлага хэрэгжүүлдэг учраас “засаг захиргаа – нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага” гэж ярихад хүргэсэн бололтой.
- Үндсэн хууль ёсоор, нутаг дэвсгэр (л) засаг захиргааны нэгжид хуваагддаг тул “нутаг дэвсгэрийн (хуваагдмал тэр) нэгж” гэдэг нь чухамдаа яг үнэндээ бол “засаг захиргааны нэгж” –ийг хэлж буй хэрэг юм. Хэрэв ийм юм бол “засаг захиргаа, (таслалтай) нутаг дэвсгэрийн нэгж” гэх хэллэгийг “засаг захиргаа – (тиретэй) нутаг дэвсгэрийн нэгж” болгон бичиж хэвшүүлж заншууштай байна;
- Үндсэн хуулийн 59 –ийн 2, 60 –ын 1 дэх заалтууд нь засаг захиргааны алив нэгжид «нутгийн удирдлага» (local governance), «төрийн удирдлага» гэсэн хосмол гэхээсээ илүү зэрэгцээ функциональ үүрэгтэй 2 байгууллага заавал ажиллах ёстойг ахин дахин тодотгодог. «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага» –ын тухай Үндсэн хуулийн IV бүлгийн нэрийг хүртэл янзалж «Засаг захиргааны нэгж дэх төрийн ба нутгийн удирдлага» болгон өөрчилж, илүү товчхон бөгөөд ойлгомжтой гарчиг зүүмээр байна.

* * *

Дүгнэлт

1. Хот, тосгон гэдэг ойлголтыг монголын нийгэм – эдийн засгийн хөгжлийн бодит байдалд тохируулан зөв оновчтой тодорхойлж хараахан чадаагүй байгаагаас хот тосгоны үүсэл хөгжил, хил зааг болон удирдлага зохион байгуулалтын олон бэрхшээл дор дороосоо ундарч, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зохиомол бэрхшээл учирч байна. Иймд, **хот ба тосгоны талаар нэгдмэл зөв ойлголттой болох** нь зохиомол саад бэрхшээлийг даван туулах эхний алхам болохоор байна.
2. Хотжилтоос үүсч байгаа ялангуяа сөрөг талын асуудлуудыг шийдвэрлэхдээ монголын нийгмийн хотжилтын өнөөгийн бодит байдлыг судлах, ингэхдээ дэлхийн улс орны хотжилтын туршлага, түвшинтэй харьцуулах явдал чухал нь чухал. Гэхдээ, өөрийн орны өвөрмөц онцлогийг бодолцож гадаадын хэмжүүр жишигт тэргүүн зэргийн ач холбогдол өгмөөргүй байна. Их Мехико хот, жишээ нь, 19.2 сая хүнтэй, 58 дагуул хоттой ...
3. Монголын нийгмийн хотжилтын түвшин ямар байна гэдэгтэй үнэлгээний тогтсон нэг хэмжүүрийг уяж өгөх хэрэгтэй санагдана. Үнэлгээ, төлөвлөлтийн чанар нь түүнийг ямар аргаар яаж тооцоолсноос, түүнд ашигласан “хот газрын хүн ам” –ын бодит тоон үзүүлэлтээс юун түрүүнд шууд хамаарна. Иймээс юуны өмнө “хотын хүн ам” –ыг хэр зөв “тоолж тогтоох” асуудал нэн чухал юм. Хот тосгоны эрх зүйн асуудлыг ярихын тулд эхлээд улс даяархи хотын хүн амын нийт тоог зөв мэдэх хэрэгтэй.

Хэрэв ингэх боломжгүй байгаа бол Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дэх засаг захиргааны нэгжийн төвүүд (Нийслэлийн асуудал тусдаа хуультай) –ээ шууд “хот ба тосгон” –оор тооцож байх өөрийн өвөрмөц “аргачлал” –д шилжмээр байна. Тэгвэл, сумын төв болгон тосгон болно, аймгийн төв болгон хот болно. Хот ба тосгоны захирагч нь аймаг ба сумынхаа Засаг даргаар давхар ажиллана. Явж явж монголын онцлогтой энэ арга аж амьдралд арай илүү ойр тусах магадлалтай.

Аймгийн төв биш, бас сум биш ... үйлдвэр дагаж үүссэн дунд зэргийн хотуудыг

[тэгээд] хааш нь хийх вэ гэдэг асуудлыг шийдэх амаргүй. Гэхдээ шийдэж болно, янз бүрийн хувилбарууд бий.¹⁰⁶ Ямар ч байсан “Засаг захиргааны нэг нэгжийн нутаг дэвсгэр дээр засаг захиргааны өөр нэгж байлгахгүй” гэсэн зарчмыг тууштай баримтламаар байна. Ер нь хот болгоныг засаг захиргааны нэгжийн төв болгон өөрчлөх замаар тэдгээрийн эдийн засгийн чадамжийг нийгмийн тусын төлөө дүүрэн ашиглах нь чухал байна. Зарим газар, засаг захиргааны “сум” нэгжийн оронд, засаг захиргааны “хот” нэгж ажиллаж болно. Энэ тохиолдолд хот нь нэг дүүрэгтэй (сумын оронд), нэг дүүрэг нь дотроо мэдээж хороотой (багийн оронд) байна, харшлах зүйл үгүй мэт.

4. Хотын “орон нутгийн зэрэглэл” гэдгээс татгалзах хэрэгтэй. Энэ нь хэрэг дээрээ, хотыг хот гэж үзэхгүй байхад чиглэсэн бас нэг арга саам юм. Алсдаа завхарч гажуудах боломжтой, анхнаасаа их осолтой санаачилга байсан. Хаягдахгүй хэвээрээ яваад байна. Нэгэнт “орон нутгийн зэрэг” үгүй болоотохоор “улсын зэрэг” –ийн тухай ярих нь аяндаа өөрөө утгагүй болно. Нэг их ам бүлтэй, айхтар олон хоттой улс биш ... гадаадыг хамаагүй дуурайж боломгүй байна. Гадаадад чинь нэг хот нь дуусаагүй байхад нөгөө хот нь залгаад эхэлчихдэг. Тэдний зовлон биднийхээс их ялгаатай.

Хотыг ангилана гэдэг ерөөсөө гадуурхах шоовдорлох сэдэлтэй зарчмын бус үйлдэл юм. Ямар ч байсан тэгж харагдах боломжтой. Аймгуудаа бид дотор нь ангилдад, аль нэгийг нь ад шоо үзээд хамгийн сүүлд аваачаад жагсаачихвал ямар харагдах вэ!? Алслагдсан зарим аймгийнхан байгаль - орон зайн шалтгаантай хэн ч буруугүй зүйлд хүртэл “тэнцвэржилт” нэхээд, тэрнийх нь дагуу өнөөдөр шийдвэр гаргах дээд түвшиндээ “бүсийн нэмэгдэл” –ийн тухай ярьж төлөвлөж байна. Энэ бол нэг жишээ.

5. Хот тосгоны эрх зүйн байдлын шинэчилсэн найруулгыг төлөвлөсөний дагуу Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхдээ, асуудлыг Үндсэн хуулийн холбогдох бүлэг заалттай хамтатган авч үзэж шууд нэгмөр цогцоор нь шийдмээр байна. Монгол Улсын Үндсэн хуулийн IV бүлэг бүхэлдээ энд “саатуулагч механизм” –ыг үүрэг гүйцэтгэж байна; гэдэг талаас нь шийдвэр гаргах дээд түвшиндээ зориуд сайтар нягталж үзмээр болжээ.
6. Үндсэн хуульд холбогдох зохих өөрчлөлтийг оруулахгүйгээр, хот тосгоны эрх зүйн байдлыг шинэчлэн найруулах замаар ахинтаа нэг зохицуулах гэж оролдох нь дутуудсан, үр дүнгүй, цаг нөхцөөсөн шахуу алхам болох эрсдэлтэй байна. Хот тосгоны эрх зүйн байдлыг бид Үндсэн хуулийнхаа хүрээнд зохицуулсаар ... мухардсаар ирсэн гашуун 15 жилийн “арвин” их туршлагатай. Үүнийг цаашид хэвээр үргэжлүүлэх нь яавч зохимжтой бус.

[Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 128 дугаар тогтоолоор аймгийн төвүүдийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгосон. Дархан, Эрдэнэт хотын статус “улсын зэрэглэл” –ийн ангилалд хамаардаг. Тэгээд ч, “монголын хот, тосгон, түүний удирдлага ...” нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн биш, харин “... нэгж дэх” гэсэн статустай байхаар Үндсэн хуулийн үзэл баримтлалд заасан. Монгол Улс бол хотгүй улс биш, харин хот нь засаг захиргааны нэгждээ харъяалагддаг, төрийн удирдлагын тогтолцооны энгийн хуваарьтай, их цэгцтэй орон]¹⁰⁷ гэж хэт хялбаршуулан тайлбарлах нь үндсэндээ Үндсэн хуулийг өмөөрөх чиг зорилго бүхий ихээхэн эргэлзээтэй үг юм.

¹⁰⁶ УИХ –ын гишүүн С. Батболдын өмнө дурдсан ярилцлагаас;

¹⁰⁷ Ийм аргумент их гардаг тул зориуд энд онцлон тэмдэглэв.

7. Хэрэв, Үндсэн хуулийг өөрчлөхгүйгээр хот тосгоныхоо эрх зүйн асуудлыг шийднэ гэвэл, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхээсээ өмнө, Монгол Улсын Үндсэн хуулийн агуулгад орсон “нийслэл” гэдэг үгийн цаана “хот” гэсэн давхар утга суусан эсэхийг албан ёсоор тодруулах нь чухал байна.

Ингэхийн тулд Үндсэн хуулийн цэцэд “зарга мэдүүлж” нэхэмжлэл гаргах замаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг түүгээр “тайлбарлуулах” хэрэгтэй. Үндсэн хуулийг тайлбарлах эрх Дээд шүүхэд ... бүр Улсын Их Хуралд ч олгогдоогүй юм. Мөн, Үндсэн хуулийг Үндсэн хуулийн цэц ч тайлбарлах ёсгүй гэгцгээх байх. Гэвч, Үндсэн хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц “тойруу аргаар” буюу хэрэг маргаан үүсгэн хэлцэх шийдэх явцдаа “жинхэнээсээ шууд тайлбарладаг” юм. Цэцийн дүгнэлт эцсийн шийдвэр байдаг. Манай Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын нэг өвөрмөц онцлог бол энэ. Үүнийг, энэ боломжийг ашиглаад үзэхэд илүүдэхгүй.

Цэцийн дүгнэлт манай сонирхсон асуудлаар “нааштай” гарвал Үндсэн хуулиараа бид “хот” гэсэн засаг захиргааны нэгжтэй боллоо л гэсэн үг. Тэгсний дараа бол, Үндсэн хуультайгаа холбоотой органик асуудлуудаа зохих ёсоор нь нийцүүлж, дор бүр нь цэгцлээд явна. Саатуулагч механизмаас салах арга зам амар олдохгүй хүнд байна. Энэ чиглэлд янз бүрийн санаачилга өрнүүлж, хууль санаачлах хүртэл тууштай явах цаг болжээ.

Уг нь манай Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 –т, «нийслэл бол Улаанбаатар, Улаанбаатар бол хот мөн» гэсэн утга санаа дурайтал бичээстэй байгаа. Үнэхээр, Улаанбаатар бол хот юм. Энэ хотод “Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, монголд байгаа гадаад орны дипломат төлөөлөгчдийн газар байнга төвлөн оршдог”, зөвхөн үүгээрээ тэр бусад хотоос ялгаатай. Түүнийг бусдаас ялгаж нэрлэсэн гол шалтгаан нь ерөөсөө энэ. Нэрлэж дурдсан энэ хэдэн байгууллагыг ирээдүйн “жишиг хот Хар хэрэмт” рүү нүүлгэвэл “нийслэл” нэр нь мөн тийшээгээ “нисээд одно”. Гэлээ гээд Улаанбаатар хот маань сум аймаг болж хувирахгүй нь лавтай. Үндсэн хуулийн цэц “үг үсгийн төдийгүй ... үзэл санааны манаач” тул тухайн асуудлаархи түүний нааштай шийдэлд тодорхой хэмжээгээр найдах үндэс бий.

8. Хотжилт нь дэлхий нийтийн “үзэгдэл” учраас түүнийг төрийн бодлогоор зохицуулах, улсын болон бүс нутгийн хүрээнд хот, тосгон, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлын харилцан уялдсан тогтолцоо, эдийн засаг, нийгмийн зохистой цогцолборуудыг бүрдүүлэх, хот тосгоны засаг захиргааны нэгж болгох, нутаг дэвсгэрийн сүлжээнд хотуудын байр суурийг жинхэнэ ёсоор нь эзлүүлэх замаар тэдгээрийн хөгжлийг дэмжих явдал нь манай өнөөгийн засаг төрийн хойшлуулшгүй нэг зорилт болж байна.

Энэ зорилт хэрэгжсэнээр хотжилтыг дэмжих, хотыг хурдацтай бие даан хөгжүүлэх төрийн бодлого холбогдох олон хавсармал нөөцийн иж бүрэн судалгаа – тэнцэл дээр суурилж, ирээдүйн ерөнхий төлөвлөгөөтэй, өөрийнхөө хөгжлийг нөхцөлдүүлэх чадамжтай “жинхэнэ хот” –уудын хөгжин дэвжих боломж нээгдэнэ.

9. Үндсэн хуулийн өөрчлөлт, Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн концепци, Бүлэг суурингийн тогтолцоо ... хот газрын давуулаг чанарын талаар төрийн зүгээс иргэддээ мэдлэг чиглүүлэг байнга өгч нийгмийн хотжих үйл явцыг тодорхой хэмжээгээр “рекламдаж” нийгмийн сэтгэл зүйг эртнээс бэлтгэх ажил төдийлэн хийгдэхгүй байна. Хөдөөгийн иргэдэд засаг, захиргааны бүтцийг

ингэж тэгэж өөрчлөх нь ийм тийм ашиг тустай гэдгийг хэн ч очиж ойлгуулахгүй байна. Энэ байдал нь яг хуулиа батлаад, засаг захиргааныхаа нэгжүүдийг өөрчлөн зохион байгуулаад “хот тосгоноо зохих ёсоор” аваад явах гэхээр “манай сумыг татан буулгах гэлээ” гээд дуу дуугаа авалцсан гомдол тэмцэл өрнөх аюултай. Гадаадын жишгээр, тэдэнд **тодорхой хил хязгаар ба хугацааны дотор сайн дураараа нэгдэх** санал тавьсан ч болмоор байна.

10. “Аливаа орон гүрний нийт нутаг дэвсгэрийг төрийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд оруулахаар зохистой байдлаар хуваасаныг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гэдэг” гэж үздэг гэвэл, Монгол Улсын хот тосгон заавал бие даасан Засаг захиргааны нэгж байх нь нэн зохимжтой байна. Бидэнд хуучин туршлага бэлэн байна. Хагас зууны тэртээх 1960 оны Үндсэн хуулийн тавдугаар бүлгийн 46 дугаар зүйлд, “БНМАУ –ын нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, хот болж хуваагдана. Аймаг нь сумдад, хот нь районд ... тус тус хуваагдана” гэсэн байна. Шинэ юм гэдэг бол ихэнх тохиолдолд сайн мартагдсан хуучин зүйлийг хэлдэг гэдэг.

11. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бүхэлдээ [шинэ] Үндсэн хуулийн “алдаа дутагдал” –д хүлэгдсэн шинжтэй, тэр чинээгээрээ бүтээлч байж чадаагүй, үнэнийг хэлэхэд хот тосгоноо ч өөрийн гэсэн үндэсний жишиг хэмжүүрээр ангилж чадаагүй, тэгэхийг хүсээгүй ... ерөнхийдөө хүлээж авах боломжгүй “сулхан” баримт бичиг болжээ. Тийм ч учраас УИХ –аар хэлэлцэлгүй удсан бололтой байна. 1990 оны Үндсэн хуулийн IV бүлгийг “янзалтал” түүнийг санаачлагчид нь түр буцаах нь зөв болов уу.

Хавсралт 1.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

(1994.5.06, №36)

Зарим хот, хороодыг сумдад нэгтгэх тухай

Монгол Улсын Үндсэн хуульд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

а) Дор дурдсан хот, хороодыг засаг захиргааны хувьд дэргэдэх суманд нь нэгтгэн харьяалуулсугай. Үүнд (жишээл жишээлж дурдвал):

...

4. Дорноговь аймгийн Зүүнбаян (тухайн үеийн зарим тогтоолд “хот” гэж дурдсан байдаг) хороог татан буулгаж, мөн аймгийн Сайншанд суманд;
5. Дорноговь аймгийн Хажуу-Улаан хороо (уурхайн хот) -г татан буулгаж мөн аймгийн Иххэт суманд;
6. Дорнод аймгийн Эрээн хороо (үйлдвэрийн тосгон) -г татан буулгаж мөн аймгийн Баян-Уул суманд;
7. Завхан аймгийн Тосонцэнгэл хотыг Булнай суманд;
- ...
11. Сүхбаатар аймгийн Бүрэнцогт хороо (уурхайн тосгон) -г татан буулгаж мөн аймгийн Мөнххаан суманд;
12. Сэлэнгэ аймгийн Түнхэл хороог татан буулгаж мөн аймгийн Мандал суманд;

13. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа **хотыг** мөн аймгийн Мандал суманд;
 14. Хөвсгөл аймгийн Хатгал **хотыг** мөн аймгийн Алаг-Эрдэнэ суманд;
 15. Хэнтий аймгийн Бэрх хороо (уурхайн хот) -г татан буулгаж мөн аймгийн Батноров суманд;
 16. Хэнтий аймгийн Хэрлэн хороо (үйлдвэрийн хот Бор-Өндөрийг хэлж байна) –г татан буулгаж мөн аймгийн Дархан суманд;
- ... тус тус нэгтгэн харьяалуулжээ.

Дээрх тогтоол гарсантай холбогдож өмнөх олон шийдвэрүүд хүчингүй болсон. Үүнд, жишээлбэл:

...

5. “Тосонцэнгэл сумын төвийг хот болгох тухай” 1963 оны 4 дүгээр сарын 5 -ны өдрийн 81 дүгээр зарлиг;
- ...
8. “Налайх хотыг Улаанбаатар хотод харьяалуулах тухай” 1965 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 250 дугаар зарлиг;
- ...
10. “Зүүнбаян **хотын** зохион байгуулалтыг өөрчлөх тухай” 1971 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 49 дүгээр зарлиг;
- ...
16. “Хатгал хороог орон нутгийн хот болгох тухай” 1975 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлиг; ... г. м.

Ашигласан материал:

1. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, 23 хууд., ЗГ, 2006.12.20;
2. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль, УБ, 1993;
3. Монгол Улсын Үндсэн хууль, УБ, 1992;
4. “Нутгийн удирдлага” сэтгүүл, УБ, 2000. №01 (12);
5. Монгол Улсын Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, УБ, 1994;
6. Р. Бурмаа, “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал - иргэдийн оролцоо”, Судалгааны тайлан, 2001,
7. В. И. Васильев, Местное самоуправление, М., 1999;
8. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 1992, нэмэлт өөрчлөлтүүд;
9. Орон нутгийн удирдлагын хөгжил сан, Шведийн Ореброгийн Их сургууль, 2001, Орон нутгийн улс төрийн ёс зүйн асуудал судалгааны тайлан, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, “Монгол улсад төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг дээшлүүлэх нь II, 2001 - 2004” төсөл;
10. Монголын нутгийн удирдлагын холбоо, “Хурал, өөрөө удирдах ёс эмхэтгэл”, Улаанбаатар, 2002;
11. Н. Э. Шишкина, “Местное управление в зарубежных странах”, М., 1995;

12. Мэдээллийн холбогдох зарим сайтууд:

- http://www.irgen.mn/index.php?option=com_content&view=article&id=753&Itemid=45
- http://mauc.org.mn/index.php?option=com_content&task=blogcategory&id=59&Itemid=107 (Монголын хотуудын холбоо)
- Бусад;



ХОТ ТОСГОНЫ ТАЛААР БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АСУУДЛУУД, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Б. Ариунжаргал

Дэлхий нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байгаа асуудлын нэг нь хотжих үйл явц юм. НҮБ-аас хүн амын хэт төвлөрөл, хотжих үйл явцаас гарах сөрөг үр дагаварыг хязгаарлах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудлын хүрээнд XXI зуунд баримтлах стратеги чиглэлийг тодорхойлсон баримт бичгүүд гаргасан байна.

Дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт “том хотруу шилжин суурьших явдлыг багасгахын тулд аливаа улс орон хөдөөгийн амжиргааны нөхцөлийг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүс нутгийн төвүүд, дагуул хотуудын хөгжлийг дэмжихийг улс орнуудын засгийн газруудын үйл ажиллагааны тулгамдсан зорилт” гэж үзжээ. Мөн хүн амын суурьшлын асуудлаар 1996 онд Түркийн Стамбул хотод болсон НҮБ-ын II-р бага хурлаас нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангахад бүс нутгийн хөгжлийг тууштай хэрэгжүүлэхийг улс орнуудын Засгийн газар хүлээх үүрэг гэж тодорхойлсон байна.

Манай орны хувьд хот сууринд шилжих явц харьцангуй хурдацтай явагдаж, хүн амын 1/3 хувь нь нийслэл хотод төвлөрч үүний хэрээр томоохон хотуудын экологийн тэнцвэрт харьцаа алдагдаж, өөр бусад сөрөг олон асуудлууд гарах болсон зэргээс шалтгаалан хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоог боловсронгуй болгох, бүс нутгуудын тэнцвэртэй хөгжлийг хангах, хот суурингийн талаар төрийн бодлого, зохицуулалт шаардлагатай болсныг үндсэн дээр дараах баримт бичгүүдийг боловсруулан гаргасан байна.

Д/д	Нэр	Он	Хаанаас гаргасан
1.	• Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийг батлах тухай	1996 оны 5 дугаар сарын 20 -ны өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 32
2.	• Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай	2001 оны 6 дугаар сарын 14 -ний өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 57
3.	• Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах тухай	2002 оны 2 дугаар сарын 26-ны өдөр	ЗГ-ын тогтоол Дугаар 28
4.	• Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	2003 оны 06 дугаар сарын 12 -ны өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 24
5.	• Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай	2005 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 201
6.	• “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” батлах тухай	2008 оны 01 сарын 31 -ны өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 12

7.	• Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай	2005 оны 9 дүгээр сарын 28 -ны өдөр	ЗГ-ын тогтоол Дугаар 202
----	---	-------------------------------------	--------------------------

Хот хөдөөгийн хоорондын ялгааг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс авч үзсэнээр бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах нь байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгаж, хот хөдөөд амьдарч байгаагаас нь үл хамааран, адил тэгш боломжоор хангах шаардлагатай байгаа юм. Ингэхийн тулд орон зайн тэгш бус байдлыг арилгасанаар нийгэм, эдийн засгийг хөгжүүлж, орон нутагт хүний тогтвортой амьдрах нөхцөлийг хангах, ядуурлыг бууруулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх юм. Аливаа улс, тэр тусмаа суурин хэвшил эрт тогтсон орнууд түүхэн хөгжлийнхөө явцад нутаг дэвсгэрээ жигд тэнцвэртэй хөгжүүлэхэд янз бүрийн зохицуулалт хийж ирсэн байна. Өндөр хөгжилд хүрсэн орнуудын түүхэн туршлагаас үзэхэд олон жижиг нэгжээ нэгтгэн бүс нутгаар хөгжүүлэн иржээ. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин өнөөгийн түвшинд хүргэхэд хот, тосгоны хөгжилд ихээхэн анхаарал хандуулан ирсэн байна.

Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл¹⁰⁸ УИХ-ын 1996 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичиг юм. Энэ баримт бичигт “Үйлдвэрлэл, хэрэглэгчдийн байршил, дэд бүтцийн хөгжлийн түвшин, байгаль, газар зүйн онцлогийг харгалзан эдийн засгийн бүсчлэл тогтоож, бүс нутаг хоорондын тэгш бус байдлыг зохицуулахад чиглэсэн татвар, рентийн ялгавартай бодлого явуулна” гэсэн байна.

Эдийн засгийн бүсчлэлийн асуудалтай холбогдуулан нүүдлийн болон суурин амьдралын хоорондын харьцаа, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хоорондын уялдаа, суурин, хот орчмын хөдөө аж ахуйн хөгжил, хөдөөгийн дэд бүтцийн хөгжлийн асуудлуудыг цогцолбороор шийдвэрлэхээр тусгагджээ.

Монол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал¹⁰⁹ УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор “бүсүүдийн төв, Монгол Улсын хотуудын зэрэглэлийн асуудлыг судалж, тодорхой санал боловсруулан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, мөн бүсүүдийн төв, Монгол Улсын хотуудын зэрэглэлийн асуудлыг судалж, тодорхой санал боловсруулан “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамт Улсын Их Хурлын 2001 оны намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэх тухай заасан байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот - хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ үйл явцыг төрөөс нэгдсэн болон нутаг дэвсгэрийн ялгавартай бодлогоор дэмжих талаар зохицуулсан байна.

Хот, тосгоны зэрэглэл тогтоон, тэдгээрийн дотроос хөдөөгийн хүн амын амьдралыг бүс нутгийн дотоод, гадаад орчинтой дэд бүтцийн сүлжээгээр зохистой холбон зохион байгуулах боломжтой, ирээдүй сайтай байршсан хот, тосгоны бүсийн, сум дундын буюу бүлэг суурингийн төв болгон сонгон хөгжүүлэх нөхцөлийг харгалзсан дэд бүтэц, хот байгуулалтын хүчин зүйлсийн аргуудыг хослон хэрэглэнэ гэжээ.

- Бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх

¹⁰⁸ Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийг батлах тухай, 1996 оны УИХ-ын тогтоол Дугаар 32

¹⁰⁹ Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001, УИХ-ын тогтоол №57

төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгоно гэжээ.

- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд аймаг, нийслэл, хот, тосгоны хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг харгалзан Монгол Улсын хот, тосгоны зохистой хэмжээ, бүтцийн загварыг боловсруулж, хот, тосгоныг үе шаттайгаар сэргээн хөгжүүлэх;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагын дагуу бүсийн төв болгон хөгжүүлэх хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Эдийн засгийн бүсүүдийн хүрээнд хөгжлийн ирээдүй сайтай байрласан хот, тосгоны сүлжээнд үндэслэн Баруун бүсэд Ховд, Улиастайг; Хангайн бүсэд Хархорин, Эрдэнэтийг, төвийн бүсэд Дархан, Зуунмодыг, зүүн бүсэд Чойбалсан, Өндөрхааныг бүсийн хөгжлийн тулгуур төв хотоор тогтоож, тэдгээрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж эхлэх, бусад аймгийн төв хотуудыг орон нутгийн хөгжлийн төв хотын жишгээр хөгжүүлж, хөдөө орон нутагт сум дундын төвүүдийг үүсгэн байгуулах замаар зах зээл өргөжин хөгжих хот байгуулалтын таатай орчин бүрэлдэх эхлэлийг тавих.

гэх зэрэг хот тосгонтой холбоотой бодлого боловсруулсан боловч бүс нутгийн зарим хотууд нь аймгийн доторх хотод тооцогдож байгаа нь энэ бодлого бүрэн дүүрэн хэрэгжих боломжгүй болж байна. “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар улсын, аймгийн зэрэглэл зааж байгаа нь хотуудыг ялган үзэж, хөгжих боломжийг нь хааж байгаагийн нэг илрэл юм.

Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги

2003 оны 06 сарын 12-ны УИХ-ын 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегид үндэслэн бүс бүрийн хөгжлийн хөтөлбөрийг тухайн бүсэд багтах аймгуудын оролцоотой 2003 оноос эхлэн боловсруулж, холбогдох төсөл, арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган дэс дараатай хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

- Бүсүүдийг хооронд нь болон гадаад зах зээлтэй зохистой холбож чадахуйц хот байгуулалт, дэд бүтцийн тогтолцоог бүрдүүлэх, бүс бүрийн хүрээнд эдийн засгийг тэтгэх чадвартай хувийн хэвшлийн түшиц компани, хоршоо, хөгжлийн бүс нутгийг тогтоон хөгжүүлэх, бүс бүрийн хүрээнд орон нутгийн цогцолбор хөгжлийг тэтгэх эдийн засаг, санхүүгийн чадавхийг (дотоодын хуримтлалыг) бий болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх.
- Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, аймгийн төвүүд байрласан сумд болон бусад аймаг, сумдын хоорондын зохистой харьцаа, хамаарлыг тогтоох, бие дааж хөгжих чадвар султай сум, багуудыг зэргэлдээ сум, багтай нь хоршин нэгтгэж, орон нутгийн чадавхийг дээшлүүлэх,
- Бүсийн зөвлөлүүд, нутгийн удирдлагын байгууллагуудын харилцан дэмжлэгийг хөгжүүлэх замаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын харилцан уялдаа, эдийн засгийн нэгдмэл байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн эрэмбэ дараалсан арга хэмжээ авна.
- Хот, хөдөөгийн хүн амын бөөгнөрөл, шилжих хөдөлгөөний зохистой хүрээгээр эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа, мэдээлэл, ахуйн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, аймаг, сумд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг бүс дотроо шийдвэрлэх боломж нэмэгдэн, хүн амын амьжиргааны бүс нутгийн ялгаа аажмаар

буурах хандлага бий болох;

Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлснээр бүсийн хөгжилд ямар ахиц дэвшил гарахыг тодорхойлсон байна. Үүнд: бүсүүдийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, сум дундын төвүүдийн зах зээлд хөдөө нутгууд татагдан хөгжих зохистой хүрээ, чиглэл тодорч, үүнд түшиглэн тус улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн бүтэц, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн зарчимд ойртуулан боловсронгуй болгох эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдэж эхлэх

Олон жижиг хөгжлийн чадвар султай сум, багийг хооронд нь нэгтгэн томруулж хөгжүүлэх нь илүү үр дүнтэй талаар ард иргэдэд бүрэн дүүрэн ойлголт өгөөгүйгээс эсэргүүцэлтэй тулгарч байгаа. Бүсийн тулгуур төвийг түлхүү хөгжүүлснээр хөгжлийн түвшин жигдэрч эдийн засаг, нийгмийн амьдрал тогтворжих үндсэн нөхцөл бүрдэх бөгөөд орон нутгийн төр захиргааны үүрэг хариуцлага ихээхэн нэмэгдэж эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны харилцан уялдаа сайжирч, засаг захиргааны үүрэг давамгайлсан нутаг дэвсгэрийн бүтцээс эдийн засгийн утгад шилжих ухамсар төлөвшиж, татаасаас ангижрах сэтгэлгээ бий болж Засгийн газрын орон нутагтай харьцдаг харьцаанд зарчмын өөрчлөлт гарч ачаалал нь тодорхой хэмжээгээр багасч жигдрэх юм.

- Уул, тал, хээр, говь нутгийн хүн амын нутагшил, суурьшлын онцлог хэв шинжүүд, тэдгээрийн хоорондын уялдаа, хамаарлыг шинэчлэн тогтооход нутаг дэвсгэр, зохион байгуулалтын ажлыг чиглүүлж, энэ үндсэн дээр аймгийн төв, хөдөөгийн суурингийн харилцан уялдсан тогтолцоо бүрдүүлэх, Эрдэнэт, Хархориныг улсын болон бүсийн хөгжлийн тулгуур төвийн жишгээр хөгжүүлэхэд чиглэгдсэн бүсчлэл-хот байгуулалтын нэгдсэн бодлого явуулах
- Хангайн бүсийн хөгжлийн чадавхийг дэмжих төрийн зохицуулалт нь Эрдэнэт-Хархорин-Цэцэрлэгийн үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилтыг гүнзгийрүүлэх зарчимд үндэслэн аймаг, сум, хот, тосгоны хооронд аж ахуйн хоршилт холбоо, зах зээлийн харилцаа үүсэн хөгжих дэд бүтцийн орчныг сайжруулах, энэ үндсэн дээр бүсийн стратегид хандсан дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол, хүн амын хөдөлмөрийн идэвхижлийг өрнүүлэх эдийн засгийн дэмжлэгийн арга хөшүүрэг, нийгмийн шижим түлхэцүүдийг бий болгоход чиглэгдэх;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд говийн аймаг, сумдад хүн ам хоршин амьдрах “голомт” нутаг (ашиг шимт болон шилмэл өмгийн малын бэлчээр нутаг, баян бүрд, мод үржүүлгийн газар, аялал жуулчлалын бааз, уурхайн тосгон г.м)-ууд, тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн судлал, туршилтын төвүүдийг олшруулах, ирээдүй сайтай байрласан сум, аймгийн төвүүдийн хоорондын дэд бүтцийн уялдаа, хоршилтыг сайжруулах зэргээр хүн амын нутагшилт, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын одоогийн тогтолцоог боловсронгуй болгох алхам хийх;

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал

Энэ баримт бичигт тусгагдсан

1. хотжилт эрчимтэй хөгжих
2. хотжилт эрчимтэй бус буюу аж ахуйг хязгаарлагдмал чиглэлтэй хөгжүүлэх
3. хөдөө аж ахуйг тэргүүлэх чиглэлтэй хөгжүүлэх бүс

гэсэн хот байгуулалтын гурван бүсчлэлээр горимлож нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тасралтгүй үйл ажиллагааг явуулахаар төлөвлөж Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтын дагуу Улаанбаатарын бүс нутгийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн

чиглэл, улсын төвлөрсөн болон нийслэлийн төсөвт тусгах, гадаад, дотоодын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллах, нийслэлийн алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоныг эрчимтэй хөгжүүлэн хүн амын хэт төвлөрлийг үе шаттайгаар сааруулах чиглэл баримтлан ажиллах талаар зохицуулахаар заасан байна.

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого

2008 оны УИХ-ын 12 дугаар тогтоолоор баталсан. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх 6 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр зохицуулсны дотор бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана гэсэн бодлогын хүрээнд:

- Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулах;
- Татварын нэр төрөл, татвар ногдуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн, татварын орлогын болон эдийн засгийн өсөлтийн уялдаа холбоог хангаж, татварын ачааллыг зохистой түвшинд байлгах, татварын тогтолцоог боловсронгуй болгох;
- Улаанбаатар, Чойбалсан, Ховд хотуудад олон улсын нисэх буудал, Хархоринд шинэ нисэх буудал байгуулж, орон нутгийн нисэх буудлуудыг хатуу хучилттай зурвас, гэрэл, суултын системээр тоноглох;
- Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтыг эрчимжүүлнэ. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг дундаж хөгжилтэй орнуудын түвшинд хүргэнэ. “Хотууд” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ.
- Хүн амын нутагшилт, суурьшлын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, хот байгуулалтын эрх зүйн орчинг сайжруулж, хот төлөвлөлтийн норм, нормативыг боловсронгуй болгох
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын бодлогоор дэмжих
- Бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийг эхний шатанд тус бүр 50 мянгаас доошгүй хүн ам, цаашид тус бүр 100 мянга орчим хүн амтай хотууд болгон хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх
- Нийслэлийн хүн амын хэт бөөгнөрлийг задалж, дагуул хотууд болох Багануур, Налайх, Багахангайг хөгжүүлж, тэдгээрт зохистой төвлөрөл бий болгох;
- Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, томоохон орд газрыг түшиглэн дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хот, тосгодыг бий болгох;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгана.
- Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
- Бүс нутгуудын удирдлагын оновчтой тогтолцоо, бүтцийг бүрдүүлж ажиллуулах.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно.
- Ойр байршилтай сумдыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгтгэж томсгох

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай болгон хөгжүүлэх.
- Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх замаар төрийн албыг үе шаттайгаар цомхон чадварлаг болгож, зохистой хэмжээнд хүргэх;
- Тавантолгой, Оюутолгой зэрэг стратегийн томоохон орд газруудыг түшиглэн орчин үеийн шийдэл бүхий 10-20 мянган хүнтэй хотууд бий болох;

Швед, Герман зэрэг орны туршлагаас харахад орон нутаг, хот тосгоны бие даасан байдлыг хангахад дараах эрхүүд хэрэгжиж байж хангагдана гэсэн шалгуур үзүүлэлтүүд байдаг байна.

1. Төсөв санхүүгийн бүрэн эрх
2. Газар нутгийн бүрэн эрх
3. Төлөвлөлтийн бүрэн эрх
4. Зохион байгуулалтын бүрэн эрх
5. Боловсон хүчний бүрэн эрх
6. Дүрэм, журам, хэм хэмжээ тогтоох бүрэн эрх

Удирдлага төсөв санхүүгийн бүрэн эрхтэй байснаар бусад 5 эрхүүд хэрэгжих бүрэн боломжтой болдог байна. Санхүүгийн эрх мэдлийг олгож бие даасан тогтолцоонд шилжүүлээгүйгээс энэ цэцэг шиг болно гэж жишээлжээ.



Манай улс санхүүгээ төсөвлөдөг, төсвөө хэмнэхэд шагнал урамшуулал байхгүй, харин ч эсрэгээрээ хэмнэсэн тэр хэрээрээ дараа жил нь бага мөнгө төсөвлөгддөг нь төсвийг хэмнэх биш, харин ч ихээр төсөвлөх үрэлгэн хандлагыг бий болгодог. Татвар гэхэд улсын санд оруулаад эргээд төсөвлөж авдаг /зарим нэг татварыг орон нутгийн мэдэлд үлдээвэл яасан юм бэ?/ Татварын албаны даргаа гэхэд Засаг дарга нь сонгох эрх байдаггүй гэм мэт асуудлыг нэгдсэн удирдлагаар биш тус тусдаа удирдлагаар удирдаж байгаа нь орон нутаг, хот тосгоны хөгжилд ихээхэн нөлөөлж байгаа гэж бодож байна.

Төвлөрөөд байгаа бүх шатны байгууллагуудын эрх мэдлийг орон нутагт шилжүүлснээр өөрсдийн нийгэм эдийн засаг болон бусад асуудлаа шийдвэрлэж болох юм. Эдийн засгийн чөлөөт бүсийн талаар дараах тогтоол, баримт бичгүүд гарсан байна.

Д/д	Нэр	Он	Хаанаас
1.	Зарим тосгоныг хотод тооцох тухай	1994 оны 7 дугаар сарын 4-ний өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 58
2.	Н ийслэлийн зарим дүүргийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай	1995 оны 2 дугаар сарын 14-ний өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 23
3.	Алтанбулаг худалдааны чөлөөт бүс байгуулах тухай	2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 38
4.	Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн хилийн заагийг өөрчлөн батлах тухай	2003 оны 05 дугаар сарын 09-ний өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 15
5.	Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай	2003 оны 06 дугаар сарын 20-ний өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 34
6.	Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай	2004 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 28
7.	Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай	2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 36
8.	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба байгуулах тухай	2005 оны 6 дугаар сарын 15-ны өдөр	ЗГ-ын тогтоол Дугаар 134
9.	Цагааннуур худалдааны чөлөөт бүс байгуулах тухай	2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр	УИХ -ын тогтоол Дугаар 74
10.	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны орон тоо болон зардлын хязгаарыг шинэчлэн тогтоох тухай	2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 97
11.	“Замын-үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн талаар авах арга хэмжээний тухай	2008 оны 2 дугаар сарын 27-ны өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 73
12.	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай	2008 оны 6 дугаар сарын 3-ны өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 227
13.	Чөлөөт бүсийн зөвлөл байгуулах тухай	2009 оны 2 дугаар сарын 4-ний өдөр	ЗГ -ын тогтоол Дугаар 37

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд улсын хилийн шалган нэвтрүүлэх цогцолборуудыг ашиглалтанд оруулж, түүнд түшиглэн худалдаа, гаалийн чөлөөт бүс байгуулан үр ашигтай ажиллах дотоод, гадаад орчин нөхцөлийг бүрдүүлнэ гэсний хүрээнд 2002 онд “Алтанбулаг”/Сэлэнгэ/, 2003 онд “Замын - үүд” /Дорноговь/, “Цагааннуур” /Баян-Өлгий/ худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиуд батлагдан гарсан байна.

Чөлөөт бүсийн давуу тал нь:

- хилийн зааг бүхий нутагтай байна
- татварын хөнгөлөлттэй байна
- газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх
- худалдаа, нийтийн үйлчилгээний эрхэлж байгаа ААН-ийн газрын төлбөрөөс тодорхой хугацаанд чөлөөлөх гэх мэт хөнгөлөлт давуу талууд байгаа юм.

ДҮГНЭЛТ

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх асуудал нь орон нутгийг хөгжүүлэх гол асуудлын нэг болж байгаа билээ. Мөн одоогийн мөрдөгдөж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь зах зээлийн үеийн нийгэм, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын орчин үеийн шаардлага, эрх зүйн орчны хувьд зөрчилтэй байна. Үндсэн хуулийн /Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэгт “Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”/ нутгийн удирдлагын үндсэн зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэхэд тэр бүр нийцэхгүй байгаа юм.

Монгол Улс 340 сум, дүүрэгтэй. Түүний нэгжид 1600 гаруй баг, хороо байдаг. Аймгийн төвөөсөө 30 хүртэл км зайтай 22, 50 хүртэл км зайтай 20, хоорондоо 30 хүртэл км зайтай 24, 50 хүртэл км зайтай 72 сум байна. Эндээс үзвэл наад зах нь 138 сумыг бусадтай нь нэгтгэх шаардлага гарч байна. Нэг аймгийн Засаг даргын Тамгын газар 55-60 хүний орон тоотой. Ингэж хэт их жижгэрсэн, бие даан өөрснөө хөгжих боломжгүй удирдлага болон санхүүгийн чадваргүй байдал, үйлдвэрлэл, үйлчилгээ байхгүй гэх зэрэг өөр олон хүчин зүйлээс хамааран орон нутгаас хот сууринд шилжих хөдөлгөөн их болсон.

Энэ талаар Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод -ойр байршилтай сумдыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгтгэж томсгох, -Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно гэсэн нь ихэнх хөгжилтэй орнуудын туршлагаас үзвэл засаг захиргааны нэгжээ нэгтгэх нь зүйтэй болов уу.

Төсөв санхүүгийн хувьд төвөөс хараат, өмч хөрөнгө захиран зарцуулах эрх бага, татварын тогтолцоо буруу байгаа зэргээс хамааран /орон нутагт төсөв санхүүгийн бүрэн эрх байхгүй бол/ бусад эрх мэдэл хэрэгжихгүйгээр үл барам хоосон зүйл болж хөгжил дэвшилд хүрэхгүй. Түүнчлэн өөрснийхөө хүч бололцоогоор амьдрах сэтгэлгээ төлөвшдөггүй, идэвхи санаачлагагүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй хандлага бий болгодог. Төсөв санхүүгийн төвөөс хараат тогтолцоо нь орон нутагт ядуурал, ажилгүйдлийг нэмэгдүүлж, хөгжил дэвших боломжуудад саад болж байгаа гол асуудал юм. Иргэд өөрийн сууж буй газар орондоо өөрсдөө амьдрах орчинтой холбоотой асуудлыг өөрсдөө мэдэж шийдэж болохгүйгээр хөгжлийн тухай ярихад бэрхшээлтэй юм. Иймээс төсөв санхүүгийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай.




ХОТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

С. Дорждагва, Ц. Түвшинзаяа, Ш. Хишигсүрэн

Хотжилтын талаар ерөнхий тойм

Хотын талаар баримтлах олон улсын туршлагын талаар танилцуулахын өмнө хотжих процесс дэлхийн хэмжээнд ямар байгаа, энэ нь ямар нөлөөлөлтэй байдаг тухай товч дурьдах нь зүйтэй болов уу. Дэлхийн хүн ам хот руу нүүн суурьших явц ихээхэн хурдацтай явж байна. 1950 оны үеэс 21 дүгээр зуун хүртэл хүн амын тооны хувьд 4 дахин, нийт хүн амтай харьцуулсан хувиар бол 3 дахин нэмэгдсэн байх юм. 1950 онд нийт хүн амын 30 хүрэхгүй хувь буюу 0.7 тэрбум хүн амьдарч байсан бол 2000 он гэхэд энэ тоо 2.8 тэрбум болж нийт хүн амын 47 хувиас илүү болсон байх юм.

Зураг №1. Хотын хүн амын өсөлт¹¹⁰



Эндээс харахад хөгжиж байгаа улсуудад хотжих үйл явц өндөр байгаа ба 2010 он гэхэд хамгийн олон хүн амтай хотууд хөгжиж байгаа орнуудад бий болох төлөв харагдаж байгаа юм. Цаашид энэ үйл явц улам эрчимтэй явах ба 2025 он гэхэд улам өндөр түвшинд хүрч нийт 8 тэрбум хүн болно гэж үзээд үүний 5 тэрбум орчим нь хот суурин газар амьдрахаар төсөөлөгдөж байна¹¹¹.

Хот болон түүний орчны өөрчлөлтийн тухай тодорхойлолт улс орон бүрт өөр өөр байна. Ерөнхийдөө хотын нэгдсэн стандарт улс орон бүрт, тэр ч байтугай тухайн улсын хотуудад харилцан адилгүй байгааг улс орнуудын хотын хөгжил, туршлага, баримтлах бодлогоос харж болох юм. Өөрөөр хэлбэл, хотын стандартыг тухайн улс орнуудын улс төрийн тогтолцоо, эдийн засгийн бүтэц, соёл заншил, газар нутаг, цаг уур, хүн амын тоо гэх мэт

¹¹⁰ Urbanization and Global Change. University of Michigan. 2004

¹¹¹ Мөн тэнд

зүйлсээс шалтгаалж нэг улсын хоёр өөр хотод ч ижил стандарт барих боломжгүй гэж үздэг.

Зарим улс орнуудын хот суурин газар амьдарч байгаа иргэдийн хувь¹¹²:

Country	2002
Philippines	59%
Argentina	88%
Ecuador	63%
Mongolia	58%
China	39%

Тухайлбал, эдгээр улс орнуудаас Хятадын хотжих үйл явцыг жижиг тоогоор жишээ болгон үзүүлэе.

	2002	2020
Хотод амьдарч байгаа хүн амын тоо	Ойролцоогоор 500 сая (39%) (Нийт 1.3 тэрбум)	Ойролцоогоор 850 сая (55%) (Нийт 1.5 тэрбум)
1 саяас дээш хүн амтай хот	40	Ойролцоогоор 80
100.000-аас дээш хүн амтай хот	660	4000-аас илүү
5000-150.000 хүн амтай жижиг хот (town)	20.000	-

Эндээс харахад хотжих үйл явц Азийн улсуудад хамгийн эрчимтэй явж байгаа бөгөөд улс орнууд, Хотууд болон Нутгийн удирдлагын олон улсын байгууллагууд хотжилтын явцад байгаль орчин, экологийн асуудлууд, хүн амын амьдрах орчин, эрхийн хамгааллын чиглэлээр бодлогоо хандуулж ажиллаж байна.

Хотын талаар ойлголт

Олон улсын хэмжээнд хотуудад тавих нэгдсэн стандарт байхгүй ч ерөнхий зарчим, зүй тогтлыг анхаарахыг зөвлөдөг¹¹³ байна. “Хот” хэмээх ойлголтыг олон улсын түвшинд “Засаг захиргааны нэгж”, “муж” хэмээх ойлголтуудаас салангид авч үздэг. Энэ хоёр ойлголтын ялгааг харуулах үүднээс харьцуулахдаа “Зэрлэг амьтан”, “Тэжээвэр амьтан”-аар зүйрлэж үзэж болно. Хот бол “зэрлэг амьтан”. Эндээс зэрлэг амьтныг “Хот”-той харьцуулсан шинжийг авч үзвэл:

Зэрлэг амьтан	Хот
Хоол тэжээлээ өөрөө олж иддэг	Төсвөө бие даан өөрөө бүрдүүлдэг

¹¹² <http://www.unhabitat.org/stats/>
¹¹³ <http://www.unhabitat.org/> - Urban Management Programme

Үр хүүхдээ өөрөө тэжээж өсгөж удам угсаагаа үлдээдэг	Дэд бүтэц болон бусад барилга байгууламж, хотын “хэлбэр дүрс”-ээ өөрөө тодорхойлдог
Байгальд өөрөө бие даан амьдардаг	Төсөв, хөрөнгөө өөрөө зарцуулдаг
Байгальд өөрийн эзэмшил нутагтай	Бусдаас буюу Засгийн газар, Засаг захиргааны нэгжээс хараат бусаар бие даан хөгжих чадвартай байх

Дээр дурьдсан шинж чанарууд нь “Засаг Захиргааны нэгж”-ээс “Хот”-ын ялгарах гол онцлог нь байх болов уу. Өөрөөр хэлбэл, Хот бие даасан, төсвөө өөрөө бүрдүүлж оршин тогтнож чадаж байхын тулд

- Байнгын оршин суугч хүн ам нь бусад засаг захиргааны нэгжээс харьцангуй олон байх
- Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжиж, зөвхөн түүн дээрээ тулгуурлан оршин тогтнодог аж үйлдвэржсэн суурин газар байх. Анхандаа хотуудыг тодорхой нэг томоохон үйлдвэрийг дагаж байгуулж байсан бол орчин үед аль болох эдийн засгийн төрөлжүүлж аль нэг тодорхой салбараас хараат бусаар оршин тогтнох нөхцлийг хангахад анхаарах болсон.
- Аль нэг засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт оршиж төрөөс олгосон тодорхой эдэлбэр газартай байх

гэх мэт шинжүүдийг агуулсан байх хэрэгтэй юм.

Хотын байгаль орчны асуудал

Дээр дурьдсан байгаль орчин, экологийн хамгааллыг хангах, хүн амын эрүүл орчинд амьдрах нөхцлийг хангаж байхын тулд эдэлбэр газартаа хотын газар нутгийг үндсэн 3 хэсэгт хувааж үздэг.

1. Хөгжлийн идэвхтэй бүс: Энэ бол голлох үйлдвэрлэл, үйлчилгээний салбар болон хотын захиргаа гэх мэтээр төсвийг бүрдүүлэх гол эх үүсвэрүүдийг багтаасан хэсэг юм.
2. Хотын ногоон бүс. Энэ нь ногоон байгууламжаасаа тусдаа ойлголт ба тусгайлан тогтоосон амралт, соёлын бүс байдаг. Энд ямар нэгэн үйлдвэрлэл явуулахыг хориглох ба үйлчилгээний томоохон бүсийг бий болгосон байна.
3. Дагуул бүс. Энэ нь голчлон дагуул хот эсвэл орон сууцны хороолол гэх мэтээр тодорхойлогддог.

Аливаа суурин газрыг хот гэж үзэхийн тулд хүн амаар нь хамгийн түрүүнд ангилал тогтоодог. НҮБ-ийн тодорхойлсоноор 1990-ээд оны үед Хүн амын хувьд 20.000 хүнтэй бол жижиг хот (urban), 100.000-аас дээш хүн амтай бол хот (city) хэмээн үзэж байсан бол орчин үед жижиг хотыг 15.000 болгож буулгажээ. Хамгийн багадаа ийм хэмжээний хүн амтай байж л эдийн засаг, төсвийн хувьд бие даан оршин тогтнох боломжтой хэмээн үздэг. Энэ тооны хязгаар бол Монгол улсын хувьд хүн амын тоог хот суурийн газар амьдарч байгаа иргэдтэй харьцуулж үзэхэд тохиромжтой байж болох үзүүлэлт гэж судлаачийн зүгээс үзэж байна. Тоог багасгасны учир нь орчин үеийн техник, технологийн дэвшилтэй холбоотойгоор хотын оршин тогтнох аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг хүний хүчээр бус технологийн дэвшлээр цомхон хэмжээнд гүйцэтгэх боломжтой болсон гэж үзсэн байна. Харин АНУ-ын тодорхойлолтоор бол 50.000 хүн амтай бол хот гэсэн ангилалд оруулдаг байна.

Хотыг байгуулах, бий болгохын тулд үндсэн 3 шатыг дамжих, эсхүл энэ 3 ажлыг заавал

гүйцэтгэсэн байх ёстой гэж үздэг. Үүнд:

1. Хотын доорх инженерийн байгууламжийг бий болгосон байх. Хүний эрүүл, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлж аливаа байгалийн болоод нийгмийн эрсдэлээс хамгаалах бүхийл байгууламжийг бий болгох хэрэгтэй юм.
2. Газар дээрх дэд бүтцийг бий болгох. Мөн л хүний аюулгүй, тухтай, эрүүл орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд зориулсан авто зам, цахилгаан, шугам сүлжээ гэх мэтийг байгуулсан байх, тэр нь байгаль орчинд хортой нөлөөгүй байх
3. Дээрх ажлуудаа хийсний дараа хотоо байгуулах хэрэгтэй ажээ.

Дээр дурьдсан үе шат (үйл ажиллагааны дараалал)-аас харж байхад хамгийн ихээр анхаарч байгаа асуудал бол байгаль орчны хамгаалал болж байна. Хүн ам хэдий чинээ хот суурин газарт төвлөрч амьдарч эхэлнэ, төдий чинээ байгаль орчинд үзүүлэх хор нөлөөл их болдог. Ялангуяа, дэлхийн улс орнуудын хотжих процесс, хот суурин газрын үйлдвэржилт, хүн амын өсөлтөөс шалтгаалж сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал ихээр явагдаж байгааг олон улсын байгууллагууд цохон тэмдэглэж байгаа¹¹⁴.

Ийнхүү хотыг байгуулсаны дараах байгаль орчны асуудлууд тавигдаж байгаа ч хотыг өөрийг нь барьж байгуулахад тооцвол зохих байгаль орчны асуудал байдаг байна. Өөрөөр хэлбэл, хотод амьдарч байгаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд байгаль орчны нөлөөллөөс хамгаалахад дараах зүйлсийг харгалзаж үзэх юм. Үүнд:

- Усны нөөц
- Мөнх цэвдэг
- Газар хөдлөлтийн идэвхжил
- Байгалийн гэнэтийн үзэгдэлд өртөх магадлал

Эдгээр нөхцөл байдлыг Монгол орны хот, суурингуудыг авч үзэн үнэлэхэд нийт хот суурины 34.7 хувь нь тохиромжтой, 51.5 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой, 11.1 хувь нь тохиромжгүй гэсэн ангилалд багтаж байна¹¹⁵. Хязгаарлагдмал тохиромжтой гэсний учир нь дээрх шалгууруудыг бүрэн хангаж чадахгүй, аль нэг нь “зөрчилтэй” байгаа юм. Хотжилтын асуудал бол байгаль орчны асуудлын зэрэгцээ тухайн улс орны онцлогоос шалтгаалан бүсчилсэн хөгжлийн бодлоготой шууд холбоотой асуудал болох юм.

Хот байгуулалт нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбогдох нь

Хотжих процессыг үр дүнтэй үргэлжлүүлэхэд зайлшгүй холбогдох, хамтаар нь авч хэрэгжүүлэх нэгэн чухал арга хэмжээ бол бүсчилсэн хөгжлийн бодлогын асуудал юм. Дэлхийн улс орнуудын туршлагыг түүхэн талаас нь судлан авч үзэхэд бүсчилсэн хөгжлийн бодлогыг улс орноо бүхэлд нь буюу тодорхой хэсгийг сонгон авсан гэсэн 2 төрлөөр хөгжүүлсэн байх юм.

Манай улсын хувьд газар зүйн байрлал болоод хүн амын тоо, хөрш орнуудтай харилцах боломж, уламжлалт аж ахуй, соёл зэрэг хэд хэдэн чухал хүчин зүйлийг харгалзаж үзсэний үндсэн дээр улс орноо бүхэлд нь хамарсан байдлаар бүсчилж засаг захиргааны нэгжийн зэрэгцээ томоохон бие даасан хотуудыг бодлогоор дэмжин хөгжүүлэх шаардлага тулгарч байна гэж үзэж болно. Зарим эрдэмтэд “одоогийн нөхцөл байдлаас харахад эдийн

¹¹⁴ Дэлхийн дулаарлын талаар илтгэл, материалуудын бараг бүгдэд нь шахуу үүнийг гол шалтгаан хэмээн үзэж байгаа.

¹¹⁵ Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төслийн үндсэн шийдлийн тухай. Архитектор, Хот байгуулалтын газрын захирал Д.Сайн-Эр. 2001 он.

засгийн хөгжил зөвхөн төвийн бүсэд л тодорхой хэмжээнд бий болсон тул бусад бүсийг бүсчилсэн хөгжлийн бодлогын хэмжээнд хөгжүүлэх боломжгүй” хэмээн үзэх нь бий¹¹⁶. Үүнтэй санал нийлэх боломжгүй юм. Жигд хөгжүүлэх бодлого нь өөрөө үндэсний болоод нутаг дэвсгэрийн аюулгүй байдалтай шууд утгаараа холбогдох учиртай.

Улс орныг нийтэд нь хөгжүүлэх бодлогын талаар гадны туршлагаас харахад 1970-1980 оны үед бүсчлэн хөгжүүлэх ажил идэвхтэй хийгдэж эхэлсэн байна. Англи улсын 1980-аад оны үеийн эдийн засгийн бүсчлэлээс харахад¹¹⁷ нийт газар нутгийг бүсчилж хуваан тэдгээрийн дотор “хөгжлийн онцгой бүс”-ийг байгуулсан. Энэ мэтчилэн “хөгжлийн бүс”, “хөгжлийн дунд түвшний бүс” гэсэн түвшинд хувааж нийгэм-эдийн засаг, улс төрийн эрх олгож өгсөн нь 2000 оны түвшинд ирэхэд аяндаа эдийн засаг, хөгжлийн шалгуурын явцад шалгаран томоохон хотуудыг бий болгож чадсан байх юм.

Дэлхийн улс орнууд хотыг хөгжүүлэхийн тулд эхний ээлжинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, санхүүгийн бие даасан байдлыг бий болгох, бизнесийн орчинг нь сайжруулах, төлөвлөлт-удирдлагын бүтэц, механизмыг боловсронгуй болгоход голлон анхаарч байна.

Хотын хүн ам, хөгжлийн асуудал

Хотжих процесс нь хэдий байгаль орчинд халтай ч онолын хувьд нэгэн томоохон боломжийг олгодог гэж үздэг. Энэ бол хүн амыг ядуурлаас гаргах, амьдралын түвшинг дээшлүүлж жигдрүүлэх боломжийг олгодог асуудал юм. Хотыг зөв, анхнаас нь бодлогоо оновчтой тодорхойлж эдийн засгийг төрөлжүүлж чадвал энэ асуудлыг амархан шийдвэрлэх боломжтой юм. Үүний тулд дахин давтан тэмдэглэхэд хотын бие даан орших гол үндэс эдийн засгийн нөөц, бололцоогоо аль болох л сайн төрөлжүүлж, олон чиглэлээр хөгжүүлэх шаардлага юм. ядуурлыг хэдийгээр бүрэн шийдэх нь амьдрал дээр боломжгүй ч хотын хувьд байж болох хамгийн доод түвшинд хүргэх бүрэн боломжтой гэж үздэг.

Мянганы хөгжлийн зорилтод дэлхийн хүн ам хотжих явц эрчимтэй болж байгааг тэмдэглээд том хот руу шилжин суурьших явдлыг багасгахын тулд улс орнуудыг хөдөө орон нутгийн хөгжлийг сайжруулах, улс орноо жигд хөгжүүлэх, бүсчлэлийн бодлогыг хөгжүүлж ажил эрхлэлтийг нэмэгдүүлсэнээр орлогын ялгааг багасгах, бүс нутгийн төвүүд болон тэдгээрийн дагуул хотуудын хөгжлийг дэмжих нь улс орнуудын Засгийн газрын үйл ажиллагааны тулгамдсан зорилт болно хэмээн үзсэн¹¹⁸.

Хүн амын суурьшлын асуудлаар 1996 онд Стамбул хотод болсон НҮБ-ын 2 дугаар бага хурлаас нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангахад бүс нутгийн хөгжлийг тууштай хэрэгжүүлэхийг улс орнуудын Засгийн газруудын хүлээх үүрэг гэж тодорхойлсон байна. Монгол улс энэ асуудлыг Үндсэн хуулиндаа “Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, “Хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, амрах эрхтэй” хэмээн тодорхой зааж оруулсан бөгөөд энэ заалтыг тунхагийн шинжтэй болгохгүйн тулд бүсчилсэн хөгжлийн бодлогод анхаарлаа хандуулах нь төр засгийн үүрэг юм.

Олон улсын туршлагаас судалж үзэхэд Хотын хүн амын өсөлт нь төв рүү чиглэсэн нүүдэл, хүн амын өсөлт гэсэн үндсэн 2 шалтгаантай байдаг. Үүний хөдөөнөөс төв рүү чиглэсэн нүүдэл нь хотын хүн амд нэгэн шинэ давхрааг бий болгодог. Нүүдлийн шалтгаанаас

¹¹⁶ Монгол улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалт. Бага хурлын материал. 2001 он. Дэлхийн улс орнуудын бүсчилсэн хөгжлийн туршлагаас. Илтгэгч: Док. Л.Цэдэндамба

¹¹⁷ Мөн тэнд

¹¹⁸ UN-HABITAT's Strategy for the Implementation of the MDG.

хамгийн их жин дарах нь ядуурлын асуудал учир хотжих процесст ядуурал бол хамгийн хүндрэлтэй асуудал болж байна¹¹⁹. Үүнийг бий болгож байгаа “хурдасгах хүчин зүйл” нь их хэмжээний ажилгүйдэл, ажлын байрны дутагдал болж байдаг ба түүн лүү чиглэсэн “татах хүчин зүйл” нь ажилгүйдлийг бий болгож байгаа гол хүчин зүйл болох ажлын байранд тавигдах шаардлага, шилжин ирэгсэдийн мэргэжил, боловсрол, ур чадварын асуудал юм. Өөрөөр хэлбэл, энэ их нүүдэл бол ажилгүйдлээс эхлээд нийгэм, эдийн засгийн асар их “зарлага”-ыг бий болгодог.

АНУ –ын хотын хөгжлийн бодлогод баримталдаг нэгэн нийтлэг “уриа” бол Хот бол бидний хүрээлэн буй орчин, бидний эрүүл мэнд, бидний амьдралын чанар хэмээн тодорхойлдог байна. Хотжилт бол олон олон муу үр дагавартай хэдий ч түүнийг аль болох багасгах, үр нөлөөг нь арилгахын тулд дараах зарчмыг баримтлах хэрэгтэй хэмээн тодорхойлжээ.

- Нүүдлийг хязгаарлах, хотын газар нутаг болон сул орон зайг хамгаалах чиглэлээр хуульчлах
- Тээврийн үнэ өртөгөөс эхлээд амьдралын өртгийг бодлогоор өсгөх
- Татварын бодлого болон Засгийн газрын тусгай бодлогоор буцах нөхцлийг бий болгох. Буцсан тохиолдолд орон нутагтаа амьдрах боломжийг бий болгох
- Нэгэнт бий болсон хотын бүсдээ анхаарал татахуйц болон шинэ бизнес харилцааг бий болгох, гэмт хэрэг болон бусад хорт нөлөөг багасгах, сургууль олноор бий болгож хүрэлцээтэй болгосноор мэдлэг боловсрол, ур чадварыг нь дээшлүүлэх

Хятад, Тайвань, Япон, Солонгос, Туркийн хотжилтын туршлага

Хот суурин газар хөгжихийн хэрээр засаг захиргааны нэгж бүтцэд ч тодорхой өөрчлөлт гардаг гэж үздэг. Улс орнуудын хот байгуулах гол шалгуур нь хүн ам, нийгэм эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, ажлын байрны хангагдсан байдал зэрэг байдаг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу засаг захиргааны нэгжийн хуваарийг:

- Бүх улсыг муж, өөртөө засах орон, шууд харьяа хот болгон хуваана.
- Муж, өөртөө засах орныг өөртөө засах жоу, сияан, өөртөө засах сияан, хот болгон хуваана.
- Сияан, өөртөө засах сияанийг сум, үндэстний сум, балгас болгон хуваана.

Шууд харьяа хот ба их хотыг тойрог, сияан болгон хуваана. Өөртөө засах жоу-г сияан, өөртөө засах сияан, хот болгон хуваана. Өөртөө засах орон, өөртөө засах жоу өөртөө засах сияан бол цөм үндэстний өөртөө засах орон болно. Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь одоогийн байдлаар 4 /Бээжин, Тэнжинь, Шанхай, Жун Цин/ улсын зэрэглэлтэй хот, 23 муж, 5 өөртөө засах орон, 2 онцгой засаг захиргааны бүстэй. 1989 оны 12 дугаар сарын 26 -ны өдөр V хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны XII хуралдаанаас баталсан “БНХАУ-ын хот төлөвлөлтийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 5 саяаас хүн амтай хотыг их хот; 2 - 5 сая хүртэл хүн амтай хотыг дунд хот; 2 сая хүртэл хүн амтай хотыг бага хот гэнэ гэж тодорхойлсон байна.

Шууд харьяа 4 хотын хүн амын байдал:

- Бээжин хот: 16.800 км², 2007 оны байдлаар 16 сая 330 мянга орчим хүн амтай;

¹¹⁹ Urbanization and Global Change. University of Michigan. 2004

- Тяньжин хот: 11.900 км², 2005 оны байдлаар 10 сая 420 мянга орчим хүн амтай;
- Шанхай хот: 6340.5 км², 2007 оны байдлаар 18 сая 580 мянга орчим хүн амтай;
- Жун Цин хот: 82.300 км², 2006 оны байдлаар 31 сая 980 мянга орчим хүн амтай.

Тайвань /БНХУ/

Тайвань нь Пескадорын арлууд, Зиньмэнь, Мазу арлууд хамаарагддаг байна. Өнөөдрийн Тайвань нь 2 /Тайбэй, Гаошүнь/ шууд харьяа хоттой, Нийт хүн амын 59 хувь нь Тайвань арлын 4 том хот болох /Тайбэй, Гаошүнь, Тайжүнь, Тайнаны/ хотуудад төвлөрдөг бөгөөд хүн ам хамгийн шигүү суурьшсан хэсэг нь Тайбэй, удаах нь өмнөд хэсэгт орших Гаошүнь хот юм. 1988 оны 1 дүгээр сарын 25 -ны өдөр батлагдсан “Газар орны тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “... Улс төр, эдийн засаг болон соёлын ач холбогдол бүхий таван зуун мянгаас нэг сая хоёр зуун тавин мянга хүртэл хүн амтай бүсийг хот гэнэ.” гэж заажээ.

Япон Улс

Япон Улс нь засаг захиргааны өөрөө удирдах ёс бүхий 47 мужид хуваагддаг. 2005 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 2374 дүүрэг тосгон /740 дүүрэг, 1303 хотхон, 331 тосгон/ -оос бүрэлдэх бөгөөд сүүлийн жилүүдэд хот тосгод нэгдэх нь олширч байгаа юм байна. Токио хот 23 тусгай дүүрэгтэй. Япон Улсын нийт хүн ам 2007 оны байдлаар 127.433.494 юм байна. Эзэн хааны 22 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Нутгийн өөрөө удирдах удирдлагын тухай” хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу “...50.000 ба түүнээс дээш хүн амтай, барилга байгууламжийн 60 хувь нь төв хэсэгт байрласан, хүн амын 60 хувь нь аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг бүсийг хот гэнэ.” гэж заажээ.

Томоохон хотуудын хүн амын байдал:

2. Токио хотын хүн ам: 12 сая гаруй
3. Екохама хотын хүн ам: 3,555,473
4. Оосака хотын хүн ам: 2,624,129
5. Нагоя хотын хүн ам: 2,190,549
6. Саппоро хотын хүн ам: 1.854.837
7. Кообэ хотын хүн ам: 1.513.967
8. Киото хотын хүн ам: 1.466.163
9. Фүкүока хотын хүн ам: 1.325.611
10. Кавасаки хотын хүн ам: 1.290.426
11. Китакюүшү хотын хүн ам: 1.000.211

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын засаг захиргааны нэгж нь нийт 9 /Гёнги, Гангвөн, Чүнгбүг, Чүнгнам, Жөнбүг, Жөннам, Гёнбүг, Гённам, Жэжү/ муж, 6 бие даасан хот /Бүсан, Дайгү, Инчон, Гвангжү, Дайжон, Улсан/, 1 тусгай хот хамаруулдаг хот буюу нийслэл хот /Сөүл/, 68 хотод хуваагддаг. БНСУ-ын “Орон нутгийн өөртөө засах хууль”-нд “Өөртөө засах өрөтгөсөн нэгж” ба “Өөртөө засах үндсэн нэгж” гэж ангилдаг. Тус хуулийн 2.1 -т заасны дагуу 1-рт “Өөртөө засах өрөтгөсөн нэгж: Тусгай хот буюу нийслэл хот, өрөтгөсөн хот ба муж, өөртөө засах тусгай муж”, 2-рт “Өөртөө засах үндсэн нэгж: Хот, гүн, дүүрэг” ангилна. 1988 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр батлагдсан “Орон нутгийн өөртөө засах хууль”-ийн 7 дугаар зүйлд заасан

үндсэн нэг нөхцөл нь: Хот нь 50.000 ба түүнээс дээш хүн амтай байна.

Томоохон хотуудын хүн амын байдал:

- Сөүл хотын хүн ам: 10.3 сая орчим
- Бүсан хотын хүн ам: 3.65 сая
- Инчон хотын хүн ам: 2.63 сая
- Дайжон хотын хүн ам: 1.46 сая
- Гвангжү хотын хүн ам: 1.41 сая

Бүгд Найрамдах Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улс нь нэгдмэл, нутаг дэвсгэрийн хувьд зөвхөн засаг захиргааны хувьд хуваагддаг. Туркын Үндсэн хууль /цаашид “ТҮХ” гэх/-ийн 126 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Турк Улс нь төрийн удирдлагын хувьд газар зүйн байдал, эдийн засгийн нөхцөлд байдал болон төрийн үйлчилгээний шаардлагыг харгалзан мужуудад, муж нь бусад шатлалд хуваагддана гэж заасан байдаг. Нөгөө талаас ТҮХ-ийн 127 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Нутгийн удирдлага нь муж, нутгийн захиргаа /belediye/ эсхүл хөдөөний иргэдийн /kou halki/ орон нутгийн хамтын хэрэгцээг хангах үүднээс үүсгэн байгуулах үндсийг хуулиар тогтоон, шийдвэр гаргах нэгжийг мөн хуульд заана, сонгуулиар сонгогдсон нийтийн хуулийн этгээд юм. Нутгийн удирдлагыг үүсгэн байгуулах, чиг үүрэг, бүрэн эрхийг нутгийн өөрөө удирдах зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно гэж зохицуулсан байна.

БНТУ нь орчин үеийн удирдлагын тогтолцоонд тохируулан 2002 оноос эхлэн орон нутгийн удирдлагын шинэчлэлтэй холбоотой ажиллагааг эрчимтэй явуулж эхэлсэн бөгөөд үүний хүрээнд 2005 он хүртэл 5216 дугаартай Их хотын захиргааны хууль, 5302 дугаартай Мужийн тусгай удирдлагын тухай хууль, 5393 дугаартай Нутгийн захиргааны хууль, 5355 дугаартай Орон нутгийн удирдлагын нэгдлийн тухай хуулийг тус тус батлан гаргасан байна.

Бүгд Найрамдах Турк Улс засаг захиргааны нэгжийг 2005 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 5393 дугаар Нутгийн захиргааны хуулиар /Belediye Kanunu/, томоохон буюу улсын хэмжээний хотын эрх зүйн байдлыг 2004 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 5216 дугаар Их хотын захиргааны хуулиар /Вьюкшегир belediyesi kanunu/ тус тус зохицуулсан байна. 5393 дугаар Нутгийн захиргааны хуулиар нутгийн захиргаа гэж дүүргийн нутаг дэвсгэр дээр амьдарч иргэдийн орон нутгийн дундын шинжтэй хэрэгцээг хангах зорилгоор байгуулсан, шийдвэр гаргах байгууллагыг сонгогчдын саналаар сонгон бий болгосон захиргаа болон санхүүгийн хувьд өөрийн гэсэн автомат шинжтэй нийтийн хуулийн этгээдийг хэлнэ.

2006 оны байдлаар БНТУ-д 81 муж, 3225 нутгийн захиргаа, 34406 хөдөө байгаа бөгөөд мужийн тусгай удирдагч нутгийн захиргаа болон хөдөөний гишүүн нь болсон 1585 орон нутгийн удирдлагын нэгдэл байдаг. Нутгийн захиргаа гэж нэг хот эсхүл дүүргийн цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, ус, цахилгаан зэрэг хэрэгцээг болон үйлчилгээг үзүүлдэг байгууллага юм. Өөрөөр хэлбэл хүн ам нь тодорхой тооноос их газар байгуулсан нутгийн удирдлага юм. Хүн ам нь 5.000 болон түүнээс дээш тоотой суурин нэгжид нутгийн /орон нутгийн/ захиргаа байгуулж болно.

Муж болон орон нутгийн төвд орон нутгийн захиргаа байгуулах ёстой бөгөөд уух болон хэрэглээний усны сав газар, байгалийн цогцолбор газар болон бусад хамгаалалтын газар, өөр орон нутгийн захиргааны хилээс 5.000 метр ойр байгаа суурин газар нутгийн захиргаа байгуулж болохгүй. 5393 дугаар бүхий Нутгийн захиргааны хуулиар орон нутгийн захиргааг байгуулахтай холбоотойгоор хүн амыг нь хамгийн багадаа 5000 байх нөхцлийг тусгасан

байна. 2005 оноос хойш өнөөг хүртэл дахин шинээр нутгийн захиргаа үүсгэн байгуулаагүй байна.

Их хотын захиргааны хуулийн дагуу Их хотын захиргаа нь хамгийн багадаа 3 дүүрэг эсхүл анхан шатны нутгийн захиргааг агуулсан эдгээр нутгийн захиргааны өөр хоорондын зохицуулалтыг хангах, хуулиар өгсөн чиг үүрэг болон хариуцлагыг гүйцэтгэх, эрх мэдлийг хэрэгжүүлэх захиргааны болон санхүүгийн хувьд өөрийн гэсэн автомат шинжтэй, шийдвэр гаргах байгууллагыг нь сонгогчдын саналаар сонгож бий болгодог нийтийн хуулийн этгээдийг ойлгоно. Анхан шатны нутгийн захиргаа гэдэг нь Их хотын захиргааны нутаг дэвсгэрийн хилийн дотор дүүрэг байгуулахгүйгээр бий болгосон, дүүргийн захиргаатай адил эрх мэдэл, давуу эрх болон хариуцлагатай нутгийн захиргааг хэлнэ.

Нутгийн захиргааны нутаг дэвсгэрт, энэхүү нутаг дэвсгэрт хамгийн ихдээ 10.000 метр зайтай суурин газруудын сүүлчийн хүн амын тооллогоор нийт хүн ам нь 750.000-аас их болсон мужийн нутгийн захиргааг бодит /fiziki/ суурин байдал болон эдийн засгийн хөгжлийн түвшинг анхааран хуулиар Их хотын захиргаа болгож болно.

Д/д	Их хот	2007 оны тооллог	2008 оны тооллог
1.	Станбул	12.460.170	12.569.041
2.	Анкара	4.127.051	4.194.939
3.	Измир	3.139.745	3.210.465
4.	Бурса	1.760.022	1.819.470
5.	Адана	1.514.364	1.525.115
6.	Измит /Кожаэли/	1.346.092	1.392.733
7.	Газиантэп	1.209.499	1.252.329
8.	Коня	973.791	980.973
9.	Анталя	877.945	911.497
10.	Каесэри	872.211	884.663
11.	Мэрсин	801.318	814.615
12.	Диярбакир	778.343	799.447
13.	Эскишэхир	581.939	600.333
14.	Адапазар /Сакаря/	531.219	537.313
15.	Самсун	504.091	502.924
16.	Эрзурум	361.160	359.752

Орон нутгийн удирдлагын төрлөөр тоогоор	
Мужийн тусгай удирдлага	81
Нутгийн захиргаа	3225
Хөдөө	34406

Нутгийн захиргааны төрлөөр тархалт	
Вьуькшеһир Belediyesi Их хотын захиргаа	16
Вьуькшеһир İlçe Belediyesi Их хотын дүүргийн захиргаа	101
Вьуькшеһир İlk Kademe Belediyesi Их хотын анхан шатны нутгийн захиргаа	283
İl Belediyesi Мужийн хотын захиргаа	65
İlçe Belediyesi (Вьуькшеһир Sınırlarına Girenler Hariç) Дүүргийн захиргаа /Их хотын хилд орсноос бусад/	749
Belde Belediyesi Суурингийн захиргаа	2011
Toplam Нийт	3225

Нутгийн захиргааны хүн ам хувиар		
	Ньфус Miktarı*	(%)
• Belediye Sınırları İzindeki Ньфус Нутгийн захиргааны хилийн доторх хүн ам	57.474.289	78.76
• Belediye Sınırları Dışındaki Ньфус Нутгийн захиргааны хилээс гаднах хүн ам	15.499.668	21.24
• Türkiye Ньфусу (2006 Projeksiyonu) Туркийн хүн ам	72.973.957,00	100
Not: Bu ньфусlara вьуькшеһир belediye sınırları izine yeni giren kıyılar dahil değildir Энэхүү хүн амд Их хотын захиргааны хил дотор шинээр орсон хөдөөнийх хамаараагүй болно.		

Их хотын болон бусад нутгийн захиргааны хүн ам нийт нутгийн захиргааны хүн ам дахь хувь		
Вьуькшеһир ve Diğer Belediyelerin Toplam Belediye Ньфусу İzindeki Payı		
	Ньфусу	(%)
• Вьуькшеһир Их хот	25.843.995	44,97
Diğer бусад	31.631.384	55,03
Toplam Belediye Ньфусу (2000) Нийт нутгийн захиргааны хүн ам	57.475.379	100%
Not: Bu ньфусlara вьуькшеһир belediye sınırları izine yeni giren kıyılar dahil değildir Энэхүү хүн амд Их хотын захиргааны хил дотор шинээр орсон хөдөөнийх хамаараагүй болно.		
Хүн амын хувьд нутгийн захиргааны тархалт		

Хүн ам	Нутгийн захиргааны тоол	Тоо хувиар	Нийт хүн ам НьFUS TOPLAMI (2000)	Хүн ам хувиар НьFUSUN % ORANI
0-1999	354	10,98	594.624	0,75
2000-4999	1651	51,19	5.125.842	6,47
5000-9999	559	17,33	3.774.296	4,76
10.000-49.999	456	14,14	9.492.773	11,98
50.000-99.999	83	2,57	5.779.232	7,29
100.000-499.999	100	3,10	23.780.312	30,01
500.000+	22	0,68	30.700.302	38,74
Их хотын захиргаа /дээд хэсэгт /16/ ВьУЬКШЕҺІR BELEDİYELEРІ (ЫST GRUPTA(16))				
TOPLAM Нийт	3225	100,00	79.247.381	100,00
ВьУЬКШЕҺІR BELEDİYELEРІ Их хотын захиргаа	16		25.843.995	
TOPLAM Нийт			53.403.386	

* * *

Ашигласан материалын жагсаалт:

Эрх зүйн акт

1. БНХАУ-ын Үндсэн хууль /1982.12.04/
2. БНХАУ-ын хот төлөвлөлтийн хууль /1989.12.26/
3. БНХУ-ын газар орны тухай хууль /1988.01.25/
4. Япон Улсын нутгийн өөрөө удирдах удирдлагын тухай /эзэн хааны 22 оны 04.17/
5. БНСУ-ын орон нутгийн өөртөө засах хууль /1988.04.06/
6. Д.Сайнбилэг. Бүгд Найрамдах Солонгос Улсын улс төрийн тогтолцоо. УБ., 2008 он.

Вэб сайт

- www.wikipedia.org
- www.baidu.com



АЙМГИЙН ТӨВ - ХОТУУДЫН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТАЛААР*Д. Золбоо*

Өнөөгийн аймгийн төвүүдийн үүсэл нь 1600-аад оноос эхэлж, 1700-аад онуудад нэлээн өргөжин хүрээ, сүм хийд хурал номын газар, улмаар цэргийн хамгаалалт, худалдааны төв, XVIII-XIX зуунд улам бүр засаг захиргааны төв буюу суурин шинж чанартай болон хөгжиж ирсэн байна.

20-р зууны эхэн үе, 1920 - 1930 –аад онуудад байгалийн онцлогоос үүссэн өвөрмөц тогтоц бүхий газрууд, хүрээ хийд, цэргийн бэхлэлт өртөөний төв, голын гарам, жин тээврийн уулзвар гэх мэт их бага суурин газруудад анхны 13, удаах 5, шинэ 3 аймгийн төвүүд байгуулагдсан түүхтэй.

Аймгийн үүсэл, хөгжлийг аяндаа цэгцрэх системийн 3 төрөл үеээр авч үзвэл:

1. Үүсэх үе. Цэгцрэл яваандаа үүсэн гарч өөрийн өвөрмөц тогтоц бүхий бүхэл бүтэн шинэ систем бий болно. Ийм төрлийн үед системийг бүрдүүлж буй элементүүд хоорондоо харилцан үйлчлэлцсэний үр дүнд хувирах бөгөөд хөгжил хувьсалынхаа явцад хувирч бий болсон олон элементээс цөөн хэдийг сонголт хийнэ. Ийнхүү үзвэл, XVI-XIX зууны эхэн хүртэл манай улсын өргөн уудам нутгийн газар бүрд (байгалийн өвөрмөц тогтоц бүхий нутаг болгонд) 700 гаруй сүм хийд, хүрээ үүсэн их бага суурин бий болжээ.
2. Цэгцрэх үе. Оршин тогтнох гадаад, дотоод нөхцлөөс үүдэн гарах хүчин зүйлийн нөлөөгөөр цэгцрэлийн тодорхой түвшинг барьж байх, эсвэл өөр эмх цэгцэт системд шилжих явдал байдаг. Ийм системд түүнийг бүрдүүлэгч элементүүдийн хувьд цоо шинэ зүйл бий болдоггүй. Харин түүний тоо хэмжээ болон орон зай, цаг хугацааны хувьд өөрчлөлт бий болдог. Энэ мэт суурингийн хоорондын зай өртөөгөөр хэмжигдэн, хүн амын тоогоор засаг захиргааны анхдагч нэгжүүд зохион байгуулагдаж, аймгийн төв өөрсдийн суурьшлийг олж цэгцэрч байв. Энэ бол түүхэн 300-гаад жилийн хугацаа байв.
3. Боловсрох үе. Өнгөрсөн туршлагаа хуримтлуулж өөрөө хөгжих, улам боловсронгуй болдог эмх цэгцэт систем болох дэвшилт төрөл юм. Орон нутгийн засаг, захиргааны төв нь гэр, хурал нь нүүдлийн шинжтэй байсан нь 1930-аад оноос байнгын төв суурингийн агуулга төрхтэй болж, хүн ам нийгэм соёл эдийн засгийн төв болон өргөжив. Ийнхүү аймгийн төвүүд 1931 оноос суурин шинжтэй болох явц хурдасч, энэ нь эзгүй талд бус харин хуучин хүрээ, хийд, цэрэг худалдааны төвүүд байсан газарт төвхнөв.

Аяндаа цэгцрэх систем оршин тогтнохын мөн чанар нь үргэлж өөрчлөгдөх гадаад болон дотоод нөхцөлдөө байнга зохицож өнгөрүүлсэн туршлага, түүхэн зайлшгүй нөхцөлтэйгээ уялдан үргэлж боловсронгуй болох явц үргэлжилж байдаг оршино. 1930-иад оноос аймгийн төвүүд суурьшихдаа эхлээд 13 байсан нь өөрийн хөгжлийн явцад нутаг дэвсгэрийн хувьд томоохон аймгуудыг хуваах замаар 1937-1941 онуудад 5 аймаг нэмж шинээр үүсгэн байгуулж, хүн амд засаг төрийн үйлчилгээг хүргэх, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, зам тээврийн оновчтой зай, байрлал, байгаль экологийн онцлогыг тусган цэгцэржээ. Шинэ хот суурингийн агуулгатайгаар үүсээд 70 гаруй жил болж байгаа аймгийн төвүүд нь эдүгээ л өөрийн өнгө төрх, хөгжлийн гадаад дотоод нөхцлөөр улам боловсронгуй болох буюу хөлд орох үедээ явна¹²⁰.

¹²⁰ Г. Жаргал “Аймгийн төвүүдийн үүсэл ба фрактал шинж” Нийтлэл

Аймгууд болон аймгийн төв нь үүсэл хөгжлийнхөө үеийг туулаад тодорхой хугацааны дараа өнгө, төрх, хэлбэр, шинжээ олсны дараа хөгжлийн дараагийн түвшинд нэгдэн нийлэх, өөрөөсөө хот суурин үүсгэн хөгжүүлэх болно. Социализмын үед аймгийн төвүүд нь үйлдвэрлэл, үйлчилгээний томоохон төвүүд болж тэнд ажиллах хүчин төвлөрөх хандлага байсан боловч түүнийг захиргааны аргаар шийдвэрлэж байв. 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэнээр хүн амын шилжилт хөдөлгөөн эхэн үедээ хөдөөших хандлагатай байсан нь 1990-ээд оны сүүлчээр төв, суурин руу шилжих нь ихсэв.

Аймгийн төвүүд нь төр, нийгмийн болон зах зээлийн харилцаанд нийцсэн үйлчилгээний төвүүд болж, тэнд сүүлийн жилүүдэд хүн амын 1/4 хувь нь (570 мянга)¹²¹ суурьшин амьдарч байна. Ийнхүү нийгэм, эдийн засгийн хөгжил нь аймгийн төвүүдийг тус бүрдээ бие даасан үйл ажиллагаатай өөрийн төв болох үйл явцад түлхэц өгч байна. Синергиетикийн хуулиар “эхэн үедээ бие биеэсээ тусгаар бөгөөд үйл хөдлөл нь хоорондоо хамааралгүй байгаад дараа нь эдгээрийн хооронд шинэ холбоо бий болж болно”.

Зарим хотуудын өнөөгийн байдал**Дархан хот**

Дархан хот нь нийт 73,408 хүн амтай Монголын 2 дахь том хот хэрнээ Улаанбаатарын хүн амын 1/10-д ч хүрэхгүй. Дархан хот нь Монгол улсын төвийн бүсэд байрладаг бөгөөд нийслэл Улаанбаатараас хойшоо 236 км Дархан Уул аймгийн нутаг дэвсгэр дээр оршдог. Аймгийн 95 хувь нь Дархан хотод амьдардаг байна.

Бусад аймгийн төвүүдийн нэгэн адил Дархан нь хотын албан ёсны статусгүй. Иймээс ч татварын болон шийдвэр гаргах бүрэн эрх эдэлдэггүй байна. Хотын захирагч нь Аймгийн засаг дарга байх бөгөөд үүнээс гадна сумын засаг дарга бас байдаг бөгөөд энэ хүн нь засаг захиргааны тодорхой үүргийг ч мөн гүйцэтгэдэг. Үүрэг хариуцлага нь давхцаж хотын менежментийг хүндрүүлэх, өөрийн хязгаарлагдмал орлоготой аймаг болон төвлөрсөн төсвөөс хэт хараат байдаг.

Социализмын үед Дархан хот нь барилгын материалын үйлдвэрийн нийслэл байсан бөгөөд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ ЭЗХТЗ-ын орнууд болон ЗХУ ба түүний дагуул улсууд руу гаргадаг байсан. Монголд өрнөсөн байсан ардчилал зах зээлийн шилжилтийн үед барилгын материалын үйлдвэрүүд хувьчлагдан зээл тусламжинд хамрагдаж чадалгүй үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн. Дарханчууд одоог хүртэл өөрийн хотоо “Барилгын хот” хэмээн тооцдог хэдий ч барилгын салбар нийт ажиллах хүчний 6 хувийг эзэлдэг бөгөөд аймгийн ДНБ-ийн 8 хувийг эзлэж байна.

Шилжилтийн үеийн сорилыг даалгүй олон тооны үйлдвэрүүд хаагдахад хүрч хөдөлмөрийн зах зээл багасаж хажуугийн Хонгор сум болон Улаанбаатар хот руу шилжин явагсадын тоо нэмэгдсэн байна. Хотын хүн ам тогтвортойгоор жил бүр 3.2 хувиар өсөж байсан хэдий ч шилжин явагсадын тоо нэмэгдсэнээр 2003 онд шилжин ирэгсэдээс даруй 1,414 хүнээр их байлаа. Үлдэж буй мах, нэхий, мод, барилгын материал боловсруулах үйлдвэрүүд нь түүхий эдийн хангамж, зардал ихтэй хуучин технологиос шалтгаалан бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байсаар байна.

Эдгээр эдийн засгийн асуудлуудаас гадна ажил эрхлэлтийн болон хөдөлмөрийн насны хүн ам 71-73.3 хувиудыг эзэлж байна. Энэ нь улсын дундажаас ойролцоогоор 8 хувиар их байна. Тээвэр, санхүүгийн үйлчилгээ болон үл хөдлөх хөрөнгийн салбарууд сүүлийн хэдэн жилд ажил эрхлэлт нэмэгдсэн байхад ДНБ-нд хамгийн их хувь оруулж

¹²¹ Монгол Улсын Статистикийн этхтгэл 2008 он

буй салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа байна. (21 хувь).¹²² Дарханыг Улаанбаатар хотуудтай холбодог төмөр болон авто замууд нь дотоодын болон гадаадын зах зээлтэй холбодог. Мөн түүнчлэн хотыг тойроод үржил шимтэй газар их байдаг нь газар тариалан болон ХАА шйлдвэрлэлд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Дэд бүтэц нь хотын давуутай тал, мөн сул тал нь болж байна. Бусад аймгууд тэр тусмаа сумдуудтай харьцуулахад Дарханы дэд бүтэц сайн хөгжсөн. Орон сууцны хороололд амьдардаг оршин суугчид (нийт хүн амын 62 хувь) хамгийн наад захын үйлчилгээ буюу цэвэр бохир ус, халаалт болон хатуу хог хаягдал зайлуулах зэрэг үйлчилгээнд хамрагддаг. Мөн Шинэ, Хуучин Дарханы хооронд ихээхэн хэмжээний инженерийн шугам сүлжээтэй газар байгаа нь шинэ барилгажилт үүсгэх боломжийг бий болгож байгаа юм. Гэсэн хэдий ч хот баригдсан цагаасаа дэд бүтцийн гол шугамуудаа засах сайжруулах ажил нэг их хийгдээгүй байна.

Шугамууд муудсаны улмаас усны алдагдалын хэмжээ 30 хувь хүрсэнээс 2004 онд НААҮГ алдагдалтай ажилласан байна. Цэвэрлэх байгууламж хүчин чадлынхаа 60-70 хувийг нь ашиглаж байна. Дулаан хангамж барилгажсан хэсгийн өнөөгийн хэрэгцээг хангаж байгаа ч хүн амын 30 хувь амьдардаг гэр хорооллолдог очдоггүй. Гэр хорооллолдог эрчим хүч, бохир ус болон хатуу хог хаягдал цуглуулах үйлчилгээ дутагдалтай. Тэд ундны усаа 30 ус түгээх газраас авдаг тэдгээр нь усаа машинаар татдаг байна. Гэр хорооллын оршин суугчид орон сууцныхаас хэд дахин үнэтэй ус хэрэглэдэг. Ядуурал гэр хороололд ихээхэн төвлөрсөн байна. Дарханы 2,000 (нийт өрхийн 12.5%) өрх амьжаргааны доод түвшин буюу 20,600 төг (Хангайн бүсийн хувьд)-өөс доогуур амьдарч байгаа бөгөөд 1,875 буюу 94 хувь нь гэр хороололд амьдардаг.

Чойбалсан хот

Чойбалсан хот одоогийн байдлаар 36142 хүн амтай бөгөөд Монголын дөрөв дэх томоохон хот юм. Анх 1938 онд Баянтүмэн хот нэртэйгээр байгуулагдан, 1941 оноос Чойбалсан хот хэмээн нэрлэх болсон ба ОХУ, БНХАУ-тай хиллэх Дорнод аймгийн төв нь Нийслэл Улаанбаатар хотоос зүүн тийш 656 км алс оршиж байна. Зүүн бүс нь хоёр тулгуур төв хоттой нэг нь Чойбалсан хот юм. Хотын хүн ам нь Дорнод аймгийн хүн амын 50,0 орчим хувийг эзэлдэг. Улсын хилд ойр байрлалтай, ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог нь гадаад харилцааг хөгжүүлэх давуу талтай.

Чойбалсан хот дотоодын агаарын тээвэртэй, нисэх онгоцны буудал нь хуучин Оросын цэргийн нисэх онгоцны буудал байсан газарт шилжин байрласан ба Улаанбаатар хот руу долоо хоногт 2-3 удаагийн нислэг хийхээр төлөвлөгдөж байна. Дорнод аймаг нийт 2563 км замтайн 60 км нь Чойбалсан хот ба хот орчмын бүсэд ашиглагддаг. Аймгийн дотоодод 370 орчим км төмөр зам Ази, Европын орнуудтай шууд холбогддог. “Түмэн голын бүс” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-ын Аршаантын чиглэлд Баянтүмэн өртөөнөөс төмөр зам тавьж холбох урьдчилсан судалгааны ажлууд хийгдээд байна.

Социалист нийгмийн тогтолцооны үед Чойбалсан хот нь Дорнод бүсийн хөгжлийн төв, ашигт малтмалын үйлдвэрүүдийн зангилаа хот байлаа. Хүн амынх нь 10,0 гаруй хувийг орос болон бусад гадаадын иргэд эзэлдэг 50,0 гаруй мянган хүн амтай хот байв. Энэ үеэс хойш Чойбалсан хотын хүн амын өсөлт буурсны зэрэгцээ ажилгүйдэл, ядуурлын хэмжээ нэмэгдсэн байна. 1995 оноос хойш шилжин ирж байгаа хүн амын тоо нэмэгдэж байгаа боловч шилжин явалт буураагүй, шилжин явагсад ба шилжин ирэгсдийн харьцаа 2:1 байна. 2003 оны байдлаар хотын нийт өрхийн бараг 44 хувь

¹²² Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ) мэдээлэл хот, сумын түвшинд гардаггүй байна.

буюу 3868 өрх, 16,7 мянган хүн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой байна.

Өнөөдрийн байдлаар Дорнод аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд¹²³ Боловсруулах үйлдвэр, уул уурхайн салбарын үйлдвэрлэл дөнгөж 1,3 хувийг эзэлж байхад бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 21,3 хувийг бүрдүүлж байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад ихээхэн өндөр үзүүлэлт юм. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2004 оны байдлаар 400271 төгрөг байгаа нь Монгол улсын хэмжээнд дээгүүр байранд орж байна. Хотын хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарын борлуулалт өсчээ.

Чойбалсан хотын дэд бүтэц бусад хотуудтай харьцуулахад хотын өргөжин тэлэх нөхцөлийг хангахуйц харьцангуй хөгжилтэй. Гэвч улсаас дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулах асуудалд орон нутаг ямар нэгэн эрх мэдэлгүй, хотын захирагчийн эрх, үүрэг, байнга санхүүгийн үйл ажиллагааг шаардаж байдаг хотын хөгжлийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргын шийдвэрээр хөдөлдөг илүү шат дамжлага нь хотын хөгжлийг сааруулж, хотын эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд зогссон, эрчим хүч, дэд бүтцийн хангамжийн хүчин чадлын илүүдлээс харагдаж байна.

Хотын нийт хүн амын 55 хувь нь гэр хороололд суудаг нь бусад аймаг, хотуудтай харьцуулахад харьцангуй бага буюу эерэг үзүүлэлт юм. Дулааны цахилгаан станц 1982 онд өргөтгөгдсөн ба цаашид засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа юм. Төв цэвэрлэх байгууламж нь зохиомол биологийн цэвэрлэгээтэй ба хоногт 10000 м³ ус цэвэрлэх хүчин чадалтай ба цэвэрлэгээний түвшин 2003 оны 12 дугаар сарын байдлаар 44 хувьтай байна.

Ховд хот

Улаанбаатар хотоос 1425 км зайд оршдог тус хот нь 1762 онд анх үүсч байгуулагдсан. Одоо 30479 хүн амтай, засаг захиргааны 12 багтай бөгөөд аймгийн нийт хүн амын 33,4 хувь нь оршин суудаг байна. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Ховд хот Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв хот болсон билээ. 1992 онд орон нутгийн төв хотуудыг сумын зохион байгуулалтад шилжүүлсний дагуу Ховд хот нь “Жаргалант сум” хэмээн өөрчлөгдсөн. Хотын албан ёсны статусгүй болсон цагаас эхлэн хот байгуулалтын удирдлага зохион байгуулалт, орлого нэмэгдүүлэх болон хотын дэд бүтцийг сайжруулахад зориулагдсан хөрөнгө оруулалт багассан байна.

Ховд аймаг нь олон ястан, үндэстний соёл уламжлалтай бөгөөд нийт 17 үндэстэн ястны өлгий нутаг юм. Ховд аймгийн хүн амын 27.5 хувь халх, 24.9 хувь захчин, 11.5 хувь казах, 8.1 хувь торгууд, 7.6 хувь урианхай, 7.5 хувь өөлд, 6.0 хувь дөрвөд үндэстэн ястнуудаас бүрддэг. Эдгээр бүлэг бүр өөр өөрсдийн уламжлал, амьдралын хэв маягаараа ялгаатай бөгөөд орон сууц, хорооллууд нь бас ялгаатай байдаг байна.

Социалист засаглалын үед Ховд хот Баруун бүсийг барилгын зарим нэр төрлийн материалаар хангаж байсан боловч одоо энэ чиглэлээр нэг л үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Гэвч хөнгөн, хүнсний болон барилгын материалын салбарын үйлдвэрлэл өсөх хандлагатай. Үүнтэй зэрэгцээд барилгын гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой өсөж ирсэн байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 67 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлдэг нь хотын эдийн засаг хүчтэй байж чадахгүй

¹²³ Дотоодын нийт бүтээгдэхүүнийг сум, хотоор гаргадаггүй.

байгааг харуулж байна.

Ховд-Улаанбаатар хотын чиглэлд агаарын тээвэртэй, хотын нисэх онгоцны буудал нь олон улсын томоохон хэмжээний нислэг хүлээн авах шаардлагад нийцдэг. Улаанбаатар хот болон Увс, Баян-Өлгий аймгуудтай шороон замаар холбогдсон. Ховд аймаг ОХУ, БНХАУ болон Казахстан улстай шууд хиллэдэг нь байршлын хувьд давуу талтай. Гэвч эдгээр хөрш зэргэлдээ улсуудтай эдийн засгийн хувьд харилцаа багатай. Хилийн боомт нь жилд зөвхөн 4 удаа нээгддэг.

Ховд хотын инженерийн шугам сүлжээ, байгууламж ихээхэн элэгдэж хуучирсан нь хотын хүн амын наад захын хэрэглээг хангаж чадахгүй байна. Ховд хот нь усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системтэй. Гэвч энэ үйлчилгээг 2003 оны байдлаар нийт хүн амынх нь 10.7 хувь нь л авч байна. Дулааны станц нь 1986 онд анх байгуулагдсан цагаасаа хойш их засварт ороогүй тул шугамууд нь хуучирч эвдэрснээс болж байнга тасалдах, түр зогсох явдлууд гарсаар байдаг. Ховд хот одоогоор ОХУ-аас эрчим хүчээр хангагддаг, гадны улсын хараат эрчим хүчний эх үүсвэртэй юм. Энэ байдал нь 2007 онд Дөргөний усан цахилгаан станц ашиглалтанд орсноор шийдэгдэж, өөрийн эрчим хүчний эх үүсвэртэй болох юм.

Эрдэнэт хот

Эрдэнэт овооны зэс молибдений орд газрыг түшиглэн "Монгол Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр"-ийг 1975 онд барихад аж үйлдвэрийн шинэ төв болон Эрдэнэт хот байгуулагдаж улс орны эдийн засгийн хөгжлийн нэг тулгуур нь болж хөгжиж ирсэн. 2004 оны байдлаар Эрдэнэт хотод 19266 өрхийн 78882 хүн амьдарч байгаа нь улсын хүн амын 3.2%, аймгийн хүн амын 96.2%-г эзлэж байна. Эрдэнэт хот байгуулагдсанаасаа хойш 25 жилийн хугацаанд хотын хүн ам жилд дунджаар 4.0 орчим хувиар өсчээ. Гэсэн хэдий ч Эрдэнэт хот Улаанбаатар руу уугуул иргэдээ алдаж байгаа нь сүүлийн гурван жилийн үзүүлэлтээр шилжин явагсад шилжин ирэгсэдээсээ илүү байгаагаас харагдаж байгаа юм.

Орхон буюу голчлон Эрдэнэт хотын хүн ам, талбайг агуулсан аймаг улсын нийт бүтээгдэхүүний 20.7 хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 8.6 хувийг үйлдвэрлэж, 33.3 хувийн борлуулалт хийдэг байна. Уурхайн орлогоос шалтгаалан нэг хүнд ноогдох ДНБ 3 тэрбум гаруй төгрөг болж байгаа нь улсын дундажаас хамаагүй өндөр байна. УБҮ-т хотын нийт ажиллах хүчний 19 хувь ажилладаг ба шинээр ажлын байр бий болгохоосоо илүү багасгах цомхотгох хандлага байгаа хэдий ч хотод сүүлийн гурван жилд 6661 ажлын байр шинээр бий болсон байна. 5000 гаруй иргэд зуучлах байгууллагын тусламжтай ажилтай болсон байна.

Бүртгэгдсэн ажилгүйдлийн тоо 2000-2003 оны хооронд 11.6-аас 6.6 хувь хүртэл буурсан үзүүлэлт байдаг. Өнөөдрийн байдлаар 1000 гаруй үйлдвэр, бөөний төв, хүнсний болон барааны захууд дэлгүүрүүд болон бусад төрлийн ААНБ үйл ажиллагаагаа явуулж байна. Эрдэнэт хот нь дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар болон Дархан хотуудтай төмөр зам болон хатуу хучилттай замаар холбогдсон бөгөөд Булган, Хөвсгөлийн чиглэлд 153,5 км хар зам тавигдах эхний ажлууд хийгдээд байна.

Хүн амын 71.0 орчим хувь буюу 56.12 мянган хүн инженерийн бүрэн хангамжтай нийтийн орон сууцанд амьдарч байна. Дэд бүтцийн хувьд бусад аймгийн төвүүд болон сумдаас харьцангуй сайн хөгжсөн боловч засвар үйлчилгээний ажилд хөрөнгө төдийлөн төсөвлөгддөггүйгээс шугам сүлжээний ашиглалтын байдал муу байгаа.

УБҮ-ийн орлогын нөлөөгөөр Эрдэнэт хот амжиргааны хувьд харьцангуй чинээлэг ба бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад орон нутгийн төсөв урсгал зардлаа хангалттай

нөхөх бололцоотой, гэхдээ аймгийн төв учраас дэд бүтэц инженерийн шугам сүлжээг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт хийх эрх мэдэл нь бага байдаг.

Эрдэнэтийн хувьд цэвэр усны хангамж бусад хотуудыг бодвол илүү хүндрэлтэй. Учир нь хотын усыг УБҮ хангадаг ба үнэ нь улсын дундажаас 2 дахин өндөр байдаг байна. Цэвэрлэх байгууламж өөрийн төлөвлөгөөт хүчин чадлаас 1.25 дахин илүү ачаалалттай ажилладаг бөгөөд шугамууд нь хуучирч муудсанаас үйл ажиллагаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлдөг болсон. Хүн амын 29 хувь нь гэр хороололд оршин суудаг. Гэр хорооллын оршин суугчдын ундны цэвэр усыг ус зөөврийн 4 автомашинаар 33 ус түгээх байранд түгээж хангадаг байна. Гэр хороололд төвлөрсөн усан хангамж болон ариутгах татуургын систем байдаггүй, хог зайлуулах үйлчилгээ хангалттай хийгддэггүй байна. 2002-2003 онд гэр хорооллын иргэдийн усны хэрэглээ 10 орчим хувиар нэмэгдсэн байна.

Цэцэрлэг хот

Цэцэрлэг хотын суурийг анх XVI зууны сүүлчээр Өвөрхангай аймагт орших эртний нэрт Эрдэнэ зуу хийдийг сэргээн засварлахаар ирсэн Францын уран барилгачдын байгуулсан жижиг сүмийн барилгад түшиглэн тавьсан. 1922 онд энэ хотыг Цэцэрлэг хот гэж нэрлэх болсон. Цэцэрлэг хот нь Монгол улсын газар нутгийн төв хэсэгт буюу Архангай аймгийн нутаг дэвсгэрт байрладаг. Одоогоор 18,0 мянга гаруй хүн амтай бөгөөд Монгол улсын нийт хүн амын 0,7 хувийг эзэлдэг (2004 оны байдлаар) юм. Улаанбаатар хотоос баруун тийш 490 км зайд оршдог. Үүнээс, Улаанбаатар хотоос Хархорин хүртэл 360 км зам нь хатуу хучилттай, үлдсэн 130 км зам нь шороон зам юм. Түүнчлэн агаарын болон төмөр зам байхгүй тул Улаанбаатарт хотод очиход хүндрэл үүсгэдэг. 2000 оноос өмнө агаарын замтай байсан боловч одоо байхгүй.

Монгол улсын бусад аймгийн төвүүдийн адил Цэцэрлэг хот нь хотын статусгүй, 1992 оноос Эрдэнэбулган сум болсон ба юуны өмнө ач холбогдол бүхий татварыг захиран зарцуулах болон шийдвэр гаргах бүрэн эрх мэдэлгүй болсон. Түүнчлэн хотын төсөв, гол салбаруудын үйл ажиллагаанд хөрөнгө оруулах асуудлыг хязгаарлагдмал болгож байгаа Үндэсний бодлогоор Цэцэрлэг хотын төсвийн зардлыг аймгаас болон улсаас хуваарилж байгаа нь орон нутгийг эрх мэдэлгүй, улсын төсвийн хараат болгож байна.

Архангай аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд 77.8 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлдэг байна. Энэ үзүүлэлт нь (мөн, аймгийн нийт хүн амын зөвхөн 17.6 хувь нь Цэцэрлэг хотод амьдардаг) Цэцэрлэг хот нь бүс болон аймагтаа эдийн засгийн ач холбогдолтой үүрэг гүйцэтгэдэггүйг илэрхийлж байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 351'949 төгрөг байгаа нь улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хагас шахам хувийг эзэлж байна.

Цэцэрлэг хотын хүн ам буурч байгаа ба ядуурал өсөх хандлагатай байна. Хотын хүн амын шилжилт хөдөлгөөн сүүлийн 2 жилд дунджаар 0,6 хувиар буурчээ. Шилжин явж байгаа хүн амын тоо 2001 оноос эхлэн жилд дунджаар 20.0 орчим хувиар ихэсч байна. 2003 оны байдлаар Цэцэрлэг хотын хүн амын 58,4 хувь нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс (Хангайн бүсийн амьжиргааны баталгаажих доод түвшин 22800 төгрөг) бага орлоготой байна. Цэцэрлэг хотын өрхийн дундаж орлого 123020 төгрөг; дундаж зарлага 120091 төгрөг байгаа нь улсын дундаж 10.0-20.0 хувиар доогуур байна.

Хотын нийт хүн амын 8,0 хувь нь усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн хангамжтай орон сууцанд оршин сууж байгаа нь бусад хотуудтай харьцуулахад маш доогуур үзүүлэлт юм. Цэцэрлэг хот усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн

системтэй, усан хангамжийн эх булаг нь хотын төвөөс баруун урагш 4 км-т орших “Таруугийн гол”-ын эрэгт байрладаг. Гэр хороололд орших 9 ус түгээх цэгүүд нь усан сан болон төвийн системд холбогдоогүй байна. Цэцэрлэг хотын ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд хотын ихэнх үйлдвэр, албан газрууд холбогдсон ба энэ шугамаар хэрэглэгчдийн бохир усыг татан насосны станцаар дамжуулан 2 ширхэг шүүх талбайд шахаж байдаг. Хоногт 2700 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай биологи цэвэрлэгээний иж бүрэн байгууламжтай боловч 1995 оноос хойш усаар шахаж туршилт тохируулга хийгээгүй байна. Цэцэрлэг хот нь усан хангамж, эрүүл ахуй, хатуу хог хаягдлын менежмент, халуун ус, халаалт, цэвэр усан хангамжийг сайжруулах, нэмэгдүүлэхэд (АХБ-ы зээл. 1907-МОН) хандивлагчдын санхүүжүүлж байгаа найман аймгийн тоонд багтаж байгаа юм.

Хотуудын тулгамдаад буй асуудлууд

Монголын хоёрдогч хотууд санхүү эдийн засгийн бодлогод хавчигдан орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх томоохон хөрөнгө оруулалтанд орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулах боломж хязгаарлагдмал байна 2003 онд батлагдсан Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтын хуулийн (ТБУСХ) дагуу, орон нутгийн төсвийн хэмжээ маш бага бөгөөд хөрөнгийн зардлаа нэмэгдүүлэх боломжгүй юм. Үүгээр орон нутагт төсөв нь (I) орон нутгийн төсвийн орлого (II) орон нутгийн төсвийн зардал, (III) ТЭЗ /Төсвийн ерөнхийлөн захирагчид/-ын улсын төсвөөс орон нутагт зарцуулж байгаа зардал гэсэн гурван хэсэгтэй.

Энэ сүүлийн хэсэг нь 2003 оноос сургууль, эмнэлэг, орон сууцны зардлыг ТЭЗ нарын улсын төсөвт тусгадаг болсноор “доороос дээш чиглэсэн” төсөв боловсруулж баталдаг байсан хуучин тогтолцоог өөрчилж байгаа гол өөрчлөлт юм. Үүний үр дүнд 2003 оноос хойш ТЭЗ-ын улсын төсвөөс орон нутагт зарцуулж байгаа зардал 30 хувиар нэмэгдэж, капитал зарлууд 2 хувиас 0,13 хүртэл буурсан байна. Энэ нь орон нутаг өөрсдийн мэдлийн хөрөнгөө капитал хөрөнгө оруулалтанд зарцуулах чадваргүй болохоос гадна Засгийн газраас орон нутгийн хөрөнгийг сайжруулахад зориулсан хөрөнгө огцом багассан байна.

2003 оноос өмнө орон нутгийн орлого зарлагын зөрүүг улсын төсвөөс нөхдөг байсан байна. 2003 оноос эхлэн төсвийн ерөнхийлөн захирагч яамдын орон нутгийн зардлыг бас оруулан тооцох болсон. Мөн хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ болон онцгой татварыг орон нутгийн засаг захиргаа цуглуулдаг боловч Засгийн газрын мэдэлд шилжүүлдэг. 2003 оноос өмнө орон нутгийн засаг захиргаа ХАОАТ-ын ихэнхи хэсэг ба тухайн орон нутгийн аж ахуйн нэгжүүдээс цуглуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ба НӨАТ-ын ихэнхи хэсгийг авч үлдэх эрхтэй байсан. Төсвийн орлогыг бүрдүүлэх шинэ журмын дагуу дээрх дөрвөн төрлийн татварыг аймагт төвлөрүүлж байгаа ба НӨАТ-г хүн амын тооноос хамааран тогтоож байна.

Зөвхөн Эрдэнэт ба Дархан хотууд өөрийн нийт зардлыг нөхөх хэмжээний орлого төвлөрүүлэх чадвартай байна. Тэдгээр хотуудын үл хөдлөх хөрөнгийн татварын орлого 13 хувь орчим байгаа нь өндөр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт бусад жижиг аймгийн төвүүдийн хувьд дөнгөж 3-4 хувьтай байна. Энэ нь дээр дурьдсан хотуудад үйлдвэржилт бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад өндөр хувьтай байгааг харуулж байна. Монгол улсын татварын хуулийн 17 дугаар зүйлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн татвар нь орон нутгийн татвар ба зөвхөн хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд хамааралтай. Үл хөдлөх хөрөнгийн татварын хуулийн дагуу орон сууц болон бусад хүн оршин суух байрууд татвараас чөлөөлөгддөг. Үр дүнд нь орон нутгийн дэд бүтцийг санхүүжүүлэхэд ашиглах бололцоотой ихээхэн хэмжээний татварын эх үүсвэр орон нутгийн татварын эрх мэдлийн гадна үлдэж байна.

Хот тус бүр эдгээр санхүүгийн асуудлыг Хотын хөгжлийн стратегид хөндөж хотын санхүүжилтийг сайжруулах зорилго бүхий стратеги боловсруулах санал дэвшүүлсэн. Орон нутгийн түвшинд орлого төвлөрүүлэх чадвар, төсвийн болон зарлагын менежментийг бий

болгохын тулд улсын бодлогыг эргэж харах, гадны тусламж олж авах үүднээс хот тус бүр дээрх санаачилгыг нэн тэргүүний ач холбогдол бүхий төслөөр шалгаруулсан байна.



4

БҮЛЭГ

ПАРЛАМЕНТ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ТУРШЛАГА

А. Пагма (МА)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд БНФУ -ын Парламентын үйл ажиллагаатай танилцах айлчлалыг 2009 оны 3 дугаар сарын 22 - 29 -ны өдрүүдэд хийлээ. Тус танилцах айлчлалын хэсгийн бүрэлдэхүүнд УИХ-ын Тамгын газрын эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн дарга Д.Насанжаргал, СШОНХТөвийн ахлах референт Ю.Эрдэнэтуяа, судлаач Д.Мягмарцэрэн, А.Пагма нар оролцов. Тус танилцах айлчлалын хүрээнд дараахи уулзалтууд зохион байгуулагдсан болно. Үүнд:

- 2009 оны 3 дугаар сарын 23 -ны өдөр Үндэсний Хурлын Хуулийн албаны дарга ноён Филипп Жарудтай уулзсан бөгөөд Үндэсний Хурлын хуулийн албаны ажил үүрэг, шинээр хийж буй өөрчлөлтийн талаар ярилцсан. Түүнчлэн ҮХ-ын Олон улсын харилцаа, батлан хамгаалах албаны ажилтан ноён Фредрик Слама Францын төрийн байгуулалт, хууль тогтоох үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн болно.
- 3 дугаар сарын 24 -ны өдөр Париж хоттой танилцах аяллыг зохион байгуулсан.
- 3 дугаар сарын 25-ны өдөр Эдийн засаг үйлдвэр, хөдөлмөрийн яамны Уул уурхай агентлагийн Ерөнхий инженер ноён Жан-Пьер Летойртуатай уулзсан ба уул уурхайн эрх зүйн асуудлаар ярилцсан.
- 3 дугаар сарын 26-ны өдөр Үндэсний Хурлын гишүүн, Эдийн засаг хүрээлэн буй орчин, газар нутгийг эзэмших асуудлыг хариуцсан байнгын хорооны дарга Патрик Олие хүлээн авч уулзсан. Мөн өдөр Номын сан, архивын албаны дарга хатагтай Элиан Фигиера Үндэсний Хурлын номын сангийн зохион байгуулалт, судалгааны баримт бичгийн талаар танилцуулсан. Энэ өдөр хуулийн албаны хяналт, хуулийн судалгааны албаны хэлтсийн дарга ноён Ив Мари Дубле Хуулийн албаны хэмжээнд явуулдаг хяналт шалгалт, судалгааны үйл ажиллагааны талаар танилцуулав.
- 3 дугаар сарын 27-ны өдөр Францын парламентын дээд танхим болох Сенатын үйл ажиллагаатай танилцах уулзалтуудыг хийсэн. Сенатын Олон улсын хамтын ажиллагааны албаны орлогч дарга Жак Бернау Сенатын үйл ажиллагааны талаар болон Люксембургийн ордонтой танилцуулсан. Эдийн засгийн комиссын ажлын албаны дарга, зөвлөх хатагтай Мари де ла Бретеш Сенатын Эдийн засгийн комисст уул уурхайн эрх зүйн асуудлуудыг авч хэлэлцэн хэрхэн зохицуулдаг талаар танилцуулсан. Түүнчлэн Сенатын судалгааны албаны ажилтан Марк Ле Дорн тус албаны үйл ажиллагааны талаар танилцуулсан.

1. Францын Үндэсний Хурлын тухай танилцуулга

Францын Үндэсний Хурал нь парламентын доод танхим бөгөөд 577 гишүүнтэй. Үндэсний Хурлын гишүүдийг бүх нийтийн шууд сонгуулиар 5 жилийн хугацаагаар сонгоно. Үндэсний Хурлын сүүлчийн сонгууль 2007 онд болсон. Үндэсний Хурлын дарга нь Бернар Аккуайе юм.

Үндэсний хуралд 289 суудал авсан улс төрийн нам олонхи болдог бөгөөд ҮХ-ын одоогийн бүрэлдэхүүнд “Ардын хөдөлгөөний төлөөх холбоо” нам 313 суудалтай, Социалист нам 186 суудал, Ерөнхийлөгчийн олонхи нам болон бусад барууны намууд тус бүр 22 суудал, Коммунист болон бусад зүүний намууд тус бүр 15 суудал, эрс зүүний үзэлтнүүд 7 суудал, Ногоон нам 4, Ардчилсан хөдөлгөөн нам 3 суудалтай байна. Үндэсний Хурлын гишүүд 6

байнгын хороо, орон тооны бус 1 хороонд хуваагдан ажилладаг байна.

Үндэсний хурал нь парламентын гишүүдийн боловсруулсан “хуулийн санаачлага” болон Засгийн газраас өргөн барьсан “хуулийн төслийг” хэлэлцэн, Сенаттай зөвшилцсөний үндсэн дээр баталдаг үүрэгтэй. “Хуулийн санаачлага” болон “хуулийн төслийг” Сенат сайшаагаагүй тохиолдолд Үндэсний Хуралд буцааж, өөрчлөлт оруулна. Хууль батлах явцад Үндэсний Хурал, Сенатын хооронд зарчмын саналын зөрөө гарсан үед Сенатын 7 гишүүн, Үндэсний Хурлын 7 гишүүдээс бүрдсэн хамтарсан комисс байгуулан нэгдсэн тохиролцоонд хүрэх чиглэлээр ажилладаг журамтай.

Хууль батлах явцад бүх нийтийн шууд сонгуулиар сонгогдсон Үндэсний Хурал эцсийн шийдвэрийг гаргах эрхтэй байдаг байна. Францын Үндэсний Хурлын хэмжээнд 2005 оноос шинэ үзэл баримтлалыг баримталж эхэлсэн ба энэхүү үзэл баримтлалын дагуу хууль эрх зүйн асуудлыг сайжруулах, батлан гаргаж буй хуулиудад судалгаатай хандах, хуулиудын хэрэгжилтэнд хяналт тавихад анхаарах номлол бий болсон байна. Энэ үзэл баримтлалын дагуу хийх өөрчлөлт 2006 оны 1 сарын 1-нээс эхэлжээ.

ҮХ -ын депутатуудад туслах ажлыг тэдгээрийн туслахуудад шилжүүлээд гол нь хуулийн чиглэлээр хууль тогтоогчдод тусалцаа үзүүлэх, тэдний хүсэлтээр мэргэжлийн судалгаа гаргаж өгөх, гаргасан хуулийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах, түүнд судалгаатай хандахад үйл ажиллагаагаа чиглүүлжээ. Ингэхдээ тухайн хууль хэрэгжих журам гарсан уу, хууль хэрэгжих нөхцөл бүрдсэн үү гэдэг асуудлыг анхаардаг ба хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш 6 сарын дараа тухайн хууль хэрхэн хэрэгжиж байгаа талаар илтгэл бэлтгэн парламентад танилцуулдаг ажээ. Энэхүү илтгэлийг бэлтгэж байгаа депутатуудад хоёр ажилтан тусалдаг байна.

ҮХ -нь Тамгын газар нь дотроо албадтай, тухайлбал, хуулийн алба нь нийт 15 ажилтантай, нарийн бичгийн дарга нарын газар, судалгаа, хяналтын хэсэг гэсэн хоёр хэсэгтэй юм. Хуулийн албаны нарийн бичгийн дарга нарын газар нь хууль тогтоогчдод хуулийн чиглэлээр тусалцаа үзүүлдэг бол судалгаа, хяналтын хэсэг нь хууль тогтоогчдын захиалгаар мэргэжлийн судалгаа гаргаж өгөх, мэдээллийн баг ажиллуулж байнгын хороодын гишүүдийг хэрэгцээтэй мэдээллээр ханган ажилладаг байна.

Дээр дурдсан хуулийн хэрэгжилтийн талаар илтгэл бэлтгэх ажилд ҮХ-ийн байнгын хороодын зүгээс ихээхэн анхаардаг бөгөөд энэхүү илтгэлийг бэлтгэхэд тухайн асуудлаарх судалгаа чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Илтгэл бэлтгэх багийн бүрэлдэхүүнийг тухайн байнгын хорооны дарга томилдог ба түүний бүрэлдэхүүнд ҮХ-ын гишүүдээс гадна тамгын газрын албадын ажилтнууд, судлаачид оролцдог.

Үндэсний хурал нь 6 байнгын хороотой ба тодорхой асуудлаар судалгаа хийх шаардлагатай тохиолдолд байнгын хороодоос судалгааны багийг байгуулдаг. Ингэхдээ тодорхой мэргэжлийн судалгаа шаардсан ажил дээр судалгаа, шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн судлаачдыг авч ажиллуулдаг байна. Зарим шаардлагатай тохиолдолд, тухайлбал, цөмийн энергийн, биоэтикийн гэх мэт асуудлаар хоёр танхим нэгдсэн судалгааны баг гарган ажиллуулдаг.

Үндэсний Хурлын номын сан нь 1833 онд байгуулагдсан бөгөөд 1835 онд одоогийн Бурбоны ордонд шинэ танхимд орсон ба энэхүү танхимыг зураач Евгени Делакура (1798-1863) эртний Грекийн домгоос сэдэвлэн чимэглэсэн нь өнөө хүртэл эртний сонгодог хэлбэр, гүн гүнзгий утга агуулгаа хэвээр хадгалсаар иржээ. Үүний зэрэгцээ тус номын сан нь маш арвин баялаг номын фондтой бөгөөд уншлагын танхим дахь номын тавиурууд дээр эртний уран гоёмсог хэвлэл бүхий номыг олноор нь зэрэгцүүлэн байрлуулсан нь

эрхэмсэг бөгөөд оюунлаг уур амьсгалыг бүрдүүлжээ.

Үндэсний Хурлын номын сан нь зөвхөн Үндэсний Хурлын гишүүдэд зориулагдсан ба эрдэмтэн судлаачид шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл авч ажилладаг байна. Номын каталогийг интернэтээр танилцуулдаг бөгөөд нийтэд зориулсан мэдээллийг орон нутгийн хүмүүс татаж авах боломжтой юм. Нийтэд танилцуулах боломжтой каталогидоо өөр ямар номын сангуудтай хамтарч ажилладаг талаараа мэдээлэхийн хамт, хамтын ажиллагаатай номын сангийнх нь каталогийг татаж авч үзэх боломжтой ажээ.



Төлөөлөгчид Францын Үндэсний Хуралд


(зүүн гараас Ю.Эрдэнэтуяа, элчин зөвлөх Б.Санжмятав, А.Пагма, Д.Насанжаргал, Үндэсний Хурлын ТГ-ын ажилтан Ф.Слама. Париж, 2009 оны 3-р сар)

Үндэсний Хурлын гишүүдэд зориулсан мэдээллийг бэлтгэн вэб хуудсандаа тавьдаг ба мөн тодорхой сэдвүүдээр сэдэвчилсэн материал бэлтгэн тусгай булан ажиллуулдаг байна. Түүнчлэн вэб хуудсаараа дамжуулан гишүүдээс захиалга авч мэдээлэл өгөх, сэтгүүлүүдэд гарсан томоохон өгүүлүүдийг уншаад шаардлагатай гэж үзсэн материалыг бичиж оруулах зэргээр номын сангийн вэб хуудсыг тогтмол, байнга ажиллуулдаг байна. Тус номын сан нь долоо хоногт 80 орчим ном худалдаж авдаг ба Үндэсний Хурлын гишүүдийн бичсэн ном, бүтээлийг бүгдийг нь худалдан авч гарын үсгийг нь зуруулан хадгалдаг байна. Ном худалдан авах тусгай журам үйлчилдэг ба 3 ажилтан саналаа танилцуулан номын сангийн дарга шийддэг байна.

2009 оны 1 сарын 1-нээс номын сан, архив хоёр тусдаа байсныг нэгтгэсэн бөгөөд нийт 40 орчим хүн ажилладаг, үүнээс номын санд 20 хүн ажилладаг. Архивын хэсэг өөр газар байрладаг бөгөөд архивын зарим хэсэг нь олон нийтэд нээлттэй байдаг. Хүмүүс хуулийн төсөл хэлэлцэгдэн батлагдах явцад гишүүдийн санал, хуульд нэмэлт өөрчлөлтийг хэрхэн яаж оруулсан талаархи протоколыг үзэх боломжтой юм.

2. Францын Сенатын тухай танилцуулга

Францын Сенат нь парламентын дээд танхим бөгөөд 331 гишүүн буюу сенатчаас бүрдэнэ. Сенатын гишүүдийг шууд бусаар буюу ҮХ-ын гишүүд, францын хотуудын мэр, орон нутгийн хурлын зөвлөхүүдээс 6 жилийн хугацаагаар сонгоно. Сенатын бүрэлдэхүүний гуравны нэг нь 3 жил тутам шинэчлэгдэж байдаг. Сенатын сүүлчийн сонгууль 2008 онд болсон.



Францын Үндэсний Хурлын номын сангийн уншлагын танхим

Сенатын одоогийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн олонхийн холбоо нам 150 суудалтай, Социалист нам 120 суудал, Төвийн холбоо нам 29, Коммунист, Бүгд найрамдах болон иргэдийн холбоо нам 23, Европын социал, ардчилсан нэгдэл нам 145 суудалтай байна. Ерөнхийлөгчийн олонхийн холбоо нам нь бусад жижиг намуудтай нэгдэн Сенатын олонхийг бүрдүүлэн ажилладаг. Сенатын гишүүд 6 байнгын хороо, орон тооны бус 1 хороонд хуваагдан ажилладаг.

Францын сенатын дарга нь тус улсын 2 дахь өндөр албан тушаалтан болох тул Ерөнхийлөгчийг нас барах буюу үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болбол Ерөнхийлөгчийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Сенат нь парламентын гадаад харилцааг хөгжүүлэхэд үндсэн үүрэгтэй оролцдог. Мөн Францын Ерөнхийлөгч ҮХ-ыг хугацаанаас нь өмнө тарааж, шинээр сонгууль явуулах эрхтэй байдаг бол Сенатыг тараах эрхгүй, сенатчдыг хэн ч эгүүлэн татах буюу огцруулах эрхгүй байдгаараа онцлогтой.

Сенатын судалгааны алба нь 2002 онд байгуулагдсан. Судалгааны алба нь дараах чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Сенатын байнгын хороод дээр хэлэлцэгддэг асуудлуудыг цэгцтэй судлах шаардлагатай байдаг. Ийнхүү судалсанаар зөвхөн өнөөдрийн асуудлыг судлаад зогсохгүй олон асуудлыг урьдчилан хараад эцсийн үр дүнг тооцоолоход ажлаа чиглүүлдэг.
- Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай судалгааг хийдэг. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах үндэслэлийг хууль тогтоогчид, байнгын хороодод гаргаж өгдөг.

- Сенатын холбогдох албад, байнгын хороод, намуудын бүлгийн хүсэлтээр тодорхой судалгаа хийдэг.
- Нэг асуудлыг янз бүрийн улс орнуудад эрх зүйн хувьд хэрхэн зохицуулдаг талаар харьцуулсан судалгаа хийдэг.

Тодорхой судалгаануудыг хийж хууль тогтоогчдод гарын авлага болгодог тухайлбал, далайн боомтуудын талаар, засгийн газрын шийдвэрүүдийн талаар, парламент хоёр танхимтай байх, тэдгээрийн үр ашгийг дээшлүүлэх талаар, эрүүгийн хэргийн явцад хяналтын шүүгч хэрхэн хяналт тавьдаг талаар харьцуулсан судалгаа гэх мэт олон сэдвээр хийжээ. 2-10 хуудас бүхий богино хэмжээний мэдээллүүдийг бэлтгэж өгдөг бөгөөд эдгээрийг нот гэж нэрлэдэг байна. Түүнчлэн судалгааны сэдвийн уралдаан зарладаг нь нэлээд сонирхолтой санагдсан.

3. Франц улсын уул уурхайн өнөөгийн төлөв байдал, эрх зүйн зохицуулалт

Өнөөгийн байдлаар тус улсын төсөв болон төрийн бодлогын хэмжээнд 20, 30 жилийн өмнөхтэй харьцуулахад уул уурхайн эзлэх жин багассан. 2002 оноос төмрийн болон нүүрсний нөөц дууссан учраас эдгээр уурхайнуудыг хаасан. Одоогоор Франц улсын нутаг дэвсгэр дээр, Шинэ Каледонид никелийн, Гаянд алтны, Лоренд давсны уурхайнуудыг ашиглаж байгаа. Тус улсын газрын гүнд нь байгалийн хий байдаг. Үүнээс шингэн түлш гарган авах болон нүүрс хүчлийн хийг агаарт гаргахгүй газар доор хадгалах талаар нэлээд ажил хийж байгаа.

Далайн цаадах департамент нүүрс, байгалийн хий ашиглах, олзворлох асуудлыг хариуцдаг. Мөн тус байгууллага нь хилээс гадуур, далайн чанад, далайн эрэг дээр нефть хайж байгаа. Ийнхүү тус улсын нутаг дэвсгэр дээр шинээр уурхай нээж ашиглах явдал бараг үгүй болсон тул төрөөс нөхөн сэргээлтийн асуудлыг голлон анхаарч зохицуулдаг. Уурхай ашиглаад дууссан газар оршин суугчдын эдийн засаг нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд дахин шинээр үйлдвэр байгуулах бодлого барин Засгийн газраас тухайн орон нутгуудад татаас өгч байна.

Уул уурхайн харилцаанд төрийн зохицуулалт, оролцоо байх нь ихээхэн бэрхшээл учруулж байсан. Учир нь уурхайнууд нь мөнгө өгөхөөсөө илүү мөнгө авдаг. Тухайлбал, нүүрс олборлох зардал нэмэгдсэн үед заримдаа уул уурхайдаа татаас өгдөг. Уул уурхайн ажиллагсдын тэтгэвэр, нийгмийн асуудалд 900 сая евро зардаг. Иймээс сүүлийн үед уул уурхай дахь төрийн оролцоог багасгаж, бараг оролцоогүй болсон. Дэлхийн 2-р дайны дараагаар стратегийн зорилгоор улсын мэдлийн нефтийн, ураны үйлдвэр байгуулсан. Бие даасан байгууллага учир хувийн компанийн байр суурьтай байсан бөгөөд төрөөс зөвхөн ашигтай зүйлд хөрөнгө оруулах тал дээр л хяналт тавьдаг байсан. Уул уурхай дахь төрийн оролцоог багасгах үүднээс "Total" гэдэг нефтийн компаниа хувьцааг нь нээлттэй болгож нийтэд зарлах замаар хувьчилсан.

Эрх зүйн зохицуулалтын хувьд хамгийн гол нь эрх зүйн орчин тогтвортой байх зарчим баримталдаг. Засгийн газар түүхий эдийн үнэ тогтворгүй байх үед татвараа зохицуулдаг. Үнэ буурах үед татвараа багасгах замаар хөрөнгө оруулагчийг алдагдалаас хамгаалж тусладаг. Мөн ураны үнэ буурсан үед уурхайг хаагаад үнэ өсөх үед ашиглах арга хэмжээ авч байсан. Хаах үед нь хөнгөлөлт үзүүлж лицензийн хугацааг нь сунгаж байсан. Энэ нь ихээхэн том тусламж болдог бөгөөд учир нь хуулиар хайгуулын лиценз авснаас хойш 10 жил ашиглаагүй бол лицензийг хурааж авахаар гэрээ байгуулж лиценз олгодог байна. Лиценз авах шаардлагууд хуулинд тодорхой тусгагдсан. Үүнд:

- Хамгийн сайн технологи байх,
- Баталгаатай санхүүтэй байх,
- Нөхөн сэргээлт хийх чадвартай байх. Эдгээрийг гэрээндээ нарийн тохиролцдог.

1960-1970-аад оны үед хойд далайд нефть олборлож эхэлсэн. 1973 онд гэнэт үнэ нь өсөх үед Англи улс гэнэтийн ашгийн татвар бий болгосон. Энэ үед Франц улс энэ туршлагыг авч хэрэглэж байсан, гэхдээ компаниудад ашигтай байх нөхцлийг үлдээсэн. Уурхай ашиглах үедээ хайгуул хийж, энэхүү зардлыг нь татвараас хасч өгдөг жишээг 1950-иад онд АНУ-д нэвтрүүлсэн. Үүнийг мөн Франц улс ашиглаж байсан. Түүхий эдийн үнэ буурах үед бүтээгдэхүүн хуваах нь орлогыг бууруулдаг учраас тус улс нь татвар хураамжийн хэлбэрээр орлого олохыг чухалчилдаг.

Сүүлийн үед тус улсад хууль бусаар бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явдал нэлээн бэрхшээл учруулж буй тул хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал яригдаж байгаа. Одоогоор орон нутаг болон тэдгээрийн цагдаагийн хэсгүүдэд эдгээр хууль бус үйл ажиллагааг хянах болон үүнээс сэргийлэхэд нь зориулж төсөвт нь нэмэлт хөрөнгө төсөвлөж байна.



АВСТРАЛИ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН ЗАРИМ ТУРШЛАГА (Танилцуулга)

Ц. Болормаа

2009 оны 6 -р сарын 16 -аас 6 -р сарын 19 -ний хооронд 4 өдрийн хөтөлбөртэйгээр Австралийн холбооны улсын Парламент болон Тамгын газрын үйл ажиллагаатай танилцан туршлага судлах айлчлал хийлээ. Энэхүү туршлага судлах айлчлалын хүрээнд Австралийн парламентын дээд танхим, доод танхим болох Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын үйл ажиллагаа түүнчлэн парламентад мэдээлэл, судалгааны үйлчилгээ үзүүлдэг номын сангын үйл ажиллагаатай нарийвчлан танилцсан юм.

Австралийн Парламент

Австралийн Парламент нь дээд, доод хоёр танхимтай бөгөөд дээд танхимыг Сенат (Senat) доод танхимыг Төлөөлөгчдийн танхим (House of Representative) гэж нэрлэнэ. Парламентын дээд танхим болох Сенат нь 76 гишүүнтэй, Төлөөлөгчдийн танхим нь 150 гишүүнтэй бөгөөд парламентын хоёр танхим тус тусдаа Тамгын газар (Department)-тай.

Парламентын Тамгын газар

Австрали улсад Парламентын хоёр танхим нь Сенатын Тамгын газар, Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар, Парламентын үйлчилгээний Тамгын газар гэсэн парламентын гишүүдэд үйлчилгээ үзүүлдэг гурван Тамгын газартай байдаг байна.



Дээрхи бүдүүвчид харагдаж буй Парламентын Тамгын газрууд нь харъяалагдах Танхим тус бүрдээ үйлчилдэг бөгөөд харин “Парламентын Үйлчилгээний Газар” нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимын аль алинд үйлчилдэг байгууллага юм. Сенатын Тамгын газар, Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар Парламентын үйлчилгээний газар нь Парламентын хоёр танхимд хэрхэн үйлчилдэгийг дараахь схемд товчхон харуулсан.



Уг схемээс “Парламентын Үйлчилгээний Газар” нь Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын Тамгын газраас тусдаа, нэг статустай бие даасан газар гэдэг нь тодорхой харагдаж байна. Тус газрыг Нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч НБД удирдана.

Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар

Туршлага судлах аялалын групп Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогтой нарийвчлан танилцсан бөгөөд энэ талаархи товч мэдээллийг доорхи хүснэгтээс харж болно.

Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын ажлын албадаас тусгайлан танилцсан алба, хэлтсүүдийг дурьдвал:

- Тамгын газрын Ерөнхий Нарийн бичиг ноён Иан Харрис
- Олон нийттэй харилцах хэлтэс
- Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс
- Хэлэлцүүлгийн хэлтэс (Table office)
- Байнгын хороодын ажлын алба
- Танхимын судалгааны хэлтэс
- Хүний нөөц
- Мэдээллийн систем болон Хэвлэлийн хэлтэс
- Радио нэвтрүүлгийн хэлтэс (Парламентын үйлчилгээний газрын харъяа)

Олон нийттэй харилцах хэлтэс

Олон нийттэй харилцах хэлтэс Парламентын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах үндсэн чиг үүргийн дагуу ажилдаг. Иргэдийг Парламентын хоёр танхимын хуралдаан болон Question time асуулт хариултын цаг, Парламентын ордонтой танилцуулах ажиллагааг хариуцан зохион байгуулдаг.

Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс

Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны хэлтэс нь Парламентын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Уг хэлтэс нь улирал тутам хэлэлцэгдэж буй, анхаарал татсан, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сэдэвчилсэн сэтгүүл гаргах бөгөөд тухайн сэтгүүлээр тусгайлан телевизийн нэвтрүүлэг бэлдэж DVD форматад оруулан архивлан хадгалдаг байна.

Түүнчлэн Парламентын вэбсайтад тухайн хуультай холбоотой гишүүдийн байр суурь, ярилцлага, бэлдсэн нэвтрүүлгийг цаг тухайд нь байршуулах үүрэг хүлээн ажиллаж байна. Уг хэлтэс нь бие даасан сэтгүүл, нэвтрүүлэг бэлдэх ажлаа 10 жилийн өмнөөс эхлүүлсэн туршлагатай байсан юм.


Хэлэлцүүлгийн хэлтэс (Table office)

Хэлэлцүүлгийн хэлтэс нь Парламентын хууль тогтоох бүрэн эрхийг нь хангах зорилгоор хууль тогтоох процессийн асуудлыг эрхлэн гүйцэтгэдэг байна. Хэлэлцүүлгийн хэлтэсийн ажил нь Парламентын байнгын хороод болон Байнгын хорооны ажлын албатай салшгүй холбоотой нарийн дэглэмтэй явагддаг байна. Хэлэлцүүлгийн хэлтэсийн үйл ажиллагаандаа баримтлах гол эх сурвалж нь Үндсэн хууль, Standing Orders буюу хууль тогтоох процесс болон хуралдааны дэгийг зохицуулсан журам байдаг байна. Энэ талаар бие даасан судалгаандаа дэлгэрэнгүй оруулах болно.

* * *



**Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын удирдлага
зохион байгуулалтын бүдүүвч**




Байнгын хороодын ажлын алба

Энэ удаагийн Парламент 20 байнгын хороо болон 8 байнгын хороодын ажлын албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Байнгын хороодын ажлын албаны зохион байгуулалтын хувьд 3 байнгын хороо тутамд нэг байнгын хороодын ажлын алба байгуулагдан ажиллаж байна.

Парламентын бүх гишүүд байнгын хороодод харъяалагдах бөгөөд тодорхой нэг асуудлаар дагнасан байнгын хороог сонгон байгуулах ба тухайн асуудлыг шийдвэрлэж дуусмагц уг байнгын хороо татан буугддаг байна. Гурван байнгын хороо тутамд байх байнгын хорооны ажлын албыг дор схемчлэн үзүүлээ.

Байнгын хорооны ажлын албаны бүтэц зохион байгуулалт



Үүнээс гадна Main Committee буюу Үндсэн хороо байдаг байна. Энэ Үндсэн хороонд хуулийн хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулах бөгөөд хуулийн төслийг зүйл заалт бүрээр нь нарийвчлан хэлэлцэх бөгөөд ажил хэрэгч санал шүүмж энэ хорооны хуралдаан дээр өрнөдөг байна. Түүнчлэн хуулиар Сенат төсөв, санхүү, мөнгөний бодлого, татвар гэх мэт хөрөнгөтэй холбоотой хуулийн төслийг хэлэлцэх эрхгүй бөгөөд эдгээр хуулийн төслийн гол хэлэлцүүлэг Үндсэн хороон дээр явагддаг байна.

Танхимын судалгааны хэлтэс

Байнгын хороодын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, түүнчлэн байнгын хороодын ажлын албаны үйл ажиллагааг хэрхэн сайжруулах чиглэлийн дагнасан судалгааг явуулдаг байна.

Радио нэвтрүүлгийн хэлтэс

Радио нэвтрүүлгийн хэлтэс нь Сенат, Төлөөлөгчдийн танхим, бүх байнгын хороодын хуралдаан, хэлэлцүүлэг, санал шүүмж, асуулгын цагийг орон даяар шууд дамжуулах үүргийг хүлээдэг хэлтэс юм. Уг хэлтэс нь бусад газар, хэлтэс, албадын нэгэн адил Парламентын ордонд байрлах бөгөөд 2 танхим бүхий телевизийн студи, хуралдааныг шууд дамжуулах удирдлагын өрөөнүүдтэй мэргэжлийн инженер, техникийн ажилчидтайгаар үйл

ажиллагаагаа явуулдаг байна. Уг шууд нэвтрүүлгүүд нь орон даяар телевизийн сувгаар, дэлхий даяар Парламентын вэбсайтаар цацагддаг байна.

Хүний нөөц

Парламентийн Тамгын газруудад нийттэй 1235 ажилчин, албан хаагчтай. Үүнээс Сенатын танхимд 152, Төлөөлөгчдийн танхимд 154, Парламентын үйлчилгээний газарт 929 албан хаагч ажилдаг байна.



Хоёр Парламентын үйлчилгээний газар

Парламентын Үйлчилгээний Газар” нь дараахь бүтэцтэй байна. Үүнд:

- Номын сан (Судалгаа шинжилгээ, мэдээлэл гэсэн 2 хэсэгт хуваагдана)
- Санхүүгийн хэлтэс
- Хүний нөөц, менежмент
- Бүтээгдэхүүн болон үйлчилгээний хөгжлийн салбар
- Барилга үйлчилгээний салбар
- Стратеги болон бизнес үйлчилгээний салбар гэсэн салбар хэлтсүүдтэй байна. Үүнээс манай аялалын групп Номын сан судалгааны салбартай тусгайлан танилцсан юм.

Парламентын Номын сан

Парламентын Номын сан анх 1901 онд Мэлбурн хотноо Австралийн Парламенттай хамт байгуулагдсан түүхтэй. 1960 он хүртэл Парламентын номын сан Тамгын газар хоёр нэг удирдлага зохион байгуулалтын дор үйл ажиллагаагаа явуулж байсан. 1962 оноос Австралийн Үндэсний номын сантай хамтарч үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч тун удалгүй бие даасан Парламентын номын сан болсон. 1999 онд Парламентын номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон “Парламентын үйлчилгээний тухай” хууль батлагдсан.

Парламентын Номын сан хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Судалгаа, шинжилгээ
- Мэдээлэл

Хуулийн дагуу Парламентын Номын сан дараахь чиг үүрэгтэй байна:

- Цаг хугацаанд нь, нууцлалын өндөр зэрэглэлийг баримтлана
- Бие даасан, гишүүд сенатуудын хүсэлтийн дагуу мэдээлэл судалгааны үйлчилгээ үзүүлнэ
- Өндөр хэмжээний стандарт мөрдөж ажиллана.
- Эрх тэгш үйл ажиллагаа үзүүлнэ
- Сенатын гишүүд асуултанд оролцох үед түүний дагуу хөтөлбөр боловсруулна
- Гишүүдийн орон нутагт мэдээллэх мэдээллийг бэлдэнэ. дамжуулна

Парламентын Номын сангийн харилцагчид нь:

- Гишүүд, Сенатууд
- Улс төрийн намууд
- Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын болон байнгын хорооны ажлын албаны ажилчид, албан хаагчид

Үзүүлдэг үйлчилгээ:

- Шинжээч дүгнэлт
- Бичгэн болон аман зөвлөмж
- Баримт, тоон болон статистик мэдээлэл
- Судалгааны зөвлөмж болон хэвлэл
- Хуулийн төслийн тайлбар
- Дэмжлэг болон сургалтын чиг баримжаа
- Сэтгүүлийн нийтлэл өгүүлэл, ном, мэдээллийн бааз
- Хэвлэл мэдээллийн нөөц \сонин, радио телевиз\
- Мэдээлэл олоход туслах
- Семинар болон Лекц

Номын сангийн судалгааны салбар жилд ойролцоогоор 20000 гаруй шинжээчийн дүгнэлт болон судалгааны ажил гаргадаг. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа маш шахуу ачаалал өндөртэй ажилладаг байна. Судалгааны салбарын бүтэц зохион байгуулалтанд хоёр жилийн өмнө өөрчлөлт орсон. Судалгааны салбар нь 80 гаруй судлаач болон туслах ажилчидтай 7 хэсэгтэй. Үүнд:

- Эдийн засгийн судалгааны хэсэг
- Гадаад хэрэг, аюулгүй байдалын судалгааны хэсэг
- Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг
- Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг
- Шинжлэх ухаан, технологи, Хүрээлэн буй орчин байгалийн баялагын судалгааны хэсэг
- Нийгмийн бодлогийн судалгааны хэсэг
- Статистик дүрслэлийн судалгааны хэсэг

Судлаачдад тавих шаардлага:

- Салбарын мэдлэг
- Судалгааны болон бичгийн ур чадвар
- Задлан шинжлэх болон зөвлөлдөх чадвар
- Хөрвөх чадвар

- Мэргэжлийн ур чадвар
- Мэдээлэл зөв олж авах, хувийн зохион байгуулалт сайтай байх.

Номын сангийн гол чиг үүргийн нэг болох Мэдээллийн салбар нь 60 -аад ажилчидтай үйлчилгээний 4 хэсэгтэй.

- Номын сангийн мэдээлэл (Хоёр сая долларын өртөг бүхий 150иад мянган номтой)
- Мэдээллийн бааз бүрдүүлэлт (Мэдээллийн бааз бүрдүүлэх, индэксжүүлэх)
- Хэвлэл (хэвлэмэл болон цахим хэвлэл, вэбсайт болон интранэтэд эх болон анатаци бэлдэх, цахим хэвлэл мэдээллийн мониторинг хийх)
- Төв лавалгааны цэг (Судалгаа, шинжилгээний захиалга авах гол цэг)

Номын сангийн мэдээллийн бааз бүрдүүлэлт болон вэбсайт нь маш нарийн зохион байгуулалттай бөгөөд үйл ажиллагаа нь жигдэрсэн байна. Номын сан мэдээллийн баазаа Парламентын вэбсайтад байршуулах бөгөөд цахим мэдээллийн баазыг дараахь байдлаар төрөлжүүлэн байршуулсан байдаг байна. Үүнд: сонины хайчилбар, нийтлэл, гишүүдын илтгэл (судлаачдын бэлдсэн), Номын сангийн өөрийн хэвлэл, номны каталоги, хуулийн төслийн шинжилгээ, улс төрийн намуудын баримт бичиг, хэвлэлийн газар, радио телевизийн нэвтрүүлэг, Парламентын гарын авлага

Номын сангийн судалгааны ажил

Номын сангийн судалгааны хэсгүүд нь судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхдээ удирдлагын гаргасан “Судалгааны захиалга хүлээн авах журам”, “Судалгааны ажил гүйцэтгэх заавар”, “Хуулийн төслийн шинжилгээ хийх журам” болон холбогдох бусад заавар журмын дагуу хийж гүйцэтгэнэ. Туршлага судлах явцад тус судалгааны салбарын судалгааны ажил гүйцэтгэх арга зүй, зохион байгуулалтын хэлбэр манай төвийн үйл ажиллагаатай тун ойролцоо байсан юм.

Австралийн судалгааны салбарын судалгаа шинжилгээний ажлын чухал хэсэг бөгөөд заавал хийх ёстой ажлын нэг нь Хуулийн төслийн шинжилгээ (Bills digest) юм.


Хуулийн төслийн шинжилгээ

Судалгааны салбарын Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг нь 2008 оны 2-р сараас шинээр үйл ажиллагаагаа эхэлсэн Парламентын нийт 267 хуулийн төсөлд шинжилгээ хийсэн байна. Хуулийн төслийн шинжилгээг хийхдээ дараахь агуулгын хүрээнд хийдэг байна. Үүнд:

- Хуульд нийгмийн ямар харилцааг дэвшүүлэх зорилт тавьсан
- Хуулийн төсөл боловсруулах явц
- Зохицуулж буй гол харилцаа хэрхэн зохицуулж байгаа
- Томоохон заалтууд
- Дүгнэлт
- Зөвлөмж, тайлбар гэсэн гол зургаан асуудлын хүрээнд хийдэг байна.

Хуулийн төслийн шинжилгээг бүх гишүүд үздэг бөгөөд ойролцоогоор сард 80-100 мянган хүн үздэг гэсэн албан ёсны тоо баримт байдаг байна. Иймээс хуулийн төслийн шинжилгээнд дурьдсан зөвлөмжийг хуулийн төсөлд тусгах боломж өндөр байдаг байна. Хуулийн төслийн шинжилгээг зөвхөн Судалгааны салбар хийнэ. Учир нь Байнгын хороодын судлаачид зөвхөн улс төрийн өнгө аястай тайлан бичдэгээс үүдэн хараат бус бие, даасан, бодит судалгаа гаргах үүднээс хуулийн төслийн шинжилгээг судалгааны

салбарын үндсэн чиг үүрэг болгосон байна.



Хуулийн төслийн шинжилгээ хийхуодагаа хоёр тохиолдол байна. Үүнд:

- Цаг хугацааны хувьд боломжгүй
- Тухайн хуулийн төсөл асуудалгүй

Хуулийн төсөлд шинжилгээ хийхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудал нь хуулийн төсөл зөвхөн Парламентад танилцуулагдсаны дараа нээлттэй болдог учраас цаг хугацааны хувьд маш давчуу болдог. Энэ нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх учраас шинжилгээг урьдчилсан байдлаар хийж эхэлдэг байна. Энэхүү бэрхшээлийг арилгах арга замыг Парламентын Тамгын газрууд эрэлхийлсээр байна.

Гурав Сенатын Тамгын Газар

Хөтөлбөрийн дагуу Сенатын танхимын асуулт хариултын цагтай танилцсан юм. Сенатын Тамгын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд Төлөөлөгчдийн танхимын Тамгын газартай төстэй бөгөөд зөвхөн Сенатад үйлчилэх үндсэн үүрэгтэй байгууллага юм. Сенатын Тамгын газар нь 4 хэлтэстэй, хэлтэс тус бүр нь дотроо ажлын албадтай байна. Тамгын газрын хэлтэс нь дараахь байдлаар зохион байгуулагдсан байна:

- Хэлэлцүүлгийн хэлтэс буюу (Table office)
- Процедурын хэлтэс (Prucedure Office)
- Байнгын хороодын алба хариуцсан хэлтэс
- Дэгийн асуудал хариуцсан хэлтэс буюу (Black Rod's office)



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ФИЛИПИН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН ТУРШЛАГА

Ц. Норовдондог (Ph.D)

УИХТГ-ын Судалгааны, шинжилгээ, олон нийттэй харилцах төвийн дарга Ц. Норовдондог Дэлхийн банкнаас УИХТГ -т хэрэгжүүлж буй төслийн шугамаар 2010 оны 02 -р сарын 21-нээс 25-ний өдрүүдэд Филиппин улсын Манила хотод болсон Дэлхийн хөгжлийн сургалтын сүлжээ (GDLN)-ний Ази-Номхон далайн бүсийн чуулга уулзалтанд оролцож, Филиппиний Конгрессийн Бодлогын болон Төсвийн судалгааны газрын мөн Мэдлэгийн менежментийн төв (KDC) -ийн үйл ажиллагаатай танилцав.

1. Global Development Learning Network (GDLN)-ийн талаар

Тус сүлжээ нь Дэлхийн банкны институтын дэргэдэх сүлжээ бөгөөд дэлхийн 80 гаруй орны 100 гаруй төвөөр дамжуулан мэдээлэл түгээх, харилцан мэдлэг туршлага солилцох, он-лайн хэлбэрийн сургалт явуулах зэргээр улс орнууд мэдээллийн технологийн дэвшил дээр тулгуурлан улам ойртон нягтрах, мэдлэг туршлагаа хуваалцах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг сүлжээ юм.

Тус сүлжээний Монгол дахь үйл ажиллагааг Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар хариуцдаг бөгөөд Монгол улсад хэрэгжүүлж буй “Засаглалын чадавхийг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд УИХТГ-ын ажилтнуудын чадавхийг сайжруулах, мэдээлэл судалгааны бааз бүрдүүлэхэд энэхүү сүлжээ нь томоохон дэмжлэг болох ба ойрын хугацаанд УИХ-ын номын санг түшиглэн Олон нийтийн мэдээллийн төв (PIC) байгуулсанаар Дэлхийн банк болон түүний группийн орнуудын мэдээлэл судалгаагаар үнэ төлбөргүй хангагдах, он-лайн хэлбэрийн төрөл бүрийн сургалт, семинарыг Дэлхийн банктай хамтран явуулах боломжийг УИХТГ-т бүрдүүлэх юм.

Семинарын явцад авсан мэдээллээс үзэхэд, GDLN-ийн сүлжээний төвүүд нь хэд хэдэн чиглэлээр төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг юм байна. Тухайлбал,

- Академик сургалт, судалгааны институтийг түшиглэн байгуулсан төвүүд нь Мэдлэгийн хөгжлийн төв (Knowledge development center), Мэдлэгийн нөөцийн төв (Knowledge resource center), Хөгжлийн нөөцийн төв (Development resource center) гэх зэргээр нэршсэн байх бөгөөд ихэвчлэн их, дээд сургуулийг түшиглэн байгуулагдсан байна. Тус семинарыг Филиппиний Азийн менежментийн институтын төв дээр зохион байгуулсан бөгөөд энэ хугацаанд тус институтын KDC-ийн үйл ажиллагаатай танилцах боломж олдлоо. Эдгээр төвүүд нь Дэлхийн банкны мэдээллийн баазаас гадна академик судалгааны мэдээллийн баазтай, сэдэвчилсэн сургалтын хөтөлбөрүүдийг зайн сургалтын хэлбэрээр явуулах боломжтой юм байна.
- Засаглалын дээд түвшинд Парламентын Ажлын албыг түшиглэн байгуулсан төвийн жишээ нь Филиппиний Конгрессийн Ажлын албанд харьяалагддаг Knowledge management System Bureau юм. Тус төв нь Конгрессийн номын санд харьяалагдах бөгөөд Дэлхийн банк болон АХБ, Азийн сан зэрэг бусад донор орнуудын судалгаа, мэдээлэл, ном товхимолыг хэвлэмэл болон цахим байдлаар төвлөрүүлж хууль тогтоох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагаа явуулж байна. Тус төвийн мэдээллүүд нь дэлхийн түвшинд гүйцэтгэсэн орчин үеийн шинэлэг мэдээлэл, судалгааны баазыг агуулах тул судлаачид болон хууль тогтоогчдод ихээхэн хэрэгцээтэй байдаг юм байна.
- Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрууд дээр уг төвүүд байх бөгөөд Филиппиний ийм төвийн үйл ажиллагаатай мөн танилцлаа.

Одоогоор Монгол улсад Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр байгуулагдсан Олон нийтийн мэдээллийн төв 4 байгаа бөгөөд эдгээр нь МУИС, Нээлттэй нийгэм форум, Өмнөговь, Дархан уул аймагт байрлаж байна. 5 дахийг нь УИХТГ-ыг түшиглэн байгуулахаар төлөвлөж байгаа ба цаашид эдгээр төвүүдийг хооронд нь холбох, улмаар Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газраар дамжуулан Дэлхийн сүлжээнд холбогдох боломжтой, сургалт, мэдээллийн ач холбогдолтой болох нь харагдлаа.

2. Филиппиний Конгрессийн Судалгаа, мэдээллийн үйл ажиллагааны тухай

Филиппин улсын Парламент нь 2 танхимтай. Сенат нь 26 гишүүнтэй, Конгресс нь 286 гишүүнтэй юм байна. Конгрессийн Ажлын алба (Parliamentary Secretariat) нь томоохон бүтэцтэй, үүнээс дараахь үндсэн 4 нэгж нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон Speaker-т зэрэг харьяалагддаг. Үүнд:

- Конгрессийн бодлогын болон төсвийн судалгааны газар
- Парламент хоорондын харилцаа болон Speakeгийн асуудал хариуцсан газар
- Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах газар
- Армийн sergeant-ийн алба

Дараахь газрууд нь Ерөнхий нарийн бичгийн даргад шууд харьяалагдана. Үүнд:

- Захиргаа, хүний нөөцийн газар
- Санхүүгийн хэлтэс
- Инженерийн хэлтэс
- Хууль, эрх зүйн газар
- Байнгын хороодын ажлын алба

Бүтцийн схемээс үзэхэд үйл ажиллагааны чиг үүрэг нь нилээд тодорхой, парламентын үйлчилгээг иж бүрэн төрөлжүүлсэн шинжтэй, харьцангуй хүн хүч нөөц боломж сайтай байна. Онцлох нэг асуудал нь Конгрессийн ажлын албаны бүтцэд судалгаа, шинжилгээний чиг үүргийг нилээд төрөлжсөн маягаар зохион байгуулжээ. Тухайлбал,

- Конгрессийн бодлогын болон төсвийн судалгааг хариуцсан газар нь харьцангуй хараат бус, бодлогын чиглэлийн судалгаануудаа хийдэг. Үндсэн судалгаа нь макро эдийн засаг, өрсөлдөх чадвар, төсөв, хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдэл, боловсрол, байгаль орчин зэрэг нийгэм эдийн засгийн гол гол асуудлуудаар бодлогын судалгаа, шинжилгээ хийх үүрэгтэй. Дотроо макро эдийн засгийн, төсвийн, бусад гэсэн 3 чиглэлийн судалгааны албатай, жилийн туршид энэ чиглэлээрээ нилээд гүнзгий судалгаа хийдэг, мэргэшсэн алба болох нь уулзалт ярилцлагын үед харагдлаа.
- Хууль эрх зүйн хэлтэс дотроо судалгаа, лавлагааны товчоотой. Хуулийн хэлтэс нь дотроо Судалгаа, мэдээллийн товчоо, Чуулганы асуудал хариуцсан товчоо гэсэн бүтэцтэй. Судалгаа мэдээллийн товчоо нь дотроо хуулийн төсөл боловсруулах алба, хуулийн судалгааны алба, хуулийн зөвлөхүүдийн албатай, мөн чуулганы товчоо нь хуулийн төсөл болон индексийн алба, чуулганы алба, хэвлэл мэдээлэл, сурталчилганы албатай.
- Байнгын хороодын ажлын албаны бүтэц нь дотроо хэд хэдэн техникийн дэмжлэг үзүүлэх Support service-тэй бөгөөд нийт 80 байнгын хороодыг төрөлжүүлэн хувааснаас 1 албанд 8-10 байнгын хороо харьяалагддаг. Эдгээр албадууд нь техник зохион байгуулалтын болон мэдээлэл, лавлагаа, судалгааны үйлчилгээг ч мөн үзүүлдэг байна.
- Конгрессийн Номын сан нь харьцангуй том, дотроо лавлагаа, мэдээллийн хэсэгтэй. Мөн Дэлхийн банкны мэдээллийн төв Номын санд харьяалагддаг.

Гадаад орнуудын, ялангуяа АНУ-ын хуулийн баазтай, Legislative Library гэж нэрлэдэг, судлаачид болон гишүүдийн уншлагын танхимтай.

Филиппиний Конгрессийн 100 жилийн ойд зориулан гаргасан номыг Монгол Улсын Их хурлын Тамгын газар /Номын сан/-т бэлэглэснийг УИХТГ-ын дарга Ц. Шаравдоржид гардуулан өгөв. Мөн Конгрессийн судалгааны албаны ажилтнуудтай уулзалт, ярилцлага хийж ойрын хугацаанд төсөв, өрсөлдөх чадварын асуудал зэрэг асуудлуудаар Тамгын газрын ажилтнууд хооронд сэдэвчилсэн ярилцлагыг он-лайн хэлбэрээр зохион байгуулах талаар талууд харилцан санал солилцов.



АНУ -ЫН КОНГРЕССИЙН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ТУРШЛАГА

Ц. Батбаяр

Ардчилалын төлөө түншлэл байгууллага /House Democracy Partnership/, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн /International Republican Institute/ -тэй хамтран парламентын албан хаагчдад зориулсан сургалтыг 2009 оны 12 дугаар сарын 06-18-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо зохион байгууллаа. Сургалт нь Ардчилалын төлөө түншлэл байгууллагын түнш 12 улс болох Афганистан, Гүрж, Гаити, Индонези, Кени, Косово, Ливан, Либерти, Македони, Монгол Улс, Пакистан Улс, Перу болон Зүүн Тимор Улсыг төлөөлөн Парламентийн судалгааны төвийн дарга, судлаач нар оролцлоо.

Тус сургалтын зорилго нь парламентын байнгын хороо, парламентын төвлөрсөн судалгааны алба, парламентын хуулийн хэлтэс, удирдлагын нэгж болон номын санд ажилладаг судлаач, шинжээч нарын хууль тогтоох чиглэлийн судалгаа, дүн шинжилгээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн юм. Мөн семинарт оролцогчид АНУ-ын Конгрессын бүтэц зохион байгуулалт ба судалгааны албаны үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээний албаны зохион байгуулалтын загвар, судалгаа дүн шинжилгээний арга хэрэгсэл, судалгааны төрөл ба бүтээгдэхүүн, үйлчлүүлэгчидтэй ажиллах арга хэлбэр, хууль тогтоох байгууллагад зориулж судалгааны тайлан бичихэд тавигдах шаардлага зэрэг чухал сэдвүүдийг судлан үзсэн бөгөөд өөр өөрийн улсын туршлагыг солилцов.

Сургалтанд АНУ-ын Конгрессын судалгааны албанд ажиллаж байсан ба одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүд болон Канадын парламентын зөвлөх хичээл заасан бөгөөд Мэрилэнд мужид зочлон мужийн түвшний хууль тогтоох байгууллагын судалгаа, шинжилгээний ажлын онцлогтой танилцлаа.

КОНГРЕССИЙН НОМЫН САН

1800 онд ерөнхийлөгч Жон Адамс АНУ-ын Засгийн газрыг Филадельфи хотоос одоогийн нийслэл болох Вашингтон хот руу шилжүүлэх тухай хуульд гарын үсэг зурснаар Конгрессын номын сан байгуулагдсан гэж үздэг. Тухайн үеийн номын сангийн фондыг бий болгох үүднээс Конгресс 5000 ам.долларын төсвийг баталж 740 боть, 3 ширхэг газрын зургийг худалдан авчээ.

Их Британийн цэргүүд дайрч номын санг галдан шатаах хүртэл буюу 1814 оны 8 дугаар сар хүртэл Капитолд байрлаж байсан байна. Тухайн үед ерөнхийлөгчийн суудлаас буугаад байсан Томас Жефферсон өөрийн 50 жил цуглуулсан номын фондоо Конгрессийн номын санд хандивласан байна. Түүний цуглуулга үнэхээр арвин байсны дээр Америк улсын түүхтэй холбогдсон ном бүтээлүүд, гадаад хэл, шинжлэх ухааны ховор номуудаас бүрдсэн байв. 1815 оны нэгдүгээр сард Конгресс Жефферсоны цуглуулгыг хүлээн авсан бөгөөд түүний хандивласан номын фонд нь 23950 ам.долларын үнэ бүхий 6487 ширхэг ном байжээ.

АНУ-ын нутаг дэвсгэр дээр хэвлэгдсэн аливаа ном хэвлэлийн нэг хувийг Конгрессийн номын санд өгч байх, ном бүтээлийг хүлээн авах, улсын төсвөөс санхүүжүүлэх, урамшуулах үйл ажиллагааг хуульчилж өгсөний үр дүнд 1850-иад онд Конгрессийн номын сангийн сан хөмрөг 55000 гаруй номтой болжээ.

Конгрессийн номын сан нь АНУ-ын хууль тогтоогч дээд байгууллага Конгресст үйлчлэхээс гадна Засгийн газрын агентлаг, бусад номын сангууд, эрдэмтэд, судлаачдаас гадна олон нийтэд мөн нээлттэй үйлчилдэг.

Номын сангийн сан хөмрөг

Өнөөдөр Конгрессийн номын сан нь дэлхий дээрхи хамгийн том номын сангуудын нэг бөгөөд 130 сая гаруй хэвлэмэл бүтээгдэхүүн байгаагаас 460 хэл дээр 29 сая ном болон товхимол, 58 сая гар бичмэл байна. Мөн түүнчлэн Хойд америкт ховор номын цуглуулгаараа томоохонд орох бөгөөд хуульзүйн чиглэлийн материал, кино, газрын зураг, хөгжмийн болон дууны цуглуулгаараа дэлхийд хамгийн томд орж байна.

Номын сангийн бүтэц зохион байгуулалт

Номын сангийн удирдах газар

- Номын сангийн удирдах газар нь номын сангийн бодлогыг тодорхойлох, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг зохион байгуулах үүрэгтэй.

Захиргааны газар

- Номын сангийн харъяа газруудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдгээр газруудын үйл ажиллагааг дэмжих зорилготой юм. Захиргааны газарт боловсон хүчин, санхүү, аюулгүй байдлын албад харъяалагдана.

Конгрессийн судалгааны алба

- Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж, мэдээллээр хангах үйлчилгээний алба юм.

Зохиогчийн эрхийн алба

- Үндэсний зохиогчийн эрхийн системийн дагуу зохиогчийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулдаг.

Хуулийн номын сан

- Конгресс 1832 онд хуулийн номын санг байгуулсан бөгөөд өдгөө 3 сая гаруй хууль эрх зүйн акт, баримт бичгүүдийг агуулсан дэлхийн хамгийн том хуулийн номын сан юм.

Номын сангийн алба

- Энэ алба нь Америкийн ард түмний бүтээсэн түүхэн ном сурвалж болон дэлхийн түүхэн баримт бичгүүдээс бүрдсэн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, чанар, зохион байгуулалт, кодчиллол зэргийг хариуцдаг.

Стратеги төлөвлөлтийн газар

- Энэ газар нь стратеги төлөвлөгөөний дагуу номын сангийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж үндэсний хэмжээнд удаан хугацааны дижитал хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Мөн ирээдүйн төлөвлөгөөг боловсруулж хамтын ажиллагааны өргөн хүрээнд ажилладаг.

Конгрессийн Судалгааны Алба

- 1914 онд Конгрессоос Конгрессийн номын сан дотор шинээр газар байгуулахаар шийдвэр гарсан байна. Тухайн үеийн Ерөнхийлөгч Вүүдроу Уйлсон хуулийн төсөл санаачилж Хууль зүйн лавлагааны албыг байгуулахаар тусгасан бөгөөд энэ нь Конгрессийн хууль тогтоох хэрэгцээ шаардлагыг хангах байлаа. 1970 оны Бүтэц, зохион байгуулалтын хуулиар Хууль зүйн лавлагааны албаны нэрийг өөрчилж Конгрессийн судалгааны алба болгосон байна.

Конгрессийн судалгааны алба нь дэлхийн хамгийн том хууль тогтоох судалгааны төв

юм. Тус алба нь төвийг сахисан, үнэн бодит мэдээллээр өөрийн ганц үйлчлүүлэгч болох АНУ-ын Конгрессийг хангаж ажилладаг. Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод үйлчилгээ үзүүлэх бөгөөд Конгрессийн Судалгааны албаны шинжээч нар хуулийн төслийг Байнгын хороодоор хэлэлцүүлэх, хууль батлагдах хүртэлхи бүх шатанд цаг үеийн, бодитой, нам бус, нууцыг хадгалсан мэдээлэл судалгааны үйлчилгээнүүдийг үзүүлдэг байна.

Гүйцэтгэх засаглал ба хууль тогтоох байгууллагын судалгааны чадавхийг тэнцвэржүүлэх зорилгоор тус албыг 1970-аад онд нилээд өргөтгөн бэхжүүлсэн. Эрх зүйн зохицуулалтын хувьд тус албаны үйл ажиллагааг АНУ-ын Конгрессийн хууль тогтоох үйл явцтай нягт уялдуулж өгсөн ба Конгресст бодлогын альтернатив хувилбарууд ба эдгээрийн үр нөлөөг боловсруулан санал болгох үүргийг хүлээдэг.

Конгрессийн судалгааны алба нь гүйцэтгэх засаглалын байгууллага болон олон нийтийн судалгааны хэрэгцээг хангах үүрэг хүлээдэггүй. Конгрессийн судалгааны алба нь нийт 700 гаруй ажилтантайгаас 450 гаруй нь бодлогын шинжээч, хуульч, мэдээллийн мэргэжилтэн, эдийн засагч, гадаад хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, цагаачлал, эрчим хүч, байгаль орчин, болон шинжлэх ухаан технологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, шинжээчид байна.

Судалгааны албанаас тайлан, мэдээлэл, семинар, илтгэл, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээнүүдийг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд доод танхимд хууль тогтоох бүхий л шатанд үзүүдэг.


Конгрессийн судалгааны албаас үзүүлдэг үйлчилгээ болон бүтээгдэхүүнүүд:

- Тойм мэдээлэл, зөвлөгөөнүүд
- Тухайн хуулийн асуудлаархи тайлан мэдээнүүдийг веб хуудсаар 7 хоногийн 24 цагийн турш
- Хууль зүйн мэдээллийн систем (LIS)
- Семинар болон уулзалт зохион байгуулах бөгөөд Холбооны хуулийн шинэчлэлийн талаар жилд 2 удаан хэлэлцүүлэг хийх
- Конгрессийн ажилтнуудад хууль тогтоох болон төсөв хэлэлцэх журмын талаар сургалт зохион байгуулах
- Хуульд дүн шинжилгээ, анализ, тайлбар хийх

Зохион байгуулалтын бүтэц

Судалгааны алба нь 5 салбарт хуваагддаг (Схем - 1)





Америкийн хууль – Энэ салбарын хуулийн чиглэлийн бүхий л асуултуудад хариулт өгдөг. Мөн түүнчлэн үндсэн хуулийн зарчим, хуульд нийцсэн байдалд дүн шинжилгээ хийдэг бөгөөд үүний дотор холбооны улсын зарчим, худалдаа, иргэний эрхийн талаас нь авч үздэг. Энэ салбарынхан бусад хуулийн салбарууд болох бизнес, гэмт хэрэг, байгаль орчин, иргэний эрх, олон улсын хууль, болон бусад асуудлуудад дүн шинжилгээ хийдэг

Энэ салбар нь 5 хэсэгт хуваагддаг бөгөөд тус бүр нь судалгааны удирдагчтай байна.

- Захиргааны хууль
- Бизнес
- Конгресс
- Шүүх ба Олон улс
- Үндэсний баялаг

Нийгмийн бодлого – Энэ салбар нь дотоодын нийгмийн бодлогын хөтөлбөрийн асуудлуудад дүн шинжилгээ хийдэг. Энэ салбарын хамрах асуудлын хүрээнд боловсрол, хөдөлмөрлөх хүч, хөдөлмөрлөх хүчний аюулгүй байдал, эрүүл мэндийн даатгал ба санхүүжилт, эрүүл мэндийн үйлчилгээ, насжилт, нийгмийн даатгал, тэтгэвэр, иргэдийн шилжилт суурьшил, эрүүгийн шүүх, нийгмийн хангамж, хоол хүнс ба орон сууцжуулах хөтөлбөрүүд багтана.

Нийгмийн бодлогын салбар нь зургаан хэсэгт хуваагдах бөгөөд хэсэг бүрийг судалгааны удирдагч удирдана.

- Хүүхэд ба гэр бүл – жирэмслэлт, хүүхэд ба үрчлэлт, бага орлоготой иргэд, орон гэргүйчүүд болон орон гэрээсээ дайжсан өсвөр насныхан, орон сууцны хөтөлбөр.
- Аюулгүй байдал ба шилжилт хөдөлгөөн – Эрүүгийн гэмт хэрэг, мансууруулах бодисны хэрэглээ, архи тамхи, галт зэвсгийн хяналт, хилийн аюулгүй байдал, шилжилт хөдөлгөөн.
- Боловсрол ба ажиллах хүч – анхан болон дунд боловсрол, техник мэргэжлийн сургалт, ажиллах хүчний асуудлууд хамаарна.
- Эрүүл мэндийн үйлчилгээ ба санхүүжилт – эмнэлгийн үнэгүй тусламж, ядуу иргэдэд зориулсан үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ ба хүүхдийн эрүүл мэндийн даатгалын асуудлууд.
- Эрүүл мэндийн үйлчилгээ ба судалгаа – эрүүл мэндийн судалгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, олон нийтийн эрүүл мэнд, ахмад дайчдын эрүүл мэндийн халамж.
- Нийгмийн даатгал – нийгмийн даатгал, ажилгүйдлийн нөхөн төлбөр, тэтгэвэр тэтгэмжийн асуудлуудыг хамардаг.

Гадаад хэрэг, батлан хамгаалах, худалдаа – Энэ салбар нь дэлхийн улс төрийн болон эдийн засгийн хөгжлийн асуудал, АНУ ба бусад улс хоорондын улс төр эдийн засгийн харилцаа, улс хоорондын асуудал болох терроризм, цагаачлалын талаар шинжээчид ажилдаг. Үндэсний аюулгүй байдлын судалгаанд зэвсэгт хүчний стратеги, АНУ-ын батлан хамгаалахын төсөв, зэвсгийн систем, зэвсэгт хүчний баазын нөхөн төлбөр зэрэг асуудлууд хамаарагдана. Худалдааны шинжээчид эдийн засгийн асуудлуудад дүгнэлт өгөх ба худалдааны тариф, экспорт, импортын асуудлуудыг авч үзнэ.

Тус салбар дотроо 7 хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

- Ази
- Батлан хамгаалах ба зэвсгийн хяналт
- Батлан хамгаалах төсөв, удирдлага зохион байгуулалт
- Европи ба Америк тив

- Гадаад бодлогын менежмент, олон улсын асуудал
- Олон улсын худалдаа ба санхүү
- Ойрхи дорнод ба Африк

Засгийн газар ба санхүү – Энэ салбар нь Конгрессийн удирдлага, зохион байгуулалт болон түүний харъяа байгууллагууд, салбар, шүүх засаглал, Конгрессийн төсөв хэлэлцэх, батлах үе шат, хууль тогтоох үе шат, Конгрессийн түүх, улс орны аюулгүй байдал ба онцгой байдлын удирдлага, нийгмийн хөгжил, сонгууль ба холбооны улсын зарчим зэрэг олон асуудлуудыг хамардаг байна. Санхүүгийн асуудлын хүрээнд банк, санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, татвар, төрийн санхүү, төсвийн болон мөнгөний бодлого, улсын зээл, эдийн засгийн зээлийн үзүүлэлтүүдийг судалдаг.

Тус салбар нь зургаан хэсэгтэй бөгөөд хэсэг бүр удирдагчтай байна.

- Банк, даатгал, үнэт цаас ба Макро эдийн засгийн бодлого
- Конгресс ба шүүх засаглал
- Гүйцэтгэх засаглалын салбарын үйл ажиллагаа – Ерөнхийлөгчийн алба ба эрх мэдэл, ерөнхийлөгчид нэр дэвшигчид, холбооны ажиллах хүч, Нэгдсэн улсын шуудан, дүрэм журмын удирдалаг, спорт гэсэн асуудлуудыг хамаарна.
- Холбооны улсын зарчим, сонгууль ба онцгой байдлын удирдлага
- Засгийн газрын санхүү ба татвар
- Хууль тогтоох ба төсвийн батлагдах үе шат

Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нөөц – Тус салбарын хамрах хүрээнд байгалийн нөөц, шинжлэх ухааны дэвшил, технологийн хөгжил, бизнесийн гол салбаруудын зохицуулалтуудыг судлана. Нөөцийн асуудлын хүрээнд байгалийн баялаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, хүнс бө загс агнуур, эрчим хүч ба ашигт малтмал зэрэг орно. Шинжлэх ухааны салбарын асуудалд иргэний болон зэвсэгт хүчний судалгаа хөгжлийн асуудлууд, мэдээлэл технологи, сансар судлал, бусад шинжлэх ухааны салбарууд хамаарна. Үйлдвэрлэлийн асуудалд тээврийн хяналт, тээврийн дэд бүтцийн асуудал, үйлдвэрлэлийн зах зээл ба зохицуулалтын талаар шинжилгээ, судалгааны ажлууд багтана.

- Хөдөө аж ахуй ба хүнсний хангамж
- Эрчим хүч ба ашигт малтмал
- Байгаль орчны бодлого
- Байгалийн нөөц ба дэлхий судлалын шинжлэх ухаан
- Шинжлэх ухаан ба технологийн бодлого
- Тээвэр ба үйлдвэрлэлийн шинжилгээ

Мэдлэгийн мэдээллийн хэсэг - дээрхи судалгааны салбаруудын бодлогын судлаачдын судалгаанд дэмжлэг үзүүлэх, туслах хэлбэрээр хамтран ажилладаг.



ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Бодлогын судалгаа, шинжилгээ”
эмхтгэл (IV боть) -ийн хавсралт1

**УИХ -ын 2009 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс
хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа**

(III ботид орсон судалгааны жагсаалт)

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
Нэг. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН АСУУДАЛ		
1	• ТӨСВИЙН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЗАСГИЙН ГАЗРААС ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХАРИЛЦАА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ (Харьцуулсан судалгаа)	Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc), Ц. Батбаяр, Ц. Батдорж, Г. Билгээ, Ц. Болормаа, Ч. Онончимэг, А. Пагма, Ц. Товуусүрэн, Ц. Элбэгзаяа
2	• МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТӨСӨВ, МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК СУДАЛГАА (2005 - 2009 он)	Д. Ариунаа (MSc), Ц. Батдорж, Г. Билгээ, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа
3	• УУЛ УУРХАЙН ОРЛОГООС ИРГЭДЭД МӨНГӨ ТАРААХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЭЭРЭГ СӨРӨГ ҮР ДАГАВРЫН ТООЦООЛОЛ (БОДЛОГЫН СУДАЛГАА)	Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батсүх (Ph.D), Д. Ариунаа, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа
4	• ЭХ ҮҮСВЭР НЬ УУЛ УУРХАЙН ОРЛОГООС БҮРДДЭГ БАЯЛГИЙН САНГУУДЫН ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГАА (Харьцуулсан судалгаа)	Ц. Норовдондог (Ph.D), Г. Алтан - Оч (Ph.D), Ч. Базар (Ph.D), Д. Мягмарцэрэн (LL.M), А. Пагма (MA)
5	• МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН БУСАД ОРНЫ ТУРШЛАГА	Ч. Онончимэг, Ц. Батбаяр, Ц. Элбэгзаяа
6	• ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН БУСАД ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ / Харьцуулсан судалгаа/	Ц. Түвшинзаяа
7	• МОНГОЛ УЛС ДАХЬ ТАМХИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ (ТОЙМ СУДАЛГАА)	Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа, О. Нарантуяа, Д. Золбоо
Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАР, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨГЖЛИЙН АСУУДАЛ		
8	• ӨНДӨР ТЕХНОЛОГИ (HIGH - TECH) -ИЙН ҮҮРЭГ РОЛЬ, ТӨРИЙН БОДЛОГО, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА (Харьцуулсан судалгаа)	С. Дорждагва, Б. Мөнхцэцэг, Д. Золбоо
9	• УУЛ, УУРХАЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН (Харьцуулсан судалгаа)	Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа
10	• НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТ, МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ	Н. Түвшинтөгс, Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Б. Ариунжаргал

11	• ЭРДЭС БАЯЛГИЙН АСУУДЛААР ГАДААД ДОТООДЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД /Лавлагаа-мэдээлэл/	Ө. Мөнхтунгалаа, О. Нарантуяа
12	• ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА	Г. Алтан-Оч (Ph.D), С. Дорждагва
13	• ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ	Н. Түвшинтөгс, Б. Ариунжаргал
14	• ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА (Харьцуулсан судалгаа)	Ю. Эрдэнэтуяа, С. Дорждагва, Ш. Хишигсүрэн, Ц. Түвшинзаяа, Д. Живгаагүнсэл, Г. Чулуун
15	• ХҮНСНИЙ САВ БООДОЛ, ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА (Бодлогын судалгаа)	Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаа
16	• НИЙЛЭГ САВ БАГЛАА БООДЛООС ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖИХ ХИМИЙН ХОРТ БОДИСЫН СУДАЛГАА (Бодлогын судалгаа)	Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаа, Д. Живгаагүнсэл, Б. Ариунжаргал
17	• БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (Бодлогын судалгаа)	Ч. Базар (Ph.D)



УИХ.MN
СУДАЛГААНЫ САН



Уншигчийн тэмдэглэл

УИН.МН
СҮДАЛГААНЫСАН




Уншигчийн тэмдэглэл

[illegible]

Уншигчийн тэмдэглэл

УИН.М
СҮДАЛГАЛНЫ

УИХ-МН
СҮДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

